



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-19
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	20-243
<hr/>	
1.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/	24-25
2.Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	25-40
3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/	40-61
4.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	61-89
5.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	89-100
6.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	100-105
7.“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 14 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	105-124
8.Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүн 2026.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	125-128, 132-164
9.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл	164-201
10.“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	201-205
11.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	205-224
12.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	224-230
13.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	230
14.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	230-234
15.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	234-243

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 28-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 70 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.¹

Томилолттой: Т.Аубакир, Д.Батлут, Ч.Лодойсамбуу, Н.Номтойбаяр, Р.Сэддорж, Б.Тулга, А.Ундраа;

Чөлөөтэй: Ч.Анар, Ж.Баясгалан, С.Лүндэг, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Батцэцэг, С.Замира, Э.Одбаяр, Ж.Чинбүрэн;

Тасалсан: С.Амарсайхан;

Хоцорсон: Н.Алтанхуяг-11 минут, Н.Алтаншагай-15 минут, Д.Амарбаясгалан-2 цаг 06 минут, Э.Бат-Амгалан-5 цаг 16 минут, Д.Батбаяр-4 цаг 03 минут, Ж.Батжаргал-37 минут, Х.Баттулга-44 минут, Х.Болормаа-09 минут, Э.Болормаа-1 цаг 23 минут, Х.Булгантуяа-09 минут, Ш.Бямбасүрэн-02 минут, Ж.Галбадрах-34 минут, С.Ганбаатар-02 минут, Д.Ганбат-3 цаг 56 минут, Л.Гантөмөр-54 минут, Ц.Даваасүрэн-6 цаг 30 минут, Т.Доржханд-5 цаг 22 минут, Б.Дэлгэрсайхан-07 минут, Б.Жавхлан-27 минут, Х.Жангабыл-04 минут, Д.Жаргалсайхан-2 цаг 12 минут, Ж.Золжаргал-6 цаг 51 минут, Г.Лувсанжамц-19 минут, М.Мандхай-04 минут, П.Мөнхтулга-29 минут, З.Мэндсайхан-03 минут, П.Наранбаяр-02 минут, О.Номинчимэг-1 цаг 52 минут, С.Одонтуяа-01 минут, Б.Пунсалмаа-09 минут, О.Саранчулуун-25 минут, Ц.Туваан-16 минут, Г.Уянгахишиг-27 минут, Г.Хосбаяр-03 минут, Д.Цогтбаатар-55 минут, Л.Энх-Амгалан-2 цаг 44 минут, Б.Энхбаяр-08 минут, Ж.Энхбаяр-31 минут, Р.Эрдэнэбүрэн-47 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 05 дугаар сарын 26-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нарын 13 гишүүнээс 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нарын 19 гишүүнээс 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй

¹ Хуралдаан даргалагч ирцийг танилцуулах үед 1 гишүүн ирцэд нэмэгдсэн.

холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./10:08/

Хуулийн төсөл татан авах талаар танилцуулах

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Засгийн газраас 2025.01.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцов./10:09/

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатараас 2025.04.03-ны өдөр өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцов./10:10/

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нарын 4 гишүүнээс 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцов./10:11/

Нэг.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

С.Бямбацогт: Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 52
Бүгд: 86
39.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 10 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа, мөн газрын дэд захирал Д.Бат-Өлзий, Хөрш орнуудын газрын дэд захирал Д.Өнөбилэгт, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, мөн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Ганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, П.Сайнзориг, С.Эрдэнэбат, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Ц.Туваан, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Аж

үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа, мөн яамны Хөрш орнуудын газрын дэд захирал Д.Өнөбилэгт, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, С.Одонтуяа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг соёрхон батлах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16.00 цагт явуулахаар хойшлуулав./11:14/

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, референт Б.Баясах нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан, дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир нар тус тус танилцуулав.

Хуулийн төсөл татан авах талаар танилцуулах

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 10 гишүүнээс 2025.11.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцов./11:33/

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Б.Батбаатар, Д.Энхтүвшин, О.Алтангэрэл, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, П.Сайнзориг, Л.Мөнхбаатар, Б.Жаргалан, Х.Тэмүүжин, Н.Алтанхуяг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./12:30/

Дөрөв.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Р.Рэнцэнбазар, А.Энхбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 12 цаг 32 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хороодын хамтарсан хуралдааны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, П.Сайнзориг, С.Цэнгүүн, С.Эрдэнэбат, Ж.Ганбаатар, О.Батнайрамдал, М.Мандхай, Н.Алтанхуяг, Г.Уянгахишиг, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд З.Мэндсайхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Р.Рэнцэнбазар, А.Энхбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат танилцуулав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 14 цаг 20 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хороодын хамтарсан хуралдааны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Б.Түвшин, Ж.Галбадрах нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн

төсөл /Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Р.Рэнцэнбазар, А.Энхбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Байнгын хороодын хамтарсан хуралдааны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 16:00 цагт явуулахаар хойшлуулав./15:08/

Долоо. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 14 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Мөнхтөр, Зам, тээврийн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Сугармаа, “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газар /ТӨҮГ/-ын захирал Д.Оюунболд, мөн үйлдвэрийн газрын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтсийн дарга Э.Балт, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын ерөнхий инженер З.Энх-Оргил, мөн үйлдвэрийн газрын Барилга байгууламжийн зураг төслийн магадлал зохион байгуулах хэлтсийн дарга Г.Мөнхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, М.Ганхүлэг, Х.Ганхуяг, Л.Мөнхбаясгалан, М.Мандхай, Ц.Туваан нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Мөнхтөр, Зам, тээврийн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Сугармаа, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын Барилга байгууламжийн зураг төслийн магадлал зохион байгуулах хэлтсийн дарга Г.Мөнхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу түр хойшлуулав./16:17/

Найм.Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүн 2026.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, мөн газрын шинжээч С.Пүрэвсайхан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Ц.Мөнхзул, мөн газрын шинжээч Ж.Азжаргал, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга Б.Баярсайхан, мөн газрын Хүүхэд, гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Бадамцэцэг, хүүхдийн эрхийн улсын байцаагч М.Отгонгэрэл, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх О.Энхмэнд, хуульч Б.Энхчимэг, судлаач Б.Саруул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Ц.Долгормаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр нар танилцуулав./16:31/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалт явуулах цаг болсон тул хуралдаан санал хураалтаар үргэлжлэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна.” гэж заасны “... 4 жил ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхийлөгчөөр ... зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 47

Бүгд: 109

56.9 хувийн саналаар Байнгын хороодын санал дэмжигдлээ.

Байнгын хороодын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Уг асуудлыг 16 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Байнгын хороодоос Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 48

Бүгд: 109

56.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн нэрийн “хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар” гэснийг “хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар” гэж өөрчилж, төслийн тэмдэглэх хэсгийн “Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.1 дэх заалтын “хугацаандаа” гэсний өмнө “эсхүл бусад шалтгаанаар” гэж нэмж, “тодорхой үзүүлэлт, аргачлалын дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 39
Бүгд: 109
64.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.1 дэх заалтын “2026 оны 07 сарын 01-ний өдрийн дотор” гэснийг “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд” гэж өөрчлөх гэсэн саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

4.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Энэ тогтоолын 1.1 дэх заалтад заасан тайланд тусгагдсан төсөл, арга хэмжээг хуульд заасан өмчлөлийн өөр хэлбэрт шилжүүлэх, эсхүл хууль зүйн тодорхой үндэслэлтэйгээр цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэх эсэх саналаа энэ тогтоолын 1.1-д заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;” гэсэн саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

5.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.3 дахь дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 36
Бүгд: 109
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.4, 1.5 дахь дэд заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/Улсын Их Хурлаар жилийн төсвийн төслийг хэлэлцэх хэлэлцүүлгийн бүх шатанд Төсвийн тухай хуулийн 29^{1.4}-т заасан цахим систем дэх мэдээллээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцыг Улсын Их Хурлын гишүүд нээлттэй харах боломжийг бүрдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74

Татгалзсан: 35

Бүгд: 109

67.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 2, 3 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 4 дэх заалтын дугаарыг “3” гэж өөрчлөх.

“2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Н.Наранбаатар/-нд даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 36

Бүгд: 109

67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

8.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтын “хуульд тусгаж” гэснийг “хуулиар баталж” гэж, “анх батлагдсан” гэснийг “анхны” гэж, “буй ачаалал, дарамт” гэснийг “байгаа нөлөөлөл” гэж, “бүрээр тус бүр үнэлж” гэснийг “нэг бүрээр судалж” гэж тус тус өөрчилж, мөн дэд заалтын “талаар судалж,” гэснийг хасах гэсэн саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Хоёр.Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн гаргасан, Тогтоолын төслийн 1.1 дэх заалтын “зогссон” гэсний дараа “, анхны төсөвт өртөг нь 50 хувиас дээшээ нэмэгдсэн,” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75

Татгалзсан: 34

Бүгд: 109

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг соёрхон батлах хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 37

Бүгд: 109

Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар буюу 66.1 хувиар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, А.Ариунзаяа, Ө.Шижир, П.Сайнзориг, Х.Баасанжаргал, Д.Энхтуяа, Т.Мөнхсайхан, О.Батнайрамдал, Б.Жаргалан, С.Одонтуяа, О.Саранчулуун, О.Номинчимэг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Л.Мөнхбаясгалан, С.Эрдэнэбат, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга Б.Баярсайхан, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 17 цаг 07 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, Ш.Бямбасүрэн, О.Саранчулуун нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2026.05.29-ний өдрийн Баасан гарагт явуулахаар хойшлуулав./18:42/

Ес.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын гишүүн С.Дондов, Х.Мөнхзул, Ж.Хунан, Б.Энхболд,

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэбаяр, Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн дарга С.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, дэд дарга Г.Эрдэнэбат, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Ж.Сайнхишиг, референт Г.Нямдэлгэр нар байлцав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, илтгэлийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 18 цаг 44 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан, Д.Энхтүвшин, А.Ариунзаяа, П.Сайнзориг, Б.Уянга, С.Эрдэнэбат, О.Батнайрамдал, Д.Бум-Очир, Л.Мөнхбаясгалан, Д.Ганмаа, Б.Хэрлэн, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын гишүүн Х.Мөнхзул, Ж.Хунан, С.Дондов, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэбаяр, Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн дарга С.Ганзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, О.Номинчимэг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт үг хэлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцэв.

Уг асуудлыг 20 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Арав. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын гишүүн С.Дондов, Х.Мөнхзул, Ж.Хунан, Б.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга

Т.Ням-Очир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэбаяр, Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн дарга С.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, дэд дарга Г.Эрдэнэбат, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Ж.Сайнхишиг, референт Г.Нямдэлгэр нар байлцав.

“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2026.05.29-ний өдрийн Баасан гарагт явуулахаар хойшлуулав./21:07/

Арван нэг.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, дэд дарга Г.Эрдэнэбат, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Төрмөнх, С.Тэгшжаргал, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн

Ө.Шижир, С.Цэнгүүн, Х.Ганхуяг, С.Эрдэнэбат, М.Мандхай нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Ж.Золжаргал, С.Цэнгүүн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2026.05.29-ний өдрийн Баасан гарагт явуулахаар хойшлуулав./22:21/

Арван хоёр.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын ерөнхий прокурорын газрын Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга Б.Эрхэмбаяр, Зам, тээврийн яамны Авто тээврийн бодлого, зохицуулалтын газрын ахлах шинжээч Т.Эрхэмбаатар, мэргэжилтэн А.Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Зам, тээврийн хяналт, төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн дарга Б.Очирбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, дэд дарга Г.Эрдэнэбат, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат нар байлцав.

Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Зам, тээврийн яамны Авто тээврийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн А.Энхболд, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Зам, тээврийн хяналт, төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн дарга Б.Очирбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар хураах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2026.05.29-ний өдрийн Баасан гарагт явуулахаар хойшлуулав./22:41/

Арван гурав.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Өмгөөллийн Грандлекс партнерс хязгаарлагдмал хариуцлагатай компанийн өмгөөлөгч Ж.Дамбаасүрэн, “Төв тусгал” сургалт, судалгааны төвийн судлаач Э.Сундуй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, дэд дарга Г.Эрдэнэбат, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нарангэрэл, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат нар байлцав.

Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 22 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Арван дөрөв.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, хог хаягдлын менежментийн зөвлөх Б.Дэлгэрбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, дэд дарга Г.Эрдэнэбат, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх П.Хулан, референт Б.Энхгэрэл, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, референт Х.Хэрлэн, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Ж.Сайнхишиг, референт Г.Нямдэлгэр нар байлцав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн

нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2026.05.29-ний өдрийн Баасан гарагт явуулахаар хойшлуулав./22:57/

Арван тав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, мөн яамны Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Батшагай, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, дэд дарга Г.Эрдэнэбат, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Ж.Сайнхишиг, референт Г.Нямдэлгэр нар байлцав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Өргөдлийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, М.Мандхай нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу 2026.05.29-ний өдрийн Баасан гарагт явуулахаар хойшлуулав./23:26/

Бусад. Монгол Улсын Их Хурал, Европын парламент хоорондын 18 дугаар зөвлөлдөх уулзалтад оролцож буй Европын парламентын гишүүн, Төв Ази, Монголтой харилцах төлөөлөгчдийн бүлгийн дарга Жүси Принчи тэргүүтэй төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы урилгаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийг 2006 онд төгссөн төгсөгчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 15 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 13 цаг 27 минут үргэлжилж, 126 гишүүнээс 110 гишүүн хүрэлцэн ирж, 87.3 хувийн ирцтэйгээр 23 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 28-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийнхээ энэ өглөөний амгаланг айлтгая. Улсын Их Хурлын 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы хуралдааны ирцийг танилцуулъя. 126 гишүүнээс 70 гишүүн буюу 55.6 хувийн ирцтэй чуулганы нэгдсэн хуралдааны ирц бүрдсэн учраас чуулганы нэгдсэн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Долоо хоногийн тов, дараалалд тусгагдсан хэлэлцэх асуудлын тухай. Гишүүнийг томилох, чөлөөлөх асуудал энэ долоо хоногийн чуулганаар хэлэлцэх ёстой байсан. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяагийн гаргасан горимын санал дэмжигдэж, хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан байна. 2.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатар нарын 10 гишүүн өргөн мэдүүлсэн. Байнгын хорооны хуралдааны явцад Төрийн байгуулалтын байнгын хорооны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны явцад хууль санаачлагчийн саналаар хуулийн төслүүдийг хэлэлцэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан. 3.Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Засгийн газар өргөн мэдүүлсэн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 5 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн Анарын гаргасан горимын санал дэмжигдэж, хойшлуулсан тул чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хассан байна.

Өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа гишүүдийн талаар мэдээлэл өгье, мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл 05 дугаар сарын 26-ны өдөр төрсөн байна. Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёлдоо төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Өнөөдрийн чуулганы хуралдааны эртэч гишүүдийг танилцуулъя. Нацагдоржийн Батсүмбэрэл, Бөхчулууны Пүрэвдорж, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Сүхбаатарын Эрдэнэболд, Лутаагийн Энхнасан нарын гишүүд өглөө 09:00 цагт ирцдээ бүртгүүлсэн байна. Эртэч гишүүддээ баяр хүргэе.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 15 асуудлыг хэлэлцэнэ. Нэгдүгээрт, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын

тогтоолын төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Засгийн газар 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдөр яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн байна.

2.Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон "Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай" хуулийн төслийг Засгийн газраас 05 дугаар сарын 15-ны өдөр яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн тул соёрхон батална.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

4 дүгээрт нь, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

5.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

6.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

7.“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулна. Уг тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа нарын 13 гишүүн өргөн мэдүүлсэн.

8.Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн нарын 21 гишүүн өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

9.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай 25 дахь илтгэлийг хэлэлцэнэ.

10 дугаарт, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцүүлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний” тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

11.Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн.

12.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд /ЗХАБТХ/ нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Батчимэг нарын 9 гишүүн санаачилсан байна.

13.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн нар санаачилсан байгаа.

14. Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Хог хаягдлын менежментийн санхүүжилтийн тогтолцоо, хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчныг сайжруулах талаар.

15.Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Ерөнхий боловсролын сургуулийн /ЕБС/ хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн төслийн хэрэгжилтийг хангах талаар. Ийм 15 асуудлыг өнөөдөр хэлэлцэх нь, нэлээн ачаалалтай чуулган болох нь өнөөдөр.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д "Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг холбогдох Байнгын хороодод хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд нарын 13 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа нарын 19 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

3.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлснийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

4.Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

5.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

6.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд /ТБХ/ тус тус хуваарилж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д Хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатанд санаачилсан хуулийн төслөө татан авч болно. Хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж тус тус заасан. Үүний дагуу хууль санаачлагчдаас хуулийн төслөө татан авах тухай албан бичгүүдийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулъя.

Хуулийн төсөл татан авах тухай. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна. Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав. Монгол Улсын Ерөнхий сайд гэсэн Засгийн газраас хуулийн төсөл авах бичиг ирсэн байна. Та бүхэнд танилцууллаа, татаж авлаа.

Хуулийн төсөл татан авах тухай 5 сарын 22-ны өдөр. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэгт хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатанд санаачилсан хуулийн төслөө татан авч болно гэж заасныг үндэслэн, 2025 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна. Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар гэсэн бичиг ирсэн байна. Хуулийн төслийг татаж авлаа.

Хуулийн төслийг татан, буцаах татах авах тухай 5 дугаар сарын 25-ны өдөр. Миний бие Улсын Их Хурлын гишүүн Анар, Баярмаа, Золжаргал нарын хамт Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Тус хуулийг хэлэлцэх эсэх талаар Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх явцад Улсын Их Хурал дахь Ардчилсан намын /АН/ бүлэг 5 хоногийн завсарлага авсан. Завсарлага авсантай холбогдуулан хуулийн хэлэлцүүлгийн үе шатууд хойшлох шаардлага үүссэн нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 81.1 дэх хэсэгт заасныг зөрчиж болзошгүй нөхцөл үүссэн, мөн Улсын Их Хурал дахь суудал бүхий улс төрийн намууд, нам, эвслүүдтэй зөвшилцөх цаг хугацааны боломжгүй болсон тул хууль санаачлагчийн хувьд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцааж татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна. Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир, Чинбатын Анар, Жудагийн

Баярмаа гэсэн бичиг ирсэн байна. Энэ бичгийг танилцууллаа. Хуулийн төслийг татан авлаа.

Нэг.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хэлэлцэх асуудалдаа оръё. Хууль, тогтоолын төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасан.

Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Энэ нөгөө Хот, тосгон байгуулах тухай хууль 06 дугаар сарын 01-ээс үйлчилж эхлэх ёстой, 06 сарын 01-нд хуулийг үйлчлэх, хэрэгжүүлэх боломжгүй болсон учраас хойшлуулах ийм хуулийн төсөл ирж байгаа юм байна. Байхгүй.

Хууль, тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Бэлэн бус гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсэж байна. Ирцийн санал хураалт, бүртгэлийн санал хураалт явуулна. Тийм болохоор ямар ч байсан бүртгэлдээ орох нь зөв байх. Ирцдээ орчхоод, бүртгэлдээ ороогүй, санал хураалтдаа бэлтгэж амжаагүй гишүүд 30 гишүүн байна. Санал хураалтдаа бэлтгэе. Алдаржавхлан, Алтанхуяг, Амгаланбаатар, Баасанжаргал, Бадамсүрэн, Батбаатар, Батболд, Батсүмбэрэл, Баярбаатар, Баярмаа, Ганбаатар, Ганзориг, Ганхуяг, Заяабал, Мөнхбат, Мөнхбаясгалан, Мэндсайхан, Номин, Отгонбаяр, Оюун-Эрдэнэ, Пүрэвдорж, Сайнзориг, Сандаг-Очир, Тэмүүлэн, Ундрэм, Үүрийнтуяа, Уянга, Хэрлэн, Цогтбаатар, Эрдэнэболд.

61 гишүүн болсон байна. Ирц, бүртгэлийн санал хураалт явуулъя. 57 гишүүн ирц, санал хураалтад бэлэн болсон байна. 29 гишүүн бэлтгэж амжаагүй байна. 29 гишүүн татгалзсан дээр гарч байгаа гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. Одоо санал хураалт явуулъя.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор

санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 34 гишүүн буюу 39.5 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Энэ санал хураалт дэмжигдээгүйтэй холбоотой ердийн горимоор хэлэлцэгдэх нь байна. Энэ яаралтай горимоор биш, ердийн горимоор хэлэлцэгдэх нь байна шүү гишүүдээ. 06 сарын 01-ээс энэ хууль үйлчилж эхлэх ёстой байсан одоо үйлчилж эхлэх нь байна. Хууль хоорондын жоохон зөрчил үүсэх нь. Үүнийг Засгийн газар болон Улсын Их Хурлын Тамгын газар хэрхэн, яаж зохицуулах шийдэл гаргая.

10.17 цаг

Зочин танилцуулъя. Монгол Улсын Их Хурал, Европын Парламент хоорондын 18 дугаар зөвлөлдөх уулзалтад оролцохоор Европын Парламентын гишүүн, Төв Ази, Монголтой харилцах бүлгийн дарга Жүси Принчи тэргүүтэй төлөөлөгчид манай улсад айлчилж байна. Эрхэм парламентын гишүүд та бүхэн Монгол Улсын Их Хуралд тавтай морилно уу. Монгол Улс Европын Холбооны гишүүн орнуудтай хөгжүүлж буй харилцаандаа чухал ач холбогдол өгдөг бөгөөд энэ хүрээнд Монгол Улсын Их Хурал, Европын Парламент хоорондын 18 дугаар зөвлөлдөх уулзалт амжилттай зохион байгуулагдсанд халуун баяр хүргэе. Та бүхний манай улсад хийж буй айлчлалд амжилт хүсэж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Дараагийн асуудалд оръё. Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням танилцуулна. Индэрт урьж байна.

Хоёр.Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Г.Дамдинням: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Путины Монгол Улсад 2024 оны 09 дүгээр сард хийсэн албан айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах тухай болон Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хэлэлцээрүүдийг байгуулсан.

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хэлэлцээрийн төсөлд нийлүүлэлтээс гадна татвар, хөрөнгө оруулалтыг тогтворжуулах заалтууд тусгагдсан. Иймд Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлж, гишүүдээс ирүүлсэн саналын дагуу Оросын Холбооны Улсын талтай нэмэлт хэлэлцээ хийсэн. Үүний үр дүнд хэлэлцээрийн үндсэн эх болон түүнд өөрчлөлт оруулах 6 зүйл бүхий протоколын төслийг эцэслэн тохиролцлоо. Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 81 дүгээр захирамжаар олгосон эрхийн дагуу миний бие 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Москва хотноо Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайд Сергей Евгеньевич Цивилёвтой тус протоколд гарын үсэг зурсан болно.

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлснээр дараах ач холбогдолтой нөхцөлүүд бүрдэх юм. 1 дүгээрт, Агаарын хөлгийн түлшний хангамж баталгаажиж, Чингис хаан олон улсын нисэх буудлын үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэх нөхцөл байдал

бүрдэнэ. 2 дугаарт, Олон улсын стандартад нийцсэн түлшийг дундын зуучлагчгүйгээр, зах зээлийн бодит үнээр шууд нийлүүлэлт хийх боломжтой болно. 3 дугаарт, Төрийн өмчит компани хамтарсан компани байгуулж, нисэх буудлын шатахуун хангамжийн байгууллагын үйл ажиллагааг хариуцан менежментийг удирдан зохион байгуулах боломжтой болох юм.

Дэлхийн геополитикийн нөхцөл байдал амаргүй байгаа энэ үед дээрх хоёр хэлэлцээр хамтдаа хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүн, түлш, шатахууны нийт хангамжийн аюулгүй байдалд онцгой чухал үүрэг гүйцэтгэнэ. Иймд агаарын тээврийн салбарын хөгжлийг дэмжих, шатахууны хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор боловсруулсан тус хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон батлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсад агаарын тээврийн хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 09 сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний талаар, хэлэлцээрт цогцолбор гэх нэр томьёо ашигласан боловч протоколд байгууламж гэх нэр томьёо ашигласан байгааг анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Жангабыл зах зээлийн болон биржийн аль үнэ ханшаар агаарын хөлгийн түлшний тооцох, агаарын түлшнээс бусад өөр төрлийн газрын тосны бүтээгдэхүүний асуудлаар гэрээ хэлэлцээр байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, дундын зуучлагчгүйгээр хамтарсан төрийн өмчит компани /ТӨК/ байгуулах талаар, төсөлд сав байгууламжийн асуудал туссан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбат энэ төрлийн гэрээ хэлэлцээр заавал хийх шаардлагатай эсэх талаар, бусад улсын сайн жишгийг судлах, түлш хадгалах сав байгууламжийн асуудлаар, Бүгд Найрамдах Казахстан Улсаас түлш авах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр хэлэлцээрийн нэр томьёоны алдаатай байдлыг засаж, нэг мөр болгох, өмчлөх асуудал тусгагдсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нэг эх үүсвэрээс түлш авахаас гадна олон эх үүсвэрээс авах асуудлыг судалсан эсэх, онгоцны билетийн үнэд өөрчлөлт орох эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбүрэн Байнгын хорооны хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргасан бөгөөд уг саналаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжээгүй болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбүрэн хэлэлцээрийг дэмжиж байгаагаа илэрхийлж, цаашид гэрээ хэлэлцээрийг тохирохоос өмнө Улсын Их Хуралд танилцуулж чиглэл авч байх, Улсын Их Хурлаас Засгийн газарт тодорхой чиглэл өгч байх, Оросын Холбооны Улстай хийх энэ төрлийн гэрээ хэлэлцээрийг хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ганбат гэрээ хэлэлцээр байгуулахдаа хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийг оролцуулах, Улсын Их Хурлын гишүүн Гантөмөр тодорхой нөхцөлтэйгөөр уг төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, Эгийн голын цахилгаан станцын асуудлыг яаралтай шийдвэрлэхэд анхаарах, газрын тосны бусад гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтэд анхаарах, цаашид Гадаад харилцааны яам хоёр талт болон олон улсын гэрээний асуудалтай холбогдуулан Улсын Их Хуралд урьдчилан мэдээлж байхад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар гишүүдийн хэлсэн саналыг анхаарч ажиллах, хэлэлцээрийн төслийн нэр томъёог жигдлэх, нэг мөр болгоход анхаарах талаар санал хэлсэн болно.

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүнд баярлалаа. Манай Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Тэмүүлэн гишүүн, Байнгын хорооны гишүүн Б.Мөнхсоёл гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагааг Европын Парламентын төлөөлөгчдөд маш сайхан, дэлгэрэнгүй танилцуулж байна. Хоёр гишүүндээ баярлалаа.

Хэлэлцэж буй асуудлын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Чулууны Хишигдалай тус яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар тус яамны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Гадаад харилцааны яамнаас Жамбалдоржийн Соёлмаа тус яамны Гэрээ эрх зүйн газрын захирал, Даваажавын Бат-Өлзий тус яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал, Дэлгэрцэцэгийн Өнөбилэгт тус яамны Хөрш орнуудын газрын дэд захирал.

Ажлын хэсгийн гишүүдэд хууль сануулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-т Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй. Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн

зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, холбогдох этгээдэд Төрийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байгаа шүү. Тийм учраас Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандахыг, гишүүдэд үнэн зөв мэдээлэл, бодитой мэдээлэл өгөхийг та бүхнээс хүсье.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү? Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар гишүүн асуултаа асууя. Б.Пүрэвдорж нэрээ татлаа. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, сая өөрөө Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулсан. Асуулт асууж, үгээ хэлье.

Д.Энхтүвшин: Энэ хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаа юм. Нэг санал хэлэх гэсэн юм. Байнгын хорооны хуралдааны явцад асуух асуултуудаа асуусан учраас нэг санал хэлэх гэсэн юм.

Энэ хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал дээр нэг өмнө хэлэлцээр дээрээ Чингис хаан ОУНБ-ын дэд бүтцийг удирдах болон ашиглах гээд энийгээ байгууламж гэж, цогцолбор гэж хэлж байсныгаа шинэчилсэн, өөрчлөн найруулахаар агаарын хөлгийн түлшээр цэнэглэх дэд бүтцийг гэж өөрчлөөд тэрийгээ байгууламж гэж хэлэхээр өөрчлөөд оруулсан байгаа. Гэсэн хэдий ч яг энэ хэлэлцээр дээрх байгаа цогцолбор гэдэг үгнүүдээ өөрчлөөгүй, Монгол хэл дээрээ. Тэгээд Орос хэл дээрээ комплекс гээд яг болоод ойлгоод явчхаж байгаа. Тэгээд Монгол хэл дээрээ байгууламж, цогцолбор гээд 2 өөр нэр томьёо ашиглаад явж байгаа. Тэгээд энийг бол ер нь яг ийм алдаа цаашдаа гаргамааргүй байна. Энэ олон улсын гэрээний тухай хуулийн 7 дугаар зүйл дээр хэрвээ энэ олон улсын гэрээг олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол хэлнээ орчуулж, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн орчуулгыг хянан баталгаажуулна гээд заачихсан байгаа.

Өөрөөр хэлбэл хоёрын хоёр яам үзэж харчхаад, тэгээд ийм алдаатай асуудлууд оруулж ирмээргүй байна. Орос дээрээ болж байгаа гээд Монголоо орхиж болмооргүй байна. Тэгэхээр ер нь цаашдаа иймэрхүү алдааг гаргахгүй байхыг энэ олон улсын гэрээ байгуулж байгаа яамнууд нь тэгээд ГХЯ-дууд дээр хэлэхийг хүсэж байна. Өмнө энэ бол нэг анх удаа биш, өмнө хэд хэдэн хэлэлцээрүүдээр нөгөө талынхаа саналыг илүү орчуулах байдалтай, Монгол агуулга адил хүчин төгөлдөр Монгол гэрээн дээрх үг агуулгууд нь ийм орчуулгын шинжтэй хагас дутуу орчуулсан байдалтай иймэрхүү дүр зургууд харагдаад байгааг цаашид анхаараарай гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Үг хэллээ. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

А.Ариунзаяа: Гадаад бодлого ер нь аливаа хэлэлцээр гэрээ, аливаа энэ зөвшилцөл УИХ-д эрх нь, бүрэн эрх нь байгаа. УИХ гадаад бодлогыг тодорхойлдог. Ерөнхийлөгч УИХ-тай зөвшилцөөд зөвшөөрөл аваад, аливаа юманд гарын үсэг зурж, Монгол Улсыг төлөөлдөг. ЗГ ч гэсэн УИХ-аасаа зөвшөөрөл авч байж, Ерөнхий сайд гэрээ хэлэлцээрүүдийг байгуулдаг. Аливаа энэ хэлэлцээрийг оруулж ирж

байхдаа зөвшөөрөл өгөхдөө бид зөвхөн дан ганц мэргэжлийн Байнгын хороогоороо ороод, хэлэлцээр хийх зөвшөөрөл өгөөд, эргээд тэр нь хэлэлцээр хигдсэний дараа УИХ-ын чуулганаар орж ирээд байгаа нь алдаа дутагдалтай байна гэдэг нь ажиглагдаж байна.

Яагаад гэхлээр мэргэжлийн байнгын хорооны зөвшөөрсөн асуудлыг чуулган дээрээ унагаах асуудал хэд хэд гарлаа. Энэ нь эргээд Монгол Улсын нэр хүндэд маш сөргөөр нөлөөлж байгаа гэдгийг бид анхаарах ёстой. Ийм учраас хэлэлцээр байгуулах зөвшөөрлийг бараг чуулганаар эхний ээлждээ хэлэлцэж байх ийм шаардлагатай гэж 1 дүгээрт үзэж байна.

2 дахь нь болохоор яг энэ агаарын хөлгийн түлш нийлүүлэх гэрээ өөрөө Монгол Улсад түлш тогтвортой нийлүүлэх хос гэрээний нэг юм шүү гэдгийг бид дахин анхаарч бодоосой. Энийг одоо бид зайлшгүй батлах ёстой. Энэ зүгээр нэг дээд дарга зөвшилцөөд шийдээд байгаа асуудал огт биш. Энэ Монгол Улсын иргэн бүрийн амьдралд хамааралтай буюу түлш тогтвортой нийлүүлж чадах уу, үгүй юү, түлшний үнийг тогтвортой барьж чадах уу, үгүй юү гэдэг ийм онцгой ноцтой асуудал явж байгаа шүү гэдгийг УИХ-ын гишүүд маань ухаарч, энэ гэрээг өнөөдөр зайлшгүй 64-өөрөө батлах ёстой шүү гэдгийг дахин, дахин хэлье.

Манай Орос Монголын найрамдлын парламентын найрамдлын бүлгийн дарга Пүрэвдорж УИХ-ын дэд дарга Орос улсад жилийн өмнө айлчилсан. Бид хос гэрээ байгуулна гэж амлачаад, гэрээ хэлэлцээрээ байгуулаад ОХУ Дум-рээ баталчихсан байгаа энэ асуудлыг манай улс нэг гэрээг нь явуулаад, нэг гэрээг нь батлаагүй. Тэгээд Пүрэвдорж гишүүн очиход дээд Дум-н дарга ч, доод танхимын ч дарга энэ асуудлаа та нар буцсан шүү гэдэг асуудлыг хэлсэн. Дараад нь Амарбаясгалан УИХ-ын дарга байхдаа бид Женевт ОУПХ-ны хуралд очиход мөн Дээд, доод танхимынх нь дарга нар нь яг энэ асуудлыг ярьсан.

Дараа нь Учрал Ерөнхий сайд УИХ-ын дарга байхдаа Орост айлчлахад мөн яг энэ асуудлыг ярьсан. Ийм учраас бүхий л түвшиндээ Монгол Улс өөрөө хэлсэн үгнээсээ буцсан гэдэг ийм асуудалд орж байгаа. Энэнээсээ гадна ОХУ өөрөө хүнд нөхцөл байдалд байгаа ч түлшээ өгч байгаа гэдгийг бид анхаарах ёстой. Зайлшгүй 64-өөр.../минут дуусав/

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Үг хэлчихлээ. Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Ариунзаяа гишүүндээ нөхцөл байдлыг ойлгож нэг энэ маш хүнд байгаа нөхцөл байдлын үед зөв мэдээлэл өгч байгаад их баярлалаа. Ер нь бол 2 хэлэлцээр хамтдаа хүчин төгөлдөр болох юм, 1990 оноос хойш бид ингээд шинэ тогтолцоонд шилжсэн цагаас хойш хувийн хэвшлүүдийн хамтын ажиллагааны хүрээнд л явж байсан энэ түлш шатахууны харилцаа. Энэ бол аж ахуйн зарчмаараа, бизнесийн зарчмаараа явна гэж бид үзэж явсаар гучаад жил өнгөрсөн байна. Тэгээд энэ бол анх удаагаа ОХУ-аас Монгол Улсад түлш шатахууныг тасралтгүй нийлүүлэх үүрэг хүлээсэн ийм хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох нөхцөл бүхий хэлэлцээр юм байгаа юм.

Тэгээд одоо бол бид ОХУ дотооддоо хомсдолтой байгаа ч манай хэрэглээг бол ер нь 97 хувь хүртэл бүрэн хангаад ингээд явж байгаа бид талархалтай хандах ёстой. Тэгэхээр энэ хэлэлцээрийг бүгдээрээ нэг ойлгоод дэмжээд өгөөч л гэж хүсье. Зүгээр өнгөрсөн хавар УИХ-ын чуулганаар орж юу, Байнгын хороодоор орж ирээд

гишүүдээс авсан саналын хүрээнд дахин нэмж сайжруулж хэлцэл хийж, протокол батлаад орж ирж байгаа гэдгийг дахин хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

П.Сайнзориг: Хэлэлцээрийн төслийг соёрхон батлах хуулийн төслийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгэхдээ энд нэг зүйлийг хэлье. Бид хэд 64-өөрөө батлах үүрэгтэй шүү, ёстой шүү л гэж байна. Ариунзаяа дарга маань цаад талын ач холбогдол, үр дагаврыг нь тооцоод л ингэж хэлээд байгаа юм. Тэгэхдээ ЗГ тухайн үедээ ажлаа олигтойхон хийчихсэн бол энэ асуудал явчих байсан байхгүй юу. Би хэн нэг сайдыг буруутмааргүй байна. Яг энэ ажил хариуцаж байгаа нөхдүүд маань орчуулга, ганц нэг заалтууд Монголд Монголын талд ашиггүй байсан шүү дээ. Энэ нөхцөл байдлуудыг нь харгалзчихсан бол ингэж цаг алдаж, гадаад харилцааны асуудал дээр эргэж буцсан ийм зүйл бол гарахгүй байсан юм 1 дүгээрт энийг хэлмээр байна.

2 дугаарт би Дамдинням сайдаас нэг асууя. Энэ гэрээний ач холбогдлыг та нэг олон нийтэд хэлж өгөөч. Ер нь Монголын талд ямар ач холбогдолтой юм бэ? Энэ агаарын хөлгийн шатахууны асуудал дээр нийлүүлэлт тогтворжих уу, үнийн хувьд тогтвортой байж чадах уу? Энэ нь эргээд энэ Монгол Улсын гадаад ертөнцтэй харилцаж байгаа энэ агаарын тээврийн тариф билетийн үнэ өртөгт ямар байдлаар нөлөөлөх вэ, энийг тогтвортой байдлаар үлдээж чадах уу гэдэг дээр агуулгын хүрээнд та нэг ач холбогдол талаас нь хэлж өгөөч?

2 дугаарт энэ ер нь агаарын хөлөг гэлтгүй бид хэд энэ нефть боловсруулах үйлдвэрийн асуудлаа шуурхайлахгүй бол энэ гадаад худалдааны тэнцэл дээр чинь хамгийн их нөлөөлж байгаа юм энэ байгаа шүү дээ. Тэгэхээр энийг нэг олон нийтэд өгчхөөч, хэлээд өгөөч. Ер нь хэд болчхоод байна. Энэ сүүлийн үед чинь 1 тэрбум доллар гардаг байсан бол одоо энэ чинь бараг 2 луу дөхөж байна, 1,8 руу дөхөж байна гэсэн сүүлийн мэдээлэл би бол авч байсан. Ийм байдалд орчхоод байгаа шүү ард түмэн. Тийм учраас энэ нефть боловсруулах үйлдвэрийг бид шахаж шаардаж, яаралтай ашиглалтад оруулах ёстой. Сая УИХ-аас бодлогын хувьд дэмжээд энэ Гадаад зээлийн үр ашгийг дэмжих хуулийг ингээд батлаад өглөө. Тэгээд тэнд ажил хариуцаж байгаа хүмүүсээс л хариуцлага нэхэхээс өөр арга байхгүй. Энийг нэг тоо статистикийн хувьд та нэг хэлээд өгөөч?

Би нэг санал бол байна. Энэ дээр Хэрэг эрхлэх газрын дарга хариулах юм уу, яах юм би мэдэхгүй байна. Энэ гадаад худалдаа ялангуяа энэ шатахууны асуудлыг Гадаад хэргийн яам нь хариуцдаг байвал яадаг юм бэ? Энэ чинь гадаад худалдааны чиг үүрэг нь тэнд байгаад байгаа байхгүй юу. Батцэцэг сайд дээр байна гэж би ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд энэ асуудлыг ер нь Гадаад хэргийн яам нэг байдлаараа цогц байдлаараа авч явдаг юм уу, яадаг юм. Тэгээд яг үнэндээ хэлэхэд энэ УУЯ-тай энэ холбоотой ч юм уу, үгүй юу. Дотооддоо үйлдвэрлээд ирвэл Дамдиннямын асуудал болж магадгүй. Яг орж ирээд энэ хэрэглэгч ОХУ-аас орж ирээд хэрэглэгч аваад явж байхад энд нэг их УУЯ-ны ч асуудал гэхээсээ илүүтэй уг нь гадаад худалдаа. Энийгээ тэгээд тэр стандарт хяналтыг нь тавьдаг газар нь.../минут дуусав/

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя, ажлын хэсэг.

Г.Дамдинням: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Чухал асуудлууд асууж байна. Ингээд Украины нөхцөл байдал, Ормузын хоолойн нөхцөл байдлаас шалтгаалаад манай улс газар зүйн байрлалын хувьд ерөөсөө хоёрхон том хөрштэй. 2 хөршийн маань газар нутаг маш том. Гуравдагч орноор дамжуулж газрын тосны бүтээгдэхүүн авна гэдэг маш бэрхшээлтэй ийм л нөхцөл байдалтай байдаг. Дотооддоо тэр үнийн хязгаарлалт, аюулгүй байдлын хязгаарлалт гээд. Ялангуяа энэ агаарын хөлгийн түлш аль, аль улсынх нь хувьд цэрэг дайны зориулалттай стратегийн бүтээгдэхүүн болж хувирдаг учраас дээгүүрээ тээвэрлүүлэх асуудал нь их бэрхшээлтэй байдаг.

Тэгэхээр бид хүссэн, хүсээгүй энэ 2 хөршөөсөө авч таарна. Тэгээд сүүлийн үед бид энэ ЗГ хоорондын хэлэлцээргүй байгаад байгаа учраас манай хойд хөрш бол жишээ нь энэ экспорт дээрээ шууд мэдэгдэхгүйгээр хориг тавьчихдаг болчихоод байгаа юм. Мэдэгдэхгүйгээр дотоодын нөхцөл байдал, хангалтаасаа шалтгаалаад хориг тавигдахад ЗГ хоорондын хэлэлцээртэй улс орнуудтай яг хэлэлцээрийнхээ дагуу нийлүүлж байгаа. ОХУ сайн хөршийн харилцааны хувьд биднийг энэ хэлэлцээртээ үнэнч байна гэж итгэж байгаа учраас гэж томьёолж хэлж бидэнд хэдийгээр гэрээгүй байгаа ч гэсэн нийлүүлдэг, тасралтгүй нийлүүлж байгаа юм.

Зарим үед ний нуугүй хэлэхэд олдож байгаа нь их юм болж байна түлш шатахуун. Европын холбоо, Зүүн өмнөд Азийн орнууд агаарын хөлгийн компани, агаарын тээврийн компаниуд бол маш ихээрээ дампуурч байна. Дотоодын нислэгүүдээ зогсоож байна. Тэгээд энэ агаарын хөлгийн түлш манай улс яг одоогийн байдлаар гэхэд дэлхийн зах зээлийн үнэ нэг тонн нь 1600 орчим доллар байна. Бид 1200 орчим доллароор авч байгаа. Тасалбарын үнэд 30-аас 40 хувийн нөлөөлөлтэй гэж ЗТЯ-ныхан маань бидэнд мэдэгддэг. Тэгэхээр бид яаж ч байсан эндээс бол давуу байдал олж байгаа юм энийг ойлгож хүлээж аваарай.

Манай ачаа эргэлт 21 хувь, зорчигч эргэлт 15 хувь өсөж байгаа жил болгон, жил болгон. 2,3 сая зорчигч өнгөрсөн жил зорчсон байна лээ. Нефтийн бүтээгдэхүүн дээр бид хэр их ачаалал үүрч байгаа гэвэл бид 2,1 тэрбум долларыг нефтийн бүтээгдэхүүнд зарцуулж байна. 3 сая тонн нефтийн бүтээгдэхүүн хэрэглэдэг болсон. 2025 онд бид, 2024 онд бид 2,8 9 орчим байсан бол одоо 2026 онд бид 3,1 сая руу хүрнэ. Уул уурхай үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдээд өнгөрсөн онд бид 2025 оны гүйцэтгэлээр 90 сая тонн нүүрс экспортолж байсан бол 2026 онд бид 100 сая хүргэнэ. Энэ бол тэгээд л цэвэр татварын орлого, цалин, тэтгэвэр нэмэх эх үүсвэрийг бүрдүүлэхэд түлш шатахууны л тасалдалгүй байдал маш чухал байгаа учраас энэ чинь чухал байгаад байгаа юм.

Газрын тосны үйлдвэр маань санхүүжилтээ бүрэн хийж чадахгүй зээл нь байгаад байдаг, төсөл нь байгаад байдаг, ажлаа хийх гэхээр төсвийн хязгаарт ороод байсныг та Их Хурлын гишүүд маань ойлгож чөлөөлж өгсөн. Бид тоног төхөөрөмжүүдээ бол бүрэн хэмжээгээр захиалаад, ажлаа эрчимжүүлээд явж байгаа. Нэг зүйлийг ташрамд хэлье. Энэ үе үеийн ЗГ сайд нарт ирж байсан асуудлуудыг үе үеэрээ Монгол төрийн залгамж чанарын хүрээнд бид бүхэн бүгдээрээ хамтраад л эцэслээд оруулж ирж байгаа ийм зүйл юм шүү гэдгийг зориуд цохон тэмдэглэе. Баярлалаа.

С.Бямбацогт: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя, үг хэлье.

С.Эрдэнэбат: Энэ дайны нөхцөл байдалтай дэлхий нийт ийм хямралтай үед бол яах аргагүй маш чухал хэлэлцээр гэж харж байна. Оросын тал ч гэсэн өөрийнхөө дотоод үнээс хямдхан үнээр бараг манай Монголд нийлүүлж байгаа. Энэ урьдчилсан арга хэмжээ авсны л үр дүн гэж би харж байгаа. Гэхдээ энэ хэлэлцээртэй холбоотой хэд хэдэн зүйлийг тодруулаад асуумаар байна. Хамтарсан байгууллага байгуулна гэхээр энэ хэд хэдийн харьцаатай компани байгуулах юм бэ? Гэрээний хугацаа 20 жил гэж байна, 10, 10-аар ч юм уу ингээд сунгаад явах боломж, бололцоо байхгүй юу?

3 дугаарт маргаан гарсан тохиолдолд ОХУ-ын Арбитрт хандана гэж байна л даа. Тэгэхээр эсхүл хөндлөнгийн гэдэг юм уу, ийм гуравдагч орны ч гэдэг юм уу ийм зүйл дээр байх боломж, бололцоо байгаагүй юм уу? Эсхүл мэдээж Оросын талын ХАҮТ-ын дэргэдэх арбитраар орно гэдэг бол тэр талд шийдэгдэх магадлал нь бол илүү өндөр болно. Ийм зүйл байна.

Түрүүн тэр Эгийн голын УЦС-тай холбоотой ярьсан, ер нь ОХУ-тай холбоотойгоор 2 орны хамтарсан хөрөнгө оруулалт энэ зүйлийг дэмжихэд энэ үеэр яригдсан асуудлууд бий юү? Хамтарсан нөгөө нэг эко юуны судалгааг хийнэ гээд л орхисон хамгийн сүүлд. Тэгээд энэ тал дээр яах вэ, энэнтэй шууд холбоогүй ч гэсэн түрүүн сайд энэ талаар дурдах шиг боллоо. Энэ талаар нэмэлт мэдээлэл байвал өгөөч ээ гэж хүсмээр байна.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя, Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Хамтарсан компани байгуулах асуудал бол олон жил яригдаж байгаа асуудал юм байна лээ. Тэгээд өмнө нь ОХУ-ын талтай хийсэн санамж бичгийн хүрээнд 60-ыг харьцах 40-ийн харьцаатай ийм компани байгуулна гээд тогтсон. Бид энэ хэлэлцээрийг соёрхон баталчихвал дараа нь бид шууд үргэлжлүүлээд гэрээ хэлцлийнхээ ажлуудад ингээд ороод явна. Тогтсон зарчмынхаа хувьд бол 60 40-ийн харьцаатай, Монгол Улсын тал 60 хувийг эзэмшинэ, энэ бол өмч эзэмшихгүй компани шүү, энэ бол зөвхөн менежмент хэрэгжүүлэх компани шүү. Тэрийг ойлгож хүлээж аваарай гэж хүсье.

2 дугаарт ОХУ, Эрдэнэбат гишүүн та нөгөө нэмэлт, өөрчлөлтийнх нь протоколыг нь хараагүй байх шиг байна. Энэ танилцуулгын урд талын нүүрийн 2 дахь хэсэг дээр байгаад байх шиг байна лээ. ОХУ-ын Арбитраар гэсэн саналаар өнгөрсөн хавар УИХ-аар орж ирсэн. Ингээд УИХ-ын холбогдох Байнгын хороодоос УИХ-ын гишүүдийн санал гараад, бид бүхэн нэмэлт хэлэлцээр хийгээд ирсэн нь энэ юм байгаа юм. Тэгээд бид Казахстан гэдэг болон Беларусь гэдэг санал манай талаас тавигдаж, Беларусаар нь асуудал шийдэгдсэн. Беларусь тусгаар тогтносон, манай улстай найрамдалт харилцаатай улс байгаа. Ингээд гуравдагч орны арбитраар шийдүүлнэ гэж шийдэгдсэн.

Дараачийн асуудал гэрээний хугацаа 20 жил байсныг нэмэлт хэлэлцээр хийсний үр дүнд 15 жил болгож сольж наашлуулсан ийм хэлэлцээр байгаа. Эгийн голын УЦС-тай холбоотой асуудал дээр хариуцсан сайд нь мэдээлэл хийсэн нь зөв болов уу гэж бодож байна. Надад одоогийн байдлаар дэлгэрэнгүй мэдээлэл алга байна.

С.Бямбацогт: Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Ганбаатар: Ганц асуулт асууя. Уул нь бол өмнөх ЗГ бол энэ асуудлыг компани хоорондын гэрээгээр зохицуулаад яваад байж болсон юм л даа. Ямар нэгэн асуудал үүсгэхгүйгээр. Ингээд Их Хурал руу оруулаад ирнэ. Тухайн үед бол яах вэ ЗГ юу гэж үзэж байсан бэ гэхлээр энэ бизнесийн харилцаа компани хоорондын, энийг ингээд сайдаа, тэгэхлээр энийг ингээд боломжтой гэж өмнөх ЗГ бол үзэж байсан л даа. Тэгээд шийдээд болоод байсан юм. Энэ чинь ахиад нэг шинэ компани байгуулах гэж байгаа юм уу, үгүй юм уу? Энэ компани нь аль хэдийн байгуулагдаад, Эрдэс ойл гэдэг компани байгуулагдаад энэ чинь их олон жил явж байгаа шүү дээ. Дамдинням сайд ахиад нэг хамтарсан компани байгуулах гээд байна уу, эсхүл Эрдэс олио хэлээд байна уу?

Би өөр дээр чинь байж байгаа зарим зүйлүүдийг бол ойлгож л байна л даа. Энэ их хүнд хэцүү цаг үед зарим зүйл дээр яахгүй бол болохгүй л байх. Гэхдээ өмнөх ЗГ-т юу хийж байсан юм бэ гээд зарим сайдууд асуугаад байх шиг байна. Тэр бол энэ чинь компани хоорондын асуудал Их Хурал руу хамаагүй давж оруулаад байдаггүй шүү гэдгийг. Тэр үед Хүрэлбаатар сайд юуны юу байсан л даа ЗГ хоорондын юуг ахалж байсан юм. Би УУЯ-наас юуны ГХЯ-наас асууя. Энэ бодлого эрс өөрчлөгдчихсэн юм уу, эсхүл шинэ зүйл нөхцөл байдал үүссэн үү гэдгийг асууя? Баярлалаа.

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Жамбалын Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгээд зовлон үзсэн хүн шүү дээ, та ойлгож байгаа байх, тэрийгээ хэлж байгаад их баярлалаа. Тэгээд энэ асуудал бол ний нуугүй хэлэхэд мэдэхгүй харилцааны л асуудал баймаар санагдаад байдаг юм. Тэгээд манай УУЯ хуулиараа ингээд хүлээх үүрэгтэй болохоор. Үнэхээр хүнд шүү, та бол мэдэж байгаа. Таны үед ОХУ юу ч хэлэлгүй гэв гэнэт 3 сар түш ямар ч шатахуун нийлүүлэхгүй хааж байсан. Одоо тэгээд энэ дайны нөхцөл байдалтай дотооддоо хомсдолтой үед хувийн ААН-үүдийн гэрээ хэлцэлтэй байгаа үед шууд хаачхаад байгаа юм экспортоо. Зөвхөн ЗГ хоорондын хэлэлцээртэй улс орнууддаа л өгч байгаа, өөрсдөө шууд хэлдэг, бид дотоодынхоо мужуудад хүргэж чадахгүй байж танайд өгч байгаа шүү, энийг ойлгоорой гэж.

Тэгээд энэ гэрээ, ЗГ хоорондын хэлэлцээр хийчихвэл бид эргээд цаг тухай бүр ингээд л ... нисэж ирээд л, ЗГ хоорондын асуудал яригдаад л, Ерөнхийлөгч яриад л, Ерөнхий сайд яриад бужигнаад байна. Яг үнэнээ хэлэхэд бид бол аргацаасаар байгаад л өдий хүрсэн. Тэгэхээр одоо бид энэ нөхцөл байдал туйлын эвгүй байгаа үед энэ хэлэлцээрээ хийж, ер нь нэг аливаа хориг саадад орохгүй байх ийм нөхцөл байдлаа бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

2 дугаарт бол тэр шинэ компанитай холбоотой асуудал яригдана. Өөрөөр хэлбэл би түрүүн тодотгож хэлсэн. Юу вэ гэхээр энэ компани бол өмч эзэмшихгүй, зөвхөн менежмент хэрэгжүүлэх компани болох юм. Тэгэхээр Эрчис ойл гэдэг компанийн 60 хувийн эзэмшилтэй, ОХУ-ын РН Аэро /RN-Aero/ гэдэг компанийн 40 хувийн эзэмшилтэй хамтарсан менежментийн компани энэ ажлыг хэрэгжүүлж явах юм. Тэгэхээр ийм л зохион байгуулалтаар бид ажиллахаар тохиролцсон явж байгаа. Тийм, тийм.

С.Бямбацогт: Ажлын хэсэг ГХЯ хариулъя. Индрийн 4 дүгээр микрофон.

Ж.Соёлмаа: ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын захирал Соёлмаа байна. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. ОХУ-ын дотоодын зах зээл, газрын тосны үнэ тогтворгүй болсонтой холбогдуулаад тухайн улсын ЗГ-аас 2023 оны 09 сарын 01-нд тогтоол гаргаад хязгаарлалтуудыг яасан. Тухайн хязгаарлалтууд дээр болохоор ЗГ хоорондын хэлэлцээргүй улсуудад бол тодорхой хязгаарлалтын дагуу газрын тосны түлш нийлүүлэх ийм тогтоол гарсан. Үүний мөрөөр Монголын тал хэлэлцээ хийгээд, 2024 оны 09 сард ОХУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын хүрээнд 2 ЗГ-ын хоорондын хэлэлцээрийг байгуулсан байгаа. Нэг нь бол газрын тосны бүтээгдэхүүнийг саадгүй хүлээж авах, нөгөөх нь болохоор агаарын хөлгийн түлш нийлүүлэх гэсэн ийм 2 хэлэлцээр байгуулсан. Агаарын хөлгийн түлшний хэлэлцээрийн хувьд гэвэл Байнгын хорооны хэлэлцүүлгийн үеэр гишүүдээс нэмэлт, өөрчлөлт оруулах, сайжруулах 5-аас 6 санал гарсан. Тэр саналын дагуу байгуулсан хэлэлцээртээ Оросын талтай дахин хэлэлцээ хийгээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчих уу? 4 дүгээр микрофон.

Ж.Соёлмаа: Гишүүдийн гаргасан тухайн саналын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын ахалсан ажлын хэсэг Оросын талтай 2 жилийн хугацаанд хэлэлцээ хийгээд тухайн сайжруулалтыг шинэ нэмэлт, өөрчлөлт бүхий протоколд оруулж чадсан. Тэгэхээр Ганбаатар гишүүний асуусан энэ агаарын хөлгийн түлшний нийлүүлэх ЗГ-ын хоорондын хэлэлцээрийн хувьд гэвэл гол зорилго нь ерөөсөө талууд итгэмжилсэн байгууллагаар дамжуулаад агаарын хөлгийн түлш нийлүүлэх, мөн хамтарсан компанийн үйл ажиллагаа эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилготой ийм товч энэ 10 заалт бүхий ийм гэрээ байгаа юм.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Ж.Ганбаатар: Яах вэ асуугаад яах вэ дээ, тэгэхдээ нэлээн хэд хэдэн ноцтой заалтууд байсан шүү, тэгээд анхааруулж хэлье. Тийм заалтууд байсан учраас өмнөх ЗГ-ын үед Их Хурал руу оруулдаггүй, компани хоорондын хэлэлцээрээр зохион байгуулаад яваад болоод байсан шүү гэдгийг хэлье. Тэгэхдээ мэдээж нөхцөл байдлыг ойлгож байгаа. Гэхдээ зүгээр ахиад сануулж хэлэхэд иймэрхүү компани хоорондоор зохицуулах асуудлыг бүх улсууд Их Хурал руу оруулдаг ийм жишиг тогтож болохгүй шүү. Дээрээс нь заалт дотор анхаарууштай заалтууд байгаа шүү. Анхаараарай, засаарай, гэхдээ нөхцөл байдлыг ойлгож байна, амжилт хүсье.

С.Бямбацогт: Үг хэллээ, баярлалаа. Салдангийн Одонтуяа гишүүн асуултаа асууж, үг хэлье.

С.Одонтуяа: Энэ уг төслийг, хэлэлцээрийг дэмжиж байгаа. Маш олон гишүүд Эдийн засгийн байнгын хороо болон сая чуулган дээр Эгийн голын УЦС-ын талаар асууж байна. Би энэ дээр товч мэдээлэл өгье гэж бодож байна. 2024 оны 08 дугаар сард Ерөнхий сайдаас надад албан даалгавар өгсөн. Эгийн голын УЦС-ын ажлыг эхлүүлэх, шаардлагатай бэлтгэл ажлыг хангах гэсэн ийм үүрэг даалгавар 2024 оны 08 дугаар сард өгөгдсөн. Ингээд 2024 оны 09 дүгээр сараас эхлээд санамж бичиг байгуулах, энэ бүх хуралдаанууд, хамтарсан экспедицийн ажлууд бол ингээд яг хуваарийн дагуу хийгдэж байгаа.

Хүмүүс нэлээд асуудаг юм. Энэ манай газар нутаг дээр баригдах станц яагаад заавал бид ОХУ-тай ингээд хамтарсан ийм баг ажиллах ёстой юм бэ гээд. Энэ дээр хэд хэдэн тайлбар өгье. Ер нь энэ хил дамнасан усны асуудал бол зөвхөн

нэг орны асуудал биш байдаг. Өөрөө Байгаль нуур нь дэлхийн цэнгэг усны 20 хувийг дангаараа бүрдүүлж байдаг ийм чухал асуудал учраас дэлхийн ЮНЕСКО, Дэлхийн өвд бүртгэгдсэн байдаг. Тэгэхээр энэ 1 дүгээр асуудал байгаа. 2 дугаарт Байгаль нуурт цутгадаг голуудын 50 хувийг Сэлэнгэ мөрөн дангаараа бүрдүүлж байдаг учраас яах аргагүй энэ хамтарсан баг гарч бол ажиллах ийм шаардлага гарсан. Ингээд ОХУ-ын ШУА, манай Монгол Улсын ШУА-уд бол энэ ажлыг төлөвлөгөө гаргаад ингээд ажиллаж байгаа.

Сая 7 дугаар хуралдаан хийгдсэн, энэ 26 онд багтааж энэ байгаль орчны экологийн дүгнэлт эцэслэж гарах юм. Өмнө нь бол хэд хэдэн 2 тал ийм зөрөөтэй байр сууриуд байсан, 2 талд 60 хэдэн оноос хойш маш олон судалгааны ажлууд байсан, энийг нэгтгээд нэгдсэн ийм дүгнэлт гаргах юм байгаа юм. Тийм учраас энэ нэгдсэн дүгнэлт гаргаад, байгаль экологийн нарийвчилсан, нийгэм, эдийн засгийн байгаль орчны үнэлгээ гарсны дараа энэ Эгийн голын УЦС-ын яг эхлэх ажиллагаа бол шийдэгдэх юм. Тэгэхээр энэ дээр бол манай академийн удирдлагууд, манай Рэгдэл гишүүн бид хэд бол УИХ-ын гишүүнийхээ хувьд энэ дээр анхаарал тавиад энэ асуудлууд дээр нь ингээд ажиллаж байгаа юм. Өнөөдрийн байдлаар тэр 71 судлаач нийт 80 гаруй шинжилгээ судалгааны ажлуудыг бол Эгийн голын УЦС баригдах тэр орчимд нарийвчлаад ингээд хийгдэж байгаа, бүх багаж хэрэгсэл, тэр шаардлагатай төсөв хөрөнгүүдийг шийдүүлээд ингээд ажиллаж байгаа гэдгийг мэдээллийг өгье.

С.Бямбацогт: Үг хэллээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Ганбаатар: Дэлхий нийтээрээ нефть, газрын тосны бүтээгдэхүүний талаар их хямралтай, хүнд байгаа. Энэ хүнд хэцүү цаг үед Дамдинням сайд бол зохион байгуулалтаар сайн хангаж энэ байдлыг бол гадарлаж байна. Ойлгож байна. Би УУЯ, эрдэс баялгийн яам гэхээсээ илүү бусад яамнуудаас, Эдийн засгийн яам, Гадаад байдлын яамнаас, Сангийн яамнаас асуулт асуух гэсэн юм. Уул уурхай, эрдэс баялгийн яамнаас бол нэг л асуулт байна. Нефть импортлогч үндэсний компаниудтайгаа зөвлөлдсөн үү, тэднээсээ ойлголт авч тэднүүсийнхээ зөвшөөрлийг авсан уу? Энэ чинь Үндсэн хуулийн 5.4 дээр эдийн засгийг төрөөс зохицуулна гээд төрийн зохицуулалттай эдийн засаг явж байгаа. Тэгэхдээ хувийн хэвшлээ дандаа ад үзэж болохгүй. Энэ талаар асуулт асууж байна, хариулъя.

2 дугаарт, Гадаад явдлын яамнаас асууя. Энэ ЗГ-ын хоорондоо шууд ингээд гэрээлж нефтийн талаар хэлэлцээр хийдэг ямар орон байгаа вэ? Миний мэдэхийн Станы 2 орон байгаа. Энэ талаар судалгаа хийсэн үү? Өнөөдөр бид ямар нэгэн баффер зон (Buffer zone)-гүй болчихлоо шүү дээ. Зүгээр тэр компани хоорондоо харилцаад тэндээ хэрүүл маргаанаа хийдэг байхад ЗГ хоорондоо шууд тулж байна гэсэн үг. Энийг ГХЯ яагаад энийг оруулж, энэ зүгээр үү, хэвийн үү? Бид энэ нефть гэдэг бол геополитик шүү дээ. Геополитикийн ямар нэгэн асуудал та энэ дээр гаргалгаа байгаа юу? Станы орнууд дээр энэ ЗГ хоорондын хэлэлцээртэй Станы орнуудад бүүр нефть нь Оросоос илүү үнэтэй, Монголоос 2 дахин үнэтэй байгаа тохиолдлууд байгаа. Судалгаа хийсэн үү?

3 дугаарт, айлаас эрэхээр авдраа ухаа гэдэг, урд хөл бүдэрвэл хойд хөлийг ташуурдана гэдэг шиг юм л бол тэгээд Эрдэс баялгийн яамыг л ташуурдаж байдаг. Нарийн яривал энэ чинь ГХЯ-ны гадаад хэлэлцээр. Би 3 дахь асуултаа Эдийн засгийн яамнаас, Сангийн яамнаас асууя. Айлаас эрэхээр авдар ух. Нөгөө нефтийн

үйлдвэр юу болов? Сая Алтанцэцэг захирал, тэр хариуцаж байгаа захирал нь 480 сая доллар орж ирсэн юм шиг байна лээ. 1,7 тэрбум доллар шүү дээ Энэтхэгийн. Хаашаа орсон нь мэдэхгүй гэж хэлсэн. Хаашаа орчхов? Энэ аль данс руу, хэзээ, хэдэн онд, хэдэн сард яг огноог нь хэлээд, хэзээ орж ирсэн бэ гэдгийг нь надад хэлээд өгөөч. Тэгээд хаашаа зарцуулагдсан. Нөгөө хариуцаж байгаа хүн чинь энэ байхгүй байна гэж хэлээд байна шүү дээ.

Өнөөдөр 1,7 тэрбум доллароор, тэгээд дээр нь нэмээд 1,2 их наяд төгрөгөөр дотоодын маш олон зээлүүдээр энэ нефтийн үйлдвэр босно гээд яваад, мөрөөдөл дээр бидний мөрөөдөл дээр тоглож байна. Ус байхгүй, нефтийн нөөц байхгүй, тэр хэлэлцээрүүд хийгдсэн үү? Дотоодоос хангах нефть Дачин Тамсагаас хийсэн үү?

С.Бямбацогт: Ажлын хэсэг, Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Надад хандаж бол манай яамтай холбоотой асуудал дээр хариулъя. Тэгээд юуны асуудал байгаа Хууль тогтоомжийн тухай хуулиараа бид олон нийтэд мэдээлж энэ хуулийг хэлэлцүүлсэн. 2 дугаарт салбарын бүх холбоодоос санал авч дэмжсэн. Шатахуун импортлогчид болон төр засгийн байгууллагуудын хамтарсан үнийн зөвлөл гэж байдаг. Тэр үнийн зөвлөл дээрээ ч энэ асуудлуудаа яриад, нөхцөл байдлаа ойлгож хамтарч ажиллахаар ингээд ярилцаад ойлголцчихсон байгаа. Хувийн хэвшлээсээ бол зөвшөөрөл авсан, ярилцсан.

С.Бямбацог: Гадаад явдлын яам, ажлын хэсэг 4 дүгээр микрофон хариулъя.

Д.Өнөбилэгт: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. ГХЯ Хөрш орнуудын газрын дэд захирал Өнөбилэгт байна. Энэ 22 оноос хойш үүссэн нөхцөл байдал, цэргийн тусгай ажиллагаа явуулсантай холбогдоод л ОХУ-ын зах зээлд өөрөө өөртөө өөрөө болохоор дотоодынхоо хэрэгцээг хангаж чадахгүй байгаа тодорхой шалтгаануудын улмаас саяхан гэхэд л ойрын хугацаанд тэр хориггоо дахиад шинэчлэн сунгах асуудал яригдаад эхэлсэн байгаа. Энэ үед бол ОХУ-аас ЗГ-ын гаргадаг тогтоол нь болохоор хугацаатайгаар хориг тавьдаг, аливаа нефть бүтээгдэхүүнийг хилийн чанадад гаргахыг хориглодог. Дотоодын хэрэгцээг хангах үүднээс. Энэ нөхцөлийг урьдчилан сэргийлэх үүднээс ЗГ хоорондын хэлэлцээр байгуулж, аливаа нэгэн импортлогч компанийг бол эрх ашгийг нь хязгаарлахгүйгээр, нийлүүлэх боломжийг хангах, ЗГ-ын түвшиндээ хангах юуг бол олгодог юм. Тэгээд гишүүний хариулсан асуултаар бол Агаарын түншлэлийн хэлэлцээрийн хувьд болохоор өнөөдрийн байдлаар ОХУ-ын Роснефть Аеро болохоор Бүгд Найрамдах Хятад.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа гүйцээгээд хариулчихъя.

Д.Өнөбилэгт: Хятад Ард Улс, Турк, АНЭУ, Испани зэрэг компаниудын улсууд Бээжин, Үрүмч, Стамбул, Дубай, Барселона хот зэрэг тус буудалд Оросын болон олон улсын агаарын түншүүдийг түншээр хангах, цэнэглэх гэрээнүүдийг тухайн улсын оператор компаниудтай байгуулан ажиллаж байна. Мөн ХБНГУ-ын Роснефть Дойчланд гэдэг охин компаниар дамжуулан Берлин, Мюнхен нисэх буудлуудыг үйлдвэрийн Jet A-1 түншээр шууд нийлүүлж байгаа туршлагатай компанитай ингээд гэрээ хэлэлцээр байгуулсан байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэгт ГХЯ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам орж байгаа. Тийм болохоор энэ ажлын хэсгээс л асууна. Ажлын хэсэг саяын Ганбаатар гишүүний асуултад гүйцэд хариулаад, тодорхой хариулаад өгөөч. Хариулт хангалтгүй байгаад байна, дутуу байгаад байна гэж байна. Дамдинням сайд.

Г.Дамдинням: Хэлэлцээртэй холбоотой.../үг тасрав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хөнгөлөлттэй зээлтэй холбоотой гүйцэтгэлээр мөнгө нь гардаг. Монгол Улс руу ямар нэгэн мөнгө орж ирдэггүй. Гүйцэтгэгч компанийн гүйцэтгэлээр Сангийн яамаар уламжлаад гүйцэтгэлийг нь баталгаажуулаад, тийм ямар нэгэн мөнгө Монгол Улсын дансанд бол орж ирдэг тийм асуудал байхгүй. Тэр бол, би тэрийг сайн мэдэхгүй байна, уучлаарай. Сангийн яамаар дамжуулаад бид гүйцэтгэлийг нь баталгаажуулаад, зээлдэгч Эксим банк руу бид явуулдаг нэхэмжлэлийг нь.

С.Бямбацогт: Бид мэдэхгүй биш. Газрын тос боловсруулах үйлдвэр чинь Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны эрхлэх асуудал, харьяалах чиг үүрэгт байгаа шүү дээ.

Ч.Хишигдалай: Мөнгө орж ирсэн асуудал бол байхгүй.

С.Бямбацогт: Тийм болохоор 480 сая доллар орж ирсэн юм уу, орж ирээгүй юм уу, орж ирсэн бол хаана, хэний дансанд байгаа юм, ямар банк, юугаар дамжсан юм бэ?

Ч.Хишигдалай: Орж ирээгүй.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Яагаад Сангийн яам, Эдийн засгийн яамнаас асуугаад байгаа вэ гэвэл газрын тосны үйлдвэрийн технологи, стандарт би асуугаагүй шүү дээ. Энэ гэрээг 1.7 тэрбум долларын гэрээг Сангийн яам үзэглэсэн. Тэгээд хариуцаж байгаа Алтанцэцэг захирал нь 4 дүгээр сарын 01-нд Төрийн ордонд маш олон хэвлэлийн өмнө 480 сая доллар орж ирсэн, хаашаа орсныг нь мэдэхгүй гэсэн. Тэгвэл та нар энэ ЗГ-ын харьяа байгууллагуудаас асуугаач, энэ дээр хариулт өгөөч? Монголын ард түмний нефтийн үйлдвэртэй болно гэдэг мөрөөдөл дээр нь тоглож, би ч гэсэндээ нефтийн үйлдвэртэй болохын төлөө яриад байгаа шүү дээ эсэргүүцээгүй. Мөрөөдөл дээр нь тоглож 1.7 тэрбум долларыг Монголын ард түмэн дараад нь хүүтэй төлнө шүү дээ. Тэгэхлээр энэ мөнгө хаачсан бэ гэдгийг л асууж байгаа. Хариулт нь байхгүй, төрийн албаны 2 хүн нь 2 өөр ярьж байна шүү дээ. Нэг нь 480 сая доллар ороод ирсэн гээд хэвлэл мэдээллээр 4 дүгээр сарын 01-нд ярьсан, нөгөөдөх нь орж ирээгүй, тэр хүн худлаа ярьж байгаа юм гэж байгаа юм.

С.Бямбацогт: Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Ганбаатар гишүүнээ, би таны асууж байгаа асуултыг Сангийн яам болон Эрдэнэс Монгол компаниудаас тодруулаад албан бичгээр хариулъя. Үнэн, манай яам цэвэр технологи, гүйцэтгэл

дээр нь л анхаарал хандуулаад ажилладаг. Мөнгө санхүүтэй холбоотой асуудал дээр бол бид гүйцэтгэлийн хэмжилтийг нь хийгээд явдаг юм 1.

2 дугаар асуудал, энэ үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын санхүүжилт, гүйцэтгэл 2-ын харьцааг харвал гүйцэтгэл нь 2 дахин урд яваа, санхүүжилтийг нь бид хоцорч өгдөг, өгч чаддаггүй бариад ингээд яваад байгаа. Надад байгаа хувь хэмжээгээр харуулсан мэдээлэл нь тийм байдаг юм. Тэгээд би Сангийн яаманд уламжлаад танд тодорхой мэдээлэл өгүүлье.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүний асуултад бичгээр, албан бичгээр, холбогдох байгууллагуудаас мэдээллүүдийг нэгтгэж авч Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас хариулт өгье. Цэвэгдоржийн Туваан.

Ц.Туваан: Гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Дэмжиж байгаа, дэмжихээс ч өөр аргагүй. 2024 оны 09 сард байгуулагдсан хэлэлцээр, энэ хэлэлцээрийг би зурж байсан юм. Эхнийх нь бол энэ Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх салбарт хамтран ажиллах тухай гэдэг хэлэлцээр, 2 дахь нь Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай гээд. Тэгээд 2 дахь хэлэлцээрийг нь тодорхой нөхцөлтэйгөөр УИХ-аар оруулж ирж, тодорхой асуудлуудыг шийдсэний дараа зурна гээд. Тэгээд энэ нөгөө хуулийнхаа дагуу л явж байгаа юм. Энэ хэлэлцээрийг УИХ хуулийн дагуу соёрхон батлах ёстой, тэгж байж хүчин төгөлдөр болох юм. Тэр асуудлаараа л явж байгаа юм. Тэгээд хайран нэг жил гаруйн л хугацааг бид хэд алдчихаж байгаа юм. Улс төржсөн, цаг алдсан, засаж залруулаад тухайн үед нь батлаад явуулах боломжтой байсан ийм л хэлэлцээр.

Тэгээд тэрний ар дээр юу боллоо Монгол Улс анх удаагаа хийж байгаа хэлэлцээр шүү дээ, энэ газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх. Эргээд нөгөө талтайгаа яаж барьж ярих юу ч байхгүй, 2 удаа бензин тасалдаад Дамдинням сайдыг бараг л дүүжилж алангаа л алдсан, тэгээд л тасарчхаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ хэлэлцээртэй байсан бол бид нэг цаас бариад ярих ийм боломж байсан. Тэгээд яасан дараагаар нь Монгол Улсын бүх л томчууд, төрийн өндөрлөгүүд, сайдууд очоод л, тэнд нь очоод л бөхөлзөөд л энэ асуудлаа ярья, яаралтай бид батална гээд л ингээд л ярьж байгаа шүү дээ. Бид гадаад улсад, ялангуяа 2 хөршдөө нэг тийм барьцгүй, хулхи, худлаа ярьдаг ийм л имижтэй болчихоод байгаа шүү дээ. Энд бол УИХ тодорхой хэмжээгээр буруутай гэж би боддог. Тэгэхээр өнөөдрийн энэ хэлэлцээрийг батлаад нэг барьж очих цаастай л болмоор байгаа юм.

2 дугаарт нь энэ түлшний үнэ өссөн. Энэ сая орон нутагт тойргоор яваад ирсэн, 4500 Сэлэнгэд. Хаврын тариалалт, хүнсний ногооны тариалалт явж байна. Тун удахгүй ингээд л бид хэд байж байтал, наадам гээд л байж байтал ургац хураалт болчихно. Инфляцыг хөөрөгддөг томоохон хүчин зүйлүүдийн эхний 3 дотор нь энэ бензин, түлшний үнэ ордог. Энэ жилийн инфляц их өндөр гарна даа. Тэгээд инфляц өндөр гарахаар бид өнгөрсөн парламентын үед баталж өгсөн нөгөө ахмадынхаа тэтгэврийг нэмэх хувь чинь энэнтэй уялдаад дахиад яваад өгнө. Ингээд улсын төсвийн асуудал бас л хүнд болоод ирнэ. Тэгэхээр иймэрхүү зүйлүүд байгаа учраас энэ эхлээд бид нийлүүлэлтээ аюулгүй болгож авъя. Дараагаар нь яаралтай үнийн асуудлаа яримаар байна. Энд юу газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэл дээр нэмэлт нэг минутаа авчихъя.

С.Бямбацогт: Туваан гишүүн асуултаа асууя. Нэмэлт минут.

Ц.Туваан: Энэ саяхан бид энэ гадаад зээлийн ашиглалт гээд нэг ийм өнгөлөн далдлалт нэртэй, тэгэхдээ ямар ч байсан урагшлуулаад энэ газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрийн санхүүжилтийг, Эрдэнэбүрэнгийн УЦС-ын санхүүжилтийг шийдсэн. Нөгөө ашиглалтад орох хугацаа ер нь нэлээн цагийн хугацааны хувьд бол нэг жил гаруй л хугацаа байгаа, ер нь дөхчихсөн. Тэгэхээр энэ дээр нэг зүйл тодруулмаар байна. Энэ газрын тосны түүхий нефтийн хангамжаа яаж шийдэх гэж байна вэ Дамдинням сайд? Та энэ дээр нэг хариулт өгөөдхөөч. Казахстан ч гэж яриад л, манайх хэлэлтгүй улс яриад л, өөр ч Араб гээд ингээд нэлээн явж байгаа. Бид нөгөө түрүүний Ганбаатар гишүүний хэлсэн айлаас эрэхээр авдраа ух гэдэг шиг Петрочайна Дачин Тамсаг компанийн удирдлагуудтай ер нь уулзаж үзсэн үү? Олборлолтоо, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх талаар ер нь ямар арга хэмжээ авав? Энэ асуудалд та нэг хариулт өгөөдхөөч?

С.Бямбацогт: Аж үйлдвэрийн сайд Дамдинням хариулъя.

Г.Дамдинням: Туваан сайд маань адилхан зовлон үүрч байсан хүний хувьд яг л асуудлуудаа яг хэлж байна. Тэгээд баярлалаа, дэмжиж байгаад. Түлшний үнэ бид бас та л мэдэж байгаа даа. Тэгээд бид очиж тасралтгүй л гуйж гувшиж, гүйж байдаг. Тэгж байгаад ямар ч байсан 2026 оны 04 дүгээр сард үндсэндээ түлшний үнэ нэг литр нь Улаанбаатар хотод 6700 хүрэхээр байсан. Тэгээд бид 4300 дээр ямар ч байсан ОХУ-ын дотоодын зах зээлээр барья гэж тохирч барилаа. Газар тариалангийн бүс нутгууд, газар тариалангийн манай орны хаврын тариалалтад 7500 тонн хэрэг болдог. 7500 тонныг бол ААН-үүдтэйгээ ярьж байгаад яг хуучин үнээр нь, 3400 төгрөгөөр нь нийлүүлсэн. Тэгэхээр яг шууд тариалалттай холбоотой зардал дээр бол харьцангуй хөнгөн тусах байх гэж бодож байна. Намар ч гэсэн бид нэлээн ажиллаад л, ингээд л бэлтгэл ажлаа хангаад явж байгаа.

Нефтийн хангамжтай, нефтийн үйлдвэр маань бол нэлээн зүтгүү нэлээн урагштай явлаа. Их Хурал маань сая ойлгож, нэг тусгай хууль гаргаж өгч дэмжсэнд талархал илэрхийлье. Гол асуудал нефтийн хангалттай холбоотой асуудал. Нефтийн хангалттай холбоотой асуудал дээр Туваан сайд, таны үед хийж байсан ажлуудыг үргэлжлүүлээд жаахан ахиц гаргаад ингээд явж байгаа. Ер нь бид 2 хөршөөсөө хамгийн 1 дүгээрт авах ёстой. 2 дугаарт дотоодын эх үүсвэрээсээ ашиглах ёстой. Одоогийн байдлаар бид 400 мянган тонныг олборлож байна. Үйлдвэрт 1.5 сая хэрэгтэй. 1.1 сая тонныг нөхөхийн тулд Петрочайнатай холбоотой маргааныг шийдвэрлэх ёстой. Петрочайнатай бид дэлхийн, таны үеэс эхэлсэн ажил байгаа. Дэлхийн бүх л нефтийн компаниуд руу, эрэл хайгуулын компаниуд руу бүгд рүү нь захидал явуулж манай оронд хайгуул судалгаа хийгээч гэдэг хүсэлт тавьдаг. Сонирхдоггүй, ирдэггүй. Ганц байгаа, идэвхтэй ажиллаж байгаа нь БНХАУ-ын 2 компани ажиллаж байна.

Петрочайна гэдэг бол дэлхийн хамгийн том нефть олборлогч компани. Энэ компанийг ер нь зовоосон доо. Ний нуугүй л хэдүүлээ ярья. Хууль буцааж ашиглаад, газрын тосны асуудлыг Ашигт малтмалын хууль ашиглаж торгоод, тэгээд орон нутагтаа сайн дураараа юм хийгээд өгье гэнгүүт нь ковид таараад жоохон хойшлонгуут нь шүүхэд өгөөд торгуулаад, энэ манай хууль, эрх зүйн орчны алдаа, нөхцөл байдалтай л холбоотой байгаа. Тэгээд энэ дээр бид Петро чайнатай хэлэлцээр хийгээд явж байна. Хуулийн байгууллагууд руугаа хандаж энэ асуудлуудаа шийдүүлээч гэдэг хүсэлт тавиад явж байгаа.

2 дугаар асуудал, бид эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой. Өөрөөр хэлбэл энэ урд хөрштэйгөө харилцах харилцаанд, ний нуугүй хэлэхэд БНХАУ-аас орж ирсэн хамгийн том хөрөнгө оруулалт энэ Петрочайна шүү дээ. 4 тэрбум доллароор хөрөнгө оруулалт орсон, хөрөнгө оруулалтаа нөхөж дуусаагүй байгаа. 3 тэрбум доллароо нөхсөн, цаана нь тэрбум доллароо нөхөж чадаагүй байгаа ийм ААН. Тэгээд энэ дээр нэг удаагийн тусгай хууль оруулж ирж, энэ маргааны асуудлыг нь энэ олон улсын гэрээ хэлцлийг буцааж хэрэглэхгүй гэдэг ийм утгатай хууль, эрх зүйн орчинд бэлдэхээр бид ажиллаж байна. Ойрын үед УИХ-аар орж ирнэ.

С.Бямбацогт: Баярлалаа. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууж, үг хэлье.

О.Саранчулуун: Баярлалаа. Энэ гадаадтай хамтын ажиллагаагаар хөрөнгө оруулалт хийх, ажил бүтээх гэдэг чинь ёстой үнэхээр нөгөө 100 айл руу 100 явна гэдгээс ч илүү хүнд, нүсэр ийм ажил байдаг юм байна. Тэгээд би энэ хуулийн төслийг бол энэ хөөцөлдөж байгаа ажлыг нь бол дэмжиж байна. Би үүнтэй холбоотойгоор Гадаад хэргийн яамнаас хүмүүс ирсэн байх гэж бодож байна. Тийм учраас нэг зүйлийг тодруулах гэсэн юм. Жил гаран өмнө Хятад улсад миний зүгээс айлчлаад, бид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дэмжих туслах хэрэгслийн асуудлаар хамтын ажиллагааг хөндсөн. Эргэж ирээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд мэдээллээ уламжилж, тайлангаа өгч, энэ чиглэлээр хамтын ажиллагааг дэмжье гэсэн энийг ажил хэрэг болгооч гээд ингээд явж байгаа. Тэгээд одоо бараг 2 жил болох гэж байна. Ямар ч ахиц, мэдээлэл байдаггүй хүлээгээд байдаг, тэгээд ямар ажил дээр ингээд тэр хөөцөлдлөгөөтэй яваад, ямар нь бол болж бүтэхгүй байгаа ялгааг бид харж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэг ямар явцтай байдаг юм бэ?

Ер нь энэ бид уул уурхай, хүнд үйлдвэр гэдэг асуудлуудаар бол гэрээ хэлцлийг яам нь хөөцөлдөөд яваад байна шүү дээ. Аймаар нүсэр асуудлыг хөөцөлдөөд яваад байхад тэр нэг жижигхэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн туслах технологийн сэргээн засахын хамтын ажиллагааны нэг иймэрхүү асуудлыг хөөцөлдөх болохоор ингээд алга болчих юм. Тэгээд энэ дээр мэдээлэл авмаар байна.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг, хэлэлцэж байгаа асуудалтай холбоогүй л асуулт байна, тийм ээ? Яах вэ хариулт өгчихье.

Д.Өнөбилэгт: Энэ тодруулсан асуудалд хариулт өгье. Ний нуугүй хэлэхэд яг энэ асуудлын явцыг бол мэдэхгүй байна. Тиймээс зохих журмын дагуу асуудлын тодруулгыг яаж, яамнаасаа танд мэдээллийг хүргүүлэх арга хэмжээ авъя. Баярлалаа.

С.Бямбацогт: Бичгээр Саранчулуун гишүүнд хариулт өгчхөөрэй. Хууль санаачилсан илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд асуулт, үг хэлж дууслаа.

Санал хураалтыг, өнөөдрийн санал хураалтуудыг нэгтгээд үдээс хойш 16:00 цагаас хураачихъя. 16:00 цагт санал хураалттай шүү гишүүдээ. Бүлгийн ажлын алба, УИХ-ын Тамгын газар гишүүдээ санал хураалтад бэлэн байлгаарай.

***Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлт
/Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн
тухай/***

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц /ҮХЦ/-ийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ. ҮХЦ-ийн дүгнэлтийг ҮХЦ-ийн гишүүн Одонхүүгийн Мөнхсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

О.Мөнхсайхан: Монгол УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг танилцуулж байна. ҮХЦ-ийн дунд суудлын хуралдааныг ҮХЦ-ийн дарга Г.Баясгалан даргалагч, ҮХЦ-ийн гишүүн Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, илтгэгч Э.Энхтуяа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан, ҮХЦ-ийн хуралдааны танхимд нээлтээ хийв. Тус хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Д.Отгонбат болон Монгол УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, УИХ-ын гишүүн Ц.Сандаг-Очир нар оролцлоо.

Дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Ерөнхийлөгчөөр 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно гэснийг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв. ҮХЦ-ийн 2026 оны 04 дүгээр дүгнэлт нь нийт 11 хуудас, үндэслэл хэсэг нь дангаараа 7 хуудас тул түүний үндэслэл хэсгийг товчилж, тогтоох хэсгийг бүхэлд нь уншиж сонсоё.

Үндэслэл: 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулиар парламентын тогтолцоог бий болгосон бөгөөд парламентын тогтолцоо нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд багтаж хамгаалагдана. Тиймээс Монгол Улсын ЗГ нь ардчилсан сонгуулиар бүрдсэн УИХ-ын олонхын итгэл дээр тулгуурлан оршино. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийг иргэд ардчилсан сонгуулиар шууд сонгох боловч тэрээр төрийн тэргүүн, ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч бөгөөд төрийн эрх мэдэл хоорондын хяналт, тэнцлийг хангахад туслах чиг үүргийг гагцхүү үндсэн бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлнэ.

Үндсэн хуулиар парламентын тогтолцоог сонгож, төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн 3 салаанд хуваарилж харилцан хяналт, тэнцлийн үндсийг тавьсан боловч түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим асуудал үүссэн байна. Тухайлбал, Үндсэн хуульд заасан хүрээнээс хальсан бусад бүрэн эрхийг Ерөнхийлөгчид олгох болсон нь түүний нөлөөллийг хүчтэй болгож, гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх эрх мэдлийн олон асуудалд хөндлөнгөөс оролцох болж, хяналт, тэнцэл алдагдахад хүрсэн гэж дүгнэсэн байна. Түүнчлэн 1992 оны Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Ерөнхийлөгчөөр 4 жилийн хугацаагаар сонгохоор, 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улираан сонгож болохоор заасан байжээ. Үүний улмаас дахин сонгогдохын тулд өөрийн бүрэн эрхийг хэтрүүлж, төрийн бусад дээд байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох эрсдэлийг бий болгосон гэж үзжээ.

Дээрх үндэслэлээр 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал, эрх хэмжээг парламентын тогтолцоотой улсын жишигт нийцүүлэн зарим өөрчлөлт, хязгаарлалтыг тусгасан байна. Тухайлбал, Ерөнхийлөгчөөр сонгогдох насны доод хязгаар 45 байсныг 50 болгон нэмэгдүүлж, 4 жилийн хугацаагаар нэг удаа улируулан сонгох боломжтой байсныг 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгох буюу дахин сонгогдохгүй болгож өөрчилсөн байна. Түүнчлэн Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно гэж өөрчлөн найруулжээ.

1992 оны Үндсэн хууль нь ардчилсан дэглэмийг тогтоох, ард түмний эрх мэдлийг хэрэгжүүлсний үр дүн, хүсэл зоригийнх нь илэрхийлэл тул хууль зүйн хамгийн дээд хүчин чадалтай бөгөөд эрэмбийн хувьд Монгол Улсад үйлчлэх хамгийн дээд хууль юм. Үндсэн хуулиар ардчилсан нийгмийн үнэт зүйлийг хамгаалж, төрийн байгууллын болон бусад суурь асуудлыг шийдвэрлэж тогтоодог учраас түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам нь ердийн хууль батлах журмаас илүү өндөр босго, шаардлагыг хангах бөгөөд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна.

Иймээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагаас гаргасан аливаа эрх зүйн акт Үндсэн хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд бүрнээ нийцсэн байвал зохино. Тухайлбал, хууль тогтоогч анхнаасаа Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцээгүй хуулийг батлахгүй байх негатив үүрэгтэй төдийгүй, өмнө нь батлагдаж хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг тэдгээрт нийцүүлэх позитив үүргийг хүлээнэ. 2019 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг УИХ-аас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана гэж заасан бөгөөд түүний 4 дүгээр зүйлд энэ хууль Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн адил хүчинтэй гэжээ.

Үүнээс үзэхэд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь нь уг нэмэлт, өөрчлөлтийн нэгэн адил хүчинтэй хуулийн дагуу батлагдсан тул тус хуваарьт заасан чиглэлийн дагуу холбогдох хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлж, тогтоосон хугацаанд багтаан батлахыг мөн Үндсэн хуулиар үүрэгжүүлсэн гэж ойлгоно. Иймээс уг хугацаанд багтаан хууль тогтоомжийг Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлээгүй эс үйлдэхүй гаргаж болохгүй.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн дагуу УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай шинэчилсэн найруулга болон дагалдах бусад хуулийн төслийг 2020 онд багтаан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхийг ЗГ-т даалгасан байна. Мөн УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд эдгээр хуулийн төслийг 2021 онд багтаан өргөн мэдүүлэхийг ЗГ-т дахин даалгасан байна. Хуулийн төслийг боловсруулахдаа Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, бүрэн эрхийн хугацаатай холбоотой зохицуулалтыг болон зөвхөн Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд заасан үндсэн бүрэн эрхийнх нь хүрээнд тодорхой бүрэн эрх олгох

асуудлыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх чиглэлийг ЗГ-т өгсөн байна.

ЗГ дээр дурдсан УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоол, 2021 оны 12 дугаар тогтоолын биелэлтийг одоо болтол хангаагүй байх тул Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн нэг дэх заалтад заасан хуулийг биелүүлэх үүргээ зөрчиж, Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах үндсэн бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна. Учир нь ЗГ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай болон дагалдах бусад хуулийн төслийг боловсруулж, 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн өргөн мэдүүлэхээр тогтсон боловч өнөөдрийг хүртэл буюу 6 жилийн хугацаанд өргөн мэдүүлээгүй, УИХ-ын тогтоолоор хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна.

Түүнчлэн ЗГ өөрийн 2024 оны 181 дүгээр тогтоолоор хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталсан боловч дээрх хуулийг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх талаар тусгаагүй байна. 2020 онд нэр бүхий иргэдээс ҮХЦ-д хандаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байхаар заасан нь Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхийлөгчөөр 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно" гэснийг зөрчсөн тухай мэдээлэл ирүүлж байжээ. Энэ мэдээллийг ҮХЦ-ийн гишүүний 2020 оны 2/495 дугаар албан бичгээр УИХ-д шилжүүлж, УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан хуваарийн дагуу маргаан бүхий заалтыг Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нийцүүлэх шаардлагатай тухай тэмдэглэсэн байна.

УИХ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай болон дагалдах бусад хуулийн төслийг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн батлаагүй байх тул Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан позитив үүргээ одоог хүртэл буюу 7 жил биелүүлээгүй гэж үзэхээр байна.

Түүнчлэн УИХ өөрийн баталсан 2020 оны 02 дугаар тогтоол, 2021 оны 12 дугаар тогтоолын биелэлтийг хянан шалгах бүрэн эрхээ хангалттай хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал, 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд холбогдох хуулийн төслийг нийцүүлэн боловсруулж, өргөн мэдүүлэх талаар албан бичгийг УИХ-ын ТББХ-ноос 2020-оос 2021 онд ЗГ-т 5 удаа хүргүүлсэн байх боловч үүнээс өөр илүү идэвхтэй арга хэмжээ аваагүй байна. Мөн УИХ 2021 оноос хойш Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай болон дагалдах бусад хуулийн төслийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх талаар санаачилга гаргасан эсэх нь тогтоогдоогүй болно.

Дээрхээс үзэхэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт "Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 4 жил" байхаар заасан нь Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг илт зөрчсөн байна. Үндсэн хуулийн энэхүү зөрчил нь ЗГ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай болон дагалдах бусад хуулийн төслийг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлээгүй, УИХ эдгээр хуулийг батлаагүй, мөн өөрийн баталсан хуваарийн биелэлтийг хянан шалгах арга хэмжээ хангалттай аваагүй эс үйлдэхүйгээс үүдэн бий болсон байх тул хууль дээдлэх ёс, Үндсэн хуульд нийцсэн байх зарчмыг зөрчсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн нэг дэх заалт, ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон, Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт "Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна" гэж заасны "4 жил" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхийлөгчөөр 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно" гэснийг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт "4 жил" гэж заасныг ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй. Энэхүү дүгнэлтийг ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг УИХ-д уламжилсугай. Даргалагч Г.Баясгалан, гишүүд Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Э.Энхтуяа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Мөнхсайхан Цэцийн гишүүнд баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 04 дүгээр дүгнэлтийг ХЗБХ Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар ҮХЦ-ийн дүгнэлтийг хэлэлцэх үед Монгол УИХ-ын гишүүн Уянгахишиг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан Ерөнхийлөгчийн тухай хууль шинэчлэх ёстой байсан бөгөөд өнөөг хүртэл өөрчлөгдөөгүй байх хугацаанд буюу 2021 онд Ерөнхийлөгчийн сонгууль Үндсэн хуулийн шинэ зохицуулалтын хүрээнд явагдсан. Мөн Ерөнхийлөгчийн хуулийн холбогдох заалтыг ҮХЦ түдгэлзүүлсэн нь хууль, эрх зүйн эргэлзээтэй байдлыг бий болгож байгаа талаар, УИХ-ын гишүүн Сайнзориг Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүрээнд УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг ЗГ-т үүрэг болгосон бөгөөд ЗГ хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүдэн энэхүү нөхцөл байдал үүссэн талаар, УИХ-ын гишүүн Баярбаатар ЗГ, УИХ 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан хуулиудаа хугацаанд нь шинэчилж чадаагүй асуудлаа бодитоор үнэлэхийн зэрэгцээ хүчингүй болгох ёстой 4 жил гэсэн зохицуулалтыг хууль зүйн процессоор хэрэгжүүлээгүйгээс ҮХЦ түдгэлзүүлсэн гэх дүгнэлт гаргах нөхцөл бүрдэж, улмаар эрх зүйн тодорхойгүй байдал үүсгэж байгаа тул маргаанаас илүүтэй Үндсэн хуульд нийцүүлэх ажлыг эрчимжүүлж, ажлын хэсгийг яаралтай байгуулан

хууль тогтоомжийг бүхэлд нь шинэчилсэн найруулгаар боловсруулах шаардлагатай талаар, УИХ-ын гишүүн Цогтбаатар Ерөнхийлөгчийн тухай хууль Үндсэн хуультай нийцээгүй ч 2021 оны сонгууль Үндсэн хуулиа баримтлан явагдсан. Нэг талаас хууль дээдлэх зарчим бодитоор хэрэгжиж байгаа хэдий ч нөгөө талаас төрөөс хуулиа цаг тухайд нь шинэчлэн, боловсронгуй болгоогүй зохицуулалтын хоцрогдлыг бий болгосон байдлыг давхар илэрхийлж байна. Ийм нөхцөлд сонгууль явуулах нь зүй ёсны биш тул цаашид илүү хариуцлагатай ажиллах шаардлагатай байхаар тус тус үг хэлж, байр сууриа илэрхийлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт "Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна" гэж заасны "4 жил" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхийлөгчөөр 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно" гэснийг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 61.1 хувиар "хүлээн зөвшөөрөх нь зүйтэй" гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Цэцийн дүгнэлтийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Өлзийхүүгийн Шижир танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ө.Шижир: Монгол УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 4 дүгээр сарын дүгнэлтийг, 04 дүгээр дүгнэлтийг 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр УИХ-д ирүүлснийг ТББХ Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, УИХ-ын гишүүн Ц.Сандаг-Очир ҮХЦ-ийн дүгнэлтийн талаар товч танилцуулга хийлээ. ТББХ-ны хуралдаанаар ҮХЦ-ийн 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Л.Гантөмөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийг Үндсэн хуультай нийцүүлэн боловсруулах ажлын хэсэг байгуулж, холбогдох хуулийн төслийг хэлэлцэн батлах ажлыг УИХ-д яаралтай зохион байгуулах шаардлагатай. Түүнчлэн Монгол Улсын ҮХЦ-ийн даргын бүрэн эрхийн хугацаа дууссан, нэг гишүүний орон гарсан тул хуулийн дагуу яаралтай Цэцийн гишүүнийг томилох нь зүйтэй гэсэн талаар, УИХ-ын гишүүн О.Алтангэрэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай болон Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийг цаг үеийн шаардлага, тогтолцоонд нийцүүлэн шинэчлэн батлах шаардлага талаар үг хэлж, байр сууриа илэрхийлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт "Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхийлөгчөөр 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа

сонгоно" гэснийг зөрчсөн гэж үзсэнийг "хүлээн зөвшөөрөх нь зүйтэй" гэсэн томьёоллоор санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцогчдын гишүүдийн олонх "хүлээн зөвшөөрөх нь зүйтэй" гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Шижир гишүүнд баярлалаа. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.3-д заасны дагуу, энэ хуулийн 32.1, 32.2-т заасны дагуу хуулийн төслийг татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байхаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслийг татан авах тухай албан бичгийг Их Хуралд ирүүлэх бөгөөд Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслийг татан авсанд тооцно гэсэн заалтын дагуу УИХ-ын гишүүн Амгаланбаатар нарын гишүүд хуулийн төсөл татан авуулах тухай бичиг ирүүлсэн байна. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2-т заасны дагуу 2025 оны 11 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна гэсэн байна, татан авлаа.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Норовын Алтанхуяг гишүүнээр тасаллаа, Дараалалд орсон уу? Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Эрдэнэболд: 2 зүйл байна. 1 дүгээрт, ер нь энэ Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн асуудлаарх Ерөнхийлөгчийн тухай, Шүүхийн тухай ингээд маш олон хуулиуд байгаа. Эдгээр хуулиудад одоогоор яг ингээд үйл явцын шатдаа хянагдаж байгаа хэчнээн ийм асуудлууд байгаа вэ гэдэг асуулт баймаар байна.

Цэцийг, Цэцийн дээр мөнх хөх тэнгэр байдаг гэж манай хуульчид ярьсаар ирсэн. 1992 оны 01 сарын 13-ны өдрийн 11 цаг 35 минутад Монгол Улсын Үндсэн хууль, шинэ ардчилсан Үндсэн хууль батлагдсанаас хойш Цэцийн маш олон маргаан шийдвэрлэх процесст бол би хувь хүний хувьд маш их итгэл үнэмшилтэй хандаж ирсэн. Сүүлийн үед манай энэ Гангабаатар, Эрдэнэбулган, Мөнхсайхан гээд Цэцийн гишүүд энэ Цэцийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, Цэцийн гаргаж байгаа дүгнэлтүүд маш онолын судалгаа сайтай, олон улсын арга зүй, онол практикийг хослуулсан, эрх зүйн суурь философийг дурдсан, олон талаас нь нягталсан дүгнэлтүүд гарсаар байгаад нь талархалтай ханддаг байлаа.

Тэр өчигдөр Дээд шүүхийн шүүгчийн нэг удаа 6 жил гэдгийг хасах хүртэл ийм итгэл үнэмшилтэй байлаа. Сүүлийн үед Цэцийн гаргаж байгаа шийдвэрүүд, сүүлийн нэг жил гаруйн дотор Цэцийн гаргаж байгаа шийдвэрүүд бол улс төрийн өнгө аястай юм шиг ингэж хардагдах боллоо. Цэцийн үйл ажиллагаанд эрх зүйч гишүүний хувьд эргэлзэж байна. Яах вэ дараад дахиад Монгол Улсын Ерөнхийлөгчийг 6 жилээр нэг удаа гэснийг бас өөрчлөх үү? Энэ системийн хямрал руу Цэц нь өөрөө дүгнэлтээрээ түлхдэг, шийдвэрээрээ аваачдаг болох гээд байгаа юм биш үү? Үндсэн хуулийг хамгаалах ёстой Цэц нь өөрөө Үндсэн хуульдаа халдаж байгаа мэт ийм үйлдлүүд гарсаар байгаад харамсалтай байна.

Байнгын хороодын дүгнэлттэй холбогдуулаад асуух асуулт нь болохлоороо саяын хэлэлцэгдэж байгаа энэ асуудал шиг хэчнээн төрлийн ийм маргаан Цэц дээр явж байгаа юм бэ? Том зургаар нь асуудлыг тайлбарлаж ойлгоход энэ хариулт хэрэгтэй байна, эндээс хариулт авъя.

С.Бямбацогт: Байнгын хороод хариулах ёстой. ТББХ-ны дарга, ХЗБХ-ны дарга хариулах ёстой, мөн Цэцийн хуралдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон гишүүн хариулах ёстой. Итгэмжлэгдсэн төлөөлөгч хэн билээ, тэгвэл Сандаг-Очир гишүүн хариулъя. Манай Байнгын хорооны дарга нар орж ирээрэй. Энэ Цэцийн дүгнэлттэй холбогдуулж энэ Байнгын хорооны дарга гэдэг чинь бол тэгээд зөвхөн хуралдаан даргалах биш, Байнгын хороогоо төлөөлж, Байнгын хорооныхоо эрхлэх асуудал, чиг үүрэгтэй асуудлуудаа хариулт өгөх, зохион байгуулах ийм үүрэгтэй шүү. ТББХ-ны дарга, ХЗБХ-ны дарга нарыг чуулганы хуралдаанд дуудаж байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгч хариулт хийе.

Ц.Сандаг-Очир: Би яг энэ маргаан дээр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр орсон юм. Тэгээд Эрдэнэболд гишүүний асуулт бол яг надтай холбоотой асуудал биш байна. Би бол зөвхөн энэ Үндсэн хуулийн орсон нэмэлт, өөрчлөлтийн Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Ерөнхийлөгчөөр энэ 4 жил энэ өөрчлөлтийн асуудал дээр л нэмэлт, өөрчлөлтийн асуудал дээр л би итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр орсон. Яг Цэц дээр Үндсэн хуулийг зөрчсөн өөр хуулийн ямар хэмжээний асуудлууд байна вэ гэдгийг бол би бол мэдэх боломжгүй. Энэ дээр Парламентын хүрээлэн гэдэг юм уу, ҮХЦ-ээс хариулах эрхгүй дэгээрээ. Тэгээд Цэц дээр өөр Үндсэн хууль зөрчсөн гэдэг асуудлаар ямар, хэчнээн хэмжээний маргаан үүсээд явж байгааг би бол хэлж мэдэхгүй байна. Зөвхөн би бол энэ маргаан дээр орсон асуудлаараа гишүүдийн асуусан асуултад хариулах дэгтэй, үүрэгтэй. Тийм учраас Эрдэнэболд гишүүний асуултад бол би хараахан хариулт хэлэх боломжгүй байна, даргаа.

С.Бямбацогт: Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Хариулах хүнгүй учраас нэмээд хэлчихье. Сая уг нь энэ гадаа Мөнхсайхан Цэцийн гишүүнтэй уулзахад бол жишээлбэл өчигдрийн шийдвэрийг Их Хурал руу явуулсан гэж байгаа. Тэгээд би сая энэ Их Хурлын ажлын алба, Тамгын газраас асуухаар жишээлбэл, ХЗБХ-нд ирээгүй гэж байгаа. Тэгэхээр ер нь бид ингээд энэ Цэцтэй холбоотой асуудал дээр маш болгоомжтой, няхуур, нямбай хандах ёстой. Яагаад гэвэл энэ бол Үндсэн хууль байгуулал, манай нийгмийн энэ суурь үзэл санаа, энэ төрийн байгуулалттай шууд холбоотой асуудлуудтай уялдсан хуулийн зохицуулалтуудыг ярьж байна л даа. Яах вэ мэдээж Монгол Улсын Үндсэн хуульдаа нийцүүлж, бусад хуулиудаа засварлах асуудал нь зайлшгүй зүйл. Энийг би эсэргүүцэхгүй байгаа юм.

Гэхдээ ер нь энэ бусад хуулиудад яг хэчнээн төрлийн ийм маргаанууд явж байгаа юм, би хардах эрхтэй тэр хүрээндээ хардаж байгаа нь жишээлбэл өчигдрийн шийдвэр дээр ингээд харахад Дээд шүүхийн 6 жилийг байхгүй болгож байна гэдэг бол дахиад Ерөнхийлөгчийн 6 жилийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Батын Батбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Батбаатар: Энэ асуудал бол бид нөгөө 4 жилийг 6 жил болгож байгаа техникийн асуудал, засварын асуудал бол биш гэж ойлгож байгаа. Энд Үндсэн

хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Монголын төр, УИХ, ЗГ Үндсэн хуульд нийцүүлэх ажлаа хийгээгүйгээс болж байгаа энэ парламентын хяналтын механизм алдагдаж байна гэж үзэж байна. Тийм болохоор миний асуулт, санал бол УИХ-ын даргад хаяглагдаж байна. Энэ асуудлаа зөвхөн техникийн засвар гэж үзэх юм уу, эсвэл Ерөнхийлөгчийнхөө эрх хэмжээ, хяналт, тэнцлийн бүх зохицуулалтыг цогцоор нь шинэчлэх ёстой болсон уу гэдэг эхний асуулт?

ЗГ 2021 онд хэлэлцээд төслийг хэлэлцээд УИХ-д шийдвэрлэхээр шийдвэрлэсэн атлаа өнөөдөр хүртэл яагаад өргөн мэдүүлээгүй байгаа юм бэ? УИХ үүн дээрээ хяналт тавьсан юм уу, шахаж шаардсан юм уу? Түүрүүн 5 удаа бичиг явсан тухай дурдагдаад өнгөрсөн. УИХ өөрөө өөрийнхөө баталсан 2020 оны 02 дугаар тогтоол, 2021 оны 12 дугаар тогтоол гээд тэр хэрэгжилтүүдийг бодитоор хянан шалгадаг. Энэ механизм Их Хуралд байхгүй болчихсон юм уу? Үндсэн хуульд нийцүүлэх ажлаа хугацаанд нь хийгээгүй төрийн байгууллагын эс үйлдэхүйдээ ямар хариуцлага тооцох юм бэ?

Энэ Цэцийн дүгнэлт дотор тэгээд биччихсэн байна лээ шүү дээ, ЗГ болон УИХ эс үйлдэхгүйгээсээ Үндсэн хуулийн зөрчлийг бий болгож байна гээд. Тэгэхээр энэ цаашдын энэ хариуцлагын механизмаа яаж хийх юм бэ гэдэг тухай. Ерөнхийлөгчийн тухай хуулийн бусад заалтууд Үндсэн хуультай зөрчилдөх эрсдэлтэй тийм зохицуулалт байгаа эсэх дээрээ бүрэн аудит хийж чадсан уу, Их Хурлын Тамгын газар, УИХ?

ҮХЦ-ээс гарч байгаа дүгнэлтийг өөрчлөх гол субъект чинь өөрөө УИХ шүү дээ. Тэгэхдээ энэ Цэцийнхээ дүгнэлтийг бид УИХ-аар хэлэлцэх тэр 15 хоногийн хугацаа нь зүгээр ийм формаль хугацаа байгаад байна уу, эсвэл тийм бодит эрх зүйн үр дагавартай хугацаа байна уу гэдгээ бодох ёстой. 2020 онд засагдах байсан алдаа одоо 2021 онд засагдах гээд ингээд явж байна гэдэг чинь хууль тогтоомжийн хэрэгжилтийн тогтолцоо чинь өөрөө бүрэн доголчихсон, Их Хурлын Тамгын газар, УИХ, гишүүд бол өөрсдөө ажиллаж чадахгүй байна гэсэн ийм дүгнэлтэд хүргээд байна. Үүн дээрээ бид энэ Ерөнхийлөгчийн сая Цэц дээр гарч байгаа дүгнэлт дотор зарим зүйлийг нь ингээд хараад байхаар Ерөнхийлөгчийнхөө хуулийг бүхэлд нь өөрчилж, засаж сайжруулах ёстой гэсэн тийм агуулга явчхав уу гэж харагдсан.

Тэгэхээр энэ Ерөнхийлөгчийнхөө институцийн хяналт, тэнцлийнхээ үүргийг хадгалах, парламентын засаглалаа бэхжүүлэх хоёрынхоо энэ заагийг энэ төсөлдөө тусгаж хэдүүлээ хийх юм уу, үгүй юм уу гэдэг. Үндсэн хуульд нийцээгүй хууль хүчин төгөлдөр үлдэж болдог мэт ийм 2019 оноос хойш чинь энэ чинь 6, 7 дахь жилийнхээ нүүрийг үзэж байна. Тэгэхээр ийм бусад хуулиуд дээр ийм зүйлүүд явж байгаа юу, ганцхан?

С.Бямбацогт: Надад хандсан учраас би хариулчихъя. Тэгээд 2019 онд бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Засаглал хоорондын хяналт, тэнцлийг бий болгох, УИХ-ын хяналт шалгалтын бүрэн эрхийг нэмэгдүүлэх ийм тодорхой алхмуудыг хийсэн. Энэ нэмэлт, өөрчлөлтийг сайн болсон гэж тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгч асан Баттулга ажлын хэсгийг ахалж ажилласан. Тухайн үед Ерөнхий сайд Хүрэлсүх, одоо Ерөнхийлөгч болоод ажлын хэсгийн дэд даргаар ажилласан. Миний нарийн, миний бие нарийн бичгийн даргаар ТББХ-ны даргын хувьд ажилласан. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бид 2019 оны 11 дүгээр сарын 26-нд ёсчлоод, эцэслээд үйлчилж эхэлсэн. 2020 оны 01 дүгээр сард УИХ-аас

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй ийм тогтоол баталсан.

Энэ дотор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж 22 хуулийг өөрчлөх ёстой. Үүнээс Их Хурал энэ, энэ хуулиудыг, ЗГ энэ, энэ хуулиудыг санаачилж, өөрсдийн чиг үүргийн хүрээнд Их Хуралд өргөн барьж, Үндсэн хуульд нийцүүлж өөрчил гэдэг тогтоолыг 2022 оны 01 сард, 2020 оны 01 сард бид баталсан. УИХ-ын 02 дугаар тогтоол. Энэ тогтоолын биелэлтэд УИХ маань өөрөө хяналт тавьж ажиллах ёстой, УИХ-ын ТББХ хяналт тавьж ажиллах ёстой байсан. Энэ тогтоолуудаас үндсэндээ УИХ бол өөртэйгөө холбоотой УИХ-ын тухай хууль, Дэгийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль, УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль гээд, тийм үү, нэлээн олон хууль нь өөрчлөгдсөн.

ЗГ тодорхой хуулиудыг оруулж ирж өөрчлүүлсэн. Өөрчлөгдөөгүй үлдээгүй 1, 2 асуудал байгаагийн нэг нь энэ Ерөнхийлөгчийн тухай хууль, нөгөөдөх нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлж Монгол Улсын хөгжлийн дунд хугацааны зорилтот 8 хөтөлбөрийг батлах ёстой УИХ, энийг ЗГ боловсруулж өргөн барих ёстой, энэ ажлаа хийгээгүй. Өөрөөр хэлбэл бол 6 жил орчмын хугацаанд Ерөнхийлөгчийн тухай хуулийг ЗГ өргөн барих ёстой байсан, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлж хөгжлийн дунд хугацааны 10 жилийн 7 зорилтот хөтөлбөрийг Их Хуралд оруулж өгөх ёстой байсан, энийг оруулж ирээгүй. Тэгээд Хууль тогтоомжийн тухай хуулиараа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, 5 жил тутамдаа нэг удаа үнэлгээ хийх ёстой. Энэ үнэлгээнүүд хийгдээд, тухайн үедээ ТББХ-ноос, ХЗБХ-ноос удаа дараа ЗГ-т "энэ Үндсэн хуульд нийцүүлж оруулж ирэх хуулиудаа гүйцээж оруулж ир" гэсэн бичиг, чиглэлийг өгч байсан юм байна лээ. Тэгтэл орж ирэхгүй өдий болчихсон явж байгааг та бүхэн анзаарч байгаа байх.

Цаашдаа УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль дээр, энэ Хууль тогтоомжийн тухай хууль болон энэ УИХ-аас баталсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг Үндсэн хуулиараа ЗГ үүрэг хүлээдэг. ЗГ ингээд хуулиа хэрэгжүүлэхгүй бол, хуулиа биелүүлэхгүй бол, хуулийн биелэлтийг хангахгүй бол ямархуу хариуцлага тооцох ёстой вэ гэдгийг Хяналт шалгалтын тухай хуульд тодорхой зохицуулалт орж байгаа. Тийм болохоор энэ хүрээндээ үндсэндээ цаашдаа энэ хууль зөрчдөг, хууль хэрэгждэггүй, хууль зөрчилтэй, давхардалтай, хийдэлтэй байдаг асуудал бол шидэгдэнэ. Ийм байдлаар зохицуулахаас өөр аргагүй болж байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Энэ ташрамд, яах вэ ҮХЦ-ийн тогтоолтой, томилгоотой холбоотой асуудлыг АН-ын бүлгээс тодорхой шаардлага тавьж байна лээ. УИХ-ын даргаар томилогдоод нэг сар орчмын хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд ҮХЦ-ийн гишүүнээр томилох үнэхээр мэдлэгтэй, туршлагатай, чадвартай хүмүүсийг судалж байна. Нэгэнт хуулийн хугацаа болсон. Гэхдээ Цэцийн гишүүний дараагийн гишүүн томилогдсоноор өмнөх гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болно. Тэр хүртэл СЕХ, Цэц, УИХ-ын гишүүн гээд энэ субъект дараагийн гишүүн нь томилогдож байж өмнөх гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусдаг. Энэ хүртэл бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа, энэ асуудлыг ойрын үед шийдэх би бодолтой байгаа гэдгийг хэлье. Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: Яг л ингээд Их Хурлын даргын хариултаас харахад УИХ, ЗГ өөрсдөө ажлаа хийгээгүй л шинж төлөв харагдаад байгаа юм Ерөнхийлөгчийн хууль

дээр. Ер нь тэгэхдээ бид энэ саяын Цэцийн дүгнэлт дотор тусаж байгаа гэж ойлгосон. Ерөнхийлөгчийн хуулиа бүхэлд нь нэг хэлэлцээд, шинэчлээд баталчихсан нь зөв болов уу гэж ингэж бодож байна. Ирэх жил Ерөнхийлөгчийн сонгуультай. Тэгээд энэ хуулийнхаа нийцлүүдээ үзээд нэг цэгцэлмээр байна.

Дээрээс нь энэ Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт орсны дараа хуулиудыг нийцүүлэх хугацааг тийм автоматаар хугацааны хуваарьтай хянадаг ийм парламентын механизмаа тэр Хяналт шалгалтынхаа хууль дээр нэлээн сайн суулгах нь зүйтэй байх гэж бодож байна. Цэцийн дүгнэлтийг хэлэлцэхдээ бид зөвхөн хүлээн зөвшөөрөх эсэхээр нь биш, зөрчлийг арилгах хууль тогтоомжийнхоо тийм багц арга хэмжээний тогтоолыг хамтад нь баталдаг байх. Цэцийн дүгнэлтийг зөвшөөрлөө, зөвшөөрсөнгүй гэхээсээ гадна тэгээд Хууль тогтоомжийнхоо тухай хуульд үндсэн.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэллээ. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Энхтүвшин: Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах үүргийг ийм үндсэн бүрэн эрхийг ЗГ Үндсэн хуулиар энэ бүрэн эрхийг хэрэгжүүлэх ёстой байдаг. Тэгээд ер нь бол яг энэ үүргийн хэрэгжилт хангалтгүй байна. Сая ч гэсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжих ёстой хугацаа нь дуусаж байхад гуравхан хоногийн өмнө, жишээлбэл, оруулж ирж "яаралтайгаар хэлэлцүүлье" гэдэг асуудал тавьж байна. 2020 онд, 2021 онд энэ Үндсэн хуулийн 2019 оны өөрчлөлттэй уялдуулаад "энэ хууль тогтоомжуудаа нийцүүл" гэхэд 2 ч тогтоол гаргасан. Тэгээд ерөөсөө гүйцэтгэхгүй байна л даа. Тэгээд яах вэ энэтэй холбогдуулаад энэ Хууль зүйн байнгын хорооноос асууж таарах уу? Энэ 2020 оны 02 дугаар тогтоолоор Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй уялдуулаад 34 хууль шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан байгаа. Тэгэхээр энэнээс, энэ 34-өөс одоо яг хэд нь үлдчихсэн байгаа вэ гэсэн тийм мэдээлэл байгаа юу? Тэгээд Ерөнхийлөгчийн хуулиа өөрчлөөгүй байгаа, тэгээд ер нь бусад яг хэд нь өөрчлөгдөөгүй үлдчихсэн байгаа юм бэ?

Дараа нь энэ Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд 153 хуульд өөрчлөлт оруулахаар ийм тусгачихсан байгаа. Тэгэхээр энэ 153 хууль тогтоомж дээр яг энэнтэй адилхан нөхцөл байдлууд үүсэж байгаа юу? Хэдэн хууль нь 2024 он чинь өнгөрчихсэн байгаа, энэ 153 хуулиас яг хэд нь үлдчихсэн байгаа, ямар, ямар чухал хууль тогтоомжууд өөрчлөөгүй үлдчихсэн байгаа вэ гэдэг асуултууд байна?

Тэгээд түрүүн гишүүд нэлээн ярилаа, УИХ хяналтын чиг үүргүүдээ сайн биелүүлэхгүй бол ЗГ бол яг өөрийнхөө бүрэн эрх, энэ үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа ийм дүр зургууд харагдаж байгаа учраас энэ УИХ-ын хяналтын чиг үүргүүдийг Байнгын хороо, Төрийн байгуулалт болон ХЗБХ-ны дарга нар яг энэ чиглэлээр нэлээн анхаарч ажиллах шаардлагатай харагдаж байна. Тэгээд ХЗБХ-ноос түрүүчийн 34 хууль, 153 хуулийн яг хэд нь үлдчихсэн өөрчлөөгүй байгаа вэ гэдэг талаар мэдээлэл асууя?

С.Бямбацогт: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулж 2020 оны 01 дүгээр сард баталсан 02 дугаар тогтоолын хэд нь батлагдсан байна вэ, хэд нь батлагдаагүй байна вэ? Тодорхой хариулт өгье.

2 дугаарт нь, 2020-оос 2024 оны хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлээс хэдэн хууль нь биелсэн, хэд нь биелээгүй байна гээд тодорхой асуулт асууж байна. ХЗБХ, нэмээд Тамгын газар хариулаарай. Энэ мэдээллүүд Тамгын газар дээр байх ёстой, ХЗБХ-ны ахлах зөвлөх бэлтгэлээ хангаарай. Цогтбаатар гишүүн, Цогтбаатар дарга Хууль зүйн байнгын хороо.

Д.Цогтбаатар: Бид манай Байнгын хорооны түвшинд, Их Хурал, Их Хурлын Тамгын газар ч яг энэ бүртгэлийг хийгээд явж байгаа. Надад яг энэ гар дээр бүр ингээд салбар салбараараа хэдэн хуулиудад ямар өөрчлөлт оруулах ёстой, тэгээд түүн дээр хэд нь ороод, хэд нь ороогүй байна гэдэг мэдээлэл одоо миний энэ гар дээр байж байгаа юм. Тэгээд би Энхтүвшин гишүүн рүү болон ер нь гишүүдэд манай энэ ажлын албаныхан энэ мэдээллээ бүх гишүүдэд тараагаад өгчих, хаана хаана юу нь хийгдээд, юу нь хийгдээгүй байгаа гээд. Тэгэхлээр тэр бүр бүртгэлтэй байж байгаа, одоо 150 хэдэн хуулийн би яг танд энэ чинь нөгөө салбар салбараараа болохлоор зарим дээр нь 20 хувь хэрэгжсэн байна, зарим дээр нь 20 хувь, 30 хувь гээд ингээд явж байгаа байхгүй юу. Тэгэхлээр тэр бүх мэдээллийг танд гаргаад, ер нь зөвхөн танд биш, гишүүдэд ер нь тараагаад өгчихье.

С.Бямбацогт: Олон нийт сонирхож байгаа байх. Ер нь Тамгын газар энэ дээр нэг нэмэлт мэдээлэл өгчих дөө. УИХ-ын Тамгын газрын тэргүүн дэд дарга Бямбадулам. Энэ хуульд, бид энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлаа сайн хийх ёстой. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүний хэлж байгаа зөв. Тэгээд ямар хуулиуд биелэхгүй, хэрэгжихгүй байгаад байна вэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой.

Ж.Бямбадулам: "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" УИХ-ын 2020 оны 02 дугаар тогтоолд 4 үндсэн чиглэлийн хүрээнд, нийт нэр заасан 30 хуульд 66 агуулга бүхий өөрчлөлт оруулах хууль тогтоомжийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхийг даалгасан. Энэ дээр яг Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хууль, Онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, тэдгээрийн саналыг авч тусгах механизмыг тодорхой болгох гээд тусгайлан заасан. Цөмийн энергийн тухай болон холбогдох бусад хууль, Иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, амьтан төрийн нийтийн өмч байх. Тэгээд Ард нийтийн санал асуулгын тухай хууль, үүнд тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх зорилго бүхий ард нийтийн санал асуулга явуулахыг хориглосон зохицуулалт оруулах. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль шинэчилсэн найруулга, Ерөнхийлөгчид хуулиар олгосон бүрэн эрх Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд заасан хүрээнд байх гэсэн ийм оруулах өөрчлөлтийн төслийг өргөн мэдүүлээгүй байна.

Төрийн нийтийн өмч, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхтэй холбоотой агуулга бүхий төслийг бол 2025 оны 06 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцүүлгийн шатад байгаа. Нийтийн өмчийн хууль энэ хэлэлцүүлгийн шатад байгаа.

С.Бямбацогт: Тэгэхээр 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулж өөрчлөх ёстой 40-өөд хуулиас 6, 7 үлдчихсэн юм байна. Түүний нэг нь Ерөнхийлөгчийн тухай хууль юм байна гэж ойлголоо. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

А.Ариунзаяа: 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан байдаг. 30 дугаар зүйлийн 2 дээр "Ерөнхийлөгчөөр 50 нас хүрсэн, сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан Монгол Улсын уугуул иргэнийг 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно" гэж оруулсан. 2021 онд Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулахдаа Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд "4 жилээр сонгоно" гэдэг тэр заалтыг анзаараагүй тэгээд сонгуулиа явуулсан гэсэн үг үү? Үндсэн хууль зөрчсөн Сонгуулийн тухай хуулиар Ерөнхийлөгчөө сонгосон гэсэн үг үү?

Тэгэхээр ийм хуулиар сонгогдсон Ерөнхийлөгчийн легитим чанар яах вэ гээд ингээд хөрвүүлээд, хөрвүүлээд яриад байвал энэ чинь хөөрхөн юм яригдаад байх юм биш үү? Ер нь энэ алдаа юу алдаа. Тэгээд олон удаа сонгогдсон гишүүд маань өөр хүмүүсийн буруу юм шиг ярьж болохгүй байх гэж бодож байна нэг талдаа. Үндсэн хууль дээр Ерөнхийлөгчийг 6 жилээр зөвхөн нэг удаа гээд, зөвхөн нэг удаа гээд тодруулчихсан байгаа учраас энэ асуудлыг өөрчлөх вий, яах вэ, ийх вий гэдэг дээр эргэлзээд хэрэггүй. Үндсэн хуулиа өөрчлөхөөс нааш дахин сонгогдох ийм асуудал байхгүй.

Гагцхүү өчигдрийн энэ Дээд шүүхийн шүүгчтэй холбоотой хүмүүс тийм юм яриад байна л даа. Тэгээд энэ заалт нь өөрөө юу байсан юм бэ гэхлээр "6 жилээр томилно" гэж байгаад байгаа юм, "Ерөнхийлөгч 6 жилээр томилно" гэж. Гагцхүү "зөвхөн нэг удаа" гэдэг энэ гуравхан үг байхгүй байна гэж үзэж, Цэц зөрчсөн байна гэсэн шийдвэрийг гаргаад, Дээд шүүхийн энэ шүүгчийг яг яах гээд байгаа нь ийм ойлгомжгүй, ийм нөхцөл байдал үүсчихлээ. Тэгээд би юунд баяр хүргэх гээд байна вэ гэхлээр, би Мөнхсайханд баяр хүргэх гээд байгаа юм. Үгүй ээ, чи нээрээ овоо шүү дээ, эр хурга тэвчинэ, тэвчинэ гэхэд яаж ийм удаан тэвчих вэ дээ, нэг тусгай санал гаргасан байна. Үгүй ээ нээрээ, Цэцийн шийдвэрт бөөнөөрөө эргэлздэг хүмүүс нэмэгдэж байгаад туйлын баяртай байна. Би жилийн өмнө "Цэц ч дээ" гэдэг ийм ойлголттой болсон шүү дээ.

Тэгээд уг нь 6 жил бол үр дүнтэй ажиллахад хангалттай хугацаа, үргэлжлүүлэн ажиллавал хараат бус байдал нь алдагдана гэсэн ийм дүгнэлтийг Мөнхсайхан бичсэн байгаа юм. Тэгээд энийг хүмүүс нь уншиж танилцаад, томилох Ерөнхийлөгч маань анхаараасай. Ганзориг нь дахиад томилогдоно гээд дайрчих вий дээ, бурхан минь. Бүх нийтээрээ харж байгаа шүү. Цэцийг ч гэсэн, Цэцийн даргын ч асуудал, гарсан ч гишүүний асуудал байгаа шүү дээ. Тэгээд Цэц хүртэл ийм нэр хүндгүй ийм шийдвэрүүдийг гаргаад байхлаар бид чинь хэндээ итгэх вэ дээ, хүнд.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Нөгөө өчигдрийн Цэцийн дүгнэлт хэлэлцээгүй бид. Ерөнхийлөгч зөвхөн нэг удаа 6 жилээр сонгогдоно гэсэн Үндсэн хуульд заасан заалт Ерөнхийлөгчийн тухай хуультай зөрчилдсэн байна, Үндсэн хуульд нийцээгүй байна гэдэг асуудал хэлэлцэж байгаа. 2020 онд бол бид чинь Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиараа Үндсэн хуульдаа нийцүүлээд, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг "Ерөнхийлөгч 6 жилийн хугацаатай нэг удаа сонгогдоно" гээд хийчихсэн байгаа. Ерөнхийлөгчийн тухай хуулиа хийгээгүй, энийг ЗГ оруулж ирэх ёстой, ингээд нэлээн удчихсан ийм байгааг ойлгож байгаа байх. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

П.Сайнзориг: Ийм асуудлаар парламент хэлэлцээд сууж байгаа нь эмгэнэл юм даа. 2019 онд оруулсан Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлттэй уялдуулж хууль тогтоомжоо засахгүй, 3 парламент дамнаад явж байгаа нь энэ төрийн зүгээр л байгаа байдал эмгэнэл юм, харамсалтай.

Тэгээд энэ бол Үндсэн хуулийн маргаан биш. Би энэ өнцгөөс уг нь тайлбарлах ёстой байсан. Энэ Үндсэн хуулиас өөрчлөлтөөс өмнө байсан заалт байхгүй юу. Энийг зүгээр нийцүүлэх арга хэмжээгээ яаралтай ав гэдэг хугацаатай зөвлөмжийг, жишээ нь Цэц өгөх л байсан. Уг нь маргаан биш. Бид энэ 4 жилийг бариад, асуудал шийдээд, үр дагавартай шийдвэр гаргаад байгаа юм ерөөсөө байхгүй. Манайд энэ хууль зүйн техник, онолын юмыг ерөөсөө бүр ялгадаг, салгадаг, ярьдаг ч хүнгүй боллоо. Дур дураараа тайлбарладаг боллоо. Үнэхээр харамсалтай байна. Энэ Үндсэн хуульд нийцүүлэх арга хэмжээ болохоос биш, Үндсэн хуулийн зөрчил биш байсан юм. Маргаан үүсгээд явж байгаа нь Цэц өөрөө эмгэнэл. Тэгээд бид хэд энэ Цэцийн хууль тогтоомжийг хурдан сайжруулж өгөхөөс өөр аргагүй гэдэг нь л энэ дээр харагдаад байгаа юм.

Тэгээд ер нь сүүлийн үед энэ Цэцэд их харамсаж байгаа, Монголын шилдэг хуульчид, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн урдаа барьдаг бүх нөхдүүд л гээд байгаа юм. Баясгалан даргаас бусдууд нь бараг МУИС-ийн нөгөө шилдгүүд нь шүү дээ. Тэгэхдээ Үндсэн хуулиа нурааж тоглож байгаа шилдгүүд. 1992 оны ард түмний хүсэл зориг, энэ 3 сая 500 мянган иргэдийн зорьж яваа тэр үнэт зүйл рүү нулимж байгаа этгээдүүд шүү дээ. Би заримтай нь, бүгдтэй нь ажиллаж байсан. Харамсаж байна, танигдахгүй болчихсон байна лээ. Уг нь бол эрх зүйч, хуульч хүмүүс чинь нэг зарчимдаа үнэнч байдаг юм, харамсалтай. Бичиж байсан номууд нь одоо хэрэггүй болсон шүү дээ тэр хүмүүс. Бүгд бичиж байсан номынхоо эсрэг шийдвэрүүдийг удаа дараа гаргаад явж байгаа. Тэгээд ийм хүмүүстэй ер нь хариуцлагын асуудлыг нь ярьдаг байх механизмыг ч гэсэн цаашдаа ярих ёстой.

Би Цэндийн Нямдорж гуай шиг туршлагатай, хор шар нь гарсан ийм хүмүүс очмоор юм байна гэж бодсон. Хүний өөдөөс эгцэлж харж чадахгүй хэдэн юм оччихсон, тэгээд Цэц гэдэг өндөр сэнтийд суучихсан. Тэгээд Цэцэд энэ төрийн эрх мэдэл байдаг юм уу, эсвэл энэ ард түмэн, парламентад байдаг юм уу? Сүүлдээ энэ чинь ингээд тогтолцоогоор нь нурааж байна шүү дээ эд нар, харамсалтай. Тэгээд зарим нь эр хурга энэ тэр гээд магтуулаад сууж байна, мэдэхгүй зүгээр, харамсаж байна. Би тэр нөхдүүдийг хараад сууж байгаа байх, би бүгдтэй нь адилхан яаманд ч ажиллаж байсан хүмүүс байна.../минут дуусав/

С.Бямбацогт: Бид Цэцийг хэлэлцээгүй, Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж байгаа. Бидэнд Цэцийг хэлэлцэх, Цэцийг шүүх эрх байхгүй. Өөрт нь таалагдахгүй шийдвэр гарсан бол шударга бус, өөрт нь таалагдаж байвал шударга гэсэн тийм хандлага байж хэрэггүй. Тийм болохоор хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуултаа асуу. Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Яах вэ танд ч байсан байх Пүрэвдорж дарга, надад ч байсан байх. Би ЗГ-т байж байхдаа Ерөнхийлөгчийн хуулийн шинэчилсэн найруулгыг үүрэг даалгавраа аваад боловсруулсан, тэгээд ингээд өргөн барих шийдвэр гараад л гацчихсан юм, одоо энийг яриад яах вэ, засъя. Гол асуудлууд энэ ерөөсөө зааг ялгаа юмаа хийхгүй байгаад л байгаа байхгүй юу. Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой. Энэ Цэцийн гаргаж байгаа шийдвэр чинь өөрөө Үндсэн хуулийнхаа эсрэг болчихоод байна шүү, сүүлийн үед. Зааг ялгаа байхгүй болчихоод

байна шүү гэдэг зүйлийг л энд хэлж байгаа юм. Тэрнээс биш нэг их хувь хүнтэй ч юм уу сөргөөцөлдөх гээд байгаа зүйл ер байхгүй. Тэгээд сүүлийн үед энэ дисторшин оф лоу (distortion of law) буюу Үндсэн хуулийн эсрэг, хууль зүйн тогтолцооны эсрэг, энэ зарчмын эсрэг явж байгаа хүмүүс дээр бусад орнууд хариуцлага тооцоод эхэлчихсэн. Солонгос жишээ нь шүүгч, прокурор, ийм шүүгч нартаа яг энэ хуулийг гажуудуулж байгаа, мушгиж ингэж шийдвэрлэж байгаа хүмүүс дээр 10 жил хүртэл ял өгдөг болчихсон байхгүй юу. Ийм зүйл. Тэгээд Цэцийг хэн ч шүүхгүй гээд Хурлын дарга тайлбарла.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

О.Алтангэрэл: Хэдүүлээ энэ хугацаа нь дууссан даргатай Цэцээр ер нь хэчнээн асуудал шийдүүлэх вэ? Ер нь хэд шийдүүлэх ёстой болоод байлгаад байгаа юм бол, тэр манай эрх баригчдад энэ шийдүүлэх асуулт, хүслийн жагсаалт нь дууссан юм болов уу, дуусаагүй юм болов уу? Бямбацогт дарга бол их мундаг үг хэлж байна шүү дээ. Аргагүй одоо ингээд ажлаа аваад удаагүй, тэгээд энэ Цэцийн гишүүдтэй холбоотой асуудлыг шийдвэрлэнэ гээд. Одоо хурдан ер нь шийдмээр байна. Аль ноднин жил хугацаа нь дууссан хүн тэнчээ алх цохиод л, юм шийдээд суугаад байдаг. Үгүй ээ, энэ чинь эргэлзээ төрнө шүү дээ. Үгүй ээ, жишээлээд бодоход 10 жилийн ЕБС-ийн багш хүн ажил мэргэжилдээ сайн, хүүхдүүдээ шалгалтад сайн бэлддэг, аав, ээж, хамт олны хайртай багш хүн 55 нас хүрээд тэтгэмжээ аваад шууд тэтгэвэрт гарч байгаа байхгүй юу. Тэтгэмжээ авлаа, цаашаагаа ажиллах ямар ч нөхцөл, бололцоо байхгүй. Тэгээд шууд хөөгөөд гаргана, тэтгэвэрт нь хөөгөөд гаргана.

Цэцийн гишүүн болохоор хамаагүй өндөр цалинтай, хамаагүй их эрх мэдэлтэй, институцийн шинжтэй шийдвэр гаргадаг хүн ингээд жил гаран байгаад байж болдог. Энд чинь бухимдаад байгаа шүү дээ. Тэгээд одоо бид гаргасан шийдвэрийг нь яриад л сууж байгаа. Нэг нь дутуу, нэгийнх нь хугацаа дуусчихсан ердөө есхөн хүнтэй байгууллага, яаж болохгүй вэ гэдгийг заадаг байгууллага өнөөдөр юу хийх вэ гэдгийг бүр заадаг болтлоо ингээд л өөрчлөгдөөд л яваад байгаа.

Тэр энэ Ерөнхийлөгчийн хуультай холбоотой зүйлүүд дээр бид идэвхийлэн ажиллах ёстой. Яг үнэндээ энэ Цэцийн гишүүдийг томилох өнгөрсөн жилийн хурал юу боллоо? Их Хурал бид өөрсдөө хариуцлагатай байх ёстой. Яг үнэндээ "хэн нь МАН-ын дарга болох вэ, хэн нь УИХ болох вэ, Ерөнхий сайд нь огцрох уу, огцрохгүй юу" гэж хэрэлдсээр байгаад л намрын чуулган дууссан шүү дээ, бид бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд нэг ийм хэрүүл, хараал дууссан бол эмх цэгцдээ орж томилмоор байна. Бид УИХ-аас өөр газар Цэцийг ярих газар байхгүй шүү, Бямбацогт даргаа. Бид эндээс ард түмнээс мандат аваад төрийн эрх барих дээд байгууллага төлөөлөөд сууж байгаа. Өвөг дээдсийн маань хэлсэн үг ч байгаа. Монголын нууц товчоон дээр "Бодончар мунхаг бие түрүүтэй, дээл захтай нь сайн" гэсэн.

УИХ хууль тогтоох дээд байгууллага болохынхоо хувьд энэ улсад болохгүй бүтэхгүй байгаа зүйл, нэн ялангуяа институцийн шинжтэй асуудал дээр бид засах ёстой. Тэгэхээр Бямбацогт дарга, тэр судалж шилдэг тэргүүний хүн хайж байгаа тэр асуудлаа хурдлаад хэдүүлээ хүнээ томилъё, та санаачилж байгаа юм байна. Дахиж цаашаагаа хэдэн захиалга гүйцэтгэхийг нь мэдэхгүй, юу хийх нь мэдэгдэхгүй ийм

хүнээр, Монгол Улсын ийм хүмүүсээр, орон тоо дутуу хүмүүсээр Монгол Улсын Үндсэн хууль буюу язгуур эрх ашгийн асуудлыг шийдүүлээд баймааргүй байна гэсэн санал хэлж байна.

С.Бямбацогт: Цэцийн нэг гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусаад жил гаруй болчихсон, нэг гишүүний орон гараад 6 сар орчим хугацаа өнгөрчихсөн байгаа. Миний хувьд УИХ-ын даргаар томилогдоод нэг сар орчмын хугацаа болж байна. Ажилтайгаа танилцах, судлах үйл ажиллагаа зохион байгуулах, мөн энэ орон гарсан албан тушаалууд дээр нэр дэвшүүлэх хүнтэйгээ танилцах, судлах гээд тодорхой цаг хугацаа шаарддаг юм байна. Энийг та бүхэн зөв ойлгоорой. Яг үнэндээ та бүхнийг шаардах хүртэл бол анзаараагүй явсан, энийгээ ойрын үед оруулж ирж асуудлыг шийдүүлнэ Их Хурлаар шийдүүлнэ гэдгээ хэлье. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн. Одоо манайхан нөгөө их гол асуудал маань Ерөнхийлөгчийг Үндсэн хуульд 6 жилийн хугацаатай сонгоно гэхчигсэн байхад Ерөнхийлөгчийн тухай хуульд 4 жилийн хугацаатай улируулж болохоор заачихсан байна. Энэ нь Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн Цэцийн дүгнэлт хэлэлцэж байгаа. Энийгээ яримаар байна. Энэ яг энэ агуулга руугаа л, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуултаа асууж, үг хэлмээр байна шүү. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Цэцийн энэ дүгнэлт сүүлийн үеийн хэдэн дүгнэлттэйгээ холбогдохоор хэд хэдэн хардлагыг төрүүлж байгааг нуулгүй энд хэлж үлдээе. Ганцхан энэ дүгнэлт биш, энэ дүгнэлт нь бусад дүгнэлттэйгээ холбоотой байна гэж харж байгаа. 1 дүгээрт, Ерөнхийлөгчийн хуулийг Үндсэн хуульд нийцүүлэхгүй эс үйлдэл гаргаж, ийм дүгнэлтийг Цэцээр гаргуулж байгаа нь яг ямар учиртай юм бэ 6 жилийн хугацаанд? Зөвхөн Ерөнхийлөгчийн хугацаанаас гадна өөр олон тогтолцооны гажуудлыг Ерөнхийлөгчийн тухай хуулиар шийдвэрлэх ёстой ч өнгөрсөн 6 жилийн хугацаанд санаатай эс үйлдэл гаргалаа. Энийг бид бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Тэгээд тэр нь ч ажиллала, энэ нь ч ажиллала гээд, энэ чинь бүгдээрээ худлаа шүү дээ. Та нар бүгдээрээ зориуд эс үйлдэл гаргаж байгааг бүгд мэдэж байгаа шүү дээ. Энийг нь хэлэх хэрэгтэй.

2 дугаарт, өчигдрийн Цэцийн дүгнэлтийн тухай энд өнөөдөр ярихгүй гэж байна. Гэхдээ өчигдрийн Цэцийн дүгнэлт өнөөдрийн хэлэлцэж байгаа Цэцийн дүгнэлттэй би холбоотой гэж харж байгаа. Холбоос үүсэж байгаа. ҮХЦ өмнө нь гаргасан шийдвэрээ олон удаа өөрчилж байсныг бид бүгдээрээ мэдэж байгаа, Эрх биш мартаагүй байх. Сонгуулийн тогтолцоотой холбоотой, давхар дээлтэй холбоотой энэ олон сайд нарын асуудлыг Цэц хэчнээн ч удаа өөрчилснийг бүгд мэдэж байгаа. Цэц ингээд шийдвэрээ өөрчилж болдог юм шүү дээ. Үндэслээд засаж залруулж болдог. Гэхдээ энэ удаа яагаад Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн энэ томилгооны, дахин томилгооны асуудлыг нээж байгаа юм бэ? Энэ бол зөвхөн Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн асуудал биш. Энэ 6 жилээр нэг удаа сонгогддог өөр бусад албан тушаалтнууд тест хийчихлээ. Дээд шүүхээр далимдуулж энийг яаж явуулж болох вэ гэдэг тестийг хийчихлээ. Энийг бид хэлэх хэрэгтэй шүү дээ илэн далангүй.

Би яагаад ингэж харж байгаа вэ гэвэл өчигдөр Цэцийн хуралдаанд итгэмжлэгдсэн, мэдээлэл гаргасан хүн өчигдөр орой пост хийхдээ хамгийн сүүлийн өгүүлбэр нь анхаарал татсан. Ямар өгүүлбэр бичсэн бэ гэвэл "нэг удаа улиран томилогдож болно гэдгийг Цэц өөрөө хүчингүй болгосон мөртөө бусад этгээд дээр түүнийгээ хэрэгжүүлэхээс татгалзах нь үндэслэлгүй юм" гэж бичсэн. Энэ юу, хэнийг хэлээд байгаа юм бэ?

3 дугаарт, Их Хурал өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд томилох ёстой, та нар ажлаа хийгээч гээд байна. Энийг Их Хурал томилдоггүй, нам томилдоггүй, намын бүлэг шийддэггүй, хэдхэн ах нар шийддэг юм шүү дээ. Энэ яриа ер нь хаагуур, яаж явдгийг бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Энийг нь та нар хэлээч, бид оролцдоггүй биз дээ, оролцож байсан хүн энэ танхимд байгаа юм уу? Хэдхэн л хүн шийддэг юм шүү дээ. Өчигдөр ҮХЦ-д өгсөн тайлбар, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн байр суурь бидний хамтын шийдвэр биш шүү, хамтын байр суурь биш.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэмэлт нэг минут Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Ер нь энэ ҮХЦ-д хэнийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилоод байгаа юм бэ, улс төрийн намуудын төлөөлөл яаж орох юм бэ, Цэцэд ямар тайлбар өгөх юм бэ гэдгийг Дэгийн хуулиар огт зохицуулдаггүй, бид хамтаараа энийг ерөөсөө огт ярилцдаггүй. Тэгэхээр төлөөлөгч төлөөлүүлэгчийн хүсэл зоригийг хууль ёсны дагуу бүрэн илэрхийлдэггүй. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд ийм явж ирснийг өчигдөр бүгдээрээ сонссон. Энийгээ бид ярих ёстой шүү дээ, манай ХЗБХ.

Хамгийн сүүлд хуульчдадаа хандаж нэг зүйлийг хэлье. Хуульчид бол энэ чуулганыг, энэ дээр яригдаж байгаа яриаг бүгд сонсож байгаа. Бүгдээрээ карьераа гоё эхлүүлдэг, нэр төртэй авч явдаг, харин нэр төртэй дуусгах ёстой юм байна. Энэ чинь ухаан юм байна, олон хуульчдаас энэ харагдаж байгаа. Бид сургамж авах ёстой, би бол дотроо сургамж аваад бодолтой карьераа дуусгах ёстой юм байна гэдэг дээр маш их зүйл.../минут дуусав/

С.Бямбацогт: ХЗБХ хариулъя. УИХ-аас томилдог албан тушаалтнуудын томилгоо бүгдээрээ яг өөрийн чинь хэлдэг нөгөө цөөхөн хүмүүсийн хүрээнд яригддаг, шийдэгддэг байсан. 2020 онд миний бие УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийг санаачилж, Их Хурлаар батлуулаад, 2021 онд. УИХ-аас томилогддог бүх албан тушаалтнууд дээр томилгооны сонсгол хийдэг, сонгон шалгаруулж, ажлын хэсэг байгуулж энэ ажлууд шийдэгддэг болсныг та мэдэж байгаа байх. Энэ хүрээнд л асуудлууд шийдэгддэг болсон. Харин зарим Цэцийн дүгнэлт гараад, зарим асуудлууд дээр томилгооны сонсгол хийх, нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, нээлттэй нэр дэвшүүлж сонгон шалгаруулах процесс өөрчлөгдөн юмнууд бол байгаа. Одоо бол ихэнх томилгоо бол томилгооны сонсгол хийж явдаг болсон шүү. Нээлттэй ард иргэдэд, Их Хурлын гишүүдэд нээлттэй яг ямар хүн оруулж ирэв, ямар үүхтэй түүхтэй, ямар удам судартай, ямар ажил албан тушаал хашиж байсан, ямар алдаа гаргаж байсан бүх юмыг нь нээлттэй нэр дэвшүүлээд, нээлттэй ажлын хэсэг байгуулаад, тал талын бүх субъектүүдээс ажлын хэсэг нь ийм хүмүүс нь шаардлага хангаж байна гэснээ оруулж ирээд, Байнгын хороон дээр нь чөлөөтэй асуугаад, хариултаа аваад, хэлэлцүүлэг зохион байгуулаад, томилгооны хэлэлцүүлэг, ингээд түүнээс нь тэнцсэн хүмүүсийг нь Их Хурлаар оруулж ирж томилдог энэ бол бидний шийдсэн хууль шүү. Урд өмнө бол өөр байсныг өөрчилсөн гэдгийг та мэдэж байгаа байх. Цогтбаатар гишүүн хариулъя.

Д.Цогтбаатар: Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр би явъя гэж гуйгаагүй шүү нэг. Тийм учраас эндээс томилогдоод хууль ёсоор, албан ёсоор би очиж тэр юуг хийсэн. Тайлбарыг УИХ-ын Тамгын газраас зөвлөгөө авч байж, энэ тайлбарыг хийж явуулсан. Түүнээс ХЗБХ дангаараа энийг хийсэн юм байхгүй.

2 би бол хууль барьдаг жижигхэн л хүн, би хуульд захирагдаж амьдарна. Өчигдөр тэр хуралд яваад очиход хүчин төгөлдөр ҮХЦ-ийн шийдвэр байж байгаа юм. Би тэрэнд нэгэнт хүчин төгөлдөр гарчихсан шийдвэр, тэрийг нь дагаад УИХ хуулиа тэр шийдвэрийг нь дагаад өөрчилчихсэн юмыг би өөрөөр яриад сууж байдаг тийм том хүн биш. Би хуульд захирагдаж амьдардаг жижигхэн иргэн. Харин тэр юу, дараа нь шинэ өөрчлөлтийг 2021 онд оруулж ирэхдээ би харин нэг гайхсан юм нь, яагаад тийм өөрчлөлтийг оруулсан нэг ч тайлбар байхгүй байна лээ шүү. ҮХЦ-ийн шийдвэр байгаад байдаг, Их Хурал нь өөрөө өөрчилчихсэн байгаад байдаг. Тэгсэн тийм өөрчлөлтийг оруулж байхдаа нэг ч тайлбар хийлгүй, ЗГ-аас өргөн барьсан нь бол харин тэр нэг удаа гэдэг юутай чинь байхгүй байгаа байхгүй юу.

Их Хурал дээр оруулж ирээд ийм нарийн хуулийг бид Эрүүгийн хууль эд нар дандаа ЗГ-аас өргөн баригдаж байх ёстой гэж ярьж байгаа шүү дээ. Тэгж байгаад дөнгөж сая буцаасан шүү дээ. Тэгээд ЗГ-аас чинь тийм юмгүй ороод ирсэн чинь энэ ажлын хэсэг дээр өөрчилсөн байгаа байхгүй юу. Би энийг нь л ярьсан. Тэгээд энэ бол би нэг ч юм худлаа яриагүй, бодит байгаа фактыг нь л хэлсэн. “Танай ҮХЦ-ийн гаргасан шийдвэр чинь ийм байна” гэсэн. Тэгээд ҮХЦ өнөөдөр яг энэ шийдвэрээ гаргаж байна. Хэрэв ҮХЦ өөр шийдвэр гаргасан бол би тэрийг нь дагаад л мөрдөөд явна. ҮХЦ өөрийнхөө шийдвэрийг ахиад яг тэр утга агуулгаараа гаргаж байна шүү дээ. Тэгэхлээр би тэр ҮХЦ-ийн шийдвэрээ л дагаад явна, би тэр фактуудыг л дурдаж ярьсан.

С.Бямбацогт: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуултаа асууж, үг хэлье, алга байна. Лхагвын Мөнхбаатар гишүүн.

Л.Мөнхбаатар: Их Хурлын дарга, өнөөдөр Цэцийн дүгнэлтийг өнөөдөр хэлэлцэж байна л даа. Энэ хэлэлцүүлэг явагдаж байдаг, хэлэлцүүлэг дээр бол дүгнэлтийг танилцуулсан ҮХЦ-ийн гишүүд байхгүй байна, оролцохгүй байгаа. Энэ асуудал бол сүүлийн бараг жил орчим ер нь ҮХЦ-ийн гишүүд дүгнэлт танилцуулчхаад шууд гараад явчихдаг. Их Хурлын танхимыг орхиод гараад явчхаад байгаа. Энэ хэлэлцүүлэгт бол оролцож сонсох ёстой. Хэдийгээр гаргасан шийдвэрээ тайлбарлаж асуултад хариулахгүй байж болно, энийг ойлгож байгаа. Гэхдээ энд хэлэлцүүлэг явагдаж байна, уг дүгнэлтийн үндэслэлийн талаар Их Хурал авах уу, үгүй юу гээд шийдвэр гаргахтай холбоотой олон үндэслэлүүдийг энд яригдаж байх үед оролцож байх нь зүйтэй. Энийгээ Дэгийн хууль яригдаж байгаа энэ үед Их Хурлын дарга энийгээ оруулах нь зүйтэй байх шүү гэдгийг хэлье гэж бодож байна.

Ер нь энэ Цэцийн дүгнэлт бол их тодорхой гарсан байгаад байгаа шүү дээ. ЗГ Их Хурлын шийдвэрийг биелүүлээгүй байна, эс үйлдэхүйгээрээ 6, 7 жил Ерөнхийлөгчийн тухай хуульд орох өөрчлөлтийг оруулах энэ асуудлыг хийж гүйцэтгээгүй байна гэсэн буюу хууль дээдлэх зарчмыг зөрчсөн байна гэсэн энэ Цэцийн дүгнэлт гарчихлаа. Тийм учраас энийг бол том агуулгаар нь ярих хэрэгтэй. Байнгын хорооны гишүүд, зарим гишүүд яриад байна лээ. Энэ бол зүгээр техникийн шинж чанартай юм. 6 жил гээд Үндсэн хуульд заачихсан байсныг 4 жил гээд Их Хуралд юу, Ерөнхийлөгчийн тухай хуульд 30 дугаар зүйлд заасан энэ заалтаа өөрчлөөгүйг техникийн зүйл гэж үзэж бол болохгүй, Энэ бол өөрөө агуулгаараа энэ төрийн байгууллагууд эс үйлдэхүйгээрээ хууль дээдлэх зарчмыг зөрчсөн гэсэн ийм дүгнэлт гаргасан шүү гэдгийг онцгой анхаарах нь зүйтэй шүү. Энийг бол хэлье гэж бодож байна.

2019 оноос хойш энд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дараа тодорхой хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлүүдийг бол ЗГ-т өгсөн, 2020 онд өгсөн. 30 хуульд 66 агуулгаар ийм өөрчлөлт хийх нь зүйтэй гэсэн чиглэл өгсөн. Энэ хуулиуд маань одоо ер нь хаана яваад байна вэ? Зарим хуулиуд орж ирсэн, бас нэлээд нь орж ирээгүй явж байгаа. Нийтийн өмчийн тухай хууль, энэ ойлголт бол шинэ нэр томъёо орж ирсэн, тэр байхгүй байна. Нөгөө Мэдэх эрхийн тухай хууль гээд манай Их Хурлын дарга өөрөө энийг хамгийн их ярьж оруулж ирсэн, тэр заалт маань орж ирээгүй байна.

Ерөнхийлөгчийн тухай хуультай холбоотой энэ заалтууд мөн орж ирээгүй байж байна. Энэ тойргийн шүүх байгуулахтай холбоотой энэ эрх зүйн орчин бүрдсэн, энэнтэй холбоотой асуудлууд бас тодорхой болоогүй байна. Шүүхтэй холбоотой том өөрчлөлтүүд орж ирсэн. Нийтийн өмчийн тухай гээд энэ том ойлголтууд маань мөн Их Хурлаар орж шийдэгдээгүй байгаа юм. Тийм учраас энэ өөрөө бол энэ эс үйлдэхүй буюу ЗГ Их Хурлын өмнө хүлээсэн үүргээдээ биелүүлж оруулж ирэх ёстой, энэ ажлыг шуурхайлах ажлыг зохион байгуулах нь зүйтэй байна. Ингэж байж Үндсэн хуулийн маань хэрэгжилт өөрөө хангагдах ёстой. Үндсэн хуулийн өөрчлөлт бол, нэмэлт, өөрчлөлт батлагдаад багагүй хугацаа өнгөрлөө, 7 жил болж байна шүү дээ. Тэгэхээр энэ талаар Их Хурлаас энэ ЗГ-т тодорхой чиглэлийг мөн ахин өгч, өмнө нь гарсан 2 мянга.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнхбаатар гишүүн гүйцээгээд асуултаа асууя.

Л.Мөнхбаатар: Тэгэхээр энэ Их Хурлын 2020 онд өгсөн 02 дугаар тогтоол байгаа байх. Тэр тогтоолоор өгсөн энэ холбогдох хууль тогтоомжуудыг боловсруулж, өргөн барьж батлуулах энэ үүргийг нь, хэрэгжилтийг нь 1 дүгээрт авч үзээд, мөн батлагдаагүй саяын энэ Ерөнхийлөгчийн тухай хуулийн энэ 30 дугаар зүйлтэй адилхан ийм зүйлүүд байгаа бол яаралтай оруулж батлах асуудал дээр манай Их Хурал, ТББХ ялангуяа тодорхой асуудлыг авч Их Хурлаар хэлэлцүүлж, Байнгын хороон дээрээ сонсоод энэ асуудлаа шийдэх нь зүйтэй байгаа шүү гэдгийг хэлье гэж бодож байна.

С.Бямбацогт: Энэ УИХ-аас баталсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тал дээр ЗГ илүү анхаарах ёстой, хэрэгжилтэд хяналт тавих тал дээр Их Хурлаас илүү ажлаа сайжруулъя гэсэн саналууд хэллээ гэж ойлголоо. Бид анхааръя. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя. Алга байна. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Жаргалан: ҮХЦ-ийн дарга Гунгаагийн Баясгалан гэж хүн Монгол УИХ-ын 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 58 дугаар тогтоолоор ҮХЦ-ийн гишүүнээр томилогдсон. Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн нэгд "ҮХЦ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацааг 6 жил байна" гэж маш тодорхой заасан байдаг. Гэгэл бүрэн эрхийн хугацаа нь дууссан ҮХЦ-ийн гишүүн нь Цэцийн даргаар ажиллаад улс төрийн онц ноцтой үр дагавар бүхий шийдвэрүүд гаргаад явж байна. Тэгэхээр ийм байж болдог юм уу? ҮХЦ-ийн дээр хөх тэнгэр л байдаг гэж яриад байгаа, бид ч тэгж бодож итгэж явсан.

Гэтэл үнэн хэрэгтээ ҮХЦ-ийн дээр биш ээ, ҮХЦ-ийн гишүүдийн дээр хөх тэнгэр биш, томилох, томилсон субъект нь л байдаг юм байна шүү дээ. Тэгээд Үндсэн хуулийн манаач байх ёстой бүрэлдэхүүн нь ингээд улс төрийн захиалга гүйцэтгэгч болчхож болдог юм уу? Тиймээс энэ бүрэн эрхийн хугацаа нь дууссан

этгээд ҮХЦ-ийг даргалаад, Их суудлын хуралдаанаараа ийм онц ноцтой улс төрийн үр дагавартай шийдвэр өчигдөр гаргалаа. Түүнээс 2 долоо хоногийн өмнө гаргалаа. Энэ шийдвэрүүдийг гаргах тийм легитим чанар байгаа юм уу, тийм хууль ёсны чадамж байгаа юм уу гэдэг асуудлыг бид ярих ёстой. Түүнээс биш зөвхөн энэ хугацаа нь дууссан хүний оронд орных нь хүнийг томилох тухай асуудал биш.

Тэгэхээр би бол юу гэж бодож байна вэ гэхлээр, УИХ ҮХЦ-ийн даргыг эгүүлэн татах шийдвэр гаргаад, дараа дараачийн шийдвэрүүд дээр ямар асуудлыг тусгах ёстой вэ гэдгээ ярих ёстой гэсэн ийм бодолтой байгаа. Яагаад вэ гэхлээр сүүлийн үед бол ҮХЦ маш ноцтой ийм улс төрийн үр дагавартай шийдвэрүүдийг гаргаад явчихлаа шүү дээ. Тэгэхээр 05 сарын 13-нд Их суудлын хуралдаанаараа хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой шийдвэр гаргасан. Өчигдөр энэ Улсын дээд шүүхтэй холбоотой шийдвэр гаргачихлаа. Тэгэхээр энэ шийдвэрүүдийн үр дагавруудыг бид бодох ёстой юм.

2 дугаарт, энэ өнөөдрийн орж ирж байгаа ҮХЦ-ийн дүгнэлттэй холбоотойгоор УИХ яагаад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд холбогдох хуулиудыг нийцүүлээгүй вэ гэдэг асуудал яригдаад байгаа юм. Тэгээд 3 парламент дамналаа гэж ярьж байгаа. Тэгэхэд энчээ бас нэг хүний асуудал яригдах ёстой. ҮХЦ-ийн гишүүнээр ажиллаж байгаад сая УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар /ЕНБД/ хүрээд ирчихсэн хүн чинь 2019-өөс 2023 оны хооронд мөн УИХ-ын ЕНБД-аар ажиллаж байсан буюу энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор холбогдох хуулиудыг нийцүүлэх асуудлыг удирдан зохион байгуулах, УИХ-ын Тамгын газрын асуудлыг зохион байгуулах ёстой тэр хүн байсан. Тэгэхээр энэ Өлзийсайхан гэдэг хүнтэй хариуцлага тооцох ёстой гэж бодож байгаа. Ер нь энэ хариуцлага алдсан хүмүүстэй хариуцлага тооцож чадахгүй, дэвшүүлэн зайлуулаад, энд тэнд байршуулаад яваад байгаатай чинь холбоотой л ийм алдаа, завхралууд гараад байна шүү дээ.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Х.Тэмүүжин: Өнөөдөр ҮХЦ-ээс орж ирж байгаа энэ дүгнэлт УИХ ажлаа хийгүй байгаагийн л том илэрхийлэл. Тэгээд бид хэд ч гэсэн УИХ-ын хууль тогтоомжийнх нь зарим хэсэг дээр нэг боловсруулалт, боловсронгуй болгох чиглэлээр нэг анхаарч ажиллах хэрэгтэй юм байна. Ийм илт алдаатай тоо, үсэг 2 дахиа орж ирж байна шүү дээ. Өмнө нь ЗГ, Ерөнхий сайдыг огцруулах асуудал дээр "3 хоногийн дараагаас хэлэлцэж 10 хоногийн дотор" гэж үг байсныг нь бид УИХ-ын тухай хууль дээрээ "7 хоног" гээд биччихсэн байгаа. Илт алдаатай.

Сая бол Үндсэн хуулиар 6 жил болчихсон байгаа зүйлийг одоо хүртэл засахгүй 4 жил гээд явж байгаа. Тэгэхээр ийм илт алдаатай, техникийн шинжтэй концепц буюу үзэл баримтлалыг нь УИХ угаасаа тодотгоод баталчихсан, нэг мөр ойлгодог болчихсон тэр үзэл баримтлалыг засах ёстой, кодификаци хийх ёстой хууль, тогтоомжуудыг нийцүүлэх ёстой ийм зүйлүүдийг зүгээр л үзэл баримтлалыг нь хэлэлцэж байгаа шиг хуулийн нүсэр процессоор хэлэлцэхгүйгээр, хурдан хугацаанд хялбарчилсан байдлаар баталдаг, шийддэг нэг журамтай болох ёстой юм байна.

Дээр нь ийм илт алдаатай зүйлийг ҮХЦ-ээр яг л маргаан шийдвэрлэж байгаа юм шиг дахиад нүсэр процесс явдаг биш, "ҮХЦ энэ чинь илт алдаатай байна" гээд

нааш нь зүгээр бичиг шидэхэд тэрүүгээр нь ажилладаг механизмтай болох ёстой юм байна. Тэгэхгүй бол ингээд Цэц нь тэнд нэг том хэрэг маргаан шийдчихсэн юм шиг, энэ дээрээ ирээд УИХ нь нэг Цэц, УИХ 2 хоорондоо маргаад байгаа юм шиг үл ойлгогдох байдал руу очдог биш, энэ хаана хаана алдаагаа хараад, хурдан техникийн шинжтэй засвар хийдэг нэг механизм хийх ёстой байх. Яг энэнтэй адилхан дахиад илт алдаа ҮХЦ дээр гарч байгаа юм. Бүрэн эрх нь жил болоод, бүрэн эрх нь дуусаад жил болчихсон ийм хүн ҮХЦ-ийн дарга хийж байгаа байдал нь тэнд гишүүний асуудал биш, ҮХЦ-ийг бүхэлд нь хууль ёсны юу, үгүй юү гэдэгт эргэлзэх тийм дүр зураг үүсгэж байгаа юм. Зүй нь бол тэндээ бас хялбарчилсан журам гаргаад, бүрэн эрх нь дуусчихсан хүнээр даргалуулж болохгүй гэдэг хууль тогтоомжийнх нь ойлгомжтой байдлыг тодорхойлж өгөх ёстой юм байна.

Тэнчээ бүрэн эрх нь дуусаагүй дахиад 6, 7 гишүүн байж байгаа шүү дээ. Тэр дундаасаа дарга тавьчихсан байсан бол өдийд Цэцийн бүтэн үйл ажиллагаанд нь эргэлзэх эргэлзээ алга болох байхгүй юу. Нэг гишүүнийх нь үйл ажиллагаанд л эргэлзэж болно. Гэтэл одоо бүрэн эрх нь дуусчихсан хүн Цэцийг даргалаад байхаар Цэцийн бүтэн үйл ажиллагаанд нь эргэлзэж байна. Зохион байгуулалтынх нь хувьд, шийдвэр гаргаж байгаа тэр шийдвэрийнх нь бүтэн бүтцийнх нь хувьд, шийдвэрээ хуваарилаад, сүүлдээ яг яаж хардаж эхэлж байна вэ гэхээр "энэ чинь улс төрийн захиа даалгавар гүйцэтгээд байна, улс төрийн захиа даалгавраа яаж гүйцэтгэж байна вэ" гэхээр "бүрэн эрх нь дуусчихсан нэг хүнд би чамайг буцаагаад томилчихно, чи миний үгээр байвал болоо шүү" гэж хэлээд жил бариад, жил өөрийнхөө.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Н.Алтанхуяг: Санал хэлнэ. Ер нь өнөөдрийн Монголд хууль ёс гэдэг юм нэг уландаа гишгэсэн ийм л улс болж хувирлаа. Хууль уландаа гишгээд зогсохгүй, Үндсэн хуулиа уландаа гишгэдэг болсон. Энэ 2019 онд Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр бол Монгол Улсын Ерөнхийлөгчийг 1 удаа 6 жилээр сонгохоор заасан заалт. 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийг өнөөдөр бид 2026 он, 7 жилийн дараа, тэгээд УИХ, ЗГ өөрснөө биш, ҮХЦ-ээр шийдүүлээд сууж байгаа. Энэ бол дампуурчихсан юм биш үү манайх. Энэ сүүлийн 10 жилд ер нь хэтэрхий юм доройтож байгаа юм биш үү, ард түмний ахуй амьжиргаа, олон юм уруудан доройтохоос гадна, хууль ёсоо дээдлэх, тэр дотроо Үндсэн хуулиа дээдлэх гэдэг юмыг уландаа гишгэлээ. Маш их ийм харамсалтай л юм болж байна. Харамсаад ч барахгүй л юм боллоо.

Дээр нь хууль ёс засагладаг биш, хувь хүн засагладаг иймэрхүү юм руу орлоо. Уг нь өмнө нь аймаар их ярьдаг байсан даа, манай Ардын намынхан. "Хувь хүн засаглахгүй, хууль засаглана" гэж, үгүй ээ мөн хуцав. Энэ 10 жилд бүр эсрэг боллоо. Тэр Үндсэн хуулийнхаа Цэцийн даргыг хүртэл, цаана нь бүрэн эрхтэй гишүүд нь байсаар байхад тэд нараас тавиад явах ёстой, яагаад ийм Баясгалан гэдэг хүнийг байлгаад байгаа юм бэ? Дахиад л улс төрийн захиа, улс төрийн даалгавар, дээрээс нь дарамт шахалт энэ асуудлыг авч Үндсэн хуулиар авч хэлэлцэхийг боль, энүүгээр авч хэлэлц, ийм шийдвэр гарга гэж. Өчигдөр гаргаж байгаа шийдвэр чинь энэний яруу тод жишээ шүү дээ.

Шүүхийн хууль дээр би орж ажиллаж байсан, нэг жилийн хугацаатай үндсэн юу билээ, Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг томилно гэсэн. Энэ чинь Үндсэн хууль

зөрчсөн байна гэдэг шийдвэр өмнө нь бас нэг удаа гарч байсан юм. Ингээд л гаргаад л. Тэгээд 06 дугаар сарын 02-нд хугацаа нь дуусдаг хүн, дуусаж байгаа хүнийг буцааж томилох юм гэнэ. Ийм шившигтэйгээр энэ ард түмний өмнө бид энд сууж, ингэж байх хэрэг байдаг л юм байх даа. Та нар маань нэг ярьж болдоггүй юм уу? Энэ чинь 10 жил олонх болж, 10 жил бодлого тодорхойлж, 10 жил завхрал хийж байна шүү дээ. Энийгээ зогсоож болохгүй юү Ардын нам? Ардын нам ч гэж дээ, ер нь хувь хүмүүс л засагладаг болчихсон, тийм, нам гээд хэлэхэд хэцүү болжээ. Танай намын нэг хэсэг нь миний явсан зовлонгоор явж л байх шиг байна. Тэгэхээр танай талын.../минут дуусав/

С.Бямбацогт: Гишүүд Цэцийн дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууслаа. Ер нь яах вэ, бидний байж байгаа байдал л даа. Дээрээ суудлаа олохгүй бол доороо гүйдлээ олохгүй гээд. Тэгээд улс төржөөд л сандал, ширээ, эрх мэдлийнхээ төлөө илүү анхаарал тавиад, улс орныхоо эдийн засаг, нийгмийн амьдрал, ард түмнийхээ аж амьдрал, УИХ-ын хэлэлцэж байгаа хууль тогтоомж, энэ УИХ баталж байгаа хууль тогтоолоо яаж хэрэгжүүлэх вэ, хяналт тавих вэ, энэ давхардал, хийдэл, зөрчлүүдийг нь яаж алга болгох вэ гэдэг үндсэн гол ажилдаа бага анхаардаг, улс төржих юмандаа илүү анхаардгийн л сул талууд нь ингэж гарч ирж байгаа юм. Бид нар, та, би. Тийм. Тийм болохоор бид цаашдаа жоохон энэ алдаануудаа засъя. Үнэхээр шинэ 126 гишүүн болсон юм бол шинэ 126 гишүүн шиг байя. Үнэхээр хуульч нь бол хуульч шиг байя. Тэгээд энэ засах, залруулах зүйлээ засаж залруулъя. Энэ ч үүднээсээ УИХ-ын тухай хууль, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар өргөн барьсан байгаа. Энийгээ яаралтай хэлэлцээд, энэ хууль цэгцэрвэл бусад хуулиуд цэгцрэх боломжууд бий болно.

ҮХЦ-ийн тухай хууль, ҮХЦ-д хэрэг маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудыг ойрын үед шинэчилж найруулж өргөн барихаар ажлын хэсэг ойрын үед байгуулна. Энэ яриад байгаа гишүүдээс оруулж байгаад энэ ҮХЦ-ийн энэ асуудлууд дээр тодорхой анхаарал тавьцгаая хэдүүлээ. Санал хураалт явуулах боломжгүй байгаа, 16:00 цагаас санал хураалт явуулна. Санал хураалтыг хойшлууллаа, 16:00 цагаас. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

12.30 цаг

Дөрөв.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна. Төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны танилцуулгыг УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Батжаргалын Заяабал танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Заяабал: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл,

2028-аас 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг УИХ-ын чуулганы 2026 оны 05 дугаар сарын 21, 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийж, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.4-д заасны дагуу төслийн эцсийн хувилбарыг бэлтгэн, танилцуулгын хамт та бүхэнд хүргүүлсэн.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд ДНБ-ий бодит өсөлтийг 2027 онд 5.8 хувь, 2028 онд 6 хувь, 2029 онд 6.3 хувь, хэрэглээний үнийн өсөлтийн түвшнийг 2027 онд 7 хувь, 2028 онд 6 хувь, 2029 онд 5 хувь байхаар тооцсон. Мөн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 2027 онд 34 их наяд 780 сая төгрөг буюу ДНБ-ий 30.4 хувь, нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээг 2027 онд 36 их наяд 493 сая 400 мянган төгрөг буюу ДНБ-ий 31.9 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 2027 онд 1 тэрбум 713 сая 400 мянган төгрөг буюу ДНБ-ий 1.5 хувьтай тэнцэх, ЗГ-ын өрийн дээд хэмжээг 2027 онд 57 их наяд 114 сая 900 мянган төгрөг буюу ДНБ-ий 50 хувьтай тэнцэхээр байна.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулах үед УИХ-ын гишүүн Батнайрамдал Оюутолгой компанийн тайлантай холбогдуулан тус компани нь ногдол ашиг хуваарилах боломжтой эсэх, болон менежментийн төлбөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар, УИХ-ын гишүүн Эрдэнэбат дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тооцоолсон инфляц нь бодит нөхцөлтэй харьцуулахад зөрөөтэй байгаа талаар дурдаж, 2029 онд инфляцыг 5 хувьд хүргэх боломж байгаа эсэх, томоохон орд газруудын төрд авах ногдол ашиг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төсөөлөл, мөн төрийн худалдан авалттай холбоотой төсвийн хөрөнгө оруулалтын зардлын өсөлт болон үр өгөөжийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналгүй тул Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.5-д заасны дагуу, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагад нийцсэн эсэх талаарх дүгнэлт гаргаагүй болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 12 цаг 32 минутаас хуралдааныг даргалав.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцох ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн

Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Содномдаржаагийн Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Равсалын Рэнцэнбазар Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Азжаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга.

Монгол УИХ-ын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ЗГ-ын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэх үүрэгтэй, 21.25-д "нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-ын хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. 21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ гэж заасныг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд танилцуулж байна.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух УИХ-ын гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт. Үг алга байна шүү. Үгүй байна, зөвхөн асуулт байна шүү. Баасанжаргал гишүүнийг оруулъя. Тэндээс Уянгахишиг гишүүн, Мандхай гишүүн, Эрдэнэбат гишүүн, Алтанхуяг гишүүн эдгээр гишүүдийг оролцуулъя. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Би Энхбаяр сайдаас асууя. Асуултаа асуухдаа тодорхой нэг үйл явдал ярья. 2024 оны 08 сарын 12-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчид ҮАБЗ-ийн тэргүүнийх нь хувьд тухайн үед албан бичиг явуулсан. Энэ Аюулгүй байдлын үзэл баримтлал зайлшгүй өөрчлөх засах шаардлагатай байгаад байна. Тухайлбал энд заагдсан 10 жилийн хугацаатай ажлууд хийгдсэнгүй. Эрчим хүчний бие даасан байдлаа хангана, шатахууны хараат бус байдлаас гарна гээд баахан хугацаатай зорилгууд тавиад биелээгүй. 2010 оны 07 сарын 15-ны өдрийн УИХ-ын тогтоолоор энэ Аюулгүй байдлын үзэл баримтлал батлагдаад ингээд явсан. Энэ нэг тусдаа асуудал.

Нөгөө талд нь төсөв, төсвийн хүрээ, төсвийн төсөөлөл тийшээгээ чиглэсэн бид хөгжлийн төлөвлөгөөгөө ингээд 1, 1 жилээр нь батлаад явж байгаа. Эдгээр зүйлс Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэх талаар шалгуур үзүүлэлт буюу эрэмбэ тогтоох зайлшгүй шаардлагатай байгаад байна гэдэг асуудлыг би 2 жил удаа дараа ярьсан. Бямбацогт даргад хүртэл яг энэ асуудлыг хэлсэн. Бичгүүд явуулаад байдаг, хариу ирдэггүй. Энэ яагаад яригдаад байгаа юм

бэ гэхлээр өнөөдөр Монгол Улсын төсөв улс төрд нөлөө бүхий субъект өөрийнхөө тойрог руу юм уу, өөрийнхөө салбар луу лобби хийж байгаа.

Сая Лувсанжамц гишүүний ахалсан ажлын хэсэг дээр 200 гаран хөрөнгө оруулалтын зарчмын зөрүүтэй саналууд орж ирсэн, 75 хувь нь унасан. Ингээд харж байхад энэ дээр улс төржсөн, тодорхой тойргийн эрх ашиг давамгайлсан байгаа болохоос биш, Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд зориулагдсан тэр төсөв, тийшээгээ чиглэсэн тэр төсвийн хүрээ, тийшээгээ чиглэсэн хөгжлийн хөтөлбөр явахгүй байна. Ийм ч үүднээс яг Монголын хөгжлийг тодорхойлох эрүүл мэндийн асуудал, боловсролын асуудлууд бүгд хаягдаж байгаа. Өнөөдөр Монголд байгаа нийт сургуулиудын дийлэнх нь 60, 70 оны үед ашиглалтад орсон, 80-аад оны сүүл үед ашиглалтад орсон эмнэлэг, сургуулиуд байгаа, бүгдээрээ их засварын асуудалтай, бүгдээрээ шинээр барих асуудалтай болчихсон. Асар цөөхөн суурь дэд бүтцийн хатуу дэд бүтцүүд шийдэгдсэн.

Дээрээс нь эмнэлэг, сургуульд зөөлөн дэд бүтэц буюу тэр багш, ажилчдын цалин, нийгмийн асуудал, хөдөөг зорьж очиж байгаа хүмүүсийг тогтоодог тэр асуудлууд алдагдчихсан. Ингээд энэ бүхэн чинь юуг илтгээд байна вэ гэхлээр, бидний дараа жилийнхээ мөнгийг төсөвлөж байгаа, орлого, зарлагыг тодорхойлж байгаа энэ асуудлууд, зарцуулалт нь, зохиомж нь өөрөө Монгол Улсын иргэний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох Үндсэн хуулийн тэр язгуур эрхийнхээ дагуу жам ёсны эрхээ эдэлдэг байх тэр зүйл алдагдчихаад байгаа.

Салбарын сайдуудаас "яагаад энийг хийхгүй байгаа юм бэ" гээд асуухаар "бид хөнжлийнхөө хэрээр хөлөө жийж байна" гэж хариулдаг, гал унтраасан байдалтай болчихсон. Тэгэхээр Энхбаяр сайдаа, одоо яг энэ төсвийн хүрээ, төсөөлөл дараад нь төсвийн асуудал бидний хамгийн гол маргалддаг, улс төрждөг сэдэв мөн. Гэхдээ энэ дээр яг энэ эрэмбэ, шалгуур үзүүлэлтээ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтайгаа нийцүүлсэн байдлаар тодорхойлох ёстой болчихоод байгаа юм. Одоо байгаа хуулийн гарц нь болохоор Аюулгүйн зөвлөлөөс журам батална гэхихсэн байгаа, тэр нь батлагдаагүй 16 жил явчихсан. Эсхүл энийг тэд чадахгүй бол Их Хурал өөрсдөө батлах гарц үлдчихсэн. Тэгэхээр та Тэргүүн Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд хийж байгаа хүний хувьд энэ дээр яг та тодорхой гарц, байр суурь хэлээч? Энийг хийчихвэл танд ч амар, засагт ч амар, бидэнд ч амар байхгүй юу. Тийм учраас төсвийн араас тойрог руугаа лобби хөөж гүйдэг биш, зүгээр л Монголд хэрэгтэй гэсэн төсвийг бид баталдаг болмоор байна. Энэ дээр хариулт авъя.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр Тэргүүн Шадар сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Та их чухал асуудлыг хөндлөө. Яг таны ярьж байгаа учир шалтгаануудаас болоод Монгол Улс Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулсан юм. Үндсэн хуулийн өөрчлөлтийн нэг гол зүйл бол улс төрийн 5 нам санал нэгдэж, улс орон хөгжихийн тулд хөгжлийн бодлого төлөвлөлттэй байна, тэр хөгжлийн бодлого нь тогтвортой байна. Улс төрийн бүх намууд энэ хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллана. Улс төрийн сонгуульд орж байгаа нэр дэвшигч хэн боловч энэ хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх асуудлаар өөрийн мөрийн хөтөлбөрөө боловсруулна. Хэрвээ энд энэ бодлогоос гадуур боловсруулалт хийвэл нэр дэвшихийг нь хасдаг, улс төрийн намын сонгуулийн нэрийн жагсаалтаас хасах хэмжээнд хүртэл хатуу зохицуулалт хийсэн. Энэ бол таны ярьдаг дур зоргын нөгөө Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд туссан, улс орны эдийн засгийн

аюулгүй байдал, нөгөө гол бодлогоосоо гадуур энэ төсвийн сахилга бат алдагдаад байсан тул ингэж журамлаж хуульчилсан.

Энийг мөрдөхийн үүднээс бид Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиа батлаад, тэрний дагуу төлөвлөгөө гаргаад, төсвийн хүрээгээ тодорхойлоод ингээд ажиллаж байгаа. Харамсалтай нь, энэ асуудал УИХ дээр хэлэлцүүлгийн явцад эвдэгдэж байгаа байдал удаа дараа гарч байгаа. Гишүүд энэ учир шалтгаан дутуу ойлгоод байж магадгүй. Энийг байнга сануулж байгаа, хуулийн зөрчил үүсэж байгаа талаар.

Хэрвээ энэ хууль сануулсаар байтал хуулийг давж, хуулийн тусгай шаардлагад нийцээгүй, эх үүсвэр нь тодорхойлогдоогүй, ТЭЗҮ-гүй, хариуцах эзэнгүй, зураг төсөв нь батлагдаагүй, тухайн жилд хэрэгжүүлэх энэ эрэмбэ шаардлагад ороогүй төслүүдийг батлуулах гэж ажиллаж байгаа улсуудыг бол бид яах аргагүй хуулийн зөрчилтэй гэж үзэж, шаардлагатай бол ҮХЦ-д өгнө. Ингэж байж бид энэ Их Хурал төсвийн бодлогын, санхүүгийн сахилга баттай болно. Бидний гол зорилго бол энэ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд туссан улс орныхоо эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нь нэг номерын асуудал. Эндээ бүгд захирагдах ёстой. Улс төрийн намууд энд бодлогоо нийцүүлэх учиртай. Ингэж байж улс орон хөгжинө.

Үнэхээр сая мэргэжлийн байгууллага, институц олон сар сууж, бүх нийгэм салбарыг хамарсан хэлэлцүүлэг зохион байгуулж, эрэмбэлээд оруулаад ирж байгаа зүйлийг дурын гишүүн санал гаргаж өөрчилж байгаа байдал бол энэ хуулиа буруу ойлгоогүйтэй, хуулиа сайн ухамсарлаагүйтэй холбоотой байх гэж бодож байгаа юм. Үүнээс цааш энэ асуудал засагдах байх.

Тэгэхээр маргааш хөгжлийн бодлогын асуудал орж ирнэ, энэ хуулийн хэлэлцүүлэг явна. Энэ дээр та энэ байр сууриа дахин, дахин ярьж, хаана хаанаа бүгд гишүүддээ хэлж, зөвлөж, анхааруулж, ингээд нэг цэгцэлж авахгүй бол улс орны хөгжлийн бодлогуудаа хэрэгжүүлж чаддаггүй, уралдаж нэмсээр байгаад урсгал зардал нь төсвийнхөө 80, 90 хувь руу оччихсон, хөгжлийн хөтөлбөрүүдээ хэрэгжүүлж чадахгүй хэмжээнд л бид очоод байна шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Тэгэхээр би 2 жил Хүний эрхийн дэд хороо гэж яваад, жишээлбэл, Монгол хүний эрүүл мэндтэй холбоотой асуудал хүний эрхтэй шууд холбоотой асуудал дээр ингээд нөхцөл байдлыг харж байхад утааны асуудал гээд бид өвөл ярьдаг, сонсгол хийдэг, тэгээд л таг, зун нь мартчихаж байгаа юм. Зун нь үер усны асуудал гээд л ярьдаг. Энэ ерөөсөө ийм улирлын шинж чанартай Монголын асуудлууд яваад байна. Сая харин хаа очиж энэ нэг сард ЗГ-аас тэр Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төв буюу Си Ди Си (CDC) гээд байгууллагыг байгуулж байна. Хөдөө орон нутгаар яваад ирлээ. Сэлэнгэ, Төв аймаг, Дарханаар яваад ирлээ. Үүнийг салбарынхан нэлээн дэмжиж байна. Байгаа төсөвтөө менежментийг нь сайжруулаад, үр өгөөжийг нь иргэдийнхээ эрхийг хамгаалахад чиглэсэн ийм бүтэц гэж харж байна. Яг үүн шиг энэ төсөв мэдээж төлөвлөгөө ярихаасаа гадна8 салбарын давхардал, уялдааг илүү хангасан, өөрөөр хэлбэл дээлний эсгүүр хийх гэж байгаа бол хүнээсээ хэмжээ авдаг гэдэг шиг ийм уялдаатай бодлогыг л бид.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Би дөрөв, тавхан юм зүгээр тодруулъя гэж бодож байна. Ер нь ирэх жилүүдэд энэ эдийн засагт, энэ гадаад нөхцөл байдал тийм нөлөөлөх байдал бол амаргүй л байх байх. Тэгэхээр энийг ер нь зүгээр Эдийн засаг, хөгжлийн яам маань бодит ямар эрсдэлүүд байна, ер нь ямар хариу арга хэмжээнүүд авахаар төсөөлж байна, ер нь юу гэж дүгнэж байгаа вэ? Энэ үе үед л дэлхийн өнцөг булан бүрд л зөрчил мөргөлдөөн, энэ трэйд (trade) худалдааны дайн, энэ бүх зүйлүүд чинь үндсэндээ энэ ААН байгууллагуудын гэдэг юм уу, тодорхой салбарын өрсөлдөх чадварыг хумьж байна, өртгийг нэмж байна. Энэ бидэнд бол шууд нөлөөлөх байх. Тэгэхээр энийг ер нь юу гэж харж дүгнэж, ямар хариу арга хэмжээ авна гэж тооцож байгаа вэ?

Тэгээд энэ хүрээндээ бид энэ дотооддоо ажлын байруудыг ер нь хадгалах, байгаа ажлын байруудаа хадгалах, ер нь зүгээр цаашдаа нэмэгдүүлэх чиглэлээр ер нь ямар арга хэмжээнүүдийг бодлогын түвшинд авна гэж энэ төсвийн хүрээний мэдэгдэл болон төсөөллийн хувьд харж байгаа вэ? Экспортын орлого маань ер нь гайгүй байж чадах уу? Зөвхөн нүүрс л гээд байдаг, нүүрсийг бид ирэх жилүүдэд 105 сая тонн нүүрс хүргэнэ л гээд байгаа. Нөгөө төмөр замын бүтээн байгуулалт маань ер нь ямархуу явцтай яваа юм бол, ашиглалтад орох уу? Зөвхөн авто тээврээр энэ хэмжээний нүүрс арай зөөхгүй байлгүй л гэж би бодож байна. Тэгэхээр энэ төмөр замын гарц, боомтууд чинь ашиглалтад орчихно гэж та тооцож байгаа юу? Ж.Энхбаяр сайдаас л асууж байна л даа.

Тэгэхээр энэ экспортыг төрөлжүүлэх буюу зөвхөн нүүрс, зэсээсээ гадна өөр ямар боломжууд байна, ХАА-н бүтээгдэхүүний төрөлжилт дээр юу байна вэ? Одоо гаргаж байгаа энэ зэсийн хэмжээг ер нь нэмэгдүүлэх боломж юу байна? ЗГ-аас Ашигт малтмалын хууль өргөн барьж байгаа гэж, энэ бодлого энэнтэй уялдаж тооцоо судалгаанд чинь орж байгаа юу? Иргэд, олон нийтэд зөв мэдээлэл өгөхгүй бол буруу, ташаа мэдээлэл авчих гээд байна лээ Ашигт малтмалын хууль дээр бол. Би уг нь бол их чухал хууль гэж бодоод байгаа юм.

Энэ төрийн өмчийн компанийн засаглал, реформын асуудлуудыг энэ хаврын чуулгандаа уг нь баталчихмаар байгаа юм. Энийг Эдийн засаг, хөгжлийн яам маань юу гэж харж байна вэ? Улсын төсөвтэйгөө дүйцэхүйц хөрөнгө оруулалтууд тэнд яригдаад байна, 40, 50 мянган хүмүүс ажиллаж байна. Ихэнх нь өгөөж муутай буюу цэвэр ашигтай нь ч тун цөөхөн юм. Энэ дээр ер нь зүгээр зах зээлийг хувийн хэвшлийн орон зайг, зах зээл дэх хувийн хэвшлийн орон зайг тэлж өгөхийн тулд, энэ өртөг зардлыг бууруулахын тулд ер нь Эдийн засаг, хөгжлийн яам энэ төсвөөс гадуурх гэдэг юм уу, энэ зүйлүүдийг юу гэж харж байна вэ? Энийг та ямар бодлогоор уялдуулах ёстой гэж бодож байна вэ? Энэ зүйлүүд дээр нэг тодорхой хариултууд авъя гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: 1 дүгээрт, манай эдийн засгийн суурилагдсан хүчин чадал дээд ачаалалтай үндсэндээ тулцгаасан. Төмөр зам дээд хэмжээнд ачаа тээж байна, эрчим хүч дээд хэмжээндээ үйлдвэрлэл явуулж байна, Эрдэнэт дээд хэмжээндээ олборлолт, баяжуулалт хийж байна, нүүрс дээд хэмжээндээ экспорт хийж байгаа. Ажиллах хүчээ бид 63 хувь хүртэл дайчилж байна.

Одоо бидэнд юу хэрэгтэй гэвэл бидэнд эдийн засаг, шинэ эдийн засаг, шинэ хөрөнгө оруулалт, шинэ экспорт, шинэ салбарыг бий болгож байж энэ нийгмийн өмнө тавигдсан олон асуудлын ард гарна. Улсын төсөв маань орсон орлогоороо урсгал зардал буюу цалин, тэтгэврээсээ илүү гарахгүй болж энэ жил ингээд тулж байх шиг байна, 2027 ондоо. Тэгэхээр бидэнд бодлогын томоохон өөрчлөлт буюу үүн дотроо экспортыг эрс нэмэгдүүлэх олон, зөвхөн уул уурхайн бүтээгдэхүүн, нүүрс, зэс, жонш, төмрөөсөө илүү, яагаад бид газрын ховор, фосфор, алтны ордууд ашиглаж чадахгүй байна вэ. Нөөц нь тогтоогдсон 200 гаруй тонн алт бэлэн байдаг, бид өөрөө хууль, эрх зүйн хүрээнд хязгаарлачихсан байдаг.

Дэлхийн хэмжээнд үнэлэгдсэн фосфоруудын томоохон орд байдаг, энийгээ бид ашиглаж чаддаггүй. Дэлхийн хэмжээнд үнэлэгдэх газрын ховор орд байдаг, үүнийгээ бид ашиглаж чаддаггүй ийм байдлууд байгаа юм. Тэгэхээр энийг шат дараатай бодлогын асуудлуудыг, шийдлийг нь Их Хуралд орж хэлэлцүүлнэ. Юуны өмнө эдийн засаг дахь төрийн өмчийн оролцоо өндөр байгааг хүлээн зөвшөөрч байгаа. Төсөв болон ТӨК-аар тооцоод үзэхэд 61 орчим хувь, эдийн засаг дахь 61 орчим хувь нь бол төрийн өмч, төрийн өмчтэй холбоотой үүсэж байгаа. Иймд хувийн хэвшилд орон зай гарах үүднээс төрийн өмчийн компаниудын удирдлага, зохион байгуулалт, үр ашгийн хувьд нэгтгэх, татан буулгах томоохон ажлууд эхэлсэн. Өчигдөр та бүхэн сонссон, ЗГ 10 ТӨК-ийг татан буулгах, нэлээдгүй олон аж ахуйг нэгтгэх ажлууд хийж байна.

Нөгөө талаас төрийн чиг үүргийн давхцал болон бүтэцтэй холбоотой үүрэг даалгавар Ерөнхий сайдаас өгөгдөөд, дүн шинжилгээнүүд хийгдээд, яг явагдаж байна. Бид намар төсөвтэйгөө хамт энэ ЗГ-ын төрийн албаны бүтэц, давхардал, чиг үүрэгтэй холбоотой томоохон өөрчлөлтийг бол хамгийн цаад хугацаа гэхэд оруулах байх. Экспортод чиглэсэн дэд бүтцүүдийн хөрөнгө оруулалтууд тасралтгүй амжилттай хэрэгжиж байна. Хил холболтын төмөр зам, боомтын ухаалаг системүүд нь бүгд ажилдаа үндсэндээ ороод, ирэх онд гэхэд бүрэн жигдэрнэ. Одоо байгаа боломжоор бид 90 сая тонн нүүрс экспортолж гаргаж чадаж байна. Төмөр замын холболт орсноор энэ байдал бүр цаашдаа баталгаажих ийм боломжууд байна. Шулуухан хэлэхэд эдийн засгийн ирэх жилүүдэд эрсдэлтэй байгаа. Дэлхийн дэг журам өөрчлөгдөж байна, дэлхийн улс орнууд худалдаа, тарифын болон зэвсэгт мөргөлдөөн гээд олон ийм тогтворгүй байдлыг үүсгэж байгаа. Энэ нь манайх шиг хөгжиж байгаа орнуудад бол шууд эхний ээлжид инфляц, болон 2 дугаарт төсөвт ирж байгаа ачаалал эрс нэмэгдэж байгаа. Валютын нөөцөд тодорхой хэмжээний дарамтууд бий болно. Энийг л бодож сөрөг арга хэмжээнүүдийг бид засаг.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Тийм, Ж.Энхбаяр сайд тодруулаад хэлээд өгөөч. Ер нь зүгээр энэ нөхцөл байдлуудын нэг дүгнэсэн дүгнэлтүүд бол ҮАБЗ-ийн хавьцаа энэ тэр бэлтгэгдэж байгаа байх. Энийг ер нь нэг чуулганаараа хаалттай сонсвол яадаг юм бэ? Гадаад нөхцөл байдал бид ер нь яах ёстой юм гэдэг асуудал дээрээ.

Энэ төрийн албаны реформоо явуулж үзээрэй. Та энийг хийчихвэл ёстой таныг бараг шүтмээр байна. Би хууль зүйн салбар болон төрийн тусгай албан хаагчдадаа илэн далангүй, шулуухан л хатуу юм хэлмээр байна. Одоо та бүгдийн нэг жил ажилласныг 1.2 жилээр тооцож байгаа энэ зүйлээсээ жишээ нь больчихвол

яадаг юм бэ? Би улс орноо бодмоор байна. Магадгүй хүнд хэцүү үеүд байсан, та бүгдийн ажиллах нөхцөлийг хангаж чадаагүй үеүд бол байсан, хүн хүч их хомс байсан үе байсан. Гэтэл энэ татвар төлөгчдийн мөнгөөр бэлдэж байгаа залуучуудыг чинь 42, 43-тайд нь тэтгэвэрт суулгачхаад байна. Жишээ нь, манай цагдаа, хууль сахиулах салбар. Энэнээсээ л эхлээд реформоо хиймээр байна. Энэ татаасуудыг яг үйлдвэрлэгчдэд өгмөөр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Төрийн албаны реформ зайлшгүй бөгөөд манай ЗГ энийг цаад хугацаа нь намрын төсөвтэй уялдуулан оруулж ирнэ.

2 дугаарт, энэ төсөл хөтөлбөрүүд буюу боломжийн асуудал. Маш их боломж байна. Бид ашиглаж чадахгүй олон боломжууд байна. Өнөөдөр нийслэл, Өмнөговь, Орхон, Дархан, Дундговь, Төв аймаг гэсэн энэ 6 орон нутаг төсвийн хуримтлалтай, давсан орлоготой байгаа. Бусад нь бүгд татаасаар байгаа. Жишээлбэл, Өмнөговь гэхэд жилдээ 192 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг давсан орлогоороо шийдэж байна шүү дээ. Тэнд нийгмийн асуудал, цэцэрлэг, сургуулийн асуудал бүрэн шийдэгдэж байна, амьдрах таатай орчин үүсэж байна. Яагаад гэвэл хөрөнгө оруулалтыг татаж чадсан. Өмнөговь одоо цахилгаан станцаа өөрөө шийдэж байна, Өмнөговь нисэх буудлаа ОУНБ болгож өөрчилж байна.

Нийслэл Улаанбаатар хот 1.6 их наядын давсан орлоготой, цахилгаан станцаа өөрөө шийддэг болж байна, дэд бүтцүүдээ өөрөө шийддэг болж байна. Энэ юу вэ гэвэл хаана хөрөнгө оруулалт татаж чадсан, хаана бизнес эрхлэх таатай орчин бүрдсэн газруудад хөгжил дэвшил.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя, Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Тэгэхээр бусад орон нутгуудад бодлогын хувьд өөрчлөлт хийх хэрэгтэй, "боломжоо ашиглаач" гэж. Улсын төсвөөс хамгийн их татаас авдаг аймгууд гаднын хөрөнгө оруулалт, хөгжлийн эсрэг хамгийн их байр суурь илэрхийлж байгаа аймгууд байгаа юм. 30-аас 40 тэрбумын татаасаар амьдарч байна. Гэтэл тэр аймгуудад ямар их том бололцоонууд, боломжууд байгаа билээ. Юун аймаг, бүс нутгийн хэмжээнд Монгол Улсыг хөгжлийн шинэ шатад гаргах томоохон батлагдсан орд нөөцөө бид улс төржөөд ашиглаж чадахгүй өдий хүрсэн хэвээрээ л байна. Энийг Их Хуралд шаардлагатай гэвэл оруулж ирж танилцуулахад бэлэн байна. Энэ дээр алтны томоохон ордууд байна, газрын ховор элементийн томоохон ордууд байна, фосфор, бордоо, тэсрэх бодисын томоохон үйлдвэрлэх бололцоотой ордууд байна.

Монгол Улсын хөгжилд шаардлагатай томоохон, социализмын үед бэлтгэгдсэн тэр нөөцөө бид улс төрөөс болоод ашиглаж чадахгүй, улс орныхоо хөгжлийг өнөөгийн түвшинд гацааж байгаа байдал байна.

Ж.Бат-Эрдэнэ: Саруулсайханы Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуух асуулт байна. Энэхүү төсөөллөө гаргахдаа ер нь бол хэр хэмжээний цаг хугацаа та бүхэн яаман дээрээ зарцуулдаг вэ гэдгийг мэдмээр байна, хоногоор? Ер нь бол энэ төсөөллийг гаргахдаа Монгол Улсад одоогийн байдлаар хүчин төгөлдөр байгаа хуулиудыг ашиглаж төсөөллөө хийдэг үү гэдэг нь бол тэр хуулиа баримталж

ажиллах ёстой шүү дээ гэдгийг сануулж байна. Яагаад тэгж байгаа вэ гэхээр Занданшатар Ерөнхий сайд өнгөрсөн оны сарын өмнө Ерөнхий сайд байхдаа "НӨАТ-ыг 5 хувийн буцаан олголттой болгоно" гээд хууль санаачлаад, УИХ-ын гишүүд тэр хуулийг дэмжээд батлаад өнөөдөр хүчин төгөлдөр ажиллаад явж байгаа юм.

Тэгэхээр тухайн үед бол Эдийн засаг, хөгжлийн яамныхан болон Ерөнхий сайд бол өөрөө хэлж байсан, "бид бүхэн бүх бүрэн дүүрэн тооцооллоо хийгээд энэ нь өөрөө төсвийн ачаалалтай, бид бүхэн зохицуулалтаа хийж байгаад гаргаад явчих бололцоотой юм" гээд. Тэгэхээр энэ нь өөрөө бол Эдийн засаг, хөгжлийн яам бол тухайн үед саналуудаа өгч байсан байх гэж миний хувьд бол ойлгож байгаа. Тэгэхээр өнөөдөр та бүхний энэ өргөн барьсан төсөөлөл дээрээ НӨАТ-ын буцаан олголтыг 5 хувиар тооцож оруулсан уу гэж асуумаар байна? Тэгэхээр хэрвээ 5 хувиар тооцож оруулсан байгаа юм бол өчигдөр Эдийн засгийн байнгын, хэд хоногийн өмнө Эдийн засгийн байнгын хороогоор орсон "НӨАТ-ын буцаан олголтыг 2 хувь болгохгүй бол улс эх орны эдийн засаг, манай төсөв маань бүрдэх боломжгүй" гэдгийг бол буруу гэдгийг нь бол хэлж байна гэдэг нь бол харагдах юм шиг санагдаад байна надад бол. Тэгэхээр энэ 2 зөрөөг та бүхэн маань ялгаад гаргаад өгөөч гэж хүсэж байна.

Ер нь ЗГ, МАН дангаараа засаг барьж байгаа. Өөрсдийнхөө баталсан "НӨАТ-ыг 5 хувиар иргэддээ буцаагаад олгочихъё" гээд гаргасан энэ хуулиа хэдхэн сарын дараа буцааж байгаа нь өөрөө их болчимгүй үйлдэл. Мөн түүнчлэн, хэрвээ энийгээ төсвийн төсөөлөл дээрээ ч гэсэн одоо хэрэгжиж байгаа хуулиа үл тоомсорлоод, бид бүхэн "энэ хуулийг ирээдүйд байхгүй болгочих юм чинь" гэдэг үндэслэлээр төсөөллөө хүртэл бууруулаад оруулаад ирчихсэн байвал энэ өөрөө маш том ноцтой асуудал гарах юм. Тэгэхээр энэ дээр та хариултыг тодорхой хэлж өгнө үү?

Ж.Бат-Эрдэнэ: Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулах уу? Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуусан байх. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Төсвийн циклтэй холбоотой мэдээллийг Энх-Амгалан хариулна шүү дараа нь. Учир шалтгаан, яагаад НӨАТ-ын хуулийг дахин оруулаад ирэв гэж. ЗГ тооцоод НӨАТ-ын буцаан олголтыг хийх нь зүйтэй гээд хууль өргөн бариад Их Хурал дэмжсэн. Нэг асуудал үүссэн. Төлөвлөөгүй зардлыг Их Хурал төсөв өргөн барьснаас хойш чуулган дээр нэмсэн. Энэ бол нөгөө цалингийн нэмэгдлүүд. Энэ цалингийн нэмэгдлийн ачаалал маань өөрөө энэ НӨАТ-ын ачааллыг, төсөвт орох орлогыг бид 1.8 их наядар бууруулж байгаа шүү дээ НӨАТ-тэй холбоотой. Гэтэл энийг зөрүүлээд юун дээр нэмчихгүй юу цалин дээр нэмчихсэн. Тэгэхээр одоо бид сонголт төсвийн хүрээ энд өөрчлөгдөхгүй, орон зай чинь 2.2 их наядын орон зай байна гэдгийг чинь энүүгээр гаргаад өгч байгаа юм. 2.2 их наядын орон зайг яаж ашиглах вэ гэдэг асуудлыг бид Их Хуралд асууж байгаа байхгүй юу. Цалингаа нэмэх үү, цалин хэвээрээ. Нэгэнт нэмэгдсэн цалин буусан түүх байхгүй. НӨАТ-ыг буулгахгүй бол цалин чинь хүндэрнэ.

Нэг бол одоо байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтууд бүрэн зогсоно, 2.2 их наядын л орон зай байдаг. Хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтаа зогсоох уу, НӨАТ-аа буцаах уу, цалин тэтгэврээ хүчингүй болгох уу, энэ бол улс төрийн шийдэл. Яагаад гэвэл УИХ хууль гаргаж зардал нэмсэн, урсгал зардлыг нэмчхэж байгаа юм. Энэ дээр ЗГ өргөн бариагүй шүү, тэрийг сайн ойлгоорой. Засаг НӨАТ дээрээ явж байтал урсгал зардлыг огцом нэмэнгүүт

нөгөө НӨАТ дээр тооцсон зардал чинь байхгүй болчхож байгаа юм. Тэгэхээр хөрөнгө оруулалтыг зогсоох асуудал үүсээд байгаа байхгүй юу. Энэ бол эрсдэл үүснэ. Яагаад гэвэл 2027 онд шинэ хөрөнгө оруулалт байхгүй, 2027 онд хэрэгжих 3.6 их наядын үргэлжилж байгаа хөрөнгө оруулалтаас бид 2.2-ыг л санхүүжүүлэх орон зай байгаа юм.

Гэтэл тэр орон зайг чинь НӨАТ-ын хуулиар буцаагаад цалингаа нэмсэн, мөн НӨАТ-аа хасчихаар тэр орлого дутна гэсэн үг. Тэгэхээр ийм эрсдэл үүсэж байна шүү гэдгийг бид та бүхэнд тайлбарлаж мэдээлж байгаа юм. Энэ дээр Их Хурал бодлогын шийдэл гаргах ёстой байхгүй юу. НӨАТ-аараа энэ хуулийг үйлчлэлийг нь хойшлуулъя, эсхүл энэ хууль үлдэнэ гэвэл хөрөнгө оруулалт байхгүй гэсэн үг. Ийм эрсдэлүүд байна гэдгийг чинь л бид гаргаад байгаа юм. Тэгэхээр хөрөнгө оруулалтаа эдийн засаг, төсвийн хүнд үед бид хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, ажлын байраа нэмэгдүүлж, ААН-ээ дэмжиж, улмаар түүгээрээ дамжиж татвар хураамжаа нэмж, төсвөө бүрдүүлэх нь чухал байна гэж засаг үзэж байгаа юм. Иймд хөрөнгө оруулалт дээр анхаараад, гадаад зээл ашиглалтаа нэмэгдүүлье гэдэг л хуулиудыг бид хэлэлцүүлээд байгаа юм шүү дээ. Тэгэхээр ахиад хэлье, гэнэтийн тооцоолоогүй зардлын огцом нэмэлт энд нэмэгдсэн, тэгээд тэрэн дээр л холбоотой асуудал үүсчхээд байна л даа. Дэндүү огцом нэмэгдэлтэй, 1.6-аас 1.8 их наяд, бараг 2027 ондоо 2 их наяд болж өсөж байгаа, инфляцтай уялдуулаад нэмэхэд тэтгэврийн нэмэгдэл орж ирэхээр.

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын индэр дээрээс тодруулъя.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам, гишүүний асуултад хариулъя. Төсвийн энэ тооцоог хийхэд ямар хугацаа зарцуулдаг вэ гэдэг асуултад би төсвийн циклийг яг эхнээс нь яаж үргэлжилдгийг хугацаатай нь танилцуулъя. Жил болгоны 1 сарын 15-наас 17-ны өдрүүдэд ҮСХ-ноос өмнөх оныхоо бүх статистик мэдээллийг ерөнхийд нь зарладаг. Энэнтэй зэрэгцүүлээд Эдийн засаг, хөгжлийн яам дээр орон нутаг болон төсвийн захирагч нараас дараа жилд юу хийх тухай улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг 1 сарын 15-наас эхэлж боловсруулж эхэлдэг гэсэн үг. Тэгээд хууль дээрээ энэ цаглаврууд яг тодорхой заагдсан байдаг. 3 сарын 15-нд ЗГ-т Эдийн засаг, хөгжлийн яамнаас танилцуулдаг, 4 сарын 15-нд төсвийн хүрээг мөн ЗГ-т танилцуулдаг. Тэгээд ЗГ дээрээс санал, дүгнэлт авсны дараа 5 сарын 1-нд эцэслэн боловсруулаад, УИХ-д.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя, 4 номер. 5 сарын 1-нд Их Хуралд өргөн барьсны дараа 6 сарын 1 гэхэд Их Хурлаас төсвийн хүрээ болон жилийн төлөвлөгөөг баталдаг. Ингээд 6-аас 7 сарын хооронд ЗГ дээр энэ батлагдсан төсвийн хүрээнийхээ хүрээнд яамнууд, салбарууд ямар хэмжээний зарцуулалт гарах вэ гэдгийг хязгаараа баталдаг. Тэгээд 7, 8 сард төсвийг задалж боловсруулах ажлууд хийгдээд, 2 сарын турш, 9 сард эргээд төсвөө нарийвчлан боловсруулаад УИХ-д өргөн барьдаг. Тэр нь 9 сард өргөн барьсан төсвийг 65 хоног, 75 хоног хэлэлцсэний дараа 11 сарын 15-нд УИХ-аас баталдаг. Ингээд дараа жилийн 1 сарын 15 гэхэд жилийн төлөвлөгөө буюу төсвийн цикл эхнээсээ эхлээд явдаг. Тэгэхээр энэ төсөв боловсруулах үйл явц 1 сарын 15-наас эхлээд 11 сарын 15 хүртэл тасралтгүй циклээр явж байдаг гэсэн үг.

Ж.Бат-Эрдэнэ: Цэнгүүн гишүүн тодруулъя.

С.Цэнгүүн: Тэгэхээр хуулийнхаа дагуу бид бүхэн процессоо дагахаар маш олон хоногийн өмнөөс эхлээд төсвийн төсөөллөө бид бүхэн батлаад явдаг гэдэг нь сая хэлж байна. Тийм учраас миний асуугаад байгаа зүйл нь Энхбаяр сайдаас ахиад асууя. НӨАТ-ыг төсөөлөхдөө орлого дээрээ та 5 хувиар нь төсөөлж оруулсан юм уу, 2 хувиар нь одоо оруулчихсан байгаа юм уу. Энэ материал дээр яг тэр нь хэд байгаа юм бэ гэдгийг хармаар байна. Яагаад гэхээр би таныг өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа НӨАТ-ын 5 хувийн буцаалтыг яг тэрүүгээр нь оруулж төсөөллөө гаргах ёстой гэдгийг сануулах гээд байна л даа. Тиймээр нь та тэр төсөөллөө гаргаад явчихсан байгаа бол өнөөдөр бид яг тэрнийх нь дагуу батлаад явахад энэ боломжтой юм биш үү гээд. Яагаад гэвэл би Их хурлын гишүүний хувьд энэ төсвийн хүрээний мэдэгдлийг дэмжих, дэмжихгүй гэдэг нь энэ НӨАТ-ыгаа та хэдээр тооцож оруулсан юм бэ гэдгийг нь яг чуулганы танхим дээр таны амнаас сонсмоор байна.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд хариулья.

Ж.Энхбаяр: Төсвийн хүрээний мэдэгдэл маань өөрөө 9 гол макро эдийн засгийн үзүүлэлтээ л баталж байгаа юм. Орлого ийм байх юм байна, орлого бүрдэхийн тулд эдийн засаг ингэж өсөх юм байна гээд, зардал нь ингэх юм байна гээд. Тэгэхээр бид тэр тэнцэл ямар байна, орон зай ямар байна гэдгийг чинь гаргаж өгнө. Энэ бол одоо мөрдөж байгаа хуулийн, бүгд мөрдөж байгаа хуулиар явна. Бидний юуны 5 хувийн хууль чинь энэ намар мөрдөх хууль байхгүй юу. Одоо мөрдөж байгаа хууль биш шүү дээ, үйлчилж байгаа хууль биш. Бид 2 хувиараа тооцож оруулж байгаа. Бид 2-оороо оруулж ирж байгаа, 5 биш, 2, одоо байгаа, одоо үйлчилж байгаа энэ хуулиа л дагана гэж оруулж ирж байгаа. Бидний яриад байгаа 5 хувь гэдэг маань намраас эхэлнэ гэж байгаа. Тэгээд энэ эхлэх хуулийг үйлчлэлийг нь хойшлуулъя гэдгээр оруулж ирнэ.

Ж.Бат-Эрдэнэ: 2 хувиар гэж байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Төсвийн хүрээний мэдэгдэл дээр хамгийн түрүүнд өнөөдөр бол төрийн албан хаагчдын цалин бууж байгаа, үндсэндээ дуусаж байгаа өдөр. Багш нар, эмч нар маань ямар ч байсан цалин хөлс нь багш нарынх нь 50 хувь, эмч нарынх нь 30 хувь, тэгээд шинэ, хуучин цалин гэдэг асуудал нь нэг тийшээ шийдэгдсэн, ЗГ эцэслэн шийдсэн. Би энд баяртай байгаа. Би эхлээд энийг дэмжсэн манай Их Хурлын гишүүд, ЗГ-таа баярлалаа гэж хэлмээр байна. Дамжуулж өгөөрэй гэсэн учраас Үйлдвэрчний эвлэлийн байгууллагынхнаас. Цалин нэмснээс болоод бүх зүйл болохоо байчихлаа, одоо ингээд иймээ тиймээ гэдэг өнцгөөр бас яримааргүй байна. Би ойлгож байна Энхбаяр сайдыг. Яах аргагүй нөгөө талд нь энэ зардлыг шийдэх ёстой. Тийм учраас өнөөдөр ингээд харахад бүрэн ч дахиад л нэг асуудал гарч ирж байгаа. Хоол, унааны мөнгийг нь өгөөгүй л гэж юм ярьж байна. Тэгэхээр 1 дүгээрт, энэ төсвийн тодотголоо, энэ саяын цалин нэмсэн асуудлаа хэзээ оруулж ирэх вэ гэдэг асуудлыг би тодруулж асуумаар байна?

2 дугаарт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхнөөс нийгмийн даатгал, ЭМД-ыг ингээд урсгал зардалд оруулаад, тэгээд төсвийн зардал болгоод ДНБ-д эзлэх хувийг нь 30 хувьд барина гэдэг юм руу оруулж ирээд байгаа. Энийгээ хэзээ болих юм бэ, энэ чинь яг үнэндээ төрийн мөнгө, төсвийн мөнгө биш шүү дээ, иргэд өөрсдөө өнөөдөр миний төлж байгаа нийгмийн даатгалыг би өнөөдрийн тэтгэвэр авч байгаа хүмүүст өгч байгаа. Магадгүй миний дараагийн үе, залуучууд миний авах

тэтгэврийг өгнө. Тийм учраас нэг ийм тоо гаргаж ирж байгаа төсвийн урсгал зардал дэндлээ, ингэлээ, тэглээ гэж яриад байгаа юм.

Сая энэ багш, эмч нарын цалин, дээрээс нь ахмадуудын тэтгэврийг аваад үзэхэд бид дөнгөн данган багш нарын үндсэн цалинг 2 сая төгрөг л болж байгаа шүү дээ үндсэн цалин. Тийм учраас би цаашдаа илүү нэмэх ёстой, боломж, бололцоо нь байвал. Түүний тулд эдийн засгаа сайжруулах ёстой гэдэгтэй санал нэг байна. Уул уурхай болон зарим нэгэн улс төржилгүйгээр зарим ашиглах ёстой юмнуудаа нутаг оронд нь өгөөжийг нь өгөөд ашиглах ёстой бол ашиглах хэрэгтэй. Тэгэхгүйгээр ер нь цалин, тэтгэвэр нэмэх нь буруу юм байна гэдэг өнцөг, уур амьсгалаар яриад байвал энэ төсвийн чинь гол зорилго нь "Ард иргэдийн бодит орлого, айл өрхийн хаалгаар хэдэн төгрөг оров" гэдгээр л ард түмэн чинь ингээд өгөөч гэж биднийг сонгосон байгаа юм.

Тэтгэвэр ч гэсэн яг ний нуугүй хэлэхэд одоо нэг инфляцаа хаах төдий л яваад байгаа шүү дээ. Тийм учраас энэ тал дээр би байр сууриа хэлэхэд тийм байна. Тэгэхээр энэ төсвийнхөө урсгал зардлын дотор энэ нийгмийн даатгал, эрүүл мэнд эхлээд оруулж ирээд, тэр төр нь даадаг тэр цэрэг цагдаа байна уу, өөр одоо юу байна, тэр хүмүүсийнхээ санг би тусгаарлах хэрэгтэй гэж бодож байгаа. Төсвөөс татаас өгөөд байгаа гэж байгаа юмаа. Тэгж ойлгохгүй бол нийгмийн даатгалын сан яг өнөөдөр төлж байгаа хүмүүс, өнөөдөр тэтгэвэр авч байгаа хүмүүсийн тэнцвэртэй явж байсан. Одоо яах вэ ачаалал нэмэгдэж байгаа нь үнэн. Тийм учраас энэ төсвийнхөө хүрээний мэдэгдэл, энэ төсвийнхөө бүтцийг логикийн хувьд их зөв авч явахгүй бол тусдаа байх ёстой санг төсөв рүү оруулж ирэнгүүтээ, төсвийн урсгал зардал маш өндөр байгаа гэдэг ийм дүгнэлт хийгээд яваад байдаг.

Би төсвийн хөрөнгө оруулалтыг илүү мөнгө олох, экспортыг дэмжих, импортыг орлох зүйл рүү хийх ёстой гэж боддог хүн. Сум болгонд нэг үйлдвэр барья, Эрээнээс хогийн шүүрийг зөөмөөргүй байна. Ийм төсвийн бодлогуудыг хийх тал дээр би ийм бодолтой гэдгийг давхар хэлмээр байна. Тэгээд байгалийн баялгийн нөгөө ашгийг бүрэн шударгаар авч чадаж байна уу, авах ёстой татваруудаа авч чадаж байна уу гэдэг тал дээр Энхбаяр сайд та одоо юу гэж бодож байна вэ? Маш олон рояалти авна гээд байгаа, эсхүл манай Засгийн газар авна гээд том, том ордууд хүлээгээд байгаа шүү дээ. Оюу Толгойноос авхуулаад л, зээлтэй холбоотойгоос авхуулаад л, энэний ирээдүйд харагдах хэдий хэмжээний юм орж ирэх юм бэ, танд яг тодорхой төсөөлөл байна уу?

Ж.Бат-Эрдэнэ: 13 цаг болчихсон байна. Чуулганы хуралдааныг цааш нь үргэлжлүүлье. Тэргүүн шадар сайд Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Монгол Улсын эдийн засгийг авч яваа салбар уул уурхайн салбар. Тэгэхээр уул уурхай тэргүүлэх бодлогод байгаа, үүнээс өгөх өгөөж дээр учир дутагдлууд өнгөрсөн хугацаанд гарсан. Энийгээ засахын төлөө бид нийтээрээ, нийгмээрээ л хичээцгээж байна. Тун удахгүй энэ Ашигт малтмалын татварын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль олон хуулиуд сая засгаар дэмжигдээд Их Хуралд өргөн барихаар болоод эхний хэлэлцүүлэг эхэлж байна. Энэ хүрээнд бид өнгөрсөн хугацааныхаа алдаа оноог цэгцлээд уул уурхайн салбараас авах өгөөжөө улам боловсронгуй болгоно.

Нөгөө талаас одоо байгаагаасаа илүү шинэ, шинэ орд газрыг нээх, геологи хайгуулд хөрөнгө оруулалтыг татах ийм шаардлага байна. Үндсэндээ бид 90 оноос

өмнөх социализмын үед хийсэн геологийн нөөцийг л одоо ашиглаж байна шүү дээ. Шинээр олигтой шинэ орд газруудыг бид нээж чадсангүй, эргэлтэд оруулсангүй. Тэгэхээр геологи хайгуулын салбарыг нэлээн либералчлах, гадаадын хөрөнгө оруулалт татах, нөөцөө бэлдэх хэрэгтэй байна. Энэ дээр нэлээн бодлогын алдаанууд хоцроод байна.

Мэдээж цалин тэтгэвэр нэмэх нь нийтийн шаардлага байж л байна, гэхдээ эдийн засагтайгаа л таарна шүү дээ. Бидний олж байгаа хэмжээндээ л бид зардлаа тооцоолж байгаа. Одоогийн байдлаар бидний олсон орлого, зардал хоёр маань ингээд тэнцээд эхэллээ. Хөгжлийн бодлого руугаа хөрөнгө оруулалт хийлгэх боломжгүй болоод ирлээ. Урсгал цалин тэтгэвэр дээрээ их зардал нэмж байна. Дандаа хуульчлагдсан зардлууд шүү дээ, УИХ хууль батлаад зардлыг нэмүүлж байгаа. Тэгэхээр бидэнд одоо ямар шаардлага үүсэж байна гэвэл шинэ эдийн засаг хэрэгтэй болж байна, шинэ зах зээл хэрэгтэй болж байна, шинэ орд газрууд хэрэгтэй болж байна, шинэ үйлдвэр, аж ахуйн нэгж хэрэгтэй. Иймд бизнесийн орчныг дэмжсэн Учрал Ерөнхий сайдын гол бодлого бол чөлөөлөлт буюу эдийн засгийн чөлөөлөлтийг хийе, энд саад болж байгаа эрх зүйн чөлөөлөлтүүдийг хийе, хөрөнгө оруулалтад саад болж байгаа чөлөөлөлтүүдийг хийе, эдийн засагтаа шинэ урсгалыг оруулъя, эдийн засгаа дахин томруулъя гэдэг шинэчилье, өөрчилье гэдэг л ийм гол бодлого явж байгаа. Тэр хүрээнд ирэх долоо хоногт орчихно.

Бизнесийн эрх чөлөө, Хөрөнгө оруулалт, Зөвшөөрлийн хуулиуд нэгтгээд 115 хууль одоогийн төслөөр нэмэлт, өөрчлөлт орохоор орж ирнэ. Одоо бид хөрөнгө оруулалтаа аль болох дэмжих, хувийн хэвшлийн эдийн засаг дахь орон зайг нь тэлэх, төрийн оролцоог багасгах ийм бодлогуудыг оруулна. Гадаадын хөрөнгө оруулалтад нээлттэй байх, энэ бий болсон маргаануудыг, хөрөнгө оруулагчдад учирсан хохирлыг барагдуулах ажлуудыг Засгийн газар байнга авч хэрэгжүүлж байна. Та бүхэн ингээд харвал төсвийн хүрээний мэдэгдэл дээр бид энэ Засгийн газрын зардлуудыг байнга багасгах бодлого оруулж ирж байгаа шүү дээ. Суурь зарлагын төсөв дээр. 27 онд бид энэ жил 37 хувь байгаа, бид ирэх онд 28, дараа нь 27, 26 хувь гээд тасралтгүй буулгаж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, 3 номерын индэр. 3 номер.

А.Энхбат: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат. Гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын шимтгэл Төсвийн тухай хуульд заасан 22 дугаар зүйл дээр энэ дагуу төсвийн бүтцийг мөн ангиллыг тодорхой хуулиар заасан байдаг. Өөрөөр хэлбэл эдийн засгийн ангиллаар, төсвийн байгууллагын ангиллаар, шатлалын ангиллаар гээд. Төсвийн нийт орлого буцалтгүй тусламж, тэр дотор нь улсын төсвийн урсгал орлого, тэрэн дотор нь татварын орлого, татварын бус орлого, татварын бус орлогоор НДШ гэж тооцогдоод явж байдаг. Нөгөө талдаа бол төсвийн зарлага талд мөн Төсвийн тухай хуулиар заагаад өгчихсөн. Нийт зарлага, тэр дотор урсгал зарлага, урсгал зардал дотроо бараа, үйлчилгээний зардал, тэгээд цалин хөлс, нийгмийн даатгалын шилжүүлэг гээд явж байдаг. Тэгээд энэ бол хуулиар тогтоосон эдийн засгийн ангилал байж байгаа. Ер нь бол нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сан бол Монгол Улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг буюу 21.1-д тэр хуулиар заачихсан байж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Үгүй ээ, би хуульд байгаа юу, үгүй юу гэж асуугаагүй юм л даа. Ер нь байх ёстой юу, үгүй юу? Ихэнх оронд нийгмийн даатгал, ЭМД-ын тусдаа сангуудыг төсвийн энэ бүрэлдэхүүн дотор оруулдаггүй. Манайх оруулаад яваад байгаа, тэгээд дотор нь бантан хутгаад, "татаас өгч байна, ингэж байна, төсвийн зардал нь өсөөд байна" гэдэг ийм нэг юм гаргаж ирээд яваад байгаа учраас цаашдаа эрүүл болгохын тулд магадгүй Тогтвортой байдлын зөвлөл та бүгд аягүй сайн мэдэж байгаа, энэ хуулиа өөрчлөх хэрэгтэй гэдэг талаасаа л та бүгд маань хэлээд өгөөч л гэж би ойлгоод байгаа юм. Тэгэхгүй болохоор энийг ингээд цааш нь явуулаад л байвал дахиад л төсөв дотор урсгал зардал нь ингээд л данхайгаад байна, төр нь данхайгаад байгаа юм шиг харагдаад байдаг. Тийм учраас энийг одоо хэдүүлээ засвал, Энхбаяр сайд ч гэсэн энэ тал дээр өөрөө бас мэдэж байгаа. Энэ нийгмийн даатгал, ЭМД тусдаа, өөрөө өөрийгөө орлогоороо, зарлагаараа нөхөөд явбал энэ илүү цаашаа эрүүл болох юм. Төсөвтэй хольцоод байхаар ингээд л төсөв дийлэхгүй байна, энэ ингээд байна гэдэг юм руу л болчихоод байгаа учраас энийг л би хэлээд байгаа юм шүү гэдгийг.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ нийгмийн даатгал, ЭМД-тай холбоотой асуудалд Мэндсайхан сайд хариулах уу?

З.Мэндсайхан: Эрдэнэбат гишүүний асуултад тодруулга өгчихье. Төсвийн тухай хуулиар манай улс чинь нэгдсэн төсөвтэй улс шүү дээ. Тэгэхээр нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сан, Ирээдүйн өв сан, Орон нутгийн төсөв гээд. Нийгмийн даатгалын сан, ЭМД-ын санг хувийн хэвшилд гаргаад, төр хамааралгүй болох ийм санал гаргаж байна төсвөөс гаргаад явах, энэ бол байж болох санал. Гэхдээ энэ бол одоо би бүтэхгүй санал л гэж бодож байгаа юм. 3.6 сая иргэнийхээ эрүүл мэндийг хувьд өгч болохгүй, 550 гаруй ахмадынхаа тэтгэврийн асуудлыг хувьд өгч болохгүй. Хувь авах ч үгүй, хувийн ААН-үүд энэ хувийн хэвшлийнхэн энийг авах ч үгүй байх. Зүгээр яах вэ, энийг одоо төсөвт ачаалалгүй гээд гаргаад бид явчих боломж нь байлаа гэж үзэхэд, өнөөдрийн нийгмийн даатгалын сангийн бүрдэж байгаа бүтцийн хувьд, ЭМД-ын сангийн хувьд харахад судалгаагаар, наадхыг чинь нэлээн бүгд "энийг гаргачихъя, төсвөөс гаргачихъя, ингээд ачаалалгүй явчихъя" гэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Мэндсайхан сайдаа, би хувьчилъя гэж ерөөсөө яриагүй. Ер нь энэ төсвийг батлахдаа төсвөөс нь салгаад, тусад нь ингээд барьж явъя л гэж хэлээд байгаа юм. Нэгдсэн төсөвтэй биш, тусад нь. Тэгэхгүй бол дунд нь холиод байхаар одоо ингээд асуудал чинь мөнхөд цаашаа үргэлжилнэ. Төр өөрөө өгөх ёстой юмаа, харин жинхэнэ бид татаас болгож, тэтгэвэр нэмэхэд тэдэн төгрөг өгч байгаа шүү гэдэг юмаа тусад нь харагдуулахгүй бол төсөв дотроо нийлүүлж баталчхаад л, тэрэн дотор урсгал зардал нь аймаар өндөр байгаад байна, одоо ингээд хэцүүдээд байна гэдэг юмыг өгөхөөр олон улсын байгууллагууд ч гэсэн энийг чинь асар их урсгал зардлын асуудлаа төр нь ингээд байгаа нь, ОУВС-ийн асуудалд хүртэл бид тэгж орсон шүү дээ. Та нар нөгөө нийгмийн даатгалдаа асар их ийм татаас өгөөд байна гэж хараад байдаг. Яг бодит байдал дээр бол өөрөө төр даах ёстой цэрэг, цагдаа, тэр хүмүүстээ л дааж байгаа татаасаа өгч байгаагаа, нийт сан нь болохоо байчхаж байгаа юм байна гэдэг мессеж өгөөд байдаг байхгүй юу. Тэгээд би энийг л хэлээд байгаа юм шүү, тийм.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Жамбалын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Ганбаатар: Баярлалаа. 2027 оны төсвийн хүрээ, 28 оны, 28, 29 оны төсвийн төсөөллийн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож байгаа Байнгын хороо, чуулган. Би энэ асуудлаар ер нь байнга идэвхтэй оролцдог, Гантөмөр сайд, Хүрэлбаатар сайдын үед. Түүнээс биш тэгээд л нэг Энхбаяр даргыг ноолоод байгаа юм бол байхгүй шүү, жоохон эмзэг байх шиг байна лээ. Тэгээд хариулж байгаа хариултуудыг заримыг нь сонсохоор "энэ нэг ийм, энэ нэг хэдэн тоо л байгаа шүү дээ, нэг их бодлого гээд байх юм байхгүй шүү дээ" гэж. Үгүй ээ, энэ чинь маш том бодлого шүү дээ. Эдийн засгийн яам чинь бүүр бид анх яаж байгууллаа. Тэгэхдээ та хариулаагүй байж магадгүй, би нэрийг нь хэлж болж байна, тэгэхдээ одоо бас яах вэ дээ гэж бодоод. Юу гэсэн үг юм бэ энэ чинь одоо "энэ хэдэн тоо л байгаа шүү дээ, энэ тоон дээрээ, энэ ямар ч бодлого байхгүй, юун бодлого яриад байгаа юм бэ" ч гэж байх шиг.

Тэгээд энэ төсвийн хүрээ гэдэг чинь энэ хүрээндээ л бид төсвөө батална гэсэн Монгол Улсын маш том бодлого шүү дээ. Үеийн үед. Энийг дагаад төсвөө ярьдаг, 16 оноос хойш, тэрнээс өмнө ч гэсэн. Тэгэхлээр гишүүд рүү нэг их буруу өгөөд, энэ хэдэн тоондоо л яах ёстой гээд, энэ хэдэн тоог чинь цаана нь бүх төсөв чинь байгаа, бүх Монгол Улс чинь байгаа. Тэгээд тэрийг одоо анхаарч ажиллана биз. Яах вэ, би зүгээр Байнгын хороон дээр асуусан асуултуудаасаа чуулган дээр асуусан асуултаа давхцуулахгүй 2 асуулт хэлэхэд бол та бол хариултдаа байнга хэлж байгаа юм, "төсөв данхар байна, төр данхар байна, зардал өндөр байна" гээд. Дунд хугацаандаа тэр 40 их наядаа бууруулж болоогүй юм уу гэж би асуусан шүү дээ. Дунд хугацаандаа тэр 40 их наядаа бууруулж болохгүй байсан юм уу? Энэ чинь төсвийн хүрээний маш том бодлого шүү дээ. Тэрийгээ нэг жоохон анхааралтай хандуулаад, зоригтойнхон шиг өөрчлөлт хийгээд ирвэл тэгээд л "Энхбаяр сайд мундаг байна" л гээд л хэлнэ шүү дээ. Би ямар сайд, дарга болох дуртай биш. Энэ АН-ын зарим гишүүд "чи яагаад сайд болдоггүй юм" гэж байна лээ. Намайг зөндөө урьдаг, би ийм сонин үед сайд хийх сонирхол байхгүй, хийх ч үгүй.

Тэгээд энэ төсвийн хүрээний энэ мэдэгдлийн үеэр ер нь бол хамгийн нэг сонин тоо байдаг нь энэ хэрэглээний үнийн индекс, түвшин гэж ярьдаг болсон. Энэ бол бид мэдсээр байгаа мөртөө засдаггүй. Тэгээд Энхбаяр сайд хариулахдаа "Статистикийн ерөнхий газрын өгдөг тоо шүү дээ". Статистикийн ерөнхий газраа дуудаж авч ирээд тоогоо засах ёстой шүү дээ. Энэ сагсаа янзалдаг юм уу, аргачлалаа өөрчилдөг юм уу, үеийн үед 5, 6 хувьтай л одоо хэрэглээний үнийн түвшин ярьдаг. Бодит байдал дээр бол дандаа 2 оронтой тоотой, энийгээ одоо засах ёстой. Би Хүрэлбаатар сайдын үеэс л байнга хэлж байгаа, хоорондоо мэтгэлцэж байгаа, маргалдаж байгаа.

Өнөөдөр ААН-үүд, иргэд үнэхээр зээлийн хүүгээс дээшээ гарах ямар ч боломжгүй байна шүү дээ. Тэгэхлээр би бол одоо Байнгын хороон дээр бодлогын хүүг ярьсан, үнэхээр энэ өндөр зээлийн хүүг чинь даваад, үнэхээр энэ яг зээлийн хүүд л үнэхээр ажил хийж байгаа хүмүүс хийгээд л байдаг, хийгээд л байдаг, зээлийн хүүгээ дийлэхгүй болохлоор тэр хүн одоо ямар ч тийм идэвх байхгүй, шүүмжлэлтэй байгаа шүү дээ аливаа асуудалд. Тэгэхлээр энэ нэг хадны мангаагаар айлгаад байгаа бодлогын хүүгийн асуудлыг шийдвэл бидэнд гаргалгаанууд гарч ирэх магадлалтай. Хувийн хэвшил хийх юмаа хийгээд, амьдруулах, аваад явах хүмүүсээ аваад явчих боломжтой байхгүй юу. Төр бүгдийг нь хийх биш, энийг бас.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Төсвийн хүрээ хуульд заасан 9 гол тоо байгаа, үзүүлэлт байгаа. Энэ бол ерөөсөө л Монгол Улсын ирээдүйн төсөв яаж гаргах нь вэ, ирээдүйн эдийн засгийн төсөв, төлөөлөл, инфляц яаж тооцох нь вэ гэдэг чинь бүгд энэ дээр л байгаа. Энд бүгдээрээ хаана хаанаа анхаараад, энийгээ их зөв, үндэс суурь сайтай гаргачихвал тэгээд л бодлого тогтвортой болоод л, төсөв зөв болоод л явна. Энэ бол санал бодол та бид хоёр нэг байгаа. Инфляцтай холбоотой бол яах аргагүй статистикийн байгууллага УИХ-ын дэргэдэх байгууллага хараат бусаар, олон улсын аргачлалаар энэ инфляцыг тооцоод өгдөг ийм хуультай, дүрэмтэй. Энд хөндлөнгөөс нөлөөлөх бололцоо байхгүй, хараат бус, зөвхөн Их Хурал энэ асуудалд орно. Тэгэхээр засаг бол тэр гарсан тооцоолол дээр бид нар дүнгээ авч явна. Мэдээж өөрсдөө тооцоолно, тоон дээр жоохон маргана, үндэслэлээ хоёр талаасаа нийлүүлнэ. Ингээд 27 онд бол инфляцыг 7 хувьтай аваад явахад ийм зорилт тавьж ажиллаж байгаа.

Нөгөө талаар эдийн засагт байгаа, одоо яг үүсэж байгаа хүндрэлийн асуудлыг яриад байна. Ер нь энэ бол үнэн. Одоо бидэнд юу хэрэгтэй гэвэл шинэ эдийн засаг, шинэ зах зээл л хэрэгтэй болоод байна. Дотоодын зах зээл, дотоод үйлдвэрлэл үндсэндээ олон түвшинд ханаад байна, 3.5 сая хүний зах зээл багадаж эхэлж байна манай ААН-үүдэд. Ийм үүднээс Евроазийн зах зээлийг тэлэх гэрээ, дүрэм хууль Их Хурлаар батлагдлаа, 7 сарын 22-ноос одоо мөрдөж эхлэх нь байна. Манай гол үйлдвэрлэж байгаа ХАА, хөнгөн үйлдвэрийн салбарын 367 нэр төрлийн бараа татварын нэн таатай нөхцөлтэйгөөр 180 сая хүний зах зээлд гарах гэж байна. Энд холбогдох гэрээ, протоколууд, хорио цээр, стандарт, гааль, мал эмнэлэг, ургамал, хорио цээрийн байгууллагууд ажлаа хийгээд, зохицуулалтууд яг ажиллаж байна. Энэ бол манай эдийн засгийг тэлэх, ААН-үүдэд нэг шинэ түвшинд гарахад их томоохон дэмжлэг болно.

Мөн Узбектэй нэг талын гэрээ, Солонгостой бас худалдааны чөлөөт ийм хэлэлцээрүүдийг хийх ажлууд, бэлтгэл ажлууд явагдаж байна. Аль болох л одоо бидэнд зах зээлээ тэлэх гол зүйл байна, экспортынхоо төрлийг нэмэгдүүлэх ийм зайлшгүй шаардлага байна. Тэгээд эдийн засгаа тэлж байж л одоо энэ тулгамдсан олон асуудлын ард гарна шүү дээ гэж.

Ж.Бат-Эрдэнэ: Отгоншарын Батнайрамдал гишүүн. Тодруулъя, Ганбаатар гишүүн, Жамбалын Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Олон зүйл дээр санал нэг байгаа л даа. Тэгээд Эдийн засгийн хөгжлийн яамыг анх байгуулж байсан тэр хүлээлт байхгүй байна л даа. Тэгэхлээр засагт ороод ажиллахаараа зоригтойнохон шиг, ялангуяа Эдийн засгийн хөгжлийн сайдад бол зөндөө эрх мэдэл байгаа шүү дээ, хуулийн дагуу. Уул нь бол Сангийн яамнаасаа илүү их эрх мэдэлтэй. Тэгээд Эдийн засгийн хөгжлийн яамыг саяхан байгуулсан шүү дээ. Бидний цаг хугацаагаар саяхан байгуулсан, тэгэхдээ бол хүлээлт маш өндөр. Би Гантөмөр сайдыг ч гэсэн шүүмжилдэг байсан "та одоо засагт ороод дуусаж байна" гээд. Танд ч гэсэн би бол Эдийн засгийн хөгжлийн яам, би өөрөө энэ хуульд их идэвхтэй оролцсон, тийм учраас хүлээлт маш өндөр байгаа юм. Тэгээд хүлээлтэд хүрэх асуудал байна шүү. Та бид хоёрын дунд зөндөө мэтгэлцээд явж байгаа, цаашдаа ч явна. Амжилт хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Ер нь Эдийн засгийн хөгжлийн яаманд бид нар Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад, ийм нэг төлөвлөлтийн том институц байх, бодлого барьдаг том институц байх ёстой гэж байгуулсан шүү дээ. Яг үнэндээ бол хүлээлт байгаа шүү, тэр хүлээлтэд хүрэхгүй байгаа. Отгоншарын Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: 2029 он хүртлээ бид эдийн засаг бол 5.8-аас 6.3 хувь өснө гэж тооцож байгаа. Өнөөдрийн бидний байж байгаа байдал бол төсвийн алдагдал 1.4 их наяд эхний улирлаар. 27 оны хөгжлийн төлөвлөгөө дээр бид нар 15.3 их наяд төгрөгийн санхүүжилт хийнэ гээд хөгжлийн төлөвлөгөө явж байгаа. Тэгэхээр Тэргүүн шадар сайд бол хамгийн их давтагдаж байгаа гэвэл эх үүсвэр байхгүй, бидэнд шинэ юм хэрэгтэй байна. Би танд нэг шинэ гаргалгаа хэлж өгье. 2026 онд, энэ онд шүү, Оюу Толгой төсөл дэлхийн хамгийн алдартай Морган Стэнли /Morgan Stanley/ банкны судалгаагаар энэ онд 5.2 тэрбум долларын ашигтай ажиллана, энэ бол 18 их наяд төгрөгийн зардлаа хасаад ашигтай ажиллана гэдэг ийм тооцоолол 3 сарын өмнө гаргасан. Энэ 18 их наяд төгрөгийн Оюу Толгойн 26 онд авах ашгийн 34 хувь нь бол 6 их наяд төгрөг байхгүй юу, 6 их наяд төгрөг шүү. Бидний 27 онд баталж байгаа хөгжлийн төлөвлөгөөний нийт санхүүжилтийн 40 хувьтай дүйцэхүйц хэмжээний мөнгө.

Тэгэхээр Тэргүүн шадар сайд аа, би танаас асуумаар байгаа юм. Та бас 4 удаа сонгогдсон туршлагатай, олон зүйлийн ард гарч байсан улс төрч хүн. Хувь улс төрчийн хувьд энэ Оюу Толгойн 34 хувьд оногдох 6 их наяд төгрөгийг бид нар авах эрхтэй юу, авах нь зөв гэж бодож байна уу та, яг таны би хувийн бодлыг сонсмоор байгаа юм 1 дүгээрт? Та "тийм", "үгүй" гэж байгаад яг нэг хариулаад өгөөч.

2 дугаарт, хөгжлийн төлөвлөгөө, төсөөллөө бид нар ярьж байгаад энийг Эдийн засаг, хөгжлийн яам хийдэг. Тэгэхээр энэ 6 их наяд төгрөгөөр яг юу хийж болох вэ, бид 26 ондоо, 27 ондоо энэ 6 их наяд төгрөгөөр яг юу хийж болох боломж бидэнд байна вэ? Яг маш хоёр ойлгомжтой асуултыг эхлээд танаас асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр Тэргүүн шадар сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Монгол Улс, Монгол Улсын Засгийн газар амласандаа байх ёстой, олон улсын болон бусад хөрөнгө оруулалтын хийсэн гэрээгээ биелүүлэх үүрэгтэй, миний зарчим тийм л байдаг. Гэрээгээ сайжруулах асуудал бол дараагийн асуудал. Сайжруулахын тулд Засгийн газраас үүрэг даалгавар өгөөд, холбогдох сайдууд хэлэлцээрийг хийгээд амжилтад хүрч байгааг та бүхэн мэдэж байгаа. Тэрнээс гэрээнд заагаагүй үнийн өсөлтийн орлогыг бид олох ёстой, авах ёстой гэсэн зүйл одоо би, та надаас асуугаад байх шиг байгаа юм. Тэгэхээр бид ямар гэрээ байна, тэр гэрээгээ бид биелүүлж байж, хариуцлагатай байж гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татна л гэж би бодож байна.

Мэдээж 6 их наяд гэдэг чинь их хөрөнгө, зөвхөн 27 оны хөрөнгө оруулах бололцоо 2.2 их наяд байна шүү дээ, тэрнээс одоо 3 дахин их бололцоо байна гэсэн үг, та ярьж байна. Мэдээж энэ хэмжээнд эдийн засаг, нийгмийн тулгамдсан маш олон асуудлыг шийдэх бололцоо энд бол байгаа. Гэхдээ энэ үүсэж байгаа энэ жилийн ашиг шууд Монгол Улс 34-ийг авах ёстой гэж үзэж бол болохгүй гэдгийг бол би өөрөө сайн мэдэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулъя, Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Монгол Улс амласандаа байх нь зөв, бид нар амласан амлалтдаа байх ёстой. Хөрөнгө оруулагч тал бас амласан амлалтдаа байх ёстой. Ингэж харилцан ашигтай, урт хугацаандаа үргэлжилдэг. Хөрөнгө оруулагч тал гэрээ хийхдээ 58 хувийн, 53 хувийн өгөөж амласан шүү дээ. Өнөөдөр тэр өгөөж дотроос бид нар 5 хувийн амнат л авч байгаа, бусад нь бүгд маргаантай, татварууд бүгд маргаантай, ногдол ашиг байхгүй, тэр амлалт биелээгүй шүү дээ. Бид нар амлалтдаа байя гэж байгаа байтал нөгөө тал амлалтдаа байх ёстой. 6 их наядын өгөөж авах боломж байгаа шүү дээ. Хувь нийлүүлэгчийн гэрээн дээр бүх зээл төлсний дараа ногдол ашиг авна гэж байгаа юм. Тавхан сарын өмнө батлагдсан 120 дугаар тогтоол дээр Хувь нийлүүлэгчийн гэрээг харилцан дүгнээд өөрчилье гэдэг 120 дугаар тогтоолоор чиглэл өгөгдсөн байгаа юм, УИХ-аас бол ажлаа хийчихсэн юм шүү. 120 дугаар тогтоолоо та уншаарай, энэ ногдол ашгаа аваач, авахгүй тэгээд эс үйлдэхүй ингээд хараад байгаад байх юм уу бид?

Ж.Бат-Эрдэнэ: Хариулъя.

Ж.Энхбаяр: Засгийн газар гэрээ хийхдээ УИХ-ын баталсан тогтоол, удирдамжид заасны дагуу л ажиллаж байгаа. Тэр хүрээнд хэлэлцээрийн багууд ажиллаж байна, ахицтай байна. Сая менежментийн гэрээ, энэ төлбөрийг буулгах асуудлыг шийдвэрлэсэн. Одоо Оюу Толгойн орд газрыг ашиглахад авсан зээлийн эх үүсвэртэй холбоотой хэлэлцээрүүд явагдаж байна, энийгээ бид нар улам сайжруулаад л явна, энэний төлөө л явна. Тэрнээс одоо бол яг ийм үнэ өсчихсөн, ашигтай байна, одоо мөнгө ав гэдэг асуудал жоохон зохимжгүй. Энэ чинь хөрөнгө, маш их хөрөнгө оруулалт, маш олон жилийн хөдөлмөр зарцуулж байж өнөөгийн зэрэгт хүрч байна шүү дээ. Авсан зээлээ төлөх ёстой, олон улсын банк санхүүгийн байгуулсан гэрээгээ тэд нар бас биелүүлэх ёстой, энд Монгол Улс хөрөнгө оруулагчийн хувьд хяналт тавиад, ТУЗ-өө ажиллуулаад ажиллаж байна. Сайжруулах ёстой. Миний яг хувийн байр суурь гэдэг бол би энэ 34 хувийг эзэмшсэн шийдвэр бол алдаатай гэж үздэг, бид зөвхөн роялтигаа.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ бидэнд маш том сургамж болох байх. Асар их хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан орд газар луу хувь эзэмшилд орсон асуудал маань бидний алдаа байсан гэж би үздэг. Бид харин энийгээ роялти буюу экспорт болгоноос шууд ногдох орлогоо аваад явсан бол өнөөдөр эдийн засгийн хувьд бид нарт хамаагүй илүү байх байсан гэдэг дээр бол ийм бодолтой байдаг. Ер нь цаашдаа ч гэсэн энэ хувь эзэмших төрийн хувь хэмжээг нэмэгдүүлэх гэдэг зүйлээс аль болох татгалзмаар байгаа юм. Монгол Улс татвараа, хураамжаа, шаардлагатай бол өсөн нэмэгдэх татвар, роялтиагаа аваад л, тэр хувийн хэвшлийн хөрөнгө оруулах, ажиллах бололцоог нь хангаад л явах ёстой.

Ж.Бат-Эрдэнэ: Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Сүүлийн 20 жил Монгол Улсад өөрчлөгдөөгүй ганцхан зүйл бол Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ, Хувь нийлүүлэгчийн гэрээ. Энэ 20 жилийн туршид бид нар Үндсэн хуулиа хэдэн ч удаа өөрчлөөд, амьдрал баян шүү дээ, өөрчлөгдөнө, сайжирна, нөхцөл байдал өөрчлөгдөнө. Ганцхан өөрчлөгдөөгүй зүйл бол хөрөнгө оруулалтын гэрээ. Нөгөө л нэг хөрөнгө оруулагчдад амласан амлалт. Хөрөнгө оруулагч ч гэсэн Монгол Улсын ард түмэнд амласан амлалтаа бас

биелүүлэх ёстой юм. Гэрээ гэдэг бол харилцан ашигтай, харилцан хүндлэлтэй, энийг гэрээ гэнэ, хэт нэг талыг барьсан бол энэ гэрээ биш шүү дээ. Ийм амлалт өгөөд өнөөдөр өгөөжөө та хар даа, бид нар 5 хувийн амнатаас өөр өгөөж бол хэцүү шүү. Татварын маргаанаа хар л даа, татвар бүгд маргаантай, ногдол ашиг байхгүй. Тэгэхээр энийг л бид нар засах ёстой юм. Энэ дээр маш том боломж байгааг бид нар бүгдээрээ харж байгаа шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Батнайрамдал гишүүн үг хэллээ. Мэндбаярын Мандхай гишүүн.

М.Мандхай: Бид өнөөдөр 2027 оны төсвийн хүрээ, хүрээний мэдэгдлийг хэлэлцэж байна. Өөрөөр хэлбэл ирэх жил ард түмний татварын мөнгийг юунд зарцуулах вэ гэдгийг шийдэх гээд бид нар сууж байгаа. Төсөв бол төрийн мөнгө биш, ард түмний халааснаас гарч байгаа мөнгө гэдгийг бүгд мэдэж байгаа. Энэ мөнгө өөрөө эргээд хамгийн түрүүнд ард иргэдийн амьдралд юу хэрэгтэй байна, түүнд л зарцуулагдах ёстой. Гэтэл миний гаргасан, ард түмний төлөө гаргасан зарчмын зөрүүтэй саналыг сая төрийн, Төсвийн байгуулалтын байнгын хороонд, Төсвийн байнгын хороонд бол унагасан байгаа. Энэ нь юу байсан юм бэ гэхлээр, дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүн худалдаж авсан бол НӨАТ-ын буцаан олголтыг 100 хувь урамшуулалтай болгоё гэсэн энэ саналыг бол унагаж байгаа юм. Одоо яг ард иргэдэд юу чухал байгаа юм, өдөр бүр мах, гурил, сүү, ногоо, өндөгний үнэ өсөөд хүнсний инфляц 19 хувьд хүрчихсэн байгаа, энэ айл өрхүүдэд бол үнэхээр их дарамт болж байгаа. Тэгэхээр энэ санал иргэдийн халаасанд бодитоор мөнгө болж үлдэх ийм боломж байсан юм. Тэгтэл Монголдоо үйлдвэрлэж байгаа үйлдвэрүүдээ дэмжье гэж ярьдаг боловч дэмжих саналаа өөрсдөө татаад унагаачихсан.

Гэтэл үүний оронд 2027 оны төлөвлөгөөнд хэдэн 100 тэрбум төгрөгийн барилгын байгууламжууд, төсөв орж ирж байгаа юм. Би жишээ дурдъя, шүүхийн шинэ барилгад гэхэд нийт 245 тэрбум төгрөг зарцуулахаар, зөвхөн 27 онд 33 тэрбум төгрөгийг тавьсан байгаа. Яах вэ, шүүхийг бол байргүй байг гэж хэлж байгаа юм биш, төрийн байгууллага хэвийн орчинтой байх ёстой. Гэхдээ өнөөдөр энэ ард иргэдийн татвараас босож байгаа энэ төсвийг бид нар хамгийн том юунд нь зарцуулах ёстой юм бэ? Тулгамдаад байгаа асуудал өөрөө хүнсний инфляц мөн биз дээ? Талхны үнэ, махны үнэ, өрхийн зээл, хүүхдийн сургалтын төлбөр гээд амин тулсан асуудлууд байна. Энэ иргэдийн хоол хүнс, өрхийн орлогыг, дотоодын үйлдвэрлэлд шууд нөлөөлөх саналыг нь хойш тавьчхаад, үр дүн нь одоо шууд мэдэгдэхгүй, ард иргэдэд мэдэгдэхгүй байгаа өндөр үнэтэй барилга байгууламжийн төслүүдийг төсвөөс санхүүжүүлэх нь өөрөө зөв юм уу, энэ зөв эрэмбэ дараалал юм уу? Энэ мөн хүнсийг, хүнсний үнийг бууруулах юм уу, өрхийн зардлыг багасгах юм уу? Энэ иргэдийн амьдралд маргаашаас мэдрэгдэх үү? Энэ төсвийн хүрээгээ тооцож, төлөвлөгөө гаргах бодлогыг барьж байгаа Эдийн засаг, хөгжлийн яам, энэ Сангийн яам анхаармаар байгаа юм.

Тэгэхээр миний байр суурь бол иргэдийн хоол хүнс, өрхийн орлого, дотоодын үйлдвэрлэлдээ шууд дэмжлэг үзүүлэх бодлогоо хойш тавьчхаад, асар өндөр өртөгтэй барилгын төслүүдийг нэн тэргүүнд санхүүжүүлэхээр оруулж ирж байгаа ийм асуудал байж болохгүй. Тэгэхээр энэ 27 оны төсвийн хүрээг бид нар хэлэлцээд, үүн дээр түшиглэсэн төсөв яригдаж байгаа тохиолдолд бид нар энэ төсвөө бетон биш, ард иргэдийн амьдралыг дэмждэг төсөв байгаасай, ийм төсвийг батлаасай гэдэг би ийм зүгээр саналыг хэлэх гэсэн юм.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Энхбаяр гишүүн.

Ж.Энхбаяр: Өнөөдөр бид төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байна. Төсвийн хүрээний мэдэгдлээр аль салбарт хэдэн төгрөг зарцуулах асуудал ердөө яригддаггүй, хуулиар тийм боломж ч байхгүй. Бид Монгол Улсын маань эдийн засаг ямар байна, орлого яаж олох нь вэ, үүнд зарлагыг ингэж гаргах бололцоо байна, гадаад зээлийн ашиглалт ийм байх юм байна, орон зай байна, халамжийн зардлын чинь дээд хэмжээ энэ шүү гэдэг л ерөнхий хүрээ, хязгаар гаргаж байгаа. Энийгээ баталбал энэ дээр чинь одоо Сангийн яам энэ зуны хугацаанд боловсруулалт хийнэ. Тэгээд сая Мандхай гишүүний хэлдгээр салбаруудын саналаа аваад, төсөл хөтөлбөрөө эрэмбэлээд ороод ирнэ шүү дээ, тэгээд тэр намар ярих асуудал. Одоо төсвийн хүрээ дээр бол ямар нэгэн салбарт тэдэн төгрөг тавина, ингэнэ гэсэн зүйл ердөө байхгүй, тийм зүйл орж ирээгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Төсвийн хүрээний мэдэгдэл оруулж ирж байгаа нь өөрөө Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагыг хамгийн үрэлгэн төсөв байна гэдэг асуудлыг хэлэлцэж байгаа юм. Тэгэхээр энэ хүрээтэй өөрөө шууд хамааралтай 1 дүгээрт.

2 дугаарт, өнөөдрийн хэлэлцэх асуудал дээр НӨАТ-н буцаан олголттой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль, татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болгохтой холбоотой бас нэг хэлэлцэх асуудал байгаа учраас би өнөөдөр өөрийнхөө гаргасан, ард иргэдийн төлөө тулгамдаад байгаа асуудлыг шийдэх зарчмын зөрүүтэй санал Төсвийн байнгын хороон дээр унасан учраас би энэ асуудлыг бүр өнөөдөр хэлье гэж бодож хэлж байгаа юм. Тэгээд би өөрөө санал хэллээ гэсэн.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Норовын Алтанхуяг.

Н.Алтанхуяг: Би Мандхай гишүүнтэй санал нэг байна, Энхбаяр сайд аа, бид нар хоосон тоо ярихгүй, эсхүл одоо ямар ч бодлогогүй тоо бас ярихгүй. Өнөөдөр энэ улсын төсөв гэж ер нь юу юм, юунд чиглэх ёстой юм, энэ 27 оны улсын төсвийн хүрээний мэдэгдэл, 28, 29 хаа ч байсан тоо жилүүдэд төсвийн төсөөллийн тухай ярьж байгаа. Энэ чинь манай ард иргэдийн амьжиргаа, ахуйд энэ төсвийг яаж дамжуулж, дэмжиж болох юм гэдэг л ийм л агуулгатай юм ярьж байгаа учраас Мандхай гишүүн ийм үг хэлчихье гэж би бодож байна. Тэгээд 12, 13 оны үед улсын төсөв бол 8, 9 их наяд л байсан юм. Хүн бол хөнжлийнхөө хэрээр, айл өрх ч гэсэн, улс орон ч гэсэн хөнжлийнхөө хэрээр хөлөө жийдэг, тэр үед нь тэгээд л наана, цаана гээд л болгоод л явдаг.

Яаж болгодог юм ерөөсөө энэ өрхийн амьжиргаа, хүн амын орлогыг дэмждэг юм руугаа л илүү чиглүүлдэг. Одоо тэр өндөр өртөгтэй янз бүрийн байшин сав, их олон юм барьдгийг бол зогсоодог, царцаадаг, дуудлага худалдаанд оруулж хувийн хэвшлийнхэнд өгдөг. Үгүй ээ, одоо мянган арга л байгаа л даа, ингээд хийхгүй. Тэгээд дахиад улсын төсөв яагаад дампуураад байгаа вэ гэхээр 24 онд зүв зүгээр явж байсан төсөв дээр 3 их наяд төгрөгийн зарлага шууд нэмээд л орлого маань нэмэгдэж байна, зарлагаа нэмнэ гээд л энэ чинь та нарт өнөөдөр аймаар хүнд ачаа болчихсон л явж байгаа, улс орон даяараа.

Хүрэлбаатар сайдын үед сонгуулийн өмнө хөрөнгө оруулалтаа нэмээд л, маш олон одоо объектын суурийг тавиад л, тэгээд нэгэнт суурийг тавьчихсан юмыг чинь одоо гүйцээхээс өөр аргагүй гээд л энэндээ чирэгдээд ингээд үхэж байгаа юм л даа. Ингээд энэ улсын төсөв гэхээс гадна ард түмний ахуй амьжиргаа бол энэ тэр лүү мөнгө нь явахгүй, ингээд байшин сав, илүү хэрэггүй байсан сав, үр ашиг багатай байсан сав руу асар их мөнгө явж байна гэдэг дээр би санаа нэг байгаа. Үндэсний үйлдвэрлэлээ дэмжмээр байна шүү дээ. Одоо та нар 500 гаруй тэрбум төгрөг улсын төсвөөс гаргаад явж байгаа, тэр нь болохлоор 6 хувийг нь хямдхан зээл өгөөд, 12 хувийг нь улсын төсвөөс төлөөд явж байгаа. Энэ бас эзнээ олохгүй байна гэдэг ийм гомдол их ирж байна. Шударга бус байна, наадхыг чинь дахиад томчуул нь хуваагаад авчихна гэж байх юм. Ийм, ийм юмнуудаа яг эзэнд нь хүрдэг, энэ хөрөнгө оруулалтын зардал нь үр ашигтай байдаг, зарлагаа хэтэрхий өсгөөд байдаггүй ийм юмнуудаа ярих ёстой л доо хэдүүлээ, ярихгүй бол болохгүй. Би, цаг дөхөж байна уу, байна.

Оюу Толгой дээр бас үг хэлэхгүй бол болохгүй байна. Энхбаяр сайд та бас их олон жил энэ танхимд сууж байсан хүн. Энэ Оюу Толгой дээр нэг жаахан арга хэмжээ авчхаж болохгүй юм уу? Одоо бид нар нэг юу билээ, нэг сонсгол хийгээд л, УИХ-аас тогтоож гаргаад л, Засгийн газар маань та нар энэ дээр ажилла гээд ингэсэн шүү дээ. Манай Засгийн газрын үед 3 сайдын хамтарсан тушаал гаргаад, анхны хөрөнгө оруулалт яагаад 2 тэрбум ам.доллараар нэмэгдчихээд байгаа юм, энэний учир утгыг олъё, бас яг одоо гарсан, нэмэгдчихсэн юм байвал тэрнийг нь зөвшөөрье гэсэн. Яагаад одоо энэнийг бас та энэ асуултад хариулаадхаарай. Яагаад энэ асуудлыг 2 тэрбумаар хэтэрсэн хэтрэлтийн шалгалтын материал яагаад нууцад орчхов? Та энэ дээр нэг хариулт өгөөдхөөч.

2 дугаарт нь, тэр Хувь нийлүүлэгчдийн гэрээг одоо, гэрээнд өөрчлөлт оруул гээд УИХ-ын тогтоол Батнайрамдал гишүүний хэлээд байгаа энэ бас үнэн, энийг яагаад хийхгүй байгаа юм бэ? Эсхүл хийж байгаа юм уу? Хийж байвал хэзээ үр дүн нь гарах юм бэ? Энэ бид нар өдөрт 13, 14 тэрбум төгрөгийн, тэрбум төгрөгийн хүү төлж байгаа гэдэг чинь үнэн биз дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр Тэргүүн Шадар сайд хариулъя.

Ж.Энхбаяр: ОТ-н гэрээтэй холбоотой улсын нууцад ороод байгаа зүйл байхгүй, бүгд нээлттэй байгаа. УИХ сонсгол хийгээд бүх ард түмнээрээ л сонссон. УИХ-ын холбогдох шийдвэр тогтоол гарсан, ЗГ-т үүрэг удирдамж өгсөн. Тэрний дагуу ажлын хэсэг гаргаад хэлэлцээр сайжруулах ажлууд явагдаж байна. Байнга сайжруулахын төлөө л бид зүтгэнэ. Мэдээж гэрээ хийхдээ дутуу тооцсон зүйл байгаа байх. Тэрийг эргэж яриад яах вэ. 20 жилийн өмнөх нөхцөл байдал, 20 жилийн өмнөх гэрээний асуудлыг бид одоо дүгнэх биш, өнөөгийн цагтай нийцүүлээд сайжруулъя гэдгээ тавиад, 2 талаасаа сайжруулаад урагшилж л байна шүү дээ.

Зээл эзнээ олохгүй байна гэдэг дээр эсрэг байна. Төрөөс зээл олгогддог зүйл зогссон. Бүх зээл арилжааны банк шийдвэр гаргаж өгч байгаа. Тэрнээс төрөөс мэдээд тэр компанид олго, энэ компанид олго гэдэг өмнөх алдаагаа давтахыг хүсэхгүй байгаа. Зээлийн эх үүсвэрийг банканд өгнө, банк цаашаа шийдвэрээ гаргана. Яамнууд ямар бодлого гаргаж байгааг жишээлбэл ХХААЯ-ан дээр ЗГ хөтөлбөр хэрэгжүүлэх атрын 4 дүгээр аяныг хэрэгжүүлэх үүднээс юу гэдэг юм өвлийн хүлэмж гэдэг юм уу, эрчимжсэн МАА гэдэг юм уу, газар тариалан энэ салбарын ийм эргэлтийн зээлийг олгоно л гээд болоо. Тэгээд компаниуд шалгуураа

хангаад, арилжааны банктай тэр дүрэм журмынхаа дагуу л авч байгаа. Бодлогыг нь зааж байгаа болохоос биш салбарыг энд тэнд өг гэдэг зүйл ердөө байхгүй болсон. Энэ асуудал аль хэдийн цэгцрээд дууссан.

Мэдээж энэ та ярьж байна. Төсвийн хүрээн дээр бид юунд зарах асуудлыг ярих яагаад ч бололцоо байхгүй шүү дээ. Боломжгүй шүү дээ орлого маань энэ байна, зарлага нь энэ байна. Зардал ерөөсөө нэмэгдээгүй, зардал, төсвийн суурь зарлага байна шүү дээ 37 хувь хүрч байсан. Одоо та харвал бид ирэх онд 28,4, 28 онд 27,4, 29 онд 26,1 буюу энэ эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах гэдэг бодлого барьж байгаа юм. Аль болох л төрийн зардлыг багасгана, энүүгээрээ хувийн орон зайг нь тэлнэ, бизнест боломжийг үүсгэнэ, эдийн засагт оролцож байгаа ТӨК-удын оролцоог багасгана, нэгтгэнэ, цөөлнө, татан буулгана. Эрчис Монгол гээд том системийн компанийг сая дуусгалаа. Эрдэс Монголын харьяанд байсан 10 том ААН-ийг татан буулгаж байна. Нийлүүлэх процессуудыг тасралтгүй хийж байна. ЗГ уялдааг сайжруулах, давхцалыг арилгах ажлууд тасралтгүй хийгдэж байна. Энэ намрын төсөв өргөн барих хүрээнд нэлээн бодлогын том өөрчлөлттэй ороод ирнэ.

Бизнес орчныг дэмжих бодлогын хуулиуд, бизнесийн эрх чөлөөг хамгаалах, өмчийн халдашгүй дархан байдал, бизнесийн нэр хүндийг хамгаалах, гаднын хөрөнгө оруулалтыг дэмжих энэ зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх хууль ирэх 7 хоногт Их Хуралд өргөн баригдана. Засгаар хэлэлцээд үндсэндээ дэмжигдсэн. 110 гаруй хууль өөрчлөгдөхөөр бид төсөл боловсруулж байгаа. Ингэж эдийн засгаа тэлэх, хөрөнгө оруулалтыг дэмжихгүй бол одоо байгаа манай эдийн засгийн чадавх дээд түвшиндээ хүрсэн. Эдийн засгаа л тэлэх, тэгэхийн тулд хөрөнгө оруулалтыг татах таатай орчныг үүсгэх нь л засгийн тэргүүлэх зорилт байна.

Ж.Бат-Эрдэнэ: Норовын Алтанхуяг гишүүн тодруулъя.

Н.Алтанхуяг: Танд үг хэлсэнд дор шүлсээ хаясан нь дээр юм байна даа, юм сонсохгүй, муйхар мулгуу өөрийнхөөрөө зүтгэдэг. Үгүй ээ энэ тоонуудын чинь цаана бодлого гарч байж тоо гардаг байхгүй юу даа. Тэгээд надад засгийн, би ЗГ зээл өгдөг гэж яриагүй. Та ч гэсэн ЗГ-аас ЖДҮ-ийн зээл хусаагүй, та тэр нэг тэр ЖДҮ-ийн сангаас авсан. Наадах чинь аль дивангар шийдэгдсэн асуудал шүү дээ. Та яагаад хүний, хүн конструктив байдлаар юм хийе гээд асуухаар өөдөөс нь мулгуу цэцэрлэгийн хүүхэдтэй ярьж байгаа юм шиг, цэцэрлэгийн хүүхэд ч гэсэн тэгж, цэцэрлэгийн хүүхэд ч гэсэн наадхыг чинь ойлгохоор асуудал шүү дээ. Би танаас тийм л юм асуусан шүү дээ. 12 хувь нь улсын төсвөөс өгөөд байна, 6 хувийг нь тэр ААН төлж байна. Зээл нь арилжааны банкаар явж байгаа л даа.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулах юм уу? Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Үгүй ээ тэгээд л хүн юм ярихаар улс төржөөд, чиний тэгээд улс төржөөд, үгүй ээ тэгээд ард түмний ахуй амьжиргааг чинь улс төрийн асуудал юм уу. 10 жил тасралтгүй сайжруулаад байхаар ард түмний амьжиргаа унаад байгаа чинь тэгээд мундаг ажиллаад байгаа юм уу? Үгүй ээ чамаас ямар хариулт сонсдог юм, чи ийм хачин юм ярьж байгаа боль. Эдийн засгийн хөгжлийн сайд гээд байгаа шүү. Үнийн өсөлт өдөр тутам нэмэгдэж байна. Энийг яаж зохицуулах гэж байгаа юм бэ? Энэ чинь арга чарга мянган арга чарга байдаг. Үндэсний үйлдвэрлэлээ яаж дэмжих гэж байгаа юм бэ? Битгий хоосон тоо яриад бай л даа. Тэгээд энэ хууль дээр чинь Мэндсайхан сайд мэдэж байгаа шүү дээ төсвийнхөө тодотголыг хэдүүлээ

хол хийвэл зүгээр байдаг юм гээд энэ Төсвийн тогтвортой байдал хүртэл хэлээд 3 сар дотор битгий хий. Тэгэхээр нь үгүй ээ заавал 3 сар. Үгүй ээ тэгээд энэ нэг юм.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд хариулчихъя.

Ж.Энхбаяр: Эдийн засаг нь 17 хувь өсдөг эдийн засгаа танд өгсөн, та Засгийн газрын тэргүүн болсон, та эдийн засгийг 4 жилийн дотор хасах үзүүлэлттэй оруулаад, валютын нөөцөө тэглэсэн сайд шүү дээ. Тэрийг чинь өсгөөд, жил болгон 5-аас 7 хувийн өсөлттэй болгоод өглөө. Валютын нөөц нь 7.3 тэрбумд хүрээд ирлээ. Үйлдвэрлэл бүх түвшинд хөдөлж байна. Таны өндөг тансаг бараа ард түмэн хэрэглэхэд тансаг гэж хэлдэг өндөр ард түмний хэрэглээнд болоод, дотоодоосоо 100 хувь хангадаг болоод ирж байна. Ганцхан жишээ, үйлдвэрлэлийн жишээ, тансаг биш болсон. Гаднаас хамаардаг байсан зүйл дотоодоосоо хангадаг болж байна, үйлдвэрлэлүүд өсөж байна. Иймд та эдийн засгийн 10 жилийн өсөлтийг үгүйсгэж чадахгүй. Таных түүх болоод үлдсэн, Монгол Улсын эдийн засгийг 17 хувийн өсөлттэй эдийн засаг, хамгийн их хөрөнгө оруулалт татдаг улс орныг та хасах болгосон хүн шүү дээ. Валютын нөөцийг тэг болгосон хүн шүү дээ.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Би асуултаа асууя, Энхбаяр сайд, Алтанхуяг гишүүнээ, миний минут яваад байна. Тэгэхээр өнөөдөр бид төсвийн хүрээний мэдэгдлээ ярьж байна. Тэгээд энийг бид 3 жилээр хийж байгаа, 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төсөөлөл гээд. Тэгэхээр энэ дээр 1 дүгээр асуулт, энэ төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн төсөөллийг тодорхой орон зайтай хийж болдоггүй юм уу? Одоо ингээд 2024 оны Их Хурлаар бид хэд 126-уулаа болсноос хойш хэдэн ч удаа төсвийн хүрээгээ өөрчилчөв, төсвөө тодотгочхов.

Тэгэхээр харахаар 28 онд жишээлбэл 37 их наяд 371 тэрбум 800 сая гээд ийм аравтын бутархайтай орлогын доод хэмжээ нь. Тэгэхээр нэгэнт бид юмыг төлөвлөж байгаа юм бол, хүрээ тогтоож байгаа юм бол тэрэндээ сая нөгөө яриад байгаа нөлөөлөл, нөхцөл байдал, гадаад дотоод нөхцөл байдлынхаа нөлөөллийг аваад, тэр орон зайгаа аваад энэ төлөвлөгөөгөө хийж болдоггүй юм уу 1 дүгээрт?

2 дугаарт төсвийн тогтвортой байдал, ер нь тогтвортой байдал гэдэг юм ерөөсөө байхгүй болчихлоо. Дагалдуулж оруулж ирж байгаа хууль дээр чинь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5 байж байгаа. Яг жилийн өмнө бид 2025 оны 06-р сарын 25-нд яг энэ 7.5 дугаар заалтад өөрчлөлт оруулсан. Тэрэн дээрээ харгалзах жилийн гэж өөрчлөлт оруулаад, энэ харгалзах жил гэдэг чинь өмнөх 2026 оных чинь жишээлбэл тэр үед 2025 оных чинь орохгүй юм байна гэдгээр ингээд тодорхой болгоод өөрчлөлтөө ороод явж байсан.

Тэгэнгүүт өнөөдөр оруулж ирж байгаа нь нөгөө тодотголд чинь хамаагүй гэдэг юм ороод ирж байгаа байхгүй юу. Тайлбарлахдаа нөгөө тухайн жилийн гэдгийгээ энэ чинь яг одоо 2026 оноо хэлээд байгаа юм гээд түрүү жилийнхээс тэр хуулийн өөрчлөлтийг оруулж байсан үеэс шал өөр тайлбар яваад ороод ирж байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэг тайлбар авмаар байна. Түрүү жил, яг жилийн өмнө оруулсан тэр харгалзах жилийн гэдэг чинь яагаад одоо үйлчилж болохгүй байгаад байгаа юм бэ гэдэг асуулт байна. Ингээд бид яах гэж Төсвийн тогтвортой байдлын тухай

хуулийг баталдаг юм, тэр дундаа бүр 7.5-ыг байлгадаг юм бэ гэдэг чинь өөрөө ядаж тэр 3 сарын хугацаанд хөдлөхгүй байгаач л гэдэг санаа шүү дээ.

Өөрөөр хэлбэл одоо яг ингээд энэ би бүр яг Ванга шиг хэлмээр байна. Төсвийн тодотгол орж ирнэ, 2026 оны төсвийн тодотгол тэрийгээ дагаад төсвийн хүрээний мэдэгдэл буюу 2025 оны 12 сард баталсан Төсвийн хүрээний мэдэгдэл чинь орж ирнэ шүү дээ. Гэтэл энэ чинь өөрөө юу бий болгоод байна вэ гэвэл тэр өнөөдөр хүчин төгөлдөр явж байгаа, хэрэгжиж байгаа төсвийн хүрээний мэдэгдэлдээ нийцүүлээд төсвийнхөө тодотголыг хийх ёстой байтал тэр төсвийн тодотгол оруулж ирэхдээ төсвийн хүрээгээ хамт өөрчлүүлээд байдаг байхгүй юу. Энэ чинь тэр төсвийн хүрээ чинь өөрчлөгдөхгүй бол тэр тодотголыг чинь бид яаж хэлэлцэх ёстой юм бэ? Энэ асуудал энэ жил дахиад давтагдах гээд байна шүү дээ.

Яг энэнтэй холбоотойгоор түрүүн Цэнгүүн гишүүн асуусан. Нэмэгдсэн өртгийн албан татварынхаа хэмжээг та бүхэн 2027 онд одоогоороо хүчин төгөлдөр байгаа тэр 50 хувийн болон 100 хувийн буцаан олголтоо тооцож хийсэн юм уу гэсэн та болохоороо тооцоогүй, 20 хувийнхаа буцаалттай явж байгаа гэсэн. Өөрөөр хэлбэл энэ төсвийн хүрээний мэдэгдлээ оруулж ирэхдээ энэ тоогоо ингэж аравтын бутархайтай гаргаж ирэхдээ та орлогоо тооцсон. Тэгэхээр тэр орлого дотроо яагаад одоогийнхоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн дагуу 2027 онд хэрэгжих ёстой хэмжээгээр оруулахгүйгээр шууд энийг хүчингүй болгоно гэдэг assumption-тайгаар буюу урьдчилан тооцоолсноор оруулж ирж байгаа юм бэ? Тэгэхээр бид өнөөдөр хууль хэлэлцэж байгаа бол өнөөдрийн хүчин төгөлдөр хууль, эрх зүйн орчиндоо нийцүүлж явж байх ёстой. Тэгэхээр түрүүчийнхээ 2 асуултад хариултаа авчихъя.

Ж.Энхбаяр: Энхбаяр сайд хариулах уу?

Ж.Энхбаяр: Дагаж байгаа хууль, төсвийн тодотгол хийх ийм тусгай шаардлагууд байдаг хуульчилчихсан. Одоо нэгийг нь би танд уншиж өгөөдөхье. Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэх, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын бүтээгдэхүүний 3 хувьд хүрэх гээд ийм төсвийн тусгай шаардлага үүсчихлээ. Тодотгол яаралтай хийх ёстой. Яагаад гэвэл яг ийм тусгай шаардлага үүссэн үед Засгийн газар яаралтай хариу арга хэмжээ аваад, төсөв, санхүүгээ цэгцлэх учиртай байх.

Гэтэл одоо мөрдөж байгаа энэ хуулиар чинь болохгүй, 3 сарын дараа гэдэг л зохицуулалт байгаа байхгүй юу. Энэ дэлхий ертөнц хурдтай өөрчлөгдөж байгаа энэ цаг үед наадах чинь урт хугацаа байна. Хариу арга хэмжээг маш хурдтай авах бололцоог нээж өгөөч. Төсвийн тухайд бол энэ 3 сар нь болж байна төсөв бол. Тодотгол хийх нэгэнт тусгай шаардлага үүсчихсэн үед хурдан хийх нь улс оронд учрах, эдийн засагт учрах хохирол, ачаалал, дарамт чинь бага л гарна шүү дээ буюу засаг ажлаа хурдан хий л гэж байна, эсрэгээр нь хэрэггүй, байж байг, нөхцөл байдал хүндэрч байг, тусгай шаардлага үүссэн ч гэсэн хийхгүй гэж байж болмооргүй байна шүү дээ. Тэр талаас нь та нар бодоод үз л дээ.

НӨАТ одоо мөрдөж байгаа хуульд бид үндэслээд л 2 хувьд нь тооцоод л 20 хувийн буцаалтаар тооцоод төсвөө, төсвийн хүрээгээ гаргаж байгаа юм. Ийм орлого, зарлагатай байна. Хэрвээ энэ батлагдвал хөрөнгө оруулалт байхгүй болох нь. Нэг бол багш, эмч нарын нэмсэн цалингаа тавьж чадахгүй болох нь. Иймд УИХ сонголтоо хийгээч. Та бүгдийн баталсан хууль дээр ийм төсөв дээр ийм хэт тооцоолоогүй ачаалал үүсгэхчлээ шүү дээ. Тэрийг л оруулж ирж байна шүү дээ.

Одоо цалин, тэтгэврээрээ нэмснээрээ хадгалах уу эсвэл НӨАТ-ын хуулиа буцаавал хөрөнгө оруулалт чинь зогсох нь. Хөрөнгө оруулалт зогсохоор одоо хэрэгжиж байгаа энэ гэрээ, тендер аваад үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн бүх ажил зогсох нь байна шүү дээ. Энэ нь эдийн засагт бүр хортой нөлөөлөх нь байна шүү дээ.

Иймд иргэдийн тэр НӨАТ-ын буцаалтаасаа илүү ААН-үүдээ, энэ бизнесээ дэмжээд, ажлын байраа хадгалаад үйлдвэрлэлийнхээ бүтээмжээ хадгалаад явах нь улс орны эдийн засагт хэрэгтэй байна шүү дээ гэдэг л зүйл шүү дээ. Одоо ингээд шийдэл энэ дээр та бүхэн л санал хурааж шийднэ. Яах юм бэ л гэж. Бид бол нөхцөл байдлыг нь гаргаад ирж байгаа байхгүй юу. Нөхцөл байдал ийм, ийм байна, энэ дээр яаж шийдэх вэ, тодотгол хийх хэрэгтэй байна, төсвийн тусгай шаардлагууд үүсэж болзошгүй байна. Иймд бид засаг эрхээ авчихъя. Энэ зуны хугацаанд найр наадам гэж байх хооронд бид энэ төсөв, тодотголоо цэгцлээд тохируулгуудаа хийхгүй бол намар ингээд тулаад төсөв өргөн барьсантай зэрэгцүүлээд өргөн барихад бол хоцрох нь. Хохирол өндөр гарах нь ийм л зүйл шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Уянгахишиг гишүүн тодруулъя.

Г.Уянгахишиг: Уг нь би яг нөгөө тодорхой асуугаад байгаа юм. Төсөвт тодотгох нөхцөл байдал үүссэн гэж болно, төсөв тодотгож болно. Нөгөө би харгалзах жил гээд түрүүн жил оруулж байсан заалт чинь яагаад энэ жил болохоо больчихсон юм бэ гэж асуугаад байна шүү дээ. Өөрөөр хэлбэл 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл батлагдчихлаа. Тэгвэл бид 2027 оны төсвөө 3 сарын дараа өргөн бариад батлаад явна. Тэгвэл 2026 оныхыгоо бид 2026 онд яг тэгж яригдаа биз дээ, 2026 онд бид 2025 оныхоо төсвийг хөдөлгөх гээд байна тэгээд одоо яах юм бэ? Тэгээд харгалзах жилийн болгоод өөрчилсөн. Тэгээд дээрээс нь одоо яг ингээд анхнаасаа л хууль өргөн бариад л хэлэлцэж эхлэхэд яригдсан тэр зүйл чинь 7.6 дээр бас байгаа шүү дээ. 7.6 дээр гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгах зорилгоор болон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн түүнд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбоотойгоор жилийн төсөв болон төсвийн тодотгол батлах бол 7.5-ын хязгаарлалт хамаагүй гээд заалт байгаа шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулах уу, 4 номерын индэр.

Л.Энх-Амгалан: Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яам. Гишүүний асуултад хариулъя. Энэ бол дагах хууль дээр орж ирсэн асуудал, 3 сарын асуудал. Тодотгол хийхэд төсвийн хүрээгээ тодотголтойгоо хамт өөрчлөөд явдаг ийм орон зайг л бий болгож байгаа асуудал. Үндсэн төсөв батлахад бол өмнө нь баталсан төсвийн хүрээгээ бол өөрчлөхгүй. Тодотгол бол дөнгөж сая сайдын хэлснээр 4, 5 нөхцөл үүссэн тохиолдолд тодотгол хийх зайлшгүй шаардлага, нөхцөл үүссэн гэж үздэг. Нөхцөл үүссэн бол тэр даруй тодотгол хийх нь эдийн засагтаа илүү, эдийн засгаа тогтвортой байдлаа хадгалахад илүү сайн нөлөөтэй гэж үзэж байгаа. 3 сар хүлээнэ гэдэг бол илүү их эдийн засгийн эрсдэл үүсэх асуудал. Өнгөрсөн жил яг энэ асуудлыг нэг удаагийн хуулиар оруулж ирээд тодотгол хийсэн. Тэгээд тодотгол хийхдээ 2.2 их наядоор төсвийн зарлагыг хасаж байсан. Тэр үед бол инфляц 2 оронтой тоонд орох хүлээлттэй.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Нэмэлт хариулт өгье, 4.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр өнгөрсөн жилийн тухайд бол тодотголыг хурдан хийсэн тулдаа инфляцыг оны эцэст 7.5 хувьд барьж чадсан. Өнгөрсөн жил ялгаагүй 3 сар хүлээнэ гээд эдийн засгийн нөхцөл байдлаа цаашаа үргэлжлүүлээд явсан бол инфляц аль хэдийн жилийн дунджаар 2 оронтой тоонд гарах ийм л эрсдэлтэй байсан гэсэн үг. Тэгэхээр энэ жил дахиад л тодотголын асуудал хөндөгдөж магадгүй байгаа, төсвийн орлогын гүйцэтгэлтэйгээ уялдаад. Тэгэхээр 3 сар тодотголыг хүлээнэ гэдэг бол эдийн засаг дээр маш том эрсдэлтэй юм гэдэг нь л сүүлийн 2 жилд харагдаад байгаа юм. Тэгэхээр бид нэг удаагийн хуулиар нэг удаа аргалж явах биш, ер нь тодотгол дээр хүрээгээ давхар хөдөлгөөд явах нь зөв менежмент юм гэж ингэж л бодож оруулж ирсэн асуудал байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Уянгахишиг гишүүн нэмэлт асуулт асууя.

Г.Уянгахишиг: Тэгээд энэ тайлбаруудаас нь сонсоод байхаар ерөөсөө тэр 3 жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл гэдэг юм чинь ямар ч хэрэггүй юм биш үү. Дээрээс нь төсөв чинь ч нэг жил явж чадахгүй байна шүү дээ, дандаа тодотгодог. Тэгэхээр юун 3 жил байтугай нэг жилийнхээ ч төлөвлөгөөг гаргаж чадахгүй байгаа гэсэн үг биз дээ. Тэгвэл яг энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэдгээр яах юм, тэр нөхцөл байдлуудыг зааж яах юм бэ? Дээрээс нь энэ төсвийн хүрээ гэж 3 жилээр худлаа төлөвлөсөн болж яах юм. Яагаад энэ бүхнийг чинь хийдэг гэхээр үнэхээр орлогоо зөв тодорхойлооч, үнэхээр тэр чинь үнэ нь буугаад орлогоо бүрдүүлж чадахгүй юм бол тэрийгээ тодорхой байлгаач. Зарлагаа хэрвээ тогтоож чадвал тэр зарлагаа танадаг байгаач. Тэгэх гэж л ер нь төлөвлөгөө ярьдаг, тэрний чинь төлөө төсөв баталдаг биз дээ уг нь. Тэгээд тэрийг чинь төсвөө тогтвортой байлгах ёстой, тэгж байж энэ Засгийн газар чинь үйл ажиллагаа нь тогтвортой явах ёстой, улс орны чинь эдийн засаг бас хэвийн явах ёстой гэдэг ийм асуудал байдаг. Тэгэнгүүт ингээд жил болгон дандаа л төсөөлж чадахгүй үйл ажиллагаанууд, үйл явдал нь болоод байгаа гэдгээр яваад байхаар чинь энэ чинь болохгүй байна шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Одсүрэнгийн Номинчимэг.

О.Номинчимэг: Төсвийн хүрээний мэдэгдэл 3 дахь хэлэлцүүлэг орж ирэхдээ анх Засгийн газраас орж ирсэн тоо нэг ч тоо өөрчлөгдөөгүй байна. Би уг нь Байнгын хороон дээр хэлэлцэж байх үед асуудал дэвшүүлсэн юм, 05-р сарын 01-нд өргөн барьсан Төсвийн хүрээний мэдэгдлийн дараа 7 хоногийн дараа Засгийн газраас НӨАТ-ын хууль, Хүн амын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулж орж ирсэн. Тэгээд энэ хүн амын орлогын албан татвараар бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ сар бүр хүн амын орлогын албан татвараас 10 хувиас чөлөөлөгдөж байгаа. Би ойлгохдоо энэ нэг жилийнх нь үр дагавар нь 850 тэрбум. Хүн амын орлогын албан татвар учраас орон нутагт татаас өгнө гэдэг утгаараа нөлөөлөл нь 1.7 их наяд гэж ойлгоод байгаа. Энийг та нар энэ төсөөллийг хийхдээ тооцож орж ирсэн юм уу гэдэг асуултад Байнгын хороон дээр тооцоолоогүй, оруулж ирээгүй, батлагдаагүй хууль байсан учраас тооцоолоогүй гэж хариулж байсан.

Одоо ингээд тэр хууль өмнөх 7 хоногт УИХ хэлэлцэх эсэх хийчихлээ. Удахгүй мэдээж хэлэлцээд, батлах байх. Тэгээд энэ асуудал ерөөсөө дэвшүүлээд үр дүн гарахгүй байна л даа. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр ДНБ-д эзлэх төсвийн нэгдсэн суурь тэнцлийн нөгөө ашгийн нэг хувь байгаа шүү дээ, хамгийн багадаа 2 байх ёстой гээд. Тэгээд 2-т нь тулгаад ямар ч орон зайгүй оруулаад ирчихсэн байхгүй юу. Тэгэхээр чинь 1.7 их наядын зөвхөн хүн амын орлогын албан татвар

дээр шүү, ийм нөлөөлөл гарах гэж байхад Засгийн газраас өөрөөс нь оруулж ирсэн бодлого шүү дээ. Энэ дээр орлого, зарлага дээр ямар ч өөрчлөлт гарсангүй, анх оруулж ирсэн тоонд нь байхгүй гэж байгаа юм. Яагаад тэр орон зайг та нар бодож 2 дахь, 3 дахь хэлэлцүүлэг дээрээ хийхгүй байгаа юм бэ?

Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооны дарга нараас асуумаар байна. Бид Өргөдлийн байнгын хорооноос хэлэлцээд өгсөн санал дээрээ энэ санал, дүгнэлтийг өгсөн. Энийг хэлэлцсэн юм уу, худлаа болох гээд байна шүү дээ. Бид одоо гурилын нүдийг биш ээ, юуны нүдийг гурилаар хуурна гэдэгчлэн ямар ч хэрэгжихгүй төсвийн төсөөлөл ингээд батлах гээд байна шүү дээ. Хэрэгжихгүй юм баталж яадаг юм хайран цаг, бодит байдлаа эд нар чинь яриад энийгээ бодлогын хүрээнд энэ төсөв мөнгөнийхөө орлого, зарлагыг суурь зарлага өөрчилж болдоггүй юм уу? Энэ зарлагуудаасаа хасъя гээд энэ тоогоо өөрчилж болдоггүй юм уу? Хэрэгжихгүй юм оруулж ирээд бид батлах гээд ингээд хэлэлцээд байх ямар хэрэг байгаа юм бэ?

Энийг чинь тэр мэргэжлийн Байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо нь яагаад энийгээ хэлэлцдэггүй юм бэ? Худлаа орж ирсэн юмаар нь бид батлах гэж байгаа юм бол ийм асуудал байна гэдгийг гаргаж ирж байгаа юм бол яагаад энийгээ хийхгүй байгаа юм бэ? Энэ одоо хэн хариулах ёстой юм. Би Энхбаяр сайдаас бол асууна. Энд Төсвийн байнгын хорооны дарга байх шиг байна, Сангийн сайд нь байж байх шиг байна, Засгийн газар нь орж ирсэн бодлого нь ингээд явж байхад төсвийн хүрээн дээрээ ямар ч одоо ингээд биелэх боломжгүй хуулиа угаасаа зөрчих нь 2 хувиа гүйцээж чадахгүй шүү дээ яг энэ тоогоор бол. Энийгээ өөрчлөхгүй, зарлагаа тэгвэл суурь зарлагаа багасгахгүй орж ирж байгаа бол хэрэгжихгүй. Хэдхэн сарын дараа энэ хууль батлагдаад 2027 онд энэ хэрэгжихгүй хуулиа зөрчсөн л юм болно. Ийм хоёрын хооронд юм хийх ямар хэрэг байгаа юм бэ? Тэгээд энэ дээр хариулт авъя. Яагаад энэ асуудлыг ерөөсөө хэлэлцээгүй юм бэ?

Ж.Бат-Эрдэнэ: Тэргүүн Шадар сайд Энхбаяр хариулъя.

Ж.Энхбаяр: Татварын багц хуулийн 2027 оны нөлөөлөл нь 300 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардана. Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдэл дээр энэ орон зайг бид гаргаад өгчихсөн. Та анхааралтай харвал төсвийн хүрээгээр 2027 онд дотоодын бүтээгдэхүүний 3 хувьтай тэнцэх хэмжээний орон зай гаргаад өгчихсөн. 2027 онд дотоодын бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 30 хувь гэж тооцсон, сүүлийн 5 жилд энэ чинь 33 хувьтай тэнцүү яваад ирснийг бид 30 болгож бууруулна. Тэгэхээр энэ 300 тэрбум төгрөгийн татварын багц хуулиар гарч байгаа энэ орон зай байгаа.

2 дугаарт энэ батлагдаагүй хууль дээр бид юу гаргаж болохгүй шүү дээ, тооцоо нөгөө хууль оруулж болохгүй, Их Хуралд хэлэлцэгдээд явж байгаа. Тэгэхээр тэр хуулиар батлагдана гэж тавьж болохгүй. Одоо байгаа хуулиа, мөрдөж байгаа хуулийнхаа хүрээнд л бид тооцоогоо оруулна шүү дээ. Дараа нь энэ хууль хэлэлцээд батлах асуудал дээр энэ төсвийн хүрээ болон төсөв дээр ирэх ачааллын асуудлаар мэдээж гишүүд байр сууриа илэрхийлж санал хураагдах байх. Тэгэхээр бид энийг бол энэ хууль хэлэлцэж байгаа хууль батлагдана гэж одоо юу гэж болохгүй, тооцоонд одоо эх үүсвэр гаргаж болохгүй. Ажлын хэсэг хариулах хүн байвал нэмж хариулаарай.

Ж.Бат-Эрдэнэ: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Энхбаяр сайдаа үгийн хөөс чинь ихдээд агуулгын голоо харахгүй байна шүү дээ, 4 аргын тоо математик, арифметик нэмээд хасаад бодчихож чадах юм байгаа биз дээ? Асуулт асуухаар шал өөр тоо ярих юм. Эсхүл та өөрөө энэ Төсвийн хүрээний мэдэгдэл, Тогтвортой байдлын тухай хуулийнхаа шалгуурын тухай ерөөсөө ойлголтгүй байгаад байгаа юм уу? Та нар энэ хуулийг оруулж ирэхдээ гадаад зээллэгийн тэр нөгөө 3 төслийг гаргана гэдэг юмаа батлагдаагүй байхад тэрийгээ тооцоолоод л оруулаад ирчихсэн байсан шүү дээ. Тэгээд одоо яахаараа адилхан Засгийн газраас оруулж ирсэн татварын багц хууль, Засгийн газрын бодлогыг чинь ярихаар тэрийг оруулж болохгүй гэдэг юм яриад байгаа юм. Юу худлаа яриад байгаа гээд байгаа юм бэ, худлаа ярьж байгаа юм бол хоёулаа факттай үзье. Би бодит байдлыг чинь хэлж байна. Та нар батлагдаагүй тэр гадаад зээллэгийн юуг тооцож орж ирсэн шүү. Одоо болохоор тэгээд хүн амын орлогын албан татвараа багасгая гэж байна. УИХ тэрийг чинь дэмжиж байгаа. Тэгээд энийгээ тооцооллыг нь хийгээд энэ хязгаар чинь болохгүйг зөрчих гээд байна гэхээр шал өөр юм яриад байх юм. Ийм юм гэж юу байдаг юм.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Би танд түрүүн нэг тайлбарлаж л байсан. Энэ тэнцвэржүүлсэн тэнцэл буюу дотоодын нийт 1.5 хувийн алдагдал буюу 1.7 их наяд байгаа. Энэ маань өөрөө гадаад зээлийг ашиглах орон зай. Энэ хуультай, хуульгүй бидэнд байгаа санхүүгийн хязгаар нь 1.7 их наяд. Одоо барьж байгаа хууль чинь энэ орон зайг л нэмье л гэж байна шүү дээ, 2 том төслөө гаргачихвал бусад батлагдсан зээлийн хэлэлцээрүүд чинь энэ орон зайд нэмэгдэнэ гэдэг л агуулга байхгүй юу даа. Тэрнээс энэ тэнцвэржүүлсэн тэнцэлтэй холбоотой энэ тоог тооцоогүй, оруулаагүй гэж ийм болчимгүй юм ярьж болохгүй байна шүү дээ энэ чинь. Нийгэм харж байгаа шүү дээ энийг чинь. Бид бол энэ төсвийн хүрээ мэдэгдэл бол яг макро эдийн засгийн гол суурь тоонуудаа л гаргаж байгаа. Энэ доторх энэ дээр үндэслээд төсөв, хөрөнгө зохиох асуудал чинь дараагийн асуудал. Намар бид хэлэлцэнэ төсөв дээр аль салбартаа илүү гаргах вэ, цалин, тэтгэвэр хаанаа байх вэ гэдэг чинь төсвийн асуудал. Одоо бидний нийт орлого, зарлагын боломж, энэ тэнцлийнхээ асуудлыг л ярьж байна шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Энэ 7 дээр байгаа нэгдсэн төсвийн суурь тэнцэл буюу ДНБ-д эзлэх нөгөө ашгийн хувь дор хаяж 2 хувь байна гэдэг энэ хуулийн шаардлага чинь энэ 3-д байгаа нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээнээс суурь зарлагын дээд хэмжээг хассанаар гарч ирж байгаа шүү дээ. Тэгээд орлого чинь угаасаа буурах нь тодорхой болчихоод байхад энийгээ багасна гэж үзвэл 2 хувьдаа барихын тулд суурь зарлага чинь багасах ёстой юм байгаа биз. Тэгж байж та нар хуулийн шаардлага хоёроо харна. Үгүй бол одоогоороо ингэж явбал энэ чинь биелэгдэхгүй, хоёроосоо бага болно. Хуулиа зөрчнө энийг чинь яриад байна шүү дээ, тэгээд ийм энгийн ойлголт ярихаар урдаас гөлөг төөрүүлэх гэж оролдоод байгаа юм уу хаашаа юм, эсхүл өөрөө ойлгохгүй байгаа юм уу би ерөөсөө бүр ойлгохоо болилоо. Тэгээд энэ эрсдэл, эрсдэлийг чинь ерөөсөө эрсдэлийн зай байхгүйгээр 2 хувиар оруулчихсан байхгүй юу. Энийгээ өөрчлөөч.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Би таныг маш сайн ойлгож байгаа. Хэрвээ орлого та буурна, эрсдэл үүснэ, энэ 2 хувийн бас тоо яриад байна шүү дээ. Хэрвээ орлого буурвал төсөв дагаад зардлаа дагуулаад бууруулаад явна. Орлогоос давсан зардал гаргаж чадахгүй. Гарах зардлын дээд хэмжээ тэр 1.5 гэж заачихсан, аягүй хатуу хязгаар, босгууд тавьчихсан байхгүй юу. Алдагдал 1.5 байна, энэнээс илүү гарахгүй. Тийм болохоор яах вэ гэвэл орлого буурвал тэр хэмжээнд л зардал буурна буюу татаад эхэлнэ гэсэн үг. Тэгэхээр энэ өргөн барьсан хуультай холбоотой 300-аад тэрбумын орон зай гаргах асуудлыг энийг энд нь шигтгээд тооцоод гаргасан байгаа. 8 их наядаа? Мэдэхгүй, би тийм олон их наядын тийм хууль мэдэхгүй байна.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 28, 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

14.10 цаг

Тав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа орьё. Хэлэлцэх асуудал 5. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Засгийн газар 2026 оны 05-р сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг. Асуулт асуух хугацаа 60 минут байна. Ингээд дараагийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны танилцуулгыг УИХ-ын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат танилцуулна. Эрдэнэбат гишүүнийг индэрт урьж байна.

С.Эрдэнэбат: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05-р сарын 01-ний өдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 28, 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт УИХ-д өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг УИХ-ын чуулганы 2026 оны 05 сарын 21, 22-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05-р сарын 26-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа. Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед УИХ-ын гишүүн Алтанхуяг энэ хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын санхүү, эдийн засагт үзүүлэх үр дүнгийн талаар, УИХ-ын гишүүн Пүрэвдаваа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд

өөрчлөлт оруулж, төсвийн тодотголын төсөлтэй хамт төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхөөр төсвийн сахилга бат алдагдах эрсдэлтэйг анхааруулж, энэ хуулийн төсөл батлагдсанаар төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хангахад нөлөөлөх эсэх, мөн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн макро эдийн засгийн үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөх талаар, УИХ-ын гишүүн С.Эрдэнэбат улсын төсвийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийн тооцоолол болон ажлын байр, дэд бүтэц, хүртээмжийн тоо, чанарын талаар, багш, эмчийн цалин, нэмэгдэлтэй холбогдуулан төсөвт тодотгол хийх эсэх, цаашид хамтын гэрээ, хэлэлцээрээр мөрдөн инфляцыг тооцож, жил бүр тодорхой төлөвлөх, хөрөнгө оруулалтын өртөг, зардлын өсөлтийн талаар асуулт асууж хариулт авлаа.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг та бүхэндээ хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт УИХ-д өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Содномдаржаагийн Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Равсалын Рэнцэнбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга.

УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийн дагуу хууль танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй. 21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-д худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. 21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэл гэж тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэсэн байна.

Ингээд УИХ-ын гишүүд Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн саналын дагуу асуулт асууна. Асуултыг, нэрсийг ирүүлсэн байна. Батын Батбаатар гишүүн, алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн, алга байна. Саруулсайханы Цэнгүүн гишүүн, алга байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Тэгээд энэ яах аргагүй бас бидний хамтдаа шийдсэн асуудал байж байгаа. Боловсролын жил, эрүүл мэндийн жил энэ тэр гээд, тэгээд энэтэй холбоотойгоор яах вэ огцом зардал, төсөв нэмэгдсэн нь бол үнэн. Тийм учраас энэ удаагийн хувьд бол энэ төсвийн тодотголыг хийхэд төсвийн хүрээний мэдэгдэл болон энд нэмэлт, өөрчлөлт оруулахаас өөр арга байхгүй ийм байдалтай бол Засгийн газар орсон.

Тийм учраас энийг ер нь бол үндсэн төсвийн хүрээ, төсөв батлах үетэй холбоотой бол хамаагүй гэж ойлгож байна. Төсвийн тодотгол хийхтэй холбоотой 3 сарын хугацаа гэдэг бол цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор гэж байгаа учраас, хэрэв энэ хуулийг хийхгүй ийм байвал эргээд нөгөө бидний боловсрол, эрүүл мэнддээ шийдсэн асуудлууд маань шийдэлгүй, оны сүүл рүү цалингүй болох, нэмэгдэлгүй болох гэж ойлгож байгаа учраас миний хувьд бол дэмжиж байна. Тийм учраас ийм саналыг хэлмээр байна.

Энхбаяр сайдаас энэхүү төсвийн хүрээнд энэ юутай холбоотойгоор өөрчлөлтийг хэрэв оруулахгүй бол яг ямар байдал бий болох вэ гэдэг дээр та тодорхой, багш, эмчийн цалинг би ойлгосон, түрүүн маш тодорхой хэлсэн. Өөр нөгөө талд нь манай олон гишүүдийн хөрөнгө оруулалтын асуудлууд хүлээгдэж байна. Өчигдөр Хөгжлийн төлөвлөгөөнд заагдсан маш олон саналуудыг оруулж ирж байсан. Тийм учраас эдгээртэй холбоотой ямар нэгэн өөрчлөлт гарах уу? Дээрээс нь бензин, шатахуун харьцангуй тогтвортой байна гэж ойлгосон. Нөгөө хөрөнгө оруулалтын зардлууд нэмэгдэх эрсдэл хэр байгаа вэ? Тэр тодотгол дээр орохоор байна уу, яахаар байна вэ гэдгийг тодотгоод асуучихъя?

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр Тэргүүн Шадар сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Инфляцын ачаалал өндөр байна, шатахуун нэмэгдсэн байгаа, 37 хувийн нэмэгдэлтэй байгаа. Одоо энэ нэмэгдэл дээрээ л тогтворжихыг хүлээж байна. Хэрэв Ойрх Дорнодын асуудал хүндэрч, байдал хурцдаад эхэлбэл энэ ахиад л асуудал үүсгэнэ. Бид хамгийн гол нь тасалдал үүсгэхгүй байх, тогтвортой нийлүүлэлтийг хангаж ажиллаж байна. Үүн дээр бид бас нөлөөлөх бололцоо хязгаарлагдмал байна. Тэгэхээр энэ үнийн нэмэгдэл маань бүх түвшинд инфляц болон бусад төсөв дээр дарамт учруулна гэдэг нь тодорхой болж байна. Иймд, шаардлагатай бол төсвийн тодотгол хийх хариу арга хэмжээг хурдан авахын тулд энэ 3 сар гэдэг хугацааг төсвийн тодотголтой холбож хүчингүй болгохыг хүсэж байна.

2027 оны урсгал зардлын хэрэгцээ 4 орчим их наяд шаардлага үүсэж байна. Зөвхөн багш, эмчийн цалин гэхэд 2 их наяд давж байгаа буюу энэ нэмэлт. Хэрэв үүгээр энэ асуудал дэмжигдэхгүй нөхцөлд бид нар нөгөө талдаа хөрөнгө оруулалтын орон зай маань 2.2 их наяд байгаа хөрөнгө оруулалт зогсоно гэсэн үг. 2027 онд шинэ хөрөнгө оруулалт хийх бололцоо маш хязгаарлагдмал. Одоо

үргэлжилж байгаа 3.6 их наядын төсөвт өртөгтэй ажлаас бид сонгож 2.2-ыг л явуулах бололцоо байна. Гэтэл энэ хууль дэмжлэг авахгүй унавал энэ 2.2 ч хэрэгжих бололцоогүй болно гэсэн үг. Зөвхөн бид хөрөнгө оруулалт бүрэн зогсоно Монгол Улсын хэмжээнд, тэгээд урсгал цалин, тэтгэвэр, НӨАТ-ын буцаалт гэсэн ийм нийгмийн шинж чанартай санхүү, зардлуудаа, урсгал зардлуудаа санхүүжүүлээд л байх ийм төлөв байгаа юм.

Иймд эдийн засгаа идэвхжүүлэх, ААН-үүдээ дэмжих үүднээс хөрөнгө оруулалтыг яагаад ч зогсоож болохгүй. Хөрөнгө оруулалт өөрөө ажлын байр, татвар хураамж гээд маш олон нөлөөлөл өндөр байгаа. Иймд энэ хуулийн төслийг оруулж ирсэн. Үнэхээр ахиад хэлье манай эдийн засгийн суурь чадавх одоо байгаа орлого зарлага 2 маань үндсэндээ ингээд тулж байна шүү. Тэгэхээр эдийн засгаа тэлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ийм бодлогын эрс өөрчлөлтүүдийг зайлшгүй хийх ийм шаардлагатай байна гэдгийг дахин давтаж хэлээд байгаа юм.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 14 цаг 20 минутаас хуралдааныг даргалав.

С.Бямбацогт: Жамбалын Ганбаатар гишүүн, Ганбаатар гишүүн болилоо. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуултаа асууя, алга байна. Банзрагчийн Түвшин гишүүн асуултаа асууя.

Б.Түвшин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ төсвийн хүрээтэй нэг холбоотой ганц нэгхэн асуулт асууя. Зүгээр ер нь энэ төсвийн хүрээг ингээд хараад байхаар орлогоо өсгөчихсөн, зардлаа өсгөчихсөн, алдагдлаа өсгөчихсөн, ЗГ-ын өр зээлээ өсгөчихсөн байж болох бүх чинээнд нь тултал бүх зүйлийг л ингээд тулгачихсан л харагдаад байгаа юм. Тэгээд энэ чинь өөрөө нөгөө том зургаараа ингээд харахаар 12-оос 25 оны хооронд төсвийн хүрээний мэдэгдэл 23 удаа өөрчлөгдсөн. Үүний 13-аас 14 нь орлогоо хэт өөдрөгөөр төсөөлснөөс болоод ингээд өөрчлөгдчихсөн байгаад байгаа юм. ЗГ-ын өр 12-оос 15 онд 110 хувиар өссөн. Өрийн дээд хязгаарыг 58.3 хувиар ингээд өсгөж байсан. Тэгээд энэ байдлууд чинь ямархуу үр дүнд хүргэх гээд байна вэ гэхээр өнөөдрийн яг бодит байгаа эдийн засаг дээр ингээд хий орлого өсгөөд, зардлаасаа одоо урсгал зардлуудаа гаргачхаад, хөрөнгө оруулалтаа танаад, байнгын тодотгол хийгээд яваад байхаар энэ томоохон төслүүд рүү мөнгөнүүд нь гарч явсаар байгаад бид жижиг бизнесүүд нь ингээд дуусчхаж байна. Тэгээд үүнээс болоод амьдрал ахуй хэцүүдэж байна. Өнөөдөр манай Монгол Улсад бараг байхгүй болчихсон байсан ломбардууд дахиад гараад ирсэн. Энэ эдийн засгийн л одоо үр дагавар.

2 дугаарт, зах зээл дээр энэ төрийн үр ашиггүй зардал нэмэгдээд байхаар бүтээмжгүй мөнгө зах зээл рүү орж ирнэ. Энэ бүтээмжгүй мөнгө чинь өөрөө инфляцыг өсгөөд, эргээд иргэдийн худалдан авах чадварыг бууруулаад ядууруулаад байдаг. Бид энэндээ нэг тийм нэрлэсэн том тоо л яриад яваад байдаг.

3 дугаарт, хувийн бизнес гэвэл бараг байхгүй болж байна. Зөвхөн төсөв дагаж амьдардаг болж байна, болж байна. Өнөөдөр ч гэсэн бид яг л ийм байдал руу яваад байгаа юм. Тэгээд ДНБ-д эзлэх хувь хэд байх вэ гээд энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс уг нь 27 хувиас илүү гаргамааргүй байна гээд хамгийн оновчтой гээд байдаг. Өнөөдөр бид 31, 32 луу хүргэж байна. Ерөөсөө энэ орлогыг бид тооцоолж байгаа биш, хамгийн дээд хэмжээнд яаж зардлыг гаргаж болох вэ гэж байгаа юм шиг л ингэж харагдаад байгаа байхгүй юу.

Өмнө нь хэлж байсан бас төсвийн хүрээний мэдэгдлийг нь олон улсад уг нь арай нарийвчлан тооцоолохын тулд 12-оос 15 үзүүлэлтээр тооцож гаргадаг. Ялангуяа салбарын зардлуудыг уул нь ДНБ-д эзлэх хувиар ингээд гаргачихдаг. Тэгээд энэ дүнгээр нь гаргаад явж байгаач гэсэн энийг аваагүй. Тэгээд энэ ерөөсөө төсвийн хүрээний мэдэгдэл үндсэндээ ерөөсөө ямар ч үр ашиггүй ийм цаас болж хувирч байна. 3 жилдээ ханаа авах нь байтугай жил болгондоо тодотгодог, жил болгондоо өсдөг болж байна гэж бол харж байна.

Тэгээд хоёрхон асуулт байна. 1 дүгээрт, тэнцвэржүүлсэн үнийг 127 доллароор авсан, бодитоороо бол зах зээл дээр үнэ 68 хавьцаа байгаа. Тэгэхээр энэ тэнцвэржүүлсэн орлогыг 127-гоор авчихлаар нүүрсний үнэ буурч байгаа үед энэ тэнцвэржүүлсэн үнээ тооцдог аргаа өөрчилбөл яасан юм бэ? Өсөж байгаа үед нөөц сан бүрддэг. Одоо буурч байгаа үед энэ чинь 127-гоор тооцоод байхад 68-аар бодитой үнэ орж ирж байгаа, цаашдаа ч бууж магадгүй. Энэ мөнгө яг бодитойгоороо байгаа юу? Дахиад төсвийн орлогын тодотгол хийх үү?

2 дугаарт, энэ төсвийн орлогыг хий бодитойгоор ингэж өсгөж байгаа хүмүүс дээр хариуцлага тооцдог тогтолцоо системийг яах вэ? Энэ чинь нэг ёсондоо уул нь хий өсгөж, хий зардлуудаа гаргаад, буцаагаад ингээд байнга тодотгол хийдэг чинь тодорхой хүмүүсийн хариуцлага гэж үзэж байгаа шүү дээ. Энэ 2 асуултад нэг хариулж өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсэг Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Сүүлийн 10 жилийн статистик үзээрэй. Энэ тооцоолсон төсвийн тэнцвэржүүлсэн орлого хий байна уу, үнэн байна уу, яг төлөвлөсөн хэмжээнд л яваа шүү. Дандаа би илүү давж биелж байгаа, хоосон орлого гаргаад л, хоосон зардал гаргаад байдаг юм шиг та ийм мэдээллийг нийгэмд буруу өгч болохгүй.

Энэ чинь бүхэл бүтэн мэргэжлийн баг хамт олон, институцүүд, судалгааны байгууллагууд энэ чинь бүтэн бараг жилийн хөдөлмөр зарцуулж, энэ тоонууд бүх Монгол Улсынхаа нийгэм, эдийн засаг, хувь хувьсгал, гадаад дотоод хөрөнгө оруулалттай нь, экспорт импортынхоо тэнцэлтэйгээ гаргаж байгаа тоонууд шүү дээ. Энд нэг хийгээр хий бичээд, хий унагаагаад байдаг зүйл байхгүй. Ингэж болохгүй юм.

Нөгөө талаар та энэ орлого зардал нэмээд байна гэж. Бид энэ төсвийн орлогыг та тоо харахад өсөж харагдаж байгаа боловч ДНБ эзлэх хувь хэмжээгээр тасралтгүй бууруулж байгаа юм. 2027 онд 30, 2028 онд 28, 2029 онд 28 аравны гэсэн ийм хувиудаар буух асуудал. Тэнцэл юун дээр та хараарай нийт зарлага одоо ДНБ 37 хувь дээр байгаа шүү дээ. Бид 31 болгоё, ирэх онуудад 30 болгоно, 28 болгоно гээд дандаа буулгах зорилтуудтай буюу эдийн засагт хувийн хэвшлийн орон зайг гаргах л ийм ажлууд хийж байгаа. Тэгэхээр бодлогын чиглэл хандлага энэ. Таны яг хэлсэнтэй зөв байгаа бид.

Нөгөө талаар л энэ үнэ, нүүрс энэ чинь өөрөө уул уурхайн бүтээгдэхүүн маань урт хугацаанд өнгөрсөн 20 жилийн дунджаар авдаг, цагтаа 300 доллар хүрсэн нүүрс заримдаа 20 доллар ч хүрч байсан, унаж байсан. Ингээд дундаж үнийг нь тооцоод үзэхээр чинь 127 гэдэг тоо гарч ирж байгаа нь тэр. Тэгэхээрээ 127-гоор бид орлого олно гэж тооцдоггүй, одоо байгаа зах зээлийн хандлага tendency ирэх 3 жилийнхээ

төлөв байдалтай нийцүүлээд тоогоо аваад л явж байгаа. Ер нь энэ 127 доллароос дээш олоод ирвэл энэ давсан орлого хуримтлалын санд очно гэсэн л асуудал байхгүй юу. Хуримтлалын санд мөнгө очихгүй байна л гэсэн үг. Яагаад гэвэл дундаж үнэ чинь 127, энэ дундаж үнээс илүү гарвал өсөлт үүслээ гэж бодож тэрийг хуримтлуул гэдэг хуультай. Гэтэл энэ 127 гарснаас хойш бид тэр үнийг даваагүй болохоор тэнд хуримтлал үүсэхгүй л гэсэн үг. Тэрнээс энэ төсөвт нөлөөлөөд, төсөвт 127-гоор тооцоод байгаа зүйл байхгүй. Тийм юм байдаггүй юм.

С.Бямбацогт: Түвшин гишүүн тодруулж асууя.

Б.Түвшин: Төсвийн хүрээний мэдэгдлийг 3 жилээр нь гаргаж байгаа, 2026 онд төсвийн хүрээний одоо орлогыг 32, 34, 37 гэж их наядаар тодорхойлсон. 2027 онд 34 байхаар байсан. Одоо орж ирж байгаа нь 36, 38, 40, ДНБ-ийхээ өсөлтийг өндөр тооцож байгаа, ДНБ-д эзлэх хувиа өсгөчхөж байгаа, тэгээд дараагийн 2 жилээ буулгаж байгаа юм шиг болохоос биш өнгөрсөн мөн үетэй харьцуулахад бүх тоонууд нь өсөж байгаа. Тухайлбал, 2026 онд одоо 32.9 их наяд ДНБ-д эзлэх нь 32.2, 2027 оных нь 34, 30 хувьтай байхыг одоо бид 36, 32 хувьтай гэж ингэж өсгөж орж ирж байгаа. Тийм учраас ДНБ-д эзэлж байгаа хувийг буулгаж байгаа гэж тооцож болохгүй. Дээрээс нь 127, 68 гэдэг 2-ын бодит орлого, тооцоолол орлого 2-ын чинь сан нь байгаа юм уу гэдэг асуултыг та нэг яг тодорхой хариулаадах.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон Энх-Амгалан. Эдийн засгийн хөгжлийн яамны газрын дарга.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам гишүүний асуултад хариулъя. Төсөв 2024 онд төсвийн нийт зарлага нийт эдийн засгийнхаа 37 хувьтай байсан. Тэгээд үе шаттай бууруулахаар бидний төлөвлөснөөр 2028 он гэхэд ДНБ-ий 28 хувьд хүрч буухаар ингэж төлөвлөж байсан. Гэхдээ өнгөрсөн жил төсөв батлагдах үед багш, эмч нарын цалинг нэлээд өндөр дүнгээр нэмснээс болоод 28 хувьд арай хүрэхээргүй болсон. Одоо 2029 онд 28 хувь буюу яг ДНБ-ий 1 хувьтай тэнцэх хэмжээний зөрөө л гараад байгаа бидний төлөвлөсөнтэй холбоотой. Тэрнээс биш 2024 оноос хойш тасралтгүй үе шаттай буурсаар байгаа гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Түвшин гишүүн тодруулж асууя.

Б.Түвшин: Худлаа хариу өгч байна шүү. Одоо энэ 2027 оны төсвийн хүрээ, 2026 оны төсвийн хүрээний тоог нь уншаад өгчихье. Тэнцвэржүүлсэн орлого 2026, 2027, 2028 онд 31, 33, 37 их наяд. ДНБ-д эзлэх хувь 31, 29, 28 хувь гэж байсан. Одоо 2027 оных нь болохоор тэнцвэржүүлсэн орлого 34, 37, 39 их наяд, одоо ДНБ-д эзлэх нь 30, 29, 28 өсөөд байгаа.

Дээрээс нь дараагийн нэг асуулт байгаад байгаа шүү дээ. Энэ 127 гэдэг тэнцвэржүүлсэн нүүрсний үнэ өнөөдрийн зах зээл дээр байгаа 68 доллар 2-ын зөрөө бодит сан яг бодитойгоороо байгаа юу? Дахиад төсвийн тодотгол хийхгүй юм байгаа биз дээ? Би яг энийг дахиад асууя гэж бодож байна.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон.

Л.Энх-Амгалан: 2026 оны төсвийн хүрээтэй харьцуулахад 2027 оны төсвийн хүрээн дээр оруулж ирж байгаа тоонууд нэмэгдсэн байгаа. Энд бодлогын 2, ерөнхийдөө нэмэгдсэн шалтгаанд 2 шалтгаан байгаа. Нэг нь 2027 оны төсвийн

нөхцөл байдал, Ойрх Дорнодын нөхцөл байдалтай уялдаад манай эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй бидний тооцож байснаас идэвх багатай байхаар шинжтэй байгаа. Тэгэхээр төсвийн хүрээн дээр тусдаг төсвийн бодлогын үндсэн хэрэгсэл төсвийн алдагдал. Тэгэхээр эдийн засгийн идэвхжил муу байгаа тохиолдолд бид төсвийн алдагдлаа нэмэгдүүлж буюу эдийн засгийн нийт эрэлтээ төсөв талаас нь дэмжиж өгдөг. Тэгэхээр 2027 оны тухайд өмнө нь тооцож байснаасаа ДНБ-ий 1 хувьтай тэнцэх хэмжээний алдагдлыг нэмэгдүүлсэн байгаа. Өмнө нь бид 0.8 хувьтай байсан бол энэ удаад 1.5 хувь болгож алдагдлыг 1.7 их наяд болгож нэмэгдүүлсэн. Энэтэй холбоотойгоор зардал нэмэгдэж байгаа. Үүний цаана эдийн засгийнхаа.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, 4 дүгээр микрофон.

Л.Энх-Амгалан: Эдийн засгийнхаа нийт эрэлтийг дэмжих ийм л бодлого байгаа. 2-т гэвэл орлого тал дээр өнгөрсөн жил энэ НӨАТ-ын буцаалтыг 5 хувь болгохтой холбоотой 1.8 их наядын орлогын буцаалт хийгдэнэ гэж тооцож байсан. Гэхдээ хөрөнгө оруулалтын ачаалал, урсгал зарлагын нэмэгдэх хэрэгцээг харгалзаад үүнийг бид дагах хууль дээр оруулж ирж буцааж 2 хувь болгож байгаа. Тэгэхээр буцааж орлого болон ДНБ-ий харьцаа энэ хуулийн зохицуулалттай холбоотойгоор нэмэгдэж байгаа.

Нүүрсний үнийн тухайд жишиг үнэ нь 127 ам.доллар, зах зээлийн үнэ бид 65-аас 70 ам.доллар байхаар тооцож байгаа. 127-гоос давсан хэсгээр Тогтворжуулалтын санд ордог. Төсвийн орлогыг тооцохдоо бид зах зээлийн үнээрээ л тооцож явдаг. Тэгэхээр нүүрс маань өөрөө нэг 20-оос 30 төрлийн чанарын ангилалд хуваагддаг. Тэрнээс хамгийн сайн чанартай нь 127-гоос давах ангиллын нүүрснүүд байгаа. Тэгэхээр тэр хэсгээрээ л Тогтворжуулалтын санд.../минут дуусав/

С.Бямбацогт: 2 удаа тодруулчихсан, Түвшин гишүүний асуултуудад нэмээд бичгээр хариулт өгчхөөрэй. Та бас одоо уулзаад дутуу асуултуудыг ийм юм байна гэдгийг тодруулаад хэлчих, бичгээр хариулт өгөөрэй Эдийн засаг, хөгжлийн яам. Пүрэвийн Батчимэг гишүүн асуултаа асууя, алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя, алга байна. Жанчивын Галбадрах гишүүн асуултаа асууя.

Ж.Галбадрах: Би ерөөсөө л энэ боловсролтойгоо холбоотой асуудлаа л шууд асуугаад эхэлье. Өнөөдөр Монгол Улсад хамгийн тулгамдаад байгаа асуудал ядуурал байгаа. Тэгээд ядуурлаас гарах ганц зөв зам бол ерөөсөө л боловсролын чанар гэж ярьж байгаа. Тэгээд бид энийгээ хэчнээн л өмнө нь яриад байсан, олон хүсэлтүүд Эдийн засаг, хөгжлийн яаманд ч явуулсан, Сангийн яаманд ч явуулсан, бүр тооцоолол хийгээд гаргаж ирээд, өнгөрсөн жилийн төсөв энэ тэрд тусгуулаад ингээд л явж байсан. Тэгээд энэ жилийн энэ хөгжлийн төлөвлөгөөнд тэр яриад байсан бодлого болгож яриад байсан зүйлүүдээсээ ухарсан байна.

Бид Солонгос, Сингапурын бэлээхэн туршлагыг яриад л байдаг. Ямар хэцүү үеүүдээ яаж боловсролдоо анхаарч байсан, Монгол Улс одоо нэг их тийм хэцүү үед бас биш байна гэж бодож байгаа. Бид боловсрол дээрээ одоо яг зөв юмаа л оруулах ёстой. Ингээд би яриад байдаг жишээ нь 108 сургууль, 95 цэцэрлэг гэдэг асуудлыг зөндөө л ярьж байгаа. Энэ юуны төлөө яриад байгаа юм гэвэл ерөөсөө л нэг ангид байдаг хүүхдийн тоо 40-өөс доош оруулъя. Улсын хэмжээнд 214 мянган хүүхэд байна, энийг арилгахын тулд 108 сургууль зайлшгүй хэрэгтэй. Нийслэлд 84 нь, хотод 24 нь, нийслэлийнхээ аль дүүрэгт нь, БЗД-т 19, 19 нь аль сургуулийн хажууд

юм гэдэг энэ нөхцөлүүдийг ингээд бүр гаргаж ирж яриад, газраа чөлөөлүүлээд ингээд явж байсан. Тэгээд өнөөдөр тэгээд энэ асуудал чинь эргээд бүр байхгүй, одоо шинэ сургууль 86, 108 байж байгаад баригдаад 86 болсон гэсэн. Тэгээд ахиад 53 сургууль барина гэж байгаа нь нөгөө шинэ сургууль ерөөсөө байхгүй. Ийм хөгжлийн төлөвлөгөө рүүгээ явчхаж байгаа юм л даа.

Тэгэхээр энэ нөгөө цаад үндсэн төсвийн хүрээ гэдэг дотроо энэ хөрөнгө оруулалт, шинэ хөрөнгө оруулалт тэр байтугай Азийн хөгжлийн банк /АХБ/-аас эдийн засгийн хүндрэлтэй үеийг давахын тулд оруулж ирэх 41 төсөл, арга хэмжээг үнийн өсөлтөөс хамаараад 33 болсон. 33-ынх нь тэр 8 нь одоо юу болдог ч юм уу үргэлжилсэн арга хэмжээнд оруулна гээд. Энэ чинь тэр ачааллыг бууруулж, тэр 200 хэдэн мянган хүүхдийн эрх ашиг, чанартай сургалт олж авах гэсэн эрх ашиг нь зөрчигдөөд байгаа энэ зүйлийг л бид арилгах гэж явж байгаа. Тэгэхээр энэ бол бодлого, энэ тэр хүүхдийнхээ эрх ашгийг бид ингээд л энэ хүүхдүүд байж байдаг юм гээд ингээд яваад байж болохгүй байна гэдэг зүйл.

Нөгөө талаас багшийн асуудал дээр багшийн дутагдлыг арилгана гээд зорилт тавьсан. Тэгсэн мөртөө энэ дээр одоо ерөөсөө ямар ч төсөв мөнгө төлөвлөгдөөгүй. Өчигдөр би яах вэ энэ төлөвлөгөөтэй холбоотой юм л даа. Зүгээр санал оруулаад 20 тэрбум төгрөг оруулъя, энүүгээр энэ цалин нэмж байгаа юм биш, энэ төсөл хөтөлбөр, багш нарыг татаж авах, тоон болон чанарын хомсдолыг нь арилгахын тулд гэж ингэж ороод тэгээд миний санал дэмжигдээгүй. Тэгэхээр бид багшаар нь хангаад, сургуулийнх нь тухтай орчныг нь хангаад, орчныг нь бүрдүүлж байж л өнөөдөр сургалтын чанараа ярина. Энд одоо бүх л юмыгаа зориулах ёстой, яаж хэлбэл энийг ойлгоод ингээд явах ёстой вэ? Би одоо мэргэжилтнүүдтэй, газрын дарга нартай нь уулзаад уул нь их уулзаж ойлгуулаад яриад, бодлого шийдвэр нь тусах болов уу гэхээр ингээд тусаж орж ирэхгүй юм. Тэгэхээр энэ хаанаасаа ингээд тайрагдчихдаг юм бэ гэдэг асуудал байгаа юм.

Нөгөө талаас энэ жилийн одоо бодлого дээр Боловсролын сайд маань алга байна. Одоо бид хиймэл оюун ухаан тал руугаа их явж байна. Гэтэл одоо сүүлийн үеийн яг олон улсад яригдаж байгаа, тренд болгож яригдаж байгаа юм бол энэ технологи боловсролд хэрэгтэй ч энэ IA, Screen-based learning энэ тэрийг хэт ашиглавал хүүхдийн тархины хөгжил, суралцах чадвар, сэтгэцийн эрүүл мэнд, уншиж ойлгох чадвар энэ тэрд маш сөрөг болж байна гээд хэд хэдэн улс бүр санаачлаад Швед улс дэлхийд бүр улсаараа татгалзаад явж байна. Франц улс бүр дижитал завсарлага гэж нэрлээд явж байна. Их Британи улс гар утасгүй сургуулийн орчин ч гэдэг юм уу нэг ийм тренд яваад байдаг. Энэтэй бид нарын барьж байгаа бодлого маань одоо хэр.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ төсвийн хүрээтэй холбоотой зүйл биш л байх шиг байх юм. Тэгээд Сангийн яам тэр боловсролын салбарын хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллүүд өгөөч. Манай салбарууд дотроос хамгийн их өндөр санхүүжилт, хөрөнгө оруулалт, гадаад зээл авч ашиглаж байгаа нь эрүүл мэнд, боловсрол 2 байгаа. Энэ салбарт ажиллаж байгаа эмч, ажилтан, багш нарын цалин хамгийн өндөр нэмэгдсэн байгаа буюу байгаа төсөв боломжоороо хамгийн их тэргүүлэх бодлого болгож хүний хөгжил гэж харсан эрүүл мэнд, боловсролд хамгийн их хөрөнгө оруулалт, хамгийн их цалин урамшуулал, хамгийн их гадаад зээлийн ашиглалтыг дайчилж байгаа. Тэр

сургууль тоо юмтай холбоотой Дэлгэржаргал тийм ээ, Дэлгэрсайхан билүү. Дэлгэржаргал Сангийн яам хариулаад өгөөч.

С.Бямбацогт: Сангийн яам 4 дүгээр микрофон, Дэлгэржаргал дарга хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Яг энэ жил боловсролын салбар дээр бүх эх үүсвэрүүдийн хүрээнд 159 сургуулийн барилга, бүтээн байгуулалт явж байгаа. Үүн дээр улсын төсөв, орон нутаг, гадаад зээл тусламж, нийслэлийн хөрөнгө оруулалт, мөн дээрээс нь татварын 1 хувийн хөнгөлөлтөөр ч гэсэн сургуулиуд бас баригдаж эхэлж байгаа. Энэ хүрээндээ яг 108 сургуулийн хэрэгцээ 3 жилийн хугацаанд бид яг шийдэх ийм хэрэгцээ 86 болсон. 95 цэцэрлэгийн хувьд 84 болж байгаа. Тэгээд эдгээрийн дийлэнх буюу 80-аас 90 хувь нь Улаанбаатар хотод хэрэгцээтэй ийм сургуулиуд байгаа. Ирэх оны төсвийн хувьд яг нийтдээ одоо яг явж байгаа бүтээн байгуулалтуудынхаа хүрээнд боловсролын салбар дээр 480-аад тэрбум төгрөгийн хөрөнгө, шилжих хөрөнгө оруулалт байгаа. Мөн дээрээс нь энэ жил яг боловсролын салбарт тоног төхөөрөмжийн хувьд өмнөх жилүүдэд байгаагүй өндөр буюу 92 тэрбум байгаа. Тэгээд түрүүний таны хэлсэн АХБ-ны тусгайлсан хэлэлцээр 3Г удахгүй хийгээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгая.

Ж.Дэлгэржаргал: АХБ-ны энэ төсөл дээр мөн яг энэ 84, 86 сургуулиас энэ 84 цэцэрлэгээсээ эрэмбийн хувьд оруулж хэлэлцээр явна. Тэгэхээр ирэх жилийн хувьд яг мэдээж төсөв дээр явж байгаа энэ хөрөнгө оруулалтууд яг одоо 05-р сарын 31-нээр хэр гэрээ байгуулагдаад үргэлжлэх вэ, шилжих хөрөнгө оруулалтын явц байдалтай уялдуулаад шилжих хөрөнгө оруулалтын дүнд бас хөдөлгөөн орох уу. Шинэ хөрөнгө оруулалтын хэрэгцээ яг энэ 86 дотроосоо хуулийн шаардлага хангаад яг бас бүтээн байгуулалтууд явах уу гэдэг асуудал мэдээж төсвийн төслийн үеэр тодорхой болно. Одоогоор төсвийн хөрөнгө оруулалтын хувьд бид цахим системээр 03-р сарын 01-нээс ингээд иргэдээсээ санал аваад эхэлдэг. Аймгуудын төлөвлөлт эхлээд явж байна, 06-р сарын 25 гэхэд яамнууд дээрээ очоод яг эцсийн байдлаар 07-р сарын 25-нд санал ирнэ. Тэгэхээр ер нь сүүлийн 5 жилийн хугацаанд яг 5 салбар дээр хамгийн их хөрөнгө оруулалт буюу 80 хувь нь хийгдэж байгаа. Үүний нэг нь боловсролын салбар байгаа.

С.Бямбацогт: Тодруулъя, дижитал шилжилтийн талаар хариулж өгнө үү гэж байна. Эдийн засгийн хөгжлийн яам хариулах уу? Яг ажлын хэсэгт Цахим хөгжлийн яамныхан, Боловсролын яамныхан байхгүй болохоор, гүйцээгээд асуучихъя Галбадрах гишүүн.

Ж.Галбадрах: Тийм, бичгээр хариу авъя. Би яг энэ асуудал яригдаад байгаа Энх-Амгалан сайдтай бид санал солилцоод, энэ тал дээрээ ярья, тооцоо гаргая гээд байгаа юм. Нөгөө талаас би Энхбаяр сайд ингээд Байнгын хороон дээр асуусан чинь хариулаад байгаа л даа. Хамгийн их хөрөнгө оруулалт орж байгаа, хамгийн их зарлага нь боловсролын салбарт гарч байгаа гээд байгаа. Тэгээд энэ хүндээ ороод, тэгээд оруулаад тэнд нь өөрчлөлт гарахгүй, хүн нь хөгжихгүй, сургууль нь ингээд хүрэлцээгүй, хүүхдийнх нь эрх ашиг нь ингээд зөрчигдөөд яваад байгаа учраас л энэ чинь яригдаад байна шүү дээ. Тэгэхээр энэ нэг номертоо, түүнээс одоо зам, тээврийн салбартай харьцуулаад боловсролыг харьцуулахаар их байна гэдэг ч юм

уу, ноднин зам, тээвэр нь илүү байлаа энэ тэр гээд л байж байна шүү дээ. Тэгэхээр хамгийн гол нь эрэмбэлээд хүүхдийн маань тэр эрх ашиг, ирээдүй болсон энэ Монгол хүмүүсийнхээ бид энэ боловсролд л анхаарахгүй бол энэ улс хөгжихгүй. Тэгэхээр яг энэ чиглэл дээр нь таныг бас энэ бодол дээрээ яагаад одоо юу гэдэг юм, хамгийн их хөрөнгө оруулалт зарлага.../минут дуусав/

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Э.Энхбаяр: Хамгийн их хөрөнгө оруулалт, хамгийн их зээл, хамгийн их урсгал зардал гээд байгаа нь энэ салбартаа хамгийн их анхаараад байгаагийн л илрэл шүү дээ. Одоо байгаа бололцоогоороо л хамгийн сайн анхаараад байгаа нь л энэ. Мэдээж улам сайжруулах, улам л хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгцээ байна.

Нөгөө талаар эдийн засгийн маань бодит чадавх маань одоо үндсэндээ ингээд олон зүйл дээр тулаад байна шүү дээ. Тэгэхээр бид эдийн засагтаа цоо шинэ эдийн засаг, шинэ хөрөнгө оруулалт, шинэ зах зээл, тэр шинэ орчныг бүрдүүлж л эдийн засгаа тэлэхгүй бол одоо бидний энэ урсгал зардал хүсэлтүүд их хязгаарлагдаж байна. Энх-Амгалан сайд ороод ирлээ, Энх-Амгалан сайд Галбадрах гишүүний асуусан дижитал шилжилт салбарын асуудалтай холбоотой юм гараад байна.

С.Бямбацогт: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Манай боловсролын салбарт хийгдэж байгаа гэрт ойрхон сургууль хамгийн сайн сургууль гэдэг 6 том шинэчлэлийн цахим шилжилтийг тодруулж байх шиг байна. Тэгэхээр бид энэ цахим шилжилтийг их сайн хийж чадвал энэ хот, хөдөөгийн сургууль, төрийн сургууль, хувийн сургуулийн ялгаа арилгах хамгийн гол механизм энэ цахим шилжилт гэж гарч байгаа. Тэгэхээр өчигдөр бас Монгол Улсын ЗГ-аас шийдвэр гарч хүүхэд бүрийг компьютержуулах, тэгэхдээ санхүүгийн түрээс төсвөөс биш, санхүүгийн түрээсийн эх үүсвэрээр одоо 300 мянган google chrome book-н үйлдвэрийг Монголд барих. Ингээд нэг багш нэг IA agent, нэг сурагч нэг IA туслах багш гэсэн энэ үндэсний платформыг бид энэ 09-р сарын 01 гэхэд Монгол хэл, математикийн хичээлээр эхлэх гэж байна. Энэ бол Монгол хүүхдийн нөгөө уншаад ойлгохгүй байгаа, хоёр хүүхдийн нэг нь уншаад ойлгохгүй байгаа энэ PISA-гийн үнэлгээгээр гарсан асуудал дээр тодорхой дэвшил болох одоо ийм цахим шилжилтийг хийж эхэлж байна.

С.Бямбацогт: Галбадрах гишүүн тодруулъя дахиж.

Ж.Галбадрах: Энх-Амгалан сайд орж ирсэн учраас би бас түрүүнийхээ асуулт дээр, энэ дэлхийн улсуудын боловсролд энэ дижитал шилжилт, энэ хиймэл оюунтай холбогдуулж ингэж гаргаж ирж байгаа хамгийн сүүлийн Америкийн Конгрессоос эхлээд энэ Швед манлайлаад, Франц улсад яваад байгаа юмнууд бүгдээрээ энэ хиймэл оюуныг ашиглахаар унших чадвар, ойлгох чадвар маш их алдагдаж байна. Анхаарал төвлөрөл буурч байна. Энэтэй холбогдуулаад бид 50 хувиа бүр багасгая, 50 хувийн компьютероо багасгая. Мадрид, Испани бүр 0-оос 12 ангийн насны хүүхдүүдийн 500 мянган хувьдаа хэрэглэдэг байсан iPad энэ тэрийг нь одоо бүр хурааж авна гэдэг шиг хориглоно. Ерөөсөө хэрэглэхийг нь сургуулийн орчинд хэрэглэхийг хориглоно. Франц улс дижитал завсарлага авъя гэдэг юм уу нэг ийм трендүүд ингээд яваад байна, энэ судалгаанууд, энэ шинжлэх ухааны үндэстэй

л энэ хүмүүс энэ нөлөөлж байгаа гэдгийг ингэж гаргаж ирж ярьж байгаа.../минут дуусав/

С.Бямбацогт: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Галбадрах гишүүн их чухал асуудал хөндөж байна. Бид энэ 06-р сард биш, 07-р сард ЮНЕСКО-гоос энэ боловсролын цахим шилжилтийн асуудлаар дэлхийн бүх улс орнуудын боловсролын сайд нарыг хамарсан ийм том хэлэлцүүлэг хийх гэж байгаа юм байна лээ Галбадрах гишүүнээ. Тэгээд бид сая 09-р сарын 01-нээс бол энэ сургуулийн орчинд гар утас, ингээд фэйсбүүкээр гэрийн даалгавар өгдөг энэ асуудлуудыг хориглож байгаа шүү дээ. Ингээд 09-р сарын 01-нээс бол ингээд мөрдөгдөөд явна. Гэхдээ ер нь хүүхдүүдийн энэ дэлгэцийн донтолт бол дан ганц сургуулийн орчинд, боловсролд цахим хэрэглээ байгаагаас болж ачаалал үүсэж байгаа, энэ донтолт үүсэж байгаа гэдэг энэ бас гэнэн төсөөлөл, гэнэн одоо дүгнэлт. Ингээд ямар ч байсан өөр дэлгэцийн хамааралтай болж байгаа бол өөр цахим хэрэглээнээс болж байгаа гэсэн нэг ийм судалгаа сая Монгол Улсад бас хийгдсэн. Энэ судалгааны юуг танд хүргүүлье гэж бас бодож байна.

С.Бямбацогт: Галбадрах гишүүн 2 удаа тодруулсан та. Галбадрах гишүүн Монгол Улсын бидний хойч ирээдүй болсон хүүхэд багачуудын боловсролд анхаарч ирсэн, гишүүн болохоосоо өмнө Шинэ Монгол сургууль байгуулж Дэлхийн боловсролыг Монгол хүүхдүүд эзэмших тал дээр маш том алхам хийсэн хүн. Энх-Амгалан сайд Боловсролын сайдаар 2 дахь удаагаа томилогдоод ажиллаж байна. Бас маш том асуудлыг шийдэж байгаа. Энэ асуудлууд дээр та 2 маань нэлээн ойр хамтарч ажиллаарай. Боломжууд одоо бас байгаа. Тэгээд та бүгдийн мэдлэг, туршлага, чадвар Монгол Улсын ирээдүй хойч хүүхэд багачуудад хэрэгтэй шүү.

Өнөөдөр Галбадрах гишүүн маань боловсролыг дэмжих сонирхлын бүлэг байгуулсан байна лээ 26 гишүүнтэй. Энэ 26 гишүүнтэй лобби бүлгийн зорилго боловсролын салбарын бодлого, хууль тогтоомж, төсөв хөрөнгө оруулалтын асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийх, Боловсролын багц хууль, бодлогын хэрэгжилтэд парламентын хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх, шинжлэх ухааны нотолгоо, өгөгдөл судалгаанд суурилсан санал шийдлийг боловсруулах, суралцагч, багш, эцэг эх, боловсролын байгууллагын эрх ашиг хэрэгцээг бодлогод, төрийн бодлогод тусгахад дэмжлэг үзүүлэх, боловсролын чанар, хүртээмж, менежмент, хүний нөөц, хөгжлийн асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах гэсэн ийм зорилготой. Энэ сонирхлын бүлгийг Энх-Амгалан сайд дэмжиж сайхан хамтарч ажиллаарай гэдгийг танд хэлье.

Энэ сонирхлын бүлгийн ахлагчаар Галбадрах гишүүн, дэд ахлагчаар Батсүмбэрэл гишүүн, гишүүдээр 26 гишүүнийг Батсүмбэрэл, Жавхлан, Зулпхар, Уянгахишиг, Сэддорж, Бадамсүрэн, Хэрлэн, Мөнхбаатар, Анар, Хосбаяр, Мөнхбаясгалан, Ундрэм, Гантөмөр, Номинчимэг, Отгонбаяр, Үүрийнтуяа, Ундраа, Лүндэг, Бум-Очир, Батнайрамдал, Баярмаа, Ганзориг, Замира, Лувсанжамц гэсэн гишүүд ажиллах юм байна. Тэгээд Боловсролын яамтайгаа сайхан ойрхон холбогдож, энэ хүүхэд багачуудынхаа төлөө илүү бодитой ажлууд хийгээрэй гэж хэлье. Санаачилга гаргаж байгаад нь баяр хүргэе танд.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалтыг 16:00 цагаас явуулна. Шууд шилжүүлчих юм уу, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй

хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

14.49 цаг

Зургаа.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Нанзадын Наранбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Н.Наранбаатар: УИХ-ын дарга, гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 05-р сарын 01-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42-р зүйлийн 42.5 дахь хэсгийг баримтлан Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулсан Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05-р сарын 26-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа явууллаа.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед УИХ-ын гишүүн Ганбаатар Монгол УИХ-аас 2025 оны 11-р сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болгож буй үндэслэл, мөн буцаан олголтыг татварын системийг эвдэхгүйгээр нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтээр нь шийдвэрлэх боломжтой эсэх, мөн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн босгыг 400 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн нь оновчтой эсэх, УИХ-ын гишүүн Батжаргал Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, сайжруулах боломжийн талаар, УИХ-ын гишүүн Ганхуяг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн босгыг нэмэгдүүлэх нь далд эдийн засгийг нэмэгдүүлэх эрсдэлтэй тул татварын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх нь зүйтэй талаар, УИХ-ын гишүүн Мөнхсоёл Нэмэгдсэн өртгийн албан татварын 5 хувийн буцаалтын хууль хэрэгжсэнээр татварын бааз суурь нэмэгдэх, далд эдийн засаг буурах, худалдааг дэмжихэд нөлөөлөх эсэх, мөн татварын буцаан олголтын хувь хэмжээг нэмэгдүүлэхэд татвар суутган төлөгчийн тоо болон төсвийн орлого хэрхэн өөрчлөгдөх талаар, УИХ-ын гишүүн Булгантуяа нийт өрхийн 30 гаруй хувь нь тэтгэвэр, тэтгэмж авагчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажил эрхэлдэггүй болон халамжаар амьдардаг иргэд байгааг дурдаж, эдийн засгийн хүндрэлтэй үед иргэдийн орлогыг дэмжих зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан

олголтыг нэмэгдүүлэх тооцоолол хийсэн эсэх, Монгол УИХ-аас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болгох нь оновчтой эсэх, мөн өрхийн гишүүдийн тооноос хамааран татварын бодлогоор дэмжих боломжийн талаар, УИХ-ын гишүүн Г.Ганбаатар Монгол УИХ-аас 2025 оны 11-р сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу олгох нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын дүн болон төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах, төсвийн бүтцийн өөрчлөлтийг хийх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед УИХ-ын гишүүдээс санал гараагүй тул УИХ-ын гишүүн Заяабал хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн 51.3 хувь буюу олонх дэмжсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Байнгын хорооны дарга Наранбаатар, Заяабал.

С.Бямбацогт: Төсвийн байнгын хорооныхон биз дээ, хамтарсан юм уу. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүний бүрэлдэхүүн хэвээрээ байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд дуудаарай, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга бас алга байна, бусад хүмүүс байх шиг байна. Ажлын хэсэг Их Хуралд хүндэтгэлтэй хандах үүрэгтэй, үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх үүрэгтэй гэдгийг бас дахин сануулъя.

УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя, алга байна. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуултаа асууя, алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя, болилоо. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя, алга байна. Жамбалын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Ганбаатар: Баярлалаа, би Байнгын хороон дээр саналаа хэлсэн, тэгээд тодорхой хариултуудыг аваагүй учраас одоо чуулган дээр дахиж асууя. Энэ саяхан Занданшатар Ерөнхий сайдын үед баталсан хууль хүчингүй болж байгаа нэгдүгээр асуудал. Энэ үнэхээр тогтворгүй байгааг харуулж байгаа юм. Татварын бодлого дөнгөж сая болно гэхчээд, одоо болохгүй гэж байгаа нь том асуудал байна гэдгийг хэлье.

2-рт, Ерөнхий сайдын зүгээс, Учрал Ерөнхий сайдын зүгээс энэ НӨАТ-ын татвар төлж байгаа босгыг 50 саяас 400 сая болгож байгаа санал гаргаж байгаа юм. Би энийг дэмжиж байгаа шүү. Зарим нэг хүмүүс, их олон жил Сангийн сайд байсан

хүмүүс юу гэж хэлж байгаа вэ гэхээр үгүй ээ энэ татварынхаа бүр суурь тогтолцоог эвдчихнэ энэ тэр гээд, тэгээд падаан бичиж өгөхгүй бол ААН-үүд жижиг ААН-үүдийг дээрэлхэнэ, авахгүй ч гэнэ үү нэг тийм юм ярьсан. Тэгэхээр энийг би татварын, Сангийн яамнаас асууя. Эртээр надад хариулсан, хэн хариуллаа, нэг нь хариулсан. Одоо нөгөө татвар хариуцсан дарга байна шүү дээ, Чимидсүрэн байна. Чимидсүрэн тэгвэл хариулах байх.

Тэгэхээр би татварын тогтолцоогоо эвдэхгүйгээр Учрал Ерөнхий сайдын гаргаж ирсэн бодлогыг дэмжих бүрэн боломжтой гэж би харж байгаа юм. Яаж вэ гэхээр энэ татварын янз янзын бичилтүүдээр бүх ААН-үүд татварын падаан өгөх бололцоотой. Энийг хийх бололцоо нь Сангийн яаманд, Татварын ерөнхий газарт байгаа. Бүр болохгүй бол бүгдээрээ татвараа төлөөд буцааж өгөх ёстой хөнгөлөх ёстой, хөнгөлөх хүмүүсээ төлчихсөнийх нь дараа нь буцаах хэрэгтэй. Энэ бол би хамгийн сүүлийн вариантыг нь хэлж байна шүү, энийг ерөөсөө хийдэггүй. Тэгэхээр би Монгол Улсын Ерөнхий сайд Учралын тэр, энэ чинь Жижиг дундын хууль шүү дээ миний батлуулсан хууль. Энэ хуулийн тэр 50 саяын босгыг 400 сая болгож байгаа юм байна лээ, 100 хувь дэмжиж байгаагаа илэрхийлье.

Тэгээд зүгээр засгийнханд хандаж хэлэхэд энэ бололцоо байгаа. Сангийн яам, Татварын ерөнхий газар энэ бололцоогоо хангаад, энэ зээлд нь дарлуулчихсан байгаа, зээлийн хүүд боомилуулчихсан байгаа энэ ААН, иргэдээ, иргэдийнхээ төлөө гаргаж байгаа санаачилгаа ингээд хийгээрэй, дэмжиж ажиллана гэдгийг хэлье. Тэгээд 2 асуултдаа хариулт авъя. Баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон. Тэр НӨАТ-ын систем эвдэх үү, эвдэхгүй юу, боломжтой юу, боломжгүй юу, давуу тал нь юу юм.

Ч.Чимидсүрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Сангийн яам, Татварын бодлогын газар Чимидсүрэн. Тэгэхээр ЗГ-аас УИХ-д өргөн барьсан татварын хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр НӨАТ-тай холбоотой ерөөсөө хоёрхон заалт л байгаа. Нэг нь бол босгын 50 саяыг 400 сая болгоё гэсэн нэг заалт байгаа. Нөгөөх нь бол НӨАТ-ын өрийг төлөх хугацааг хоёр сараар хойшлуулах ийм зохицуулалтын асуудал байгаа. Гэхдээ НӨАТ-ын босго дээр бол хэдийгээр албан ёсны буюу зайлшгүй НӨАТ-ын суутган төлөгчөөр болох нь 50 сая боловч сайн дураараа НӨАТ төлөгч болох босго маань 10 сая хэвээрээ байгаа. Тэгэхээр яах вэ 50 саяас 400 сая болгоход 23429 татвар төлөгч албан ёсны НӨАТ суутган төлөгчөөс хасагдах боловч сайн дураараа суутган төлөгч байх эрх нь нээлттэй.

Ер нь НӨАТ-ын систем дээр бол иж бүрнээр нь харах шаардлагатай юу гэвэл шаардлагатай энэ хууль дээр. Гэхдээ энийгээ бид дараа дараагийнхаа татварын хуулийн шинэчлэл, багц өөрчлөлт дээрээ тусгах талаар анхаарах ёстой. Тэгэхээр энэ одоогийн 400 болгож байгаа босго бол өмнө бид 10 сая байж байгаад тэгээд 50 саятай болсон. Одоо бид энэ 400 болгож байгаа асуудал ер нь НӨАТ-ын босгын хэмжээ хэд байвал оновчтой вэ гэдэг дээрээ л тооцоолол хийгээд, 50 саяыг 400 байх нь одоогийн цаг үедээ оновчтой юм байна гэдэг энэ тооцооллыг Олон улсын валютын сан /ОУВС/-гаас гаргасан аргачлал, зөвлөмжийн дагуу гаргаж тооцож гаргасан ийм босго байгаа.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Ж.Ганбаатар: Санал нэг байгаад баярлалаа, санал нэг байгаа юм байна. Байнгын хороон дээр хариулсан тэр яамны залуу болохоор яг дэмжээд ч байгаа юм уу, үгүй ч юм уу тэр хуучин сайдаа хамгаалаад ч байгаа юм шиг нэг тиймэрхүү нэг бүдэг бадаг юм ярьсан юм. Тэгэхээр нь би таны хариултаас ойлголоо, засгийн бодлогыг ойлгож байна. Тэгэхээр энэ 400 сая гэдэг чинь жилийн борлуулалт шүү дээ. 400 сая төгрөгийн жилийн борлуулалт гэдэг их мөнгө биш шүү. 400 сая төгрөгийн жилийн борлуулалттай ААН гэдэг үнэхээр татвараа яах вэ гэдэг тийм л ААН-үүд. Бүх цалин, бүх зүйлээ төлөөд тэрний ар талд тэр зээлийнхээ хүүг төлөөд, тэрний ар талд одоо яах вэ гэсэн тэр хүмүүст ЗГ боломж олгож байгаад нь баярлалаа. Тэгэхдээ тэрийг НӨАТ-ын падаан бичихгүйгээр шийдвэрлэнэ гэвэл нөгөө талдаа энэ Ардчилсан намын дарга.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд асуучих уу? Болно.

С.Бямбацогт: Өнөөдөр Их Хурлын дарга ч сайхан ааштай, баярлалаа. Энэ Цогтгэрэл дарга хэлж байна лээ, энэ одоо бүгдээрээ НӨАТ-ын падаан бичиж өгөхгүй бол том асуудал болно гэж. Яг тэгнэ шүү, бүгдээрээ НӨАТ-ын падаан бичиж өгөхгүй бол энэ үнэхээр татварынхаа бодлогыг эвдэх асуудал үүсэх магадлалтай. Тийм учраас Сангийн яам, Татварын ерөнхий газар анхаараарай. Эдийн засгийн хөгжлийн яаманд би нөгөө очиж тайлбарласан, би Энхбаяр сайд хаана байна, дууд гэж хэлээгүй шүү, сайд чинь өнөөдөр надад тэгж байна лээ. Би зүгээр очоод л өөрөө тайлбарласан, ингэж, ингэж ч хийнэ шүү, одоо дэд сайд өөрөө сонсож байсан байх. Ингэж, ингэж юу Татварын ерөнхий газрыгаа шахъя бүгдээрээ, ингэж, ингэж ажиллавал наадах чинь эвдэхгүйгээр шийдэх бололцоо байна. Баярлалаа, санал хэллээ.

С.Бямбацогт: Ер нь тодорхой мэдээлэл өгчих нь зөв байх. Энэ иргэдийн бүх иргэдийн амьдралтай, ААН-ийн бизнестэй холбоотой асуудал учраас. Нэмэгдсэн өртгийн албан татвар бол мөшгөлтийн татвар, бүртгэлийн татвар. Энэ системээ эвдээд саяын одоо Ганбаатар гишүүний хэлж байгаа асуудал эрсдэл үүсчих вий. Энэ дээр бас нэг тодорхой мэдээлэл өгчихье, хариулчихъя, 4 дүгээр микрофон, яаж хэрэгжүүлэх вэ?

Ч.Чимидсүрэн: 400 саяас дооших түрүүн хэлсэн 23 мянган ААН-тэй холбоотой төсвийн нөлөөлөл талаас нь аваад үзвэл 160 тэрбумын бол төсвийн орлого буурах нөлөөтэй байгаа юм. Тэгэхээр бидний нийт төсвийн орлогын дийлэнх нь өөрөөр хэлбэл нөгөө том сегментэд хамаарагдах мянган ААН-д хамаарах орлогоос бүрддэг учраас харин 400 саяас дооших борлуулалтын орлоготой ААН-д бол зайлшгүй суутган төлөгч байхгүй, болохгүйгээр хоорондоо бол тооцоогоо хийгээд явах боломжтой. Өмнөх тогтсон НӨАТ суутган төлөгчөөрөө бүртгэгдээд явж байсан соёлоо, татварын харилцаагаа үргэлжлүүлээд явъя гэвэл 10 саяын босго нь бол хөдлөөгүй байгаа учраас тэр нь бас бүрэн боломжтой байгаа.

С.Бямбацогт: Уян хатан, бүртгэлийн систем эвдрэхгүй гэж ойлголоо, тийм ээ? Хүсвэл 10 саяас дээш 400 сая хүртлээ НӨАТ төлөгчөөр бүртгүүлж болно, систем эвдрэхгүй гэж ойлголоо шүү. Хассуурийн Ганхуяг гишүүн, алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя, алга байна. Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя, алга байна. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя, алга байна. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя, алга байна.

Энэ нэлээн чухал хууль, иргэдийн дунд нэлээн хүлээлт үүссэн асуудал. Тэгээд нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өнгөрсөн 2025 оны 11 сарын 14-ний өдөр Монгол УИХ баталсан. Уг хуулиараа нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын буцаан олголтыг одоо 20 хувийг шаталсан хэлбэрээр нэмэгдүүлж 100 хувь хүртэл буцааж олгох зохицуулалтыг бид хийгээд, 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс үйлчлүүлэхээр байсан. Одоо ингээд хүчингүй болж байна, болох гэж байгаа. Энэ ч бас цаг нөхцөл байдалтайгаа холбоотой. Энэ өнгөрсөн оны 10 сард энэ хуулийг УИХ хэлэлцэж баталж байх үед бол эдийн засаг, нийгмийн нөхцөл, дэлхийн геополитик, улс төрийн нөхцөл байдал бүгд бол өөр байсан.

Он гарснаас хойш, 2 сараас хойш үндсэндээ Ойрх Дорнодод үүссэн геополитикийн нөхцөл байдал, Ормузын хоолойтой холбоотой шалтгаалан бараа бүтээгдэхүүний үнэ, бензин шатахууны үнэ маш их огцом нэмэгдсэн. Энэ үнийн өсөлт иргэдийн халаасыг хоосолж, бизнес эрхлэгчдэд сөргөөр нөлөөлж эхэлсэн. Тийм учраас 2026 онд үндсэндээ энэ 4 дүгээр сарын инфляц 5 сарын 26-ны өдрийн байдлаар 11.1 хувьд хүрээд байна. Энэ дотроо хүнсний бүтээгдэхүүний инфляц үүнийх нь 70 хувийг эзэлж байгаа. Тийм болохоор бид бүхэн үнэхээр энэ инфляцдаа онцгой анхаарах ёстой. Инфляцад хамгийн их өртөж байгаа иргэд бол бага орлоготой иргэд маань байгаад байгаа юм бага орлоготой иргэд. Эдгээрээ хамгаалсан бодлого бидэнд хэрэгтэй байгаа.

Өчигдөр Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим дээр очоод бизнес эрхлэгчтэй, татвар төлөгч нартай, баялаг бүтээгч нартай, ажлын байр бий болгож байгаа ААН-үүдийн удирдлагуудтай уулзаж байхад бол нөхцөл байдлыг үнэхээр хүнд байна гэдгийг ярьж байна лээ. Нүдээрээ би бас харлаа, чихээрээ сонслоо. Бизнесийн орчны судалгаа тийм сайн биш. Бизнес эрхлэх итгэл үнэмшил буурсан, ашигт ажиллагаа саарсан ийм үзүүлэлттэй байгаад байгаа. Тийм болохоор тодорхой бодлогын арга хэмжээг авах бидэнд шаардлагатай байна. Олон улсад Казахстан, Узбекистан зэрэг бүс нутгийн орнууд шиг бизнесийн жишиг орчныг бий болгох, татвар, НДШ-ийн дарамтыг багасгаж, зээлийн хүүг бууруулах тал дээр онцгой анхаарахгүй бол цаашид нөхцөл байдал улам хүндрэхээр байна гэдгийг баялаг бүтээгчид маань хэлж байна.

Тэгээд нэмэгдсэн өртгийн албан татвар бол хэрэглээний татвар. Хэрэглээ өндөртэй, ахиу орлоготой хэсэг нь энэ татварын буцаан олголтоос илүү ихийг хүртдэг. Хэдийгээр бид одоо хэрэгжиж байгаа хүчингүй болгох гэж байгаа хууль шаталсан байдлаар шийдсэн ч, бодит судалгаагаар өндөр орлоготой, их хэрэглэдэг иргэд нь бага орлоготой иргэдээсээ бараг 4 дахин илүү хөнгөлөлт эдлэхээр болж байгаа юм. Гэтэл бидний бодлого бол бага орлоготой иргэдээ дэмжсэн бодлого явуулах зайлшгүй шаардлага үүсэж байгаа юм. Тийм учраас энэ хуулийг хүчингүй болгоод, харин энэ хуулийг хүчингүй болгосноос бий болж байгаа, эх үүсвэр болж байгаа 1.6 их наяд төгрөгөө бид хэрэглээг урамшуулахад биш, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бага орлоготой иргэдээ дэмжих энэ талд зориулах ёстой.

Энэ үүднээсээ үндсэндээ үнийн өсөлтөд хамгийн их нэрвэгдэж байгаа эмзэг бүлгийн болон бага орлоготой иргэдээ, ахмадуудынхаа тэтгэвэр халамжийг зорилтот хэлбэрээр нэмэгдүүлэх энэ бодлогыг ЗГ онцгой анхааралдаа авч оруулж ирмээр байна. Ажил хөдөлмөр эрхэлж улсын ачааг үүрч яваа дундаж давхаргынхныг татварын дарамтаас чөлөөлөх, хамгаалах энэ бодлогыг оруулж ирмээр байна. Эдийн засгийн хөдөлгүүр болсон ААН-үүд, баялаг бүтээгчдээ

бодитоор дэмжих энэ тал дээр илүү анхаармаар байна. Тийм болохоор энэ рүү чиглэсэн татварын өөрчлөлтүүдийг Их Хуралд өргөн барьсан байгаа. Энэ рүү чиглүүлж бодлогоо батлах тал дээр Их Хурал анхаарах ёстой байх.

Одоо нэмэгдсэн өртгийн албан татварын энэ саяын буцаалтаар их хэрэглэдэг хүмүүст урамшуулал өгөхийн оронд өглөөнөөс үдэш хүртэл хөдөлмөрлөж байгаа 1.4 сая иргэндээ шууд татварын хөнгөлөлт үзүүлбэл энэ бодитой дэмжлэг болно. Өрхийн орлого нэмэгдэнэ, бага орлоготой эмзэг бүлгийнхэнд маань илүү том дэм болно. Энэ үүднээсээ энэ тал дээр манай ЗГ ч бодлогодоо анхаармаар байна. Татварын хуулиудыг хэлэлцэхдээ ч Их Хурал бас ажлын хэсэг энэ талдаа анхаарч, асуудлыг шийдэх ёстой шүү гэдгээ энд сануулж хэлье. Ингээд УИХ-ын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалтыг 16:00 цагаас явуулна.

15.08 цаг

Долоо. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 14 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Энхтүвшин: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын гишүүн Пунсалмаа нарын 13 гишүүнээс 2026 оны 05-р сарын 07-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээний тухай Монгол УИХ-ын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг УИХ-ын чуулганы 2026 оны 05-р сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 05-р сарын 26-ны өдрийн хуралдаанаар дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39-р зүйлд заасны дагуу явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед УИХ-ын гишүүн Наранбаатар тогтоолын төсөлд тусгагдсан зарим асуудлыг төслийн үзэл баримтлалд нийцүүлэн өөрчлөх, хасах, мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөвт өртөг нь хүрэлцэхгүй болсон шалтгаанаар зогссон төслүүдийн талаар судалж, 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулах, Төсвийн тухай хуулийн 29^{1.4}-т заасан цахим систем дэх мэдээллийг УИХ-ын гишүүд нээлттэйгээр харах боломжийг бүрдүүлэх зэрэг зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн тогтоолын төсөлтэй холбогдуулан УИХ-ын гишүүн Рэгдэл улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнүүдийн төсөвт өртөг нь

50-иас дээш хувиар нэмэгдсэн төслүүдийн талаар ЗГ-аас судалж, УИХ-д танилцуулахтай холбоотой зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн 47.1 хувь буюу олонх дэмжээгүй бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батболдын Мөнхтөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга, Чадраабалын Сугармаа ЗТЯ-ны Авто замын бодлого, зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Далхаагийн Оюунболд Зам тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, Эрдэнэбаярын Балт Зам тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтсийн дарга, Загд-Очирын Энх-Оргил Барилгын хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий инженер, Ганхуягийн Мөнхболд Барилгын хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын Барилга байгууламжийн зураг төсөл, магадлал зохион байгуулах хэлтсийн дарга.

Уул нь бид Пунсалмаа гишүүн өргөн барих үед нь ярьж байсан. Зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалт биш, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээлээр, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, мөн ТӨК-удын тодорхой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр зарладаг төсөл хөтөлбөр энэ бүгдийг нэгтгээд нэг нэгдсэн бодлого, зохицуулалттай больё гэж уул нь ярьсан даа. Тэгээд энэ хүрээндээ уул нь яг энэ холбогдох албан тушаалтнууд нь ирсэн бол. Энэ хүрээндээ яриагүй. Зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гээд явцуугаар явчихсан уу? Энэ дээр уул нь анхаарсан их зүгээр байсан юм. Ганцхан улсын төсвийн хөрөнгө оруулалт дээрээ бид илүү анхаарчхаад, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гаднын зээл тусламжийн зарцуулалт, үр ашигтай байдал, ТӨК-удын болсон, болоогүй баахан тендер зарлаад юу хийж байдаг юм, яаж шалгаруулж, юу хийдэг юм мэдэхгүй энэ юмнууд маань задгай л хаягдчих гээд байх юм. Энийгээ уул нь хамтад нь ярьсан бол, ажлын хэсэгт энэ хүмүүсээ дуудсан бол. Эцсийн хэлэлцүүлэг дээр энийг анхаарчих нь зөв байх.

Ажлын хэсгийн гишүүд УИХ-д хүндэтгэлтэй хандах ёстой, үүрэгтэй. УИХ-ын гишүүдийн асуух асуусан асуултад үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх үүрэгтэй, худлаа мэдээлэл өгөхийг хуулиар хориглосон. Тийм болохоор та бүхэнд хууль сануулж байна, УИХ-ын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандахыг хүсье.

УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуултаа асууна. Батын Батбаатар гишүүн, алга байна. Өлзийхүүгийн Шижир гишүүн, алга байна, за.

Ө.Шижир: Сая Бямбацогт даргын хэлж байгаатай санал нийлж байгаа юм. Зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалт гэхээр ингээд УИХ-аас баталж байгаа хөрөнгө оруулалтын ажил, хөтөлбөр, төсөл хөтөлбөрүүд болчихоод байдаг. Тэгээд орон нутгийн төсөв гэдэг нэг хянагддаггүй тийм байгууллага байгаад байдаг. Нэмэх нь орон нутгийн өмчит компаниуд гээд улсын Төрийн өмчийн хороон дээр бүртгэл нь байдаггүй нэг ийм, нийт улсын төсөвт орон нутгийн хэчнээн ч компани байдаг юм гээд, бид ТӨХ-той уулзаж байхад тодорхой тоон мэдээлэл байдаггүй нэг ийм асуудлууд байдаг юм байна лээ.

Тэгээд орон нутагт ч гэсэн улсын мөнгө, татвар төлөгчдийн мөнгө, улсын төсөв ч гэсэн яг адилхан. Үүн дээр цаашдаа ажлын хэсэг байгуулаад явахад энийг оруулаад явах боломжтой гэж бодож байгаа юм. Тэгээд ер нь нэг л юм байгаа шүү дээ. Бид яг ний нуугүй хэлэхэд, энэ үе үеийн Сангийн сайд нарын буруу. 3 гишүүн ороод, 3 сум дээрээ 1, 1 км зам тавиульа гэхээр нөгөө 1 км замыг нь гурав хуваагаад тавьчихаж байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр хооронд замын өртөг нь өснө, ажиллах хүч нь өснө. Тэгээд ганц километр замыг хүлээхийн тулд 3 жил болно. 3 жилийн хугацаанд төсөвт өртөг нь хамгийн багадаа 30-аас 40 хувь нэмэгдэнэ. Ингээд энэ нь эргээд тэр орон нутгийн ч тэр, улсын төсөв ч тэр, Сангийн яамных нь ч тэр, бүгдийнх нь нийтлэг зовлон болчихоод байгаа юм.

Тэгэхээр ер нь бид цаашдаа энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орох арга хэмжээнүүдийнхээ хуулиудыг ер нь юу гэдэг 5 тэрбумаас дээш бол нэг жил, 5 тэрбумаас дээш бол 2 жил ч гэдэг юм уу, ингээд интервал тавьж өгөөд, тэр тавьж өгсөн интервалаараа хөгжлийн төлөвлөгөөгөө хийчихвэл манай жилийн хөгжлийн хөтөлбөр гэдэг чинь аягүй тодорхой болно шүү дээ. Ингээд юмнуудаа зоогоод, зоогоод явчих юм байна гээд. Тэгэхгүй ингээд нэг жижигхэн саванд бүгдийг нь багтаах гээд аль ч үгүй болоод, тэр хооронд улсын төсвүүд нь өсөөд, хөрөнгө оруулалтын өртөг нь өсөөд, ажиллах хүч нь өсөөд, бензин шатахуун нь өсөөд, тог цахилгаан нь өсөөд явчихаар нөгөө анхны төсөвт өртөг дээрээ мөнгө нь багтахаа больчихож байгаа юм. Бид ийм л зовлон туулчихаад байгаа юм л даа.

Тэгэхээр энэ тогтоолын төслийг та хэд маань дэмжээд яваарай, нэг тодорхой ч гэсэн асуудлаа шийдье. Жишээ нь, би нэг тоо хэлье. 2016 оноос 2026 оны хооронд жишээ нь 1062 ширхэг ЕБС-ийн өргөтгөл, цэцэрлэг, дотуур байр, спорт заал барьсан байгаа юм. Нийтдээ бусад өөр төсөл, барилга, хөтөлбөрүүд гэвэл 579 ширхэг барилга байгууламжийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна. Ингээд 2100 орчим. Энэ 2100 орчим төслийн чинь нийтдээ бараг 70 хувь нь шахуу төсөвт өртөг нэмэгдсэн, хугацаандаа ороогүй байгаад байгаа байхгүй юу. Одоо ингээд л энэ ногооноор тодруулсан нь дандаа хугацаандаа ороогүй барилгууд гэсэн үг. Ийм байдал чинь өөрөө эргээд татвар төлөгчдийн хөрөнгийг, татвар төлөгчдийн мөнгийг зөв хөрөнгө оруулагч үр ашиггүй, үр дүнгүй л болгоод байгаа юм л даа.

Энэ хуулийн төслийн чинь гол зорилго, үндэслэл ерөөсөө л энэ. Тийм учраас УИХ-ын гишүүд маань энийг дэмжээд өгье. Энэ ялангуяа Засгийн газрынханд бүр ашигтай байгаа юм. Бүр цаад утгаар явахаар Сангийн яамныханд ашигтай. 100 хүүхдийн цэцэрлэгийн дотуур байрыг 3 жилд хувааж бид барьж яах гээд ч байгаа юм. Нэг сумын төв дээр нэг цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг бид 3 жил хувааж барьж яах гээд ч байгаа юм бэ. Нэг сумын төвийн 1,5-хан километр замыг 3 жил хувааж барих нь компани талдаа бол хүндрэлтэй л баймаар юм. Тэгэхээр энэ мэт юмнуудыг бид асуудлуудыг бид ингээд шийдчихье. Хамгийн гол нь, энэ цаана нь

тэр сургууль хүлээж байгаа, цэцэрлэгийн дотуур байраа хүлээж байгаа хүүхдүүдийн эрх ашиг гэж юм хохироод байгаа юм.

Нөгөө талдаа, тухайн сум орон нутагт хийж байгаа ажил хөдөлмөрийн, бүтээн байгуулалтын үр дүнг нь хүлээж байгаа бас иргэд нь хохироод байгаа юм. Тэгээд нэг магадлан төсөв нь өсөхөөр магадлан хийсэн болдог, тэгээд л нэг юмнуудыг нь нэмсэн болоод дахиад л төсвийг нь нэмдэг, тухайн жилдээ багтдаггүй гэх мэт ийм олон зүйлийг шийдье гэсэн л ийм хуулийн төсөл шүү. Тэгээд та бүгдийг бүгдийг нь дэмжихийг хүсье.

С.Бямбацогт: Наранбаатар дарга хариулъя, Төсвийн байнгын хороо.

Н.Наранбаатар: Түрүүний Их Хурлын дарга хэлж байсан, эцсийн хэлэлцүүлэг дээр улсын төсвийн гэдэг дээр анхаараарай гээд хэлж байсан. Тэгээд эцсийн хэлэлцүүлэг дээр бид яриад, нэмэгдүүлж болохоор юм байна гээд бид Байнгын хороон дээрээ ярьж 1 дүгээрт.

2-т гэвэл хууль санаачлагч анхнаасаа улсын төсөв гээд ороод ирчихсэн учраас манай Байнгын хороо энүүгээрээ л явчихсан. Тэгээд хугацаа 07 сарын 01 гэж байсныг Байнгын хороон дээрээ ярьж байгаад энэ хаврын чуулганы хугацаанд гэхчхэн жаахан хойшлуулаад. Одоо орон нутгийн төсвөөр хийж байгаа гадаадын зээл тусламжаар гэхээр хугацааны хувьд бас л их шахуу болно. Бүх л сумдаас, аймгуудаас мэдээллээ авч нэгтгэнэ, тэгээд тэн дээр үнэлгээ хийнэ, эрэмбэлнэ, саналаа боловсруулна, эргэж одоо Их Хуралд танилцуулна гээд нэлээн ажлууд болох байх гэж.

Шижир гишүүний асуусан дээр бол түрүүн асуулт биш дэмжиж дэмжсэн байр суурьтай үг хэлсэн гэж ойлгосон. Тэгээд миний хувьд ч гэсэн манай Байнгын хороон дээр олон гишүүд үг хэлсэн. Үнэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ингээд үр ашиггүй эхлээд гацсан олон барилга байгууламж байгаа учраас үүнийг цаашаа яах юм бэ гэх гэдэг асуудлыг нь засаг УИХ руу оруулж ирэх нь зүйтэй гэдэг дээр гишүүд бол дэмжиж санал өгөөд, ингээд Байнгын хороон дээрээс дэмжигдээд орж ирж байгаа.

С.Бямбацогт: Ер нь улсын төсвийн хөрөнгө, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ТӨК-удын хөрөнгө, гаднын зээл эд нар чинь бүгдээрээ л төрийн мөнгө. Бүгдээрээ л татвар төлөгчдийн мөнгө. Тийм болохоор энэ татвар төлөгчдийн мөнгөөр төсөв бүрддэг. Төсвөө бид улсын төсөв орон нутгийн төсөв гэж ангилж ялгадаг. Төсөв хүрэлцэхгүй болохоор гаднаас зээл тусламж авдаг. Тийм болохоор энэ эх үүсвэрүүд нь нэг л эх үүсвэртэй, нэг л зорилготой юм чинь бүгдээрээ үр ашиг сайжруулах гэж байгаа бол хөрөнгө оруулалтын үр ашгийг энэ бүх улсын төрийн мөнгө, татвар төлөгчдийн мөнгө гэж үзэж бүгдийг нь нэг зарчимтай үр ашигтай болгох талд анхаарах ёстой. Тийм болохоор эцсийн хэлэлцүүлэг дээрээ Төсвийн байнгын хороо, УИХ-ын Тамгын газар энэ талд нь илүү анхаарч, Сангийн яамныхантай хамтарч ажиллаж хийгээрэй, энийг чинь илүү жоохон сайжруулах хэрэгтэй байна шүү. Зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалт гэхээр илүү явцуу болчихоод байна. Болдын Уянга гишүүн, алга байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Чухал тогтоол оруулж ирж байна. Орж ирсэн танилцуулгаас ингээд харахад 2024 онд 449 төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө

оруулалтаар хэрэгжүүлж, 1,6 их наяд төгрөг бүхий үндсэндээ нэмэгдлийг тооцож авахаар болсон байгаа. Ингээд энийг үндсэндээ харахад нийт төслийн 43 хувьд хувийг үндсэндээ хамарч байгаа юм. Тэгэхээр энэ 24 оны тоо статистикийг ингээд харвал Монгол Улсын төсвөөр хэрэгжиж байгаа 2 төсөл тутмын нэг нь ямар нэгэн байдлаар анх тооцсон төсөвт өртгөөсөө нэмэгдэж байна гэдэг ийм тооцоо танилцуулгууд гарч ирсэн байна. 25 он, 26 он болон бусад мэдээллүүд нэлээн дутуу харагдаж байна. Тэгэхээр үндсэндээ энэ асуудлыг нэлээн нарийн судлах, дахиад олон нийтэд мэдээлэх чиглэл дээр ажлын хэсэг ямаршуу байдалтай ажилласныг тодруулъя?

Ер нь энийг нэлээн задалж ярих шаардлагатай байна. Улсын төсвийн энэ хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа томоохон төсөл хөтөлбөрүүдийн чанарын асуудал, төсөвт хөрөнгө нь нэмэгдэж байгаа асуудлыг сууриар нь шийдэх чиглэл дээр тодорхой үр дүнгүүдийг цаашдаа гаргаад явахыг дэмжиж байна. Тэгээд хэд хэдэн би саналуудыг хэлье. Тэгээд боломжоороо та бүхэн маань хариулаарай.

Тогтоолын төслийн ерөнхий агуулга нь тайлан гаргах, судлах гэсэн иймэрхүү үндсэн агуулгууд байгаа юм. Төсвийн хөрөнгийн энэ зарцуулалтад гарсан зөрчлийг шалгаад, буруутай этгээдийг энэ тогтоож байгаа байдал хуулийн дагуу тодорхой хариуцлага тооцохтой холбогдолтой энэ заалтуудыг илүү тодорхой оруулж өгөх ийм шаардлагууд байна. Тэгээд энэтэй холбогдолтой үндсэндээ ажлын хэсэг дээр ямаршуу байдлаар ажиллаж байгаа вэ? Мөн энэ тогтоолын төсөл байсан ч, байгаагүй ч энэ чиглэлийн арга хэмжээг ЗГ-аас яаж авч хэрэгжүүлсэн бэ гэдэг дээр тоон мэдээлэл байгаа бол тэрийг үндсэндээ харъя.

Баригдсан төслийн чанартай холбогдолтой асуудлуудыг, 2 төсөл тутмын нэг маань ингээд нэмэгддэг юм байна. Ингээд нэмж бариад ямар ч байсан нэг бүтээн байгуулалт бий болно. Бүтээн байгуулалт нь дуусаагүй байж бороо гоожиж байна, бүтээн байгуулалт нь дуусаагүй байж салхинд дээвэр нь хуурч байна. Тэгээд энэ чанартай холбогдолтой асуудал дээр нөгөө хар жагсаалт, олон зүйлүүдийг бид бүхэн ярьдаг. Төдийлөн үр дүнтэй байж чадахгүй. Өнөөдөр ч гэсэндээ баригдсан бүтээн байгуулалтын ажлууд ялангуяа энэ зам, дэд бүтэц, барилгын ажлууд хангалтгүй байгаа дээр ямар агуулгыг тусгаж байна вэ гэдгийг 2-т нь асууя?

3-д нь бид энэ Тендерийн тухай хууль дээр шалгаруулалт дээр яах вэ харьцангуй боломжийн байна. Хамгийн бага үнийн саналаа өгөөд үндсэндээ төслүүдээ бид бүхэн шалгаруулчхаж байна. Хамгийн бага үнээр өгсөн төсөл болгоны 2 төсөл болгоны нэг нь төсвөө нэмэгдүүлэх байдлаар үүний цаана тийм янз бүрийн ийм зохион байгуулалттай ийм хэлбэр байгаа юм биш биз дээ? Тэгээд үндсэндээ нөгөө хамгийн бага үнэтэй үнээр авсан тэр төсөл маань буцаагаад анх өгсөн төслөөсөө ч өндөр хэмжээний ийм байдал руу орж байна. Тэгэхээр энэ тендерийн шалгаруулалтаас гадна явцын шатанд тухайн энэ төслийг үнэлэх, түүнтэй нь холбогдолтой хариуцлага тооцохтой холбогдолтой ямар зохицуулалтууд байна вэ? Энэ Тендерийн хуультай холбогдолтой энэ асуудал дээр дахин шалгахтай холбогдолтой ийм заалтуудыг тогтоолын төсөлдөө тусгаж байна уу гээд ингээд нарийвчлах зүйлүүд нэлээн байна. Эдгээр асуудлуудыг эхлээд тодруулъя.

С.Бямбацогт: Сангийн яамнаас хариулчих уу? Энэ хөрөнгө оруулалтын бодлого, барилга байгууламжийн төсөвт өртөг байнга нэмэгддэг, үр ашигтай болгох тал дээр. Энэ зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалт байх уу, цааш нь орон нутаг, гадаадын зээл бусад юм дээр ямар боломж байгаа юм.

Ж.Дэлгэржаргал: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Яг төсвийн хөрөнгө оруулалт, нэгдсэн төсвийн нийт зардалд орж байгаа хөрөнгийн зардлын хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалт ер нь 30 хувьтай байгаа. Бусад хөрөнгө оруулалт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл. Нэгдсэн төсвийн нийт зардлын хөрөнгийн зардалд орохгүй хөрөнгө оруулалт ТӨК-удын хөрөнгө оруулалт байгаа. Яг ТӨК-удын хөрөнгө оруулалт бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 10 дахин өндөр ийм хөрөнгө оруулалтууд явж байгаа.

Яг энэ төсөвт өртөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар явж байгаа асуудлуудын төсөвт өртгийн нэмэгдлийн нийт шалтгааных нь 70-аас 75 хувь нь бэлтгэл ажилтай холбоотой, зураг төсвийн асуудлууд. Бид хуулийн шаардлагаараа яг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдаас гардаг журам аргачлалуудыг жил болгон ингээд сайжруулаад шаардлагуудаа тавиад яваад байгаа боловч зураг төсөвтэй гээд төсөвт тусгагдсан ажлууд маань хүртэл өртөг нэмэгддэг. Тэгэхээр энэ зураг төсөв дээр дутуу асуудлууд. Тэгэхээр энэ зураг төсвийг яг мэргэжлийн байгууллагууд магадлал хийж хянадаг байгаа. Улсын хэмжээнд 3 байгууллага байгаа. Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв.

Сангийн яамны хувьд яг энэ хөгжлийн төвүүд магадлаад, хянаад ирүүлсэн төсөвт өртгөөр тухайн төслийг төсөвт тавигддаг. Ингээд хэрэгжилтийн явцад хяналтад 2 төрлийн хяналт тавигдаж байгаа. Тухайн зураг, барилга байгууламжийн зургийг зохиосон зохиогчийн хяналт. Тэгэхээр нийт төслийн гэрээний үнийн дүнгийнх нь нэг хувийг бид зохиогчийн хяналт хэрэгжүүлснийх нь төлөө төсвөөс өгдөг. Нийт гэрээний үнийн дүнгийн 2 хувийг болохоор захиалагчийн техник технологийн хяналт тавьсных нь төлөө энэ төвүүдэд олгоод явж байгаа. Тэгэхээр хяналтын явцад яг энэ тусгайлан зохицуулсан чиг үүргүүд байгууллагууд мэдээж ажиллаад явж байгаа.

Тэгэхээр бидний хувьд яг энэ хяналт нь тавигдаад ирсэн тохиолдолд Төсвийн хуулийн шаардлага хангаж байгаа дээр л Сангийн яам хяналт тавьж, санхүүжилтийг олгоод явж байгаа. Тэгэхээр мэдээж өмнөх 16-аас бид 25 онд 2, 3 мянга гаруй барилга байгууламжийн төсөл хэрэгжүүлсний 3 төсөл тутмын 1 нь ямар нэгэн байдлаар өртөг нэмэгдэж, эсвэл материалын үнийн өсөлт авсны үндсэн дээр ашиглалтад орсон гэсэн судалгаа гарсан. Тэгэхээр энэ бол яг энэ зохицуулалтын хувьд шинэ зохицуулалт шаардлагатай байгаа учраас бидний хувьд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, 6 сард өргөн барихаар төлөвлөж байгаа.

Энэ дээр яг энэ төслүүд дээр гарч байгаа өртөг нэмэгддэг, хугацаа сунжрах асуудлуудыг бүх яг үе шатаар нь зохицуулах асуудлуудыг л хариуцлагын асуудалтай нь оруулж ирж байгаа. Яг хөрөнгө оруулалтуудын төслүүдийн хувьд улсын комисс ажиллахдаа чанарын асуудал бол бүгд ингээд тусдаа хуулиар зохицуулсан асуудлууд байгаа боловч хэрэгжилт хангалтгүй, энийг дагасан хяналтын асуудал, хариуцлагын асуудал сул байгаа нь харагдаж байгаа. Тэгэхээр энэ хууль зүйн хувьд бид сайжруулаад байгаа нь өөрөө улсын төсвийн хөрөнгө оруулалт буюу нийт төсвийн зардал, хөрөнгийн зардлын 30 хувьд нь л зохицуулалт хийгээд байгаа. Цаана нь бид яг 10 жилийн өмнөхтэй харьцуулбал хөрөнгө оруулалтын хэмжээ өссөн, төслүүд.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя, 4 дүгээр микрофон.

Ж.Дэлгэржаргал: Томоохон төслүүдийн төсөвт өртөг ч гэсэн хэмжээ нь том болсон учраас үүнийг дагасан зохицуулалт шаардлагатай байгаа. Тэгээд 2026 оны хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалт өөрөө орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаасаа бага байгаа.

С.Бямбацогт: Тэгэхээр сая хэлж байна шүү дээ төсөвт өртгийн 2 хувиар зураг төсвийн мөнгө бодогддог. Төсөвт өртгийн 2 хувиар захиалагчийн хяналтын зардал бодогддог. Төсөвт өртгөөс нэг хувиар зохиогчийн хяналт бодогддог. Энэ чинь юу гэж байна гэвэл ерөөсөө л үнэ өсөх, өсгөх үндсэн шалтгаан болчихоод байгаа юм. 1 тэрбум төгрөгийн барилга бариад 2 хувийн гэвэл төсөвт өртөгтэй барилга барихад 2 хувь гэвэл 20 сая, тэрийг 5 тэрбум болгочихвол 100 сая.

Ийм учраас яг энэний чинь болоод сумын төвүүд дээр, сумуудад баригдаж байгаа нутгийн удирдлагын ордны барилга бэлэн жишээ. 2 давхар барилга 20 давхар барилгын багана, дам нуруугаар цутгагддаг. Хоёрхон давхар барилгын багана, дам нуруу 20 давхар барилгын багана, дам нуруу шиг тийм зузаан, өргөн ингээд төсөвт өртөг нэмэгддэг. Тэнд 20 хүн суух байшинг бараг 200 хүн суух талбайтай болгоод, хоосон талбайдаа өрөө тасалгаа нь ихдээд байхаар ашиглалтгүй баахан талбайнууд болгоод барьчихдаг. Ингээд нөгөө сумын төвд баригдаж байгаа сумын Тамгын газрын 20 хүн суух байшин 20 давхар байшингийн төсөвт өртөгтэй адилхан дүйцэхүйц болоод, тэндээс нь зураг төсөв зохиож байгаа хүн нь 2 хувь гээд хангалттай их мөнгөний урамшууллаа авдаг. Захиалагчийн хяналт тавих гэж байгаа нөхдүүд нь нүдээ аниад, захиалагчийн хяналтын төсвийг нь батлаад өгчихдөг. Энэ манай энэ хөгжлийн төвүүд, Барилгын хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв энэ дээр нүдээ аниад, яагаад гэвэл тэндээс өөрсдөө захиалагчийн хяналт тавьж санхүүждэг учраас нүдээ аниад өсгө, өсгө, өсгөөд байвал бидний санхүүжилт нэмэгдэх юм гээд. Энэ чинь эхний үндэслэл болчихоод байгаа юм үнэ өсөхөд.

2 дугаарт нь, дахиад араас нь тэгээд л нэг шалтаг, шалтгаан гараад л цахилгаан өссөн, шатахуун өссөн, барилгын материал өссөн гээд л үнэ өсгөх юм хийдэг, дахиад энэ хөгжлийн төвүүд нь нөгөө магадлан хийдэг, магадлал хийдэг. Энэ магадлал дээрээ дахиад үндэслэлтэй байна гэдэг. Яагаад гэвэл өөрсдийнх нь авах урамшуулал нэмэгдэх учраас, санхүүжилт нэмэгдэх учраас үнэ өсгөх нь үндэслэлтэй байна гэдэг. Эцэст нь Сангийн яам тэгээд нэгэнтээ энэ эрх бүхий байгууллага нь үнэ өсгөх үндэслэлтэй гээд гаргаад өгчихөөр, түүнийг нь Сангийн яам санхүүжүүлэхээс өөр аргагүй болдог. Энийгээ шийдмээр байна шүү дээ. Энийг шийдэхдээ зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр биш, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт дээр, гаднын зээл дээр, энэ ТӨК-уд дээр бүгдийг нь нэгтгээд шийдмээр байна шүү дээ. Ганхүлэг гишүүн асуултаа нэмж асууя.

М.Ганхүлэг: Тийм, хариуцлагатай холбогдолтой асуудлыг сайжруулах шаардлагатай гээд хүлээн зөвшөөрч байх шиг байна. Тогтоолын төсөл дээр хариуцлага тооцох тухай тодорхой чиглэл оруулах зайлшгүй хэрэгтэй. Одоо зүгээр тайлагна, мэдээл гэдэг ийм ерөнхий агуулгууд байгаад байна, тэгэхээр энийг ахиад тодруулъя. Ажлын хэсгийн, хууль санаачлагчаас. Дээр нь тэр Тендерийн тухай хуультай холбогдолтой явцын шатад бид бүхэн яг ямар зохицуулалтуудыг мөрдөж байна вэ? Өнөөдрийг хүртэлх хугацаанд төсөвт өртгөө нэмэгдүүлээд, мөн чанаргүй олон төрлийн энэ төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн хэчнээн ААН-д, ямар

хуулиар, ямар хариуцлагуудыг тооцсон байгаа вэ гэдэг тоон мэдээллийг би асуугаад байгаа юм? Энэ нь сул байгаа юм уу, бага байгаа юм уу, яг юу нь чадахгүй байгаа вэ гэдэг дээр яг нэг тодорхой хариулт өгч, энийг тогтоолын төсөлдөө бид бүр тусгаж оруулах хэрэгтэй. Тэгэхгүй бол үндсэндээ ярьсаар байгаад энэ байдал үргэлжлээд явах.../минут дуусав/

С.Бямбацогт: Хууль санаачлагч ямар үндэслэлээр гэдгээ тайлбарлая. Араас нь Сангийн яам нэмж хариулт бэлдэж байгаарай.

Б.Пунсалмаа: Ганхүлэг гишүүний асууж байгаа асуултууд маш зөв, оновчтой асуултууд асууж байна. Тэгэхлээр бид Монгол улсын хэмжээнд 938 хууль, УИХ-ын 2550 тогтоол, захиргааны хэм хэмжээний 3222 эрх зүйн акт өнөөдөр үйлчилж байгаа. Ийм олон хууль тогтоол байдаг хэр нь ерөөсөө бид энэ хуулийнхаа хэрэгжилт гэдэг юмыг тэр болгон авч хэрэгжүүлэхгүй байна. Тийм болохлоор энд шинээр нэмж хууль оруулж ирэх гэхээсээ илүү хуулийнхаа хэрэгжилт дээр хяналт тавьж ажиллая гэсэн ийм бодлогын үүднээс энэ тогтоолын төслийг санаачилсан юм байгаа юм.

Тэгэхлээр сүүлийн 3 жилийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр 2537 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа. Тэр 2537 төсөл арга хэмжээнээс 2300 нь шилжих хөрөнгө оруулалт гээд дандаа өмнө нь орж ирсэн төсөл.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя, Пунсалмаа гишүүн.

Б.Пунсалмаа: Нэмж санхүүжүүлж байгаа гэсэн үг. Энэ дотроос 522 төсөл арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн байгаа. Тэгэхлээр 2537 төсөл арга хэмжээнүүдээс дахиад нэмж төсөвт өртөг нь нэмэгдэх магадлал ихтэй буюу 212 шинэ төсөл арга хэмжээ сүүлийн 3 жилд орж ирсэн. Шинэ төсөл арга хэмжээ орж ирэх орон зайгүй болчихоод байна гэсэн үг. Хуучин өмнөх төсөл арга хэмжээнүүдээ гүйцээн санхүүжүүлэх зорилгоор төсөв маань зориулагдсаар байгаад, шинэ төсөл арга хэмжээ орж ирэх орон зай багасаад байгаа учраас энэ төсөл арга хэмжээг бид тогтоолын төслийг санаачилж оруулж ирж байгаа юм.

Тэгэхдээ зэрэг энэ тогтоолын төслийн дагуу Засгийн газар нь одоо хэрэгжиж байгаа бүх төсөл арга хэмжээнүүдийг бүгдийг нь эрэмбэлээд, аль төсөл арга хэмжээг гүйцээн Засгийн газрын санхүүжүүлэх бололцоотой вэ, алийг нь зогсоох шаардлагатай вэ, алийг нь өмчлөлийн өөр хэлбэр рүү хуулийн хүрээнд шилжүүлж болох вэ гэдгийг ингээд шийдээд, ингээд энэ төсөл арга хэмжээнүүдийг ангилаад нэг удаа Засгийн газрын хэмжээнд хэрэгжиж байгаа төслүүдээ цэгцэлье.

С.Бямбацогт: Сангийн яам хариуцлага тооцсон уу, хууль бус байсан уу, хууль зүйтэй байсан уу тэр дээр нь нэмээд хариулчихъя.

Ж.Дэлгэржаргал: Өртөг нэмэгдэж байгаа төслүүдийн хувьд 2023 оноос эхлээд бид 2 зохицуулалтын бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа. Энэ дээр өмнө нь яг энэ магадлалын дүнгээр гарсан асуудлуудыг шууд төсөв дээр тусдаг байсан бол Үндэсний аудитын газраар аудит хийлгэдэг болсон. Зарим шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн дүгнэлт гаргуулах. Тэгэхээр 2023 оноос эхлээд энэ төсөвт өртөг нэмэгдсэн ажлууд аудитын дүгнэлтээр шийдвэрлэж байгаа. Тэгэхээр аудитын дүгнэлт тусгагдсаны дагуу аль, ямар асуудлаас үүдэлтэй, хэн буруутай гэдгээс яг тэр чиглэлээрээ Төрийн албаны тухай хууль болон холбогдох

хуулиудаараа хариуцлагын асуудлууд явагдаж байгаа. Яг Төсвийн тухай хууль болон түүнийг дагаж гарсан холбогдох дүрэм журмаар Сангийн яам яг хариуцлага тооцох нь их тодорхойгүй яг тийм боломж байхгүй байгаа учраас энэ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль дээр хариуцлагын асуудлуудыг тусгайлан оруулж ирж байгаа. Ер нь явж байгаа.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя.

Ж.Дэлгэржаргал: Хэрэгжиж байгаа төслүүд дээр дахин үнэлгээ хийх ийм аргачлал байдаг. Өөрөөр хэлбэл хэрэгжээд явж байгаа төслүүд дээр бид төсвийн төслийн санал ирэхэд нь дахин үнэлэх аргачлалаар хэвийн байна уу, энэ асуудалтай байна уу гэж үнэлгээ гаргаад, энийг цааш нь яг төсвөөр үргэлжлүүлээд явах уу гэдэг шийдвэр гаргах ийм үнэлгээний аргачлал байдаг. Яг төсвөөс хийгдэж байгаа хөрөнгө оруулалтуудын хувьд одоо яг ингээд барилга маань дуусаагүй явж байгаа, тийшээ төсвийн мөнгө орчихсон байгаа учраас, татвар төлөгчдийн санхүүжилт орчихсон байгаа учраас яг тэрийг хувийн хэвшил рүү шилжүүлэх ч юм уу, зогсоох асуудал эрсдэлтэй. Яагаад гэвэл тэр хөрөнгө оруулалтууд нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх асуудал байдаг учраас Сангийн яамны бодлогын хувьд хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн төслүүдийг хамгийн түрүүнд дуусгах энэ эрэмбийн асуудлыг 22 онд Төсвийн тухай хууль дээр байгаа. Тэгэхээр бид төсвийн төсөл боловсруулахдаа яг энэ хуулийн заалтын дагуу эхлээд гэрээтэй төслүүдээ санхүүжүүлэх төлөвлөлтөө хийгээд, дараа нь их засвар буюу байгаа барилгуудаа тордож насжилтыг нь уртасгах, тэгээд үлдсэн.../минут дуусав/

С.Бямбацогт: Тодруулж, асууя Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Тэгээд яах вэ бүрэн хариулт авч чадахгүй байгаад байна. ААН-үүдээ юм хийж байгаа хүмүүсээ заавал ч үгүй ингэж хариуцлага тооцох гээд байгаа юм биш. Гэхдээ ийм байгаа байдлыг бид өөгшүүлээд яваад байвал дараа дараагийн бүтээн байгуулалтын ажлууд яг энэ зарчмаараа явах гээд байна. Орон нутагт хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлууд дуусаагүй байж үндсэндээ тодорхой чанаргүй байгаа асуудлуудыг бид зайлшгүй энэ тогтоолын төсөлд агуулгадаа оруулах хэрэгтэй. Зөвхөн төсөв хөрөнгө нэмэхээс гадна, чанаргүй баригдаж байгаа энэ барилгуудтай холбогдолтой асуудлуудыг тогтоолын төсөлдөө оруулах хэрэгтэй.

Би Пунсалмаа гишүүнээс асууж байгаа асуудал нь болохоор хариуцлага гэдэг үг байна уу, хариуцлага тооцох тухай тодорхой чиглэл санал байна уу гэдгийг тогтоолын төслөөс нь асуугаад байгаа юм? Энэ асуудлыг бид бүхэн оруулж байж, илүү шахаж байж бид дараагийн арга хэмжээнүүдээ аваад явна. Нэрээр нь хэлбэл зөндөө олон төслүүд байна. Манай Дорнод аймгийн тэр 50км зам, жижиг энэ сургууль, цэцэрлэгүүдийн асуудлууд эзэн нь.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариуцлагын асуудлаар Наранбаатар дарга Төсвийн байнгын хороо хариулъя.

Н.Наранбаатар: Энэ тогтоолын төсөл дээр хариуцлага гэсэн заалт байхгүй. Тогтоолын төслийг анх боловсруулсан ерөөсөө үзэл баримтлал нь хэн нэгэнтэй хариуцлага тооцохдоо биш, дуусаагүй байгаа барилгуудаа цаашаа яах вэ гэдэг дээр л анхаарч энэ тогтоолын төслийг боловсруулсан юм. Манай Төсвийн байнгын хорооны хурлаар энэ жилийн Үндэсний аудитын газрын хяналт шалгалт хийх

сэдвийг баталсан. Энэ дотор Барилгын хөгжлийн төв орсон, Замын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв гэсэн 3 байгууллагын үйл ажиллагаанд аудит хяналт шалгалт хийнэ гэж орсон байгаа. Яагаад гэхээр энэ дээр их төсөвт өртгүүд нь их нэмэгдэж гарч ирдэг учраас эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийнэ гэсэн ийм зүйлүүд орсон.

Тогтоолын төсөл дээр Ганхүлэг гишүүн хариуцлага гэдэг үг үсэг оруул гэж байна. Тэрийг бид Байнгын хороон дээрээ эцсийн хэлэлцүүлэг дээрээ ярилцаад, санаачлагчтайгаа ярилцаж байгаад болохоор бол.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэгэнтээ цэгцлэх гэж байгаа бол цэгцэлсэн шиг цэгцлэх хэрэгтэй л дээ. Тэгэхгүй дутуу алсан могой шиг юм хийх хэрэггүй байх. Энэ хариуцлага заавал байх ёстой. Энэ улсын төсөв, орон нутгийн төсөв, ТӨК-удын хөрөнгө оруулалт энэ бүгдийгээ нэг мөр энэ дотор оруулаад цэгцэлчихмээр байна шүү дээ. Энэ тал дээр Төсвийн байнгын хороо эцсийн хэлэлцүүлгээр анхаараарай. Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ тогтоолын төслийг нь дэмжиж байгаа юм. Тэгэхдээ яах вэ агуулга тал дээр нэг жоохон ажилламаар байна. 22 онд улсын төсвөөр хэрэгжиж байгаа дутуу баригдсан боловсролын салбарын хөрөнгө оруулалт дээр Төсвийн байнгын хороо, Боловсролын байнгын хороо хамтарч ажиллаад, тухайн үед 60 гаруй дутуу баригдсан байсан объектуудыг бүгдийг нь ашиглалтад оруулж байсан. Тэрийгээ дагаад нөгөө төсөв өргөн барихад нь бид урсгал зардлыг нь, боловсролын салбарын урсгал зардлыг нэмээд, сугалааны цэцэрлэг гэдгийг байхгүй болгож байсан юм.

Тийм, тэгэхээрээ бид энэ нэгэнт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа энэ төсөл арга хэмжээг шалгаад сайжруулъя гэж байвал нэг жоохон өргөн цар хүрээнд жоохон юмаа харчихвал их сайн байна. Тэгэхээр бид дараа дараагийн ямар арга хэмжээ авах талаар оруулмаар байгаа юм. Яах вэ бид энэ асуудал угтаа хэлбэл УИХ-д өөрт нь байгаа юм. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль, одоо бид жилийн төлөвлөгөө батлахад орж ирсэн санал дээр нь ямар нэгэн эрэмбэгүйгээр, ямар нэгэн тэргүүлэх чиглэл барихгүйгээр олон санал, төсөл хөтөлбөр ордог. Төсөл батлагдахад бас тэгдэг. Тэгэхээр бид энэ Төсвийн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиуд дээр ер нь улсын төсвөөр яг юу хийх вэ, юуг хийхгүй вэ гэдгийг маш сайн эрэмбэлж ер нь хуульдаа оруулж өгмөөр байгаа юм.

Одоо ганцхан л эрэмбэ байгаа шүү дээ. Тэр нь юу вэ гэхээр зураг төсөв, ТЭЗҮ гэдэг л эрэмбэ байгаа юм. Зураг төсөв, ТЭЗҮ-г харин хасаж болдог, байгаа бол тэгээд үгүй гэж хэлэх ямар ч боломжгүй ийм нөхцөл байдалд байдаг л даа хууль нь угаасаа ийм юм. Тэгээд энэ дээр нэг хэд хэдэн санал юу хэлэх гээд байна гэхээр бид ер нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг харахад нэлээн олон тоног төхөөрөмжийн саналууд байдаг юм. Нэг бол Засаг хажуудаа лизингийн компанитай болох юм уу, аль эсвэл бид энэ лизингийг тухайн бүрэн эрх, УИХ-ын бүрэн эрхтэй нь дүйцүүлэх байдлаар лизингээр энэ тоног, төхөөрөмж машин эд нарыг нь авахыг нь үүд хаалгыг нь нээгээд өгчихвөл улсын төсөв дээр ирэх ачаалал нь багасах байхгүй юу. Тэгээд тэрийг жил жилд нь тодорхой хэмжээний зардлыг нь урсгал зардал дээрээ тавиад, тавиад явчихвал бид нэг жилийн дотор бүх багш нарын компьютерыг шийдэж болж байна. Одоо яг шаардлагатай газрын бүх автомашинуудыг шийдэж болж байна. Одоо юу гэдэг юм нэг иймэрхүү байдлаар тоног төхөөрөмжүүдийг бүгдийг нь шийдэх боломж байгаа,

эрүүл мэндийн салбар ч гэдэг юм уу. Энийгээ бид төсвийн хууль дээрээ 1 дүгээрт оруулж өгмөөр байгаа юм. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульдаа оруулж өгмөөр байгаа юм.

Тэгээд гадаадын, Бямбацогт даргын яриад байгаа бид зөвхөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээс энэ гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа тэр төсөл арга хэмжээ энэ тэрээ нэгтгэж явмаар байгаа юм. Одоо 10 аймаг дээр 10 дулааны цахилгаан станц /ДЦС/ гээд яриад л байдаг, дуусдаггүй, хэрэгждэггүй ийм төсөл арга хэмжээнээс болбол нэг бол татгалзах, нэг бол төсөл хөтөлбөрөө өөрчлөх шаардлагатай. Тэгээд энэ дээр ямар нэгэн санал, дүгнэлт гарахгүй. Тэгэхээр Засгийн газарт өгөөд хаях биш, энэ дээр УИХ-аас ажлын хэсэг гарч ажиллах ёстой юм. Магадгүй хамтарсан ажлын хэсэг байх уу, үгүй юу.

Тэгээд үүнтэй улбаалаад би 3 асуулт асууя гэж бодож байгаа юм. 1 дүгээрт, энэ зарим төсөл хөтөлбөрийг нэг хувьчилна гэсэн асуудал орсон байна л даа. Тэгэхээр энэ эрэмбийг нь хэн хийх вэ, ач холбогдлыг нь яаж харж, алийг нь хэрэгтэй, хэрэггүй гэдгээ эрэмбэлж ингээд хувьчлах гээд байгаа вэ гэдэг 1 дүгээр асуулт?

Мөн цаашдаа одоо хэрэгжиж байгаа гадаадын зээл тусламжаас ер нь ингээд олон жил, бид сая ашиглалтыг сайжруулах, Гадаадын зээл ашиглалтыг сайжруулах хуулийн төслийг санаачиллаа шүү дээ. Санаачлаад, батлууллаа. Өнгөрсөн жил тухайн хуулийг би өөрөө санаачилсан, манай Мөнхбаясгалан гишүүн байна, маш санаачилгатай гишүүн, Аубакир байна, манай Сайнзориг байна бид 4 санаачлаад, уг нь ингээд тэр чинь эрэмбэлж байгаа байхгүй юу. Яг түүнтэй адилхан энэ гадаадын зээлүүд дээрээ эрэмбэлэх асуудал зайлшгүй хэрэгтэй. Тэгээд хэрэггүйгээсээ хэрхэн, яаж салах вэ? Энэ дээрээ.../минут дуусав/

С.Бямбацогт: Пунсалмаа гишүүн хууль санаачлагч хариулъя.

Б.Пунсалмаа: Тийм ээ, тэгэхлээр энэ тогтоолын төслийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, дээрээс нь орон нутгийн төсөв, орон нутгийн сан, гадаадын зээл тусламж, төрийн өмчийн бүх объектуудаа бид бүх ер нь өмчлөлийн хэлбэрүүд одоо хэрэгжиж байгаа, одоо яг баригдаж байгаа энэ төслүүдээ бүгдийг нь нэг хавтгай дээрээ гаргаж ирж харъя гэж байгаа юм. Тэгээд явцыг нь ингэж тооцоод, аль, аль төслүүдийг нь хэрэгжүүлэх вэ, аль алийг нь зогсоох вэ энэ шийдвэрүүдийнхээ, энэ жагсаалтаа Засгийн газар УИХ-д авчирч бидэнд тайлан болгож бэлтгэж өгнө. УИХ-ын гишүүд бид эцсийн шийдвэрийг гаргах юм. Аль, аль бүтээн байгуулалтын ажлыг зогсоох вэ, аль алийг нь үргэлжлүүлэх вэ гэдэг дээр шийдвэрээ гаргах юм, УИХ өөрсдөө шийдвэр гаргана.

С.Бямбацогт: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Үгүй ээ, энэ УИХ-аас ажлын хэсэг өмнө яг боловсролын салбар дээр гараад, би тухайн үед ажлын хэсгийг нь ахлаад явж байсан юм. Тэгэхээр энэ 1 дүгээрт энэ наадмаас өмнө гэдэг хугацаа бол худлаа шүү. 2 дугаарт ийм хэмжээний тогтоолын төслийг Засгийн газарт чиглэл өгч байгаа бол эндээс УИХ-аас Ажлын хэсэг гарч ажиллах ёстой. Тэгээд тэр болбол бүх төсөл, энэ хөрөнгө оруулалтын тэр төслүүд дээр очиж үзээд, тэгээд тухайн салбарын яамтай нь уулзаад үргэлжлүүлэх үү, үргэлжлүүлэхгүй юу, хувьчилж болох уу, болохгүй юу ингэж явахгүй бол зүгээр Засгийн газарт ингээд найдаж үлдээгээд, тэгээд 07 сарын 01 гэдэг хугацаа өгчихвөл, энэ бол ямар ч ач холбогдолгүй тогтоол болно шүү. Энийг би анхааруулаад

хэлчихмээр байна. Тэгэхээр саяын тэр гадаад зээлтэй холбоотой асуудал дээр би Дэлгэржаргалаас нэг хариу сонсчихмоор байна. Тэгээд хугацаан дээр би Наранбаатар даргаас асуух гээд байгаа юм. Энэ дээр та ер нь Их Хурлаас ажлын хэсэг байгуулаад ажиллуулаад, тэгээд энэ эрэмбийг нь хийгээд, тухайн салбар яамнууд дээр нь ажиллаад явбал яасан бэ гэдэг л санал байна.

С.Бямбацогт: Хэрэгждэггүй биш, хэрэгждэг тогтоол баталмаар байна шүү дээ. Манай Пунсалмаа гишүүн өөрөө хэрэгждэг тогтоол гарах ёстой, хэрэгжихгүй байна гэж ярьсан. Одоо энэ чинь өөрөө хэрэгжихгүй, аягүй бол янз янзын ашиг сонирхол орсон юм болох гээд байгаа юм биш биз. Наранбаатар гишүүн, Наранбаатар дарга, Төсвийн байнгын хороо хариулъя.

Н.Наранбаатар: Тийм энэ тогтоол дээр бол тэр эрэмбийг нь тогтоох, судалгаагаа хийгээд эрэмбийг нь тогтоох, үнэлэх, барих, төлөвлөх энэ үйл ажиллагааг бол Засгийн газарт үүрэг чиглэл өгсөн. Ямар нэгэн УИХ-аас ажлын хэсэг байгуулах барих тухай заалт байхгүй юм. Нэмж оруулаад ингээд явж болох бололцоотой. Тийм, бид анхны хэлэлцүүлэг дээрээ гишүүдээсээ саналуудаа авчихсан, зарчмын зөрүүтэй саналуудаа аваад л ингээд л явж байгаа. Тийм нэмж санал хүрч ирвэл бид эцсийн хэлэлцүүлэг дээрээ хэлэлцээд, ингээд бүүр цаашаа энэ чинь өргөжөөд явах нь л дээ. Анхныхаа бүүр үзэл баримтлалаас нэлээн цаашаа нэмэгдээд, хүрээ нь нэмэгдээд, хариуцлагын заалт орж ирээд, бүүр ажлын хэсэг байгуулагдаад ингээд явах юм байна л даа. Тэгэхээр санаачлагчаас тодруулсан нь дээр байх гэж бодож байна.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон хариулъя, ажлын хэсэг.

Ж.Дэлгэржаргал: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Сангийн яам, Дэлгэржаргал. Тэгэхээр гадаад зээл тусламжийн төслүүдийн хувьд яг хэрэгцээ шаардлагыг тодорхойлох 2 асуудал байгаа. 1 дүгээрт нь, яг хэлэлцээр хийгдээд явахад Засгийн газар Өрийн удирдлагын тухай хуульд тавьсан шаардлагын дагуу ТЭЗҮ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцоод, нөгөө талаас нь хөгжлийн түнш байгууллага өөрөө өөр өөрийн стандарт дүрмүүдтэй, тэрнийхээ дагуу шаардлагуудаа хангаад УИХ-аар соёрхон батлагддаг. УИХ-аас соёрхон баталсны дараа тусгайлсан хэлэлцээр бол Засгийн газар дээр хийгдээд, яг тухайн зээлийг ямар төслүүдэд, яаж санхүүжүүлэх асуудлууд деталь нь ингээд хийгдээд явж байгаа. Одоо явж байгаа нийтдээ зээлийн 74 төслийн ихэнх нь 2016 оноос хойш хэлэлцээрүүд нь яваад батлагдсан байгаа. Тэгэхээр өнөөдрийн цаг хугацаанд харахад бид төслүүдээ эргэж харах зайлшгүй нөхцөл байгаа. Тийм учраас сүүлийн 2 жил бид төслүүдийг эрэмбэлээд, нийт дүнг 370-аад тэрбумыг зарим төслүүдийг хойшлуулах.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

Ж.Дэлгэржаргал: Зогсоох хэлэлцээрийг хөгжлийн түнш талтайгаа хийгээд, энэ гаргаж авсан дүнгээ одоо явж байгаа томоохон мега төслүүд дээрээ хуваарилах зохицуулалтыг хийсэн. Цаашдаа яг энэ байдал үргэлжлээд явна. Тэгэхээр энэ нь илүү хэлэлцээрүүдийг хийхэд мэдээж зээлийн нөхцөл өөрчлөгдөж байгаа учраас хүрээ хязгаараа хумих асуудал аягүй чухал байгаа. Хөгжлийн бодлогынхоо яг тэргүүлэх чиглэлдээ бидэнд зээлийн төслүүдийг авах, одоо байгаа төслүүдээ ч гэсэн эрэмбэлэх асуудал хийгдээд явж байгаа.

С.Бямбацогт: Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: Эдийн засгийн тэргүүлэх чиглэл гээд манай сайд яг хэлчихлээ л дээ. Би Эдийн засгийн тусгай бүс, чөлөөт бүсийн хуулийг боловсруулах явцад манай Монгол Улсад нийт хэчнээн эдийн засгийн тэргүүлэх чиглэл байна вэ гээд судалгаа хийхэд 180 гэж байгаа юм. Тэгэхээр чинь 180 тэргүүлэх чиглэлтэй байхаар яаж манай Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль олигтой гарах вэ дээ. Дэлхийн ямар ч оронд 180 тэргүүлэх чиглэлтэй орон гэж байхгүй шүү эдийн засгийн чиглэлээр.

Тэгэхээр манай Эдийн засгийн яам энэ дээр жоохон ажилламаар байна. Энэ чинь тэргүүлэх чиглэлүүдээ маш тодорхой болгоод, тэгээд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиа оруулж ирэхэд төсөл, арга хэмжээ нь тэрэн дотроо явдаг байхгүй болохоор чинь, тэр чинь 180 байхаар чинь юу ч хамаагүй орох боломжтой болчихож байгаа байхгүй юу. Үндсэндээ бол хөгжлийн төлөвлөгөөнд. Энэ асуудлууд нь бид өөрсдөдөө байна, хуульдаа байна. Тэгэхээр юу гэдэг юм энэ гадаадын зээл болон энэ лизингийн чиглэлийн асуудлуудыг углуургаар нь судлаад, тэр Төсвийн хөрөнгө оруулалтын хуулиа оруулж ирэхдээ тэр нэг зохицуулалтуудаа оруулж ирмээр байх юм. Энэ дээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя.

Л.Мөнхбаясгалан: Энэ их зөв зүйтэй тогтоолын төсөл санаачлан оруулж ирж байгаа Пунсалмаа тэргүүтэй гишүүддээ баярлалаа. Цагаа олсон асуудал байна. Энд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гацаж байгаа хамгийн дээд талынх нь насжилт гэсэн чинь 16 жилийн гэж байгаа юм. Нийт 69,1 хувь нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ёстой төсөл, арга хэмжээний 69.1 хувь нь 1-ээс 4 жилийн болчихсон, 26.8 хувийн 140 төсөл, арга хэмжээ нь 5-аас 9 жилийн болчихсон, 4.1 хувь буюу 21 төсөл, арга хэмжээ нь 10 ба түүнээс дээш жилийн болчихжээ насжилт нь.

Тэгэхээр би ийм асуулт асуух гээд байна л даа. Энэ Эрчим хүчний хөгжлийн төв, Замын хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төв нь энэ төсөвт арга хэмжээг нэмэгдүүлэх магадлалыг хийснээрээ хэдэн хувийн урамшуулал авдаг юм бэ, энийг судалж үзсэн үү? Хувийн байгууллагууд хэрвээ ингэж байшин барилга, ийм сургууль, цэцэрлэг барьж байгаа бол аль болохоор түргэн хугацаанд энэ ажлаа дуусгадаг шүү дээ. Тэгэхээр улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийхээрээ ингээд удаад байдаг. Тэгэхээр энэ улсын төсвийн өгч байгаа мөнгө нь үнэхээр бага дээрээ байгаад байна уу, эсвэл энийг гацаах сонирхол аль нэг талд нь байгаад байдаг юм уу? Хөшүүргийг нь юунаас болж ингэснийг надад хэлж өгөөч. Хууль санаачлагчаас асууя даа.

С.Бямбацогт: Пунсалмаа гишүүн хариулъя, хууль санаачлагч.

Б.Пунсалмаа: Ер нь энэ төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа энэ төслүүдийн төсөвт өртөг нь нэмэгдээд байгаа. Энэ дээр олон магадлан хийдэг байгууллагууд ажиллаж байгаа. Давхар, давхар, зэрэг, зэрэг олон байгууллагууд дүн гаргаж ингэж ажилладаг юм байна лээ. Гэхдээ эцсийн үр дүн тун муу. Нэг төсөвт өртөг хэд дахин өсөх ийм шинжтэй. Жишээлбэл, зарим төсөл, арга хэмжээнээс дурдвал энэ барилгын засварын нэг төсөл 2 жилийн дотор 1000 хувь өсчихсөн байх юм. Дүүргийн спорт цогцолбор 697 хувь өсчихсөн байна, 14 жил болсон. Хөгжимт жүжгийн театрын барилга 800 суудалтай 547 хувь өссөн байна. 5 жил болсон төсөл,

арга хэмжээ магадгүй жилийн 10 хувийн инфляцтай гэхэд 50 хувь өсөж болно, тэгэхэд 500 хувь өсөж байгаа гэдэг дэндүү их өсөлт болж байгаа юм. Энийг ямар хуулиар, ямар аргачлалаар ингэж боддог вэ гэдгийг тухайн Эрчим хүчний, Барилга хөгжлийн төв, Замын хөгжлийн төвийнхөн өөрсдөө үндэслэлээ гаргаж ирж тайлбарлах байх. Магадгүй барилгын материалын үнийн өсөлттэй холбож тайлбарлах байх.

Гэхдээ барилгын материалын үнийг бид энэ эдийн засаг дээрээ тооцоод, инфляцын түвшин гээд УИХ-аараа хэлэлцдэг. Тэгэхээр ямар үндэслэлээр би энийг материалын үнийн өсөлттэй холбосон гэж хэлэхэд дэндүү учир дутагдалтай тайлбар байх гэж бодож байна. Тэгэхээр эдгээр байгууллагуудаас сонсьё гэж бодож байгаа.

С.Бямбацогт: Барилга, хот байгуулалтын яам хариулах уу? 4 дүгээр микрофон, ажлын хэсэг нэмж хариулъя.

Б.Мөнхтөр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам Мөнхтөр. Гишүүний асуултад хариулъя. Ер нь түрүүнээс хойш нэлээн магадлалтай холбоотой зохион байгуулалтын үндэслэлүүд, тэгээд хариуцлагын тогтолцоо гээд хэд хэдэн чухал асуудлууд хөндөгдлөө. Энэ хүрээнд хариултыг өгье. Ер нь төсөвт өртөгт нэмэгдэж байгаа үндсэн хэд хэдэн шалтгаан байгаа. Гол үндсэн асуудал нэг маягийн зураг төсөл гээд жишиг төсөл маягаар ингээд төсөвт ерөнхий маягаар суулгачихдаг асуудал. Энэнээс болоод ер нь төсөв нэлээн нэмэгддэг.

Нөгөөтээгүүр, батлагдсан зураг төсөл төсөвгүйгээр, таамгаар томсгосон төсвөөр энэ өртгийг төсөвт суулгаад явчихдаг. Мөн төсөвт өөрчлөлт ордог. Саяынх мэдээж тариф, цалин, барилгын материалын үнэ ханштай гээд энэ мэдээж огцом нэмэгдэхгүй, тодорхой хувиар 5, 10 хувиар нэмэгдээд явдаг ийм тогтолцоо байгаа. Бас нэг томоохон төсөв нэмэгдэж байгаа үндэслэл.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, 4 дүгээр микрофон.

Б.Мөнхтөр: Бас нэг томоохон төсөв нэмэгддэг гол үндэслэл батлагдсан төсөв зураг төсөлгүйгээр төсөвт суулгачихдаг асуудал. Энэнээс болоод тодорхой төсөл, арга хэмжээний төслүүд нэлээн огцом, огцом нэмэгдэх ийм асуудлууд байгаа. Цаашдаа энэ асуудлуудыг гаргахгүй байж чадвал төсөвт магадлалаар төсөвт өртөг нэмэгдэхгүй байх нэг үндэслэл болно.

Хариуцлагын тогтолцооны асуудал байгаа. Тогтолцооны хувьд шат шатны комиссууд, техникийн комисс, улсын комиссууд ажиллаад явж байгаа. Энэнээс холбоотойгоор чанарын асуудал хөндөгддөг. Мэдээж 100 хувь чанар хангагдахгүй, зохион байгуулалтаас хангагдахгүй байгаа. Ер нь гаргасан зөрчил дээр ААН болон экспертүүд дээр нэлээн хариуцлагын асуудлууд Хот байгуулалтын яамнаас анхаараад явж байгаа. Бид сүүлийн үед хийсэн судалгаагаар ерөнхийдөө зөрчилтэй 51 ААН дээр арга хэмжээ авах гээд явж байна. Нийтдээ 26 шинжээч, экспертүүдэд хариуцлагын асуудлыг ярьж, эрхийг нь хасах энэ зохион байгуулалтын ажлууд хийгдээд явж байгааг та бүхэндээ хэлье.

С.Бямбацогт: Үгүй ээ, одоо яг, яах вэ өвчин нүүрэн дээр нь юм харахаар зөвхөн наад талд нь биш, уг үндсийг нь арилгах ёстой. Тэрэнтэй адилхан наад барилгын норм, дүрэм, зураг төсөв зохиох, бодох аргачлал энэ юмаа хөдөлгөж

болохгүй юу? Тэгээд л ерөөсөө зураг төсөв, төсөвт өртөг нэмэгдээд л байвал түүнээс захиалагч нь санхүүждэг, түүнээс зураг төсөв зохиосон хүмүүс нь зураг төсвийн мөнгөө авдаг, түүнээс зохиогч нь зохиогчийн хяналтын зардлаа авдаг. Аль болох л их төсөвтэй байх тусам энэ олон сонирхол чинь яваад л, төсөв чинь том болчихоод байна шүү дээ. Тэрийг татвар төлөгчдийн мөнгө, тэрийг ард түмний мөнгө гэж хараад яаж хэмнэх вэ гэдэг тийм үнэлгээтэй болчихвол наад барилгын зураг төсөв чинь эхнээсээ өсөх нь жоохон бодитой болчихно шүү дээ. Энэ дээр та бүхэн ямар бодлого хийж байгаа юм бэ? Ийм өөрчлөлт хийх талаар бодол байгаа юу? Хариул даа, 4.

Б.Мөнхтөр: Таны асуултад хариулъя. Ер нь магадлал хийснийхээ, ер нь зураг төслийн үнийн 5 хувийг экспертүүд авах одоогийн дүрмээр зохицуулалт хийж байгаа. Цаашдаа бид зохион байгуулалт дээр ер нь энэ зохион байгуулалтын ажлыг хөндлөнгийн зөвлөх үйлчилгээнд шилжүүлэх, нөгөөтээгүүр энэ үе шатыг цөөлөх цахимжуулах, хугацааг богиносгох гээд энэ дүрэм, журмын зохицуулалтуудыг хийж байгаа. Ер нь цогц агуулгаар Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр энэ харилцаануудыг нэг бүрчлэн суулгаад явж байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

С.Бямбацогт: Хариулт нь ерөөсөө тодорхой биш. Төсөвт өртгөөс тэр 5 хувийн зардлыг олон талын сонирхолтой хүмүүс нийлээд аваад байгаа. Тэрбумаас 5 хувь гэдэг чинь 50 сая, 2 тэрбум болгочихвол 100 сая, 5 тэрбум болгочихвол 500 сая. Тэгэхээр тэд нар чинь 500 саяыг авахын тулд нэгдмэл сонирхолтой болчихоод л, улсын төсөв юм чинь яадаг юм, улсаас гарч байгаа мөнгө, ард түмний мөнгө юм чинь, бидний мөнгө биш юм чинь ямар хамаатай юм гээд хувийнхаа байшин барихад тийм зардал гаргахгүй шүү дээ. Та бүхэн яг тэр сумд баригдсан сумын төв дээр Нутгийн удирдлагын ордны барилгыг хэрэв хувьдаа барьсан бол хэдэн төгрөгөөр барих вэ, улсын төсвийн хөрөнгөөр, татвар төлөгчдийн мөнгөөр барьсан нь хэдэн төгрөг болчихоод байна харьцуулаад гаргахад л наана чинь тэмээ, ямаа шиг юм харагдаж байгаа шүү дээ. Энийгээ л нэг зөв, бодитой үнэлдэг, урамшуулал, тэр захиалагчийн хяналт, зохиогчийн хяналт, зураг төсвийн мөнгө нь өгдөг болчихвол энийгээ л шийдмээр байна шүү дээ. Энэ дээр ерөөсөө тодорхой хариулт өгчихгүй юм. Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Сүүлийн 3 жилд 522 төсөвт өртөгтэй энэ байгууламжуудын гуравхан жилд 1.9 их наядар өссөн байгаа байхгүй юу. Энэ дотор 10-аас дээш жил болж байгаа нь манай Дундговь аймгийн Сайнцагаан сумын Төв халхын дуулалт жүжгийн театр, мөн Сайнцагаан сумын усан бассейн бүхий цогцолбор барилга гээд. Тэгэхээр магадлал хийж байгаа энэ Эрчим хүчний хөгжлийн төв, Замын хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төвийнхөн хэдэн төгрөгийг нь урамшуулалд авдаг юм бэ? Үнийг нь өсөх тусмаа авч байгаа урамшуулал нь нэмэгдэж байна гэж ойлгож байна шүү дээ, мөн үү? Энийг надад хэлээд өгөөч. 16 жил гацсан байна гэдэг чинь арай дэндүү байна шүү дээ, 1.9 их наяд чинь их мөнгө шүү дээ.

С.Бямбацогт: Хариулъя, ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Тодорхой хариулъя. Гишүүд тодорхой асуугаад байхад л нэг бөөрөнхий хариулт өгөөд байх юм. Маш тодорхой асуулт асуугаад байна шүү дээ.

Г.Мөнхболд: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Зураг төслийн үнийн 5 хувийг Барилгын хөгжлийн төв авч байгаа. 5 хувийнхаа 30 хувийг нь зохион

байгуулалтад, 70 хувийг нь тухайн зураг, төслийг үзсэн экспертэд олгож байгаа. Тийм.

С.Бямбацогт: Тэгээд ерөөсөө эндээс л эхлээд байгаа шүү дээ. Дараад нь магадлал хийж байгаа. Нэг шалтаг олж байгаад, цахилгааны үнэ өссөн, шатахууны үнэ өссөн, барилгын материалын үнэ өссөн шалтаг олж байгаад нөгөө 5 хувийг хувааж авч байгаа нөхдүүд маань нэгдмэл сонирхолтой болоод л магадлал хийгээд л үнэ өсөхөөс өөр аргагүй гаргаад өгчихдөг. Мэндбаярын Мандухай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: Энэ тогтоолын төсөл өөрөө чухал юм. Өнөөдөр бид асуудал хуульгүйдээ биш, ерөөсөө хариуцлагагүйдээ, эрэмбэлж чаддаггүй, хяналтгүйдээ л яг аргаа барж энэ тогтоолыг Пунсалмаа гишүүн бусад гишүүдийн хамт санаачилж орж ирсэн юм болов уу гэж харж байгаа. Бид энэ улсын төсвийн татвар төлөгчдийн мөнгөөр хөрөнгө оруулалтаар санхүүжих энэ төсөл, арга хэмжээний төлөвлөлтөөс хэрэгжилт хүртэл бүх үе шатад ил тод байж чаддаггүй, хариуцлага, систем, хяналт нь тодорхой бус, дутагдаж байгаа учраас энэ олон 100 тэрбум төгрөгийн хөрөнгө ийм үргүй болж байгаа ийм асуудал байгаа юм.

Хууль санаачлагчдаас энэ тогтоолтой холбоотой тодруулах хэдэн асуулт байна. Төсвийн тухай хуульд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, эрэмбэлэлт, цахим системийн талаар зохицуулалт байгаа гэж ойлгож байгаа. Мөн Засгийн газрын журмаар төсөл, арга хэмжээг үнэлэх, төлөвлөх журам батлагдсан. Гэтэл бодит байдал дээр энэ зураг төсөлгүй төсөв нь хэд дахин өсөж байгаа. Олон жил энэ царцсан төслүүд үргэлжилж байгаа. Тэгэхээр энэ асуудал өөрөө хууль байхгүйдээ биш, эсрэгээрээ хэрэгжилтгүй байгаад байгаа нь цаашлаад энэ нэг удаагийн улс төрийн шинжтэй арга хэмжээ юү, эсвэл энэ Төсвийн тухай хууль болон мөрдөгдөж байгаа журмуудын хэрэгжилтийг илүү албажуулж хариуцлагын механизм бий болгох гэж байгаа зорилготой юм уу? Энийг тодруулаад өгөөч.

Хоёрт, аудитын байгууллага олон жил дараалан энэ төсөв дээр өртөг нэмэгдсэн, дуусаагүй орхичихсон төслүүдийн талаар дүгнэлт гаргадаг. Тэгсэн ч гэсэн ижил асуудал ерөөсөө байнгын л давтагдаж байгаа. Тэгэхээр энэ тогтоолын төсөл өөрөө түүнээс ялгаатай юү гэж асуух гээд байгаа юм. Аудитын дүгнэлтийг хэрэгжүүлдэггүй өнөөгийн бидний байгаа тогтолцоо ямар хариуцлага, албадлагын механизмыг бий болгох юм бэ? Яг тодруулаад ялгааг нь хэлээд өгөөч.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль дээр улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан төсөл хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Гэтэл бодит байдал дээр улс төрийн нөлөө, эрэмбэ муутай төслүүд ингээд явагдаж ирж байгаа. 2027 оны төсөв хэлэлцэж байгаа асуудал дээр хүртэл энэ төлөвлөгөө л, яг энэ асуудлууд яригдаж байгаа хэвээр. Тэгэхээр энэ тогтоол батлагдсанаар хөгжлийн тэр бодлогын эрэмбэ, төсвийн хөрөнгө оруулалтын шийдвэр хоёр үнэхээр уялдаж чадах уу, эсвэл өнөөдрийнх шиг улс төрийн шийдвэр давамгайлаад яваад байх юм биш биз дээ гэдэг санаа зовнил байна л даа. Эндээс хариултаа авчхаад тодотгоё.

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя. Пунсалмаа гишүүн.

Б.Пунсалмаа: Мандхай гишүүний асуултад хариулъя. УИХ-ын гишүүдэд төсөв батлах онцгой эрх байдаг юм. Энэ онцгой эрхийг Засгийн газрын үйл ажиллагааны хүрээнд бид хязгаарлуулаад байгаа юм. Энэ нь PIMIS буюу хөрөнгө

оруулалтын үйл ажиллагааны цахим системд УИХ-ын гишүүд бүрэн бүтнээр нь харж чадахгүй байгаад байгаа юм. Энэ PIMIS систем дээр төсвийн санал авах, төлөвлөх, эрэмбэлэх, батлах бүх шатны үйл явцыг PIMIS систем дээр Сангийн яам, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэсгийнхэн харж байгаа, бүтнээр нь харж байгаа, шийдвэрээ гаргаж байгаа. Яг энэ төлөвлөлт, энэ PIMIS цахим мэдээллийн санд УИХ-ын гишүүд бүгдээрээ ороод энэ явцтай танилцаад шийдвэрээ гаргалцвал энд эцсийн шийдвэр буюу төсөвт тавигдах хөрөнгө оруулалтууд үр дүнтэй байж болохоор байгаа юм.

Тийм учраас энэ тогтоолын төслийн нэг хэсэг нь энэ цахим мэдээллийн санг УИХ-ын гишүүд бүтнээр нь харах гэсэн энэ тогтоолын төсөл дээр энэ саналыг оруулж өгсөн, дэмжигдсэн байж байгаа. Тэгэхээр УИХ-ын гишүүд төсөв батлагдах үед энэ төсвийг санал авах түвшнээс нь эхлүүлээд харах бололцоо нээгдэх юм гэж хэлж байгаа юм.

Хоёрдугаарт нь ер нь бид энэ хөгжлийн урт, дунд, жилийн хөгжлийн төлөвлөгөө, дээрээс нь энэ төсөв батлагдсаны дараа олон магадлан хийдэг олон шатлалын байгууллагууд, олон давхардлуудаа нэг цэгцэлмээр байгаа юм. Хэт олон, гол жанжин шугамаа харж болохоо больтол энэ олон төлөвлөлтүүд, энэ олон давхар шалгалтын тогтолцоонууд маань өөрөө манай төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт, төсвийн хамгийн үр дүнтэй захиран зарцуулалт гэдэг юмыг илүү манантуулаад, тэрийг ийм ойлгомжгүй байдалд оруулаад байгаа юм. Тийм учраас бид ер нь энэ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль гэж шинэ хууль.../минут дуусав/

С.Бямбацогт: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Тэгэхээр нэгдсэн цахим системийг бий болгохоор давуу тал үүсэх юм байна гэж хэлж байгаа. Тэгэхээр би энэнтэй холбоотойгоор тодруулах юм гарлаа л даа. Энэ нэгдсэн цахим системийг орон нутгийн төсвийн байгууллагуудтай холбоод, төслийн мэдээллийг илүү цаг хугацаанаас үл хамаарсан рийл тайм /real-time/ ил болгох ажлыг тэгвэл хэзээ эхлүүлэх вэ? Яг ямар бүтэц, эрх зүйн зохицуулалтаар хэрэгжүүлье гэсэн төлөвлөгөө байгаа вэ гэдгийг асууя?

Хоёрдугаарт, иргэн, ААН-д ямар нэгэн үүрэг үүнтэй холбоотойгоор үүсэхгүй гэж дүгнэсэн байгаад байна лээ тайлан дээр. Нэгдсэн мэдээллийн системийг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулалт, дээрээс нь хөрөнгийн зураг төсвийн шинжилгээ хийхэд орон нутагт жишээлбэл, боловсон хүчний чадавхыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байх болов уу гэж харж байгаа. Тэгэхээр энийг ямар эх үүсвэрээр, яаж зохицуулж, хэрхэн хангах вэ гэдэг асуулт асууя, тодруулъя?

С.Бямбацогт: Ажлын хэсэг, 4 дүгээр микрофон.

Ж.Дэлгэржаргал: Мандхай гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Цахим системийн хувьд төсвийн хөрөнгө оруулалтын гар утасны аппликэйшн, веб сайт байгаа Public.investment.gov.mn гээд. Энэ нь өөрөө PIMIS систем гээд явж байгаа. Сангийн яам өөрөө яг хөгжүүлээд, 19 оноос эхлүүлээд, 22 онд яг энэ системээр явна шүү гэдэг хуулийн заалтаа Төсвийн тухай хуульд оруулсан. Тэгэхээр 2026 оны төсөв дээр батлагдсан хөрөнгө оруулалт бүхий л талаараа рийл тайм /real-time/ ил тод, нээлттэй байгаа.

Нөгөө талд нь болохоор энэ систем өөрөө хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй. Олон нийтэд зориулсан хэсэг, нөгөөдөх нь хөрөнгө оруулалтын үндсэн үйл ажиллагааг явуулах бүрэлдэхүүнтэй. Тэр утгаараа бид сумдаас авхуулаад төлөвлөлтийн асуудал жил бүрийн 3 дугаар сарын 1-нд бүх сумд төлөвлөлтөө хийгээд, аймгууд хийгээд, яг энэ цаг үед аймгууд маань төлөвлөлтөө цахим систем дээр хийж байгаа. Тэгэхээр энийг цаашаа илүү нээлттэй болгоход бид эх үүсвэрүүдээ нэмэх асуудал байгаа. Үүн дээр нэмээд орон нутгийн төсөв, төрийн өмчит компани.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчих уу?

Ж.Дэлгэржаргал: Зээл, тусламжийн асуудлууд гээд. Энэ систем яг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжиж байгаа, ямар нэгэн компани хийдэггүй. Хувь Монгол инженерүүд хөгжүүлээд, Сангийн яам дэргэдээ энэ системийг хөгжүүлээд явж байгаа. Өөрөөр хэлбэл энэ системээр яваагүй тохиолдолд санхүүжилт олгодоггүй. Дээрээс нь яг энэ систем дээр төлөвлөлт яваагүй бол төсвийн төсөлд тусгадаггүй. Систем өөрөө яг зөвхөн саналуудыг нэгтгэх гэхээсээ илүүтэй 2010 оноос хойших бүх хөрөнгө оруулалтын мэдээлэл, өөрөө мэдээллийн 8 дэд системтэй. Дээрээс нь аргачлалуудыг хэрэгжүүлэх систем байгаа. Санал илгээгээд зөвхөн нэгтгэдэг биш, эндээ аргачлалаа хийдэг, үнэлдэг, эрэмбэлдэг. Өнгөрсөн жилийн хувьд бид үүн дээр их өгөгдлийн системийг оруулаад, анх удаа боловсролын салбар дээр зөвхөн хэрэгцээнд тулгуурлаж гуравхан шинэ сургуулийн барилгыг өргөн барьж байсан. Батлагдахдаа Их Хурал дээр 10 сургууль нэмэгдэж байсан. Тэгэхээр энэ систем өөрөө мэдээлэл дээрээ суурилад илүү оновчтой хөрөнгө оруулалтуудыг төлөвлөөд, төлөвлөснийх нь.../минут дуусав/

С.Бямбацогт: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ УИХ-ын тогтоолыг дэмжиж байгаа. Чухал тогтоол. Бид хэд энд тараагдсан материалууд дотроос нэг хэдэн тоо байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд 1.9 их наяд, энэ ер нь ямар хэмжээний мөнгө юм бэ? Ойролцоогоор 4 тэрбум төгрөгөөр нэг цэцэрлэг ч юм уу, сургууль, соёлын төв гээд ингээд тооцоолж үзэхэд 500 барилга, объект барьчих хэмжээний мөнгө. Тэгэхээр эд нар чинь ингээд нөгөө өмнө нь төсөвлөгдөөд, улсын төсөв дээр суучихсан юмнууд дээр нэмээд төсөвлөгдөөд, тодотголоор ингээд ороод юм уу явчихаар энэ их мөнгө ингээд шинэ юм руу биш, хуучин юм дээр нэмэгдээд алга болчихоод байгаа юм. Улаанбаатарын машины түгжрэл шиг л ингээд ар араасаа энэ солигдох, шинээр бариулах энэ байшингуудын дараалан түгжрэл үүсчхээд байна л даа.

Сая ингээд хөдөө орон нутгаар, тойргоор явахад сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, тамгын газар бараг л сум болгонд ихэнх нь 50-60, 40-өөс дээш жилийн насжилттай ингээд сольё, их засвар хийе гэдэг асуудлууд ярьж байгаа. Үнэхээр магадлангаар ороод, дотор нь үйл ажиллагаа явуулах боломжгүй болчихсон газрууд ч маш их байна. Тэгээд ингээд энийг шийдэх гэхээр яг энэ нөгөө гацаанууд чинь тээг болчихоод, хамаг хөрөнгө оруулалтын мөнгө нь ингээд гуравхан жилд 1.9 их наядараа өмнө нь төсөвлөгдсөн мөнгө рүү ороод алга болчихоод байна л даа. Тэгэхээр энэ асуудлыг гацааг нь гаргаж, яаралтай шийдэж, зөв голдиролд нь оруулах асуудал учраас энэ Их Хурлын тогтоолыг дэмжиж байгаа юм.

Хэдэн тодорхой асуулт асууя. Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгон буюу 3 дугаар баг дээр 420 сая төгрөгөөр баригдаад гүйцээгүй бие засах

газар байна гэвэл та нар итгэх үү? Бие засах газар ч юу байх вэ, анхны зориулалт нь халуун ус гэж зориулалтаар баригдаж байгаад гүйцэлгүй зогсоод, тэгээд тэнд ерөөсөө л бааж шээдэг бие засах газар болоод хувирчихсан. Энэ асуудал дээр Барилгын яамнаас хүн байвал нэг энэ 420 саяын асуудлыг хэлээд өгөөч?

Зам, тээврийн яамнаас энэ Төв аймгийн Мөнгөнморьтын замын асуудал бараг 7-8 жил рүүгээ орлоо. Төсөв, мөнгөө бүгдийг нь авчихсан, зам тавигддаггүй. Энэ нөгөө нэг жишээнүүд нь байхгүй юу. Яг энэ шиг жишээ зөндөө байна. Сангийн яамнаас энэ ахмадын өргөөг ер нь хамгийн сүүлд хаана барьсан бэ? Төсөв дээр тавигдсан уу? Энэ дээр нэг нэмэлт хариулт өгөөдхөөч. Ийм 3 тодорхой асуудлууд дээр хариулт авъя.

С.Бямбацогт: Хэн эхэлж хариулах вэ? Сангийн яам эхэлж хариулъя, дараа нь ЗТЯ, Барилгын яам.

Ж.Дэлгэржаргал: Туваан гишүүний асуултад хариулъя. Сангийн яам, Дэлгэржаргал. Ахмадын хөгжлийн төвийн хувьд сүүлийн 2 жил шинээр тусгагдаагүй байгаа. Яагаад гэхээр ер нь сүүлийн 2 жил хөрөнгө оруулалтыг тооноос илүү чанарт анхаарсан. 25, 26 онд батлагдаж байгаа хөрөнгө оруулалтын төслийн тоо өмнөх онуудтай харьцуулахад 2 дахин буурсан байгаа. 2023 оноос өмнөх онууд дандаа мянгаас дээш төсөл батлагддаг байсан. Тэгээд энэ тохиолдолд яг төсвийн жилийн хугацаа, барилгын улиралд төслүүд маань амжиж хэрэгжиж амждаггүй. Тийм учраас 2 дахин бууруулаад, илүү цөөн тооны төслүүдийг богино хугацаанд хэрэгжүүлэх бодлого барьж байгаа. Ахмадын хөгжлийн төвийн хувьд, жишээлбэл, 26 оны төсвийн төслийн саналыг аваад, бид иргэдийн саналыг авч үзэхэд шаардлагагүй хөрөнгө оруулалтуудад иргэд саналаа өгсөн. Соёлын төвийн барилга, конторын барилгууд, ахмадын хөгжлийн төв. Иргэдийнхээ санал дээр үндэслээд 26 онд анх удаа яг ийм хөрөнгө оруулалтуудыг тусгалгүй өргөн барьсан байгаа.

С.Бямбацогт: БХБЯ хариулъя. Хариултаа бэлдэж бай л даа, одоо болтол тэгээд хэн хариулахаа мэдэхгүй суугаад байдаг юм уу? 4 дүгээр микрофон.

Т.Мөнхтөр: БХБЯ, уучлаарай дарга, нөгөө хөрөнгө оруулалт талаасаа Сангийн яам сая хариулчихлаа. Энийг туухайчилж танд дараа нь тодруулаад бичгээр хариу өгье. Энэ нөгөө гүйцэтгэлийн явцтай асуудал.

С.Бямбацогт: Бичгээр хариулт өгнө шүү.

Т.Мөнхбаяр: Ойлголоо. ЗТЯ, тэр Мөнгөнморьтын зам олон жил болчихлоо, юу болсон бэ? Мөнгөө авчихсан гэж байна. БХБЯ-наас бичгээр тэр Сэлэнгийн Шаамар сумын асуудлыг хариулна шүү.

Ч.Сугармаа: Туваан гишүүний асуултад хариулъя. ЗТЯ, Сугармаа. Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам 60 километр. Анх 2019 онд гэрээ байгуулж хэрэгжиж эхэлсэн, анхны төсөвт өртөг 48 тэрбум, магадлал хийгдээд 52 тэрбум болсон байна. Хэрэгжиж эхэлснээс хойш 28 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна. Удааширсан шалтгаан түншлэлээр "Тотал-Инж" болон "Ринг Рөүд" гэж 2 компани тендерт шалгарч авсан. Ажил гүйцэтгэх явцад түншлэл задраад, хоорондоо шүүхийн маргаан үүссэн. ЗТЯ-наас гэрээг цуцалсан. Гэрээ цуцлагдаад Тотал-Инж түншлэлийн толгой компани Тотал Инж шүүхдэж, Тотал Инж-ийн талд.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа гүйцээе, 4 дүгээр микрофон.

Ч.Сугармаа: Тотал Инж компанийн талд шүүхийн шийдвэр гарсан. Тийм болохоор ЗТЯ-наас шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүднээс гэрээг сунгасан. Тотал Инж компани өнөөдрийн байдлаар ажил эхлээгүй байна. Шалтгаан нь ахин зураг төсөв ажилд магадлал хийлгэх шалтгаантайгаар ажил эхлээгүй байна.

С.Бямбацогт: Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя, алга байна. Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Яах вэ, энэ чинь нөгөө ер нь жоохон сайжирчхаад байгаа л энэ шүү дээ. Нөгөө өмнө нь УИХ дээр гишүүд нэг жоохон жижигхэн юм оруулчхаад батлуулчихдаг, үнийн дүн багатай, тэгээд дараа нь тэрийгээ ингээд нэмэх гэж явдаг л нэг ийм байсны гай ингээд засагдаагүй. Тэгээд яах вэ сайжруулсан нь 3 жил болсон гэвч ингээд асуудлууд ингээд л яваад байна л даа. Тэр түрүүний тэр ахмадын хөгжлийн төв дээр ингээд манай Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын иргэд маань, ахмадууд маань ялангуяа харж байгаа байх. Өчигдөр бүр маш олон ахмадууд хэлсэн. Тэгээд УИХ-ын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд, Далайн Батбаяр, бид 3-т та нар нэг л зүйлийг энэ 2027 оны төсөв дээр заавал шийдээрэй, бид хэд ахмадын хөгжлийн төвгүй байгаа гэсэн. Тэгээд яг бодит байдал дээр нөгөө тамгын газрын барилга, ахмадын хөгжлийн төвүүд ингээд төсөв дээр тусгагдах боломжгүй гэсэн хариултыг албаныхан өгч байна шүү.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Эцсийн хэлэлцүүлэг дээр энэ тогтоолоо нэг жоохон цэгцлээд, илүү үр дүнтэй хэрэгжих боломжтой болгоод оруулж ирье. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлмээр байна. Хариуцлагагүй төсөвлөдөг, төлөвлөдөг, төсөвт өртөг нь үндэслэлтэй, үндэслэлгүйгээр нэмэгддэг, олон жилээр сунжирдаг энэ юмандаа нэг цэг тавимаар байна. Нэгэнтээ УИХ-аас тогтоол гарч байгаа бол арай жоохон үр дүнтэй тогтоол болох талд нь анхаараач. Төсвийн байнгын хороо энэ талдаа анхаар. Дээрээс нь зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалт биш, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хамруулъя. Тэр гаднын зээл, тусламжаас үр ашиггүй зарцуулагдаж байгаа зүйл байсан, тэрийг яах юм, анхаарч оруулъя.

Мөн бусад эх үүсвэрүүд, ТӨК-уд чинь цаана чинь хэдэн их наядоор нь ингээд л хөрөнгө оруулалт хийдэг гээд бөөн асуудлууд яригддаг, баахан зардал гаргадаг компаниуд, төслийн компаниуд. Олон жил Эгийн голын УЦС барина гээд л баахан л мөнгө хийсэн, хаачсан. Таван толгой цахилгаан станц барина гээд баахан компани байгуулаад, баахан зардал гарсан, зураг төсөв хийсэн юм хааччихсан. Нэг иймэрхүү юмнуудаа нэг цэгцлэх хэрэгтэй байна. Тэгээд нэгэнтээ тогтоол батлах гэж байгаа бол ажилласан шиг ажиллаад, нэг гаргасан шиг гаргамаар байна энэ тогтоолоо. Энэ талдаа анхааръя. Сангийн яам энэ талд нь Эдийн засгийн хөгжлийн яам туслаад өгөөч. Энэ талаасаа эцсийн хэлэлцүүлгээр анхаарч ажиллаарай гэдгийг чиглэл болгоё.

Санал хураалт явах ёстой, санал хураалтын ирц зааланд танхимд арай дүүрээгүй байна. Гишүүдийг санал хураалтдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Тэр болтол дараагийн асуудлынхаа танилцуулга явуулж байя. Гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг дуудаж байна.

16.17 цаг

Найм.Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүн 2026.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг УИХ-ын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн танилцуулна. Энэ илтгэлүүдийн дараа санал хураалт явна шүү. Гишүүдээ танхимдаа, Алтангэрэл гишүүн, Пунсалмаа гишүүн санал хураалт явна шүү дээ одоо. Тэгье. Удахгүй эх үрсийн баяр болох гэж байгаа манай хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг санаачилсан гишүүдийг танилцуулгаа хийнэ үү хэмээн урьж байна. Бадамсүрэн гишүүн. Бадамсүрэн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан нарын гишүүд өргөн барьсан байгаа.

М.Бадамсүрэн: УИХ-ын дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ.

Монгол УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон Алсан хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшсан, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана. Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоог бүрдүүлнэ. Хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлдэх хөгжүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгоно. Сургууль бүрд спорт, урлагийн заал, номын сан бүхий хүүхдийн цогц хөгжлийн төвийг үе шаттайгаар байгуулна. Биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэвхтэй амьдралын дадал төлөвшүүлэх насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ хэмээн тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй салбар дундын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлнэ. Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог иргэд, олон нийтийн оролцоотой бүрдүүлж, гэр бүл, нийгмийн орчинд дахь хүүхэд хамгааллыг сайжруулна. Сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж, хүүхдийн хөгжих таатай орчныг бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, хөгжил, хамгааллын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэнэ. Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие эх, эцгийн хөдөлмөр эрхлэлт, асрахуй, эдийн засгийг дэмжих бодлого баримтална. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ гэж тодорхой заасан.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын

тухай хуулиар хүүхдийн эрх хамгаалал, боловсрол, хүүхдийн хөгжлийг дэмжих зорилго, ерөнхий чиг үүрэг тусгасан хэдий ч хэрэгжилтийг хангах механизм дутмаг, тодорхойгүй байна. Хүүхдийн оролцоонд суурилсан хөгжлийг дэмжих, нас насанд нь тохирсон хөгжлийн үйл ажиллагаанд хөгжлийн ялгаатай байдал, олон янз байдлыг харгалзан үзэж тэгш хамруулах, үүнтэй уялдаатайгаар хот ба хөдөөгийн ялгааг арилгах, багш, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг олон асуудал шийдлээ хүлээж байгаа бөгөөд эдгээрийг салбарын бодлогоор бус, салбар дундын, улсын хэмжээнд хэрэгжүүлэх нэгдсэн зохицуулалт бүхий хууль зүйн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа тул хүүхэд бүр хөгжлийн үйл явцад тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэх, хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагааг төрөөс дэмжих, санхүүжүүлэх, зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 5 бүлэг, 20 зүйлтэй бөгөөд дараах үндсэн зохицуулалтуудыг тусгасан. Үүнд: 1 дүгээр бүлэгт хуулийн зорилт, Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн зорилго, хуулийн үйлчлэх хүрээ, хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд баримтлах зарчим, хуулийн нэр томъёоны тодорхойлолт зэргийг тодорхойлно. 2 дугаар бүлэгт хүүхдийн хөгжлийг дэмжих, хичээлээс гадуурх хөгжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалт, чиглэл, хүүхдийн оролцоо, эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг, оролцоо зэрэг асуудлыг тусгана. 3 дугаар бүлэгт төрийн байгууллага болон оролцогчийн эрх, үүргийг тодорхойлно. 4 дүгээр бүлэгт хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг зориулах эх үүсвэр, түүнийг зарцуулах журмын зохицуулалтыг заана. 5 дугаар бүлэгт Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зэргийг тус тус тодорхойлно.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хууль болон нэгдэн орсон олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх механизм бүрдэж, хүүхдийн хөгжлийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ. Мөн нөгөө талаар биеийн тамир, урлаг, спорт болон олон төрлөөр өөрийгөө хөгжүүлэх нь хүүхдийн бие даасан хувь хүн болж төлөвших, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэж, улмаар хувь хүн болон нийгэм, эдийн засгийн хэмнэлт гаргах нөхцөл бүрдэх билээ. Хүүхэд чөлөөт цагаа үр ашигтай өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд зориулах тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгөтэй болж, хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулж буй бүх хэлбэрийн байгууллага, ААН-үүд, боловсрол, сургалтын байгууллагуудын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Танилцуулж дууслаа, баярлалаа.

С.Бямбацогт: Бадамсүрэн гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Ганбатын Хосбаяр танилцуулна. Таныг индэрт урьж байна. Хосбаяр гишүүний танилцуулгын дараа гишүүдээ санал хураалт явна шүү. Хуулийн төслүүдийг эцэслэн батална. 64 гишүүн байх ёстой. Агаарын түлштэй холбоотой, агаарын түлшний хэлэлцээр соёрхон батлах 64 гишүүн сууж батлах ёстой. Тийм болохоор гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Хосбаяр гишүүн танилцуулга хийе.

Г.Хосбаяр: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ.

Монгол УИХ-ын гишүүн Бадамсүрэн нарын 21 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 5-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хүүхдийн оролцоонд суурилсан, хүүхдийн насанд тохирсон хөгжлийн үйл ажиллагаанд хүүхдийг тэгш хамруулах, багш, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг олон асуудлыг шийдвэрлэх нэгдсэн зохицуулалт бүхий цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар хуулийн төсөлд заажээ. Хуулийн төслийг баталснаар Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, Үндсэн хуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тогтолцоо болон хүүхдийн хөгжлийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, биеийн тамир, спорт, урлаг зэрэг олон төрлөөр өөрийгөө хөгжүүлэх, хүүхэд бие даасан хувь хүн болж төлөвших, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэнэ гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төсөлд өөрийн хүсэл сонирхлын хүрээнд оюун ухаан, бие бялдар, авьяас чадвар, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих хөтөлбөр, сургалт, дугуйланд хамрагдан ирээдүйн бие хүн болж төлөвшихөд нь төрөөс бодлого болон санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх чиглэл, хэлбэр, арга зам, хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн байгууллагуудын чиг үүрэг, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зарчим, үүрэг, хариуцлага, хяналтын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ыг баримтлан Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдаж, 2026 оноос хэрэгжиж эхэлбэл Монгол Улсын 6-16 насны 800 мянга орчим хүүхдийн 1 сарын хичээлээс гадуурх сургалтын зардлыг дунджаар 50 мянган төгрөг байхаар төлөвлөж, 6 сарын хугацаанд хамрагдах 300 мянган төгрөгийг төрийн зүгээс дэмжлэг үзүүлж, жилдээ 240 орчим тэрбум төгрөгийг Ирээдүйн өв сан болон Хуримтлалын сангаас зарцуулах шаардлага гарна гэж хууль санаачлагчид үзжээ.

Хуулийн төслийг d.parliament.mn сайт хуудсанд байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байна. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэх үед УИХ-ын гишүүн Наранбаяр санхүүжилтийн эх үүсвэр, Үндэсний баялгийн сангийн оролцоо, хүүхдийн хөгжлийн төвийн зохион байгуулалт, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаар, УИХ-ын гишүүн Галбадрах хуулийн хэрэгжилтийн бэлтгэл, барилга байгууламж, тоног төхөөрөмж, хүүхдийн хамрагдалт, сургуулийн орчинд хэрэгжүүлэх боломж, багшлах боловсон хүчний талаар, УИХ-ын гишүүн Чинбүрэн хүүхдийн бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдал, сэтгэл зүйн дэмжлэгийг хуульд хэрхэн тусгах талаар, УИХ-ын гишүүн Энхтуяа санхүүжилтийн тогтолцоо, эрхийн бичиг, Ирээдүйн өв сангийн хөрөнгийг ашиглах боломжийн талаар, УИХ-ын гишүүн Саранчулуун хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын хүртээмж, сургуулийн орчин болон нийгмийн дэмжлэгийг хэрхэн сайжруулж, тэднийг тэгш хамруулах, хөгжүүлэх талаар, УИХ-ын гишүүн Рэгдэл сургалтын байр, багшлах боловсон хүчний талаар,

УИХ-ын гишүүн Хосбаяр хөдөө сумдын төвд хүүхдийн хамрагдалтыг хэрхэн шийдэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан УИХ-ын гишүүн Наранбаяр санхүүжилт, барилга байгууламжийн ашиглалт, эрхийн бичиг, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах талаар, УИХ-ын гишүүн Саранчулуун хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын хүртээмжийн талаар, УИХ-ын гишүүн Мөнхтуяа Дорнод аймгийн хэмжээнд хэрэгжүүлж туршсан "Хүн болох багаасаа" төслийн үр дүнгийн тухай дурдаж хуулийн төслийг дэмжиж байгаа талаар тус тус үг хэлсэн болно.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцогчдын олонх буюу 65.4 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 80.7 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Хосбаяр гишүүнд баярлалаа. Гишүүд санал хураалтад одоогоор танхимд 108 гишүүн ирцэд орсноос 50 гаран гишүүн байна. Газрын тос, Агаарын хөлгийн түлшний хэлэлцээрийг 64 гишүүн эцэслэн батлах ёстой. Гишүүд орж ирэх хэрэгтэй байна. УИХ-ын дэд дарга нар, бүлгийн дарга нар, бүлгийн дэд дарга, бүлгүүдийн ажлын алба, Хуралдаан зохион байгуулах газар гишүүдийнхээ ирцийг сайжруулахад анхааръя. 53 байна, 64 болж байж бид эцэслэн батлах ёстой. Тэр болтол ажлын хэсэг танилцуулж байя.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, УИХ-ын гишүүн Бадамсүрэн нарын 21 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж байгаа. Ажлын хэсэг Балжиннямын Баярсайхан Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга, Батсүхийн Бадамжав Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Цэндийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга, Сөртөөний Пүрэвсайхан Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч, Батжаргалын Мөнх-Эрдэнэ Нийслэлийн боловсролын газрын ахлах мэргэжилтэн, Жанцандоржийн Азжаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хууль тогтоомж, бодлого төлөвлөлт хариуцсан шинжээч, Лувсансодовын Бадамцэцэг Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газрын Хүүхэд, гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Мягмаржавын Отгонгэрэл Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Отгонбаярын Энхмэнд УИХ-ын гишүүний зөвлөх, Болдбаатарын Энхчимэг хуульч, Бямбадоржийн Саруул судлаач.

Ажлын хэсгийн гишүүдэд хууль сануулъя. УИХ-д хүндэтгэлтэй хандах, УИХ-ын гишүүдийн асуусан асуултад үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх үүрэгтэй. Худлаа мэдээлэл өгөх, УИХ-д хүндэтгэлгүй хандвал УИХ-ын тухай хуульд заасан хариуцлага тооцож болохыг анхааруулъя.

16.31 цаг

Гишүүд ээ, санал хураалтаа эхлүүлье, үүний дараа асуулт, хариултаа явуулъя. Ардчилсан намын бүлгийн дарга, дэд дарга, Их Хурлын дэд дарга, тийм үү. Эцэслэн батлахаас бусад санал хураалтаа явуулж байя. Санал хураалтаа явуулчхаад араас нь хэлэлцчихье. Санал хураалт, одоо Байнгын хороодын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. 52 гишүүн бэлэн болсон, 57 гишүүн бэлэн бус байна. Хуралдаан зохион байгуулах албаныхан бэлэн болоогүй гишүүдэд хэлж өгөөрэй. Өнөөдрийн юмаа өнөөдөртөө дуусчихвал. Гишүүдийг санал хураалтдаа, бүртгэлийн санал хураалт, ирцийн санал хураалт явуулъя. 62 гишүүн ирц бүртгэлд орсон байна, татгалзсан гарч байгаа 47 гишүүн чуулганы танхимд хүрэлцэн ирж санал хураалтад оролцоно уу. Нэр нь гарч байгаа байх, цаашдаа энэ нэрийг ингэж гүйлгэхгүй, байнга тавьдаг болох гэж байгаа. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна гэж заасны 4 жил гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Ерөнхийлөгчийг 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно гэснийг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 62 гишүүн буюу 56.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Байнгын хороодын саналаар санал хураалт явуулж дууслаа. Байнгын хороодын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай УИХ-ын тогтоолын төслийг баталсанд тооцлоо. УИХ-ын гишүүддээ талархал илэрхийлье.

Байнгын хороодын гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Хуралдаан зохион байгуулах хараад хэлээд өгөөрэй, сая 63 гишүүн байгаа мөртөө 59 гарч байна шүү, санал хураалтдаа бэлдсэн гишүүд. Санал хураалт явуулна.

Байнгын хороодоос Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 61 гишүүн буюу 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, аль нэг нам, бүлэг, эвсэлд, бүлэгт харьяалагддаггүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 9 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Улсын Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

Тогтоолын төслийн нэрийн “хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар” гэснийг “хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар” гэж өөрчилж, төслийн тэмдэглэх хэсгийн “Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Наранбаатар гишүүн гүйцээн боловсруулах чиглэл авч байгаа юм байна. Гүйцээн боловсруулах чиглэл аваад, саналаа хойш татлаа.

2.Тогтоолын төслийн 1.1 дэх заалтын “хугацаандаа” гэсний өмнө “эсхүл бусад шалтгаанаар” гэж нэмж, “тодорхой үзүүлэлт, аргачлалын дагуу” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 109 гишүүн санал хураалтад оролцож, 70 гишүүн буюу 64,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 1.1 дэх заалтын “2026 оны 07 сарын 01-ний өдрийн дотор” гэснийг “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд” гэж өөрчлөх. Санал гаргасан Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар. Гүйцээн боловсруулах чиглэл авлаа, саналаа хойш татлаа.

4.Тогтоолын төслийн 1.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Энэ тогтоолын 1.1 дэх заалтад заасан тайланд тусгагдсан төсөл, арга хэмжээг хуульд заасан өмчлөлийн өөр хэлбэрт шилжүүлэх, эсхүл хууль зүйн тодорхой үндэслэлтэйгээр цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэх эсэх саналаа энэ тогтоолын 1.1-д заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;”. Наранбаатар гишүүн бас гүйцээн боловсруулах чиглэл авч байна.

5.Тогтоолын төслийн 1.3 дахь дэд заалтыг хасах. Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар санал гаргасан. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 109 гишүүн оролцоноос 73 гишүүн буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 1.4, 1.5 дахь дэд заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/Улсын Их Хурлаар жилийн төсвийн төслийг хэлэлцэх хэлэлцүүлгийн бүх шатанд Төсвийн тухай хуулийн 29¹.4-т заасан цахим систем дэх мэдээллээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцыг Улсын Их Хурлын гишүүд нээлттэй харах боломжийг бүрдүүлэх.” санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 109 гишүүн оролцоноос 74 гишүүн буюу 67,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 2, 3 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 4 дэх заалтын дугаарыг “3” гэж өөрчлөх.

“2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Н.Наранбаатар/-нд даалгасугай.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 109 гишүүн санал хураалтад оролцсоноос 73 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.найруулгын санал. Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтын “хуульд тусгаж” гэснийг “хуулиар баталж” гэж, “анх батлагдсан” гэснийг “анхны” гэж, “буй ачаалал, дарамт” гэснийг “байгаа нөлөөлөл” гэж, “бүрээр тус бүр үнэлж” гэснийг “нэг бүрээр судалж” гэж тус тус өөрчилж, мөн дэд заалтын “талаар судалж,” гэснийг хасах. Санал гаргасан Их Хурлын гишүүн Наранбаатар. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Гүйцээн боловсруулах чиглэл авлаа.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал. 1.Тогтоолын төслийн 1.1 дэх заалтын “зогссон” гэсний дараа “, анхны төсөвт өртөг нь 50 хувиас дээшээ нэмэгдсэн,” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 75 гишүүн буюу 68.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" УИХ-ын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ. Түрүүн яригдсан асуудлуудыг цогцоор нь аваад, сайн тогтоол гаргах тал дээр эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхаарна уу. Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

16.42 цаг

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе, эцэслэн батлах санал хураалт байгаа. Сая 70 хэдэн гишүүн байсан, бас зарим гишүүд ороогүй байна шүү. Эцэслэн батлах санал хураалт учраас хариуцлагатай санал хураалт, гишүүд хурууны хээгээ уншуулсан уу?

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос 72 гишүүн буюу 66.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

УИХ-ын нийт гишүүдийн олонх дэмжсэн тул Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг эцэслэн баталсанд тооцлоо. Эцэслэн баталсан агаарын хөлгийн түлшний асуудал нь хямд, найдвартай, тасралтгүй түлшээр хангагдах боломжийг УИХ бүрдүүлж өглөө. Засгийн газар, манай Аж үйлдвэр, уул уурхай, эрдэс баялгийн яамныхан энэ талдаа маш хурдан шуурхай зохион байгуулж, Монголын иргэдийг гадагшаа, дотогшоо агаарын хөлгөөр зорчихдоо хямд үнэтэй тийзийн үнэ нэмэгдүүлэхгүй байх тал дээр илүү онцгой анхаарч ажиллаарай.

16.44 цаг

Дараагийн асуудалдаа оръё. УИХ-ын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Манай УИХ-ын гишүүн Бадамсүрэн, Мөнхбаясгалан нарын санаачилсан Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл байгаа. Нарантуяа-Нара, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууна уу.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе. Энэ Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл нь их нийгмийн хүлээлттэй хууль гэж харж байгаа. Ер нь бид өнгөрсөн хугацаанд өнөөдрийг хүртэл ихэвчлэн хүүхдийн асуудлыг дандаа эрсдэл гарсан хойно нь хамгаалах, халамжлах тактикаар явж ирсэн бол энэ хууль ь хүүхдийг урьдчилан хамгаалах, түүний хүрээнд соён гэгээрүүлэх, авьяас чадварыг нь хөгжүүлэх замаар зөв иргэн болох суурь бодлогыг тодорхойлж байгаагаараа зөв зүйтэй хууль гэж бодож байна. Хүүхдийн хөгжлийг төрийн бодлогын түвшинд авч үзэж байгаа нь талархууштай. Өмнө нь ийм хүүхдийг хөгжлийг төрийн бодлогын хэмжээнд хууль баталдаг, дээр нь төсөв батлахад нь буулгаж байсан. Гэхдээ бас нэг асуудал хөндөхөд энэ хууль батлагдаад амьдрал дээр яг таг хэрэгждэг, үр өгөөжтэй байгаасай гэж хүсэж байна.

Тиймээс хууль санаачлагчдаас үзэл баримтлалын хүрээнд хэд хэдэн зүйлийг тодруулъя. Өнөөдөр Монгол Улсад хүүхдийн хөгжлийн боломж авьяас чадвараас бус, эцэг эхийн санхүүгийн боломж, амьжиргааны нөхцөлөөс ихээхэн хамааралтай болсон байна. Нэг хэсэг нь хөгжлийн төв, гадаад хэлний сургалт, соёл, урлаг, спортын дугуйланд хамрагдаж байхад нөгөө хэсэг нь наад захын хөгжлийн үйлчилгээ авах боломжгүй хэвээр байна. Хот, хөдөөгийн ялгаа их байна, чинээлэг өрх болон олон хүүхэдтэй өрхийн боломжийн ялгаа ч маш их байна. Энэ тэгш бус байдлыг бид бодитоор харах ёстой. Тиймээс энэ хууль бодит амьдрал дээр яг энэ ялгааг багасгах уу, эсвэл дахиад зорилттой ч хэрэгжилтгүй үлддэг баримт бичиг болох уу?

Хот, хөдөөгийн хүүхдүүдийн харьцангуй байгаа хөгжлийн ялгааг яаж арилгах вэ? Олон хүүхэдтэй өрхийн хүүхдүүдийн хөгжлийн хүртээмж тэгш боломжийг хангах тусгай бодлого, дэмжлэг энэ хуульд хэрхэн тусгагдсан бэ? Гуравдугаарт нь, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хүртээмжтэй орчин, хөгжлийн үйлчилгээний тэгш хүртээмжийг хэрхэн хангахаар заасан байгаа вэ? Дөрөвдүгээрт, хуулийн үйлчлэх хүрээний насны зааг дээр хууль санаачлагчдаас зайлшгүй тодруулах шаардлагатай байна нэг байгаа нь яагаад насныг 6-аас 18 хүртэлх насны буюу сургуулийн насны хүүхдүүдийн хөгжилд чиглүүлж гаргасан юм бэ? Уг нь сургуулийн өмнөх нас буюу 0-6 насны хүртэлх хүүхдийн хөгжлийн, хөгжлийг хамгийн үр өгөөжөө өгдөгт ийм хөгжил гэж үздэг. Тэгэхээр энэ хөгжлийг бид хэрхэн, яаж дэмжих вэ?

Хүүхдийн хөгжлийг дунд нь тасалдуулахгүйгээр 0-18 нас хүртэл нь цогц системээр хармаар байна. Гэтэл 0-6 насны хүүхдийн хөгжлийн бодлогыг энэ анхдагч хууль дээрээ хязгаарлаад өгчихөөр энийг бас яаж харах вэ гэдэг асуудал байна.

Тавдугаарт, хуулийн төслийн зардлын тооцооны судалгаанд 2025 онд батлагдсан 26 оноос хэрэгжиж эхэлбэл Монгол Улсад 6-16 насны 800 мянга орчим

хүүхэд байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн 1 сарын хичээлээс гадуурх сургалтын зардлыг дунджаар 50 мянган төгрөг байхаар төлөвлөж, 6 сарын хугацаанд хамрагдах төсөвт өртгийн 300 мянган төгрөгийг төрийн зүгээс дэмжлэг үзүүлж жилдээ 240 орчим тэрбум төгрөгийг Ирээдүй өв сан болон Хуримтлалын сангаас зарцуулах шаардлагатай гэж гарсан байна. Үүнтэй холбоотойгоор хот болон төвийн аймгуудад ажиллаж байгаа шатар, зураг, код бичих, гадаад хэл эсвэл соёл урлаг, спортын дугуйлангууд сарын дундаж төлбөр дунджаар хамгийн багадаа 150-аас 300 мянган төгрөгийн хооронд байгаа. Тэгэхээр төрөөс 50 мянган төгрөгийн ваучер эсвэл дэмжлэг өглөө.../минут дуусав/

С.Бямбацогт: Нарантуяа-Нара гишүүн асуултаа гүйцээе.

М.Нарантуяа-Нара: Тэгээд төрөөс энэ 50 төгрөгийн ваучер дэмжлэг өглөө гэхэд үлдсэн 150-аас 200 мянган төгрөгийг эцэг эхчүүд халааснаасаа бүрэн төлж чадах уу? Энэ нь эргээд зөвхөн боломжтой айлын хүүхэд дугуйланд явдаг, орлого багатай өрхийн хүүхэд дахиад л энэ боломжоос гадуур үлддэг энэ байдлыг үүсгэх юм биш байгаа даа гэсэн ийм бодолтой байна. Тэгэхээр зэрэг эдгээр 5 асуудал дээр хариулт авъя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Бадамсүрэн гишүүн хариулъя, бусад хууль санаачлагч нэмж хариулж болно.

Б.Бадамсүрэн: Нарантуяа-Нара гишүүнтэй санал нэг байна, таныг дэмжиж байгаад их баярлалаа. Яг үнэн. Бүх хүүхдэд тэгш боломж олгоё л гэж зорьж байгаа. Өөрөөр хэлбэл, орлогын байдлаас, эцэг эхийнх нь байдлаас үл хамаараад хүүхэд бүрийг авьяас, ур чадвар, оюуны хөгжил, биеийн хөгжлийг нь нээн илрүүлэх ахиц, өөрчлөлт гаргахад нь төрийн бодлогоор дэмжлэг үзүүлье гэдэг зорилготой гол нь.

Хот, хөдөөгийн ялгааг арилгах нь бүсчилсэн хөгжлийн бодлогын зорилго. Энэ хүрээндээ хөдөөд үнэхээр энэ төсөл амжилттай хэрэгжиж байгаа. Яагаад гэвэл нөгөө Дорнод аймагт хэрэгжүүлсэн туршлагаас харахад сумдад 1 дүгээрт, сургууль нь нэг ээлжтэй байдаг учраас үдээс хойш нь сургуулийн барилга нь Хүүхэд хөгжлийн төв болгоно, 2 дугаарт, багш нар харьцангуй цөөн хүүхэдтэй хичээллэдэг учраас хүүхэд нэг бүртэйгээ хичээлээс бусад хичээлээс гадуур үйл ажиллагаа, секц, дугуйланд нь ихээхэн дэмжиж ингэж ажиллах боломж олгогддог.

Мөн энэ хууль дээр эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг чиглэсэн тусгайлсан ийм мэргэжлийн тоног төхөөрөмж, багштай байхаар тэр сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах энэ гүйцэтгэгч нь энэ шаардлагыг хангасан байхаар ингэж зааж өгсөн байгаа. Насны заагийн хувьд энэ яг хууль дээрээ 18 хүртэлх насны бүх хүүхдийг энэ хуулийн үйлчлэлд хамруулна гэж оруулсан байгаа. Танилцуулга дээр 6-аас 18 насны хүүхдүүд буюу ЕБС-ийн хүүхдүүдэд энэ ийм, ийм үр нөлөө үзүүлнэ гээд ингээд орсон байгаа юм. Тухайлбал энэ хуулийн 3.1-д Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа нийт хүүхдүүдийн хувьд энийг заасан байгаа.

Төлбөрийн хувьд таны хэлж байгаа үнэн. Төлбөр нэлээн өндөр байгаа. Гэхдээ чөлөөт өрсөлдөөний зарчмаар буюу дугуйлан, секцүүдийг олноор хичээллүүлээд эхлэхээр өрсөлдөөн үүсэж, үнэ багасах ийм нөхцөл байдал үүснэ. Ер нь багш нар хамгийн сайн чаддаг зүйл нь хүүхдүүддээ хичээл зааж, арга зүй эзэмшиж ажиллаж байгаа нь хамгийн чухал. Түүнээс багш уул уурхай юм уу,

барилгын бизнес эрхлээд явахад ихээхэн хүндрэлтэй. Тийм учраас багш нар хамгийн сайн чаддаг зүйлээрээ нэмэлт орлого олох боломжийг бүрдүүлэхээрээ энэ онцлог байгаа. Дээр нь энэ сургалтын төвүүдэд тулгамдаж байгаа, секц, дугуйлан хичээллүүлэхэд тулгамдаж байгаа нэг гол асуудал нь байрны асуудал байгаа юм. Өөрөөр хэлбэл, байрны түрээс өндөр байгаа учраас өчигдөр гэхэд Монгол Улсын Ерөнхий сайд бөгөөд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дарга Сүхбаатарын талбайн баруун талын хуучин нийслэлийн байрыг Хүүхдийн ордон болгож байна.

Ер нь гэртээ ойр сургууль хамгийн сайн гэдэг шиг ийм Хүүхэд хөгжлийн төвүүдийг хуучин ашиглалт багатай байгаа барилга болон сургуулийг нэг ээлжид оруулах стратегийг баримталж, үдээс хойш нь ийм хөгжлийн төв болж ажилласнаараа түрээсийн зардлыг үлэмж хэмжээгээр багасгаснаар төлбөрийг багасгах боломжтой гэж үзэж энэ дээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнхбаясгалан гишүүн хууль санаачлагчийн хувьд нэмээд хариулчихъя, дараа нь тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Нарантуяа-Нара гишүүнд баярлалаа. Тийм ээ, зарим айл чинээлэг айлын хүүхдүүд, зарим айл амьдралын боломж тааруухан, дунд зэрэг ийм байгаа нь үнэн. Тэгээд одоогоор хүүхдэд очдог 100 мянган төгрөг харилцан адилгүй түвшинд яваад байгаа. Энэ хуулийг бид хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, дараа нь явцын дунд сайжруулж болно. Хууль санаачлагчийн хувьд энийг ваучер хэлбэрээр өгч болно. Дансанд нь мөнгө биш, тухайн хүүхэд өөрөө л тэр картаараа, ваучераар энийг зөвхөн тэр дугуйлан, секц, оюуны спортод зориулдаг байхаар хуульчилж өгвөл энэ өрхийн хэрэгцээнд юм уу өөр ямар нэгэн юманд явахгүй.

6-аас 18 нас гэдэг нь ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн орнуудын хийсэн судалгаагаар манай 6-аас 11 настай 5 хүүхэд тутмын нэг нь жингийн илүүдэлтэй.../минут дуусав/

С.Бямбацогт: Тодруулж асууя, Нарантуяа-Нара гишүүн.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр ер нь ингээд хүүхдийн хөгжлийг ваучер хэлбэрээр дугуйлан, соёл, урлаг, спортод хамруулъя гэж байгаа нь яг нөгөө өмнөх чуулганаар ялангуяа тоотой хэдэн гишүүд нэлээн эсэргүүцэж байгаад унагаасан нөгөө л соёлын ваучер хөтөлбөрийн нэг төсөөтэй юм явж байгаа байхгүй юу. Тэгэхдээ би нэг юманд эмзэглээд байгаа нь энэ бид дугуйлангийн үнийг тодорхой хэмжээнд хямдралтай үнээр барих гэж байгаад ч юм уу, энэ нөгөө төр, хувийн хэвшлийн ажилд оролцохгүй байх гэдэг юмыг бид алдагдуулчих вий дээ. Хэтэрхий ингэж нөгөө дугуйлангийн үнийг барих гэж байгаад бид хувийн хэвшлийн чанартай, сайн сургуулилт бүхий энэ дугуйлангуудын үйл ажиллагаанд нөлөөлчих вий гэсэн эмээлт байна. Тэгэхдээ яах вэ явцын дунд сайжруулаад явна гэж байгаа учраас бид ч гэсэн саналаа хэлээд явах боломжтой юм байна гэж харж байна. Тэгээд ер нь ингээд хүүхдүүдийг бид ингээд төрсөн орчин, эцэг эхийн боломж, бололцоо, орлогоор ингээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнхбаясгалан гишүүн хариулъя.

Л.Мөнхбаясгалан: Дугуйлан, секцийн үнийг барина гэсэн бодлого байхгүй. Энэ чөлөөт өрсөлдөөнөөрөө явна. Гол нь бид нөгөө хүүхдэд зарцуулах мөнгийг нь өөр юманд үрдэггүй ваучер /voucher/ юм уу картаар өгөх нь зөв байхгүй юу. Мөнгөөр

өгвөл өрхийн хэрэгцээ рүү явчихна. Тэгэхээр нөгөө дахиад дундаас доош амьдралтай хүүхдүүд дугуйлан, секцэд хамаарч чадахгүй юм гэдэг ийм байгаа юм. Дугуйлан, секцэд хамруулсны үр дүн Европын орнуудаар үр дүн нь нэлээд сайн харагддаг. Энэ дээр урлагийг нэмж оруулж ирэх ёстой.

С.Бямбацогт: Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Би нэгдүгээрт, Бадамсүрэн гишүүн Дорнод аймгийн Засаг даргаар ажиллаж байхдаа маш сайн ажиллаж, манай яамтай, манай харьяа агентлагуудтай маш сайн ажилласан гэдгийг цохон тэмдэглэе. Ялангуяа яг энэ хүүхэд хамгааллын салбарт манай Нансалмаа дарга байсан шиг санаад байх юм. Халамжийнх болохоор Гэрэлмаа гэж байсан билүү дээ. Ямар ч байсан маш сайн хамтарч ажилласан. Үнэхээрийн яг энэ хүүхэд хамгаалал, хүүхэд хөгжлийн асуудалд Засаг дарга нар тухайн аймгийнхаа Хүүхдийн үндэсний зөвлөлийн дарга байж энэ асуудлыг хариуцдаг учраас Засаг дарга нар өөрсдөө энэ асуудалд анхаарах ёстой юм.

Тэгээд яах вэ, өөрийнхөө сайн туршлагыг улсын хэмжээнд хуульчлаад оруулж ирж байгаа нь нэг талдаа сайн. Ер нь үндсэндээ хуулийг хэлэлцэхийг нь дэмжиж байгаа. Би юуг нөгөө талдаа дэмжихгүй байгаад байна вэ гэхээр баялгийн сангийн энэ асуудлыг уг нь Баялгийн сан өөрөө хүн бүрд ижил тэгш ногдол ашиг нь орж байх ёстой юм. Тэгээд хүн бүр өөрийнхөө нэрийн данснаасаа боловсрол, эрүүл мэнд, орон сууцад зарцуулах эрх нь нээгдээд байгаа шүү дээ. Тэгээд хүн болгонд уг нь тэгш хуваарилах ёстой. Тэр нь хүүгийн орлого санж үү, ашиг нь санж үү, юу нь санж вэ хамаагүй. Энэ дээрээ хэдүүлээ ярилцаж болох байх.

Дээрээс нь миний санал юу вэ гэхээр өнөөдөр бид хүүхдэд зарцуулж байгаа бүхий л энэ салбаруудын ер нь хэдэн төгрөгийг юунд зарцуулаад байна вэ гэдгийг нэг хавтгай дээр авчирч харах ёстой байгаад байгаа юм. Тэгж байж зохион байгуулалтаа сайжруулах энэ бололцоо бүрдэх юм болов уу гэж харж байгаа. Хүүхдийн төлөө сан гэж бид Хүрэлсүх сайд Ерөнхий сайдаар ажиллаж байхад санаачлаад, дараа нь Оюун-Эрдэнэ сайдын үед энэ бүр албажиж яваад, тухайн үедээ шинэ жилийн үдэш 2 тэрбум төгрөг цуглаад, түүнийг дараа нь төрийн сандаа байршуулаад, одоо 24 тэрбум төгрөг төвлөрчихсөн байгаа өдий 5 жилийн хугацаанд. Тэгээд ер нь тэр зарцуулалт нь огт явахгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр би нэлээд чамлалттай байгаад байгаа.

Сүүлдээ нөгөө Автотээврийн газарч ч гэсэн азын дугаар борлуулсан тэр төлбөрөө ер нь танай яам руу шилжүүлэхгүй гээд өөрсдийнхөө хуульдаа өөрчлөлт оруулчихсан. Гэвэл Хүүхдийн төлөө сангийн хууль дээр тэр нь хэвээрээ байгаад байгаа учраас ингээд 2 хуулийн зөрчилтэй байгаад байгаа юм. Тэгээд ЗТХЯ-ны дургүйцээд байгаа юм нь юу вэ гэхээр үгүй ээ, ердөөсөө үр дүн харагдахгүй байгаад байна шүү дээ. Яагаад танайх руу жил болгон өдий хэмжээний мөнгийг төлөх юм бэ, бараг 20 тэрбум, 22 тэрбум төгрөгийг зөвхөн ЗТХЯ-наас шилжүүлчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нэг талдаа аргагүй. Тэгэхээр яг энэ хүүхдийн төлөө санаачилж байгаа бүхий л ажлуудыг уг нь нэг хавтгай дээр гаргаж ирж байгаад, тэгээд яг энэ хүүхдийн хөгжил рүү зарцуулах ёстой юм байгаа юм.

Сүүлд яригдаж байгаа асуудал нь төрийн өмчит зуслангуудын, төрийн өмчит байрнуудын засвар гээд нэг тийм бүтэлгүй юм яригдаад байх юм. Энийг уг нь төсвөөсөө хийх ёстой юм байгаа юм шүү дээ. Энийг анхаарах ёстой. Хөдөлмөр,

нийгмийн хамгааллын яам ковидын /COVID-19/ үед ч гэсэн юу гэдэг юм 20-оос 22 онд намайг ажиллаж байхад үнэхээрийн маш сайн ажлуудыг эхлүүлсэн юм байна гэдгийг дурдах нь зүйтэй гэж үзэж байна. Биднийг, намайг ажлаа өгч байхад бид чинь бүтэн жилийн хугацаанд хүүхдийн нөгөө 100 мянган төгрөгийг 50 мянган төгрөгийг нь ямар ч байсан хүүхдийн тэр дансанд нь хадгалъя, нэр дээр нь хадгалъя, 50 мянган төгрөгийг нь тухайн зорилтот бүлгийн юу гэдэг юм ээж, аав нь үнэхээрийн боломжгүй байна гээд өргөдөл гаргаад бэлнээр нь авч болно гэдэг ийм шийдвэрийг гаргаад бүтэн жил хэвшээд явчихсан байсан. Тэгээд дараагийн бэлтгэл нь юу байсан юм бэ гэхээр хүүхдийн ийм картаар тухайн зөвхөн хүүхдэд зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ дээр ажилладаг байх. Тэгээд энэ асуудлыг манай Шижир санаж байвал, даргаа би 2 минутаа юм уу нэг минутаа авчихъя, тэгэх үү, миний минут дуусчих гээд байна. Тэгээд яг энэ асуудлаар тухайн үедээ Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллаж байсан Шижир санаж байгаа байх. Бид тухайн үед хамтдаа ярилцаад ердөөсөө энэ хүүхдийн мөнгө хүүхдэдээ очихгүй байгаад.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа асууж амжсангүй, хариултаа асуучихъя. Асуулт юу билээ, асуултаа асуучихъя.

А.Ариунзаяа: Хүүхдийн мөнгө хүүхдэдээ зарцуулагдахгүй байгаад байгаа учраас энийг бусад улс оронтойгоо адилхан, нэн ялангуяа Исландтай адилхан хүүхдийн картаар нь дамжуулаад, хүүхэд хөгжил, өөрт нь хэрэгтэй бүтээгдэхүүн, хийжүүлсэн ундаа гэдэг юм уу, буруу чипс ийм юман дээр ажилладаггүй ийм хөтөлбөр болгоё гээд бид эхний бэлтгэл ажлуудаа явуулж байсан. Энэ картаар ажиллах боломжтой гэдгийг бид хүнс, тэжээлийн дэмжлэг дээрээ туршаад, одоо хүртэл хүнс, тэжээлийн дэмжлэг нь И-баримтын /E-barimt/ тухайн бүтээгдэхүүний кодоор нь зөвхөн тодорхой бүтээгдэхүүнүүд дээр л ажилладаг. Энэ бүх туршилт, юмнууд нь хийгдчихсэн. Тэгээд Учрал дарга өчигдөр хүүхдийн мөнгийг хүүхдэд нь л зориулна гэж их зөв юм хэлж байна лээ. Тэгэхээр яг хэчнээн хүүхдийн оролцооны байгууллага, дугуйлан, клуб байдаг юм бэ. энэ тоон мэдээлэл та нарт байна уу, энийг хэрхэн яаж хүүхдүүдэд зарцуулж болох вэ? Хүүхэд.../минут дуусав/

С.Бямбацогт: Хэн хариулах вэ, Байнгын хороо хариулж болно, ажлын хэсэг хариулж болно, хууль санаачлагч хариулж болно. Ажлын хэсэг Гэр бүл, хүүхэд хамгааллын ерөнхий газар Баярсайхан дарга хариулъя, 4 дүгээр микрофон. Өөр хүн хариулж болно. Байнгын хороо бас хариулж болно. Танилцуулга хэн уншсан билээ, Хосбаяр гишүүн уншсан билүү, бас болно. Ер нь үүрэгтэй шүү энэ чинь. 4 дүгээр микрофон.

Б.Баярсайхан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Хүүхдийн хөгжлийн төлөө зарцуулах ёстой хүүхдийн фондын мөнгө өнөөдөр 29 тэрбум төгрөг байгаа. Эндээс өмнөх жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрт оношилгооны аппарат авах 4.5 тэрбум төгрөг, Найрамдал зуслангийн засварын ажилд 2.2 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөөд, худалдан авах ажиллагаа явагдаж байгаа. Энэ жилийн 2026 оны хүүхдийн фондын буюу Хүүхдийн төлөө сангийн төсөв нь 7.3 тэрбум төгрөг байгааг энэ талбайн хажуу талын хуучин нийслэлийн ордныг Хүүхэд хөгжлийн ордон болгох энэ засвар үйлчилгээнд зарцуулахаар ингээд шийдвэр гарсан.

Нийтдээ улсын хэмжээнд жижиг, дунд, жижигхэн, том хэмжээний 26 мянга гаруй дугуйлан, секц ажиллаж байгаа боловч өнөөдөр энэ нь Монголын хүүхдийн

хөгжлийн асуудлыг төдийлөн шийдэж чадахгүй байгаа юм. Тэгээд энэ хууль зөвхөн дугуйлан, секцээс илүүтэйгээр ерөөсөө Монгол Улсын хүүхдийн хөгжих эрхийг нь хангах тэр өргөн цар хүрээтэй бодлогын ийм хууль байх ёстой гэдэг дээр бид санал нэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл, зөвхөн дугуйлан, секцээр хөгжих бус сургууль, цэцэрлэг, гэр бүлийн орчинд хүүхдийн хөгжлийг төр яаж дэмжих юм, залуу гэр бүлийг яаж соён гэгээрүүлэх юм бэ гэдэг энэ чиглэл дээр хууль маань нэлээн өргөн хэмжээнд батлагдах ёстой байх гэж ингэж харж байна. 26 мянга гаруй жижиг, дунд дугуйлан байна.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Хүүхдийн төлөө сангийн зарцуулалтын талаар би асуулга тавьсан байгаа. 29 тэрбум төгрөг дансанд байгаад, тэгээд яг хүүхдийнхээ хөгжил рүүгээ зарцуулагдахгүй, хүүхдийн авьяасыг тодруулах дээр нь яг үндсэн нөгөө нэг зорилгодоо ердөөсөө нийцээгүй. Тэгээд зуслангийн болон энэ байр, байшингийн засварт төр өөрөө юмаа хариуцаач дээ. Тэгээд Найрамдал миний санахын л намайг сайдаар ажиллаж байхад төсвөөс мөнгө тавьж байсан, ЗГ-ын нөөцөөс мөнгө авсан. Тэгээд Хүүхдийн төлөө фондоос 2 тэрбум төгрөг арай уу, энийг шалгах ёстой байх даа. Ер нь миний хэлэх гээд байгаа санаа бол Бадамсүрэн дарга ер нь ингээд мөнгө байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлыг бид зохицуулж, зөв голдиролд нь оруулахгүй л бол ингээд гарын салаагаар урсаад, үндсэндээ хүүхдэдээ ердөөсөө очихгүй байгаад байна. Энд л санаа зовж байна.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Зочин танилцуулъя. УИХ-ын гишүүн Тогтмолын Мөнхсайханы урилгаар АШУҮИС-ийн 2006 оны төгсөгчдийн төлөөлөл УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Манай Мөнхсайхан гишүүний 6 жилийн хугацаанд хамтдаа сурч, анагаахын их сургууль төгссөн, эмч болсон төгсөлтийнхний маань 20 жилийн ой болж байгаа юм байна. УИХ-ын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс Мөнхсайхан гишүүн тэргүүтэй төгсөгч та бүхэндээ амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Тэгээд хүн ардынхаа эрүүл энхийн манаанд өргөсөн тангарагтаа үнэнч, илүү амжилт гаргаж зүтгээрэй. Манай Мөнхсайхан гишүүн тэнд сууж байна. Нэг төгсөлтийнхөө 20 жилийн ойнхоо баяраа тэмдэглэж байгаа байх. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя.

Ө.Шижир: Оройн мэнд. Би энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ бид хэдэн зүйлийг заавал сануулж хэлэх хэрэгтэй. Хүүхдийн төлөө гэж “за” хэлдэг мөртөө үг, үйлдэл нь дандаа үгүй, үгүй, үгүй байдаг. Үүнийг бид өнгөрсөн бүх жилээр харна. Монголын төр нь ч тэр, ЗГ нь ч тэр, нийслэл хот нь ч тэр дандаа үгүй гэж хэлсээр ирсэн өнөөдрийг хүртэл. Бид хамгийн дуу зохиодог, клип хийдэг, үйлдэл нь дандаа эсрэг байдаг, үр дүн нь дандаа эсрэг байдаг. Алхаад явъя зам байхгүй хүүхдүүд нь, хүүхдээ тэрэгтэй нь түрээд явъя олигтой хол явах зам байхгүй, өвөл нь утаагаар хордуулчих шахна, зун нь бороо орохоор живүүлчих шахна. Ийм болсон тохиолдол байгаа шүү. Цэцэрлэгт хүрээлэнд найзуудтайгаа тоглож байгаад нас барсан хүүхдийн тухай саяхан бидэнд бодит кэйс /case/ байгаа, сургуулийнхаа биеийн тамирын талбай дээр тоглож байгаад хаалганд даруулж нас барсан нь бодит кэйс /case/ байгаа. Өнөөдөр хүртэл бид 3 настай хүүхдийг хайгаад Онцгой байдал ингээд ажиллаад явж байна. Энэ үнэхээр сэтгэл эмзэглүүлэм.

Тэгээд нэг асуулт байгаа юм. Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд сурч, амьдрах эрхтэй гэдэг Хүүхдийн эрхийн хамгааллын тухай хууль дээр байгаа энэ хуулийн

заалтууд нь яг хэр хэрэгжиж байгаа юм, үүн дээр дүгнэлт хийсэн юм байдаг юм уу гэдэг ийм байна? Ер нь бид ниргэсэн хойно хашхирав гэдэг шиг араас нь ингээд өнөөдөр хууль орж ирж байна гэж нэг талаасаа харамсах юм. Нөгөө талаас бүр оройтчихоогүй дээр нь орж ирж байгаа нь яамай даа ч гэж бодох юм. Яг ний нуугүй хэлэхэд. Бид, та бүхэн санаж байгаа бол хүүхдүүддээ зориулсан бүх юмыг ёстой ёстэй юм шиг, өс санаж байгаа юм шиг устгасан, бүгдийг нь устгасан. Хүүхдийн ордон гэж бяцхан газартай үлдсэн, Хүүхдийн парк гээд том цэцэрлэгт хүрээлэнтэй байсныг хувийн хэвшлүүд 4 талаас нь аваад мэрээд идчихсэн, Хүүхдийн урлан бүтээх төв гээд байсан хойд талд нь баахан барилга, байшин барьж, яг хажууд нь зочид буудал, нөгөө талд нь баар барьчихсан.

Найрамдал зуслан нь бараг баян айлын зуслангийн харуул шиг боллоо шүү дээ яг бодитойгоор. Хүүхэд, залуучуудын театр гэж байсан одоо байхгүй, хувьчлагдсан. Янзага зуслан, Хандгайт зуслан гээд хүүхдийн зуслангууд бүгдээрээ байхгүй болсон. Өс санаж байгаа юм шиг бид үнэхээр ёстой шил дараалан устгасан шүү. Тэгээд хүүхдийн төлөө “за” гэж хэлдэг, үйлдэл нь дандаа үгүй, үгүй, үгүй байдаг. Бид энийг ингээд яг төрийн бодлогын хэмжээнд харах хэрэгтэй. Хэн үйлдлийг хийсэн, өнөөдөр би дахиад хэлье, Улаанбаатар хотын А бүсэд байгаа улсын ерөнхий боловсролын сургуулиуд нэг ч бүтэн биеийн тамирын талбайтай сургууль байхгүй шүү дээ. 84-р сургуулийг хараарай, үүдэнд нь яг шавааруулж 3 барилга барьчихсан байгаа. Өргөтгөл барья боломж байхгүй, ард нь тохижилт хийе боломж байхгүй. Бид ингээд хүүхдийнхээ төлөө бүгдийг нь ингээд устгачихсан.

Тэгээд яг өнөөдрийн байдлаар ний нуугүй хэлэхэд, бид энийг бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Жоохон орлого өндөртэй, өөрийн орлогоосоо зарцуулах боломжтой хүмүүс хүүхдүүдээ хичээлийн бус цагаар бие бялдраа хөгжүүлэх, эсвэл урлаг, спортын арга хэмжээ явуулах төлбөрийг нь төлж чадаж байгаа хүмүүс л явуулж байгаа. Дийлэнх иргэд чадахгүй, тэнд авьяастай үлдсэн хүүхдүүд хохирч байгаа. Тэнд авьяастай хүүхдүүд бүр тулчихсан авьяастай тулаад л гарч ирж байгаа. Өнөөдөр өрхийн орлогоосоо багахан илүүчилж чадах чадалтай гэр бүл л үр хүүхдүүдээ хөгжүүлэх хөтөлбөрт хамруулж байгаа байхгүй юу. Яагаад гэвэл маш үнэтэй, үнэтэй болсон. Улс тэгээд дахиад энэ аутизмтай /autism/, Дауны синдромтой /Down syndrome/ хүүхдүүдийн цэцэрлэг гэдэг асуудал манай улсад байхгүй. Байгаанууд нь бараг жилийн 10 саяын төлбөртэй. Тэр хүүхдүүд зөвхөн хүүхдүүдээ цэцэрлэгт явуулахын төлөө ажиллаж, амьдарч байгаа эцэг, эх хүртэл байна. Энэ нийгмийн асуудлуудыг яах юм бэ гэдэг юм байгаа юм.

Нөгөө талдаа бид, та нар хараарай, Монгол Улс чинь Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуультай шүү дээ. Тэгээд энэ хуулийг мэддэг залуучууд байтугай Их Хурлын гишүүд бараг байхгүй. 2017 онд баталсан энэ хууль нь өнөөдөр хэрэгжилт тэг. Тэгээд энэ шиг ийм амьгүй хуулиудыг бид батлах уу, амьтай болгох уу гэдэг ийм асуудлууд төрийн бодлого байгаад байгаа юм. Улсын сургуулиуд дээр энэ сая Бадамсүрэн гишүүн илтгэлдээ дурдаж байна, нөгөө багш нар мэргэжлээрээ давхар орлого олох боломжтой гэж байна. Улсын сургуулиуд чинь 2 ээлжтэй шүү дээ, тэр нэмэлт хичээлүүд нь яах юм, шөнийн цагаар явах юм уу, өөр орон байр хайх юм уу? Би 2 дахь асуулт энийг нь асуучхаад, тодруулчихъя.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 17 цаг 07 минутаас хуралдааныг даргалав.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах билээ? Бадамсүрэн, хууль санаачлагч Бадамсүрэн гишүүн хариулна.

Б.Бадамсүрэн: Шижир гишүүнтэй санал нэг байна. Тэгэхдээ би харин гайхаад байдаг юм, энэ ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш 36 жил болоход хүүхдийн хөгжлийн бие даасан хууль ер нь яагаад батлаагүй юм бэ гэж. Бид бусад улс орнуудаас үнэхээр хүүхдийн хөгжлийн талаар авч хэрэгжүүлж байгаа бодлогоороо маш их хоцорч байгаа. Өнөөдөр зөвхөн ЕБС-д даатгахад хүүхэд маань бүх талаараа хөгжиж байна гэдэг улс орон бараг байхгүй. Заавал хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу чөлөөт цагаар нь үр дүнтэй өнгөрүүлэх, дэлгэцээс холдуулах, хүүхдүүдийг бие бялдар, оюун санааны хувьд ахиц, өөрчлөлт гаргахын тулд нэмэлт сургалтын төв, секц, дугуйланд явуулдаг. Энэ бүх хөгжингүй улс орнуудад, хөгжилтэй улс орнуудад хэрэгжиж байгаа учраас энэ хуулийг оройтсон ч гэсэн өнөөдөр бидний гишүүд хамтраад санаачлаад ингээд өргөн бариад хэлэлцүүлж байгаа.

Тэгэхээр аливаа юм анхдагч юм мэдээж алдаа, оноотой байдаг. Гэхдээ л эхлэл бол аливаа амжилтын үр дүнгийн 50 хувь байдаг учраас энэ эхэлж байгаа нь чухал байгаа юм гэдэгт таны саналд нэгдэж байгаад баярлалаа. Ер нь орлогын байдлаасаа хамаараад хүүхдүүдээ хүссэн секц, дугуйланд нь явуулж, авьяас, ур чадварыг нээж хөгжүүлж чадахгүй байгаа нь үнэн. Ялангуяа хөдөө орон нутагт энэ үндсэндээ бараг боломжгүй. Хөдөө орон нутагт багш нар олон байдаг боловч сургууль нь нэг ээлжтэй боловч тэнд ямар нэгэн санхүүгийн, хууль, эрх зүйн дэмжлэг байхгүй учраас энэ зөвхөн сайн дурын л ийм ажил болсон байгаа. Тийм учраас энийг анхаарна. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Ахмад настны тухай хууль гээд энэ хуулиуд маань нөгөө санхүүгийн механизмыг нь хамтад нь шийдэж өгөөгүй учраас ингээд ерөөсөө хэрэгждэггүй. Тэгээд нэг ийм сайхан хууль баталсан, тэгээд амьгүй.

Тийм учраас энэ Ирээдүйн өв сан, хүүхдүүддээ хөрөнгө оруулж байгаа, мөнгө хадгалж байгаа энэ зориулалттай санг жинхэнэ утгаар нь амилуулъя л гэж энэ хуультай хамт ингэж өргөн барьсан байгаа. Хэрвээ энэ Ирээдүйн өв сангаас зарцуулагдах механизм нь батлагдахгүй бол энэ хууль мөн л адилхан Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуультай адилхан нэг ийм хэрэгжихгүй хууль болно. Ирээдүйн өв санд мөнгө хадгалж байгаа мөнгө хадгалах нэг хэрэг. Одоогийн хүүхдүүддээ оюуны хөрөнгө оруулалт хийх нь ирээдүйд мөнгө хадгалснаас хэдэн 10, 100 дахин илүү үр дүнтэй гэж олон улсад үзэж байгаа. Тийм учраас ингэж явна.

ЕБС-ийн багш нарын хувьд таны нийслэлийн хэмжээнд санаа зовниж байгаатай санал нэг байна. Гэхдээ одоо хагас, бүтэн сайн өдөр, амралт өдрүүдэд багш нар нэмэлт секц, дугуйлангаа хичээллүүлнэ. Дорнод аймагт 3 өдөр хичээллэдэг, энэ нь хагас, бүтэн сайн өдөр, тэгээд ажлын нэг өдөр нь багш зохицуулалт хийгээд. Одоо ч нэг өдөр нь цахим болоод ингээд ажлын 4 өдөртэй нийслэлд үйл ажиллагаа явуулж байна. Цаашдаа ер нь Америк зэрэг орнууд ажлын 4 өдөртэй болсон байна лээ. Тэгэхээр энэ 3 өдөрт нь багш нар маань нэмэлт орлоготой болоод өөрийгөө хөгжүүлээд, тэгээд байгаа бүх бааз сууриа ашиглая гэж байгаа юм. Энэ сургууль 2 ээлжтэй, нэг ээлжтэй сургууль, үдээс хойш нь соёлын төвүүд, бусад боломжтой төрийн байр, байшин гээд ингээд тоолоод үзвэл зөндөө боломж байгаа.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Мөнхбаясгалан гишүүн нэмж хариулъя.

Л.Мөнхбаясгалан: Шижир гишүүний асуултад хариулахад, энэ зөвхөн ажиллаж байгаа багш нар дугуйлан, секцэд хамрагдахгүй. Энэ тэтгэвэртээ гарсан багш нар, тэтгэвэртээ гарсан спортын ахмад зүтгэлтнүүд, шатрын мастерууд, урлагийн авьяастнууд, бүжигчин энэ хүмүүс хүүхдүүдийг сургаж болно. Дээрээс нь хүүхдүүдийн дугуйлан, секц гэхээр зөвхөн сургууль дээр явах юм шиг ойлгож болохгүй. Тэгэхээр энэ талыг олон талаас нь бодох ёстой. Энэ Шижир гишүүн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга байхдаа та бүгдийн хамтарсан Европын 9 орноор явж хийсэн судалгаан дээр суурилсан энэ хуулийг ингээд хамтдаа өргөн барьж байгаа учраас та тэр талаар сайн мэдэж байгаа байх гэж бодож байна. Монгол хүүхдүүдийн оролцсон хүүхэд өөрөө үйлдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэргийн золиос болсон хүүхдийн тоо, мансууруулах бодист донтсон хүүхдийн тоо энэ маш аймшигтай жил болгоноор.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Шижир гишүүний хэлсэн тэр өөрөөр хэлбэл Ахмад настны тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Малчны тухай хууль энэ тэр гээд олон хуулиудыг яг тодорхой сегментэд зориулж гаргасан. Гэвч харамсалтай нь энэ үр дүнтэй хэрэгждэггүй, хэрэгжилт тэг гэж яриад байна шүү дээ. Тэгэхээр яг энэ ажлын хэсэг дээрээс Баярсайхан дарга тухайн үед энэ ахмадын хуулиудыг, залуучуудын хуулийг баталж байсан хүн байх. Тийм учраас энэ талаараа яг энэ Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль яаж амьтай байх юм бэ, үйлчлэл нь сайн байх юм бэ гэдгийг хариулна уу. Индрийн 4-р микрофон.

Б.Баярсайхан: Эрхэм гишүүн Шижирийн асуултад хариулья. 2017 онд батлагдсан Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль хэрэгжихгүй байгаа нь үнэн. Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар гэж байсан, залуучуудын асуудал өнөөдөр Соёлын яаманд харьяалагдаж байгаа. Гэтэл өнөөдөр Монгол Улсад залуучуудын амиа хорлолт, залуу гэр бүлийн салалт, хүүхдээ өнчрүүлж байгаа байдал, амиа хорлож байгаа байдал, цус ойртож байгаа байдал, мансууруулах бодист автаж байгаа байдал өнөөдөр гамшгийн хэмжээнд хүрсэн. Ер нь цаашдаа хүний хөгжлийн нэгдсэн, цогц бодлогыг бид хийхгүй бол хүний хөгжил үнэхээр орхигдож байгаа сегмент болгон дээр.

Энэ Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль анх удаа хүүхдийн хөгжлийн бодлого болж орж ирж байгаа. Бид өнгөрсөн 35 жилд хамгаалах талаар маш их ярьсан. Хамгааллын хуулиудыг маш их хийсэн. Гэтэл яг хүний хөгжлийн асуудал.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулья.

Б.Баярсайхан: Хөгжсөн хүүхэд өөрөө хамгаалагддаг, хөгжсөн хүүхэд өөрийгөө аваад явдаг, хөгжсөн хүүхэд өөрөө амьдралд хүн болдог гэдэг энэ зарчмын дагуу энэ хөгжлийн тухай хууль зайлшгүй байх шаардлагатай. Тэгээд Шижир гишүүн өөрийнх нь хэлснээр сүүлийн 35 жилийн хугацаанд бид хүүхдүүдийнхээ хөгжих боломж, бүх дэд бүтэц, байгууллага бүгдийг нь татан буулгасан. 80-аад онд бид 220 хүүхдийн зуслантай байсан бол өнөөдөр 50 хүрэхгүй шахам зуслан хувийн, төрийн ажиллаж байна. Зусланд хамрагдаж хөгжих хүүхдүүдийн 90 хувь нь зусланд хамрагдаж чадахгүй байгаа, хөгжлийн дугуйланд хамрагдаж чадахгүй байгаа, 2 ээлжийн сургууль хүүхдэдээ хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж чадахгүй байгаа. Хөдөө орон нутаг, хамгаалах байранд байгаа хүүхдүүдэд хөгжлийн ямар ч орчин нөхцөл, хэрэглэгдэхүүн байхгүй байгаа. Тэгээд

энэ хуулийг санаачилж, энэ хууль батлагдах гэж байгаад хүүхдийн байгууллагынхан маш их баяртай байгаа. Тэгээд хүнээ хөгжүүлж байж улс нь хөгжинө.

Б.Пүрэвдорж: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Би энэ хуулийг дэмжиж байгаа. Нэг юм асууя. Боловсролын ерөнхий хуультайгаа яаж уялдаж байгаа вэ гэдэг нэг асуулт байгаад байгаа. Боловсролын ерөнхий хуультайгаа?

Хоёрдугаарт, ингээд харах юм бол залуучууд нь нэг тусдаа яамтай, хүүхэд нь нэг тусдаа яамтай, ингээд Гэр бүл, нийгмийн хамгааллын яаман дээрээ байгаа шүү дээ. Тэгээд ингээд хоёр хуваагаад хаячхаж байгаа байхгүй юу. Хоёр өөрөөр хөгжүүлэх бодлого юм уу эсвэл хоёр тусдаа сегмент юм уу? Залуучуудын яам гээд ингээд нэг хуультай, бүтэцтэй, энэ талд нь болохоор гэр бүлийн яамандаа хүүхдийг нь хамааруулчихдаг, тэгээд ингээд энэ хоёрыг нь ингээд хоёр салгаад хаячихаар жишээ нь юу гэх юм, хүүхдийн асуудал манайд хамаагүй гэж Залуучуудын яам нь хэлэх юм уу, эсвэл залуучуудын асуудал манайд хамаагүй, тэр яамтайгаа ярь гэж Хүн ам, нийгмийн хамгааллын яам нь ярих юм уу? Нэг ийм ингээд логикийн аягүй том хоёр зөрчил байгаад байна л даа. Үүн дээр би яаж харсан юм, тэгээд Боловсролын ерөнхий хуультайгаа яаж холбогдож байгаа юм бэ?

Б.Пүрэвдорж: Дараа нь бичгээр хариулна шүү. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Би Шижир гишүүний асуудлыг яг үргэлжлүүлээд асууж байна гэж ойлгоорой. Асуудлуудаа адилхан хандах гэж байсан. Ер нь зүгээр үгээрээ “за” гэдэг бүгд постер зураг авхуулах, янз янзын видео шторк хийхдээ бүгд сайхан уянгалаад “за” байдаг. Үйлдэл, бодлого, төсөв, санхүү тавьж өгөх дээрээ дандаа эсрэг байгаа шүү, бид. Тэгэхээр энийгээ бид, төрийн байгууллагууд хандлагаа өөрчлөхөөс эхлэх ёстой гэж үзэж байгаа. Тэгээд ингээд өнгөрсөн цаг хугацааны явцад хараад байхаар нийслэл, тэгээд дээрээс нь нэмэх нь Дорнод, Өмнөговь хоёр л хүүхдийн төлөө төсөв тавьсан юм байна. Би энэ 3 засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид баярлалаа гэж хэлэх гэж байгаа юм. Хандлага нь зөв байна. Манай Бадамсүрэн гишүүн өөрөө энэ Дорнодын Засаг дарга байсан, тэр соёлыг суулгаж өгсөн юм байна лээ.

Тэгэхээр яах вэ, энэ дээр би Бадамсүрэн гишүүн энэ хуулийг санаачлаад явж байхдаа Засаг даргаар ажиллаж байсан туршлага дээрээ үндэслэсэн гэж байгаа юм. Тэгэхээр ер нь зүгээр энэ хөтөлбөрүүдийг та улсын хэмжээнд хэрэгжүүлж байхад ер нь ямар ахиц, дэвшил гарна гэж тооцож байгаа төсөөллүүд юу байна, ер нь зүгээр Дорнодод хэрэгжүүлэхэд ямар үзүүлэлтүүд гарч байсан юм б? Хүүхдийн хөгжил, сурлага, өсөлт, хөгжил дээр ер нь юу гарч байсан юм, энэ нэг түүхээсээ хуваалцаач гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт, ер нь Засаг даргын ажлыг энэ чиглэлдээ үнэлчих хэрэгтэй. Байгаль орчны асуудал буюу тэр дундаа газрын доройтлоос яаж сэргийлж байгаа, хүүхдийн эрхийг яаж хамгаалж байгаа, хууль зүйн туслалцааг хэрхэн яаж зохион байгуулж байгаа энүүгээр нь л дүгнэх хэрэгтэй. Ажлын байрыг яаж нэмэгдүүлж байгаагаар нь. Тэгэхээр энэ үзүүлэлтүүдийг бид цаашдаа Ерөнхий сайд, сайдууд маань үр дүнгийн гэрээ гэдэг юм уу, гүйцэтгэлийн гэрээ байгуулахдаа анхаараач гэж байгаа юм. Би Ерөнхий сайдтай санал нэг байна лээ. Сая пост явж байхыг нь

харсан. Яг хүүхдийн асуудал ярингуут нэг яам, тамгын газар яриад байна лээ. Тэр хэрэггүй, Ерөнхий сайд шулуухан хариулж байна лээ шүү дээ, зөв. Харин байгаа хуулиудынхаа хэрэгжилтийг хангаад, төсөв, мөнгө тавьдаг, жоохон үйл ажиллагаагаа бид ил тод, жоохон процессжуулж өгөх хэрэгтэй байна.

Тэрнээс биш ингээд хүүхдийн нэр бариад сайхан, сайхан байгууллага байгуулаад, яам байгуулаад явахгүй гэсэн. Харин байгаа хуулиа л хэрэгжүүлэе. Цаашдаа энэ зүгээр УИХ дээр байгаа энэ хуулиудыг нэгтгэж хэлэлцэх боломж байх уу? Одоо Гэр бүлийн тухай хууль хэлэлцээд явж байгаа, араас нь Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль орж ирж байгаа, энэ арай тусдаа. Үүний дараа манай Мөнхсайхан гишүүн хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр нэлээд томоохон хуулийн төсөл барьсан, Сургуулийн орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хууль байгаа. Ингээд Бадамсүрэн гишүүний хууль байна. Жишээ нь энэ хоёрыг би зүгээр нэгтгээд, нэг сайхан иж бүрэн хууль гаргачаасай гэж бодож байгаа юм. Зүгээр хууль санаачлагчид маань нэг уулзаж ярилцаач, нэг ажлын хэсэг гаргаад яваад үзвэл яадаг юм, уялдах юмнууд байгаа даа, би энэ чиглэлд нь анхаараач гэж байгаа юм.

Дараагийн нэг юм, энэ хүүхдүүдийн хөгжлийн төвүүд байгуулна гэж байгаа. Энд ажиллаж байгаа багш, ажилчдыг ер нь яаж дэмжих юм бэ, эд нарыгаа өөрөө яаж хөгжүүлэх юм бэ, энэ хүмүүс ер нь олдоц нь хэр байгаа юм бэ? Энийг ярьж байж шийднэ шүү дээ. Тэгэхээр би ер нь зүгээр цаашдаа Хүүхдийн хөгжлийн төв гэхээсээ илүүтэй тэр нийгмийн хөгжлийн төв, энэ дээр нөгөө тэтгэвэртээ гарсан ахмадууд маань, түрүүн Мөнхбаясгалан гишүүн хэлж байх шиг байна лээ, ажилладаг урамшууллаар, тэтгэвэр дээрээ нэмэлт орлоготой байдаг, нийгэмдээ идэвхтэй, хүүхэд, залуучуудынхаа тэр энерги дунд байдаг тэр орчныг бид бүрдүүлж өгөх ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ чиглэлд ер нь энэ төсөл санаачлагч нараас ямар байр суурьтай байгаа вэ?

Эцсийн асуулт, энэ хүүхдийн 100 мянга байна. Энэ зөв бодлого. Тэгэхдээ энэ мөнгө шаардлагагүй нэг хэсэг байна. 85 хувь нь авдаг юм шиг байгаа юм, 15 хувь ч юм уу, яг энэ авах шаардлагагүй тэр хэсгийн мөнгөнүүдийг зөв ашигламаар байна. Энэ хуулийн маань дагаж байгаа хууль дээр баялгийн сангаараа бид оролдох гэж байгаа. Хүүхдийн төлөө зөв л дөө. Ер нь мөнгө зарцуулах ёстой, тэгэхдээ яг баялгийн сангаас явчихдаг, дараа нь ингээд л нэг нийгмийн сегментийн асуудлыг шийдэхдээ дахиад л энийг хөндөөд ороод ирэх вий дээ. Тэгэхээр би.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Хууль санаачлагч Бадамсүрэн гишүүн хариулъя.

М.Бадамсүрэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Улсын хэмжээнд энэ төсөл үр дүн гарна гэдэгт 100 хувь итгэлтэй байгаа. Яагаад гэхээр хүүхдүүд нөгөө хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа гэж, сурсан эрдмийг сураар боож болохгүй гэж, хүүхэд байхдаа л хамгийн их бие хүн болж төлөвших бүх зүйлээ олж авдаг учраас хүүхэд насанд нь бид ачаалал даадаг, багаар ажилладаг болгож өгөхөд төрөөс дэмжлэг үзүүлэхгүй бол болохгүй. Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд 3-т төр заавал анхаарал хандуулдаг. Энэ ямар ч дэглэмээс үл хамаараад ингэж ажилладаг учраас энэ дээр үр дүн гарна гэдэгт 100 хувь итгэж байгаа.

Дорнод аймгийн тухай та асуулаа. Дорнод аймагт гэхэд төсөл хэрэгжсэн 3 жилийн хугацаанд нийт 23346 хүүхэд энэ төсөлд хамрагдсан байгаа юм. Өөрөөр хэлбэл, жилдээ 7500-аас 9 мянган хүүхэд хамрагдаж байна. Бага, дунд ангийн нийт хүүхдүүдийн 45 хувиас дээш хувь нь үүнд хамрагдаж байгаа. Тэгэхдээ энэ нөгөө мөнгө нь хязгаарлагдмал буюу Дорнод аймаг гэхэд жилдээ 9 мянган хүүхдийг сургахад зориулж 1.8 тэрбум төгрөг, өөрөөр хэлбэл 1 километр хатуу чичилтэй авто зам тавих мөнгөөр Дорнод аймгийн нийт 9 мянган хүүхдийн хүсэл сонирхолд нийцсэн дугуйланд дэмжлэг үзүүлж ажилласан ийм дүн гарсан байна. Мөн тусгай хэрэгцээт болон эмзэг бүлгийн хүүхдүүдийн 21 хувиас дээш хувь нь хамрагдсан гэдэг ийм статистик дүн байна.

Дээр нь багш нар дагаад хөгждөг юм байна лээ. Ер нь багш хүн ингээд нөгөө арга зүйг их эзэмшсэн байдаг учраас хүүхдүүддээ хичээл, нэмэлт сургалт орохын тулд өөрийгөө маш их хөгжүүлж бэлддэг юм байна лээ. Ер нь бусад өмнөд хөрш, Өмнөд Солонгос зэрэг улс орнуудад ингээд хичээлээс гадуурх ийм секц, дугуйланд хамруулахад нэлээн төсөв, зардал хэрэгтэй байдаг учраас энэндээ маш их хөрөнгө мөнгөө эцэг эхчүүд нь нөөцөлдөг. Энэ нь хэт том ачаалал болдог юм байна лээ. Монгол Улсын хувьд нөгөө хөгжиж байгаа орон учраас энэ зүйл дээрээ бид одоо зарцуулахаас өөр аргагүй болоод байгаа.

Хүүхдийн 100 мянганы тухайд, ер нь ахуйн хэрэгцээндээ голчлон зарцуулагдаад байгаа учраас хүүхдийнхээ хөгжил рүү нь зориулсан ийм тодорхой бодлого ер нь дэмжиж өгөх нь зүйтэй юм байна гэж үзэж байгаа. Тэгэхээр Дорнод аймгийн тухайд гэхэд ингээд нийт эцэг эхчүүдтэйгээ яриа хэлцэл хийж, манай багш нарын зүгээс, тэгээд эцэг эхчүүд хүүхдийн 100 мянган төгрөгөөсөө 20 мянган төгрөгийг нь энэ хүүхдийнхээ сургалтад зориулж хамтарсан оролцоотой ийм хөрөнгө оруулалтын хэлбэрээр явж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл, эцэг эх оролцоно, тэгээд төр, орон нутаг оролцоно, тэгээд сургууль, багш оролцоно. Тэгээд хамтдаа ингэж тал талаасаа хамтарсан хөрөнгө оруулалт хийгээд явахаар энэ их тодорхой үр дүн гарч байгаа ийм үзүүлэлт байгаа гэдгийг танд хэлье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Эрдэнэбат гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн хариулья.

С.Эрдэнэбат: Сайнзориг гишүүн маш чухал юм асуулаа. Бидний өмнөх баталсан хуулиуд нь хүний нөөцөө сайн бэлдээгүй орхичихдог, хэн яг хийх гээд байгаа юм бэ гэхээр хүүхдүүдтэй хэн ажиллах гэдэг хүмүүсийг бид маш их анхаарах ёстой. Багш нараар хамгийн гол цөм нь багш байх болно. Бид багш нарынхаа нэмэгдэл орлогыг нэг хэсэг яаж байна вэ гэхээр манай сургуулиудаар яваад, танай багш нар хувийн секц, дугуйлан ажиллуулж байна уу гэдэг бараг тийм нууц судалгаа байдлын юм авч хязгаарлаж байсан шүү дээ. Энэ өөрөө нэг талаар маш буруу байгаа. Секц, дугуйлан, нэмэлт авьяас хүүхдүүдэд өгье гэж байгаа тэр багш, ажилчдыг хязгаарлаж ерөөсөө болохгүй. Тэртээ тэргүй 2 цаг илүү ажиллуулах цалингийнхаа санд багтаагаад 2 цагаас илүү цаг өгөхгүй энэ тэр гэдэг нэг ийм төсөв дотроо багтсан жижиг бодлоор ингэж явсаар байгаад бид хүүхдүүдээ ч хөдөлгөөнгүй болгосон, багш нарыгаа ч гэсэн хөгжүүлэх асуудал дээр хязгаарлаад байгаа юм. Тэгэхээр энэ хуулиар бид хагас сайн, бүтэн сайнд, хүн өөрийнхөө боломжоор, хүүхдийн амралтаар, зуны, бусад улс орнууд саммер скул /summer school/ гэж явдаг.

Б.Пүрэвдорж: Сайнзориг гишүүн тодруулья.

П.Сайнзориг: Манай хууль санаачлагчид хуулийн төслүүдтэй сайн уялдуулж ажиллахад анхаараарай гэж хүсэж байна. Хоёрдугаарт, энэ хууль маань жоохон тунхгийн шинжтэй байгаад байгаа учраас жоохон процессын хэм хэмжээнүүдийг оруулж өгмөөр байна. Хэн юугаа хариуцах, жишээ нь Хүүхэд хамгааллын тухай хууль байгаа шүү дээ. Гэтэл Одонтуяа дарга ахалж байгаа үе тэнгийн дээрэлхэлтийн асуудал, зохицуулалтуудад нь байгаа мөртөө процесс нь байхгүй, хэн хариуцах нь байхгүй, төсөв нь байхгүй гээд байхгүй, тэгээд л ингээд мухардчихсан. Тэгэхээр энэ зүйлүүд рүү анхааръя гэдэг зүйл байна. Тэгээд ер нь зүгээр хүүхдийн хөгжлийн төвүүд гэдэг юм уу, хүүхдэд үйлчилгээ үзүүлэх гэж байгаа зүйл гэртэй нь ойрхон байх нь зүгээр шүү. Тэгэхээр энэ 20 минутын хотын концепцыг /concert/ цаашдаа ярих ёстой. Ер нь зүгээр хүүхдийн хөгжлийн асуудал ерөөсөө хот төлөвлөлтөөсөө эхлээд л, бид амьдрах орчноос эхлээд л ярих ёстой. Тэгэхээр энэ рүүгээ анхааръя гэдэг зүйл байна. Тэгээд мэдээж хүүхдүүдийн энэ спорт, урлагаар дэмжих нь зөв. Спорт дундаа багийн спортыг сайн дэмжээрэй, усан спортыг дэмжээрэй, аминч биш, багаараа үүрэг хариуцлага хүлээдэг, гарсан тэр гавьяа, шагналыг хамтаараа ингэж.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Нэг зүйлийг залруулахгүй бол болохгүй нь. Энэ танхимд, дээрээс нь зурагтаар, дэлгэцээр үзэж байгаа хүмүүс, цахимаар үзэж байгаа хүмүүс бүгдээрээ хүүхдийн төлөө бүгдээрээ санаа зовж байгаа нь мэдээж. Гэхдээ энэ хөгжсөн хүүхэд хамгаалагддаг, хамгаалагдсан хүүхэд хөгждөг гээд энэ нэг афоризм хаанаас гарч ирээд ийм балай юм яваад байгаа юм. Энийгээ боль л доо, та нар хүүхэд хамгааллын мэргэжлийн хүмүүс биз дээ бүгдээрээ. Энэ ойлголт чинь маш хортой, сөрөг үр дагавартай.

1 дүгээрт, хүүхэд хамгаалал хэний үүрэг юм, хүүхдийн өөрийнх нь үүрэг биш. Энэ ойлголт чинь хүүхэд өөрөө өөрийгөө хамгаална гэдэг явцуу утга руу аваачна. Хоёрдугаарт, хохирогчийг буруутгана. Өнөөдөр хүчирхийлэлд өртсөн хүүхдийг чи хөгжөөгүй болохоор хүчирхийлэлд өртсөн гэж хэлэх гэж байгаа юм уу, энэ логикоор, болохгүй биз дээ. Гуравдугаарт, бүх хөгжсөн хүүхэд хамгаалагддаггүй, авьяастай, чадвартай, сайн хүүхдүүд ч хүчирхийлэлд өртдөг олон тохиолдол байдаг. Тэгэхээр хүүхдийн эрхийн ийм үндсэн, чухал концепцын ойлголтыг нэг ийм цэцэн цэлмэг, ийм нэг гоё толгой холбосон үг болгоод хэдүүлээ ийм буруу ойлголт ерөөсөө нийгэмд тарааж болохгүй. Би уг нь зөндөө л энэ хүүхэд хамгааллын хүмүүст урьд нь зөндөө л хэлж байсан, тэгээд энийг ерөөсөө засахгүй юм. Тийм учраас энэ удаа хэлэхээс өөр арга алга. Яагаад гэвэл энэ ойлголт олон нийтэд маш хүчтэй тарах аюултай. Эргээд бид хохирогчийг буруутгах маш сөрөг ойлголт руу очно гэсэн үг. Тийм учраас энийг хаа хаанаа бүх хүмүүс анхаараасай гэж үзэж байна.

Дээрээс нь хөгжил гэдгийг бид буруу ойлгоно, хөгжлийг зөвхөн дугуйлан, секц, сургалт гэж ойлгохгүй. Хөгжил гэдэг хүүхэд амарч чаддаг байхыг хүртэл ойлгодог, ЮНИСЕФ-ийн /UNICEF/ маш том зөвлөмж байгаа. Тэгээд үндсэндээ хүүхдийн 4 эрхийн том асуудал яригддаг, үүнээс зөвхөн нэг эрхийн тухай л бид өнөөдөр ярьж байна. 4 эрх цогцоороо байж өнөөдөр хүүхдийн ирээдүйн насан туршийн амьдралыг нь тодорхойлох үүргээ төр хүлээж байна гэж үздэг. Нэг дэх эрх нь хүүхдийн хамгаалагдах эрх, бидний хамгийн сайн мэдэх хүүхэд хамгаалал гэж яриад сурсан. Хоёр дахь эрх нь хүүхдийн оролцооны эрх, хүүхэд нийгмийн амьдралд оролцох бие

хүн гэдгийг нь хүлээн зөвшөөрөх ёстой. Гуравдугаарт, энэ хөгжих эрхийн асуудал, хөгжих эрхийн асуудал зөвхөн боловсролын асуудлаар хязгаарлагдахгүй, бүх нийгмийн орчин хүүхэд хөгжих боломжтой байх ёстой гэж ойлгох ёстой. Дөрөвдүгээрт, хүүхдийн эсэн мэнд амьдрах, хамгаалагдахаас гадна дахиад тусдаа эсэн мэнд амьдрах эрхийн асуудал гэж үндсэн ийм 4 асуудлаар төр үүргээ хүлээх ёстой гэдэг.

Тэгээд бид ингээд нэг нэгээр нь сэглээд, нэг асуудал болохоор зөвхөн нэг эрхийнх нь тухай яриад, энэ яах вэ энэ танхимд байгаа улс төрчдийн буруу гэхээс илүү хүүхэд хамгааллын хүмүүс, хүүхдийн эрхийн чиглэлийн хүмүүс яг энэ ойлголтыг зөв, системтэй өгөх ёстой. Буруу ойлголт ерөөсөө өгч болохгүй. Энэ чинь өөрөө наад зах нь төсөв батлахаас өгсүүлээд маш том асуудал дагуулна. Төсвийн нэг том жишээ, энэ зуслангуудад, энэ Найрамдал 2, тэр Хөвсгөл дахиад Найрамдал, хотын Найрамдал, яах гэж энд мөнгө зарцуулаад байгаа юм, хэдэн хүүхэд амрах юм, хэдэн хүүхдэд юм бэ? Монголын бүх хүүхдүүд очиж амрах юм уу? Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүд бүгдээрээ тэр үйлчилгээг авч чадах юм уу? Яг үнэн дээ Найрамдлын эрхийн бичиг нэг өдөр, бараг нэг цагийн дотор сугалаагаар яваад л дуусдаг шүү дээ. Ийм юманд яагаад мөнгө зарцуулаад байгаа юм, ерөөсөө энэ чинь хүртээмж байхгүй байна шүү дээ. Хүүхдэд зарцуулж байгаа мөнгө хамгийн нэгдүгээр шалгуур нь хүртээмжтэй байх ёстой.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж нэг минут тодруулья.

Х.Баасанжаргал: Төрийн бодлого өөрөө хүүхдийг ялгаварлан гадуурхах үндсийг тавьж болохгүй гэдэг. Найрамдлыг бид санхүүжүүлснээрээ зөвхөн Найрамдалд явдаг хүүхдүүдэд зориулсан үйлчилгээг төр гаргаж байна, Найрамдалд явж чадахгүй хүүхдүүдээ бид ялгаварлан гадуурхаж байна гэсэн үг. Хөвсгөл зуслан, Найрамдал 2 бариад тэнд ахиад хэдэн хүүхэд очих юм, зуны 3 сарын л үйл явдал уу? Өвөлжингөө хүүхэд авлаа гээд, бүр өвөлжингөө хүүхэд авъя л гэж бодъё, хэдэн хүүхэд, хэд хоног юм, 7 хоногийн дотор хүүхэд хөгжих юм уу? Тэгээд суурь асуудал руугаа оръё л доо. Ерөөсөө суурь асуудал руугаа орохгүй, яг нэг ийм гоё, нэг ийм PR шинжтэй. Хүүхдүүдийн өөрсдийнх нь оролцоо энэ хуулийг боловсруулахад байгаа юм уу? Та нарын танилцуулга, мэдээлэл дотор хүүхдүүдээс авсан санал гэдэг зүйл огт байхгүй байна шүү дээ. Хүүхдийн асуудлыг хүүхдээс нь өөрөөс нь заавал асуудаг үндсэн, гол дүрэм байгаа шүү дээ.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Ямар асуулт, асуулт асуугаагүй шүү дээ. Доржзовдын Энхтуяа гишүүн асуулт асууна.

Д.Энхтуяа: Энэ хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Тэгээд 2016 онд Хүүхдийн эрхийн тухай хууль, 2024 онд Хүүхэд хамгааллын тухай хууль батлагдсан юм байна лээ. Тэгэхээр энэ хууль батлагдвал Хүүхэд хөгжлийн тухай хууль болж батлагдах нь. Ер нь түрүүн гишүүд хэлж байна, өнөөдөр хүүхдэд зарцуулж байгаа 100 мянган төгрөг ерөнхийдөө судалгаагаар өрхийн амьжиргаанд зарцуулагдаад байна. Хүүхдийн яг тэр оюуны хөгжил, бие бялдрын хөгжил, урлаг, спортоор хичээллэх энэ боломжийг энэ 100 мянган төгрөгөөр энд зарцуулагдахгүй байна гэдэг нь тогтоогдчихсон.

Тийм учраас хүүхдийн хөгжлийн асуудлаар яг энэ тусгай хууль дээрээ нарийвчилсан зүйл, заалтыг ямар зүйл, заалт оруулаад байгаа юм бэ? Энэ чинь нэг тийм тодорхой бус байгаад байна. Түрүүн Мөнхбаясгалан гишүүний анхны явж

байсан хуулийн хувилбарыг би уншиж байсан л даа, 30 мянган төгрөгийн ваучерыг сар болгон хүүхдэд зарцуулна, эцэг эх нь дээрээс нь 20-ийг байна уу, 30-ийг байна уу, 5-ыг байна уу нэмээд, тэгээд яг энэ тусгай зөвшөөрөлтэй ийм байгууллагуудад тэр ваучерыг уншуулж хэрэглэх ийм хэрэглээг нь, зохицуулалтыг нь хийж өгсөн байсан л даа. Тэгээд яг энэ зохицуулалт энэ хууль дээр ороогүй юм шиг ингэж уншигдаж байна. Тэгэхээр яг ямар процедураар энэ хүүхэд хөгжлийг зарцуулах гээд байгаа мөнгөн хөрөнгө чинь зарцуулагдах юм бэ гэсэн 1 дэх асуулт байна.

Хоёрдугаарт, хуулийн төслийн энэ 8.1, 8.1.2-т улсын төсөв, Үндэсний баялгийн сангаас жил бүр хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтад зориулан олгох төсвийг батална гээд тэгж байна. Тэгэхээр өнөөдөр Баялгийн сангийн тухай хуулиар Ирээдүйн өв сан 2030 он хүртэл Ирээдүйн өв санд бүртгэгдэж байгаа энэ хөрөнгө 2030 он хүртэл түгжихсэн байгаа. Тэгээд энэ түгжээсийг яаж тайлах юм бэ, ямар арга замаар тайлах юм бэ? Хуримтлалын санд мэдээжийн хэрэг тодорхой хэмжээний хуримтлал бий болж байгаа, энийг захиран зарцуулах нь хуулиар заагаад өгчихсөн байгаа. Хөгжлийн санд ер нь тэг бичилттэй ингэж явж байгаа өнгөрсөн хугацаанд. Тэгэхээр яг энэ бодитойгоор би яах вэ энэ хуулийг дэмжиж байна, батлагдчихаасай гэж бодож байна. Гэхдээ яг ингээд төсөв, санхүүтэй ороод, тэгээд дээрээс нь бүр энэ баялгийн сангийн Ирээдүйн өв сантай ингээд холбогдоод ингээд тавьчихаар энэ хууль маань батлагдах болов уу гэж санаа зовж байна л даа. Тэгэхээр ямар арга замаар Ирээдүйн өв сан, энэ Баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулаад, тэгээд 2030 он хүртэл түгжихсэн, тэгээд энэ гадаадын банкнуудад 4-өөс 5 хувийн хүүтэйгээр байршуулчихсан нэлээн хатуу зохицуулалттай байгаа байх гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр та бүхэн судалгаа хийсэн үү?

Ер нь хүүхэд маш сониуч байдаг, хүүхэд насандаа. Тэгэхээр энэ сониуч занг, сониуч зантай байдаг, маш их энергитэй байдаг, тэгэхээр энэ энерги, энэ сониуч занг нь мэдээж урлаг, спорт, оюуны спорт, бие бялдрын спортод хандуулах ийм тусгай төрийн бодлого явагдах ёстой гэдэг дээр би санал нэгдэж байна. Тэгэхээр энэ хоёр асуултад хариулт аваад, тэгээд тодруулъя.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Бадамсүрэн гишүүн хариулъя.

М.Бадамсүрэн: Яг хууль дээр тэдэн төгрөг гэж батлах боломжгүй байгаа юм. Тэгээд Хүүхдийн эрхийн тухай одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дээр нэг хүүхдэд ногдох хүүхэд хөгжүүлэх үйлчилгээний зардал, нормативын хэмжээг санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яам, Боловсролын яам, хүүхдийн асуудал хариуцсан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд хамтарсан тушаалаар баталдаг. Энэ зохицуулалтаараа баталчхаад байгаа. Тэр нь зуны сургалт, бусад энэ хөгжлийн үйл ажиллагаанд дунджаар 71 мянгаас 105 орчим мянган төгрөгөөр ингэж баталсан байгаа юм. Тэгээд энэ нөгөө инфляцаас хамаараад тухайн нэг хүүхдийг сургахад ямар зардал гарах вэ гэдгийг тооцож байгаа учраас яг тэдэн төгрөг гэж зааж өгч болохгүй байгаа.

Таны ярьж байгаа, одоогоос 2, 3 жилийн өмнө гэхэд Дорнодод эхэлсэн, 2023 онд эхэлсэн энэ төсөлд гэхэд яг 30 мянган төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас дэмжлэг болгож олгож, эцэг эх нь 20 мянган төгрөг гаргаж байсан. Тэгэхээр энийг цаашид яг ийм хүртээмжтэй болгохын тулд инфляцтай уялдуулаад жоохон нэмэгдэх байх гэж бид харж, тооцоогоо улсаас үзүүлэх дэмжлэгийг 50 мянган төгрөг гэж гаргаж байгаа юм. Тэгэхээр эцэг эх талаасаа тодорхой мөнгө гаргахаар ингэж

урьдчилсан байдлаар тооцож байгаа. Тэгээд нөгөө Хүүхдийн эрхийн тухай хуулийг ишлэл болгоод авчихсан байгаа байхгүй юу энэ дээр. Хүүхдийн эрхийн тухай хууль дээр тэр 3 сайд хамтарч батлах зохицуулалт нь өөрөө байгаа учраас, хуульчилсан байгаа учраас энүүгээрээ явъя гээд 1 дүгээр таны асуултад.

Хоёрдугаарт нь, сая ингээд нөгөө Хүүхдийн төлөө санд ингээд 29 тэрбум төгрөг байна л гэж байна, яг үнэндээ энэ мөнгө чинь ингээд 4, 5 жилийн хугацаанд миний мэдэхээр зарцуулагдахгүй байгаа. Яг юунд зарцуулахаа одоо бол тодорхой болгоогүй шүү дээ, мөнгө нь байгаад байдаг, юунд зарцуулахаа тодорхой болгоогүй. Тийм учраас энэ дээр нөгөө санхүүжилтийн механизмыг нь энэ бодлоготойгоо хамт хийж өгөхгүй бол энэ хууль цаашаа амилахгүй, энэний яг амин сүнс нь энэ болчхоод байгаа юм. Тэгээд Ирээдүйн өв сан гэдэг УИХ-ын хууль батлах нь бүрэн эрхийн асуудал. Ирээдүйн өв санд хуримтлагдаж байгаа мөнгөний гол зорилго нь ирээдүй үедээ хөрөнгө оруулалт хийх, ирээдүй үедээ мөнгө хадгалах ийм зорилготой. Тэгэхээр энд хадгалж байгаагаас нь гадна, энэ хадгалж байгаа, үндсэн өсөж арвижиж байгаа хөрөнгөд нь хүрэхгүйгээр, өөрөөр хэлбэл одоогийн байдлаар 6 их наяд төгрөг Ирээдүйн өв санд байна гэж байгаа юм.

Ирээдүйн өв сангийн энэ мөнгийг валют хэлбэрээр гадаадын банкнаас бонд худалдаж авдаг юм байна лээ. Гэхдээ улирал улирлаар, улиралдаа аваад татаж авчхаад, дахиад гэрээ хийгээд, дахиад сунгаад явдаг. Тэгэхээр энэ мөнгө нь ингээд байж байдаг, яах вэ энэ гадаад зээлжих зэрэглэлд нөлөө үзүүлдэг валютын сангийн нөөцөд ордог хэдий боловч хүүд жилдээ одоогийн байдлаар энэ 2026 онд гэхэд хүүд нь 200 гаруй тэрбум төгрөг төвлөрнө. Энэнийх нь 50 хувиас доошгүй хувийг нь, зөвхөн хүүгийнх нь мөнгөний 50 хувиас доошгүй хувийг эргээд хүүхдийнхээ хөгжилд зориулъя. Энэ оруулсан хөрөнгө оруулалт нь ирээдүйд мөнгө хадгалахаас хэдэн 10, 100 дахин үр дүнтэй гэж үзэл баримтлалын хувьд ингэж тусгасан байгаа юм. Тэгээд цаашдаа ярилцаж болно, энэ чинь анхдагч хууль учраас хэлэлцүүлгийн явцад.

Б.Пүрэвдорж: Энхтуяа гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтуяа: Ер нь энэ төсвийн том энэ далай руу ороод, тэгээд алга болчих вий дээ гэдэг дээр маш их санаа зовж байна. Тэгэхээр энийгээ маш нарийн тусгаж өгөх юм байна гэж ойлголоо. Тэгэхээр ер нь энэ хүүхэд хамгаалал, хүүхдийн хөгжилд зориулсан энэ төсөв, мөнгө яг нэг албан тушаалтны өөрийнх нь үзэмжээр шийдвэрлэгдээд, тэгээд яг хүүхдэдээ очдоггүй гэдэг дээр бүгдээрээ санал нэгдэж байна л даа. Тэгэхээр тэр Ирээдүйн өв сангийн бонд зараад, тэгээд хүү гээд тэгж байна шүү дээ. Тэгэхээр одоо энэ бидэнд өгч байгаа мэдээллээр энэ хүүгээ юунд зарцуулдаг юм бол, та ер нь энэ дээр судалгаа хийсэн үү? Тэгэхээр энэ дээр авах бол, хүүг нь энэ хүүхэд хамгааллын, хүүхэд хөгжлийн таны төсөвт зарцуулах ийм боломжтой юм байна гэж үзсэн юм байна шүү дээ. Тэгэхээр одоо яг тэр хүүг нь захиран зарцуулж байгаа ийм нөхцөл байдал байгаа юу?

Б.Пүрэвдорж: Бадамсүрэн гишүүн нэмж хариулъя.

М.Бадамсүрэн: Монголбанк болон Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас би УИХ-ын гишүүнийхээ хувьд ийм мэдээлэл авсан байгаа юм. Тэгээд энэ мэдээлэл байгаа. Энэ Монголбанкнаас ирүүлсэн мэдээлэлд заасан зүйлийг байгаа мэдээллийг танд танилцуулж байгаа юм. Хүүгийн орлого нь ингээд нэмэгдээд явах юм байна лээ. Жилдээ ингээд 200 гаруй тэрбум төгрөгөөр. Ирэх онд дахиад мөнгө нэмэгдэх байх. Өөрөөр хэлбэл, энэ Үндэсний баялгийн

сангийн тухай хуульд зааснаар 3 сантай байна. Энэ Ирээдүйн өв сан буюу эхний санд нь Монгол Улсын хэмжээнд нийт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр буюу АМНАТ буюу роялтигийн /royalty/ төлбөрөөс орж байгаа орлогын Төсвийн тогтворжуулалтын санд шилжүүлээд, үлдсэн хэсгийнх нь 65 хувийг нь шилжүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, бараг нийт АМНАТ Монгол Улсын хэмжээнд нэг 4-өөс 6 их наяд төгрөг байдгийн 60 орчим хувь нь энд шууд орж байгаа гэсэн үг. Тэгээд жил болгон арвижаад ингээд яваад байна энүүгээрээ. Хамгийн багадаа 2 их наяд гаруй төгрөгөөр жил болгон, энэ үндсэн мөнгө нь, хүү нь тусдаа.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Пүрэвдаваа гишүүн алга байна. Тогтмолын Мөнхсайхан гишүүн асуулт асууна.

Т.Мөнхсайхан: Энэ хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ бид ер нь энэ төсөв, санхүү зарцуулалтынхаа энэ механизм, зарчмаа өөрчлөхгүй бол бид эрүүл мэнд, боловсрол, ирээдүйдээ оруулах хөрөнгө оруулалт хийхгүй юм шиг байгаа юм. Өнөө маргаашдаа үр дүн нь гарах, иргэдээс илүү их алга ташилт авах бүтээн байгуулалтын чиглэлд хамаг төсөв, мөнгөө хийчхээд, дараа нь эрүүл мэнд, боловсролынхоо салбарт мөнгө хуваарилаад байхаар бид ирээдүйд амжилтад хүрэхгүй л байна л даа. Тэгэхээр бусад улс эх орныхоо жишгийн дагуу эрүүл мэнд, боловсролдоо төсөв, мөнгөө хангалттай хэмжээнд зарцуулчхаад, үлдсэнийг нь тэр хөрөнгө оруулалт, бусад зүйлдээ хуваарилдаг энэ зарчим руугаа орох ёстой байх. Ингэж байж асуудал шийдэгдэх байх.

Тэгээд энэ хуулийн хувьд улсын төсөвт дарамт болохгүй гэж байгаа, гэхдээ Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсвөөс ер нь 240 орчим тэрбум төгрөг зарцуулагдана гэж ингэж ярьж байгаа. Тэгэхээр та хэд маань Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай энэ хууль батлагдлаа гэхэд 5 жилийн дараа хүүхдийн хөгжлийн ямар үзүүлэлтүүд хэдэн хувиар сайжрах юм бэ гэдэг энэ судалгааг хийсэн байх энэ гол үзүүлэлтүүдийг та хэд нэг хэлээд өгөөрэй? Бидний нэг номерын шийдэх ёстой асуудал судалгаагаар ч нотлогдсон тодорхой асуудал хүүхэд үдийн хоолонд хамрагдсанаараа хүүхдийн сэтгэн бодох чадвар, оюуны чадамж, хүүхдийн бие бялдрын хөгжил хэдэн хувиар яаж сайжрах вэ гэдэг нь тодорхой болчихсон шүү дээ. Олон улстай ч тодорхойлчихсон, манай улс ч судалгаагаа хийчихсэн.

Гэтэл манайх 5-р анги хүртэл, 6-р анги хүртэл хүүхдүүддээ үдийн хоол өгөөд, дээш ангийнханд нь яг өсөлт, хөгжил явагддаг насны хүүхдүүдэд үдийн хоол байхгүй. Гэтэл энэ яригдаж байгаа төсөв, мөнгөөр 6, 7, 8-р ангийн хүүхдүүдийг жишээ нь үдийн хоолонд хамруулчхаж болохоор байна л даа. Тэгэхээр бид энэ хуулиа батлахаас гадна, бидний нэг номерын асуудал бүх хүүхдүүдээ үдийн хоолонд хамруулчихвал бидэнд ирээдүйд маш их үр дүн гарах гээд байна. Жил ирэх тусам нэмэгдэж байгаа энэ өвчлөл чинь буурах гээд байна. Хүүхдүүдийн маань сэтгэн бодох чадвар, оюуны чадамж маш өндөр хувиар дээшлээд нэмэгдэх гээд байна. Энэ талаас нь та хэд маань хэр сайн бодож үзэв энэ хуулийг?

Тэгээд түрүүн хэлж байна, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль гэж байгаа, энэ хууль болон бусад хуулиудтайгаа хэр сайн уялдуулав? Миний санаачилсан Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль байгаа, энэ хуультай та хэд маань уялдуулж хэр судалж үзэв? Гэхдээ энэ хоёр зарчмын хувьд нэг хууль байх нь нэг их тийм оновчтой, зөв гаргалгаа биш болов уу. Гэхдээ

давхардал нийцлийн хувьд ямар байна вэ гэдгийг та хэд маань хэр судалж үзсэн бэ. Эдгээр асуултад хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Мөнхбаясгалан гишүүн хариулна.

Л.Мөнхбаясгалан: Энэ хуулийн талаар судалгааг 19 оноос эхлүүлсэн байдаг. Европын 9 орноор биечлэн явж судалгаа хийсэн, эндээс хамгийн том дэлхийд гайхагдсан жишээ Исланд /Iceland/ улсын жишээ. Хүүхдүүд, өсвөр насны хүүхдүүд хар тамхи, мансууруулах бодист донтсон, гэмт хэргийн золиос болсон, гэмт хэрэг үйлддэг болсон, архины хамааралтай болсон, тамхины хамааралтай болсноос Исланд /Iceland/ улс хөл хорио тогтоож байсан. Тэгээд эндээс энэ хүүхэд хамгааллын хүүхэд хөгжүүлэх энэ хуулийг санаачилснаараа энэ улс ердөө арваадхан жилийн дотор энэ тоон үзүүлэлтээрээ энийгээ бууруулж чадсан ийм жишээтэй.

Тийм учраас Европын орнууд, Австрали /Australia/, Саудын Араб /Saudi Arabia/ улсаас авхуулаад Исланд /Iceland/, Унгар /Hungary/, Швейцар /Switzerland/ улсууд энийг авч хэрэгжүүлсэн байдаг. Үр дүн нь үнэхээр гайхамшигтай сайн гарсан. Та Эрүүл мэндийн сайд байсан хүн, тэгэхээр өнөөдөр спортод зориулж байгаа 1 доллар маргааш эрүүл мэндийн салбарт зориулах 2 доллароос хамаагүй илүү үр дүнтэй гэдэг ийм үг хүртэл байгаа. Тэгэхээр би энд манай энэ судалгааны багт явж байсан Саруулыг энэ дээр нэмээд ажлын хэсгийн микрофон дээр гарч ирээд энэ бусад орнуудын жишээг хэлж өгөөч гэж хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Индрийн 4-р микрофон.

Б.Саруул: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. 2018 оноос эхлэн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтраад, Биеийн тамир, спортын газартай хамтраад олон улсын судалгааг эхлүүлсэн байгаа. 2018 оноос хойш нийт 9 улсаар явсан, энэ Европын өндөр хөгжилтэй улс орнуудын судалгааг хийсэн байгаа. Үүн дээр бид Исланд /Iceland/ улсын жишээг хамгийн тод дурдаж болно. Энэ 1998 оны байдлаар нийт өсвөр үеийн хүүхдүүдийн 42 хувь нь сүүлийн 30 хоногт согтууруулах төрлийн ундаа хэрэглэсэн, нийт өсвөр үеийн 21 хувь нь тамхи тогтмол татдаг, нийт хүүхдүүдийн 17.2 хувь нь мансууруулах төрлийн ургамал тогтмол хэрэглэдэг ийм судалгаа байсан. Үүний үр дүнд болохоор Исландын ЗГ-аас хөл хорионы хуулийг баталж, 2002 онд Хүүхэд хамгааллын хууль гэдэг нэртэй хуулийг батлаад, 12-оос доош насны хүүхдийг 8 цагаас хойш гадаа.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

Б.Саруул: Хөл хорионы хуулийг баталсан байгаа. Үүний араас Хүүхэд хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийт бүх хүүхдийг өөрсдийнхөө сонголт дээр үндэслэгдсэн биеийн тамир, спорт, урлаг, спортын дугуйланд хамрагдах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ хөтөлбөрийн үр дүнд 2015 оны тоогоор өсвөр насны хүүхдийн архины хэрэглээ нь 6 хувь болтол буурсан, тамхины хэрэглээ 2 хувь хүртэл ийм буурсан, мөн мансууруулах төрлийн бодисын хэрэглээ 2 хувь хүртэл ийм буурсан олон улсын жишээ байгаа. Үндэсний баялгийн сангаараа тэргүүлдэг Норвег /Norway/ улс яг энэ Исландын /Iceland/ жишгийг хуулж хэрэгжүүлж байгаа. Нэг хүүхдэд 400 еврогийн төсвийг жил болгон төсөвлөдөг. Дээрээс нь нэмээд хүүхдүүд сайн дурын үндсэн дээрээс дуртай дугуйлан, секц, хөгжлийн хөтөлбөрт хамрагдах энэ бололцоог нь Европын улс орнууд бүрдүүлж өгсөн байгаа.

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя, Мөнхсайхан гишүүн.

Т.Мөнхсайхан: Энэ хуулийг хоёр гараа өргөөд дэмжиж байгаа. Тэгээд хамгийн гол нь хэр судалгаа, нотолгоонд тулгуурлаж, хэр зөв эрэмбэлж орж ирсэн бэ л гэдэг асуудлыг ярьж байгаа юм. Бид алдаагаа давтаж болохгүй. Өнгөрсөн хугацаанд хүүхдийн эрхийг хамгаалах хэчнээн хууль гарав, хэчнээн хүүхдийн энэ байгууллагууд байна. Гэтэл өнөөдөр хүүхдийн эрхийн асуудал, үзүүлэлтүүд жил ирэх тусам дордож байна шүү дээ. Энийг тэр өсвөр насны хүүхдийн жирэмслэлт, үр хөндөлтийн асуудлууд илхэн тодхон харуулж байгаа юм. Тэгэхээр энэний алдааг давтаад, дахиад нэг баахан хөрөнгө оруулалт хийгээд, баахан хүүхэд хөгжлийн төвүүд байгуулчихдаг, нэг баахан үрэлгэн зарлагатай мөнгө зарлагадсан, үр дүн гарсан зүйл байхгүй, хүүхэд хөгжлийн үзүүлэлтүүд нь буурсан ийм зүйл болох вий. Энийгээ та хэд маань сайн тооцоолж, төсөвлөж, төлөвлөж хууль дээрээ тусгаасай гэдэг үүднээс л энэ асуултуудыг хэлж, саналуудыг хэлж байгаа юм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Отгоншарын Батнайрамдал асуулт асууна.

О.Батнайрамдал: Хүүхдийн хөгжлийг байнга дэмжинэ, тэр маш ойлгомжтой. Энэ хууль дээр гэхдээ нэг асуудал байна, энийг заавал ярих ёстой. Энэ хуулийн дагалдан хууль дээр Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байна. Ирээдүйн өв санд хадгалагдах, хуримтлагдах мөнгөний хуримтлагдсан хүүгийн 50 хувиас илүү хувийг хүүхдийн хөгжилд зарцуулна гээд. Ирээдүйн өв сан гэдэг Үндэсний баялгийн сан. Үндэсний баялгийн санг хөндөхөөр бид Үндсэн Хуулийн зарчим заавал баримтлах ёстой болж таарч байгаа юм.

Үндсэн Хуулийн 6.2-т газрын хэвлийн баялгийг одоо болон ирээдүй үедээ тэгш, шударга Үндэсний баялгийн сангаар дамжуулж хүртээнэ гээд ингээд Үндсэн хуульдаа заачихсан юм л даа. Тэгэхээрээ тэр дундаа Ирээдүйн өв сан бол одоо болон ирээдүй үедээ хуваарилалтынх нь ирээдүй хэсэг нь байхгүй юу. Ирээдүйдээ бид хадгална. Энэ цаашаагаа улам ингээд арвижиж байх ёстой юм. Тэгэхээр энэ Ирээдүйн өв сан одоогийн хуулиар 2030 он хүртэл гар хүрч болохгүй. Энэ яагаад гэхээр арвижих боломжийг нь олгох ёстой. Одоогоор 6 их наяд төгрөг хуримтлагдчихсан. Тэгэхээр энэнийхээ нөгөө хуримтлагдсан хүүгийнх нь 50 хувийг нь авчихаар чинь энэ чинь цаашаагаа арвижихгүй байхгүй юу даа.

Сая Бадамсүрэн гишүүн ингээд арвижна гээд байна л даа, үгүй шүү дээ, арвижна гэдэг чинь цаашаагаа хүүгийн хүү тооцоод эсвэл цаашаагаа яах вэ гэхээр өгөөж нь дахиж хөрөнгө оруулалт хийгээд энэ чинь нөгөө арвижих концепт байхгүй юу. Ингэж байж Норвег /Norway/ шиг, бусад орны баялгийн сан шиг энэ бидний арай ядан цуглуулсан 6 их наяд цаашаагаа 10, 20, 30 их наяд болж буцаад энэ нь ирээдүй үедээ хуваарилагдах ёстой байхгүй юу. Одоо үед хуваарилагдах зарчим ямар зарчмаар явдаг вэ гэхээр төсвөөр явдаг, төсвийн хуваарилалт. Тэгэхээр бид хүүхдүүдийн, хүүхдийн хөгжлийг дэмжих гэж байна гээд эсвэл ахмадаа дэмжих гэж байна гээд ч юм уу, ахмадын тэтгэврийг нэмэх гэж байна гээд ч юм уу энэ хадгалж үлдэх ирээдүйн өв санд бид хамаагүй хүрч болохгүй юм. Энэ ерөөсөө нөгөө газрын баялаг чинь дуусдаг учраас, шавхагддаг учраас цаашаагаа арвижих боломжийг нь бид олгохгүй бол баялгийн хараал болж үлддэг байхгүй юу.

Тийм учраас Ирээдүйн өв сан дээр бид ерөөсөө хүрч болохгүй, энэ ингээд арвижих боломжийг нь бид заавал олгох ёстой. Харин энд санхүүжилтийг нь бид

шийдэх боломжтой юу гэвэл боломжтой, шийдэх ёстой. Хууль санаачлагчдын тооцооллоор жилд 180-аас 240 тэрбум төгрөг хэрэгтэй юм байна шүү дээ, энэ хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд. Өнөөдөр бид хүүхдийн мөнгөн дээр 1.8 их наяд төгрөгийг бид хүүхдийн мөнгө гэж зарцуулж байгаа. Гэхдээ хүүхдийн мөнгө гэж бид нэрлэдэг боловч хүүхдэд очиж байгаа юу гэдэг дээр яг үнэнийг хэлэхэд асуумаар байгаа юм. Энэ дээр судалгаа байна уу? 1.8 их наядыг хүүхдийн мөнгө гэж бид хуваарилчхаад, тэр яг хүүхдүүдийн хүмүүжилд очиж байгаа юу, хүүхдүүдийн боловсрол, эрүүл мэнд, хүүхдүүдийн тэр сургалт, секцэд очиж байгаа юу?

Буцаад тэгвэл бид энэ хүүхдийн мөнгийг цаашаа хүүхдэд нь яаж илүү хуваарилах вэ. Илүү энэ 1.8 их наядыг тэгвэл 2 их наяд болгоход энэ чинь бид орон зай нэмж үүсгэж болох нь байна шүү дээ. Гэх мэтчилэн энэ Баялгийн сангийн Үндсэн хуулийн хуваарилалтаар, одоо үеийн зарцуулалт дээрээсээ бид одоо үеийн хүүхдүүдтэй хуваарилах энэ механизм явах ёстой. Ирээдүйн өв сан бол ирээдүйд, одоо төрөөгүй байгаа, ирээдүйд төрөх хүүхдүүдэд өнөөдөр бид Оюу Толгой төслийн баялгийг ашигласан учраас энэ шавхагдахад ирээдүйн хүүхдүүдэд үлдээх өв үлдээх учраас энэ Ирээдүйн өв сан гэж энийг нэрлэсэн юм байна лээ л дээ. Тэгэхээр ийм нэг жоохон асуудал гэх юм уу байгаа юм. Тэгэхээр энэ дээр.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Нэлээн яг энэ олон, олон арга хэмжээнүүдийг харьцуулж ярина гэдгийг манай хууль санаачлагчид бодож, төлөвлөж, хариултдаа бэлтгэх ёстой. Бадамсүрэн гишүүн хариулъя.

М.Бадамсүрэн: Үндэсний баялгийн сан ч бай, улсын төсөв ч бай ямар ч байсан хүүхдэдээ хөрөнгө заавал зарцуулах хэрэгтэй. Хүний хөгжилд оруулсан хөрөнгө оруулалт олон жилийн дараа гардаг онцлогтой. Тэгэхээр үеийн үед улс төрчид ингээд ил харагдах гоё ганган талбай, өөр юу байдаг юм зам харгуй гээд ийм юм хийдэг. Тэгээд би түрүүн хэлсэн, бүхэл бүтэн Дорнод аймаг гээд нэг том аймагт 1 километр хатуу хучилттай авто зам тавих мөнгөөр нэг жилд 9 мянган хүүхдийг хөгжүүлэхэд нь хичээлээс гадуурх секц, дугуйланд хамруулж болж байна. Тэгэхээр энэ агуулгаараа би Батнайрамдал гишүүнтэй санал нэг байгаа. Тэр улсын төсвөөс ч байж болно, Үндэсний баялгийн сан аль нь ч байсан хүүхдэдээ ямар ч байсан мөнгө зарцуулах хэрэгтэй. Тэгэхгүй болохоор ингээд ерөнхий нэг хууль гаргачихдаг, тэгээд нөгөөдөх нь төсөв хэлэлцэх үеэр нэг эрх мэдэлтэй хүнээс хамаараад, сайд, дарга нараас хамаараад хүүхдийн мөнгөө хамгийн сүүлд л зарцуулаад байгаа шүү дээ. Яагаад гэвэл үр дүн нь удаан гардаг.

Тэгээд түрүүн Мөнхсайхан гишүүн тодорхой хэлсэн шүү дээ. Эхлээд ингээд хүүхэд эрүүл мэнд, боловсролдоо зориулчхаад, үлдсэнээр нь бусад юмаа хийе. Ирээдүйн үеэ бид бодохгүй бол, бидний дараагийн үеийг энэ насанд хүрээгүй хүүхдүүдийг чинь хэн ер нь анхаарах юм бэ л гэдэг асуудал байгаа юм. Тэгэхээр хэлэлцүүлгийн явцад энийг илүү сайжруулах, олон талаас нь ярих боломжтой. Яагаад гэвэл энэ анхдагч хуулийн төсөл, тэгэхээр энэ талаас нь бүгдээрээ ямар ч байсан хуулиа батлах, тэгээд батлахдаа эх үүсвэр нь харин хаанаас байх вэ гэдгийг илүү нарийвчилж ярих ийм боломж нээлттэй байгаа гэж бодож байгаа.

Ямар ч байсан эцсийн дүндээ зорилго маань хүүхдүүдээ хөгжүүлэхэд бид хөрөнгө зарцуулдаг байх л гол зорилго дээрээ л очих ёстой, арга хэлбэр нь ямар ч байж болох юм байна. Яагаад баялгийн сан гэж ингэж сонгож оруулсан гэхээр ингээд баталчихаар яг төсөв хэлэлцэх үеэр шахагдаж явсаар, явсаар байгаад л

баахан хөрөнгө оруулалт, зам талбай, байшин барилга ярьж явсаар байгаад тэгээд л нөгөө хүүхдийнх нь зардалд мөнгө хуваарилахгүй тэгээд л ингээд яваад ирсэн нэг.

Хоёрдугаарт, Хүүхдийн төлөө санд 29 тэрбум төгрөг байхад яаж зарцуулахаа мэдэхгүй өнөөдөр хэчнээн жил болчихсон байна шүү дээ, тэгээд ингээд энэ маягаараа яваад байх юм уу. Үгүй ээ, би тэгж л бодож байна. Яг эцэг хүний хувьд энэ хүүхдүүдийнхээ сайн сайхны төлөө бид байгаа үедээ, эрх мэдэлтэй байгаа үедээ, шийдвэр гаргаж байгаа үедээ энийг батлах ёстой л гэдэг ийм л хүсэл эрмэлзэлтэй байгаа. Тэгэхээр энийгээ Батнайрамдал гишүүнд хэлье. Тэгээд хэлэлцүүлгийн явцад саналуудаа ярилцаад явах боломжтой л гэж үзэж байгаа.

Б.Пүрэвдорж: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Өнөөдөр УИХ-ын чуулганы танхимд хүүхдийн асуудал яригдаж байгаад баяртай байна. Тэгээд энэ танхимд гарч байгаа шийдвэр болгоны үр дагавар ямар нэгэн арга хэлбэрээр Монголын ирээдүй болсон хүүхэд багачуудад нөлөөтэй байдаг. Гэхдээ бид ерөөсөө яг хүүхдийн асуудлыг ингэж тусгайлсан байдлаар хөндөж ярихгүй байгаад байгаа. Уг нь УИХ-аас гарч байгаа шийдвэр болгон л хүүхдүүдэд ямар нэгэн байдлаар нөлөөлж байгаа шүү дээ. Тэгээд өнөөдөр бид хүүхдүүдэд ямар орчин бүрдүүлчхээд сууж байна вэ гэдэг дээрээ ер нь үнэлэлт, дүгнэлт өгөөд ярих ёстой. Өнөөдөр Монголын хүүхэд багачууд энэ нийслэл хотод Улаанбаатарын утаа, түгжрэл дунд бүх бага насаа өнгөрөөж байна. Тэнд ямар ч хөгжих орчин байхгүй байна. Хөдөө орон нутагт, алслагдмал, төвлөрсөн суурин газраас хол, ямар орчинд манай хүүхдүүд бойжиж байгаа билээ.

Тэгэхээр энэ суурь асуудлууд яах аргагүй зайлшгүй яригдах ёстой. Тэгээд энэ суурь асуудлууд дээрээ хамгийн их төсөв хөрөнгөө тавьж, энэ суурь асуудлууд дээрээ энэ хүүхдийнхээ асуудлыг ярих ёстой гэж хэлмээр санагдаад байгаа юм. Бид өнөөдөр хүүхдүүдийн энэ амьдрах орчинтой холбоотой асуудлыг арай өөр түвшинд ярихгүй бол цаашлаад энэ утаан дотор бойжсон хүүхдүүд ер нь эрүүл ахуйн хувьд, эрүүл мэндийн хувьд ямар нөхцөл байдалтай байна вэ гэдэг асуудалтай л байгаад байна. Дээрээс нь энэ боловсрол, эрүүл мэндийн салбарын хүртээмжийн асуудал байгаад байгаа, чанарын асуудал байгаад байгаа. Тэгээд өнөөдөр эцэг эхчүүд хүүхдүүдэд байдгаа зарж байгаа шүү дээ. Манай Монголчууд чинь боловсролд маш их хөрөнгө оруулалт хийдэг, хүүхдүүдийнхээ төлөө ерөөсөө байдгаа л зарцуулдаг.

Тэгээд сургуулийн хүртээмж хомс байгаад байгаа учраас, сургуулийн танхимын цаг бага байгаад байгаа учраас эцэг эхчүүдийн хувиас нь, халааснаас нь нөгөө өдөр өнжүүлэхийн зардал, янз бүрийн дадлага давтлагын зардал гээд л зөндөө зардал гардаг. Тэгээд тэр болгоныг ерөөсөө бид энэ танхимд ярьдаггүй. Тэгээд яах вэ, ийм боломж олдсон дээр энэ том асуудлуудаа нэг ярихыг хүссэн юм. Тэгээд цаашид энэ танхимд гарч байгаа шийдвэр болгон дээр манай УИХ-ын гишүүд энэ шийдвэр, миний энэ дарж байгаа кноп хүүхдүүдэд яаж нөлөөлөх вэ гэдэг дээрээ нэг бодож байгаасай гэж хүсэж байна.

Энэ орж ирсэн Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл дээр хоёр асуудлыг хөндөхийг хүссэн юм. Хүүхдүүдээсээ бид ямарваа нэгэн тийм зардал, мөнгийг харамлах ёсгүй гэдэг дээр санал нэг байгаа. АН-ын хувьд ч гэсэндээ үеийн үед хүүхдийг дэмжсэн бодлогыг ямагт түүчээлж, манлайлж ирсэн, хүүхдийн мөнгөнөөс авхуулаад. Яах вэ, энэ зардал хаанаас гарах вэ гэдэг дээр зарим

гишүүдтэй, бусад санал хэлсэн гишүүдтэй санал нэг байна. Үндэсний баялгийн санг бид хөндөж болохгүй ийм нөхцөл байдалтай байгаад байгаа юм. Тэр тусмаа Ирээдүйн өв сан гэдэг чинь яг л нөгөө хуримтлал үүсгэх ёстой, хөндөж болохгүй сан байгаад байгаа юм. Тэгэхээр энэ нөгөө дагалдаж орж ирсэн тэр хуулийн төслийг бараг хууль санаачлагчид маань татаад авчхаасай гэж хүсэж байгаа юм. Яагаад гэхээр бид баялгийн сангаа нэг эвдчихгүйхэн шиг, ямар нэгэн иймэрхүү янз бүрийн санаачилгуудаар үрэн таран хийчихгүйхэн шиг, ялангуяа тэр Ирээдүйн өв санг хадгалж явах ёстой гэдэгтэй санал нэг байгаад байгаа юм. Төсөвт орон зай олдож болох байх.

Хоёрдугаар асуудал нь юу вэ гэхээр нэг жижигхэн асуудал байна. Энэ 15 дугаар зүйл дээр хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулагч гээд нэг орон тооны асуудал яригдаад байгаа юм. Тэгээд яг ний нуугүй хэлэхэд, янз бүрийн орон тоо бүрдүүлж байгаад л нөгөө нийслэл хотод хэсгийн ахлагч гэдэг шиг нөгөө сонгуулийн сүлжээ байгуулаад давхичихдаг шүү дээ. Тэгэхээр энэ хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагч гэдэг хүнийхээ чиг үүргийг яг юу гэж бодож байгаа вэ, энэ дээр тодорхой хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн хариулъя.

С.Эрдэнэбат: Жаргалан гишүүн маш чухал юмыг давхар хөндлөө. Яг ний нуугүй хэлэхэд өрхийн нийт дундаж өрхийн орлогын 10-аас 15 хувь орчмыг эцэг эхчүүд хүүхдийнхээ нэмэлт сургуулийн төлбөр, дугуйлан, секцийн зардалд гаргаж байгаа гэсэн судалгаа байгаад байгаа юм. Тэгэхээр энэ нь өөрөө эргээд дундаж болон бага орлоготой иргэдийг хүүхдүүдийн хөгжлийн асуудалд давхар анхаарч байгаа иргэдийн орлоготой холбоотой асуудал учраас энэ нэг талаараа нийгэм, эдийн засгийн шууд нөлөөтэй.

Хоёрдугаарт, тэр зохион байгуулагчид гээд байгаа хүмүүсийн хувьд хэлэхэд ямарваа нэгэн тийм санаа байхгүй байх гэж би бодож байна. Энийг тэр хүүхдүүдийг дугуйлан, секц хүмүүст нь холбож өгөх, энийг заавал орон тооны тийм ажилтан байх уу, үгүй юү гэдгийг хүртэл бид зохион байгуулчхаж болох байх. Тэгэхгүй яг хүүхдүүд болон багш нарын хооронд нөгөө талаас нь сургах гээд байгаа багш биш ч гэсэн ховор ур чадвартай, мөн нөгөө талаар гэртээ хүүхдээ хараад байж байгаа мундаг, мундаг тийм ээжүүд байдаг болсон байж байна, 3 хүүхдийг хамт байлгаж байгаад давхар сургадаг гэдэг юм уу. Тэгэхээр энэ аягүй олон зохион байгуулалтын ажлууд гарах юм байна лээ. Тэрийг нь зохион байгуулах чиг үүрэгт нь тодорхой хэмжээний үнэ хөлс өгөх гэдэг юм уу, ийм байдлаар зохион байгуулах ийм төсөөлөлтэй байж байгаа. Заавал төрийн албан хаагч байх уу, үгүй юү гэдэг дээр энийг хууль хэлэлцэх юман дээр тодорхой болгож болох байх л гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Бадамсүрэн гишүүн нэмж хариулъя.

М.Бадамсүрэн: Жаргалан гишүүнтэй санал нэг байна тантай. Энэ хуулийн төслийн 4.1.5 дээр хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагч гэж хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаа гэрээний үндсэн дээр эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг гэж ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл, санхүүжилт нь батлагдаад нөгөө хүүхдийн тоогоороо аймаг, нийслэлд хуваарилагдахаар аймаг, нийслэлийн Засаг дарга нь тухайн шатныхаа Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүний хувьд, төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд гэрээний үндсэн дээр эрхлэх ТББ, хуулийн этгээд, сургалтын төв, секц, дугуйланг сонгон шалгаруулаад, тэнд нэг хүүхдэд ногдох

зардалтай холбоотой энэ гэрээгээ байгуулна. Түүнээс нэг ч орон тоо энэ дээр нэмэгдэхгүй гэсэн үг. Өөрөөр хэлбэл, энэ үйл ажиллагааг бүхэлд нь хувийн хэвшил буюу ТББ, иргэний нийгмийн байгууллага, сургалтын төв, секц, дугуйлан хариуцаж эрхлэхээр ингэж хуулийн төсөлд тусгасан байгаа. Ер нь энэ ардчилсан нийгэмд хөдөлгөгч хүч нь иргэний нийгмийн байгууллага байдаг юм байна лээ. Зах зээлийн эдийн засагт гол бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалагч нь мэргэжлийн холбоод байдаг юм байна лээ. Яг энэ концепцоор явж байгаа.

Б.Пүрэвдорж: Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

С.Одонтуяа: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Би энэ УИХ-ын гишүүн Эрдэнэ бид энэ БГД-т энэ хүүхэд хөгжлийн асуудлыг нэг цогцоор нь шийдэж байсан юм. Хүүхэд хөгжлийн ордон, хүүхдийн зуслан, хүүхдийн эмнэлэг, усан спорт сургалтын төв гээ. Энэ ерөөсөө гол ингээд бааз суурь болж байгаа юм. Тэгэхээр одоо мэдээж төсөв, хөрөнгө хүнд учраас ийм байшин, барилга барих боломжгүй гэж байх шиг байна л даа, тэгэхээр энэ хууль ерөнхийдөө багш, хүүхдийн урсгал зардлуудыг нь л шийдэх юм байна.

Ер нь ингээд хулгай хийхэд энэ улсад мөнгө байгаад байна. Нэг түшмэлийн гэрээс 7 тэрбум гарч байгаа шүү дээ, энэ 7 тэрбумыг энэ төсөвлөсөн мөнгөөр үзэхэд бараг зуугаад мянган хүүхдийн энэ зардлыг төлчихөөр ингээд байгаад байгаа юм. Тэгэхээр бид ямар ч байсан энэ мөнгийг олж, үр хүүхдүүддээ зарцуулах ёстой. Ер нь энэ хүүхдийн талаарх, энэ хүүхэд хөгжилд анхаарахгүйгээс үүсэж байгаа нөхцөл байдал маш эвгүй байгаа шүү дээ, энэ инээдэм биш бүр ханиадам. Жишээлэхэд, үе тэнгийн дээрэлхэлтээр дэлхийн дунджаас Монгол Улс 2-оос 3 дахин өндөр байгаа гэж байгаа. Би өчигдөр энэ Оюуны ундраа, Монгени, 47-р сургуулийн хүүхдүүдээс асуухад ерөөсөө нэг дуугаар л хариулж байгаа, энэ хүүхэд хөгжилд анхаарах хэрэгтэй, хүүхэд багаасаа зөв хүмүүжих ёстой гэж хүүхдүүд хариулж байгаа юм.

Амиа хорлолтоор нэг хүнд оногдохоор дэлхийн дунджаас их өндөр явж байна. Мансууруулах бодис гээд нэлээдгүй тархаж байна, өсвөр насны хүүхдийн жирэмслэлт гээд түрүүн гишүүд нэлээн хэд хэллээ. Хамгийн ноцтой асуудал сүүлийн үед энэ цахим донтолт болсон. Тэгэхээр цахим донтолтоос салгах гол арга ерөөсөө л энэ секц, дугуйланд явуулах энэ байгаа. Тэгээд Баярсайхан гишүүн өмнөх 4 жил парламентад байхдаа яг энэ хүүхдийн асуудлаар дагнаж байсан болохоор би энэ дээр нэлээд чамбайруулаад ажиллаж чадна гэж бодож байна. Та харин энэ бүх хуулиудынхаа уялдааг нэг сайн гаргаж өгөх хэрэгтэй байна.

Би энэ талаар олон улсын туршлагауд судалж байсан. Энийг судлахад хамгийн гол асуудал гэртэй нь ойрхон, тэгээд хотхон дотор, тэгээд ер нь энэ тэтгэврийн багш нар, өөрөө гэрээсээ хол ажил хийх боломжгүй ийм хүмүүсийг ингээд ажиллуулдаг. Тэгэхээр энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй. Түрүүн Сайнзориг гишүүн нэг чухал санал хэллээ. Энэ хүүхдийн мөнгөө зарим хүмүүс төдийлөн ингээд нэг их чухал биш байдаг. Тэгэхээр энэ хэдэн хүмүүс нийлээд энэ хүүхдийн мөнгөөрөө тэр хүүхдээ хөгжүүлэх боломжийг нь энэ хуулиар нээж өгөөд, тэр дүрэм журмыг нь гаргаад өгчихвөл энэ дээр иргэд дуртай байна. Огт хаалттай бол иргэд нэг нэгэн рүү утасдаад ингээд хийж чаддаггүй, тэгэхээр энийг анхаарах хэрэгтэй.

Нэг асуулт байна. 10.1.1-д Ирээдүйн өв санд хуримтлагдсан хүүгийн орлогын 50 хувиас доошгүй хувийг хүүхдийн хөгжилд зарцуулна гээд энэ дээр яг хийчихсэн

тооцоо байна уу, энэ яаж гарах юм бэ? Эдийн засгийн судалгаа, тооцоо байна уу гэдэг энэ зүйлийг асууя. Тэгээд ер нь энэ хууль хэрэгжихэд нэг ийм зүйлийг бид, энэ Их Хурлын гишүүд бодолцмоор санагдсан. Бүх газар зэрэг хэрэгжих биш, Солонгост ийм пилот /pilot/ хэд хэдэн газрыг эхлээд сонгодог юм байна. Жишээлэхэд, би нэг ЭМД-ын шинэ хууль ингээд нэг газар эхлээд хэрэгжиж байгааг харсан. Тэгээд тэр дээр алдаа, оноо юу байна, бусад газрууддаа ингээд хэрэгжүүлээд явдаг. Тэгэхээр энэ сонголт хийж байгаад ингэхгүй бол нэг баахан мөнгө, ваучер сүүлд нь баахан идсэн, уусан, ерөөсөө энийгээ боль гээд энэ хуулийн утга нь унаад алдагдчих вий. Тэгэхээр энэ дээр их нарийн, сайн бодож энэ хуулиа хийхгүй бол тэгээд л нэг баахан юм ярьдаг, сүүлд нь мөнгө байхгүй гээд нэг өдөр энэ хууль хэрэгжихгүй болох вий гэдгээс би болгоомжилж байна.

Б.Пүрэвдорж: Бадамсүрэн гишүүн хариулъя.

М.Бадамсүрэн: Одонтуяа гишүүнд баярлалаа. Та яг асуудлын голыг олж, их чухал санал хэллээ, зөвлөмж хэллээ. Ер нь Ирээдүйн өв санд 6 их наяд төгрөг байгаа. Энэний 4.1 орчим хувийн хүүтэй бонд авдаг юм байна лээ гадаад валютаар. Энд нэг 240-өөс 250 тэрбум төгрөг энэ 2026 оны байдлаар гэхэд төвлөрнө гэж ийм дүн мэдээг Монголбанкнаас, Сангийн яамнаас авсан юм. Тэгэхээр цаашдаа энэ нэмэгдээд явна. Жилдээ Ирээдүйн өв санд АМНАТ-ийн төлбөрийн 65 хувь гээд бодохоор чинь нэг хамгийн багадаа 2-оос 3 их наяд төгрөг нэмэгдээд явах юм байна лээ. Энэ Үндэсний баялгийн сангийн тухай хууль маань өөрөө ийм учраас уул уурхайн олборлолт явагдаж л байвал ирээдүй үеэсээ зээлж байгаа энэ газрын хэвлийн баялгийн өгөөж нь ингээд ороод явах юм байна лээ. Энэ тооцоогоор нэг хүүхдэд ногдох ийм норматив зардлыг 3 сайд хамтраад 71 мянгаас 105 мянган төгрөгөөр баталсан байна лээ. Тэгэхээр энэ хүрээндээ явахаар энэний 50-аас 60 хувь гэхээр нэг хүүхдэд 50 орчим мянган төгрөгийг зориулахаар, дэмжлэг үзүүлэхээр ингэж тооцоолол хийсэн байгаа. Тэгээд энэ нөгөө үзэл баримтлал дээрээ энэ талаар тайлбарлаад бичсэн байгаа.

Хоёрдугаарт, таны тэр хэрэгжилт яаж зохион байгуулах вэ гэдэг дээр би маш их санаа зовж байгаа. Ер нь хамгийн хэцүү зүйл маань энэ байгаа. Тэгэхээр аймгийн Засаг даргаар ажиллаж байхдаа, Хүүхдийн төлөө зөвлөлийн даргаар ажиллаж байхдаа "Хүн болох багаасаа" төслийг эхлүүлэхэд би хагас жилийн хугацаанд энэ дээр ажилласан, яг бэлтгэл хангаад, тэгээд төсөв нь батлагдаад, холбогдох дүрэм журам гаргаад, энэ норматив гаргаад. Тэгээд сургалт, лекц, дугуйлантай хэлэлцүүлгүүд хийгээд, хүүхдүүд, багш нартай хэлэлцүүлэг хийж бэлтгэл ажил гээд. Энд би маш их санаа зовж байгаа. Хууль батлагдлаа гэхэд энийг хэрэгжүүлэх аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар болон хяналт тавьж ажиллах хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагуудын идэвх, санаачилга, ур чадвар, энд зориулах энэ ажиллагаа үнэхээр чухал.

Тэгэхдээ ямар ч байсан болгохын төлөө явна. Хамгийн боломжгүй зүйлээс боломжтой зүйл рүү бид шилжиж байж л хөгжлийн тухай яригдах учраас энийг хэрэгжүүлэхэд бүрэн боломжтой. Гэхдээ саад бэрхшээл ихтэй, хүнээ бэлдэнэ, зөвлөх үйлчилгээг давхар явуулна. Энийг хувийн хэвшил зөвлөх үйлчилгээг хийх нь зүйтэй гэж үзэж байгаа. Энэ хамгийн зөв зарчим гэж үзэж байгаа. Тийм учраас энэ дээрээ бүрэн боломжтой. Харин нэмээд манай яам, агентлагийн зүгээс хэрэгжилт дээр ер нь юу гэж төсөөлж байгаа вэ. Энэ чиглэлээр өмнө огт ажил хийгдээгүй биш, хийгдсэн байгаа л даа. Надад байгаа мэдээллээр хэдэн билээ, хөгжлийн үйл

ажиллагаанд зориулж жилдээ 3, 4 тэрбум төгрөг баталсан юм байна лээ, тэрийгээ яг яаж хэрэгжүүлж байгаа юм гээд тэр дээр тодорхой хэрэгжилт дээр ийм зүйл дээр анхаарна гэдэг зүйлийг тайлбарлавал яг ажил гардаж байгаа хүмүүсийн хувьд илүү оновчтой болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Индрийн 4-р микрофон, Их Хурлын гишүүн асан Баярсайхан дарга хариулна.

Б.Баярсайхан: Бид 1990 оноос хойш 2 нийгмийн хооронд шилжихдээ хүүхдийн асуудал, хүний хөгжлийн бодлогын асуудлаа орхигдуулсан. Тийм учраас сүүлийн 35 жил бид дандаа хамгаалах хууль, хамгааллын тухай ярьсан. Сая Баасанжаргал гишүүн ярьж байна, бид хамгааллын ажлаа орхиё гээгүй, 2026 оны төсөв хүүхэд хөгжүүлэх, 1.3 сая хүүхдийг хөгжүүлэх төсөв 3.6 тэрбум төгрөг. Хамгаалах төсөв маань 11 тэрбум төгрөг. Гэтэл хүүхдийн хүчирхийлэл байнга нэмэгдэж, гэр бүлийн хүчирхийлэл тасралтгүй огцом өссөөр байна жил болгон, амиа хорлож байгаа хүүхдийн тоо, бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдийн тоо, өсвөр насандаа ээж болж байгаа хүүхдийн тоо гээд бид хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийн асуудлыг ярих юм бол үнэхээр сэтгэл эмзэглүүлэм үндэсний.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

Б.Баярсайхан: Үндэсний аюулгүй байдлын хэмжээнд нөлөөлөх хэмжээнд бид очсон байгаа. Өнөөдөр бид хүүхдээ хөгжүүлэхгүйгээр улсаа хөгжүүлж чадахгүй угаасаа. Тэгэхээр хөгжсөн улс орнуудын туршлага сая Саруул дарга ярилаа. Хөгжсөн улс орнууд Хүний хөгжлийн бодлогын яамтай, хүүхдээ хэрэгжилт дээр биш хүүхдээ бодлогын яаман дээр тавьдаг. Монгол Улс ХААҮЯ-тай, малын хөгжлийн бодлоготой мөртөө хүүхдийн хөгжлийн бодлогогүй өнөөдрийг хүртэл явсаар ирсэн. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийн 83 хувь нь өнөөдөр гэр бүлийн орчинд байхад 2026 оны гэр бүлийг хөгжүүлж, хамгаалах төсөв нь 107 сая төгрөг батлагдсан байж байгаа. Тэгэхээр бид 21 аймаг, 9 дүүрэг, 330 сум, бүх хороонд үнэхээр энэ хөгжлийн 3.6 тэрбум төгрөгөө усны дусал мэт, шүлсний дусал мэт бид хувааж хэрэглэдэг, үр дүнд хүрэхгүй байгаа.

Б.Пүрэвдорж: Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Сайн байна уу. Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хууль дээр 9 чиглэлийг тусгасан байна лээ. Шинжлэх ухаан, гадаад хэл, спорт, хөтөлбөрт суурилсан хувь хүний хөгжил, сэтгэл зүйн боловсрол, санхүүгийн боловсрол, нийгмийн оролцоо, хүрээлэн байгаа орчин, соёл, урлаг гээд заачихсан байгаа. 1 дэх асуулт нь энэ чиглэл, энэ дараалал дээр ямар судалгаан дээр юм уу, ямар эрэлт хэрэгцээ дээр тулгуурлаж эдгээрийг оруулсан бэ гэдэг нэг асуудал байгаа?

Хоёрдугаарт гэвэл яг энэ 5.1.5 дээр болон 5.1.7 дээр тусгасан нийгмийн оролцоо гэдэг хэсэг дээр ямар үйл ажиллагааг төлөвлөж харж байгаа юм, яг одоо хэрэгжиж байгаа үйл ажиллагааг илүү хөгжүүлэе гэвэл өнөөдөр нийгмийн оролцоо, сэтгэл зүйн боловсрол хоёр дээр одоогоор ямар үйлчилгээ хэрэгждэг вэ?

Дараагийн асуулт нь бид энэ хуулийн төслийн 15 дугаар зүйлд хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулагчийн үүргийг жоохон ерөнхий биччихсэн юм болов уу

гэж би харсан. Яагаад гэхээр хичээлээс гадуурх үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байхаар л тусгасан байгаа. Тэгэхээр энэ дээр яг ямар мэргэшил байх юм, яаж хүргэх юм гэдэг тэр процесс нь жоохон бүдэг байгаа. Тэгэхээр энэ дээр ер нь ямар төлөвлөлт байгаа вэ гэдгийг тодруулъя?

Энэ чиглэлийн мэргэжлийн хүмүүс ирсэн байгаа учраас би нэг зүйлийг тодруулмаар байгаа юм. Ер нь болгох талаас нь ямар нөөц, боломж байгаа вэ гээд хармаар байна л даа. Тэгэхээр өнөөдөр энэ Насан туршийн суралцахуйн төвүүд ер нь ямар төсөвтэй байдаг, ямар үйл ажиллагаа явуулдаг юм бэ? Эдгээрийн зорилтот хүмүүс дотор хүүхдүүд, 0-ээс 18 насны хүүхдүүд хэр их үйлчлүүлдэг юм бол. Ийм тоо, судалгаа, мэдээлэл байгаа юу? Тэр дотор нь хүүхэд хөгжлийн агуулгатай юм байна уу, үгүй юу гэдгийг асуух гээд байгаа юм.

Мэдээж гуравдугаарт нь, энэ хүртээмжийн баахан шаардлага тавилаа гэж бодъё л доо. Дижитал /digital/ хүртээмж, мэдээллийн хүртээмж, биет орчны хүртээмж гээд тусгаад тавилаа гэж бодоход өнөөдөр байгаа энэ хичээлийн бус, гадуурх үйл ажиллагаа явуулдаг сургалтын төвүүд, дугуйлан ч байдаг юм уу, секц байдаг юм уу, эд нар хэдэн хувь нь ер нь энэ хүртээмжийг хангах нөөц, бололцоо байгаа гэж харж байгаа вэ?

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгээс хариулъя. Ажлын хэсгийн 4-р микрофон, нэр, овог, албан тушаал хэлье, хэлээд хариулаарай.

Б.Бадамжав: Боловсролын яам Бадамжав. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Насан туршийн суралцахуйн талаарх асуултад хариулъя. Насан туршийн суралцахуйн төв 21 аймаг, 9 дүүрэгт ажилладаг байгаа. Насан туршийн суралцахуйн төвийн хүрээнд боловсрол нөхөн олгох бүх насны хүүхдэд, амьдрах ухааны ур чадвар, эрүүл мэндийн боловсрол, гэр бүл, хувь хүний хөгжил, цахим ур чадвар, тогтвортой хөгжлийн боловсрол, ахмад настны боловсрол, суралцагч хот, малчин залуучуудын хүүхэд боловсрол, Монгол хэл бичгийн чадамж гээд маш олон төрлөөр зохион байгуулдаг байгаа. Сургууль завсардсан хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох сургалтыг зохион байгуулагч байгаа, энэ хүрээнд сүүлийн 3 жилийн байдлаар хамрагдагсдын тоо харьцангуй буурч байгаа. 2023-аас 2024 оны хичээлийн жилд 454 хүүхэд хамрагдаж байсан бол 2024-өөс 2025 оны хичээлийн жилд 340, энэ хичээлийн жилд 304 хүүхэд болж буурсан байгаад байгаа.

Б.Пүрэвдорж: Өөр хэн хариулах билээ. Саранчулуун гишүүн нэмж тодруулъя.

О.Саранчулуун: Би эрэмбэ, дарааллыг асууж байгаа. Энэ 9 чиглэлийнхээ үндэслэл нь юундаа байгаа юм бэ гэж асууж байна. Энэ Насан туршийн суралцахуйн төвүүдэд сургалт, үйл ажиллагаанд нь 0-ээс 18 насны 454 хүүхэд байснаас 340 болж буурсан байна. Энэ Насан туршийн суралцахуйн төвийн нийт улсын төсөвт зарцуулж байгаа зардал нь хэд байдаг юм бэ? Өөрөөр хэлбэл, хэчнээн төгрөгийн зардлаар, хэдэн хүнд, ямар үйлчилгээ хүргээд байгаа гэдэг нэг мэдээлэл л авчихъя.

Дахиад асууя, хуулийн төслийн 15 дугаар зүйлд хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулагчийн үүргийг тусгасан байгаа, тэгэхдээ нэлээн ерөнхий байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо үйлчилгээ хүргэж байгаа, та хэд маань энийг яаж хүргэх гэдэг тэр механизмыг нь яг хэрхэн харж байна вэ, ямар шийдэл байх юм бэ гэдгийг

асуугаад байна. Дахин тодруулъя, 4 дэх асуулт нь хүртээмж ярьж байгаа, болгоно гээд энд тусгачихсан байгаа шүү дээ. Хүртээмжийг ер нь хангахад хэр бэлэн юм бэ?

Б.Пүрэвдорж: Ажлын хэсэг хариулъя. Бичгээр хариулт өгнө шүү, Саранчулуун гишүүнд. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна.

О.Номинчимэг: Хүүхэд хөгжлийн тухай бид үнэхээр бодлогын түвшинд анхаарах цаг нь болсон. Тэгэхээр ийшээ чиглэсэн үйл ажиллагааг бодлогын хүрээнд дэмжиж оруулахыг дэмжиж байгаа. Бид үнэхээр хүүхдүүдийнхээ нөхцөл байдлыг харахаар, түрүүн гишүүд маань ч гэсэн хэлж байна, донтолт гэдэг юм маш өндөр байна. Бага наснаас, 2, 3 наснаасаа дэлгэцэд донтож байна, аав, ээжүүдийн үнэхээр санаа зовниж байгаа юм болж байна. Архи, тамхины донтолт, цаашаагаа явах юм бол мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын донтолт гээд. Тэгээд энэний чинь гол асуудал нь юу юм бэ, яаж шийддэг юм бэ гэхээр ерөөсөө л хүүхэд чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх, хөгжих энэ боломж, орон зайг нь нээхгүй ийм л юм руу яваад байдаг. Тэгээд энийг илүү ийм бүтээлчээр зохион байгуулалтын хувьд ингэж хийе гэдэг ийм хуулийн төсөл орж ирж байна гэж харж байгаа.

Хүүхдийнхээ хөгжлийг бид үнэхээр анхаарахгүй бол 3.5-хан сая хүн амтай бид, тэгээд ингээд яг энэ олон нийтийнхээ эрх ашиг, хүүхдийнхээ эрх ашгийг хамгаалсан хууль тогтоомж гаргая, чангалъя гэхээр ерөөсөө энэ нь ингээд УИХ-ын хэмжээнд бодлого нь явж өгдөггүй. Энд бид хүүхдийгээ илүү харж байна уу, бизнесийг нь илүү харж байна уу гэдэг үнэхээр би дотроо асуулт асуудаг юм. Яг иймэрхүү чиглэлийн бодлого, төлөвлөлтийг харахаар. Миний бодлоор зүгээр бизнес эрхлэгчдийн юм уу, өөр бусад ашиг сонирхол нь дийлээд явахгүй байх шиг байгаа юм. Тэгээд энэ нөгөө хүүхдүүдээ бид яг энэ чөлөөт цагийг нь зөв өнгөрүүлдэг сургалт, хөтөлбөртэй болгож оролцуулдаг байя гэдэг энэ санаа нь зөв. Тэгээд энэ утгаар нь дэмжиж байгаа юм.

Хууль дээр асуух 2 тодруулах юм байна. Нэгдүгээрт, энэ хуулийг яах вэ, ингээд хэрэгжүүлээд 9 чиглэлээр ийм сургалт, хөтөлбөр хийнэ гэж байна, энэнийх нь ингээд мөнгө, төсвийг нь улсаас дэмжлэг үзүүлнэ гэж байна. Тэгээд 1 хүүхэд жилд 6 сараас доошгүй хугацаанд хамрагдах боломжийг хангана гэж байна. 6-аас 18 насны хүүхдүүд хамрагдах юм байна гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр хүүхдүүддээ бид яг энийг хэрэгжилтийг нь хангаад явахын тулд төсвийн хувьд жилд хэдийг төлөвлөнө гэж та бүхэн ер нь тооцож байгаа юм бэ? Энэ нөгөө яг хэдийн дэмжлэг гаргах нь төрөөс үүрэг болгож ингэж гаргах нь тодорхойгүй байгаад байгаа байхгүй юу. Сардаа 5 мянгыг гаргах гээд байгаа юм уу, 50 мянгыг гаргах гээд байгаа юм уу, 500 мянгыг гаргах гээд байгаа юм уу? Энэ тооцооллоо бид харж байж энэ боломж, хэрэгжилт нь яах юм, яг энэ төсвийн хөрөнгө оруулалт биш, энэ Баялгийн сан юу гээд эх үүсвэрүүдийг нь яах юм гэдгээ илүү нарийвчлах гээд байгаа юм. Тэгэхээр энэний тооцоолол хэдийг гэж бодож байгаа юм, яагаад хуульдаа тусгаагүй вэ гэдгийг нэгдүгээрт асууя?

Хоёрдугаарт яах вэ, ингээд харахаар Хүүхэд хөгжлийн төв дээр ингээд төвлөрсөн юм л байх юм шиг байгаа юм. Тэгээд ингээд нэг ийм төр ч юм уу, ингээд орон нутгийн ийм төрийн чиг үүрэгтэй газар ингээд юмаа төвлөрүүлчихээр дахиад л бид нөгөө энд бүртгүүлсэн, зөвшөөрөл авсан гэдэг нь танил тал, энэ тэр гэдэг юм болчих вий дээ. Одоо хүүхэд хөгжилтэй холбоотой, ялангуяа спорт, урлаг юу гэдэг юм, ийм асуудал нэлээн дугуйлангууд, секцүүд байдаг. Энэ хувийн хэвشلүүдэд шууд боломжийг нь олгох байдал дээр ямар зохицуулалт орж ирэх юм бэ? Тэрийг

нь яг энэ спортын чиглэлээр ч гэдэг юм уу, соёл урлагийн чиглэлээр гэдэг юмыг нь энэ хүүхдүүддээ өгөхийн тулд ямар процесс байх юм бэ? Мөнгийг нь аймаг, дүүргийн Засаг дарга нь ингэжээд, би энэнтэй гэрээ, энэ дугуйлантай нь гэрээ хийнэ, гэрээ хийхгүй гэдэг юм байх юм уу. Эсвэл хүүхдүүддээ ерөөсөө эрхийг нь хэдэн мянга байх юм, тэр 50 мянга байх юм уу, 100 мянга байх уу, ваучер байх юм уу, тэрүүгээр нь өгөөд энд нь хамрагдах боломжийг нь олгох юм уу? Ингэж байж бид нөгөө хүртээмжийг нь харахгүй бол дахиад нэг төрийн байгууллага, даргын үзэмжээс хамаарсан, тэнд төвлөрсөн зөвшөөрлөөс хамаарсан ийм юм болчих вий дээ гэдэг нэг ийм болгоомжлол л байна. Тэгээд энэ хоёр асуудал дээр хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Бадамсүрэн гишүүн хариулна.

М.Бадамсүрэн: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. 6 сарын хугацаа гэдгийг яагаад зааж өгсөн гэхээр, ер нь аливаа хүн 180 хоног буюу 6 сарын хугацаанд нэг зүйлийг хийж байж дадал болдог гэж судлаачид шинжлэх ухаан талаас нь тайлбарладаг. Тийм учраас хүүхдийг 6 сараас доошгүй хамрагдах энэ боломжийг олгоё гэдэг, нэг хичээлийн жилийн хугацаанд.

Хоёрдугаарт нь, энэ 3 сайд буюу Хүүхдийн эрхийн тухай хуульд зааснаар хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний норматив, нэг сард нэг хүүхдэд ногдох зардлыг батлах эрхийг нь хуулиар олгосон байгаа учраас энэ дээр давхардуулж тусгаагүй. Энүүгээр одоо ингээд баталсан байдлаараа гэхэд 87 мянгаас 110 мянган төгрөгийн хооронд нөгөө энэ сургалтынхаа чиглэлээс хамаараад ингэж 3 сайдын хамтарсан тушаалаар баталсан байдаг. Тэгэхээр бид төсвийн байдлаасаа л харгалзаж байгаа юм. Яг энэнд шаардагдах зардлыг нөгөө өсөн нэмэгдэх тэр Ирээдүйн өв сангаасаа нэмэгдээд явахад энэ боломжтой гэж үзэж байгаа юм. Тэгээд норматив зардал нь өөрөө инфляцаас хамаараад тухайн тухайн үедээ 3 сайд хамтраад батлаад явна. Бидний тооцоолсноор нэг хүүхдэд 50 мянган төгрөгийн 1 сарын хугацаанд суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх гэдэг энэ. Зөрүү цаад цаана нь үлдэж байгаа зардлыг нь эцэг эх оролцож гаргахаар ингэж зохицуулахаар төлөвлөсөн.

Дараагийнх нь, энэ процессын хувьд сонгон шалгаруулалт явагдана. Өөрөөр хэлбэл, тухайн аймаг, сум, нийслэлийн тухайн дүүрэгт хэдэн хүүхэд ямар чиглэлээр суралцах вэ гэдгийг тооцоолж, хүүхдүүдийн саналыг авсны үндсэн дээр спортын чиглэлээр тэдэн хүүхэд сургана гээд энэ нь ингээд багц болоод Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт нь зарлагдаад, шалгарсан гүйцэтгэгчтэй нь гэрээ байгуулаад, тэгээд хяналтын үйл ажиллагаа хэрэгжээд явах ийм зохицуулалтаар тооцож байгаа. Яах вэ, ер нь Дорнод аймагт энэ төсөл хэрэгжихдээ яг энэ зохицуулалтаар явж байгаа.

Нөгөө хувилбар нь нөгөө эрхийн бичиг өгөх, картад хүүхдэд картад картлуулаад, энүүгээрээ өөрөө сонголтоороо дугуйлангаа сонгоод явах тэгээд ийм 2 хувилбар байгаа. Тэгээд энийг хэлэлцүүлгийн явцад, анхдагч хууль учраас хэлэлцүүлгийн явцад энэ дээр сайжруулах, уялдаа холбоог нь илүү тодорхой болгох, тэгээд парламентад байгаа хуульч гишүүдийнхээ санал, зөвлөмжийг авч ажлын хэсэг, Байнгын хороод дээр ажиллаж энийгээ улам сайжруулах ийм боломж байгаа. Юутай ч анхдагч хууль хүүхдийн хөгжлийг дэмжих ийм нарийвчилсан зорилго руу явж байгаа хууль учраас энийгээ хэлэлцэх эсэхээ шийдвэрлэсний

дараа практик болон хууль эрх зүйн хувьд нь уялдаа холбоог нь хангаад, ингээд хэлэлцэх, сайжруулах бүрэн боломжтой гэж үзэж байгаа юм.

Б.Пүрэвдорж: Номинчимэг гишүүн нэмж тодруулъя.

О.Номинчимэг: Ойлголоо. Тэгээд энэ хуульдаа энийг тодорхой хийхгүй бол хууль чинь хэрэгжихгүй, Бадамсүрэн гишүүнээ. Тэгээд норматив зардлынхаа дор хаяж тэдэн хувийн ч гэдэг юм уу ингэж хуульдаа орж ирэхгүй бол төсвийн байдлаас хамаарна гэвэл нэг өдөр л төсвийн байдал чинь болохгүй нь гээд 0 болно. Тэгэхээр энэ нэг удаа, нэг жилээ хэрэгжээд, нэг жил нэг их хэрэгжихгүй байдал руу орчих вий дээ. Үнэхээр яг энийгээ тогтвортойгоор хөгжлийг нь дэмжинэ гэж байгаа бол энийг нь маш тодорхой хуульдаа зааж өгөх ёстой. Тэгж байж бид хэрэгжилтийг нь хангуулахын тулд бид төсөв, гүйцэтгэх засаглал, эндээ хяналтаа тавьдаг, шаарддаг, ийм болж байж л наадах чинь тодорхой явна гэж хэлмээр байгаа юм.

Тэгээд хоёрдугаарт, хөдөө орон нутаг болон хотын байдал өөр, хүн амын төвлөрөл, эдийн засгийн идэвхжил, эд нар нь өөр учраас магадгүй хөдөө орон нутаг тендерээр яваад ингээд нэг тусгайлсан зөвхөн тэр сумын ч байдаг юм уу, аймгийн хүүхдүүд яахад ийм секцийг гаргаж болох байх. Хотод олон секц байгаа тэгээд тэн дээр нь заавал тендер гэж завааралгүй ер нь байгаад нь оролцох боломжийг нь нээлттэй өгөх хэрэгтэй.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Энэ чинь заримынх нь суудал нь харагддаггүй. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Рэгдэл гишүүн алга байна. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн индрийн 2 дугаар микрофоноос үг хэлнэ.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль гэж энэ хууль цаг үеэ олсон гэж хэлэхэд хэцүү. Яагаад гэвэл бид ийм хуулийг аль эрт л гаргах ёстой байсан. Тэгэхээр хүүхдийн хөгжлийг дэмжинэ гэдэг ямагт л үе үеийнхний хамгийн түрүүнд хийх ёстой ажлын нэг, орж ирж байгаа нь сайн хэрэг. Би дэмжиж үг хэлнэ. Тэгэхдээ анхаарах зүйлүүд хэд хэд байгааг хэлье.

1 дүгээрт бид Үндэсний баялгийн сангийн тухай болоод Ирээдүйн өв сангийн тухай хууль дээрээ цоожилчихсон байгаа юм. Цоож зүүчихсэн 2030 гэдэг цоож. 2030 он хүртэл өнөөдөр энэ Ирээдүйн өв сангийн тухай хуулийн сангийн эх үүсвэр хөрөнгөөс 2030 он хүртэл энэ хуулийн 9.1, 9¹ дүгээр зүйлд зааснаас бусад хэлбэрээр зарцуулахыг хориглоно гээд ингээд заачихсан байж байгаа. Тэгэхээр энэ цоожийг бид энийг яг тодорхой хэмжээнд янзалж энэ цоожийг онгойлгохгүй бол энэ санхүүгийн эх үүсвэр нь тодорхойгүй болчхоод байгаа гэдгийг хэлье. Тэгэхгүй Үндэсний баялгийн сангийн тухай хуульд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн ирээдүй өв сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор гээд арвижуулах ёстой гэсэн. Үүний араас нь хуримтлагдсан хүүгийн орлогын 50 хувиас доошгүй хувийг хүүхдийн хөгжилд зориулна гэж нэмнэ гэж байгаа юм. Тэгэхээр энэ арвижуулах ёстой энэ заалттайгаа энэ нь яаж уялдаж байна вэ?

2 дугаарт Ирээдүйн өв сангийн энэ заалттай хэрхэн уялдаж байна гэдгийг эрхэм УИХ-ын гишүүд бид сайтар ярилцахгүй бол болохгүй. Энэ дээр Сангийн яам мэргэжлийнхээ дүгнэлт юмыг ирүүлэх ёстой шүү. Сангийн яам үүн дээр дуугүй байгаад байгаа нь миний сонирхлыг татаж байна. Энэ дээр ямар учиртай юм бэ? Яагаад гэвэл энэ тэнд байгаа, Лондонд байж байгаа, гадаадад байршуулчихсан 6 их наяд төгрөг өнөөдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийг ВВ түвшинд аваачих, зээлжих зэрэглэлийг тогтвортой байлгаж дээшлүүлэхэд тодорхой хувь нэмэр болж байгааг бүгд мэдэж байгаа. Ийм учраас Ирээдүйн өв сангийн тухай хуулийн тэр 9 дүгээр заалттай холбоотой энэ заалтыг бид ярихаас өөр арга байхгүй гэдгийг хэлье.

Хоёрдугаарт, энэ хуулийг хэрэгжүүлэхэд бид олон талаас нь ярилцах ёстой. Хамгийн оптималь /optimal/ буюу хамгийн тохиромжтой хувилбар тэр эрхийн бичиг. Эрхийн бичгээ хүүхэд болгон нь аваад аль сургалтын төв, аль дугуйлан, аль сургууль, аль номын сан, аль Насан туршийн суралцахуйн төв, хаана ч очих нь өөрийнх нь эрх байхаар ингэж зохицуулж эхлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Тэгэхээр энэ хуулийн төсөл дээр байгаа өнөөдрийн энэ заалтуудыг харахаар нэлээн зөвхөн барилга, байгууламжийг заачихсан, дээр нь нэмээд хүүхдийн ийм төвүүдийг байгуулаад байх юм шиг ингээд заачихсан байгаа. Бид өнөөдөр санхүүгийнхээ нөөц, бололцоог түшихээс өөр аргагүй. Энэ тохиолдолд бид хувийн хэвшил, төр хоорондын түншлэлийн хүрээнд олон асуудлыг шийдэх боломжтой гэдгийг бид харах ёстой юм.

Өнөөдөр Дорнод аймагт болон Сүхбаатар аймагт амжилттай хэрэгжсэн "Хүн болох багаасаа" гэж ийм сайхан хөтөлбөрүүд хэрэгжүүлээд, ингээд явчихсан. Сургуулиуд дээр дугуйлан, секцүүд хичээллэж байгаа нь нэлээд байгаа. Тэгэхээр энэ нэг ээлжтэй сургуулиудыг түшиглэсэн ийм үйл ажиллагаа явах нь их зүйтэй байгаа юм. Бусад үед нь энэ заалыг нь хэрхэн ашиглах, номын сангуудыг хэрхэн ашиглах, Насан туршийн суралцахуйн төвүүдийг хэрхэн ашиглах вэ гэдэг нь энэ хуулийн олон механизм талаас нь харж, бид энэ хуулийн бичилтийг нь чамбайруулах хэрэгтэй гэж ингэж бодож байгаа. Ер нь хүүхдийг хөгжүүлэх асуудал олон яам, тамгын газар, олон агентлагийг дамнадаг. Гэхдээ жишээлбэл сургууль дотор байхдаа Боловсролын яам.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж нэг минут үг хэлье.

П.Наранбаяр: Тэгээд тэндээсээ гарахаараа жишээлбэл Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяанд орно гэдэг биш, бид энэ хүүхэд өөрөө төрөхдөө л эрхийн бичигтэйгээ төрдөг, тэндээсээ хөгжих ийм боломжоор хангагддаг ийм байх ёстой гэж харж байна. Ийм учраас бид нэг жоохон шинэлэг хараад, ер нь өнөөдөр байж байгаа нөөц, бололцоо дээрээ суурилсан ийм Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг гаргаж ирэх нь зүйтэй гэж бодож байна.

Тэгээд эцэст нь яах вэ, энэ хуулийн төслийн нэртэй холбоотой байхад энэ "тухай" гэдэг үгийг нь аваад хаячихмаар санагддаг. Зүгээр Хүүхдийн хөгжлийг дэмжих хууль гээд, бид хууль болгон дээрээ "тухай" гэсээр байгаад ийм дандаа хууль болгон "тухай" нэртэй болчихсон байна. Энэ англи хэлний on, орос хэлний о, об гэдэг юмыг л зүгээр буулгачихсан ийм зүйл байгаа юм. Тэгэхээр энийг бодолцож үзнэ биз дээ. Шууд л Хүүхдийн хөгжлийг дэмжих хууль, ямар ч илүү ойлголт байхгүй, ямар нэгэн юмны тухай биш, шууд дэмжих хууль байгаасай гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Шинэбаярын Бямбасүрэн гишүүн индрийн 2-р микрофоноос үг хэлнэ.

Ш.Бямбасүрэн: Баярлалаа. Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага болон практик /practice/ шаардлагыг тодорхойлохдоо Монгол Улсын Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, НҮБ-ын (UN) холбогдох судалгаа, дүгнэлт, хүүхдийн хөгжлийн талаарх мэргэжлийн байгууллагын судалгаа, санал, дүгнэлтийг үндэслэсэн нь ийм төрлийн хууль, эрх зүйн зохицуулалт нэн шаардлагатай байгаа мэт боловч тус хуулийн төслийн зүйл, заалтыг нарийвчилж авч үзвэл дээр дурдсан үндэслэл, зорилгодоо хэрэгжүүлэх арга зүй, хүрэх үр дүн нь нийцэхгүй, зөрчилдсөн агуулга их байна гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын боловсролын хөтөлбөрт тусгагдсан зорилтыг давхардуулан зохицуулахаар, боловсролын байгууллагын хүний нөөц, дэд бүтцийг дайчлан ашиглах гэсэн зохицуулалтууд нь өнөөгийн хэрэгжиж байгаа боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг сулруулах, ойлгомжгүй байдал үүсгэх, нэгдсэн удирдлага болон бодлого алдагдах үр дагавартай байна гэж үзэж байна. Мөн хуулийн төслийн 11.1.3, 12.1.2, 12.1.5 дахь зэрэг заалтууд дээр Хүүхэд хөгжлийн төвийг ажиллуулах, хүүхэд хөгжлийг дэмжих сургалтын үйл ажиллагаа явуулахад төрийн болон орон нутгийн өмчийн бүх сургууль, цэцэрлэг, соёлын төв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн барилга байгууламжийг тэргүүн эгнээнд гэрээгээр ашиглуулах гэж заасан дээрх байгууллагуудын хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, цаашлаад чиг үүрэгт заагдсан сургалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөхөөр байна гэж үзэж байна.

Тэгээд ерөнхий агуулгаар нь авч үзвэл нэгдүгээрт, тус хуулийн төслийн 12.1.6-д төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хичээлээс гадуур хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтыг зохион байгуулах гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн сонгон шалгаруулж гэрээ байгуулах гэсэн байна. Тэгэхдээ энэ сонгон шалгаруулалтад ялсан чиглэлээр хамрагдсан хүүхдийн тоонд нийцүүлэн санхүүжилт авна гэж байгаа юм. Энэ дээр ерөөсөө сургалтын чанар, үр дүн ярихгүйгээр зүгээр ингээд хүүхдийн тоогоор ингээд асуудлыг хэлэлцэж байгаа нь учир дутагдалтай байна гэж үзэж байна.

Тэгээд сонгон шалгаруулалтад оролцож байгаа сургалт явуулах субъектүүд нь ихэнх нь сургуулийн багш нар байх бөгөөд өөрийн багшилж буй чиглэлээрээ хичээлээс гадуур төлбөртэй сургалт зохион байгуулна. Ингэхдээ сургуулийн заал, талбайг гэрээгээр ашиглах явдал бий болно гэж байна. Тэгээд нэгэнт заал, талбайн хүрэлцээ хангалттай биш байгаа өнөө үед давхар төлбөртэй сургалт хичээллэхэд сургууль, цэцэрлэгийн заал, талбайг ашиглах нь хүндрэл үүснэ гэж үзэж байна.

Хоёрдугаарт, хуулийн төсөлд тусгагдсан Хүүхэд хөгжлийн төв байгуулах асуудал нь дэмжих боломжтой агуулга байгаад байгаа юм. Тэгээд аймаг, сум, нийслэл, дүүрэгт Хүүхэд хөгжлийн төв байгуулахад улсын болон орон нутгийн төсвөөс шийдвэрлэх нь зүйтэй байгаа. Гэтэл Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагын заал, талбайг гэрээгээр ашиглах хэлбэрээр хэрэгжүүлэх талаар хуулийн төсөлд тусгасан нь бодит зорилгоосоо холдож, зөвхөн төлбөртэй сургалт явуулдаг сургалтын төвүүдийн үйл ажиллагааны хэлбэртэй болчхож байгаа юм.

Гуравдугаарт, энэ хуулийн зорилго нь маш тодорхой томъёолбол, хүнсний талон, соёлын ваучертай төстэй шийдэл байгаад байгаа юм.

Дөрөвдүгээрт, зах зээлийн зарчмыг эвдэж, зах зээлийнхээ зарчмаар өөрийнхөө сургалтын төвийг ажиллуулж байгаа хувийн ААН-үүдтэй төр өрсөлдөх гэж байгаа юм шигээр ийм компаничилсан байдлаар ийм юмыг төсвийн мөнгөөр, татвар төлөгчдийн мөнгөөр, ирээдүйн хуримтлалын мөнхөөр санхүүжүүлэх нь буруу гэж үзэж байгаа юм. Иймд хүүхдийн хөгжлийг дэмжих нэрийн дор төрөөс хүүхдийн хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлж буй боловсролын цогц бодлогын хэрэгжилтийг бууруулах, үр дүнгүй халамж мэт төсөв захиран зарцуулах үр дагавартай хуулийн төслийг дэмжихгүй гэсэн байр суурьтай байна. Үүний оронд харин Хүүхэд хөгжлийн төв, эсвэл Хүүхдийн ордон, эсвэл хүүхэд, залуучуудад дутагдалтай байгаа спорт заалны хүртээмжийг нэмэгдүүлбэл энэ чиглэлээр хүүхэд, залуучууд хөгжих боломжтой. Тийм учраас.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Дэмжихгүй байр сууринаас үг хэллээ. Отгоны Саранчулуун гишүүн индрийн 1-р микрофоноос үг хэлнэ.

О.Саранчулуун: Энэхүү хуулийг үзвэл 9 чиглэлийн үйл ажиллагааг хүүхдийн хөгжлийн чиглэлээр дэмжинэ гэсэн байгаа юм. Үүний 5.1.3-т Спортын биеийн тамир гэжээ. Миний хувьд болохоор нэг туршлага ярья л даа. Одоогоос 10 жилийн өмнө бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг зөвхөн алхалт, гүйлтээр сэдэлжүүлэх замаар эрүүл мэндийг нь сайжруулах, өөртөө итгэх итгэлийг нь дээшлүүлэх ийм хөтөлбөрийг эхлүүлсэн. Бид 116, 29-р сургууль, 55, 60 гээд 70-р сургуулиудаар хэрэгжүүлэхэд хүүхдүүдийн эрүүл мэнд, нийгмийн оролцоо, олон зүйл сайжирсан ийм үр дүн байгаа. Бид энэ хөтөлбөрийнхөө үр дүнд жил болгон хүүхдүүдийн, багачуудын гүйлт гэж арга хэмжээ зохион байгуулдаг. Энийг бид яаж зохион байгуулсан бэ гэхээр, тухайн хүүхэд тэр ангийн анги удирдсан багш, биеийн тамирын багш нар, сургуулийн нийгмийн ажилтан, удирдлагатай нь хамтран ажиллаж, гэрээ хийж, харилцан эцэг эхтэй нь ажилласнаар энэ хөтөлбөр үр дүнтэй явж байгаа гэсэн үг.

Би нэг юмыг хэлэх гээд байгаа санаа нь болохоор, бид янз бүрийн хүүхдийн хөгжлийг дэмжих гоё санаачилга байгаа ч гэсэн, ер нь хүүхдүүд рүү чиглэсэн энэ сургалтын аливаа үйл ажиллагаа зөвхөн нэг шинэ байшин барихад ч биш, гол нь тэнд ажиллаж байгаа багш нарт арга зүй дутагдалтай холбоотой асуудал байгаа байхгүй юу. Өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд жишээлбэл 11 дэмжих төв байгаа. Сургууль авч чадахгүй байгаа учраас, сургуульд арга зүй дутагдаж байгаа учраас, дээрээс нь зарим хүүхдүүд үнэхээр хүнд бэрхшээлтэй байгаа учраас. Тэгвэл бэрхшээл арай гайгүй, сургуульд сурч байгаа хүүхдүүдэд нь нэлээн тусламж хэрэгтэй хүүхдүүдэд нь биеийн тамирын багш нартай нь ажилласнаараа хүүхдүүд нийгмийн оролцоог хангаж, сайжруулж болоод байна.

Тэгэхээр Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хэрвээ ярьж байгаа бол бид багш нарыг дэмжээд, багш өөрөө тэр хичээлийнх нь цаг, багш нарын сургууль дээрх үйл ажиллагааг нь дэмжих аргачлал, арга зүй, энэ чиглэлийн дэмжлэгийг түлхүү явуулбал илүү нэгдүгээрт, зардлын хувьд үр өгөөжтэй, хоёрдугаарт, одоо байгаа боловсролын энэ салбарт ажиллаж байгаа хүмүүсийн хувьд ч гэсэн үр бүтээмжийг нь сайжруулна, дээрээс нь хүүхдүүдэд чиглэсэн хөтөлбөрийг баяжуулах ийм боломжтой гэж бодоод байгаа. Тэгэхгүй бол сургуультайгаа өрсөлдөх сургуулийн

гадуур дахиад нэг хөтөлбөр гэхээр дахиад бүтэц, дахиад үйл ажиллагаа, дахиад өрсөлдөөн, дахиад тусдаа юм болох гээд байгаа.

Дараагийн нэг асуудал нь 21 аймаг, 9 дүүрэгт Насан туршийн суралцахуйн төвүүд байна гэж байна, жилээс жилд хүүхдүүдийн тоо, оролцоо нь буурсан гэсэн. Бид түрүүн асуусан чинь асуултдаа хариулт авч чадаагүй, яагаад буурсан юм бол. Тэр чинь арга зүйд байгаа байхгүй юу. Бид багш нарыг арга зүйгээр дэмжих ёстой. Жишээлбэл маш сайн сургалтад сургасан, өчнөөн олон юм сурчихсан багш нар чинь сургуульд ажиллахгүй, сургуулийн гадна өрсөлдөгч болж орж ирээд байх ийм нөхцөл байдал байгаа шүү дээ. Өнөөдөр хувийн зарим сургуулиуд өчнөөн сургуулийн нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлж болоод байгаа байхгүй юу, тэр чинь арга зүйтэй байгаа.

Тэгэхээр миний бодлоор хүүхдийн хөгжлийг дэмжих агуулгыг би дэмжиж байна үзэл баримтлалын хувьд. Гэхдээ хэрэгжүүлэх механизмын хувьд бид яг энэ дээр байгаа шиг ийм хүртээмжтэй олон төвүүд, багш нар үйл ажиллагаа явуулаад хэрэгжүүлэе гэвэл, нэг бол одоо улсын сургуульд ажиллаж байгаа багш нарынх нь цагийг тийш нь ингэж зөөх ийм хоёрдмол байдал руу оруулах уу гэдэг нэг ийм болгоомжлол байгаад байна.

Дээрээс нь манай хүүхдийн чиглэлээр Монгол Улсад хүүхдийн хөгжлийн чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаа, дугуйлан, секцүүд өөрсдөө хүртээмжтэй болж эхлээгүй л байгаа байхгүй юу. Тэгэхээр бэлэн биш байгаа юм шиг санагдаад. Тэгэхээр байгаа багш нар, одоо байгаа багшийн хөтөлбөрүүдийг баяжуулах, багшийг чадваржуулах, биеийн тамирын хичээл, жишээлбэл зөвхөн биеийн тамирыг аваад үзэхэд биеийн тамирын сонголтыг илүү өргөн болгож өгөх замаар энэ агуулгыг хэрвээ сайжруулах юм бол илүү бодитой бөгөөд илүү олон хүүхдэд хүртээмжтэй болно гэж ингэж үзэж байна.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг хуулиудтай нэгтгэж явуулна.

18.42 цаг

Ес.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл

Дараагийн асуудалд оръё. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцэнэ. Илтгэлийг Хүний эрхийн үндэсний Комисс /ХЭҮК/-ын дарга Дугарын Сүнжид танилцуулна, индэрт урьж байна.

Д.Сүнжид: Эрхэм УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12, 9 дүгээр зүйлийн 9.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15.1.4, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.3.5, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 24.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн Комисс хуулиар олгогдсон чиг үүргийн дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг 2026 оны 03-р сарын 27-нд УИХ-д хүргүүллээ. Энэ удаагийн илтгэлийг Монгол Улсын урт, дунд хугацааны

бодлого, төлөвлөлт, Комиссын стратеги төлөвлөгөө, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд хийсэн хяналт, шалгалт, иргэдээс Комисст ирүүлсэн гомдол, мэдээлэл, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, судалгаа, дүн шинжилгээ, төрийн болон бусад байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, бусад эх сурвалжид үндэслэн 6 бүлгийн хүрээнд боловсруулж, УИХ-аар шийдвэр гаргуулахаар 60 саналын хамт тоймлон танилцуулж байна.

Нэгдүгээр бүлгийн хүрээнд иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилтийг авч дүгнэсэн. Хүний амьдралын чанар зөвхөн орлого, эдийн засгийн өсөлтөөр хязгаарлагддаггүй. Эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлт, орчны чанар, аюулгүй байдал, нийгмийн оролцоо, сайн сайхан байдал зэрэг олон хэмжээсний нийлбэр ойлголт байдаг учир эдгээрийг цогц байдлаар хүний хөгжлийн индекс, Тогтвортой хөгжлийн зорилтуудын албан ёсны үзүүлэлтүүд, бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалт зэрэг олон улсад хамгийн өргөн хэрэглэгддэг хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтээр хэмждэг.

Хүн амын тоо сүүлийн 10 жилд өсөж, дундаж наслалт нэмэгдсэн ч гэсэн эрүүл мэндийн зарим суурь үзүүлэлтүүдэд ахиц гарахгүй байгаа. Нас баралтын түвшин сүүлийн 10 жилийн дунджаас өссөн, хотжилт, хүн амын насжилт, эмзэг бүлгийн эзлэх хувь нэмэгдэж байгаа нь эрүүл мэндийн тогтолцооны бодлого, зохицуулалт, хэрэгжилтийг цогц байдлаар шинэ түвшинд гаргаж, хүн амын амьдралын чанарт бодит, тогтвортой өсөлтийг бий болгосноор үр дүнгээ тооцоход чиглүүлэх хэрэгцээ, шаардлагыг бий болгожээ. Эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг бодитой хэрэгжүүлэхэд талуудын оролцоог хангах хариуцлагын механизм чухал бөгөөд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд иргэний эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээр тусгаж, холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрт хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих тодорхой зорилтуудыг дэвшүүлж, 2021 оноос нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжин томоохон өөрчлөлтийг хэрэгжүүлж байгаа хэдий ч зорилт, үр дүнгийн зөрүү байсаар байна. Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх үзэл баримтлалд суурилан хүний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийн баталгааг бүрэн хангахын тулд эрүүл мэндийн салбарын бодлого, тогтолцоо, хууль, эрх зүйн орчин, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, даатгал, санхүүжилт, хүний нөөцийн асуудал зэрэг эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал, зөрчил, шалтгаан нөхцөл, тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, нийт 18 саналыг дэвшүүллээ.

Хоёрдугаар бүлгийн хүрээнд "Шүүх шинжилгээ ба хүний эрх" сэдвийг авч үзсэн. Энэ сэдвийн хүрээнд шинжлэх ухаан, технологийн хөгжилд тулгуурлан нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хараат бусаар үндэслэл бүхий дүгнэлт гаргаж, хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд шүүх шинжилгээний байгууллага чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсад шүүхээр шийдвэрлэгдсэн дийлэнх хэрэг, ялангуяа хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бэлгийн хүчирхийллийн болон авто тээврийн гэмт хэрэг, зөрчилд шинжээчийн дүгнэлтийг заавал гаргаж, тус дүгнэлтэд үндэслэн хэргийг эцэслэн шийдвэрлэдэг практик нэгэнтээ тогтжээ.

Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр шинжилгээ хийх үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн Хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх эрх,

хувийн мэдээллээ хамгаалуулах эрх, хохирлоо нөхөн төлүүлэх эрх, шударгаар шүүлгэх, нотлох баримтаа шалгуулах зэрэг үндсэн эрхийг хөнддөг эмзэг асуудал юм. Иймээс шинжээчийн тусгай мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, тэдний хараат бус байдлын баталгааг хангах, шинжилгээнд ашиглах техник, технологи, лабораторийн орчин нөхцөл нь хүний эрхийн олон улсын зарчим, хэм хэмжээнд нийцсэн байх, шүүх шинжилгээний үйл ажиллагаанд хүний эрхийг хангах чиглэлд онцгойлон анхаарал хандуулахыг НҮБ (UN) болон түүний гишүүн улсуудаас зөвлөдөг. Комиссоос шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гүйцэтгэж буй үүрэг, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, төв, орон нутгийн нөхцөл байдалд үнэлэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар 11 саналыг дэвшүүллээ.

Гуравдугаар бүлгийн хүрээнд олон нийтийн мэдэх эрхийн төлөв байдлыг авч үзсэн бөгөөд Монгол Улсад мэдээлэл хайх, хүлээн авах эрх нь Монгол Улсын Үндсэн Хууль болон олон улсын гэрээгээр баталгаажсан ардчилсан засаглал, төрийн ил тод байдал, олон нийтийн хяналтыг хангах суурь эрх юм. Уг эрхийг хэрэгжүүлэх хүрээнд сүүлийн жилүүдэд эрх зүйн орчин, институцийн тогтолцоо тодорхой хэмжээнд бүрдэж, мэдээллийг ил болгох хүрээ, ил тод байдлын үзүүлэлтүүд ахицтай өөрчлөгдөж байгааг тэмдэглэж байна. Гэвч бодит хэрэгжилтийн түвшинд мэдээллийн ил тод байдал нь илүү хэлбэрийн шинж давамгайлж, мэдээллийн чанар, хүртээмж, бодит хэрэглээ хангалтгүй хэвээр байна.

Түүнчлэн мэдээллийн ангилал, нууцлалын зохицуулалтын уялдаа сул, нууцын хүрээ өргөн, тодорхой бус байгаа учир мэдээллийг дур мэдэн нууцлах, улмаар олон нийтийн мэдэх эрхийг хязгаарлах эрсдэлийг бий болгож байна. Мөн мэдээлэл авах хүсэлтийг шийдвэрлэх, татгалзсан шийдвэрийг хянан шалгах, хариуцлага тооцох механизмын нөлөө сул байгаа нь эрх зөрчигдсөн тохиолдолд үр дүнтэй хамгаалалт бүрдэхгүйг харуулж байна. Иймээс иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийн хүрээнд эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг хүний эрхийн зарчимд тулгуурлан үнэлж, шийдвэр гаргуулахаар 6 саналыг дэвшүүллээ.

Дөрөвдүгээр бүлгийн хүрээнд Хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилтийг авч дүгнэсэн бөгөөд 2020 онд Монгол Улс Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталж, хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлыг тодорхойлон үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, эрх зүйн үндсийг бүрдүүлсэн нь бүс нутгийн хэмжээнд ахиц дэвшилтэй алхам болсон төдийгүй нийгэмд хүний эрх хамгаалагчийн эрхийн талаарх мэдлэг, ойлголт дээшилсэн эерэг үзүүлэлт гарсан.

Өмнө нь Комиссоос УИХ-д хүргүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлүүдэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдөж байгаа салбар, чиглэл тус бүрд хэрэгжилтийг үнэлж, тодорхой санал, зөвлөмжийг тусгасан боловч хэрэгжилт хангалттай бус байгааг албан ёсны тайлан, хэлэлцүүлгүүд илэрхийлж байна. Мөн Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн нийтлэг үүргийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, эрсдэл учирсан хүний эрх хамгаалагчийг хойшлуулшгүй хамгаалалтад авах төрийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, тэдэнд хууль, эрх зүй, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх тогтолцоо бий болох асуудал тулгамдсан хэвээр байна. Хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилтэд үүсэж буй эрсдэл, тулгамдсан

саад бэрхшээлийг бууруулах, түүнчлэн төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн нийтлэг үүргийн хэрэгжилтийг төрөөс хэрхэн хангахад чиглэсэн арга хэмжээний талаар дүгнэж, 6 саналыг дэвшүүллээ.

Тавдугаар бүлэгт Хүүхэд хамгааллын тогтолцооны анхаарах зарим асуудлыг авч үзсэн бөгөөд энэ хүрээнд хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо нь хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхэд хамгааллын нэгдсэн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төсөв, санхүү бүхий олон талт, цогц хамтын ажиллагаанаас бүрддэг. Монгол Улс хүүхэд хамгааллын тогтолцооны эрх зүйн орчныг сайжруулах, үйлчилгээ, бүтэц, санхүүжилтийг нэмэгдүүлэх зэргээр тодорхой ахиц дэвшлийг гаргаж байгаа хэдий ч хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий зарим бүтэц, нэгжийн үйл ажиллагаа хэлбэр төдий явагдаж, уялдаа холбоогүй, үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн хангалтгүй байна гэж дүгнэсэн.

Хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, Хүүхдийн эрхийн улсын байцаагч, 108 Хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төв, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас томилогддог шинжээч, хууль ёсны төлөөлөгч, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан баг, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны талаар энэхүү илтгэлд тусгаж, цаашид авах арга хэмжээний талаар 11 саналыг дэвшүүллээ.

Зургаадугаар бүлэгт жендерийн эрх тэгш байдлыг хангахад эрэгтэйчүүдэд тулгамдсан асуудлыг авч үзсэн. Монгол Улс 2011 онд баталсан Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар төр, эдийн засаг, нийгмийн соёлын хүрээнд болон гэр бүлийн харилцаанд жендерийн эрх тэгш байдлын баталгааг бүрдүүлж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах чиглэлээр жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги, эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.

Гэвч жендерийн тэгш байдлыг хангах эрх зүйн орчин, бодлогын хэрэгжилт нь эрэгтэйчүүдийн амьдралын хэв маяг, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал зэрэг эрсдэлт хүчин зүйл, суурь шалтгааныг бүрэн өөрчлөөгүй байна. Тухайлбал, Монгол Улсад 2024 оны байдлаар эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс 8-аас 9 жилийн хугацаагаар бага, үйлдвэрлэлийн ослын 65-аас 75 хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна. Мэргэжлээс шалтгаалсан өвчний 79 хувь, зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 80 орчим хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Эрэгтэйчүүдийн хувьд боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, сэтгэцийн эрүүл мэнд, амь насны эрсдэл өндөр байгаа бөгөөд тэдний асуудал үл үзэгдэгч хэвээр байгааг дээрх статистик үзүүлэлт харуулж байна.

Энэхүү нөхцөл байдал нь зөвхөн хувь хүний асуудал бус нийгмийн тогтолцооны асуудал юм. Комисс Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, осол гэмтлийн нөхцөл байдалд хийсэн судалгаа, дүн шинжилгээ, холбогдох байгууллагын баримт мэдээлэлд тулгуурлан асуудлыг дүгнэж, шийдвэр гаргуулахаар 8 саналыг дэвшүүллээ.

Эрхэм УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ХЭҮК-оос танилцуулж буй Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцэн цаашид авах арга хэмжээний талаар холбогдох шийдвэрийг гаргаж өгөхийг хүсье. Баярлалаа.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 18 цаг 44 минутаас хуралдааныг даргалав.

С.Бямбацогт: Сүнжид даргад баярлалаа. Хүний эрхийн илтгэлийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна, таныг индэрт урьж байна.

Х.Баасанжаргал: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ХЭҮК-оос 2026 оны 03-р сарын 27-ны өдөр УИХ-д ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг Хууль зүйн байнгын хороо 2026 оны 05-р сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлд заасны дагуу Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж, холбогдох санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд ирүүлсэн.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг судалгаа, тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, дүгнэлтэд үндэслэн иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилт, шүүх шинжилгээ ба хүний эрх, олон нийтийн мэдэх эрхийн төлөв байдал, хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын тогтолцооны анхаарах зарим асуудал, жендерийн эрх тэгш байдлыг хангахад эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал зэрэг 6 бүлэг сэдвийн хүрээнд бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын ХЭҮК-ын дарга Дугарын Сүнжид танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үеэр УИХ-ын гишүүн Сайнзориг шүүх шинжилгээ ба хүний эрхийн асуудлын хүрээнд шүүх шинжилгээний байгууллагын албан хаагчдын ажлын байрны нөхцөл байдал, цогцос хадгалах зориулалтын тоног төхөөрөмжийн хүрэлцээ, шинэчлэлийн талаар, олон нийтийн мэдэх эрх хангагдаж байгаа эсэх, тогтолцооны хувьд хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд анхаарах асуудлын талаар, УИХ-ын гишүүн Цэнгүүн яаралтай эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийн хүрээнд Монгол Улсад 2024 онд бүртгэгдсэн аврах боломжтой нас баралтын тоон мэдээллийн талаар, УИХ-ын гишүүн Баасанжаргал Шүүх шинжилгээний байгууллагын өнөөгийн нөхцөл байдал, хүүхэд шүүх шинжилгээнд орж байгаа тохиолдолд тусгай нөхцөл, шаардлага тавигддаг бөгөөд нийслэл, орон нутгийн хувьд уг шаардлага хэрхэн хангагддаг талаар, шүүх шинжилгээний дүгнэлт нотлох баримтын хүрээнд шаардлага хангаж байгаа эсэх, Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, хяналтад хүүхдийн оролцоог хангаж байгаа эсэх, өмнөх оны УИХ-ын тогтоолд туссан боловч биелэгдээгүй асуудлуудын талаар тус тус асуулт асууж, хариулт авсан.

Байнгын хорооны хуралдаанаар УИХ-ын гишүүн Сайнзориг шүүх шинжилгээний байгууллагын албан хаагчдын үйл ажиллагаанд шаардагдах

зориулалтын тоног төхөөрөмжийн шинэчлэлийг бодлогын түвшинд анхаарах, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг хэлэлцэхэд ЗГ-ын гишүүд, холбогдох төрийн байгууллагын төлөөлөл хуралдаанд заавал оролцдог байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хүний эрхийн тайлан, илтгэлтэй уялдуулж сонсдог болох, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд илтгэл хэлэлцэх дэгийг нарийвчлан зохицуулах талаар, УИХ-ын гишүүн Баасанжаргал Монгол Улсын Ерөнхий сайд аймаг, орон нутгийн удирдлагуудыг томилохдоо хийх гэрээнд хүүхэд хамгааллын асуудлыг тусгаж, шалгуур үзүүлэлт боловсруулж оруулах санал гаргаж байгаа талаар тус тус үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.5 дахь хэсэгт "Энэ хуулийн 115.2.3, 115.2.15-д заасан илтгэл, тайланг холбогдох Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд заавал танилцуулах бөгөөд бусад тайлан, илтгэл, мэдээллийг холбогдох Байнгын хороо хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанд танилцуулж болно" гэж заасны дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ХЭҮК-ын 25 дахь илтгэлийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Баасанжаргал гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүхэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцүүлж байгаа ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя: Дугарын Сүнжид ХЭҮК-ын дарга, Хүрэлбаатарын Мөнхзул ХЭҮК-ын гишүүн, Жаргалсайханы Хунан ХЭҮК-ын гишүүн, Батзэвэгийн Энхболд ХЭҮК-ын гишүүн, Сангишаравын Дондов ХЭҮК-ын гишүүн, Баттулгын Батбямба ХЗДХЯ-ны ТНБД, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын яамны ТНБД, Адъяасүрэнгийн Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД, Бавуужавын Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД, Намжилын Эрдэнэбаяр ЭМЯ-ны ТНБД, Сүрэнжавын Ганзориг Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн дарга. Мягмарнаран дарга хаана байна вэ, дуудаарай.

УИХ-ын тухай хуулийн 21.24-т Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан болон бусад этгээд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй, 21.25-д Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, УИХ-д худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж тус тус заасныг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сануулъя.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд нэрээ өгнө үү? Лутаагийн Энхнасан гишүүнээр тасаллаа. Ирцийн дараалалд оруулъя. Лутаагийн Энхнасан гишүүн асуултаа асууя.

Л.Энхнасан: Өдрийн мэнд хүргэе. Энэ удаагийн ХЭҮК-ын тайланд жендерийн эрх тэгш байдлыг хангах асуудалд эрэгтэйчүүдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг хөндөж авсан байна. Өнөөдөр Жендерийн асуудлыг зөвхөн эмэгтэйчүүдийн хүрээнд авч үздэг биш, эрчүүдийн тулгамдаж байгаа боловсролын хоцрогдол, өвчлөл, дундаж наслалтын зөрөө, амиа хорлолт, осол гэмтэл болон гэнэтийн нас баралтыг энд авч үзсэн байна. ХЭҮК энэ асуудлыг олон нийтийн анхааралд хүргэж байгаад талархал илэрхийлье. Статистик мэдээг үзвэл Монгол Улсын амиа хорлолтын түвшин дэлхий дунджаас 2 дахин өндөр байна. Эрэгтэйчүүдийн ялангуяа амиа хорлолтын түвшин эмэгтэйчүүдээс 5-аас 8 хувь их байна гэж харагдаж байна. Ялангуяа 15-аас 40 насны эрэгтэйчүүд хамгийн өндөр эрсдэлтэй гэж харагдаж байна. Эрэгтэйчүүд яг хөдөлмөр эрхлэх эсхүл эдийн засгийн дарамтаас болоод уу, эсхүл гэр бүлийн харилцаа, нийгмийн хүлээлтээс болж сэтгэл гутралд эсхүл орж байна.

Мөн тайлангаас харахад осол гэмтлийн тухайд харвал 2025 онд замын тээврийн ослоос 536 хүн амь насаа алдсан байна гэж эмгэнэлтэй тоо гарч байна. Ялангуяа эрэгтэйчүүд гэнэтийн болон гаднын шалтгаанаас нас баралт өндөр байна. Бусад орноос манай амиа хорлолт дэлхийн дундаж түвшнээс өндөр байна. Ялангуяа Ази дээрээ Солонгосын дараа орж байгаа шүү дээ. Бүр 2-т.

Мөн тайлангаас харахад хүн амын дундах санамсаргүй хордох хордлогын шалтгааны нас баралт дэлхийн дунджаас 1,7 дахин өндөр байна гэсэн статистик мэдээ харагдаж байна. Тэгэхээр би илүү комиссоос асуухаас илүү тайлан дээр амиа хорлолтыг урьдчилан сэргийлэхээр төлөвлөгөө боловсруулж байгаа юм байна яам, 2026-аас 29 онд гэж байна. Төлөвлөгөө нь одоохондоо батлагдаагүй байгаа юм байна. Энэ яагаад батлагдаагүй байгаа, ямар төлөвлөгөө дээр ямар, ямар асуудлууд орсон юм бэ? Энэ дээр яам ямар бодлого баримталж цаашдаа ажиллах гэж байгаа юм бэ? Энэ Сэтгэцийн эрүүл мэндийн хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулахгүй болохгүй юм байна лээ. Сэтгэл зүйн нэр томьёо болон салбарт.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд асуултаа асуучихъя. 1 минут.

Л.Энхнасан: Ирэх жил эрүүл мэндийн жил болох гэж байгаа учраас сэтгэцийн биш, ялангуяа сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудлыг нэр томьёог ялангуяа төрөөс баримтлах бодлогыг бид тодорхой болгох хэрэгтэй байна. Энэ дээр яамнаас хариулт өгмөөр байна. Ямар ажил төлөвлөж хийх гэж байгаа вэ?

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? ЭМЯ уу? ТНБД-аас асуух шиг боллоо. Ажлын хэсэг хариулъя 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Энхнасан гишүүний асуултад хариулъя. ЭМЯ ТНБД Эрдэнэбаяр. Амиа хорлолтоос сэргийлэх төлөвлөгөөг бид салбар дундын байдлаар боловсруулаад ажлын хэсэг ажиллаад явж байгаа. Энэ чиглэлээр ХЭҮК-оос зөвлөмжүүд ирсэн. Энэ дагуу салбар дундын баг үүсгээд, 2026-аас 2029 оны төлөвлөгөө гэдэг энэ төлөвлөгөөг боловсруулаад хэлэлцэгдээд явж байгаа. Удахгүй

батлагдана. Яг энэ төлөвлөгөөнд нарийвчилж зааж байгаа зүйлүүдийг танд нэмэлт байдлаар тодруулаад өгчихье. Бичгээр албан.

С.Бямбацогт: Аль болох асуултад уул нь гүйцэд хариулах гишүүдийн асуултаар дамжуулж иргэд олон нийт мэдээлэл авч байгаа. Тийм болохоор бичгээр хариулчихъя гээд байхгүй боломж олдсон дээрээ та нар өөрсдийнхөө салбарын үйл ажиллагаа, эрүүл мэндийн салбарт баримталж байгаа бодлого, зорилт, хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр бусад зүйлсээ уул нь тодорхой хариулчихвал зүгээр шүү. Энхнасан гишүүн тодруулж асуух уу?

Л.Энхнасан: Би хуультай холбоотой асууж байна. Түрүүн яам дээр бид нийгмийн эрүүл мэндийн ажлын хэсэг ажиллаж байхад энэ сэтгэл зүйн асуудлыг хуульд тусгана гэж ярьж байсан. Энэ хуулийн төсөл шинэчлэгдэж байгаа гэсэн ямар түвшинд байгаа вэ, ЗГ-аас оруулах гэж байгаа юу? Хэрвээ тийм оруулах гэж байгаа төлөвлөгөө байхгүй бол би энэ хуулийг өөрөө санаачлаад оруулъя гэсэн бодолтой байна.

С.Бямбацогт: Яг хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт биш байна Энхнасан гишүүнээ, тэгэхээр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуултаа асууна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: ХЭҮК-ын энэ 25 дугаар илтгэлийн 3 дахь хэсэг буюу олон нийтийн мэдэх эрхийн талаар хэсгээс нь асуулт асууя. Үндсэн хуулийн 16.17 дээр Монгол Улсын иргэн төрийн нууцад хамаарах асуудлаас бусад асуудлаар мэдээлэл хайж, хүлээж авах эрхтэй гээд заачихсан байгаа. Энэ эрх нь зүгээр нэг иргэний эрх гэхээсээ гадна төрөө иргэд хянах, төр иргэнийхээ өмнө хариуцлага хүлээх гол ач холбогдолтой заалт байдаг, эрх байдаг. Энэ эрхийг хязгаарлаж байгаа зүйлүүд талаар нэлээн дурдсан байна. Энэ эрхийг хязгаарладаг, хуулиар хязгаарладаг юм нь Төрийн болон албаны нууцын тухай хууль байдаг. Өмнө нь 1995 онд Төрийн нууцын тухай гэж хууль батлагдаад 2016 онд шинээр төрийн болон албаны нууц болгож, өөрөөр хэлбэл төрийн гэдэг дээр нь албаны нууцын тухай зүйл, заалт нэмж ингэж өргөжүүлсэн. 1995 онд батлагдсан хууль 22 жилийн хугацаанд албаны болж нэмэгдэхээсээ өмнө төрийн нууцад хамаарах 22 л мэдээлэл байсан бол албаны нууцыг нэмснээрээ 8 жилийн хугацаанд энэ нууцын тоо нь 7 дахин нэмэгдсэн, 575 болсон. Иймэрхүү дүр зураг, тоон мэдээлэл байна.

Тэгээд яах вэ албаны нууц гэдэг зүйл нэмж оруулаад энэтэй уялдаатайгаар шаардлагагүй олон зүйлийг нууцад авсан. Энэнээс үүдээд авлигатай холбоотой, нийтийн өмч, хөрөнгийг шамшигдуулахтай холбоотой ийм асуудлууд, хар сэрүүд байнга үүсэж байсан. Энэ хуулийн өөрчлөх гээд хуулийн төсөл УИХ-ын чуулганд орж ирсэн боловч яг хэлэлцүүлэг нь материал тараагдаад гэнэт алга болчихсон байгаа. Энэ яг хууль хэзээ хаана орж ирэх вэ? Энэ ямар шатандаа явж байгаа вэ? Энэ талаар мэдээлэл өгөх хүн байвал өгөөч?

Энэтэй холбоотой би зүгээр нэг жишээ хэлье л дээ. Харбины гэрээ гэж бид хэдийн хувьд ярьдаг УИХ маань яг энэ мэдэх эрхэд өөрөө эс үйлдэл, санаатай болон санамсаргүй байдлаар ингээд ийм эрхэд халдаад байгаа юм. Жишээлбэл Харбины гэрээ Үндсэн хуулиараа энэ газрын хэвлийн баялаг ард түмний баялаг гээд энэ баялаг эзэн байна гэдэг чинь мэдэх эрх нь хамгийн чухал эрх байгаа. Энэ эрхийг нь олон улсын гэрээгээр Үндсэн хуулиар олгосон эрхийг нь ингээд хязгаарлачихсан. Энэ Харбины гэрээний 5.6 дээр нь болохоор заасан заалтаар болохоор төрийн

байгууллагууд хоорондоо, жишээлбэл Сангийн яам энэ гэрээний талаар мэдээлэл авахдаа, жишээлбэл Хятадын талаас зөвшөөрөл авахаар иймэрхүү байдалд оруулчихсан. Ер нь Үндсэн хуулиар олгосон эрхийг хязгаарлахад зөвхөн хуулиар хязгаарладаг. Энэ олон улсын гэрээгээр хязгаарладаг иймэрхүү асуудлууд.../минут дуусав/

С.Бямбацогт: ХЭҮК-ын дарга Сүнжид хариулъя. Индрийн 3 дугаар микрофон.

Д.Сүнжид: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Олон нийтийн мэдэх эрх дээр, төрийн болон албаны нууц дээр таны хэлсэн тоо баримтыг ер нь дурдсан. Төрийн нууц, албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний нууц гээд бид ийм нууцтай холбоотой асуудлыг нэг талаасаа алийг нь нууцлах шаардлагатай, нөгөө талаасаа алийг нь олон нийтэд мэдээлэх шаардлагатай вэ гэдэг ийм шалгуурыг тогтоогоод, бид Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хувь хүний мэдээллийн тухай хуулийг шинэчилсэн найруулсан. Ахиц дэвшил байгаа хэдий ч гэсэн цаасан дээр илүү зохицуулалтын түвшинд, яг бодит байдал, хэрэгжилтээр нууцад авах шаардлагагүй мэдээллийг нууцад авсан байна гэдгийг тоо баримттайгаар дүгнэсэн байгаа. Мөн Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслийг манай ХЭҮК-оос дүгнэж үзээд, тэгээд энэ дээр зарим ахицууд гарсан байна, зарим дээр нь дахин ажиллах, боловсруулах шаардлагатай байна гэдэг дүгнэлтийг хийсэн. Эхний хэсэг дээр тантай санал нийлж байна. Гэрээний тухайд бид яг тухайлан үзээгүй учраас яг энэ дээр дүгнэлт хэлэх боломжгүй байна.

Ер нь үндсэн зарчим юу вэ гэхээр нууцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийт мэдэх боломжтой. Ингэж байж бид нар авлига, төрд итгэх илтгэл, олон нийтийн итгэл гэдэг ийм зүйлийг олж авдаг. Дээрээс нь энэ ашиг сонирхлын зөрчил урвуугаар ашиглах эрсдэл гэдэг зүйлээс сэргийлэхийн тулд л бид нийтийн мэдээлэл нууц байх ёсгүй мэдээлэл гэдгийг ангилдаг. Энэ хүрээнд тодорхой өөрчлөлт хийх ёстой гэдэг дүгнэлтийг хийсэн байгаа.

С.Бямбацогт: Тодруулъя. Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Нөгөө шинэ хуулийн төслийн талаар нэмэлт мэдээлэл өгөх гэж байна уу 4 номер дээр. Тэгэх гэж байгаа бол би тэрийг тодруулж асуух гэж байсан юм. Яг энэ хуулийн төсөл маань ямаршуу шатандаа явж байгаа юм бол? Энийг эртхэн шиг хэлэлцээд баталчихвал энэ Үндсэн хуулиар олгосон энэ мэдэх эрхтэй холбоотой нэлээн сайжирсан ийм хуулийн төсөл явж байгаа харагдсан. Тэгээд энэ талаар мэдээлэл өгөөч?

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Б.Батбямба: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. ХЗДХЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбямба байна. Энэ хуультай холбоотойгоор Монгол Улсын ЗГ-аар хэлэлцсэн байгаа ХЗДХЯ-наас холбогдох санал санал, дүгнэлтээ боловсруулаад ЗГ-ын 2026 оны 01 сарын 08-ны өдрийн 1/26 тоот тогтоолоор хүргүүлсэн. ЗГ дээр хэлэлцээд энэ хуулийг яг энэ хэлбэрээр нь оруулахад учир дутагдалтай байна гэж үзээд түр буцаасан. Одоо ингээд дахиж энэ санал, дүгнэлтүүдээ хэлэлцэх шатдаа явж байгаа. Зөвхөн энэ хуулиас гадна энэ хуулийг дагаад нийтдээ бараг 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт орохоор хуулийн

төсөлд тусгагдсан явж байгаа. Тэр гол тэр дагах дагаж мөрдөх журмын тухай хуулийн хүрээнд энэ санал, дүгнэлтүүд боловсруулагдаад явж байгаа гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: ХЭҮК Хүний эрх хамгаалагчийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хөдөлмөрийн тухай, УИХ-ын хяналт шалгалтын тухай, УИХ-ын хуралдааны дэгийн тухай, Нийтийн сонсголын тухай зэрэг 9 хуулиар шууд үүрэгжүүлсэн байгаад байдаг Хүний эрхийн Комиссыг. Гэхдээ Хүний эрхийн комисс нь өөрөө хэрэгжүүлэгч байгууллага биш. Тэгээд жил болгон ийм зузаан, зузаан илтгэл гаргадаг. Тэгээд манай гишүүд зарим нь ийм ном тараасан юм уу гэж асууж байгаа шүү дээ. Тэгэхээр уншсан, уншаагүй ийм нөхцөл байдалтай байгаа байхгүй юу.

Тэгээд хэрэгжилтийг аваад үзэхлээр манай УИХ-ын хяналт шинжилгээний газар 2018-аас 24 оны хооронд УИХ-аас гарсан энэ дагасан тогтоол 6 шийдвэрийн хүрээнд 6 жилийн хяналтыг хийсэн чинь үнэлгээ хийсэн чинь 35,2 хувийн хэрэгжилттэй гэж. Тэгэхээр л бид чинь нэг л юм буруу хийгээд байна л гэсэн үг биз дээ тийм ээ? Тэгэхээр энийг сайжруулах тал дээр шинэ УИХ-ын дарга бид ер нь анхаарах ёстой юм байна. Дагаж гарч байгаа тогтоолууд яагаад биелэхгүй байна вэ? Хүний эрхийн Комисс зөвлөмж үүргийг биелүүлээгүй хүмүүст хариуцлага тооцуулах саналыг оруулах үүргийг хүлээж байгаа УИХ-д. Тэгээд 1 ч ийм хариуцлага тооцуулах санал оруулж ирж байгаагүй. Тэгэхээр энэ дээр анхаарах ёстой юм байна.

1 дүгээрт, зүгээр нэг удаа хэлэлцээд өнгөрөх биш, нэгэнтээ л ийм зузаан ном гаргаж байгаа юм бол Байнгын хороод энэ асуудлуудыг нэг бүрчлэн өөрийнхөө хариуцах асуудлуудаа уншиж, танилцаж, тогтоол шийдвэрүүдийг гаргаж, засагт үүрэг чиглэл өгсөн бол тэр нь яагаад хэрэгжихгүй байна вэ гэдэг дээрээ хариуцлагатай хандах шаардлагатай байна гэж.

Энэ удаагийн энэ 25 дугаар илтгэлийн эрүүл мэндийн хэсэг болон эрэгтэйчүүдийн энэ жендерийн эрхтэй холбоотой хэсэг нийлээд бараг энэ номын тал нь яг энэ эрүүл мэндтэй холбоотой асуудал байгаа байхгүй юу. Тэгээд яг уншаад үзвэл яг өнөөдөр тулгамдаад байгаа асуудал буюу иргэний эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь зөрчигдсөн байна гэдэг нь харагдаж байгаа юм. Тэгээд энэ дээр яг хамгийн гол зүгээр агуулгаар нь би хэлбэл энэ ЭМД-ын нэг худалдан авагчийн гүйцэтгэлээр санхүүжих зарчим. Ер нь энэ эрсдэлийг бий болгож байна гэсэн ерөнхий нэг ийм дүгнэлт гарчхаад байгаа юм. Энэ нь өөрөө юутай холбоотой юм бэ гэхээр УИХ-ын гишүүд нэг талдаа эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын цалинг нь 75 хувь цалинг нь нэмэгдүүлнэ гээд шийдвэр гаргачхаад, улсын төсвөөс нэг ч төгрөг тавихгүй шимтгэл төлөгчдийн буюу нийгмийн даатгалын санд хариуцуулаад үлдээчихдэг. Тэгээд нөгөө зардлаа дааж чадахгүй, эргээд нөгөө шимтгэл төлөгч шимтгэлээ төлчхөөд өөрсдөө үйлчилгээгээ авч чадахгүй нөхцөлд хүрээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ агуулгаар нь та хэд.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуулт, хариулсныхаа дараа тодруулж асууя. Ажлын хэсэг 3 дугаар микрофон ХЭҮК-ын дарга Сүнжид.

Д.Сүнжид: Ариунзаяа гишүүний эхний тавьдаг Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэлийн мөрөөр УИХ-аас жил бүр тогтоол гаргадаг. Энэ тогтоолын хэрэгжилт өөрөө хангалттай байгаа эсэх гээд энэ дээр үнэхээр мөрөөр нь арга хэмжээ авах шаардлагатай. ХЭҮК дүн шинжилгээ хийж үзсэн. Энэ дээр сүүлийн зөвхөн өнгөрсөн жилийн 25 оны 77 дугаар тогтоолын хэрэгжилт гээд тэгэхэд 50 хувь хүрэхгүй 47 гэдэг үнэлгээтэй байдаг. Энэ дээр тухайлбал хүүхдийн эрхийн асуудлыг жил болгон авч үзсэн байдаг. Энэ нь хамгийн бага хэрэгжилттэй хувь гэж ингэж явдаг. Тийм учраас нэгэнт УИХ-ын тогтоол гарсан учраас хууль тогтоомжид заасны дагуу ЗГ-аас тогтоолын хэрэгжилтийг холбогдох Байнгын хороо, УИХ-д тайлагнах үүргийг хэрэгжүүлэх, түүний шалтгаан нөхцөлийг тодорхойлох, мөн хариуцлага тооцох асуудлыг ярих гэдэг энэ саналыг дэмжиж байгаагаа илэрхийлье.

2 дахь асуултыг гүйцэж асуусных нь дараа би хариулах уу? Эрүүл мэндтэй холбоотой. Эрүүл мэндийн салбарт тулгамдаж байгаа асуудал ийм 6 бүрэлдэхүүн хэсэг эрүүл мэндийн салбарт авч үзэж байна тогтолцооных нь хувьд. 1 дүгээрт эрх зүй, удирдлага, засаглалын хувьд авч үзэж байна. Энэ дээр тулгамдаж байгаа асуудал байна. Ер нь аль болох санхүүжилт нь хаанаас тодорхой хөтөлбөр, төсөл, төсөл батлахгүй бол бид ингэж зөвхөн сайхан зорилго тавьж батлаад тэгээд санхүүжилтийг ЭМД-ын санд ингэж гаргах нөхцөл байдал өөрөө ийм зохимжтой биш юм байна. Нөөцийн хуваарилалтыг зохистой хуваарилж байгаа хэрэг биш байна. Удирдах удирдлагыг томилж зохион байгуулж байгаа асуудлыг шинэчлэхгүй бол ТУЗ-ийн 30 хувь нь томилогдсон байдалтай, энэ улс төрөөс нөлөө бүхий гэдэг ийм байдалтай байдаг учраас энийг өөрчлөх шаардлагатай байна гэдэг 1 дүгээр дүгнэлт байгаа.

2 дугаарт хүрэлцээний асуудал байгаа. Энэ дээр бид хүрэлцээ ярихад энэ эмийн чанар, нөөц, тоног төхөөрөмж, эмч, ор гээд энэ нөөцүүд, статистикуудыг ярихдаа гол нь хот, хөдөө энэ ялгаатай байдлуудыг авч үзэх ёстой гэдэг дүгнэлтийг хийж байгаа. Хүртээмжийн асуудал дээр мэдээлэл үйлчилгээний хүртээмж гэж байгаа, орчны хүртээмж гэж байгаа бүгдээрэнд нь анхаарах ёстой, 62 хувь хангалтгүй байна гэдэг ийм дүгнэлтийг бид нийтэд нь хийгээд байгаа юм. Тэгээд энэ тодорхой бүлгүүд байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадууд, жирэмсэн эмэгтэйчүүд, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд ч гэдэг юм уу энэ хөдөө орон нутаг, суурин газраас алслагдмал газар амьдардаг хүмүүст эрүүл мэндийн үйлчилгээ хүргэхэд энэ хүртээмжийн асуудлыг сайжруулах ёстой гэдэг дүгнэлтийг хийсэн. Санхүүгийн даатгалын асуудал буюу санхүүгийн хамгаалалт гэж бид нэрлээд байгаа. Энэ дээр бид энэ нэг худалдан авалтын тогтолцоог сайн гэж үзсэн боловч өглөг, авлагын хэмжээ асар их, нэг талдаа өглөгтэй, нөгөө талдаа авлагатай. Эцэстээ иргэн өөрөө сэтгэл хангалуун биш, халааснаасаа гарч байгаа зардал өндөр, гадаадад зарим талаар Монголд оношлогдох, эмчлэгдэх боломжтой гэж үзэж байгаа хэдий ч гадаадад заавал 2 хүн тутмын нэг нь Монголд оношлогдох боломжтой, эмчлэгдэх боломжтой өвчний талаар гадаадад зорчдог гээд нэг ийм үзүүлэлт байгаа учраас өрхийн аж ахуй, санхүүд шууд нөлөөлөх ийм дарамт болж байна.

Иймээс санхүүгийн хамгаалалтыг сайжруулах ёстой, энэ өглөг, авлагыг барагдуулах үе шаттай алхмыг хийх ёстой гэдэг дүгнэлтийг хийсэн. Чанар нийцтэй, аюулгүй байдлын хүрээнд энэ оношны зөрөөтэй байдлыг буюу тэр эмчээс хамаарах, тоног төхөөрөмжөөс хамаарах энэ байдлыг бууруулах ёстой гэж дүгнэлтийг хийсэн. Яагаад гэхээр энэ дээр 13 хувь оношны зөрөөтэй байдал явж байгаа гээд. Тийм учраас энэ эмчилгээ үйлчилгээний аюулгүй байдал, чанар гэдэг

дээр анхаарах ёстой гээд нийтдээ энэ 5 шалгуур үзүүлэлтээр тус бүрд нь анхаарах асуудлууд бүгдэд нь байна гэдэг дүгнэлтийг хийж саналыг дэвшүүлсэн.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Тэгэхээр аливаа энэ сангийн буюу нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сангаас гарч байгаа зардлыг хэрэвзээ УИХ-ын гишүүд шийдэх гэж байгаа бол улсын төсвөөс санхүүжилтийг нь шийддэг байх хэрэгтэй гэдгийг онцлон хэлмээр байна. Цалин хөлсний нэгдсэн бодлого алдагдсан байна гэдгийг бусад салбарууд дээрээ та хэд маань дүгнэсэн байна. Энэнтэй ч гэсэн би санал нэгдэж байна. Цалин хөлсний бодлогоо ЗГ нэгдсэн байдлаар авч үзэхгүй бол салбар бүр дээр өөр, өөр, төрийн албан хаагчдыг хохироож байгаа, ялгаварлаж байгаа ийм асуудал байна гэдгийг хэлье.

Мөн түүнчлэн нэг дүгнэсэн асуудал болохоор Монгол Улс хорт хавдрын шалтгаант нас баралтаар дэлхийд тэргүүлж, шинээр бүртгэгдсэн хорт хавдрын бараг 2/3 нь хожуу шатдаа оношлогдож байгаа, тамхинаас шалтгаалсан нас баралт нийт нас баралтын 17 хувийг эзэлж, жил бүр ойролцоогоор 4300 хүн тамхины хэрэглээтэй холбоотой нас барж байна гэсэн байгаа юм. Тамхины хуулиа батлаач. Ажлын хэсгийг хэн ахалж байгаа вэ?

С.Бямбацогт: Тамхины хууль манай Номинчимэг нарын гишүүд өргөн барьсан. Ахалж байсан ажлын хэсгийн гишүүн нь ЗГ-ын гишүүн болоод солигдсон, Чинбүрэн гишүүн ахалж байгаа. Чинбүрэн гишүүн 2 удаа хуралдах гээд ирц нь бүрдэхгүй байх шиг байна. Шаардлагатай бол ажлын хэсэгт би хэлсэн байгаа. Хуралдаа ирэхгүй байгаа гишүүдийг ажлын хэсгээс гаргаад, ажлын хэсгийнхээ гишүүдийн тоог цөөлөөд, цааш нь хэлэлцээд явах наад хуулиа хурдан батлах талд нь чиглэл өгч байгаа. Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Нэгэнтээ Хүний эрхийн комиссын энэ илтгэл дээр нь яг энэ тамхины хэрэглээнээс шалтгаалсан бүр эдийн засгийн алдагдал жил бүр 801 тэрбум болоод, Монгол Улсад сүрьеэгийн өвчлөл ихтэй, олон ийм тэсвэртэй сүрьеэгийн дарамт өндөр 30 орны нэгд ороод, бүр энэ тамхины шалтгаант нас баралтыг онцолсон байхад энэ тамхины ажлын хэсэг бүтэн жил гаруй Тамхины тухай хуулийг ингээд дараад суучхаж болохгүй. Ийм учраас болохгүй бол ажлын хэсгийн гишүүдийг нь цөөлөөд, тэгээд энэ хаврын чуулгандаа багтааж хуулийг баталмаар байна даргаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн хурал нь удаа дараа хуралдах гээд хуралдаж чадахгүй, ажлын хэсгийн ахлагч нь солигдсон, бас 2 удаа хуралдах гээд хуралдаж ирц нь хүрэхгүй, 2 удаа хуралдсан гэнэ, ирц их муу байгаа гэж байна. Тийм болохоор жоохон эрчимжүүлнэ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууж, үгээ хэлье.

П.Сайнзориг: Баярлалаа. ХЭҮК-ын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаад комиссын илтгэлүүд чуулганы нэгдсэн хуралдаанд орж ирж хэлэлцдэг болсон. Хуучин ХЗБХ-н дээр сонсоод л дуусчихдаг байсан, ач холбогдол өгөх нь бага, энэ 5 дахь удаагийнх болж байгаа юм байна. Тэгэхээр би энийг цаашдаа үр дүнтэй болгох талаас нь 2 санал хэлье гэж бодож байгаа. Би ХЗБХ-ны хурал дээр хэлсэн, өнөөдөр тэнд ЗГ-ын юм уу холбогдох төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулдаг байя гэдэг энэ саналыг хэлсэн. Энэ дээр шуурхай арга хэмжээ авсан УИХ-ын Тамгын газартаа баярлалаа. Ер нь сонсоод сууж байх хэрэгтэй байгаа юм.

Өчигдөр Эдийн засгийн байнгын хороон дээр Заяабал дарга хэлж байна лээ шүү дээ. Энэ яамнуудаас бараг хүн ирэхээ больсон, мэргэжилтнүүд ирдэг болсон. Би Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн компанийн хууль хуралдуулах гээд үзэж л байна. Яамнуудаас хүн ирэхээ больсон, мэргэжилтэн л ирж байгаа. Тэгээд мэргэжилтэн нь нөгөө дандаа шинэ хүүхдүүд байна лээ. Бичиж тэмдэглэхээсээ залхуураад дуу хураагуур нууцаар биччихсэн сууж байгаа байхгүй юу. Үгүй ээ, үнэхээр энэ төрийн алба бүр дампуурч байна. Тэгээд сая Мөнхбаатар дарга өглөө хэллээ. Цэцийн гишүүн шууд шийдвэрээ уншчихаад гараад явчхаж байгаа байхгүй юу. Энд гишүүд юу хэлээд байгааг ерөөсөө байхгүй, сонсохыг бүр үл хүндэтгэж байгаа байхгүй юу. Үнэхээр хараат бус байж болно, тэгэхдээ энэ гаргасан шийдвэртэй холбоотойгоор энэ УИХ, парламент юу хэлж байгааг нэг сонсоод суучих тэвчээртэй байх ёстой шүү дээ. 1 дүгээрт энэ зарчмыг хэлмээр байна. Тэгээд төрийн байгууллагууд ирсэнд баярлалаа.

Энэ 614 хуудас материал бүхий 6 сэдвээр ингээд бэлдээд ирлээ, илтгэл. Тэгэхээр ер нь зүгээр би комиссоос зохион байгуулалтын талаас нь эхлээд нэг асуугаадахъя гэж бодож байгаа юм. Энэ сэдвүүдийг ер нь та хэд яаж сонгож байгаа вэ? Тухайн жилийн илтгэлийг бэлтгэхдээ ямар шалгуурыг барьж байна? Ямар үзүүлэлтүүдийг анхаарч үзээд илүү энэ рүүгээ чиглэе гэж явж байгаа вэ? Энийг зүгээр нэг танин мэдэх үүднээс асууж байгаа юм.

Би тэгээд хурлын даргад нэг уриалга гэх юм уу, хурлын дарга дэмжиж өгөөч гэж байгаа юм. Ер нь цааш цаашдаа яах вэ, энэ комиссынхоо илтгэлийг сонсоход яг энэ ЗГ-ын гишүүд байя. Энэ дээр жишээ нь жендер, хүүхдийн эрхийн асуудал ярихаар Ерөнхий сайдын асуудал гээд харахаар Хэрэг эрхлэх газрын дарга сууж баймаар байгаа байхгүй юу. Тэгэхээр би энэ дээр юу хэлэх гэж байна гэхээр энийг хэдүүлээ бүтээмжтэй ажил болгоё, хавар Хэрэг эрхлэх газрын дарга бараг 20, 30 хүнтэй бүх Байнгын хороо руу ороод хууль тогтоомжийн хэрэгжилтийг танилцуулаад явсан юм. Тэгэхээр үүнтэй тухайн жилийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү их тодруулж уялдуулчихмаар байна. Комисс сонгож авсан энэ сэдвийн хүрээнд тухайн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт хэр байгаа юм бэ гэдгийг уялдуулаад, энэ дээрээсээ хэдүүлээ тал талынхаа тэр хийсэн судалгаа, нөөц энэ чинь ингээд үр ашиггүй хаяж болохгүй шүү дээ. Тэгэхээр энийгээ уялдуулаад яг хуулийг нь өөрчлөх бол өөрчилье, төсөв тавих бол тавья, яадаг юм бэ зохион байгуулалтыг нь хийж өгөх бол өгөөд ингээд ЗГ, бусад төрийн байгууллагууд ингээд хүчээ нэгтгэмээр байна. Комисс гэдэг УИХ гишүүд баталсан хуулийнхаа.../минут дуусав/

С.Бямбацогт: 1 минут Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Комисс гэдэг УИХ өөрөө баталсан хуулийнхаа араас өөрсдөө ажлын хэсэг гаргаад хяналт тавьж болно. Дээрээс нь энэ байгууллагуудаа ашиглаад ирүүлж байгаа тайланг нь ашиглаад хяналт шалгалтаа хийж байгаа механизм байхгүй юу. Тийм учраас ЗГ-ын төлөөллүүд маань сонсож сууж байгаад, яг шударга л хэлэх ёстой, үнэхээр хууль чинь болохгүй байна, төсөв чинь болохгүй байна, тэгээд энийгээ ингээд нэг яг тухайн сэдэв байдаг юм уу нэг комисстойгоо эсхүл тохирчхож болж байна, 5-аас 6 сэдвээс хэтрэхгүй байя гээд. Яг тэр чиглэлийнхээ хууль тогтоомжуудын хэрэгжилтийг бүтнээр нь ЗГ хийгээд яг хавар дээрээ яг чуулган дээрээ уулзаад, цагийг нь хэлэлцэх цагаа нэг ахиухан тавьж байгаад тэгээд бодит үр дүнгээ гаргадаг, төсөв хэлэлцэхдээ энийгээ анхаардаг, ирэх намрын чуулгандаа холбогдох хуулийг нь барьдаг ч юм уу ийм зохион байгуулалтад оръё

гэдэг зүйлийг хэлж байна. Тэгээд хурлын дарга анхаарч өгөөч. Би дэгийн хуулийг намрын чуулганд өргөн барья гэж бодож байгаа. Энэ хавар арай амжихгүй юм шиг байна. Ийм чиглэлээр ингээд тал талд хийж байгаа энэ судалгаа материалуудаа яг нэгтгэж, хүчээ нэгтгээд яг ажлын.../минут дуусав/

С.Бямбацогт: УИХ-ын үйл ажиллагааг сайжруулах УИХ-ын тухай болон Дэгийн тухай хуулиуд, Хяналт шалгалтын хуулиудын нэмэлт, өөрчлөлт өргөн барьсан, ажлын хэсэг байгуулагдах гэж байгаа. Энэ хүрээндээ Сайнзориг гишүүний ярьж байгаа энэ асуудал зарим нь хөндөгдсөн, орсон байгаа. Ингээд УИХ-д хүндэтгэлгүй хандвал Төрийн албаны тухай хууль болон бусад хуульд заасны дагуу хариуцлага тооцно гээд ерөнхий заалттай. Энэ заалтыг яасан бэ гэхээр яг ямар албан тушаалтан яагаад хариуцлагагүй, хүндэтгэлгүй хандав, ямар үйлдэл гаргав, үүнийг нь томилсон байгууллага руу нь, томилсон байгууллагын удирдлага руу нь албан бичгээр явуулаад хариуцлага тооцож эргэж мэдэгд гээд, ямар хариуцлага тооцсон тухай эргэж мэдэгдээд, мэдэгдсэнийг нь хуралдаан даргалагч, Байнгын хорооны дарга болон чуулганы хуралдаан даргалагч УИХ-ын гишүүдэд нийтэд мэдэгддэг байх. Ингэж илүү хүч оруулсан зохицуулалт орж байгаа, ингэж УИХ-даа илүү хүндэтгэлтэй хандах энэ зохицуулалтыг хийж байгаа.

Тайлантай холбоотой асуудал дээр манай Тамгын газрын энэ Хяналт шалгалтын газрынхан байхгүй байж байна. Энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх газар байж байгаа, энэ газрынхан сууж байх ёстой. Яах аргагүй, юу гэдэг юм ХЭҮК-ын тайлан хэлэлцэж байх үед энэ ямар асуудал дээр онцолсон юм. Энэ жилийн тухайд гэвэл иргэний эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэж байна. Энэнтэй холбогдуулаад Эрүүл мэндийн сайд, ЗГ-ын гишүүн сууж байх, мөн шүүх шинжилгээ ба хүний эрх гэж байна Хууль зүй, дотоод хэргийн сайд сууж байх, Хүний эрх хамгаалагчийн эрхийг хэрэгжилт гээд Хууль зүй, дотоод хэргийн сайд, хүүхэд хамгааллын тогтолцооны асуудал гээд энэ дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан, жендерийн асуудал ярьж байхад Жендэрийн үндэсний хорооныхон, холбогдох албан тушаалтнууд нь сууж байдаг.

Мөн энэ тайлан хэлэлцэх үед нь ЗГ-ын үйл ажиллагааны тайлантай хамт хэлэлцэж, энэ үйл ажиллагааны тайлангийн урд нь юм уу хэлэлцэж хооронд нь уялдуулж энэ хуулийн хэрэгжилтийг илүү сайн хангуулах талд нь бид бодлогын зохицуулалт хийе хуулийн. Ингэж өгөх юм бол УИХ-ын хянан шалгах чиг үүргээс илүү үр дүнтэй болно, УИХ хуулийн хэрэгжилтдээ илүү анхаарал тавьдаг, энд нь ач холбогдол өгдөг болно, ингэхгүй тэгээд нэг тайлангаа танилцуулсан болдог, Их Хурал нэг хэлэлцсэн болдог, нэг цөөхөн гишүүн сууж байгаад нэг сонссон болдог, тэгээд бодлогын шийдэл байхгүй, үр дүн байхгүй ингэдгийг өөрчилье. Тэгэхээр Тамгын газар энэ ажлын хэсэг байгуулагдах үед нь энэ дээр мэргэжил арга зүйн туслалцаа үзүүл. Наана нь хүмүүсээ Хяналт шалгалтын газар, тэр Хуулийн хэрэгжилтийн хяналт тавих газрынхнаа суулга, оруулж ир. Энэ асуудал дээр тодорхой шийдэл гаргаж оруул. Бусад асуултад ХЭҮК Сүнжид дарга хариулъя, 3 дугаар микрофон.

Д.Сүнжид: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Сэдвийг яаж сонгодог вэ гэхээр 1 дүгээрт нь стратеги дээр нэг хүний эрхийн төлөв байдлыг үнэлсэн үнэлгээ байдаг, түүнийхээ чиг баримжааг хардаг, 2 дугаарт ирүүлж байгаа гомдол, мэдээллийг хардаг, 3 дугаарт нь бид иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм, соёлын эрх, зорилтот бүлгийн эрхийг эн тэнцүү авч үзэхийг хичээдэг. Мөн бусад хуулиар тогтоосон мэдээллийн тухай, хүний эрх хамгаалагчийн эрх зүйн

байдлын тухай, мөн жендерийн эрх тэгш байдлыг хангах гээд энэ хуулиудын хүрээнд заасан үүргээ харгалзаж сэдвүүдийг бид сонгодог юм. Тэгээд сүүлийн 4 жил эдийн засаг, нийгэм, соёлын эрхээр, иргэний болон улс төрийн эрхээр сэдэв давхцуулахгүй бид жил бүр илтгэж байгаа. Жагсаал, цуглаан хийх, хэвлэн нийтлэх эрх чөлөө өмнөх 22, 23 дахь илтгэлд оруулсан ч гэдэг юм уу. Тэгээд хөдөлмөрлөх эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрохыг өмнөх 21, 22, 23-д оруулаад ингээд нэг ийм байдалтайгаар Үндсэн хуульд заасан эрхүүдийг 3 бүлэглээд ээлж дараалан илтгэлдээ тусгаж ингэж дүгнэж явж байна.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Тэгэхээр энэ батлагдсан бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг л бид хэд бас энэ сонсож байгаа нэг хэлбэр шүү дээ, хүний эрх талаасаа. Тийм учраас комисс сэдвээ батлангуут энийгээ ЗГ-т хүргүүлээд, ЗГ нь энэ сэдвийн дагуу, тухайн салбарын сэдвийн хүрээнд яг хөндөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүтэн үнэлээд оруулж ирээд, энэ комиссын илтгэлтэй араас нь хэлэлцдэг, тэгээд шийдвэрээ гаргадаг баймаар байгаа юм. Түүнээс биш хавар та хэд анзаарсан уу, бүх Байнгын хороогоор Хэрэг эрхлэх газрын дарга 20, 30 хүнтэй тойрсон шүү дээ. Тэгсэн чинь журам батлаагүй, баталсан энэ тэр гээд ийм тайланг бид сонсмооргүй байгаа юм, хууль тогтоомжийн тайланг. Тэгэхээр яг ийм, энэнтэйгээ уялдуулаад цаашдаа яах вэ гэдгээ анхааръя. Тэгээд би яах вэ, уг санаагаа Бямбацогт даргыг дарга болоход бичгээр хүргүүлсэн, манай нэг дэд дарга Эрдэнэбат дарга дээр хамтарч ажиллаад энийг яг ажил болгоё гээд бид явж байгаа. Энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийг яг ингэж ач холбогдол өгч сонсоод, тэгээд сайжруулах, тодруулах, хэрэгжилтийг нь эрчимжүүлэхэд бид өөрсдөө юу анхаарах.../минут дуусав/

С.Бямбацогт: Яг энэ тайлан хэлэлцэж байгаа үед хяналт, шалгалт хариуцсан удирдлагууд, Тамгын газрынхан, зөвлөхүүд сууж байх ёстой шүү. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Үг хэлж болно.

Х.Баасанжаргал: Асуулт, үг нэг билүү даргаа, хамтдаа тийм ээ. Асуулт, үгээ хэлчихье. Эхний ээлжид үг хэлээдэхье. УИХ, ХЗБХ, Хүний эрхийн дэд хороо анх удаа ХЭҮК-ыг чуулганаар, Байнгын хороогоор хэлэлцэхээсээ өмнө орон нутагт буюу Өвөрхангай аймагт урьдчилсан нэг ийм жижиг хэлэлцүүлгийг анх удаагаа хийж үзлээ. Хүний эрхийн дэд хорооны санаачилгыг дэмжсэн Их Хурлын даргад баярлаж талархсанаа илэрхийлье. Өвөрхангайн хүүхдүүд оролцсон. Тийм учраас би энэ чуулган дээр хүүхдүүдийнхээ үзэл бодол юу илэрхийлснийг, ямар хүсэлтийг энэ Их Хурлын гишүүдэд гаргасныг хэлж танилцуулах нь зүйтэй байх гэж бодож байна. Түүний зэрэгцээ Их Хурал цаашид ер нь энэ ордноос гарч хурлаа хийдэг, орон нутгийн иргэдээ сонсдог, зөвхөн тойрог гэхгүйгээр институцийн хэмжээнд орон нутагт ажилладаг ийм байдлаар арга барилаа хэдүүлээ өөрчилье гэсэн саналыг уламжилъя даргад.

Хүүхдүүдийн хувьд хэд хэдэн саналыг хэлсэн, 1 дүгээрт хүүхдүүд гэрээсээ сургууль, сургуулиасаа гэр хүрэх энэ орчин, зам, аюулгүй байдал хангагдахгүй байна гэдгийг хүүхдүүд хэлсэн. Тэр дундаа онцолж байгаа нь эзэнгүй нохой, гэрлэн дохионы оновчгүй зохицуулалт гэж байгаа юм. Гэрлэн дохионы оновчгүй зохицуулалт, дуусаагүй барилга, байгууламж өөрөө аюултай орчныг бий болгоод байна гэсэн. 2 дугаарт номын сангийн хүртээмж бага, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх орчин, нөхцөл бидэнд хангалтгүй байна, үүнийг шийдээд өгөөч гэсэн. 3 дугаарт энэ

бидэнд хандсан их гашуун үг. Юу вэ гэвэл томчууд, насанд хүрэгчид өөрсдөө шударга бус байдлыг бидэнд харуулаад байна. Тухайлбал тэмцээн, уралдаан зохион байгуулахдаа маш шударга бус шүүлт хийдэг, томчууд өөрсдөө шударга байгаач гэдгийг дамжуулсан. 4 дүгээрт үе тэнгийн дээрэлхэлт, хүүхдийн гаргасан элдэв аливаа алдаа, зөрчилд нь ямар хариу арга хэмжээ аваад байгаа юм, ямар төлөвлөгөө гаргаад байгаа юм бэ гэдэг чинь бидэнд ерөөсөө тодорхой биш байна. Эсрэгээрээ та нар энэ алдаа гаргасан хүүхдийг дандаа шийтгэнэ гэж яриад байх юм, бид үүнийг хүсэхгүй байна. Алдаа гаргасан хүүхдийг шийтгэх биш, цааш нь засаад, залруулаад аваад явчхаач, та нар ийм бодлого гаргаж чадахгүй байгаа юм уу гэсэн.

Хамгийн сүүлд нь хүүхдийг оролцуулж тэдний дуу хоолойг сонсдог боловч асуудлыг нь хэрхэн шийдвэрлэсэн талаар бидэнд ерөөсөө эргэж мэдэгддэггүй. Та нар бидний энэ хүсэлтийг бичиж аваад, цүнхэндээ хийгээд битгий мартаарай гэж дамжуулсан. Тэгэхээр бид хүүхдийн баярыг хүүхдийн баяр гэж тэмдэглэхээс илүү бүгдээрээ үүрэг хүлээгчид, хүлээсэн үүргээ биелүүлсэн үү, үгүй юү гэдэгтэй дүн шинжилгээ хийдэг ийм өдөр байгаасай гэж хүсэж байгаа. Тийм учраас манай Хүний эрхийн дэд хорооны хувьд хамгийн анх энэ орон нутгийн томилолтоо Өвөрхангай аймгаас эхлүүлж, Өвөрхангай аймгийн хүүхдүүдийн дуу хоолойг энэ өдөр Их Хурлын чуулганы танхимд.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, асуучихъя, нэг минут.

Х.Баасанжаргал: Орон нутгийн хүүхдүүдийн дуу хоолойг бага ч болов энэ чуулган дээр илэрхийлэх ёстой гэж бодож манай Хүний эрхийн дэд хорооны гишүүд орон нутагт ажилласан. Цаашид ч гэсэн бид Хүний эрхийн энэ илтгэлийг үндсэндээ 25 жил бид энэ байшин дотор сонслоо. Яг л энэ байшин дотроо яг улс төрчид л сонслоо. Иргэдтэйгээ хамт сонсож, тэдний санаа бодлыг тусгаж, УИХ-ын тогтоолыг биелэхүйц бодитой гаргадаг, үүнийх нь мөрөөр хяналт шинжилгээ хийдэг, яг саяын Сайнзориг гишүүний хэлдэг энэ саналын дагуу бүтэн ийм бодлогын цикл дор оруулах хэрэгтэй байна. Ийм саналыг гаргаж байгааг та бүхэн хүлээж авч, УИХ-ын гишүүд дэмжиж, илүү бодитой байх гэдэг тал дээр илүү санаачилга гаргаж хамтарч ажиллаасай гэж хүсэж байна. Тэгээд Хүний эрхийн дэд хорооны гишүүд энэ тал дээр бүгд энэ хүний эрхийн асуудал дээр дуу хоолойгоо байнга чангаар илэрхийлж байх болно гэдгийг уламжилъя, баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэллээ. Яах аргагүй сая энэ 06 сарын 01-нд Эх, үрсийн баяр болно. Эх үрсийн баярын өмнө хүүхдийн эрхтэй холбоотой асуудал, хүний эрхтэй холбоотой асуудлуудыг Их Хурал хэлэлцэж байгаа. Үүний өмнө ч гэсэн манай Хүний эрхийн дэд хороо, Баасанжаргал даргаар ахлуулсан дэд хороо ХЭҮК-той хамтраад орон нутагт хүүхдийн эрхийн асуудлаар тодорхой дэд хорооны хурлаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Сая ярьж байгаа гэрлэн дохионы оновчгүй зохицуулалт, дээрээс нь дуусаагүй барилга эрсдэлтэй байна, эзэнгүй нохой, томчуудын шударга бус байдал болох зөвхөн орон нутагт биш хаа сайгүй л Улаанбаатарт ч байж байгаа асуудал.

Тийм болохоор иймэрхүү асуудлууд дээр манай ХЭҮК энэ жил тайлангаа оруулж ирсэн байна, хүүхдийн хамгааллын тогтолцоонд анхаарах зарим асуудлууд гээд. Үүнтэй холбоотой УИХ-аас тогтоол гарна. Үүний дараагийн хэлэлцэх асуудал дээр. Энэ дээр манай гишүүд тодорхой байр суурь илэрхийлж танилцаж, энэ хүүхдийн эрхэд илүү онцгой анхаарч, онцолж тогтоол гаргах тал дээр анхааръя.

Мэдээж тогтоол зүгээр нэг гаргаад өнгөрдөг биш, гаргасан тогтоолоо бодит амьдрал дээр хэрэгжих, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг нь үнэлж, дүгнэж үр дүнг нь тооцох энэ зохицуулалт бидэнд чухал байгаа. Хамгийн их хаягдаад, орхигдоод байгаа асуудал сая Баасанжаргал гишүүн хэлж байгаа асуудлууд мөн. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ анхаарцгаая. Болдын Уянга гишүүн асуулт асууж, үгээ хэлье.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Энэ тайлантай ингээд жил болгон танилцаж байгаа, тэгээд энэ удаагийн тайланг нэлээн анхааралтай уншиж үзлээ. Ерөнхийдөө болохоор Хүний эрхийн Комиссынхон маань энэ тайлангаа илүү сайн бичиж болох байсан юм шиг л санагдаад байх юм. Зарим зүйлүүдийг орхигдуулсан байна гэж үзэж байна, тэгээд энэ талаараа тайлбарлая. 2 зүйл дээр онцлоод ярья.

Мэдэх эрхтэй холбоотой, тэгээд хүүхэд хамгааллын тогтолцооны талаарх гээд ингээд Үндсэн хуулиа бүгдээрээ эшилж байгаа. Танай тайлангийн бүтцийг ингээд харахаар Үндсэн хуулийн 16.11 гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална гэж байгаа. Ингээд явж байгаад түр хамгаалах байруудын талаар бичээд, нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байгаа боловч орон нутагт хүртээмж байхгүй байна, үйлчилгээний орчин, мэргэжлийн боловсон хүчин гээд нөгөө ер нь бүх хүний л мэдэж байгаа зүйлсийг биччихсэн байгаа юм л даа. Яагаад юм гээд харангуут шаардлагатай зардлыг нь нарийвчилж төлөвлөөд төсөвт тусгахгүй байгаа учраас гээд л байдаг шалгуур байгаа байхгүй юу. Тэгээд ингээд хууль, эрх зүйн орчноо харахаар уул нь бид 2024 оны 01 дүгээр сард шинэчилж найруулсан Хүүхэд хамгаалах хуультай. Тэгээд яах вэ зүгээр өгүүлбэр байна Хүүхэд хамгаалах хуулиа хэрэгжүүлэе гээд шийдэл байхгүй. Яг яаж хэрэгжүүлэх нь зүгээр юм, УИХ-ын тогтоол батлагдах гээд байна шүү дээ. Яг тогтоол дээр зүгээр бүх хүний бараг логикоороо нэг жаахан бодоод суухад гарч ирэх хэсэг өгүүлбэрүүдийг нийлүүлээд тайлан боочихсон, энийг хангалтгүй гэж хармаар байгаа байхгүй юу.

Хүүхэд хамгаалах тухай хуулийг нарийвчлаад уншлаа. Нэлээн хангалттай зохицуулалтууд нь уул нь суучихсан юм шиг, тэгээд газар дээрээ буухгүй байгаа юм шиг байна л даа, 24 оны 01 сард шинэчилж найруулагдсан, 24 оны 07 сард парламент шинээр бүрэлдсэн, тэгээд магадгүй ингээд хөрсөн дээрээ арай буухгүй, бас л журмууд нь байхгүй байна уу? Тэгвэл яг ямар журам нь байхгүй байгаа юм, тэрийг ярих ёстой байхгүй юу. Ингээд хүүхэд хамгааллын хэсэг дээр цаашаа явангуут цахим орчинд үйлдэгдэж байгаа янз бүрийн асуудлууд ерөөсөө дурдагдаагүй байх юм. Энэ дээр ямар нэгэн гомдол ирсэнгүй юү? Юу тохиолдсон болоод цахим орчинд асуудлууд үүсэж байгаа талаар огт дурдагдахгүй байна вэ? Ингээд Өмнөговь аймгийн ахлах сургуулийн хүүхдүүдийн дунд эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулж байсан юм. Сая зун, өвөл 2-р сард, нэг минутаа нэмээд авчихъя дарга.

С.Бямбацогт: Минут сунгая.

Б.Уянга: Цогтцэций сумын 11 дүгээр ангийн нэг хүүхдийн эсээг эсээ дээр байгаа өөрсдийнхөө багаараа авсан судалгаанд мэдээллийг нь зүгээр уншиж танилцуулъя. Манай суманд насанд хүрээгүй 5 охины 3 нь цахим дээрэлхэлт, дарамт, шахалтад өртөж байна. Цахим орчинд 7 охин тутмын нэг нь эсрэг хүйстнээсээ ямар нэгэн гаж зураг, бичлэг авч байна. 1 сарын хугацаанд зохион байгуулсан ахлах ангийн хүүхдүүдийн дундах тэмцээнд өөрсдөө статистикаа бэлдээд гаргаж ирж байгаа асуудал нь энэ. Тэгээд манай Хүний эрхийн Комисс

энийг мэдэж байх ёстой шүү дээ, тэгээд энэ яагаад дурдагддаггүй юм? Энэ дээр хариулт авъя.

С.Бямбацогт: Хэр хариулах вэ? Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон ХЭҮК-оос Хунан ХЭҮК-ын гишүүн хариулъя.

Ж.Хунан: Уянга гишүүний асуултад хариулъя. ХЭҮК хүүхдийн эрхийн асуудалд онцгой анхаарал хандуулдаг, таны дурдсан энэ хүүхэд хамгааллын тогтолцооны бүтэц, нэгжүүдийн талаар өмнөх илтгэлүүддээ ХЭҮК үнэлгээ, шинжилгээ хийгээд танилцуулаад тэрний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ эд нарыг үзсэн байгаа. Тэгээд энэ удаа нэг цэгийн үйлчилгээний төвтэй холбоотой, ялангуяа түр хамгаалах байртай холбоотой ахиц дэвшил гарсан үгүй юү гэдэг талаас нь илүү харсан. Хамгийн тулгамдаж байгаа асуудал энэ төсөв хөрөнгөтэй л холбоотой байгаа. Та зөв хэллээ. Үнэхээр бодит амьдрал дээр бид хэдийгээр эрх зүйн орчныг нь сайжруулчихсан, бүтцийг нь бий болгочихсон ч гэсэн яг анхан шатны нэгж дээр ажиллахад шаардлагатай тэр зардал, төсөв, хүний нөөцийн энэ тогтвортой, аюулгүй байдал энэ баталгааг нь бид хангаагүй өнөөдрийг хүртэл ингээд явж байгаа учраас бид энийг дахин, дахин ингэж дурдаж явж байгаа гэдгийг танд дуулгая.

Хүүхдийн үе тэнгийн дээрэлхэлт, цахим орчин дахь хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлыг мөн ялгаагүй ХЭҮК ялангуяа 24 дэх илтгэлдээ энийг тухайлан хөндсөн байдаг. Өөрөөр хэлбэл энэ технологи ашиглаж энэ үе тэнгийн дээрэлхэлт, цахим орчинд ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл үйлдэж байгаа энэ асуудлыг бид хөндөж гаргаж тавьсан. Энэ хүрээнд УИХ-ын тогтоол мөн гарсан байдаг. Сүүлд энэ оны эхэнд Боловсролын сайдад ХЭҮК-ын даргын зөвлөмж явсан байдаг. Энэ нь үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой цогц арга хэмжээ авахыг зөвлөсөн ийм зөвлөмж явсан байгаа.

С.Бямбацогт: Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Та хэдээс маань зөвлөмж, дүгнэлт эд нар явчихдаг юм байна, тийм ээ? Тэгээд хэрэгжилт нь хангалтгүй байгаа учраас түр хамгаалах байрныхаа асуудлыг 24 дүгээр илтгэлээсээ 25 руугаа давтаж оруулаад, гайгүй болчихсон гэж үзээд цахим дээрэлхэлтийг илтгэлдээ оруулдаггүй юм уу? Улам муудаж байгаа шүү дээ. Тэгэхээр хариулт хангалтгүй байна, та хэд тайлангаа дутуу бичсэн байна. Үгүй ээ, тоглоом ч үгүй. Энэ чинь орчин үед ингээд л нэг их олон хуудас юм уншаад л, уншаад л үргэлжилсэн үгийн зохиол шиг байгаад байгаа байхгүй юу. Тэгээд цаг үетэйгээ нийлж алхах хэрэгтэй байна.

2 дугаарт энэ хүний мэдэх эрхтэй хэсэг Үндсэн хуулийн 17.6 хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсын батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална гээд. Энд ерөөсөө сошиал дээр ямар нэгэн худал гүтгэлэг гаргаад, ямар ч үндэслэлгүй мэдээлэл гаргаад тэр нь хүний мэдэх эрхэд нөлөөлөөд байхад судалсан нэг өгүүлбэр ч алга. Яагаад юм бол?

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон ажлын хэсэг хариулъя.

Ж.Хунан: Уянга гишүүний асуултад хариулъя. Энэ мэдэх эрхтэй холбоотой асуудлаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон албаны

нууцын тухай хуулиудын дээр хийсэн судалгаан дээр хийгдсэн байгаа. Энэ дээр ер нь нийтийн мэдээллийг мэдэх эрх дээр энэ төрийн байгууллагуудын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд мэдээлэл өгч байгаа төв дээр судалгаа хийгдэж явсан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар 67 төрлийн мэдээллийг ил тод болгохоор хуульчилсан байдаг. Тэгээд Төрийн болон албаны нууцын тухай хууль дээр тухайн хуулийн зохицуулалтуудын хоорондын уялдаа холбоотой зохицуулалтуудыг судалсан. Тэгэхээр судалгааны болон энэ илтгэлийн хүрээ, хязгаар маань зөвхөн энэ төрийн байгууллагуудын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд л хийгдсэн байгаад байгаа.

С.Бямбацогт: Сүнжид дарга нэмж хариулъя 3 дугаар микрофон.

Д.Сүнжид: Уянга гишүүний 2 асуултад нэмж хэлэхэд, эхний цахим орчин дахь жендерийн, цахим технологи ашиглан үйлдэж буй жендерийн ялгаварлан гадуурхалт гээд өнгөрсөн жил бид авч үзсэн юм. Илтгэлд авч үзсэн, тэрний хамгийн гол өртөж байгаа хүмүүс нь хүүхдүүд, өсвөр насныхан. Тэгээд нөгөө digital literacy хамаатай энэ хүмүүс өртөж байна гээд. Тэгээд тэр 33 төрлийн олон улсад ийм мөшгөдөг, дарамталдаг, зураг, бичлэг эвлүүлдэг, түүнийг нь ашиглаж эргэж өөрийг нь заналхийлдэг, мөлжлөгт өртдөг гээд. Энэ дээр бид өнгөрсөн жилийнх дээр энэ тухай илүү нарийвчилж авч үзээд, үүний мөрөөр арга хэмжээ авах шаардлагатай байна гэдэг саналыг уламжлаад, УИХ-ын 77 дугаар тогтоолд энэ санал орсон юм. Нэг асуудал бий. Ингээд бид тогтоолд орчихсон гээд орхиогүй. Цахим орчинд үйлдэгдэж байгаа хүүхдүүдийн, эмэгтэйчүүдийн залилан болон бусад гэмт хэргийн эсрэг бид.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя, 3.

Д.Сүнжид: Илтгэлээс гадна бусад арга хэмжээгээрээ үргэлжлүүлж авч байгаа гэдгээ хэлье. 2 дахь асуулт, энэ нэр төр гутаах, доромжлохтой холбоотой. Бид өнгөрсөн 2 жилийн хугацаанд олон нийтийн хяналт шалгалтыг технологи ба хүний эрхийн сэдвээр 11 дэд сэдэв, задарвал 16 сэдэв болж байгаа, энэ хүрээнд авч үзсэний нэг нь энэ. Түүнийгээ бид сая 5 сарын 14-нд илтгэлд оруулаагүй, тэгэхдээ 14 сэдвийг тусдаа тайлан болгоод энийгээ бид олон нийтийн хүртээл болгосон. Төрийн эрх бүхий байгууллагууд хийх ёстой ажлыг нь, ялангуяа ЗГ-т тусад нь зөвлөмжийг гаргасан бөгөөд яг тэр хүрээндээ зөвлөмжийг нь энэ дээр ч гэсэн оруулчихсан байгаа. Тэгэхээр энэ тэрэнд орсон, нэр төр гутаах, доромжлох энэ асуудлыг тэнд нь тусад нь нэг сэдэв болгоод бид тэндээ авч үзээд ямар арга хэмжээ авах ёстой байгааг дүгнээд, зөвлөмжийг нь ЗГ, Ерөнхий сайдад хүргүүлсэн болохыг танилцуулъя.

С.Бямбацогт: Баярлалаа. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үгээ хэлье.

С.Эрдэнэбат: Илтгэлтэй танилцсан, тэгээд маш чухал сэдвүүдээр дажгүй бичигдсэн байна гэж би харж байгаа. Дажгүй гэж хэлдэг нь өөрөө энэ яг энэ сэдвүүдтэй холбоотой асуудалтай нэлээн холбоотой ажилладаг байсан учраас. Эхний асуудал нь эрүүл мэндийн асуудал, эрүүл мэндийн салбарын ажилчдын ажлын байрны дарамт, хүчирхийлэл гэдэг зүйлийг тавьсан байна, бодитой тоо, судалгаагаар тавьчихсан байна. Энэ юунаас болоод байдаг вэ? Энэ дээр яагаад өнөөдөр энэ Эрүүл мэндийн сайд, холбогдох албан тушаалтнууд байхгүй байна вэ, тэд нар сонсох гэж л энийг ярьж байгаа биз дээ. 1 дүгээрт. Ингээд УИХ-ын гишүүд

хоорондоо яриад, Хүний эрхийн Комисстойгоо хоорондоо яриад ингээд дуусах юм уу, яах юм.

2 дугаарт, эрүүл мэндийн үйлчилгээ авагчдын 66 орчим хувь нь үйлчлүүлэгчдийн дарамт, нийт судалгаанд хамрагчдын 33 орчим хувь нь удирдлагын дарамт гэсэн байна, ялгаварлан гадуурхалтад өртдөг байсан байна. Тэгэхээр энэ эрүүл мэндийн салбарын ажилчид чинь яаж тогтвор суурьшилтай, сэтгэл ханамжтай ажиллах вэ? Сая энэ жил бид эрүүл мэндийн салбарт анхаараад цалин хөлсийг нь нэмсэн, гэхдээ цалинтай тэнцэхүйц хэмжээний ажлын байрны аюулгүй байдал, сэтгэл ханамж, энэ байдал чинь өөрөө маш чухал юм. Тийм учраас та хэд энийг нааш тодорхой тавьсан байна. 1, 2, 3, 4 гээд энэ тал дээр Хүний эрхийн комисс тодорхой шаардлагыг тодорхой болгож өгмөөр байна, яг ийм, ийм зүйлийг хий гэж. Тэгэхээр ийм зүйлийг ер нь та хэд өгсөн үү гэж?

Хоёрдугаар асуудал нь эрүүл мэндийн салбарын ажилчдын хөдөлмөрлөх эрхийн асуудал гээд. Би өөрөө энэ эрүүл мэндийн салбарын ажилчдын эрх ашгийг хамгаалах тал дээр ажиллаж байсан хүний хувьд яг ний нуугүй хэлэхэд маш их дарамт хүртдэг юм. Үндсэн эрүүл мэндийнхээ салбарын ажлыг хийх үү, ажилчдынхаа эрх ашгийн төлөө тэмцэх үү гэдэг энэ сонголтыг тулгадаг. Тэр хүмүүсийг албан тушаал, карьер, шагнал, урамшуулал, бусад зүйлээр дарамталдаг, хасдаг ийм зүйл байдаг, энийг та бүхэн бичсэн байна.

Хоёрдугаарх нь хүний эрхийг хамгаалагч гээд маш чухал зүйл байж байгаа. Хүний эрхийг хамгаалах чухал хууль гаргасан, гэхдээ анхны хуулийн төслөөсөө нэлээн өөр болсон, жоохон хүчгүй болсон. Яг энэ эрүүл мэндийн салбарын ажилчдын төлөө тэмцэж байгаад яасан бэ гэхээр, яг та хэд бичсэн байна энэ 358 дугаар хуудас дээр, хүний эрхийг хамгаалагчдыг яадаг вэ гэхээр авлига, хээл хахуулийн хэрэгт буруутгадаг, хэвлэл мэдээллээр бусдыг гүтгэсэн гэдэг зүйл тавьдаг, төрийн эсрэг үйл ажиллагаа явуулсан гээд. Яг энэ зовлон, жаргалыг би өөрөө биеэрээ мэдэрч байсан, та бүгд мэдэж байгаа, танай Хүний эрхийн Комисст хандаж байсан. Тийм учраас энэ байдал хэвээрээ байгаад байгаа, энэ хууль шүүхийн байгууллага болон энэ бусад байгууллагад иймэрхүү үйл ажиллагаа, хууль бус улс төрийн захиалгатай ийм зүйлүүд байсаар байгаад энэ дээр нь тодорхой тэр албан тушаалтнууд хэрэг мөрдсөн, үүсгэсэн, мөрдөн шалгасан гэдэг зүйл дээр нь тодорхой арга хэмжээ авмаар байна. Тэгэхгүй бол энэ хэзээ ч салагдахгүй. Нэмэлт нэг минутаа авчихъя даргаа.

С.Бямбацогт: Эрдэнэбат гишүүнд цаг сунгая, минут сунгая.

С.Эрдэнэбат: Нөгөө малчдын асуудал байна гээд их чухал сэдэв, бидний байнга ярьдаг. Яг та хэд маань тоогоор гаргаад тавьчихсан байна л даа. Хөдөө малчин залуучууд ганц бие амьдралтай, 11 хувь нь хэнтэй ч гэрлээгүй ингээд яваад байна. Үндсэндээ энэ яг энэ тал дээр яг яах ёстой вэ, бид ямар хууль гаргах ёстой вэ, юунд анхаарах ёстой вэ гэдэг тал дээр та хэд маань юу гэж бодож байна вэ гэдгийг асуумаар байна. Тухайлбал Хангайн бүсэд гэхэд илүү их зүйл байдаг юм байна л даа, 11 хувь нь огт гэрлээгүй энэ тэр гээд. Тийм бүр ингээд тодорхой тоо тавьчихсан байна шүү дээ. Тэгэхээр бид энийг яриад л байдаг, тэгээд энэ тал дээр хэдүүлээ ямар арга хэмжээ ер нь авах ёстой юм бэ гэдэг зүйл дээр би тодруулж асуумаар байна. Дараа нь тодруулъя.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг 3 дугаар индэр, 3.

Д.Сүнжид: Эрдэнэбат гишүүний эхний асуултад хариулъя. Тэгээд гүйцээгээд 2, 3 дахь асуултад манай комиссын гишүүдээс хариулна. Эрүүл мэндийн салбарт гарч байгаа гомдлын, иргэдээс гарч байгаа гомдол нэг жилдээ 25 мянга орчим гомдол ирж байна. Тэгээд ихэнх гарч байгаа гомдол нь юутай холбоотой вэ гэхээр 1 дүгээрт эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байна, халааснаас мөнгө гарч байна гэдэг асуудал ирнэ. Тэгээд нэмэх нь цагийн хоцрогдол, хүлээлгэ их байна гэдэг асуудал ярьдаг. Түүнээс гадна эмчийн буюу эрүүл мэндийн ажилтнуудын зан харилцааны асуудлын талаар гомдол гаргаж байна.

Харин эмч нарын зүгээс гаргаж байгаа гомдлын ихэнх хувь нь дарамт, шахалттай холбоотой, заавал хэлэх ёстой нэг асуудал ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажлыг хавсран гүйцэтгэдэг гэдэг 2 хүний нэг тутамд илэрхийлдэг. Түүнийхээ төлөө цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, илүү цагийн хөлс гэдэг юм авдаггүй гэдгийг ярьж байгаа. Нэмэх нь гомдол гаргаад, зохих ёсоор хүсэлт, гомдол гаргаад зохих ёсоор шийдвэрлэж чаддаггүй гэдгийг хэлээд. 4-д нь дахиад нэг хэлээд байгаа зүйл нь үйлчлүүлэгчдээс ирж байгаа дарамт, заналхийлэл, зүй бус харьцаа гэдэг ихсэх боллоо. Ялангуяа анхан шатанд үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүс, 103-ын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүс ч гэдэг юм уу. Улаанбаатар хотын хэмжээнд, суурин газарт энэ хамгийн түгээмэл байна гэдгийг хэлээд, энэнээсээ болоод бид ажлаас халшрах хам шинжтэй буюу ажлаа өөрчлөхөд бэлэн байна, заавал энд ажиллах албатай гэж өөрсдийгөө үзэхгүй байна гэдэг ийм байр суурь илэрхийлж байгаа юм.

Тийм болохоор энийг бид нэг хувь хүн, нэг хүний асуудал, нэг эмчийн асуудал гэж үзэхээсээ илүү тогтолцооны асуудал гэж үзээд, Улаанбаатар хотын хэмжээнд ямар арга хэмжээ авах, хөдөө орон нутагт ямар арга хэмжээ авах гэдэг юм уу, ийм байдлаар үе шаттайгаар бодлогын хэмжээнд үүнийгээ зохицуулах нь зүйтэй гэдгийг ЭМЯ-нд санал болгож байгаа, зөвлөж байгаа, шаардаж байгаа юм. 2 дахь асуудалд манай Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан гишүүн Дондов хариулна, 3 дахь асуултыг манай Мөнхзул гишүүн хариулна.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон ажлын хэсэг хариулъя.

С.Дондов: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль 2021 онд батлагдсан, ингээд энэ батлагдсан цагаас хойш хүний эрх хамгаалагчдын эрхийг хамгаалах, хүний эрх хамгаалагчдын эрх зөрчигдсэн эсэх асуудлаар дүгнэлт гаргах асуудал, мөн энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа үйл ажиллагааг ХЭҮК хэрэгжүүлж байна.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заахдаа төрийн байгууллага, албан тушаалтан, мөн хуулийн этгээд, ашгийн бус байгууллага дотоод журамдаа хүний эрх хамгаалагчийн үйлдлийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд нь хамтран оролцох агуулгатай заалт оруулна гээд хуульчилсан. Тэгээд энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэхийн тулд ХЭҮК-оос төрийн байгууллагад зориулсан болон хуулийн этгээдэд зориулсан ийм аргачлалыг боловсруулан гаргасан байгаа. Арга зүйн дэмжлэг олгох зорилгоор. Энэ ингээд одоо бид хэрэгжих шатдаа явж байна гэж хэлж болно. Өнгөрсөн жилд ТАЗ-тэй хамтраад төрийн байгууллагуудад хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндлэх, үйл ажиллагааг нь дэмжих энэ агуулга бүхий заалтыг хэрэгжүүлэх энэ шатдаа яваад.../минут дуусав/

С.Бямбацогт: Отгоншарын Батнайрамдал гишүүн. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэбат: Яах вэ, манай Хүний эрхийн комиссын хүч чадал гэдэг юм уу, магадгүй яг энэнтэй холбоотой салбарт нь гарсан асуудлаар албан тушаалтнууд нь шууд хариуцлага тооцох ийм саналуудыг шууд оруулж ирээд хэлэлцүүлдэг ийм эрхийг нь өгмөөр байгаа юм. Үндсэн хуульдаа ч гэсэн бид энэ хүний эрхийн байгууллагыг тодорхой тавьж өгч эрх хэмжээг нь нэмэгдүүлэхгүй болохоор хэрэгжүүлэх ёстой байгууллагууд нь тоохгүй. Өнөөдрийн байгаа байдал ч гэсэн ингээд харагдаад л байна л даа.

Би саяын түрүүн хэлдэгтэй холбоотой, эрүүл мэндийн ХЭҮК-ын илтгэлд эрүүл мэндийн салбарын ажилчдын судалгаанд оролцогчдын 30 гаруй хувь нь дарамтад өртдөг гэж байна. Шинэхэн томилогдсон Батшугар сайд энэ дээр анхаараарай. Үнэхээр ажилчдаа ачаалалдаа дарагдаж ядсан ажилчдыг хажуугаар дарамт үзүүлээд байдаг тийм дарга нар байвал хариуцлага тооцоорой гэдгийг би тодорхой хэлмээр байна. Тэр эмийн уналт таталттай холбоотой асуудлыг яаж өгөөрэй, тэгэхгүй бол энийг нөгөө мансууруулах бодист хэрэглэнэ гэдэг байдлаар аваачаад жинхэнэ хэрэглэгчдийг чирэгдүүлдэг асуудал яг энэ дээр тодорхой биччихсэн байна. Энэ өөрөө маш чухал асуудал юм байна лээ.

С.Бямбацогт: ХЭҮК 20 жилийн өмнө хэдэн төгрөгийн төсөвтэй, хэдэн боловсон хүчинтэй байсан, одоо хэд болсон билээ. Тэр талаар асуултад хариулахдаа нэмээд мэдээлэл өгчихье. Харьцангуй сүүлийн жилүүдэд ХЭҮК хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудлыг Монголын төр засаг, парламент илүү онцгой анхаарч өдрөөс өдөрт сайжраад л явж байгаа. Энэ тал дээр тодорхой мэдээлэл өгчхөөрэй. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуултаа асууя.

О.Батнайрамдал: Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл эрүүл мэндтэй холбоотой асуудлууд байна, хүний эрхийн хамгаалагчийн эрхийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын тогтолцоо, ер нь бид энэ дээр төсөв сайтай бол дийлэнх нь шийдэж болох асуудлууд л харагдаад байна л даа. Энэ дунд шийдэл байна. Энэ олон нийтийн мэдэх эрх байхгүй юу, 3 дугаар бүлэг буюу олон нийтийн мэдэх эрх.

Яг үнэндээ өнөөдөр Үндсэн хуулийн 6.2-т маш ойлгомжтой тусгасан стратегийн ач холбогдол бүхий бол ард түмний өмч, төрийн нийтийн өмч буюу ард түмний өмч. Гэтэл Монгол Улсад өнөөдөр хамаг том хулгай, луйвар бүгд энэ стратегийн хэдэн ач холбогдол бүхий ордууд дээр явсан. Энэ чинь өөрөө хүний эрхийн хамгийн том зөрчил шүү дээ. Яагаад гэхээр тэр хулгай, луйвар луу урссан хэдэн их наяд төгрөг буцаад бидний өнөөдөр энэ боловсрол, эрүүл мэнд дээр байгаа асуудлуудыг шийдэх алдагдсан боломжууд байхгүй юу. Тийм учраас энэ стратегийн хэдэн орд дээр явж байгаа хулгай, луйвар, тэрүүн дээр явж байгаа тэр нууцад авсан мэдээллүүд Монгол Улсад явж байгаа хүний эрхийн хамгийн том зөрчил, бусад хүний эрх зөрчигдөх боломжийг олгож байгаа алдагдсан боломжууд байхгүй юу.

Тэгэхээр олон нийтийн мэдэх эрх, мэдээллийн ил тод байдал, тайлагнал өөрөө энэнд 3 дугаар бүлэг дээр орсон энэ чинь өөрөө шийдэл нь байхгүй юу. Маш ойлгомжтой жишээ хэлье. Тэгээд дахиад л ОТ ярина л даа. Яагаад гэхээр ОТ-н сонсгол хийхэд 92467 хуудас нотлох баримтыг бид төрийн 30 байгууллагаас

цуглуулсан, 51 хувь нь нууцтай. Албаны нууц, төрийн нууц, маш нууц, тэр битгий хэл ОТ дээр хийсэн Үндэсний аудитын газрын дүгнэлт нь өөрөө нууцын тамгатай. Ард түмний өмчийг ард түмний төлөөлөл болсон УИХ нь ард түмэндээ тайлагнах гэхээр нууцын тамгатай, амаа үдүүлээстэй. Тэгэхээр ийм байдалтай яваад байхаар чинь бид энэ бусад хүний эрх нь зөрчигдөөд байлгүй яах вэ дээ. Яагаад гэвэл тэр тийшээ орох төсөв нь буцаад нууцын тамганы ард явсан хулгай, луйвар яваад байгаа юм чинь. Тэгэхээр энэ дээр маш тодорхой энэ жишээн дээрээ шийдэл байна. ОТ-н сонсгол болсон, энэ сонсголыг би жишиг болгохыг чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм. Энэ 92467 хуудас нотлох баримтын 49 хувь нь ил байгаа юм. Энэ ил 49 хувийг одоо УИХ-ын Тамгын газрын архивд байгаа. Тэгэхээр энийг УИХ-ын дарга руу албан тоот явуулж, ил тод parliament.mn дээр байрлуулж.../минут дуусав/

С.Бямбацогт: Батнайрамдал гишүүн асуултаа гүйцээж асууя.

О.Батнайрамдал: Тэгэхээр энэ ил тод мэдээллийг parliament.mn дээр нээлттэй байршуулж, олон нийтийг мэдэх эрхээр нь хангаач гэж байгаа юм, 30 байгууллагаас цуглуулж авчирлаа. Энийг нээлттэй, ил тод болгож өгөөч, ийшээ хэн ч гэсэн ороод хайгаад өөртөө ашиглах, мэдэх эрхээ хангах бүрэн боломжтой байх ёстой. Үлдсэн харин 51 хувийг Монгол Улсын ЗГ луу өчигдөр би Ерөнхий сайд руу албан тоот явуулж, тэр бусад мэдээллийг нууцаас нь гаргаач гэж байгаа юм, нууцаас нь гарга. Энэ нууцын тамга сүүлийн 30 жил хулгай, луйврын халхавч болж ирсэн болохоос биш хүний эрхийн маш том хулгай болж ирсэн шүү. Тэр нууцын тамганы ардах алдагдсан боломжийг бид зөв урсгаж чадсан бол өнөөдөр хүний эрхийн энэ report шал өөр тайланг гарч ирэх боломж, нөхцөл нь байсан байхгүй юу. Энэ 30 жилийн явж ирсэн алдагдсан боломж байгаа юм. Тэгэхээр миний асуулт энэ 3 дугаар бүлэгтэй.../минут дуусав/

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

С.Ганзориг: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль гээд, Төрийн болон албаны нууцын тухай хуулиуд дээр энэ хууль хоорондын уялдаа, холбоо хангалтгүй байгаа гэдэг дээр энэ илтгэлийн зөвлөмж гарч байгаа, санал гарсан байдаг. Тэгэхээр энэ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар нээлттэй, хязгаарлалттай, хаалттай мэдээлэл гээд төрөлжүүлээд ангилчихсан. Байгууллагын нууц, хувь хүний нууцтай холбоотой зүйлүүд дээр болохоор байгууллагын нууц, хувийн мэдээлэл, албаны нууц гээд хууль хоорондын энэ уялдаа холбоо мөн энэ албаны нууцад оруулж байгаа энэ жагсаалтын тоо сүүлийн, түрүүн Энхтүвшин гишүүн хэлж байсан 575 болж ингээд өссөн. ЗГ энэ нууцын жагсаалтыг өөрсдөө ингээд баталдаг ийм боломж нь хуулийн эрх зүйн орчинд байгаад байгаа. Тэгэхээр аль нь хязгаарлалттай мэдээлэл, аль нь хаалттай мэдээлэл юм, тэгэнгүүт албаны нууц, Төрийн болон албаны нууцын тухай хууль дээр болохоор маш нууц, нууц гээд ингээд ангилагдаад энэ хоорондын уялдаа холбоо хангагдаагүйн улмаас тэр нууцын мэдээлэл илүү хүрээ нь тэлж өргөжсөн. Мөн ЗГ тэр хуулиараа тухайн нууцын төрлийг нэмэгдүүлэхийг үүрэг болгочихсон учраас энэ асуудал явагдаад байгаа.

С.Бямбацогт: Тодруулж асууя, Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Тэгэхээр бидний хамгийн анхаарах ёстой зүйл ерөөсөө л олон нийтэд бид мэдэх эрхээр нь л хангах ёстой. Стратегийн ач холбогдол бүхий орд хөндөгдөж ашиглагдаж байгаа бол захиран зарцуулсныг нь ард түмэнд нь

тайлагнадаг ёстой, олон нийтийг мэдэх эрхээр нь хангах ёстой, энэ олон улсын зарчим шүү дээ. Мэдээллийг нь ил болгоод тайлагнадаг процессыг нь л оруулчих ёстой. Өнөөдөр стратегийн ач холбогдол бүхий орд дотроос УИХ дээр нэг ч компани нь ирж тайлагнадаггүй юм шүү дээ. Уул нь бид чинь тэр ард түмний элч төлөөлөгч гээд байгаа шүү дээ. Ард түмний өмч юм бол элч төлөөлөгчид нь тайлагнадаг процесс байх ёстой шүү дээ, тэгэхээр байхгүй л байгаа юм. Тэгэхээр энэ байхгүй байгаад байхаар чинь энэ эрх нь зөрчигдөөд, тэгээд бусад эрхүүд рүүгээ орж болох санхүүжилт нь тэр чигээрээ хумигдсан ийм л нөхцөл байдалтай байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бид хамгийн түрүүнд засах ёстой юм л даа. Ерөөсөө үндсэн шийдэл нь олон нийтийг мэдэх эрхээр л хангах ёстой юм. Энийг л бид нар хамтдаа заавал.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид иргэдийн мэдэх эрхийг хангах заалтыг Үндсэн хуульд оруулсан. Иргэдийн мэдэх эрхтэй холбоотойгоор Төрийн болон албаны нууцын тухай хууль 19 билүү батлагдсан, Хувь хүний нууцыг хамгаалах тухай батлагдсан, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль батлагдсан. Эдгээр хуулиудын хэрэгжилт тийм хангалттай сайн биш байна гэж үзээд ЗГ-аас Төрийн болон албаны нууцын тухай хуулийн ил тод байдлын тухай хуулийг Их Хуралд өргөн барих гээд ингээд жоохон саатаж байгаа. УИХ-ын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын гишүүдийн өргөн барьсан хууль байгаа. Энэ хуулиудыг ер нь ЗГ өргөн барихаар хамтад нь хэлэлцээд явчихъя гэж байгаа.

Иргэдийн мэдэх эрхийг хангах энэ чухал асуудал. Ялангуяа энэ парламентын бидний баримталж байгаа зарчим иргэддээ ил тод, нээлттэй, илүү иргэдийнхээ оролцоонд тулгуурласан парламент байна гэсэн бодлого, зорилт тавьж ажиллаж байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ энэ асуудлууд яригдана, цаашдаа илүү ил тод, нээлттэй, иргэдийн оролцоотой байх. Ингэж байж энэ парламентын маань үйл ажиллагаа сайжирч, парламентад итгэх иргэдийн итгэл сэргэнэ. Парламентын ардчилсан парламентын засаглал маань илүү бэхэжнэ. Ийм л бодлого барьж байгаа шүү. Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууж, үгээ хэлье.

Д.Бум-Очир: Миний ярих гэж байсан асуултыг гишүүд маань нэлээн ярилаа, Ариунзаяа гишүүн, жишээ нь Сайнзориг гишүүн, тэр биелэлтийн тухай асуудал. Их Хурлын тогтоол дагаад гарч байгаа. Жишээ нь өнгөрсөн жил 24 дүгээр илтгэлийг дагаад 77 дугаар тогтоол гарсан.

77 дугаар тогтоолын нэг заалтыг бий болоод бидний хэсэг гишүүд нэг хууль санаачлаад явсан. Харамсалтай нь цаг хугацааны шалтгаанаас болоод амжихгүйгээр болчихлоо. Гэхдээ дахиж оруулж ирнэ, тэр сонгох эрхийн тухай асуудал. Миний асуух гээд байгаа гол зүйл түрүүн гишүүд ярьсан, энэ тогтоолын төсөл, Их Хурлын тогтоолын төслийн хэрэгжилтийг хувь хувиар нь, жил жилээр нь гаргаад тавиадхаач. Түрүүн ингээд яг энд тэндээс нь хэлээд байна, би гол нь энийг олон нийт мэдээсэй гэж бодож хэлж байгаа юм. Жишээ нь өнгөрсөн оны 24 дүгээр илтгэл дагаж гарсан тогтоолын биелэлт хэдэн хувьтай байгаа юм, тэрний өмнөх жилийнх, тэрний өмнөх жилийнх, тэрний өмнөх жилийнх гээд ингээд бүгдийг нь нэг хармаар байна. Ер нь 50 хувиас хэтэрдэг юм уу даа, үгүй юү? Хамгийн ихдээ 50 хувь гардаг юм уу, заримдаа бүр 30 хэдэн хувийн биелэлттэй байж байна шүү дээ. Энэ биелэлтийн асуудлыг ярихгүйгээр цаашдаа ингэж олон илтгэл сонсох хэрэгтэй юм уу, үгүй юм уу гэдэг асуудлыг гишүүд ярьж байна. Би ч гэсэн адилхан байр суурьтай байна.

Бидний гол ярих зүйл хэрвээ хүний эрхийн тухай асуудал дээр бид ахиц дэвшил гаргая гэж байгаа бол энэ тогтоолын төслийн хэрэгжилтийг л ярьдаг баймаар байна. Энэ илтгэлтэйгээ хамт бараг энэ илтгэлээс илүү би өнгөрсөн жилүүдийн тогтоолын төслийн хэрэгжилтүүдийг яримаар байна. Тэгээд аль нь яагаад хэрэгжихгүй байгаа юм, хэрэгжүүлэхэд хэн ажиллах ёстой юм, анхаарах ёстой юм, хэн хариуцлага хүлээх ёстой юм бэ гэдэг зүйлийг яримаар байна. Тэгэхгүй ингээд жил болгон илтгэл янз бүрийн сэдвээр сонсоод байдаг, өнгөрсөн жилүүд нь жишээ нь боловсролын асуудал өнгөрсөн жилийнх дээр байхгүй, энэ жилийнх дээр байхгүй, тэрний өмнөх жилийнх дээр байгаа юм байна гэж би ойлгосон.

Ингээд тэр жилийн боловсролын асуудлаар орсон тогтоолын төслийн хэрэгжилт хаана байна вэ? Энийг хэн хариуцах вэ? Энийг 1 дүгээрт бид нэг тийш нь болгомоор байна. Ингээд жил, жил сэдэв сэдвээр оруулж ирээд байдаг, өнгөрсөн жилийн сэдвүүд нь хэрэгжсэн ч юмгүй хаягдаад байдаг ийм байдлууд, эсхүл жил, жил оруулж ирэхдээ бүх холбогдох сэдвүүдээ оруулж ирээд, тэр хэрэгжилтийг нь үнэлдэг систем байвал үнэлээд, энэ тэдэн оноос хойш юм хийж чадсангүй, хэрэгжсэнгүй гээд ийм нэг зүйл баймаар байна.

Дараагийн нэг зүйл юу гэхээр энэ амиа хорлолттой холбоотой зүйл байгаад байна. Энэний талаарх нарийвчилсан судалгаа байна уу? Сэтгэл зүйчийн, цагдаагийн дараагийн.

Дараагийн нэг зүйл энэ 594 дүгээр хуудсан дээр байгаль орчин, нийгэм, соёлын эрсдэлийн үнэлгээний эрх зүйн орчны зохицуулалтыг бий болгох гэсэн ийм тогтоолын төсөл дээр шүү. Энийг оруулж ирсэнд би маш их баяртай байна. Яагаад оруулж ирэв, ямар судалгаан дээр үндэслэж оруулж ирэв? Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл авмаар байна.

С.Бямбацогт: 3 дугаар микрофон индрийн ХЭҮК-ын дарга Сүнжид хариулъя.

Д.Сүнжид: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Их Хурлын тогтоол гараад Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг биелүүлэх үүрэгтэй этгээд нь ЗГ, тэгээд ЗГ-аас нэг удаа, Их Хурлаас Их хурлын бүрэн эрхэд байгаа эргэж ЗГ-ын тогтоолыг хэлэлцэх, хариуцлага тооцох, шалтгаан нөхцөлийг үнэлэх энэ бүрэн эрхэд нь хамаардаг. 2 жилийн өмнө 24 онд бид өнгөрсөн жилийнх нь буюу 2023 оны 35 дугаар тогтоолын хэрэгжилтийг ХЗБХ-гоор хэрхэн яаж хэрэгжсэн бэ гэдгийг илтгэл хэлэлцүүлэгтэй хамт бүх ЗГ-ын холбогдох албан тушаалтнуудыг байлцуулж, хэлэлцэж үзэж байсан нэг туршлага бий. Ер нь илтгэлийн мөрөөр гарчихсан ЗГ-т даалгасан энэ тогтоолын хэрэгжилтийг сайжруулах ёстой гэдэгтэй санал нэг байна.

Тухайлан жишээ авсан гишүүний тодруулахыг хүссэн 2024 оны 37 дугаар тогтоол байгаа юм. Энэ дээр боловсролын салбарын асуудлуудыг бид 4 боловсролын салбарт бүгдэд нь авч үзсэн, 3 заалтаар үүрэг болгосон юм. Энэ хэрэгжилт нь өөрөө 49 хувьтай буюу муу хэрэгжилттэй гэдэгтэй л ороод явж байгаа юм. Ямар асуудлууд байна вэ гэхээр сургалтын байгууллага, дотуур байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдлын стандартыг хангуулаач гэсэн, энэ тогтолцоо бүрдүүлээч гэдэг нэг асуудал байгаа юм. 2-т хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн сурах эрхийг хангах хүрээнд асуудлыг заалгасан. 3-д хувийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тавих шаардлага, шалгуурыг тодорхой болгоод, эрх зүйн орчныг бүрдүүлээд ингээд хяналт тавиаач гэдэг ийм 3 зүйл байсан,

энэ тэгээд бүрэн хангалттай хэрэгжээгүй гэж манай үнэлгээгээр ингээд гараад явж байгаа. Тиймээс энэ Сайнзориг гишүүн, Бум-Очир гишүүн, тэгээд Баасанжаргал гишүүний хэлээд байгаа ер нь Их Хурлын тогтоол хэрэгждэг байх ёстой, түүний мөрөөр мөн арга хэмжээ авах, хариуцлага тооцох болон хамгийн гол нь эцэстээ иргэддээ, иргэдийн эрхийг хангах энэ тогтолцоонд өөрөө үр дүн гарах ёстой учраас энийг дүгнэдэг ийм нэгдсэн системтэй болох санааг дэмжиж байгаагаа илэрхийлье. 2 дахь асуултад Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан Дондов гишүүн хариулт өгнө.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон, ажлын хэсэг хариулъя.

С.Дондов: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Байгаль орчны болон нийгэм, соёлын үнэлгээний эрх зүйн орчныг бий болгох талаар яагаад санал оруулсан бэ гэсэн. Энэ дээр бид ХЭҮК-т ирсэн гомдлууд, мөн түүний мөрөөр хийсэн хяналт шалгалтын үр дүнд яалт ч үгүй байгаль орчны, тухайн байгальд амьдарч байгаа иргэдийн эрх ашиг зөрчигдөж байгаа, түүний хажуугаар нийгэм, соёлын бодит нөхцөл байдлуудад хүндрэлтэй байгаа энэ асуудлууддаа тодорхой кэйсүүд дээр хяналт шалгалт хийж, ажиллагаа хийсний үндсэн дээр хэдийгээр Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон ч гэсэн тэнд тухайн А лицензтэй байгаа компаниудын үйл ажиллагааны улмаас тухайн малчин иргэд болоод бусад иргэдэд учирч байгаа хохирол, түүнийг бүрэн хэмжээгээр төлж чадахгүй байгаа, нөхөн төлбөр бүрэн олгож чадахгүй байгаа асуудал тулгамдсан асуудал байна гэж үзсэн. 2 дугаарт, тухайн үе.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя, 4 дүгээр микрофон.

С.Дондов: Тухайн тэр орчинд байгаа соёлын үнэт зүйл, мөн тэндхийн нийгмийн бодит нөхцөл байдлуудыг бодитоор үнэлэлгүйгээр ийм тусгай хэмжээний ийм лицензүүд өгөөд байгаа явдал нь иргэдэд болоод тэнд байгаа соёлын үнэт зүйлүүд ч гэсэн төвөгтэй үйл явдал, төвөгтэй нөхцөл байдлуудыг бий болгож байна гэж үзээд энэ саналыг гаргасан. Өмнөх жилд бид байгаль орчны энэ асуудлаар судалгаа хийгээд өнгөрсөн жилийн илтгэлд байгаль хамгаалагчдын өнөөгийн нөхцөл байдал гэсэн энэ сэдвийг оруулсан байгаа хүний эрх хамгаалагчдын хэсэг.

С.Бямбацогт: Амиа хорлолтын талаар ажлын хэсэг Мөнхзул хариулъя, 4 дүгээр микрофон.

Х.Мөнхзул: Амиа хорлолтын асуудал үнэхээр эрэгтэйчүүдийн хувьд анхаарал татсан асуудал байгаа. Амиа хорлолтын асуудал дээр нас баралтын 3 дахь шалтгаан болоод удаж байгаа ч гэсэн өнөөгийн байдлаар энэ чиглэлээр урьдчилан сэргийлэх, тэмцэх бодлого, төлөвлөгөө батлагдаагүй байна. Ер нь энэ амиа хорлолтын асуудлаар яг шалтгаан, нөхцөлийг нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс судалсан байна. Энэ дээр 3 шалтгааныг онцолсон байгаа, энэ дээр нийгэм, орчны асуудал сүүлийн жилүүдэд ялангуяа цахим дарамт, дээрэлхэлттэй холбоотой асуудлууд, мөн эдийн засгийн асуудал буюу ажилгүйдэл, ер зээлийн асуудал, гэр бүлийн нөхцөл байдал, гэр бүлийн доторх харилцаа, гэр бүлийн хүчирхийллийн асуудал, ингээд сэтгэцийн бусад асуудал гээд энэ амиа хорлолтын гол.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя 4 дүгээр микрофон.

Х.Мөнхзул: Ийм шалтгаан болж байна гэсэн судалгааг хийсэн байгаа юм. Тэгэхээр ер нь эрэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэнд, тэр байтугай энэ донтолт гээд энэ чиглэлээр өнөөдөр яг тусламж, үйлчилгээ хангалтгүй байна. Энэ чиглэлийн сэтгэцийн эрүүл мэнд, донтолттой холбоотой эмч, эмнэлгийн ажилтнууд бол нийт эмч нарын 1 хувьд ч хүрэхгүй байна. Тэгэхээр энэ дээр ялангуяа бид Эрүүл мэндийн тухай хууль дээр энэ чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлэхийг сэтгэл засалч үзүүлнэ гээд хязгаарлачихсан. Тэгэхээр бид ялангуяа сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, донтолтын эмгэг даван туулагчдыг энэ чиглэлээр ажиллуулж, тэгээд нийгэм, хамт олонд нь түшиглэсэн, эрүүл мэндийн байгууллага дээр биш нийгэм, хамт олонд нь түшиглэсэн ийм тусламж, үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай байна гэж дүгнэсэн байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Лувсанбямбаагийн, Бум-Очир гишүүн тодруулж асууя.

Д.Бум-Очир: Энэ байгаль орчин, нийгэм, соёлын эрсдэлийн үнэлгээний эрх зүйн зохицуулалтыг бий болгох гэгчихсэн байгаа. Байгаль орчных нь тодорхой хэмжээгээр байгаа, нийгэм, соёлынх нь маш учир дутагдалтай байгаа тухай би өмнө нь чуулганы хуралдаан дээр хэлж байсан. Миний бие иргэддээ болоод энэ ХЭҮК-ынхон орж ирчихсэн байгааг холбогдуулан энэ хуулийн төслийг эхний хувилбарыг биччихсэн байгаа гэдгээ хэлмээр байна. Та бүхэнтэй хамтран ажиллах болно. Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль гэдэг хууль шаардлагатай юм байна гэдгийг бид өнгөрсөн хугацаанд зөндөө ярьсан. Энэ салбар хоорондын дунд ингээд хаягдаад байдаг хууль. Соёлын өвд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг Соёлын өвийг хамгаалах тухай хуульд оруулна гээд Соёлын яамныхан ам хэлээ өгсөн байгаа шүү. Энийг хариуцах улсууд нь хариуцаад хийгээрэй гэж бодож байна. Амиа хорлолттой холбоотойгоор нарийвчилсан судалгаа, олон улсын жишгүүд бий шүү. Энийг.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэллээ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг Их Хурал баталчихсан. Та болохоор нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ гээд өөр өргөн агуулгатай, өөр олон асуудал орсон хуулийн төсөл боловсруулж байгаа нь ХЭҮК болон бусад байгууллагууд хамтарч ажиллая. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууж, үгээ хэлье.

Л.Мөнхбаясгалан: Нөгөө Балдангийн өвөлжөө шатсан жил төрсөн гэдэг шиг 2024 оны 5 сарын 2-ны өдөр УИХ-ын 37 дугаар тогтоол гарчээ. Энэ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 23 дахь илтгэлийн дагуу тогтоол гарсан байгаа. Бид өнөөдөр дахиад л тогтоол батлах гэж байна. Гэхдээ энийг би хэрэгжинэ гэдэгт огт итгэхгүй байна л даа. Яагаад гэхээр энэ 23 дахь илтгэл нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар гарсан байхгүй юу даа. Энэний Б хэсэгт нь агаар, ус, хөрс, орчны бохирдлыг бууруулах бодлогыг сайжруулах, тандалт судалгаа хийх гэсэн байгаа юм. Г-д нь орчны бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө, урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллийг олон нийтэд тогтмол, хүртээмжтэйгээр хүргэх, НЭМҮТ-ийн үйл ажиллагааг сайжруулах, усны нэгдсэн менежментийг сайжруулах гээд энэ дээр байгаа байхгүй юу. Энэ хэрэгжээгүй. Надад энийг яагаад хэрэгжээгүй тухай та бүхэн зовлон байгаа бол зовлонгоо, баяр хөөр байгаа бол баяр хөөрөө энд хуваалцаж өг.

Дээрээс нь манай улсад энэ усны нэгдсэн менежментийн төлөвлөгөө дуусаад олон жил болж байгаа юм. Дахиад шинэчилдэггүй өнөөдрийг хүртэл, тэгсэн хэр нь

улс даяараа ус нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй болчихсон. Энэ нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дотор байдаг, огтхон ч тоодоггүй. Тэгээд би бас нэг жишээг хэлье. Энэ жилийн энэ илтгэл дээр чинь, бидний энэ батлах гэж байгаа УИХ-ын тогтоол дээр чинь эрүүл мэнд гэсэн асуудал ороод ирчихжээ. Гэтэл манай Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо баг дээр эрүүл мэндийн үнэлгээ хийх гээд 6 жилийн хугацаа хөөцөлдлөө. Би Их Хурлын гишүүн болоод Мөнхсайхан сайдыг байхад бичиг явуулсан, НЭМҮТ гэж байгууллага байдаг юм, өдөж байгаа юм шиг 96 сая төгрөг нэхсэн.

Энэ 96 сая нь байна шүү дээ, ЭМЯ-ны Ёс зүйн хороог хуралдуулахад 750 мянган төгрөг хэрэгтэй гэж байгаа юм. Цай, кофены зардал ингээд л өчнөөн мөнгө нэхнэ. Ингээд 2 жил хөөцөлдөөд Батшугар сайдын үе ирлээ. Чинбүрэн сайдын үе дууслаа, Батшугар сайдын үе ирлээ, дахиад нөгөө бичгээ явууллаа. Тэгсэн чинь өнөөдөр 250 сая төгрөг өгчихвөл эрүүл мэндийн үнэлгээг нь хийгээд өгье гэж байгаа байхгүй юу. Үгүй ээ, яагаад ингэж байгаа юм, яагаад энэ Ёс зүйн хорооны 15 хүн хуралдахад цай, кофены төлбөр нь 3 сая 200 мянган төгрөг болдог юм бэ? Ийм байхад бид өнөөдөр ХЭҮК-ын илтгэлийг хэлэлцээд, эрүүл мэндийн талаар бид УИХ-аар тогтоол гаргана гээд том, том яриад суумааргүй байгаа байхгүй юу. Яагаад энэ бүхэн чинь хэрэгждэггүй юм бэ, Их Хурлын даргаа, бид өнөөдөр энийг гаргаад яах юм бэ? Дээрээс нь сая Бум-Очир гишүүний ярьж байгаа, бид 2 яг ижилхэн хууль.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэмж нэг минут Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Нөлөөллийн бүсийн тухай хууль санаачлаад бичээд, тандалт, судалгаа нь дуусаад одоо яг бичиж байна. Цогтцэций сумын би сая хэд хэдэн малчин айлаар ороод ирлээ. Нүүлгэн шилжүүлэлтэд өртчихсэн, мөнгийг нь өгнө гэж байгаа юм. Нүүх газар байхгүй, танд 100 сая төгрөг өгье, хотод очиж амьдар гэх үү гэхээр үгүй шүү дээ, би малаа яах юм, би тэнд очоод яаж амьдрах юм гэж байгаа. Малчид нь өнөөдөр нутгаасаа хөөгдөөд, нүүх газаргүй болчихсон, энэ чинь хүний эрх, чөлөө тийм үү? Тэгээд надад яагаад энэ тогтоолууд чинь хэрэгждэггүй гэдгээ тайлбарлаад өгөөч? Эрүүл мэндийн сайдад би энэ мөнгө нэхээд байгаа НЭМҮТ-өөс, энэ яагаад ийм их мөнгө нэхээд байдаг юм, эрүүл мэндийн үнэлгээ хийлгэхэд ёс зүйн хороогоор орно ч гэх шиг юу яриад байдаг юм, 250 сая төгрөгийг Их Хурлын гишүүн би олох ёстой уу? Батшугар сайд энэ дээр надад хариу, тайлбар энэ хүмүүсээсээ авч өгөөрэй. Тогтоол.../минут дуусав/

С.Бямбацогт: Тогтоол яагаад хэрэгжихгүй байна гэж байна. ХЭҮК-ын дарга Сүнжид хариулъя.

Д.Сүнжид: Эрхэм гишүүд ээ, энэ ХЭҮК-ын өөрийнх нь үүрэг бол хүний эрх, эрх чөлөөний тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийгээд, нотолгоо, баримттайгаар УИХ-д танилцуулах үүрэгтэй. Үүний дагуу УИХ өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд тогтоол гаргаж байгаа. Үүнийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллага нь, субъект нь ЗГ байдаг учраас би илүү энэ ЗГ энэ тогтоолын хэрэгжилт дээр юунаас болоод, яагаад тогтоолыг хэрэгжүүлж чадахгүй, анхаарал хандуулахгүй байгааг нь тайлбарлах нь зүйтэй гэж үзэж байна. Бид сайн дураараа нэгэнт хүний эрхийн асуудлыг тулгамдсан асуудал байна, зөрчил байна, шийдэх ёстой асуудал байна гэж дүгнэсэн учраас энэ тогтоол хэрэгжихгүй байна гэдгийн араас нь бид өөрсдөө гишүүний зөвлөмж өгдөг, хэлэлцүүлэг хийдэг, үнэлгээ

гаргадаг нэг ийм байдалтай явдаг юм. Тэгэхээр ЗГ-аас би хариулт авах нь зөв болов уу гэж бодож байна.

С.Бямбацогт: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Тэгэхээр та бүхэн энэ өөрсдийнхөө илтгэлийн дагуу УИХ-аас гарсан тогтоолын хэрэгжилтийг яагаад хэрэгжихгүй байна, энэ тухай өөрсдөө сайн дураараа араас нь явдаг гэж байна шүү дээ, үүрэггүй мөртөө тийм үү? Тэд нар та нарт ямар нэгэн хариу хэлдэг үү? Тайлбар, шалтгаан тоочдог уу, бичиг явуулсан уу? Тэгээд би танай ажилд л туслах гээд байна л даа.

С.Бямбацогт: 3 дугаар микрофон.

Д.Сүнжид: Яг таны дурдсан эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбоотой бид араас нь гишүүний зөвлөмж явуулсан. Усны асуудал, агаар, орчны бохирдол, дотоод орчны стандарт, хотын стандарт, хөрсний бохирдлын асуудлаар хариу ирүүлсэн юм. Гэхдээ хариулж байгаа хариулт нь төлөвлөж байна, бид энэ арга хэмжээг авах болно гэдэг байдалтай илүү ирж байна. Энэ хүрээнд жишээлэхэд нөгөө давхардал, хийдэл, зөрчил байна гэж үзээд 126 хууль, захиргааны хэмжээний актад нэмэлт, өөрчлөлт оруулаач гэсэн. Тэр жишээлэхэд ажил хэрэг болоогүй яваад байгаа юм. Ядаж ЗГ-ын түвшинд хэм хэмжээний актадаа энийгээ тодорхой болгох боломжтой юу гэвэл боломжтой. Усны менежментийн асуудал байна, энийгээ баталчих боломжтой юу гэвэл боломжтой. Хариу бол ирүүлсэн. Тэгэхдээ төлөвлөж байна, бэлтгэж байна, зохион байгуулна гэдэг ийм байдалтай хариу ирүүлсэн болохыг танилцуулъя.

С.Бямбацогт: ЭМЯ Мөнхбаясгалан гишүүний асуултад бичгээр хариулт өгчих. Энэ Төрийн хэмнэлтийн тухай хууль гарсан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв гадаад, дотоод томилолтын зардал байхгүй, бензин, шатахууны зардал байхгүй болоод явахгүй байгаа юм уу, эсхүл тийм тарифаар авдаг журамтай юм уу? Иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн үнэлгээ хийх гэхээр ингээд хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй мөртөө хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй ажлаа хийхгүй, тодорхой төлбөр нэхэж байгаа нь ямар учир шалтгаантай юм бэ? Энэ дээр тодорхой хариултуудыг өгөөд, тодорхой шийдлүүд танилцуулаарай, бичгээр хариулт өгөөрэй.

Нөлөөллийн бүсийн асуудал, нийгмийн нөлөөллийн үнэлгээ 2 арай жоохон өөр агуулгатай. Энэ дээр манай гишүүд хоорондоо ярилцаад ойлголтын зөрүүгээ нэгтгээд анхаарчхаарай. Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууж, үгээ хэлье.

Д.Ганмаа: Оройн мэнд хүргэе. Юуны өмнө энэ Монгол Улсын ХЭҮК-ынхон маш сайн тайлан бичсэн гэж би бодож байна. Жишээлбэл эрүүл мэндийн тал дээр бүрэн бүрэлдэхүүн хэсгээр нь, тус бүрээр нь удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, эм, санхүүжилт гэх мэтчилэн яг байх ёстой бүрэлдэхүүн тус бүрд нь тайлангаа гаргаад, тоо баримттай, сайн судлаачдыг нэгтгэж их ойлгомжтой хэлбэрээр хүргэж байгаад талархаж байна.

Энэ хэд хэдэн асуудлуудыг мэдээж бид эмнэлгийн тусламж, үйлчилгээ, чанар, хүртээмж гээд яривал маш их асуудлууд энд яригдаж байна. Олон ч гишүүд энэ талаар ярилаа. Тэгэхдээ өнөөдөр би зөвхөн эрүүл мэндийн ажилтны цалин

хөлс, ажлын байр, хүний нөөц, нийгмийн асуудлыг илүү түлхүү ярья гэж бодлоо. 1 дүгээрт, хэдийгээр Монголд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтны 82 хувь нь эмэгтэйчүүд байдаг, тэрний 33 хувь нь 30-аас 39 насны ангилалд байдаг. Эд хийж бүтээхдээ, хүүхдүүд жоохон, гэр бүлээ бүтээх энэ насны хүмүүс байдаг. Гэтэл яг хамгийн дээд давхарга гэх юм уу даа, дарга нар нь дандаа эрэгтэйчүүд ихэвчлэн байдаг. Тэгэхээр энэ жендерийн буюу эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажлын байр, авч байгаа цалин, үнэлэмж, тэр байтугай сургуульд сурч байгаа бүр эхнээсээ эхлээд л анагаах их сонин сургууль шүү дээ ер нь. Бүр нэг уначхаагүй л эрэгтэй хүүхдүүд нь ороод эмч болох боломжтой, эмэгтэйчүүд нь бүр нэг онц сайн л сурахгүй бол ерөнхийдөө барагтай дээшээ гарах боломжгүй ийм сонин салбар байхгүй юу. 20, 30 жилийн өмнө ч тийм байсан, одоо ч гэсэн тийм л байгаа.

Чадалтай мундаг эмэгтэйчүүд олон байдаг, тэгэхдээ дарга, цэрэг нар нь дандаа л эрчүүд байдаг. Сайд нар нь ч гэсэн, том газрын дарга нарын тал, ер нь дээшээгээ явах тусмаа л эрчүүд л байгаад байдаг. Тэгэхээр энэ дээр ямар асуудал үүсдэг вэ гэхээр энд ерөнхийдөө жендерийн хувьд бие биеийнхээ зовлон, жаргалыг бүрэн ойлгож авч, ажлын байран дээр тэгш боломж, тэгш хүртээмж, нийцтэй байдлыг гаргахад их асуудлууд үүсдэг байхгүй юу. Энэнтэй холбоотой одоо үүсэж байгаа нөхцөл байдал ч гэсэн мөн адилхан гэж би бодож байна. Комисст бүртгэгдсэн ажлын байрны дарамттай холбоотой маш олон өргөдлүүд гардаг юм байна. Дээрээс нь эмч, эмнэлгийн ажилчдыг байнга ажлын бус ажлаар ажиллуулдаг юм байна. Тэрэн дээр ажлынх нь хийх ёстой хүрээнээс нь гадуур ажил, тэрийг бүр 23,8 хувиар илүү цагаар давхар ажиллуулдаг. Илүү цагаар ажиллуулаад эмч, эмнэлгийн ажилчид, сувилагчид хийх ёстой ажлынхаа хажуугаар өөр ажил их 10-аас 12 цагаар ажиллуулж, тэгээд тэрэн дээрээ нэмсэн нэмэлт цалин энэ тэрийг нь нэмж сайн өгч чадахгүй учраас.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа гүйцээж асууя, нэг минут.

Д.Ганмаа: Эдгээр асуудлууд үүсдэг учраас ажлаас халшрах, ажлаас зугтах, ажлаас гарах эсхүл ерөөсөө ажлын алдаа гаргах гэдэг асуудлууд ерөөсөө байнга тохиолдоод байдаг юм байна. Эдгээртэй холбоотой би асуулт гэхээсээ илүү яах вэ 2 зүйл ярья гэж бодсон юм. 1 дүгээрт, эмнэлгийн тусламжийн талаар их сайн судалж, та хэд яг хүн төвтэй, нэгдмэл тийм тусламж, үйлчилгээг байлгах шаардлагатай байна гэдэг дүгнэлт гаргасанд баяртай байгаа. Яг ийм хуулийн төсөл орж ирж байгаа.

2 дугаарт, энэ эмэгтэйчүүдийгээ, ялангуяа тэгээд эмч, сувилагч, дунд ажилтныхаа тоо, цаг, илүү цагийн нэмэгдэл хөлсийг нь бүрэн тооцдог тийм цахим хяналтын систем бий болговол яасан юм бэ? Тэгээд орон нутагт ажиллаж байгаа эмэгтэйчүүд, тэнд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилчдыг жендерийн тэгш байдлыг хангахын тулд бид нэмэгдэл тооцдог чигээр энэ дээр илүү бодлого.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариулья, хэн хариулах вэ? ХЭҮК 3 дугаар микрофон Сүнжид дарга хариулья.

Д.Сүнжид: Ганмаа гишүүний саналыг дэмжиж байна. Тэр нөгөө санаачлах хуулиуд, зохицуулах ёстой асуудлууд, тэгээд эмч болон эрүүл мэндийн ажилтнуудын хөдөлмөрлөх орчин, нөхцөл, ажлын ачаалал, цалин хөлстэй энэ асуудлуудыг шийдвэрлэх ёстой гэдэг дээр саналыг дэмжиж байна. Жендер дээр

тухайлан энэ эрүүл мэндийн энэ удаагийн 25 дахь илтгэлд дурдаагүй. Тэгэхдээ өнгөрсөн илтгэл дээр авч үзсэн юм. Бид төрийн үйлчилгээний албан хаагчдын асуудлыг авч үзэхэд боловсрол болон эрүүл мэндийн салбар адилхан, ихэнх нь эмэгтэйчүүд ажилладаг, эмэгтэйчүүдийн зөвхөн орлого олох боломж нь өөрийнх нь үндсэн ажил нь энэ байдаг. Тийм учраас ядуурлын байдалд өртөх эрсдэл энэ 2 салбарт их өндөр байдаг бөгөөд эмэгтэйчүүд энэ дээр нь давамгайл өртөж байна гэдэг тийм судалгаа гарсан.

Тийм учраас энэ дээр би салбарынх нь яамнаас яг энэ чиглэлд жендерийн энэ эрх тэгш байдлын харьцаа, давуу боломж олгох эсэх энэ асуудлыг авч үзээд, дүгнэж бодлогоо гаргах ёстой гэдэг ийм саналтай байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Жендерийн асуудал ярихаар нөгөө дандаа эмэгтэйчүүдийн асуудал яриад байгаа. Энэ удаа жендерийн эрх тэгш байдлыг хангахад энэ эрэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудал гээд орж ирсэн. Энэ гэхдээ ганцхан эрэгтэйчүүд биш, залуу эмэгтэйчүүд, залуу эрэгтэйчүүдэд аль алинд нь тулгамдсан асуудалтай болчихоод байгаа юм. Хөдөөд эхнэргүй залуус маш олон болчихсон. Эхнэр авъя гээд эмэгтэй хүн байхгүй, хотод нөхөргүй залуу бүсгүйчүүд олон болчихсон, нөхөртэй болъё гээд залуучууд нь цөөхөн болчихсон. Энэ өөрөө үндсэндээ Монгол Улсын хүн ам зүйн бодлого, цаашлаад үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолтой холбоотой асуудал болно. Нэг үе чинь Монгол Улсын хүн ам жилдээ 80 мянгаар өсөж байсан, хүүхэд төрж байсан, одоо хүүхэд төрөлт багассан, 50 мянга хүрэхээ больж байгаа. Энэ юутай холбоотой вэ гэхээр мэдээж энд залуу гэр бүлүүд маань, залуучууд маань хоорондоо гэр бүл болж байвал үр хүүхэдтэй болно, тэр хэмжээгээр хүн ам өсөх бодлого хэрэгжинэ. Ингээд үндсэндээ хөдөөдөө эрчүүд, бүсгүйчүүд нөхөргүй, эхнэргүй баахан эрчүүд болчихсон, хотдоо баахан нөхөргүй бүсгүйчүүд болчихсон. Энэ асуудлыг уул нь нэлээн хөндөж ярих ёстой байсан.

Нэг болохоор дандаа эмэгтэйчүүдийн асуудал яриад, нэг болохоор нөгөө талд нь дандаа эрчүүдийн асуудал яриад. Ингээд энэ 2 асуудал дээр хамгийн том тулгамдсан, эсхүл дандаа эмэгтэйчүүд маань жендерийн удирдах түвшинд, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо их байх ёстой гэж яриад л, эсхүл боловсролын байгууллага, эрүүл мэндийн салбарт эрчүүд цөөхөн байна, оюутнуудын дунд эрчүүд цөөхөн байна гэж яриад байдаг биш, энэ нэг том бодлогоо бид орхиод байгаа шүү. Энэ тал дээр анхаарах ёстой, энэ тал дээр анхаарсан, ийм асуудлыг олж харсан зүйл байвал нэг яриарай. Бадарчийн Хэрлэн гишүүн асуултаа асууя.

Б.Хэрлэн: Оройн мэнд хүргэе бүгдэд нь. Тэгэхээр ХЭҮК-ын энэ тайлан Монгол Улсад хүний эрх хэр хэмжээнд хангагдаж байгаа юм бэ гэдгийг тодорхой харуулдаг ийм албан ёсны эх сурвалж, гол мэдээлэл гэж бодож байна. Энэ тайланд, өнөөдрийн энэ 25 дахь тайланд 6 асуудал тусгагдсаны 3-тай нь холбоотой асуулт асууя.

Нэгдүгээрх нь, тэр Монгол Улсын иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээг авах эрхийн хэрэгжилтийн тухай хэсэг байгаа. Энэ дээр дэлхийн хөгжлийн индексээр эрүүл мэндийн үзүүлэлтээр Монгол Улс 2016 онтой харьцуулахад 2023 онд 17 байраар ухарлаа гээд ингээд бичихсэн байгаад байна. Энэний учир шалтгааныг хайхаар 1 дүгээр бүлэгтээ энэ нэлээн хэд хэдэн судалгаанууд хийсэн ийм байдалтай тайлангаа бичсэн байна л даа. Тэгээд надад

энэ дээр 2 асуулт байна. Тэгэхээр эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийг, эрх нь хангагдаж байгаа эсэхийг ямар хэмжүүрээр үнэлж дүгнэдэг юм бэ 1 дүгээрт? 2 дугаарт, энэ эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах энэ эрх өнөөдөр насны бүлгээр нь аваад үзвэл хэн энэ эрхээ хангуулж чадахгүй байна вэ? Аль эмнэлэгт тухайлбал, анхан шатны уу эсхүл лавлагаа шатны эмнэлэгт энэ эрх нь зөрчигдөөд байна уу, үгүй юү? Ямар өвчин эмгэгээр өвдсөн тохиолдолд энэ эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь зөрчигдөөд байгаа юм бэ? Энэ дээр яг ийм тодорхой мэдээлэл байвал энэ тайланг бичсэн хүмүүс надад хэлж өгөхгүй юү? Тэгэхээр яг энэ бүлэг дээрээс хараад байхад ердөөсөө эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг бүхэлд нь хараад, үнэлээд, дүгнэчихсэн ийм л тайлан болчихоод байна л даа. Тэгэхээр саяын асуултад хариулаад өгөөч гэж.

2 дугаарт, хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцооны зарим асуудал гэсэн энэ бүлэгтэй холбогдуулаад асууя. Тэгэхээр хүүхдийн эрх, өнөөдрийн тогтолцоо хүүхдийн ямар эрхийг нь хамгаалах бололцоо, боломжийг нь бүрдүүлээд, ямар эрхийг нь хамгаалж чадахгүй байх ийм байдалд хүрээд байгаа юм бэ, өнөөдрийн энэ тогтолцоо? Тэгэхээр энэ дээр яах вэ, хүүхэд хамгааллын тогтолцоог бүх түвшинд нь авч үзээд, санхүү мөнгөтэй нь, хөрөнгө чинээтэй нь ингээд холбоод аваад үзчихсэн байна л даа. Тэгэхээр чухам өнөөдрийн тогтолцоо үнэхээрийн ажиллаж чадаж байгаа юм уу, чадахгүй байгаа юм уу, аль эрхийг нь хамгаалаад байгаа юм, аль эрхийг нь хамгаалж чадахгүй байгаа юм бэ гэдэг дээр, 3 дахь нь энэ тодорхой хариулт өгнө үү гэж?

Дараа нь сая эрчүүдийн эрхийн тухай асуудал ярьж байна л даа. Тэгэхээр эрчүүдийн эрх зөрчигдөөд байгаа асуудал руу жаахан гүн рүү нь өнгийж та нар харав уу? Сая Бямбацогт дарга хэлж байна. Нийгэм, сэтгэл зүйн, эдийн засгийн ямар, ямар хүчин зүйлүүдийн улмаас болоод эрчүүдийн эрх өнөөдөр зөрчигдөөд байгаа юм бэ? Тухайлбал энд би нэг хууль хэлмээр байна л даа. Би нэг минут сунгаад авчихъя, тэгэх үү, асуултаа тодорхой болгох.

С.Бямбацогт: Нэг минут сунгачихъя.

Б.Хэрлэн: Тэгэхээр бид мэднэ, хөдөө малтай айлууд малынхаа бэлчээрлэх талбайг арай ахиухан байлгахын тулд эхнэр, нөхөр 2 нэг нь нэг суманд, нөгөөдөх нь нөгөө суманд харьяалалтай байж байгаад, аргагүй ахуй амьдралын шаардлагаар 2 тусдаа амьдраад, ингээд яваад, тэгээд нөгөө гэр бүл чинь ингээд хиймлээр салах ч байдаг юм уу, хиймэл нөгөө өрх тусгаарласан гэр бүлүүд үүсчихдэг. 6 настай хүүхэд нь сургуульд орно гээд явахаар эхнэр нь хүүхдээ аваад сумын төв рүү явчихдаг. Ингээд ирэхээр хойно нь нөгөө эрэгтэй хүн чинь мал дээрээ ганцаараа үлдээд, хоолтой хоолгүй тэгээд өвдөх нь их. Тэгээд илүү буруу зөрүү зуршилд орох явдал нь нэмэгдээд явчихдаг. Энэ мэтчилэн эрчүүдэд тулгамдаж байгаа асуудлыг арай жаахан учир шалтгааныг нь гүн рүү нь орж хайв уу? Тэгэхээр энэ хүний эрхийн төлөв байдлын тухай тайлан гэдэг хүний эрх хэр хэмжээнд хангагдаж байгаа юм бэ гэдгийг баталгаа нотолгоотой, үндэслэлтэйгээр тайлбарласан байх ёстой. Тэгэхээр энэ асуултуудад хариулж өгөхгүй юү?

С.Бямбацогт: 3 дугаар микрофон ХЭҮК хариулъя.

Д.Сүнжид: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн ямар шалгуураар үзэх вэ гэхээр бүх нийтийн хамралтын хувь хүн төвтэй эрүүл мэндийн

бодлогыг ДЭМБ 5 шалгуураар л үнэлж байна. Тэр шалгуураар нь энэ илтгэлд авч үзсэн. 1 дүгээрт нь, хүрэлцээтэй байгаа эсэх, хүртээмжтэй байгаа эсэх, чанартай байгаа эсэх, нийцтэй байгаа эсэх гээд. Тэгээд эцэст нь 5 дугаарт нь энэ санхүүгийн хамгаалалт өрхөд иргэнд байж чадаж байгаа юу гэдэг ийм шалгууруудыг авч үздэг юм байна. Тэгэхээр энэ 5 шалгуурын дагуу авч үзсэн.

Ямар эрхүүд зөрчигддөг вэ гэхээр бүх нийтийн эрүүл мэндийн хамралт гэдэг дээр иргэн өвдөхөөсөө өмнө эсхүл өвдсөн үедээ өөрийнхөө очиж болохуйц хэмжээний зайд нийтийн тээврээр юм уу, таксигаар юм уу, явган юм уу очиж болохуйц хэмжээний зайд очоод өөрийнхөө хүссэн үйлчилгээг авч чадахуйц байна уу, үгүй юу гэдэг дээр даатгалтай энд нь ороод явж байгаа ийм шалгууруудыг тавьдаг юм байна. Ингээд үзээд энэ 5 шалгуурынхаа дагуу тус бүрд нь ер нь асуудлуудыг нь дүгнэсэн байгаа. Ямар иргэдийн эрх, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх зөрчигдөж байна вэ гэхээр ахмад настнуудынх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийх, жирэмсэн болон төрсөн, бага насны хүүхэдтэй иргэдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээ, суурин газраас алслагдмал амьдардаг иргэдийн тусламж, үйлчилгээ авах эрх энэ хангалттай биш байна гэдэг ийм дүнгүүд байгаа.

Мөн түүнээс гадна ялгаварлан гадуурхалт дээр ЛГБТ /LGBT/ группүүдийн асуудал орж ирж байгаа, нөгөө нууцлалын асуудал, хандах асуудал орж ирж байгаа. Мөн сүрьеэ өвчтэй хүмүүс өөрсдийгөө ялгаварлан гадуурхдаг нийгмийн зүгээс гэж үзээд, энэ эрүүл мэндийн байгууллагын зүгээс биш, нийгмийн зүгээс ялгаварлан гадуурхалтад өртдөг учраас ийм нэг онцгой, онцгой анхаарал хандуулах ийм шаардлагатай ийм группүүдийн, зорилтот бүлгүүд байна гэдгийг нь гаргасан. Жендерийн үзүүлэлтээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үйлчилгээ авч байгаа байдал илүү урьдчилан сэргийлэх шатандаа биш, эрэгтэйчүүд илүү өвдсөний дараагаар ханддаг гэдэг ийм тоон судалгаануудыг энэ дээр гаргаж ирчихсэн байгаа.

Төрөлжсөн эмнэлгүүдийн хувьд яах вэ, лавлагаа шатал бүх шатдаа та хандаж болно гээд үзчихсэн учраас 78 хувь нь анхан шатыг алгасаад, өрхийн эрүүл мэнд, сумын ЭМТ-өө алгасаад шууд лавлагаа шат руугаа хандаж байгаа дүр зурагтай төрөлжсөн эмнэлгүүдтэйгээ очдог. Тийм учраас ачаалал ийм харьцан адилгүй байна гэдэг ийм дүр зураг харна, тэгээд хавдрын эмнэлгийн ачаалал, тэнд үйлчлүүлэгчдийн олон санал, хүсэлт ийм асуудал байгаа гэдэг төрөлжсөн эмнэлэг дээр гарч ирдэг.

С.Бямбацогт: Одсүрэнгийн, Хэрлэн гишүүн тодруулж асууя. Тэгье. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг 4.

Х.Мөнхзул: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид энэ удаагийн илтгэлээрээ жендерийн тэгш байдлыг хангахад эрэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудлуудыг сонгохдоо яг хүйсийн хувьд зөрүүтэй асуудлуудыг илүүтэйгээр сонгож авсан. Энэ дээр эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал, эрэгтэйчүүдийн боловсрол, ялангуяа хөвгүүдийн боловсролын асуудал, эрэгтэйчүүдийн амиа хорлолт болон энэ сэтгэцийн эрүүл мэндийн асуудал гээд мөн энэ осол, гэмтэл, аваар гээд ХАБ-ын асуудал гээд ийм хүйсийн зөрүүтэй асуудал гарч байгаа асуудлуудыг сонгосон байгаа. Тэгэхээр ингэж сонгохдоо бид яг энэ асуудлын суурь шалтгаан нь юу юм бэ, энд нөлөөлж байгаа хүчин зүйлүүд нь юу юм бэ гэдгийг гаргаж тавихыг оролдсон. Тухайлбал энэ орон нутагт ялангуяа малчдын дунд ингээд хүйсийн тэнцвэр алдагдаж ганц бие эрэгтэй малчдын.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Малчдын тухай ганц бие хүйсийн тэнцвэр ярьж байна чухал.

Х.Мөнхзул: Нэмэгдэж байгаагийн яг шалтгаан нь юу юм бэ гэхээр энэ дээр маш олон нийгэм, эдийн засгийн, хүн ам зүйн олон шалтгаантай байна. Тухайлбал, хамгийн гол юуг боловсролыг эрэлхийлсэн энэ нийгмийн хөдөлгөөн, энэ боловсролын тогтолцооны төвлөрөлтэй холбоотой, 1990 оноос хойш их, дээд сургуулиуд маш их ингээд Улаанбаатар хотод байгуулагдаж, тэгээд илүү охин хүүхдээ сургуулийн юунд хамруулах энэ жендерийн асуудалтай холбоотой асуудлууд байна. Тэгээд хамгийн гол тулгамдсан юу нь бол мэдээж Монгол Улсын нийгэм, эдийн засгийн асуудал, хот, хөдөөгийн ялгаа, дэд бүтэц, үйлчилгээний хүртээмж гээд залуус амьдрах ийм чанарын ялгааны асуудал байгаа. Тэгэхдээ Монгол Улсын ЗГ-аас энэ чиглэлээр арга хэмжээнүүд авч байна. Тэгэхээр бид энэ мэдээж энэ аягүй олон ийм цогц.../минут дуусав/

С.Бямбацогт: Ер нь наад асуудал чинь маш чухал, хурцадсан, тулгамдсан асуудал болсон. Тийм болохоор бичгээр тодорхой шийдэл танилцуулъя. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Хүний эрхийн 25 дахь илтгэл маш сайн бичигдсэн байна. Тэгээд энэ дээр бид Байнгын хороогоор ч гэсэн сонссон, 3 тодорхой зүйлийг л би энэ чуулган дээр хэлье гэж бодож байгаа юм. Тэгээд 1 дүгээрт, эрэгтэйчүүдийнхээ асуудлыг бид анхаарах үнэхээр цаг нь болчихжээ. Энэ амиа хорлолт, мэргэжлээс шалтгаалсан өвчин, зам тээврийн ослоор нас барагсад гээд ингээд харах юм бол ерөөсөө л дийлэнх нь, ихэнх нь эрэгтэйчүүд байна. Яг залуу, хөдөлмөрлөж байх насандаа нас барж байгаа тоо маш өндөр байна. Тэгээд энэ тооцооллууд, энэ тоонууд ерөөсөө л манай нийгмийн толь шүү дээ. Эрэгтэйчүүд дээрээ бид нар ямар их ачаалал өгч, ямар их эрсдэлтэй нөхцөл байдал байна вэ гэдгийг харуулж байгаа юм.

Тэгээд энэ ХЭҮК-ын энэ илтгэл дээр байгаа яг энэ хөдөлмөрийн идэвхтэй насныхан маань, эрчүүд их эрт нас барж байна, мөн амиа хорлолтын 85 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна гэдэг энэ тоо үнэхээр сэтгэл эмзэглүүлж байгаа юм. Бид чинь ингээд адилхан л эрх тэгш нийгмийг бүтээхийг зорьж байгаа. Тэгтэл эрэгтэй хүүхдүүд ч гэсэн сургуульд сурахад, эрэгтэй хүүхдүүд хөдөлгөөнтэй байна, боль гээд л багш нар нь загнадаг. Угаасаа л жаахан хүүхдүүд чинь, эрэгтэй хүүхдүүд хөдөлгөөнтэй, өөрийнх нь хүйсийн онцлог шүү дээ. Тэгээд тэрийг нь ч ойлгохгүй ерөөсөө дандаа томоотой байх ёстой гээд багаас нь ингээд тийм сэтгэл зүйн онцлогийг нь харгалзаж үзэхгүй ийм орчин ч гэсэн бүрдчихсэн юм шиг харагдаад байгаа юм. Тэгээд энэ дээр яг энэ сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой асуудал ярихаар, эрэгтэй хүүхдүүд дээр ялангуяа эрэгтэй хүн тэвчих ёстой шүү гээд ингээд олон л нийгмийн ийм хэвшмэл ойлголтууд байдаг. Тэгээд ингээд хувь хүнийх нь сул тал гэхээсээ энэ тоонууд ерөөсөө л эрэгтэйчүүдэд тусламж ирэх боломжгүй, тэгээд ийм нийгмийн дарамтын үр дагавар юм уу л гэж харагдаж байгаа юм.

Тэгэхээр одоогоос бид энэ дээр анхаарах ёстой. Ялангуяа энэтэй холбоотойгоор би энэ донтолт, сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой тоо, судалгааг авч үзсэн юм. Ерөөсөө л энэ архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, донтолт, сэтгэл гутрал эрэгтэйчүүд дээр хамгийн өндөр байна. Тэгээд энэ сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл зүйчийн тусламж, үйлчилгээг бид яаж хүртээмжтэй болгох вэ гэдэг асуудал дээр түрүүн Мөнхзул гишүүн маань их зөв өнцгийг гаргаж ирж байна. Бид

дүүрэг дүүрэгтээ яг энэ гэртээ ойрхон энэ тусламж, үйлчилгээг гаргахгүй бол, СЭМҮТ гэдэг юм уу ганцхан энэ төв дээр бүр хүндэрсэн хойно нь очдог эсхүл очоод очер олдохгүй 2, 3 сар болдог. Тэгтэл энэ чинь байнга ийм сэтгэл зүйн үйлчилгээг авах хэрэгцээ яалт ч үгүй үүсчихсэн байгаад байгаа. Тэгээд энэтэй холбоотой энэ яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар байгаа дээр 2 юм хэлмээр байна. Энэ юу юм байна лээ, залуучуудын амиа хорлолтын төлөвлөгөө гээд уг нь гаргачихсан юм байна лээ шүү дээ. Тэгсэн чинь ЭМЯ, ХЗДХЯ, Боловсролын яам, Гэр бүл хамтарч гаргана гээд энэ салбар дунд нь хийх ёстой гээд зогсчихсон байгаа юм байна лээ. Энийгээ хурдан энэ төлөвлөгөөндөө.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэг минут сунгая.

О.Номинчимэг: Гаргаад батлах хэрэгтэй байна. Энэнийхээ дагуу арга хэмжээ авахгүй бол бидний амиа хорлолт, ялангуяа эрэгтэйчүүдийн маань амиа хорлолт үнэхээр сэтгэл эмзэглүүлж байна.

2 дугаарт, хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих төлөвлөгөө байх ёстой. Тэгтэл дахиад л боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд хамтарна гээд. Тэгээд сайд нар нь хоорондоо учраа олдоггүй юм уу ерөөсөө энийгээ, энэ ажлуудыг орхигдуулаад байна, энэ дээр анхаараад өгөөч.

2 дахь асуудал төрийн нууцтай холбоотой асуудал, энэ би уг нь яримаар байна, зөндөө л байна. Төрийн нууц задруулсан нь байдаггүй мөртөө төрийн юу нь сэтгүүлч эд нарыг аваад хорьчихдог ийм ойлгомжгүй байдлаа зогсоох ёстой. Төрийн нууцын хууль УИХ дээр ороод ирчихсэн байгаа. Тэгэхдээ яагаад ч юм хэлэлцэгдэхгүй байгаа юм. Яагаад бид энийгээ хурдан хэлэлцэхгүй байгаа юм бэ, энэ чинь зөндөө их бүх нарийн тоо баримтууд ингээд хаа хаанаа гарчхаад байна. Энийгээ хурдалмаар байна.

3 дахь асуудал энэ тогтоолын төсөл байна. Би зүгээр тогтоолын төсөл харахаар маш их юм байгаа, нэг жилийн дотор үнэхээр энийг хийж гүйцэтгэнэ гэдэгт би итгэхгүй байгаа. Ялангуяа энэ шалгуур үзүүлэлт дээр бид.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэлчихлээ, манай ХЭҮК-ынхон анхааралдаа авч тодорхой шийдлүүдийг ярих хэрэгтэй байх. Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууж, үгээ хэлье.

Ж.Золжаргал: Хүний эрхийн энэ тайлан хэлэлцдэг болсон өөрчлөлт нь их сайн зүйл болсон гэж бодож байгаа. Тэгээд хүний эрхийн нөлөөлөх хүрээлэл нь их том болохоор бүх салбарын юмыг оруулж ирээд л эрүүл мэндийн салбар, боловсролын салбар юу байдаг юм, ингээд л зөндөө удаан ярьж болох байх л даа, тэгээд тэр нь ч муу юм биш байх. Энэ бүх хууль тогтоомж, төрийн үйл ажиллагааны чинь эцсийн зорилго нь хүний эрхийг хамгаалах гэж байгаа учраас иймэрхүү зүйлийг яриад, тэгээд юу болж байна гэдгийг хууль тогтоогч нар ойлгож авдаг байх гэж.

Гэхдээ энэ үүргээс гадна их чухал зүйл байгааг би та бүхэндээ сануулах гэсэн юм. Түүрүүн нэг халт ярина лээ, энэ ингээд ХЭҮК-оос Монгол Улс дахь хүний эрхийн байдлын талаарх илтгэлийг боловсруулаад УИХ-д хүргүүлнэ гэж. Энэ чиг үүргийн 12 чиг үүргийн хамгийн сүүлд бичсэн байгаа. Тэгээд энэ чиг үүргүүд дотор, жишээлбэл 7.1.6 дээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй маш том үүрэг, яаж хамгаалах юм бэ, энэ чинь цагдаа биш. Гэхдээ энэ Монгол Улсад тэр хууль, эрх зүй

нь болохгүй байна уу, төрийн үйл ажиллагаа нь болохгүй байна уу, хүний эрхийг зөрчиж байгаа байдал дээр хамгаалах гэдэг бодлогын зөвлөмж өгөхөөс гадна, хурдтай, шийдэмгий арга хэмжээ авах гэсэн ийм агуулгыг илэрхийлж байгаа гэж бодож байгаа юм. Тэгэхээр зарим зүйл дээр ХЭҮК маань жоохон хүчтэй, зоригтой, чанга дуу хоолой болж яваасай гэдэг хүсэлтийг хэлмээр байна. Надад 2 асуулт байгаа юм.

1 дүгээрт нь, үүнтэй холбоотойгоор Улаанбаатар хот маань 180 мянган хүнийг нүүрсээ авч түлэх гэж байгаа, зөвхөн энэ аппликэйшнийг ав гээд хүчирхийлээд шахчихсан, хүнд сонголт өгдөггүй. Нэг юм өгнө, өөр юмаар авч болохгүй, даарахгүйн тулд авдаг. Тэгээд нөгөө дээрээ биометрик царайны юугаар таньж, И-Монголтой /E-Mongolia/ холбогддог, энэ иргэдээс ирсэн гомдол л доо, Хүний эрхийн Комисс руу очсон байна лээ, дүгнэлт гаргасан байсан. Тэгээд дүгнэлт гаргаад, мэдээлэл цуглуулаад уулзах гэсэн уулзаагүй учраас бид өөрсдийнхөө байгаа мэдээлэл дээр тулгуурлаад зөрчсөн байна гэж дүгнэсэн гэнэ лээ. Тэгэхээр зөрчсөн юм бол энэ хуулийн заалт дээр Хүний эрхийн Комиссын шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй бол холбогдох албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх, ААН-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, үйл ажиллагааг зогсоох талаар санал гаргаж, холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ гэж байгаа юм. Ийм зүйл хийсэн зүйл байна уу? Хэнийг хариуцлагад татаад, хэзээ яаж татах талаар хүргэсэн санал байгаа юу?

С.Бямбацогт: Хариулъя, ажлын хэсэг 3 дугаар микрофон.

С.Ганзориг: Золжаргал гишүүний асуултад хариулъя. Түрүүн нийслэлийн нөгөө "Хотула" аппликэйшнтэй холбоотойгоор асууж байх шиг байна. Тэгээд энэ дээр 3 төрлийн мэдээлэл шаардаад, эхлээд хамгийн бага мэдээлэл буюу имэйл хаяг, гар утсаар бүртгэл хийгдээд, дараа нь ДАН системээр танин баталгаажуулалт хийгдээд, дараа нь цалин, орлого, албан тушаалыг бичээд ингээд нүүрс авах ийм мэдээллийн сан үүсгэж байсан. Энэ дээр албан шаардлага өгөөд, шаардлага өгөөд энэ зөрчлийг арилгуулахаар нийслэлд өгсөн байгаа. Шаардлагын хэрэгжилтийн буцаж харах, хариу харах хугацаа хараахан болоогүй.

Мөн энэ хувийн мэдээлэлтэй холбоотойгоор таны асуусан асуултад, тухайн хүний хувийн мэдээлэл, эмзэг мэдээллийг задалсантай холбоотойгоор зөвлөмж болон шаардлагын хүрээнд хариу арга хэмжээ аваад, зарим албан тушаалтнуудад сахилгын болон сануулах арга хэмжээнүүдийг ингээд авсан байгаа.

С.Бямбацогт: Хариулт хангалттай гарахгүй л байна даа. Тодорхой асуугаад байхад тэгээд л хүссэн асуултдаа юм уу, мэдэж байгаа асуултдаа хариулаад бусдыг нь орхичих шиг л болох юм. Яам хариулъя.

Б.Батбямба: Золжаргал гишүүний асуултад хариулъя. ХЗДХЯ дээр энэ эрх зүйн шинэчлэлийн хүрээнд энэ эрх зүйн ялангуяа энэ хүний эрхийг хангах, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой багц арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж явж байгаа. 1 дүгээрт, Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа, Монгол Улсын ХЗДХЯ дээр бүртгэлтэй байдаг захиргааны эрх зүйн актын санд бүртгэлтэй 2400 орчим журам байгаа. Дээрээс нь энэ дээр нэмэгдээд бүртгэлгүй олон журмууд энэ иргэдийн эрхийг хязгаарлах ийм асуудлууд яригдаж байгаа. Тэгээд УИХ-ын тогтоол, ЗГ-ын мөрийн хөтөлбөрийн хүрээнд одоогоор 800 гаруй журмыг хүчингүй болгох ажил эрчимтэй явагдаж байна. Нийтдээ Монгол Улсын

хэмжээнд 8 субъектийн зүгээс энэ захиргааны хэм хэмжээний акт гаргаж мөрдөж, нийтийн эрх зүйн харилцаануудыг зохицуулаад явж байгаа. Тэгэхээр энэ эрх бүхий субъектүүдэд өөрсдийнхөө гаргасан эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийж, хэрэгжилтэд нь тэгээд.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, 4 дүгээр микрофон.

Б.Батбямба: Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд өгсөн 3 үндсэн чиглэлээр хийх ажлуудынх нь дагуу ХЗДХЯ-наас тодорхой аргачлалуудыг гаргаж өгсөн байгаа. 1 дүгээрт хуульчлан зохицуулах асуудал яригдаж байгаа, 2 дугаарт шууд хүчингүй болгох асуудал, 3 дугаарт нь бусад хууль тогтоомжтой нийцүүлээд энэ асуудлаа нэгтгэж нийлүүлэх ийм асуудлууд яригдаж байгаа.

Түрүүний ярьсан нууцын тухай хууль дээр нэмээд хэлэхэд УИХ-ын гишүүдээс өргөн барьсан энэ хуулийн төсөл маань ЗГ дээр хэлэлцэгдээд 1 дүгээрт үзэл баримтлалын хувьд нэлээн зарчмын өөрчлөлт гарахаар байна гэсэн ийм дүгнэлт гарсан. Яагаад гэхээр энд зөвхөн төрийн болон хувь хүний нууцтай холбоотой асуудал яригдсан, албаны нууцтай холбоотой асуудлыг бүрэн орхигдуулсан байсан учраас үзэл баримтлалын хувьд энэ бүрэн өөрчлөх шаардлага гарсан. 2 дугаарт, албаны нууцыг хассантай холбогдуулаад Нууцын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал маань 50 хувиас хэтэрсэн ийм зохицуулалтууд гарч ирсэн учраас Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу энэ шинэ үзэл баримтлал.../минут дуусав/

С.Бямбацогт: Золжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Золжаргал: Энэ ХЗДХЯ, ХЭҮК ямар дүгнэлт гаргаж, юун дээр ажиллаж байна гэдгийг анхаараад, мэдээлэлтэй байгаад, тэр дээр байр суурьтай байж байх хэрэгтэй байхгүй юу. Хаа хамаагүй тийм тайлбар яриад байх юм. Тэр ч яах вэ, Монгол Улсын Үндсэн хууль хүний эрхийн тухай шүү. 1 дүгээр бүлэг Улсын бүрэн эрхт байдал, тэрний цаана Монголчуудын өөрсдөөрөө амьдрах эрхийн тухай л асуудал. 2 дугаар бүлэг Хүний эрх, эрх чөлөө. 3 дугаар бүлэг Төрийн байгуулалт. Тэгэхээр энэ төрийн байгуулалтын юм чинь бүгдээрээ эрхийн төлөө үйлчилнэ. Эрхийг хамгаалах гэдэг хуулийн заалт Үндэсний комисс дээр байгаа. Энийгээ илүү зоригтой хэрэгжүүлээч. Саяынх зүгээр нэг жишээ, зөндөө юм асууж болно.

Нэмэлт нэг асуулт асуучихъя. Тэр нь гадаадад байгаа Монголчууд хэдэн 100 мянга болно, сонгуульд оролцох эрхээ эдэлж чадахгүй байна, энэ чинь үндсэн эрхийнх нь нэг шүү дээ. Энэ тал дээр тайлан дээр байгаа юу?

С.Бямбацогт: Ажлын хэсэг 3 дугаар микрофон хариулъя.

Д.Сүнжид: Золжаргал гишүүний асуултад хариулъя. ХЭҮК-ын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу бид гомдлыг хүлээж аваад хянадаг, эсхүл гишүүн өөрийнхөө мэдээллээр хяналт шалгалтыг явуулдаг. Тэгээд энэний хүрээнд бид жилдээ 1400 орчим өнгөрсөн жил хүлээж авсан байна, 101 шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн байна, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны хүрээндээ ийм ажиллагаа хийсэн байна. 22 албан тушаалтанд хариуцлага тооцуулах ийм албан бичгийг явуулаад, зөвлөмж, шаардлагыг биелүүлээгүй, эсхүл зөвлөмж, шаардлага дотор хүний эрхийг зөрчсөн байгаа учир энэхүү албан тушаалтантай хариуцлага

тооцооч гээд өнгөрсөн жилийн байдлаар 22 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан гэдэг ийм тоон мэдээ танилцуулъя.

Сүүлийн асуулт дээр сонгох, сонгогдох эрхийн хүрээнд бид өнгөрсөн жил авч үзсэн. Тэгээд энэ хүрээнд бид хэд хэдэн санал, зөвлөмж гаргасан. Тэрний нэг нь яг энэ гадаадад байгаа Монголчуудын сонгох эрхийг олгох ёстой гэдэг ийм.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя, 3 дугаар микрофон.

Д.Сүнжид: Хэд хэдэн бүлгүүд ингээд сонгуулиа өгч чадахгүй орхигдоод байгаа юм. 1 дүгээрт ажил мэргэжлийнхээ улмаас орон нутгаасаа өөрийнхөө харьяаллын газар биш байгаа хүмүүс орхигдож байна, оюутнууд орхигдож байна. Түүнээс гадна гадаадад байгаа сонгогчид орхигдож байна. Сэжигтэн, нөгөө баривчлах байранд байгаа хүмүүсийг бид авч чадахгүй байгаа юм. Зөөврийн хайрцгаар авдаг тэрэнтэй холбоотой зохион байгуулалтаа хийж чадахгүй, өөр орон нутагт байгаа тохиолдолд авч чадахгүй гээгддэг. Эмнэлэгт хэвтэж байгаа хүмүүс ч гэдэг юм уу, ийм түр хугацаанд өөрийнхөө харьяаллын биш байгаа газруудад гээгдэж байна гэдэг дүгнэлтийг хийгээд, энийг хуулиараа боломжийг нь олгох ёстой. Нэгэнт Үндсэн хуулиар сонгох, сонгогдох эрхийг 18 нас хүрчихсэн, эрх зүйн чадамжтай иргэн бүхэн эдлэх ёстой байхад энэ зохион байгуулалтыг бусад хуулиараа хийх ёстой гэдэг саналыг өгсөн бөгөөд УИХ-ын тогтоолд тусгасан болохыг танд танилцуулъя.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дугаар илтгэлийг хэлэлцлээ. ХЭҮК нэлээн сайн бэлдсэн, тайлангаа жилээс жилд сайжирч байгаа. Урьд нь ХЭҮК-ын тухай хуулийг бид чинь 2021 онд батлав уу? Хуулийн шинэчилсэн найруулга баталсан. 2001 онд ХЭҮК 9 орон тоотой байсан байна, 2003 онд ХЭҮК 12 орон тоотой, 70 сая төгрөгийн төсөвтэй байсан байна. Өнөөдөр 90 орон тоотой, 12 тэрбум төгрөгийн төсөвтэй болсон. Өөрөөр хэлбэл ХЭҮК-ын хуулийг шинэчилсэн найруулснаас хойш эрс үйл ажиллагаа, зохион байгуулалт, төсөв, орон тоо бүх зүйлүүд нь нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор хүний эрхийн асуудлыг ч гэсэн олон нийтийн анхааралд авчирч чадсан, ингээд үндсэндээ үйл ажиллагаа жигдрээд явж байна.

Тийм болохоор цааш цаашдаа хүний эрх, эрх чөлөөний асуудал энэ парламентын, Монгол төрийн бодлогын хамгийн гол цөмд нь байх ёстой. Энийг ч гэсэн тодорхой хэмжээнд хийж хэрэгжүүлж байгаа, өдрөөс өдөрт, жилээс жилд үйл ажиллагаа нь сайжирч байгаа. Тэгээд тайлан илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулаад Байнгын хорооноос тогтоолын төслийг оруулж ирсэн байгаа. Тогтоолын төсөл дээр гишүүд анхааралтай хандаж асуудлуудаа ярих байх. Ингээд нэгдсэн хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцлээ.

20.55 цаг

Арав. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл хэлэлцэнэ. Төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

П.Сайнзориг: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ХЭҮК-оос 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр УИХ-д ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг ХЗБХ 2026 оны 05-р сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. ХЗБХ Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.7 дахь заалтад заасны дагуу Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулсан бөгөөд Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болон Хүний эрхийн дэд хорооноос илтгэл хэлэлцсэнтэй холбогдуулан гаргасан санал, дүгнэлтээ ХЗБХ-нд ирүүлснийг мөн хэлэлцсэн.

Байнгын болон дэд хорооноос гаргасан саналыг УИХ-ын тогтоолын төсөлд тусгаж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах нь зүйтэй гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн болно. Тогтоолын төсөл батлагдсанаар хүүхэд хамгаалал, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах эрх, мэдээлэл авах эрх, хүний эрх хамгаалагчийн эрх, эрхийн баталгаа, жендерийн эрх тэгш байдал зэрэг асуудлаар цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, төрийн байгууллагуудын уялдаа хариуцлагыг сайжруулах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Түүнчлэн тогтоолын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хавсралтаар баталснаар хэрэгжилтийн үр дүнг бодитой үнэлэх, хяналт шинжилгээ хийх, төрийн байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэнэ гэж үзлээ. Мөн өмнөх жилүүдэд Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлтэй холбогдуулан баталсан УИХ-ын тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгаатай холбогдуулан хяналт шалгалтыг эрчимжүүлэх, хэрэгжилтийг хангуулах талаар тусгасан нь хүний эрхийг хангах чиглэлээр УИХ-аас гаргасан шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг бодитой үнэлэх, хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэл, шалтгааныг тодорхойлох, хүний эрхийн асуудлаар гаргасан шийдвэрийг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэлтийг хангах ач холбогдолтой гэж үзэж байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай МУИХ-ын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү? Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

А.Ариунзаяа: Бид энэ УИХ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол, Байнгын хороодын энэ асуудалтай холбоотой ЗГ-аас жилдээ 2 удаа энэ тайланг сонсдог. Эхний хагас жилийн энэ тайланг саяхан сонсож дууссан, ингээд дараагийн хагас жилийн тайлан өгөх ийм хугацаа ирсэн байгаа. Тэгээд ер нь ингээд ямар үүрэг даалгавар өгөөд байдаг юм, тэр нь яагаад биелэхгүй байгаа юм бэ гэдэг дээр хяналт тавиад үзсэн чинь одоо ЗГ чинь 6 мянга орчим зүйл, заалтаар биелэлтээ хагас жил тутам ирүүлдэг юм байна лээ. Тэгээд тэр дотроо 2016 оны, 2017 оны тогтоолууд хүртэл байгаа байхгүй юу. Тэгээд зарим зүйл, заалтууд нь бүр хэрэгжээд дуусчихсан, хяналтаас ердөөсөө гаргаагүй. Тэгээд ийм нэг маш олон зүйл, заалтаар тэгээд хэрэгжилт нь ийм муу байгаад байдаг. Тэгэхээр үүрэг даалгавар маань ч гэсэн өөрөө тодорхойгүй байдаг юм байна гэсэн ийм дүгнэлтэд хүрээд байгаа юм.

Энэ ХЭҮК-ын илтгэлийг дагаж гарч байгаа энэ тогтоолуудыг аваад үзэхээр яг л адилхан алдаагаа бид давтаад байна л даа. Нөгөө хэнд үүрэг даалгавар өгч байгаа вэ гэдгийгээ тодорхой зааж өгөхгүй, ерөнхий даалгаврууд гарчихаар энийг дараагийн гүйцэтгэх хэрэгжүүлэх байгууллага нь тодорхой биш байгаа учраас ингээд дунд нь хаягдаад, тэгээд ердөөсөө ингээд биелэлт байхгүй. Тэгэхээр яах вэ энэ удаагийнх ингээд өнгөрсөн хэрэг, 7 хуудас ингээд бас нэг ерөнхий чиглэл болчихлоо. Гэхдээ араас нь бид яг тусгайлж байгууллага бүрээр нь эзэнжүүлж даалгавруудаа өгмөөр юм байна лээ. Тэгээд хугацаатай, биелэгдэх боломжтой ийм асуудлаар нь, үүрэг даалгавар маань ч гэсэн өөрөө тодорхой байхгүй бол биелэлт нь угаасаа энэ муу гарах нь ойлгомжтой байгаад байгаа юм.

ХЭҮК-ынхон болохоор хэрэгжүүлэгч байгууллага биш. Гэхдээ энэ тогтоолоор нэг үүрэг өгөгдөөд байгаа байхгүй юу. Монгол Улсын ХЭҮК-ын болон гишүүний зөвлөмж, шаардлагыг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих, хэрэгжүүлээгүй төрийн байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох саналаа боловсруулж, УИХ-д танилцуулахыг даалгаад байгаа юм. Тэгэхээр ХЭҮК өөрөө энэ үүрэг даалгаврыг нь биелүүлэхгүй байгаа хүмүүст хариуцлага тооцуулах тухай саналаа УИХ-д оруулж ирвэл та нарын шаардлагыг чинь тоодог болно. Тэгэхгүй бол одоогоор хэн ч, юу ч тоохгүй байна, шүдгүй арслан байгаад байна. Тэгэхээр үнэхээрийн арслан болмоор байгаа бол шүдээ УИХ-ыг ашиглаж, тэгээд холбогдох хүмүүст хариуцлага тооцсоноор дараа дараагийн шаардлагыг чинь сонсож, нэг илүү сайн хөдлөх хүмүүс гарч ирэх болов уу гэсэн ийм л саналтай байна.

С.Бямбацогт: ХЗБХ-ноос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолын төслийг боловсруулсан. Энэ тогтоолын төсөл сая Ариунзаяа гишүүний хэлж байгаа 6 багц асуудлын хүрээнд маш олон заалттай ийм тогтоол байгаа. Тэгээд энэ заалтуудыг нь хараад үзэхээр зайлшгүй орох ёстой байсан уу, байгаагүй юу, үнэхээр чухал гол бодлогын асуудлууддаа оруулах ёстой байтал шаардлагатай биш, багцлаад оруулчих ийм асуудлууд орсон тийм тогтоол болсон байна лээ. Тэгээд эргээд л нөгөө хэтэрхий деталь руу орвол хэрэгжих бололцоо, боломж эзэн биегүй болчих гээд байдаг. Нэг иймэрхүү болсон байна, цааш цаашдаа энэ тогтоол, анх удаа энэ тогтоолыг дагуулж орж ирж байгаа зүйл хэрэгжилт нь тодорхой шалгуур үзүүлэлттэй байх ёстой, энэ тогтоолын нэг дэх заалтад заасан хүний эрх,

эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг тооцох шалгуур үзүүлэлтийг хавсралтаар баталж өгч байгаа. Энэ бол ийм шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ шүү, хэмжинэ шүү, хянана шүү гэдгээ. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тогтоолын хавсралтаар баталсан. Биелэлтийг тооцох шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн суурь түвшин болон хүрэх түвшнийг хамт баталж, УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд УИХ, ХЗБХ-нд ирүүлэхийг ЗГ-т, Ерөнхий сайдад даалгаж байгаа.

Өөрөөр хэлбэл шүдтэй болгох, илүү хэрэгжих, хэрэгжиж байна уу, үгүй юу гэдгийг нь хянах, хэмжих ийм боломжтой болгосон ийм хавсралт нь орж өгч байгаа. Үүгээрээ урьд өмнөх тогтоолуудаас илүү давуу талтай, илүү үр дүнтэй болох гэж байгаа. Гэхдээ хэт их жоохон нуршсан, дэлгэрэнгүй заалтуудтай болчихсон байна лээ, цааш цаашдаа энийг анхаарах ёстой байх.

Энэ удаагийн ХЭҮК-ын тайлан дээр хүүхдийн эрхийн асуудлыг, Монгол Улсын хойч үе болсон хүүхдийн эрхийн асуудлыг нэлээн онцолж анхаарсан. Байнгын хорооноос гарах гэж байгаа тогтоол ч гэсэн энэ асуудлыг нэлээн тодорхой орсон байгаа. Олон жил цаасан дээр хүүхдийн эрх ярьж, бодлогын баримт бичиг баталсан ч амьдрал дээр тэдний эрх зөрчигдөж, хоосон лоозон төдий явж ирсэн. Өнөөдөр манай улсад хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд 30 орчим хууль, олон улсын гэрээ, конвенц хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Гэтэл хүүхдийн эрхийн байдал ямархуу байдалтай байгаа билээ. Яг өнөөдөр хүртэл ингээд тэр Заамарт цооногт 30 метрийн гүнд хүүхэд уначхаад, 3 настай хүүхэд Монгол даяар араас нь чих тавин, амьд гараасай билээ гэж чих тавин амьсгаа даран хүлээж байна. Иймэрхүү байдлаар эцэг эхчүүд хайнга ханддаг болчихсон. Өвөрхангай аймагт манай Хүний эрхийн дэд хороо очоод хуралдахад хүүхдүүд юу ярьж байна вэ гэхээр эзэнгүй нохой, харанхуй гудамж, дуусаагүй барилга, зохицуулалтгүй гэрлэн дохио бидний эрхийг зөрчиж байна гэж ярьж байна. Ийм асуудлыг бид тэгээд л яриад л байдаг, хоосон лоозон.

Тийм болохоор энэ тогтоолын гарч байгаа нэг ач холбогдол Монгол Улсын ирээдүй болсон 1.3 сая хүүхдийнхээ эрхийг тунхаглах биш, бодитоор хамгаалах асуудлыг хөндсөнөөрөө онцлогтой болж байна. Төрөөс цалинжиж хүүхдийн төлөө ажилладаг 2 мянга орчим албан хаагч, 21 байгууллага нийслэлд ажиллаж байна. Монгол Улс хүүхдийн эрхийн индексээр 194 улсаас дөнгөж 91-д жагсаж байгаа. Гэхдээ бид сэтгэл гаргаад зүтгэвэл үр дүн гарна. Өнгөрсөн жил тоо баримтууд хүчирхийллээс зугтаж түр хамгаалах байранд байрлах хүүхдийн тоо жилээс жилд нэмэгдэж байна гэсэн сэтгэл эмзэглүүлэх тоо гарч байгаа. Зөвхөн өнгөрсөн онд гэхэд 4200 хүүхэд аврал эрж аврах, хамгаалах байранд очсон байж байгаа. Цахим орчинд дарамтлуулдаг, сэтгэл зүйн хохирол амссан хүүхдийн тоо өмнөх оноос 25 хувиар нэмэгдсэн байна гэж гарч байгаа, шуурхай тусламжийн 108 утсанд эрх нь зөрчигдсэн 57 мянган хүүхэд тусламж эрж холбогдсон байж байгаа. Тийм болохоор бид анхаарах ёстой, хүүхдийн төлөө зарцуулж байгаа төсвийг нэгтгээд нийлүүлээд үзвэл 8.1 их наяд төгрөг байж байгаа.

Гэтэл хүүхдийн эрх маань бодитоор хангагдаж байна уу, үгүй юу гэдэг дээр бид анхаарах ёстой цаг болсон. Тэгээд энэ талаар манай ХЗБХ-ноос нэлээн бодитой хэрэгжүүлэх тогтоол оруулж ирсэн. ХЭҮК энэ удаа ХЭҮК-н хүний эрх чөлөө, хүний эрхийг хамгаалах тогтоолд тодорхой оруулж ирсэн. Үүнийг хэрэгжүүлэх тал дээр Их Хурал, ЗГ-аас онцгой анхаарч ажиллацгаая. Эх үрсийн баярын өмнө энэ хүүхдийн эрхтэй холбоотой асуудал, хүний эрхтэй холбоотой асуудлыг бид бүхэн хэлэлцэж тогтоолыг батлахаар болж байна. Тэгээд цаашдаа тогтоолын

хэрэгжилтэд илүү анхаарч ажиллацгаая. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Санал хураалтыг маргааш өглөө Баасан гарагийн нэгдсэн чуулганы хуралдаанаар явуулна. ХЭҮК-ын гишүүддээ баярлалаа, тайлангаа тавьсан. Илүү тайлангаа Их Хурал дээр тавьж, тодорхой асуудлуудаар анхаарал, бодлогын чиглэлүүдээ авсан байх гэж бодож байна.

21.07 цаг

Арван нэг.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг УИХ-ын гишүүн Жудагийн Баярмаа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Баярмаа: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын тухай хуулийн 39.4.1-д заасны дагуу нийтийн өргөдлийн цахим системд иргэн Рэгзэнгийн Шинэгэрэлийн байршуулсан ХХОАТ-ын хэмжээг 1 хувь болгон бууруулах өргөдлийг 100187 иргэн ердөө зургаахан хоногийн дотор дэмжсэн. Дэмжигчдийн 84 орчим хувь нь 18-аас 40 насны залуус, 57 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ үзүүлэлт татвар төлөгчдөд татварын хувь хэмжээг бууруулах нь ус, агаар мэт хэрэгтэйг харуулж байна.

Үүнээс гадна Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр, ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт өрхийн орлогыг нэмэгдүүлэх, дундаж давхаргыг тэлэх, иргэдийн татварын ачааллыг бууруулах зорилтууд туссан нь энэхүү хуулийн төслийн эрх зүйн үндэс юм. Татварын бодлогын хувьд Монгол Улс өнөөг хүртэл иргэдийн орлого, хувийн хэвшлийн өсөлтийг дэмжихээс илүүтэйгээр татвар хуримтлуулах замаар төсвийн зарлагаа санхүүжүүлэх чиглэлд давамгайлж иржээ. Үүний үр дүнд сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсын төсвийн орлого 6 их наяд төгрөгөөс 33.5 их наяд төгрөг болж, 6 орчим хувь өссөн байна. Гэтэл энэ хугацаанд иргэдийн голч цалин ердөө 3 дахин өсжээ. Өөрөөр хэлбэл төрийн орлого иргэдийн орлогоос илүү хурдтай нэмэгдсэн байна. 2018 онд төрийн нийт зарлага ДНБ-ий 30 хүрэхгүй хувьтай тэнцэж байсан бол өнөөдөр 35 орчим хувийг давсан байна. Энэ нь төрийн бүтэц данхайж, төрийн оролцоо эдийн засагт улам нэмэгдсэнийг илтгэж байна.

Өнөөдөр Монгол Улсад хувь хүний орлогын албан татварын орлогын 82 орчим хувь нь цалингаас суутгаж авч буй татвараас бүрдэж байна. ҮСХ-ны мэдээллээр үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн 86.8 хувь нь 1-ээс 9 ажилтантай жижиг, дунд бизнесүүд бөгөөд тэдний дундаж цалин нь 1.7 сая орчим төгрөг байна. 2026 оны эхний 4 сарын байдлаар 2.1 сая орчим иргэн 13.34 их наяд төгрөгийн хэрэглээний, 190404 иргэн 1.12 их наядын хугацаа хэтэрсэн болон чанаргүй, 601 мянган иргэн 6.38 их наядын цалингийн, 104674 иргэн 883 тэрбумын хугацаа хэтэрсэн болон чанаргүй цалингийн зээлийн тус тус үлдэгдэлтэй байна.

Мөн өргөн хэрэглээний барааны үнэ, инфляц, нийслэлийн татварууд, автотээврийн татвар, зам ашигласны төлбөр, цахилгаан, дулаан, ус зэрэг суурь үйлчилгээний тарифууд үе шаттайгаар нэмэгдэж, иргэдийн бодит орлогыг улам бууруулж байна. Өнөөдөр хөдөлмөр эрхэлж хамгийн шударгаар татвар төлж буй цалинтай иргэд дундаж давхаргын жишгээр хуримтлал үүсгэж хөрөнгөжиж чадахгүй байгаа нь эсрэгээрээ инфляц, зээлийн дарамт, татвар, НДШ-ийн ачаалалд хамгийн их өртөж, өрнөөс өр, зээлээс зээлийн хооронд амьдарч байна.

Судалгаа, улс орнуудын эдийн засгийн өсөлтөд ХХОАТ-ын өөрчлөлт сөргөөр нөлөөлдөг болохыг хэд хэдэн судалгаанд дурдсан байна. Тухайлбал, АНУ-ын хувьд холбооны түвшинд 1947 оноос хойших 2006 онуудын ДНБ-д эзлэх ХХОАТ-ын орлогын мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд ХХОАТ-ыг 1 хувиар бууруулахад нэг хүнд ноогдох ДНБ эхний улиралд 1.4 хувь, 3 дугаар улиралд 1.8 хувиар өссөн байна. 2022 оны Такс Фаундэйшны /Tax Foundation/ судалгаа, мөн Европын Холбооны өндөр хөгжилтэй 25 улсын 1975-аас 2010 оны мэдээлэлд хийсэн судалгаагаар ХХОАТ-ын өөрчлөлт эдийн засгийн өсөлттэй урвуу хамааралтай болохыг дурджээ. Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2025 оны 11 дүгээр сард хийсэн ХХОАТ-ын талаарх иргэдийн ойлголт, хандлагыг тодорхойлох чанарын судалгаанд оролцогчдын 80 хувь нь Монгол Улсын хөгжлийг дэмждэг ч татварын өсөлтөөр бус төрийн үр ашигтай засаглалд тулгуурлан дэлхийн жишигт хүрэх ёстой. Гэтэл үндсэн шалтгаан нь төрд итгэх итгэлийн хомсдол, амьжиргааны түвшин, татварын мөнгөөр бүрдсэн улсын төсвийн зарцуулалт, үр ашиггүй, үрэлгэн, хариуцлагагүй, ил тод биш байдал, дээр нь авлига, хээл хахуулийн асуудал, нөөцөө зөв ашиглаагүй байдал зэргээс болж татвар төлөх дургүй хэмээн хариулсан байна. Тодруулбал, татвар Монгол Улсын хөгжилд зарцуулагдахгүй байгаа нь энэхүү судалгаагаар харагдаж байна.

Эдийн засаг, нийгмийн үр дагавар. Хуулийн төсөл нь ХХОАТ-ын тухай хуулийн 6.3-д заасан татварын хэмжээг 1 хувь болгон бууруулах агуулгатай. Энэ өөрчлөлтөөр дараах үр дүн гарна. Иргэдийн гар дээр үлдэх бодит орлого нэмэгдэнэ, худалдан авах чадвар сайжирна, хөдөлмөр эрхлэх идэвх нэмэгдэнэ. Цалингаа нуух, бэлэн мөнгөөр тооцоо хийх зэрэг сүүдрийн эдийн засаг хумигдана. Хувиараа бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх сонирхол нэмэгдэнэ. Дундаж давхаргыг бодлогоор дэмжих нөхцөл бүрдэнэ хэмээн үзэж байна.

Мөн татварын таатай орчин нь жижиг, дунд бизнес, үйлчилгээний салбарын орлогыг дэмжсэнээр татварын бааз суурь нэмэгдэж, эдийн засаг дахь цусны эргэлт сайжрах ач холбогдолтой юм. Үүнийг өмнөх татварын хувь хэмжээг бууруулсны ард үүссэн татварын орлого нэмэгдсэнтэй холбож тайлбарлаж болно.

Эрхэм гишүүд ээ, жижиг өөрчлөлтүүд эдийн засгийг өөрчилж чадсангүй. Харин ХХОАТ-ыг 1 хувь болгож бууруулах энэ төсөл нь иргэдийн орлогыг хамгаалах, дундаж давхаргаа дэмжих, эдийн засгаа ил болгох бодит реформ юм. Энэ зөвхөн татварын хувь хэмжээ бууруулах асуудал биш. Энэ төр өөрийнхөө үрэлгэн бүтэц, зардлаа танаж, төрийн жинхэнэ шинэчлэлийг хийх бодит шаардлага, бодит боломж юм. Эцсийн эцэст иргэд цалин нэхэж халамж хүсээгүй, аргаа барсан тулдаа хөдөлмөрлөж олсноосоо төрд хураалгадгаа жаахан ч атугай багасгая, өөрсдөө илүү ухаалаг, үр ашигтай зарцуулъя гэсэн санаа юм. ХХОАТ-ыг 1 хувь болгоцгооё. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Баярмаа гишүүнд баярлалаа. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Х.Ганхуяг: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

МУИХ-ын гишүүн Баярмаа нарын 32 гишүүнээс 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2026 оны 05-р сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь Монгол Улсын иргэн, татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилхан хөдөлмөр эрхлэлтийн орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсан шилжүүлсний орлого, үйл ажиллагааны болон шууд бус орлого, иргэний бусад орлогод ноогдуулах ХХОАТ-ын хэмжээг 1 хувь болгон бууруулснаар татвар төлөгч иргэдийн татварын ачааллыг хөнгөлж, дундаас дээш орлоготой өрхийн хөрөнгийн зах зээлд оролцох оролцоо нэмэгдэнэ гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Жаргалсайхан хууль батлагдсанаар өрхийн орлого болон иргэдийн амьдралд үзүүлэх нөлөөллийн талаар, УИХ-ын гишүүн Цэнгүүн 100 мянган иргэний гарын үсэгт үндэслэн санаачилсан ХХОАТ-ыг 1 хувь болгон бууруулахыг дэмжиж байгаагаа илэрхийлж, энэ төсөл нь ЗГ-аас өргөн мэдүүлсэн хуулийн төслийн зорилго, агуулгатай нийцэж байгаа эсэх, УИХ-ын гишүүн Энхтүвшин хуулийн төслийг төсвийн жилийн дундуур өргөн мэдүүлсэн нь Татварын ерөнхий хуульд тусгагдсан татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувийн хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн болон тухайн жилийн төсөлтэй хамт боловсруулах зохицуулалттай нийцэж байгаа эсэх, мөн иргэдийн хэдэн хувийн дунджаас дээш болон доош орлоготойг тодруулж, хувь хүний орлогын татварын хувь хэмжээг бууруулснаар орон нутгийн төсвийн орлогын бууралтыг хэрхэн шийдвэрлэх талаар, УИХ-ын гишүүн Үүрийнтуяа ХХОАТ-ыг бууруулснаар орлогын түвшний ангиллаас хамаарч иргэдэд үзүүлэх татварын нөлөөллийн судалгаа хийгдсэн эсэх, мөн орон нутгийн төсвийн орлогын дийлэнх хувийг хувь хүний орлогын татвараас бүрдүүлж байгаа тул орлогын эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх талаар, УИХ-ын гишүүн Алтанхуяг ХХОАТ-ыг бууруулж 1 хувь болгохыг дэмжиж байгаагаа илэрхийлж, татварын бодлого, төсвийн зохицуулалттай холбоотойгоор ЗГ үнийн өсөлт болон төсвийн зохицуулалтын талаар олон нийтэд хэрхэн танилцуулж байгаа талаар, УИХ-ын гишүүн Шижир өрхийн орлого зарлагаасаа доогуур байгаа өнөөгийн нөхцөлд хувь хүний орлогын татварыг 1 хувь болгон бууруулснаар иргэдийн амьжиргааг дэмжихэд хэрхэн нөлөөлөх, мөн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд ямар үр дүн үзүүлэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан УИХ-ын гишүүн Ганхуяг хувь хүний орлогын татварыг бууруулах хуулийн төслийг дэмжиж байгаа ч орлогоос хамааруулан татвар ноогдолтыг шатлалтайгаар тогтоох нь зүйтэй талаар, УИХ-ын гишүүн Пунсалмаа хувь хүний орлогын татварыг 1 хувь болгохыг дэмжиж байгаа бөгөөд өндөр татвар төлсөн иргэдэд буцаан олголтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж, УИХ-ын гишүүн Даваагийн Цогтбаатар, А.Ганбаатар нар хувь хүний

орлогын татварыг 1 хувь болгосноор иргэдийн мөнгөн орлого болон дотоодын зах зээл дэх мөнгөн урсгал нэмэгдэх тул хуулийн төслийг дэмжиж байгаа талаар тус тус санал хэлсэн болно.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 47.1 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэхийг хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ганхуяг гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтийн дарга. Ажлын хэсгийн гишүүдэд УИХ-ын үйл ажиллагаанд, Их Хуралд хүндэтгэлтэй хандахыг хүсье. Мөн УИХ-д үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх үүрэгтэй, худлаа мэдээлэл өгөхийг хориглодог, та бүхэнд сануулж байна.

УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуултаа асууна. Батын Батбаатар гишүүн алга байна. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя.

Ө.Шижир: Би Байнгын хороо энэ тэр дээр асуулт асууж, үг хэлсэн болохоор товчхон хэлнэ. Ер нь ЗГ-ын, төрийн УИХ-ын үндсэн үүрэг иргэдээ яаж сайхан амьдруулах вэ, тэдний амьдрах орчныг яаж сайжруулах вэ, худалдан авалтыг яаж нэмэгдүүлэх вэ, мөнгөний ханшийн уналтыг хэрхэн хамгаалах вэ, иргэдийн бодит орлого хэрхэн нэмэгдэв, дундаж орлогыг яаж нэмэгдүүлэх вэ гэдэг л үндсэн чиг үүрэг, зорилготой юм байгаа юм шүү дээ. Тэр ч үүднээсээ энэ хуулийн төслийг дэмжиж гарын үсэг зурсан хүмүүсийн нэг. Татварын ачааллыг бууруулах, иргэдийн бодит орлогыг дэмжих, аж ахуйн нэгжүүдийнхээ үйл ажиллагааг сайжруулах, тэдний бодит орлогыг нэмэгдүүлэх, эргээд зах зээлд хөрөнгө оруулалт нийлүүлэх ийм бодлогыг УИХ, ЗГ хийх ёстой юм. Харамсалтай нь өнөөдөр бид татварын талаар ганц ч ган хийгээгүй 2 жил боллоо. Өнгөрсөн хугацаанд, 2016 оноос хойш дахиад хэлье, татвар нэмэхгүй гэж амлаж гарч ирсэн МАН 11 төрлийн татвар нэмсэн. Энэ нь иргэдийн халааснаас шууд авч байгаа мөнгө.

Өнөөдөр инфляц ингээд 11 хувьд хүрчихлээ, 11 хувь гэдэг та бидний халаасанд байгаа 100 мянган төгрөгийн 11 мянгыг нь төр буруу бодлогын хүрээнээс дээрэмдэж байна гэсэн үг. Худалдан авах чадвар луу нь халдаж байна гэсэн үг, халааснаас нь шууд авч байна гэсэн үг. Тэгээд бид яаж ЖДҮ-н бизнес эрхлэгчээ дэмжих вэ, яаж анхан шатны бизнес эрхлэгчээ дэмжих вэ, яаж тэр 1-ээс 9 ажилтантай байгаа 80 хэдэн мянган компанийн үйл ажиллагааг 10-аас 20 ажилтантай болгох уу, яаж 20-оос 30 ажилтантай болгох вэ гэдэг ийм бодлого уг нь ярих ёстой юм. Тэрнээс яаж байгаа бүгдээс нь бүх татвар, шимтгэл, хураамж, нөхөн торгууль, инфляц, тэгээд ямар нэгэн төрийн дарамт, авлига гээд ингээд авч болох бүх юмыг нь яаж авч болох вэ гэдэг ийм бодлоготой байж болохгүй л дээ.

Өнөөдөр энэ нийгмийн бухимдал чинь юу болоод байгаа вэ гэхээр авлига хэрээс хэтэрснийг, авлига авч байгаа мөнгө нь сая саяар байж байгаад тэрбум тэрбумаар, дараа нь их наядаар ярьдаг болсныг. Зүгээр нэг танай намын нэг хурган даргын гэрийн сейфээс 7.4 тэрбум төгрөг олддог болсныг л шүүмжилж бухимдаад байгаа юм шүү дээ. Ийм нөхцөл байдлууд олон болоод тэр хүн татвар төлөхийг хүсэхгүй байгаад байгаа юм. Олж байгаа орлогоосоо ихэнх юмаа татварт төлөөд ирэхээр ахуй амьдралд нь хүрэхгүй болохоор хүн татвар төлөх сонирхолгүй болоод байгаа юм. Татвар төлөх сонирхолгүй болоод ирэхээр далд эдийн засгийг бий болгоод байгаа юм. Бэлнээр авчихъя гэдэг ч юм уу, үйл ажиллагааны зардал болгоод гаргачихъя гэдэг ч юм уу, тэр хүнд өнөөдөр хэмнэгдэж байгаа 100 мянган төгрөг нь их мөнгө байхгүй юу даа.

Өнөөдөр магадгүй энд сууж байгаа хүмүүс инфляцын 11 хувийн тэр нөлөөллийг ойлгохгүй, мэдрэхгүй шүү дээ. Хамгийн бага цалин авч байгаа, хамгийн бага цөөхөн ажилтантай компанид ажиллаж байгаа дундаж цалин 1.8 сая төгрөг байгаа тэр хүмүүс инфляцын нөлөөг энд байгаа хүмүүсээс 5 дахин илүү мэдэрнэ, 5 дахин илүү зовно. Өмнө нь 5 талх авдаг байсан бол энд байгаа хүмүүс авдгаа авдгаараа л авна, тэд нарт нөлөөлөл байхгүй. Харин бага, дунд орлоготой иргэд 5 талхаа 3 болгоно. Инфляцын нөлөө ч ийм байхгүй юу. Тэгээд хувь хүний орлогын албан татварыг 1 хувиар бууруулахад ДНБ эхний улиралдаа 1.4 хувиар, 3 дугаар улиралдаа 1.8 хувиар өсдөг тийм олон улсын судалгаа байна гэдгийг сая илтгэлдээ дурдлаа.

Өнөөдөр манай ДНБ 90 их наяд, ойролцоогоор 88, 89, 90 их наяд гээд бодоход нийт ДНБ-ий чинь 65 орчим их наяд төгрөг нь иргэдийн шууд цалин болон тэтгэвэр, шууд орлогоосоо авч байгаа худалдан авалтаас үүсэж байгаа шүү дээ. Худалдан авалтаас үүсэж байгаа ДНБ байхгүй юу, нийт ДНБ-ий чинь бараг 65 их наяд нь. Хэрвээ хүн амын орлогын албан татварыг 1 хувь болгоод бууруулбал иргэдэд үлдэж байгаа бодит орлого нь зах зээлд шууд нийлүүлэгдэнэ. Хаа нэгтээ алга болохгүй, хэн нэгэн даргын халаасанд очихгүй, хэн нэгэн даргын тансаг хэрэглээнд очихгүй, хэн нэгэн хүний өмнөөс боломжийг хулгайлах ийм юм руу очихгүй, шууд зах зээлд нийлүүлэгдэнэ, дотоодын нийт бүтээгдэхүүнийг чинь нэмэгдүүлнэ гэсэн үг.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ тийм ээ, дэмжиж үг хэллээ. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуултаа асууя, алга байна. Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуултаа асууя.

С.Цэнгүүн: Оройн мэнд хүргэе. Бид ингээд ер нь хөдөлмөр эрхлэгч нараа дэмжье гэдэг бодлого санаачлаад ХХОАТ-ыг 10 хувиас 1 хувь болгоё гэж байхад ЗГ нь ч тэр, тэгээд зарим нэг МАН-ын гишүүд нь болохоороо энэ маань өөрөө боломжгүй юм, их хэрэггүй юм, нэг хөдөлмөр хийж байгаа хүмүүс нь гээд байгаа, тэрийгээ болохоороо өндөр орлоготой хүмүүсийгээ үзэн ядах байдлаар нэг хараад байх шиг байгаа юм. Гэтэл яг үндсэндээ энэ татварыг бүрдүүлж байгаа ХХОАТ-ын дийлэнх буюу 80 гаруй хувийг нь хамгийн бага түвшнээр татвар төлөгч буюу бидний хэлдгээр энгийн яг цалингаараа амьдардаг хүмүүс нь л бүрдүүлээд байгаа юм. Тэн дунд ямар нэгэн байдлаар хамгийн өндөр цалин авдаг хүмүүс нь ерөөсөө ороогүй.

Тэгээд 1 зүйл байгаа нь болохоор бид хөдөлмөр хийдэг хүмүүсийг ерөөсөө дэмжье гэдэггүй. Тэр нь юун дээр харагдаж байна гэхээр албан бус хөдөлмөр

эрхлэлтийн тоог хараад үзэхээр 2020 онд албан бус хөдөлмөр эрхлэгчид нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт 54 мянга байсан байгаа юм, 2024 он болоход 112 мянга болж 2.1 дахин өссөн. Энэ юуг илэрхийлж байгаа вэ гэхээр манай татварын бодлого маш хүнд байгаад байна. Тийм учраас энэ хүмүүс маань татвар төлөгч биш байгаад ингээд албан бусаар хөдөлмөр эрхлээд ингээд явах шийдвэрийг гаргаад байна гэсэн үг. Хувь хүний орлогын албан татварыг 1 хувь болгосноор бид энэ далд байгаа эдийн засгийг гаргаж ирэх юм.

Дараагийн нэг зүйл нь болохоор бид энэ дундаж давхаргаа дэмжинэ, ХХОАТ-ыг багасгахгүйгээр тэр дундаж давхарга руу чиглэсэн бодлого явуулна гээд байдаг. Тэгээд энэ ЗГ-ын хэрэгжүүлж байгаа бодлого нь болохоор ЖДҮ сангаар жишээ нь дэмжинэ гэж хэлдэг, 2025 онд 1210 компани хүсэлтээ явуулсан байгаа. Тэн дундаас 324 компани болохоор тэр ЖДҮ сангаасаа зээл авсан, нийтдээ 47.8 тэрбум төгрөг, ингээд үлдэж байгаа 886 компани нь болохоор санхүүгийн эх үүсвэр байхгүй болохоор хөнгөлөлттэй ЖДҮ-ийн зээлд хамрагдаж чадаагүй. Тэгэхээр ямар компаниуд нь жилийн бүр ингээд маш өндөр хүүтэй, ББСБ энэ тэрээс 36 хувийн хүүтэйгээр зээл аваад, ямар нь нэг жилийн 5 хувийн хүүтэй зээл аваад явах юм бэ? Тэгээд энэ 2 компани нь хоорондоо яаж өрсөлдөх юм бэ? Энэ өөрөө яаж шударга зарчим байгаа юм бэ? Тэгэхээр ингээд төр өөрөө ингээд шударга бус зарчмуудыг бий болгоод, харин ч бүр ингээд нийтэд нь бүх иргэдэд нь хамаатайгаар хамгийн олон хүнийг хамарсан ХХОАТ-ыг 1 хувь болгочихъё гэж байхад нь тэрийг нь дургүйцээд байгаа гэдэг нь маш тийм шударга ёсны зарчимд үйлчлэхээргүй байгаад байгаа юм.

Ингээд шударга ёс ярихаар би ЗГ-ыг гайхаад байна л даа. Татвар төлөгчдийн мөнгөн дээр л төр өөрөө оршиж байгаа, ЗГ оршиж байгаа. Тэгээд байж байтал энэ татвар төлөгчдийн мөнгөөр нь бид бүхэн ингэж улсын бүтээн байгуулалтаа хийдэг гээд нэрлээд байдаг. Өнөөдөр АТГ дээр 900 хэрэг шалгагдаад яасан ч юмгүй байгаа юм. Өнгөрсөн энэ бүх саруудын хугацаанд МАН-ынхан хэн нь хамгийн сайн хулгай хийсэн бэ гэдгээ гайхуулаад ч байгаа юм шиг, бүр хэвлэлийн хурлууд ээлж ээлжээрээ хийгээд л яваад байсан. Тэгээд тэр хэргүүд нь шийдэгдсэн ч юм байхгүй, хэдэн их наядын тухай, тэрбумын тухай бид сонсоод гайхширдаг байсан чинь одоо их наядын тухай яриад яадаг ч үгүй болчихсон. Ингээд өөрсдөө болохоороо татвар төлөгчдийн мөнгийг шамшигдуулаад хулгай хийгээд ингээд авснаа яриад байгаа хэр нь тэр зүйлүүддээ ямар ч хариуцлага хүлээхгүй, тэгсэн хэр нь татвар төлөгч нар нь үнэхээр төлж чадахгүй байна, энийгээ буулгая гэж байхад нь, 100 мянган хүн гарын үсэг зурчхаад байхад тэрийгээ буулгах боломжгүй гээд хэлээд явж байна гэдэг маш болчимгүй үйлдэл. Энийгээ зогсоох ёстой байгаа юм.

Тэгээд яалт ч үгүй цаг хугацааны явцад энэ бодлого өөрөө манай татварын тогтолцоо буруу байгаа юм гэдэг маань харагдаад байгаа юм. Энэ нь Монгол Улсдаа амьдрах биш гадагшаа явахаар иргэд.../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэллээ. Жаргалсайханы Золжаргал гишүүн хариулъя.

Ж.Золжаргал: Саяын тэр 80 гаруй хувь нь 2 сая төгрөг хүрэхгүй цалинтай байна гэдэг дээр би нэмээд коммент хэлье. 80 гаруй хувь нь 2 сая төгрөг хүрэхгүй цалинтай байгаа. Тэгээд 2 сая төгрөг хүрэхгүй цалинтай хүнээс юугаараа гийгүүлсэн гэж 200000-ыг нь авах гээд байгаа юм. Ингээд инфляц байна, нөгөө олон улсын нөхцөл байдал, түлш шатахуун гээд ерөнхийдөө өртөг нэмэгдээд байгаа. Монгол Улс маань логистикийн өртөг өндөртэй, олон улсын дунджаас 2 дахин өндөр

өртөгтэй, одоо энэ өртөг улам их нэмэгдэнэ. Тэгэхээр энэ цаг үед хүмүүс юу хүлээх вэ гэхээр ямар нэгэн дэмжлэг хүлээнэ, цалингаа нэмэх юм сан энэ тэр гээд.

Тэгэхээр нөгөө нэмэх юм нь байхгүй, өгөх юм байхгүй бол ядаж авдгаа багасгаач, өгөх юм байхгүй авдгаа багасга. Өгөх юмаа нийгмийн даатгалаар өгчхөж байгаа, ЭМД-аа төлчхөж байгаа, дээрээс нь инфляцын зөрөөг төлж байгаа, нөгөө логистикийн өртгийг төлж байгаа. Тэгээд цаана гарч байгаа энэ үр дүн нь энэ 2 сая гаруй хүн 11 их наяд төгрөгийн хэрэглээний зээлтэй, эд нар чинь зээлийнхээ хүүг дийлэхээ байж байна. Тэгэхээр авдаг юмаа багасгаж, тэр төгрөгийн ханшны зөрөө, энэ орчин нөхцөлөөс болоод алдаад байгаа мөнгөний, энэ чинь унаж байгаа ийм алдагдлынх нь ядаж талыг нь татварынх нь юугаар арай нэг жоохон хөнгөрүүлэхгүй бол тэгээд түлхээд хаячих юм бол их л хүнд байдал руу орно доо л гэж бодож байна.

С.Бямбацогт: Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Ер нь яах вэ, манай энэ АН-аас сонгогдсон гишүүдээс ажил хэрэгч, шударга хэдэн гишүүд байгаа, тэдний нэг нь яалт ч үгүй манай Баярмаа байна, Пүрэвдорж байна, Ганбат байна, гишүүд бий. Өнөөдрийн бидний татварын хуулийг орлодог нь энэ шударга хуваарилалтын талаарх асуудал байхгүй юу. Тэгээд үндсэндээ 2 жил УИХ дээр ажлын хэсэг гараад ажиллаад, тэгээд өнөөдрийн хувилбараар ЗГ-аас өргөн барьсан Татварын багц хууль дээр хувь хүний орлогын татварыг шатлалтай байх нь зөв. 792 мянган төгрөг хүртэлх орлого дээр 0 хувь гээд ороод ирж байгаа юм.

Тэгээд би яах вэ, 2 асуудал байгаа юм, яг 1 хувийг цалингаас, цалинтай адилтгах орлого дээр 1 хувь байя, бусад бизнесийн үйл ажиллагаа дээр хувь хүний орлогын татвар 1 хувь байя гэхээр 2 асуудал байгаад байгаа юм. Нэг нь юу вэ гэхээр улс орон болохоор яах ёстой вэ гэхээр ААН-үүдийг дэмжих, тэр нь болохоор эргээгээд нийгэмд үзүүлдэг нөлөөллүүд нь их өндөр байдаг юм. Жишээлбэл ажлын байр бий болгох, шинэ техник, технологи авчрах. Энийг чинь ингээд хувь хүн рүү шилжүүлчихээр, хувь хүний орлогын албан татвар 1 хувь гээд эрс бууруулчихаар яах вэ гэхээр ААН хэлбэрээр бизнесийн үйл ажиллагаа явахаа болино гэсэн үг. Жишээлбэл Улаанбаатар хотод ингээд томоохон хотхон барьж байгаа эсхүл уул уурхай эрхэлж байгаа хүмүүс яах вэ гэхээр иргэнээрээ бизнесээ хийдэг болно гэсэн үг. Энэ 1 дүгээр асуудал. Энэ ингээд шинэ техник, технологи, нөгөө нийгмийн асуудал, ажлын байр гэдэг асуудлууд маань ингээд нэлээн сонин болно гэсэн үг.

2 дахь асуудал нь юу гарч ирж байна вэ гэхээр бизнесээс олж байгаа орлогоос, Бямбацогт дарга би үгээ хэлчихье. Та яг нөгөө хариулах хүнтэй очоод саад болоод байна. Тэгэхээр нөгөө бизнестэй холбоотойгоор нөгөө хувь хүний орлого энэ тэрээ бууруулчихаар татвараас зайлсхийх асуудлууд их үүснэ. Энэ ингээд 2 том асуудал байгаа юм. Нэг ёсондоо компаниараа хийхээ болино, тэгээд яах вэ гэхээр нөгөө хувь хүнээр хийгээд эхэлнэ гэсэн үг.

Зөвхөн ингээд цалингаас тэгвэл 1 хувь авдаг больё гээд бодоод үзэхэд яах вэ гэхээр бизнес эзэмшигч нар яах вэ гэхээр өөрсдөө өөрсөд дээрээ ногдол ашгаа цалин хэлбэрээр аваад эхэлнэ гэсэн үг цалин хэлбэрээр. Тэгэхээр энэ чинь нөгөө ХХОАТ-ыг бид 1 хувь болгох гээд байгаа боловч энэ нь цаашдаа татварын системийг бүхэлд нь эвдэнэ. Тэгээд би энэ дээр ингээд 2 хүнээс асуулт асуух юм. 1 дүгээр асуудал болохоор би энэ Цогтнарangaас асуулт асуух юм, Чимэдсүрэнгээс асуучихъя. Тэгээд миний энэ эргэлзэж байгаа энэ эргэлзээ зөв үү, буруу юу? Яагаад

гэхээр би маш олон оронд энэ татварын хуулиудыг судалсан, олон орны татварын хуулийг судалсан. Тэгээд яг хувь хүн дээр ингээд шатлал байх нь зөв юм байна. Тэр яриад байгаа дундаж орлоготой иргэдийг болохоор шатлалаар нь тэглэе, тэрнээс дээших нь тодорхой хэмжээний татвартай байя. Тэр нь ААНОАТ-ынхаа уялдаж явахгүй бол татвараас зайлсхийх, нөгөө хөрөнгө мөнгө чинь угаасаа татвар төлөгч болгон биднээс илүү ухаантай, татвараас яаж зайлсхийх вэ гэдгийг хамгийн түрүүнд хийнэ. Тэгээд энийг бол эргэлзээ нь энэ байгаад байгаа юм. Энийг би Чимэдсүрэнгээс 1 дүгээрт баталгаажуулж асуумаар байна.

2 дахь асуултыг болохоор би Баярмаа гишүүнээс асуух гээд байгаа юм. Баярмаа гишүүн болон бусад яг энэ санаачилж байгаа гишүүдээс юу асууж гуйх гээд байна гэхээр цөмөөрөө энэ санаачлаад ороод ирсэн энэ хуулийг нь дэмжмээр байгаа байхгүй юу. Гэтэл ингээд ЗГ-аас яг энэ ХХОАТ-тай холбоотой бас Татварын багц хууль өргөн барьчихсан байна. Тэр дээр ингэж шатлал ороод ирчихсэн байгаа. Шатлал нь 792 мянгаар ингээд шатлал хийчихсэн байгаа. Тэгэхээр магадгүй шатлалыг нь, тэр 792 мянгыг нэмэгдүүлэх ч байдаг юм уу, иймэрхүү байдлаар конструктив байдлаар цөмөөрөө ингээд хамтраад хэлэлцүүлээд явах, ингээд шатлалтай болгох энэ асуудлуудыг жишээлбэл Баярмаа гишүүн дэмжиж байгаа эсэхийг би тодруулчихмаар байна?

С.Бямбацогт: Эхлээд Чимидсүрэн дарга Сангийн яам хариулъя, дараа нь хууль санаачлагч бэлдэж байгаарай.

Ч.Чимидсүрэн: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Сангийн яам, Татварын бодлогын газар Чимидсүрэн. ХХОАТ дээр орлогын тэгш бус байдлыг бууруулдаг гол механизм, тийм аргачлал нь энэ шаталсан татварыг боловсронгуй болгох гэж таны хэлж байгаатай бидний санал нэг байна. Бид энийг хуулийн хэлэлцүүлгийн шатанд, мөн та ажлын хэсгийг ахлаад, гадаад, дотоодын бусад орнуудын жишээн дээр ч гэсэн ингээд аваад үзэхэд энийг авч хэлж байгаа. Тэгэхээр ер нь манай орны хувьд 1990 оноос хойш шинэ татварын юу бий болсноос хойш энэ шаталсан татварын тогтолцоотой байсан. Тэгээд шаталсан татварын хувь хэмжээ маань 1, 10, 25, 45 хүртэл ингээд хувь хүний цалингаас нь авдаг ийм системтэй байж байгаад, 4 аравтын ийм зарчим горим руу ороод, одоо буцаад 2022 оноос авхуулаад бид шаталсан татварынхаа энэ тогтолцоонд оруулсан.

Саяын бид ЗГ-аас татварын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж байгаатай холбоотой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор өнөөдрийн энэ оны хэмжээнд байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээнд 100 хувийн ХХОАТ-ын хөнгөлөлт үзүүлье гэсэн энэ шатлалыг оруулж ирсэн байгаа. Тэгэхээр ерөнхийдөө зарчим, агуулгын хувьд таны барьж байгаа, таны тайлбарлаж байгаатай санал нэг байна.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Баярмаа гишүүн хариулъя.

Ж.Баярмаа: Хариулъя. Шаталсан тогтолцоо одоо ажиллаж байгаа. 120 сая хүртэлх жилийн цалингийн орлоготой хүмүүсээс 10, 120-оос дээш 15, 180-аас дээш 20 хувь гээд. Тэгэхээр өнөөдрийн энэ статистикийн дүнгээр сарын 10 саяас дээш цалинтай иргэн Монголд 3192 байна, 180-аас дээш 3158 байна. Тэгэхдээ энэ нь давхардсан тоо гэж байгаа. Давхардсан тоо гэдэг чинь, жишээлбэл сард 10 саяас дээш төгрөгийн цалинтай иргэн давхардсан тоо гэдэг нь 3 мянга орчим байх магадлалтай гэсэн үг. Тэгэхээр уртаашаа гуравхан мянган хүн л сарын 10 саяас

дээш цалинтай байна гэсэн үг. Тэгээд цалин төлж, татвар төлж байгаа иргэд 1 сая орчим гээд тоо энэ статистикаар яваад байна. Тэгэхээр энэ иргэд чинь бүхэлдээ сая иргэн 10 саяас доош татвартай буюу.../минут дуусав/

С.Бямбацогт: Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: Би яг ингээд дахиад танаас тодруулж асууя. Яагаад ингээд байна гэхээр энэ татварын системийг бүхэлд нь эвдэнэ, татвараас зайлсхийдэг болно, ямар ч бизнесмен компаниар биш хувь хүнээрээ бизнес хийдэг болно. Том, том хотхонууд, том, том уул уурхай, том, том үйлдвэрүүд хувь хүнээр хийгдэж эхэлнэ. Цалингаас, зөвхөн цалингаас 1 хувь авлаа гэж бодоход ногдол ашгаа болон бусад бүх орлогоо цалингаараа авдаг болно. Энэ гадаадад байдаг жишиг.

Тийм учраас энэ заавал ч үгүй шатлалтай байх ёстой байдаг юм, тэгж байж энэ хууль маань ер нь зөв болно гэсэн үг. Тийм учраас би таныг ингээд дэмжмээр байна. Тэгээд би юу тодруулаад байна гэхээр шатлалтай байхыг та дэмжих үү? Шатлалтай байх нь олон улсын практик юм. Энэ чинь олон удаа туршигдаад үзсэн, татвараас ингээд зайлсхийхгүй байх, эдийн засгаа эвдэхгүй байх, татварын тогтолцоогоо эвдэхгүй байх энэ тогтолцоо нь өөрөө энэ юм. Тэгээд энийг та дэмжих үү, дэмжихгүй юү гэдэг л асуулт дээр хариулт авчихъя?

С.Бямбацогт: Баярмаа гишүүн хариулъя.

Ж.Баярмаа: Дэлхийн улсуудад хийсэн судалгаа байна л даа. Энэ яг нөгөө флат /flat/ буюу тогтмол татвар, прогрессив /progressive/ буюу таны хэлж байгаа шаталсан сайн, муу, давуу ба сул талтай гээд энэ судалгаа байна. Тэгээд шатлалтай байсны муу юм байна, сайн юм байна, шатлалгүй байсны муу юм байна, сайн юм байна. Тэгэхээр мэдээж энэ чинь яриа хэлэлцээ хийж болно. Хамгийн гол миний санаа зовж байгаа энэ асуудал нь юу гэвэл энэ дундаж анги байгаад байгаа юм л даа. Энэ сая иргэн чинь дундаж анги байгаад байна. Энэ дундаж ангийнхаа татварын ачааллыг л бууруулъя гэж байгаа юм. Тэгэхээр магадгүй тэр нэг 3 юм уу, 4 юм уу, 5 мянган иргэн ч юм уу, эсхүл нэмээд таны санаа зовж байгаачлан бусад энэ бизнесменүүд ингээд орлогоо цалингаар аваад байна гэдэг ийм зовнил байгаа бол энийг ажлын хэсэг байгуулагдаад ажиллавал энэ дээр ярьж болно. Маш сайн судалгаа гаргаж болно. Тэгээд шатлалтай байвал гол тэр 10 саяас доош татвар төлж байгаа 1 сая иргэн дээрээ 1 хувиа байлгаад, тэрнээс дээш.../минут дуусав/

С.Бямбацогт: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Хуулийн төслийг сонсоход их сайхан, Баярмаа гишүүнээ, 1 хувь болгоё гээд би ч гэсэн хоёр гараа өргөөд дэмжмээр байна. Гэхдээ нэг хэдэн зүйл байна. Төрийн татвар авч байгаа гол үндсэн зорилго ерөөсөө л орлогыг дахин хуваарилах. Тийм учраас дэлхийд 196 орон байгаагаас хэдэн орон нь 1 хувийн татвартай байдаг вэ? Би зүгээр статистикийн мэдээлэл, энэ датаг авч үзээд ингээд харахаар Арабын Нэгдсэн Эмират Улс, Катар гэх мэтчилэн улс орнууд хүн амын орлогын албан татвар авдаггүй, өөрөөр хэлбэл тэд нар хангалттай байгалийн баялгаасаа орлогоо олчихдог ийм орнууд байдаг. Европын болон дундаж бүлэг ихтэй Европын ихэнх улс орнууд шаталсан татварыг хэрэглэдэг. Зарим оронд хувь хүний орлогын албан татварыг нэг иргэнд ногдох амьжиргааны баталгаажих доод түвшин нь, өрхийн чинь нэг гишүүнд тэрнээс доош байвал ямар ч татвар авахгүй энэ тэр гээд янз бүрийн ийм шатлалууд байдаг.

Тийм учраас бид арайхийж олж байгаа энэ татвар, шимтгэлээ тэгээд багш, эмчийнхээ цалин, хүүхдийн мөнгө, тэгээд ахмадын тэтгэвэр, төрийн үйл ажиллагааны зардал гээд ийм зүйлүүддээ зарцуулж байгаа. Яг ингээд аваад үзэхээр хэрвээ ЗГ магадгүй ХХОАТ-ын хөнгөлөлтүүдийг оруулж ирээгүй бол энэ татварыг дэмжээд явахад би бэлэн байсан. Харин ЗГ нийгмийнхээ хамгийн эмзэг, энэ үнэ тарифын өсөлтөд өртөж байгаа нийт хүмүүсийгээ орлогоор нь ялгахгүйгээр 800 орчим мянган төгрөг гэж байгаа, энийг би орж ирээд төсөв дээр ярих болов уу гэж бодож байгаа хөнгөлө. Орон сууцны хөнгөлөлтийг 60 сая байсныг 150 сая болгоё гэж байгаа юм байна лээ. Сургалтын төлбөр, хүүхдүүдийн хүмүүс яадаг, энийг өөрчилж дундаж бүлэгт хэрэглэгдэх байдлаар оруулж ирье гээд.

1 хувийн гээд орлогын албан татварын, ААНОАТ гээд 1 хувийн татвар энэ тэр гээд эргээд ийм татварын бодлогын юмнуудаа оруулж ирж байгаа учраас одоо шууд 1 хувийг бий болгоё гэхэд сонсоход сайхан боловч эргээд төсвийн маш олон хүндрэлүүдийг авчрах юм байна. Энд Эдийн засгийн сайд нар хэлж байна. Татвараа бууруулах уу, цалингаа нэмэх үү, тэтгэврээ тавих уу, үгүй юү гэдэг дээр ирнэ. Тийм учраас цаг нь болсон үед магадгүй бид төсвийн орлогоо сайжруулаад, таны тэр ярьж байгаа юмнууд би бол зөв, төсвийг үр ашигтай байлгах ёстой, дундаж ангиа тэлье энэ тэр гээд. Тэгэхээр дундаж анги ихтэй байгаа Скандинавын орнууд, Европ, Ази, Япон, Солонгос гээд дэлхийн ихэнх орнууд яг энэ шаталсан татварыг л хэрэглэдэг. Тэгэхээр бид магадгүй яах вэ, зүгээр 1 хувийн татвартай болгоё гэдэг байдлаар ингээд тавилаа гэж бодоход үндсэн татварынхаа суурь, бааз суурийг унагаагаад, эргээд дараа нь төсөв бүрдэхээ байлаа, үйл ажиллагаа болохоо байлаа гэдэг ийм үедээ ирсэн үедээ эргээд татвараа нэмнэ гэдэг ийм асуудал руу орох эрсдэл бий. Тэр үед тун хүнд байна.

Тийм учраас би танаас тодорхой асууя. Зуун ерэн хэдэн орноос яг энэ тэг хувийн татвартай, 1 хувийн татвартай хэдэн орон байна вэ? Дээрээс нь тэр 100 сая төгрөгийн цалинтай хүн байгаа шүү дээ, манай ОТ дотор гадаадын экспертүүд /experts/ энэ тэр гээд хүмүүс. Тэр хүн 1 хувийн татвар төлөх юм байна, дунджаар 2 сая төгрөгийн цалинтай багш 1 хувийн татвар төлнө гээд. Ингээд аваад үзэхээр магадгүй дийлэнх өндөр орлоготой хэсэгт нь илүү буюу нөгөө төрийн орлогыг дахин хуваарилах гэдэг энэ зарчим, татварын зарчим алдагдах ийм эрсдэлтэй, болзошгүй гэдгийг та хэр тооцож үзсэн бэ гэдгийг би асуумаар байна?

С.Бямбацогт: Хэр хариулах вэ? Хууль санаачлагч хариулъя. Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Тэг хувийн татвартай улсууд байгаа, Арабын, надаас асуугаад байгаа юм биш үү, юу болоод байна. Тийм улсууд байгаа. Та сая зөв хэллээ. Катар, АНЭУ энэ тэр гээд байна. Эд нар ер нь ямар ангилалд ордог вэ гэвэл уул уурхайгаас хамааралтай эдийн засагтай улс, Монгол ямар улс билээ, яг адилхан уул уурхайгаас хамааралтай эдийн засагтай улс байхгүй юу. Атал Монгол Улс өнөөдөр иргэдээ татвараар ерөөсөө дарамтлаад сөхрөөчихсөн. Гэтэл энэ улсууд тэг татвартай. Энэ улсуудын бодлого юу вэ гэвэл, яагаад тэг байна гэвэл гаднаас өндөр ур чадвартай, тэр tax-free zone-д нь орж ирж ажиллах сонирхолтой эдгээр улсуудыг татах зорилгоор ингэж байна. Дээрээс нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах гэж ийм бодлогыг хэрэгжүүлж байна. Тэр татварын индексийг /tax index/ улс орнуудаар гаргадаг, манай улс энэ татварын индексээ гаргах сонирхолгүй байдаг юм байна лээ. Яагаад гэвэл тийм ээлтэй тийм татвартай улс биш гэж үздэг 1-д.

2-т та сая өндөр хөгжилтэй улсуудыг ярилаа. Үнэн, үнэн, ялангуяа Скандинавын улсууд. Эд нар яаж байна гэвэл номинал /nominal/ буюу нэрлэсэн татвар нь маш өндөр, жишээлбэл Дани байна шүү дээ хамгийн өндөр татвартай улс, номинал буюу нэрлэсэн нь 55-аас 56 хувийн ийм татвар байдаг боловч нөгөө хөнгөлөлт, чөлөөлөлт нь явсаар байгаад 25-аас 40 хувийн л татвар төлдөг. Өөрөөр хэлбэл 2 дахин бага татвар төлдөг байхгүй юу, бодит эффе́ктив такс нь. Дэлхийн бүх улсууд тийм. Би танд Японы жишээг хэлье. Нэрлэсэн татвар нь 45 хувь, тэгэхдээ яг явсаар байгаад хэдэн хувийн татвар төлж байна вэ гэвэл 10-аас 25 хувийн татварыг төлж байгаа юм. Монгол Улсын нэрлэсэн татвар 10 хувь, бодит татвар яг 10 гэж явдаг. Ерөөсөө ямар ч хөнгөлөлт, чөлөөлөлт ажилладаггүй, 10 хувийн татвар нь 10 хувь. Гэтэл таны ярьж байгаа энэ улсууд 40, 50 хувийн өндөр татвартай мөртөө хөнгөлөлт, чөлөөлөлтөөрөө явсаар байгаад иргэн болгон ар дээрээ тооцоолоод үзэхээр 2 дахин бага буюу 25 хувийн татвар төлж байдаг үүгээр ялгаатай.

Төсвийн орлого тасарна гэж байна. Бид санаж байгаа байх 2025 онд ерөөсөө яагаад ч боломж байхгүй, хасах танах боломжгүй гэж байсан боловч юу боллоо хоёрхон долоо хоногийн дотор 2.3 их наядаар танаад оруулаад ирсэн, танаад оруулаад ирсэн бүр долоохон хоногийн дотор шүү. Тэгэхээр энэ төсөвт үргэлж цоорхой байгаа, энэ тансаглалаа зогсоо. Энэ олон машин дагуулж явж байгаа, энэ олон үнэтэй машины бензин зарцуулж байгаа энэ юмнаасаа татгалз, 55 тэрбумаар үнэтэй оффис түрээслэхээ боль. Ямар ч ашиггүй ажиллаж байж, ТӨК-уудын тавхан нь ашигтай ажилладаг гэж байгаа шүү дээ, мөртөө 60 гаруй их наядын asset буюу хөрөнгөтэй, энэ хөрөнгөөсөө зар борлуул. 2,8 их наядын төгрөгөөр.../минут дуусав/

С.Бямбацогт: Тодруулж асууя Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Тэгэхээр та өөрөө хүлээн зөвшөөрч байна шүү дээ, тийм үү, буцаалтын тэр олон хөнгөлөлтүүдийг өргөжүүлье гэдгийг одоо би энэ ЗГ-аас орж ирж байгаа юм дээр дахиад надад санал байгаа. Тухайлбал, хүүхдийн хадгаламж гэдэг ч юм уу, зарим нэгэн төрлийн татваруудыг хөнгөлье. Хүүхдийнхээ боловсролд зарцуулах гэж байгаа, эрүүл мэндэд зарцуулах гэж байгаа, яг түрүүний хэлдэг тэр чинь ухаалаг татвар байхгүй юу. Төр нь өөрөө өөрийнхөө орлогодоо нийцүүлээд иргэддээ үзүүлэх хэнийг хэдэн хувиар, яаж хөнгөлөх вэ гэдэг ийм юмыг нь өгье.

Энэний чинь татварын завсар нь яах гэж байна вэ гэхээр магадгүй бидний гадаад, дотоодын өндөр цалин, орлоготой, зөвхөн цалингаар хязгаарлаагүй байлаа шүү дээ энэ чинь. Татвараас бултах ийм орон зайнууд гарна. Би энэ төсвийнхнөөс асуумаар байна. Шинээр ЗГ-аас оруулж ирж байгаа юман дээр хэчнээн төгрөгийн татварын хөнгөлөлт, дэмжлэгийг үзүүлэхээр оруулж ирсэн юм бэ? Орон нутгийн татварууд дээр ямар хөнгөлөлт хүндрэл учрах вэ? Гол нь орон нутгууд энэ хүн амын орлогын албан татвараар, сум, хөдөө орон нутаг манай Монгол чинь тархай бутархай орон учраас энд нь шууд хүндрэлийг үзүүлэх юм байна гэж би ойлгоод байгаа. Тэр талаар.../минут дуусав/

С.Бямбацогт: Татварын ерөнхий газар, Сангийн яам, Чимидсүрэн дарга хариулъя.

Ч.Чимидсүрэн: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ЗГ-аас өргөн барьсан хууль дээр ХХОАТ-тай үндсэндээ 2 заалт байна гэж хэлж болно. Нэг

нь цалин, хөдөлмөрийн хөлснөөс 792 мянга хүртэлх энэ цалинг нь 100 хувь хөнгөлөх, энэнийх нь жилийнх нь төсвийн нөлөөлөл нь 540 тэрбумын нөлөөтэй байгаа. Тэгээд хувь хүний орлогын албан татвар маань өөрөө сум, дүүргийн төсвийг бүрдүүлдэг учраас давхар 2 дахин эффе́кттэй буюу 1 их наяд 680 тэрбумын нөлөөтэй гэсэн үг.

2 дахь заалт нь өөрийн өмчилсөн орон сууцаа борлуулах юм бол түүнээс 2 хувийн татварыг авдаг байгаа. Тэгэхээр өөрийн өмчилсөн орон сууцдаа 5-аас дээш жил өөрийн хаяг дээрээ ингээд оршин суусан байгаад тэрнийгээ борлуулах юм бол тэр 2 хувийн татварыг нь чөлөөлөх гэсэн энэ 2 заалт орсон байгаа.

С.Бямбацогт: Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: Баярмаа гишүүн болон бусад гишүүдийн хамт санаачилж орж ирж байгаа энэ ХХОАТ-ын хууль санаачлагчдын ярьж байгаа энэ агуулгатай ер нь санал нэг байгаа. Энэ хуулийг ер нь дэмжиж байгаа.

Гэхдээ энэ хуулийн төслийн бичилт дээр анхаарах, засах, ярих зүйлс байна. Жишээлбэл энэ ХХОАТ-ыг дан ганц цалингийн орлого бүрдүүлдэггүй. ХХОАТ-ыг 1 хувь болгох гэдэг чинь нэг өөр, цалингийн хөлсийг 1 хувь болгоно гэдэг чинь бас нэг өөр ийм утга агуулгатай зүйл юм. Би хувьдаа энэ цалин хөлсний татварыг 1 хувь болгохыг дэмжиж байгаа. Харин энэ иргэдийн олж байгаа бусад орлогод ногдуулж байгаа татварыг яагаад хэвээр үлдээхгүй хавтгайруулж байгааг би 1 дүгээрт асуумаар байгаа юм. Энд чинь хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох гээд, хөрөнгө ашиглуулсан, түрээслүүлсэн, ногдол ашгийн орлого олсон, хүүгийн орлого олсон, хөрөнгө борлуулсан, шилжүүлсэн, үл хөдлөх хөрөнгө борлуулсан, ингээд ерөнхийдөө хөрөнгийг худалдаж байгаа, шилжүүлж байгаа хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгслийг худалдан борлуулах, ингээд цаашлаад эд хөрөнгийн мөнгөний хонжвор, сугалааны хонжворын орлого гээд маш олон ийм бусад орлогууд байгаа, тэрийг ерөөсөө ярихгүй байгаад байгаа юм. Тэгээд яагаад энийг ингээд ташраар нь ингээд 1 хувь болгож оруулж ирж байгаа юм бэ гэдгийг би асуумаар байгаад байгаа юм?

05 сарын 28-ны ЗГ-ын хуралдааны тэмдэглэл байгаа. Энэ хуулийн төсөлтэй холбоотой. ХХОАТ-ын орлогын 71 хувийг өндөр орлоготой иргэд буюу 13 хувь бүрдүүлж байгаа гэдэг энэ судалгааг ЗГ-аас өгсөн. Тэгэхээр бидний яриад байгаа бусад орлого буюу 1-ээс 2 үл хөдлөх хөрөнгөтэй, түүнийгээ эргэлдүүлж байгаа, орлого олдог хүмүүсийг дэмжинэ. Харин энэний чинь цаана нөгөө 20, 30, 40, 50 үл хөдлөх хөрөнгөтэй, энүүгээрээ орлого олж, түрээсэлж, шилжүүлж орлого олж байгаа энэ хүмүүсийг татвараас нь 1 хувь болгоод чөлөөлөгдөж байгаа юм.

Тэгэхээр энэ өөрөө бусад энэ яригдаж байгаа 16-аас 19-ийн энэ зүйлд орсон бусад энэ орлогууд чинь өөрөө, энд хамаарагдаж байгаа хүмүүс чинь нөгөө хөрөнгөтэй, мөнгөтэй хөлжсэн ийм хүмүүсийн татвар өөрөө буурах нь. Тэгэхээр Ганхуяг гишүүдийн санаа зовж хэлж байгаа нь зөв юм. Хонжвор, мөрийтэй тоглоом шиг зүйлээр орсон энэ 40 хувийн татвар авдаг байсныг дахиад 1 хувь болгоод үндсэндээ нөгөө мөрийтэй тоглоом шиг энэ хүмүүсийг дэмжсэн хууль болсон байна гэж харагдаж байгаа. Тэгээд энийг яагаад ярихгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хөрөнгийн орлого, ногдол ашиг, хувьцаа энэ 10 хувь байсныг 1 хувь болгож байгаа юм. Энгийн иргэд нэг л байртай, нөгөө ипотекийн худалдаж авч байгаа байрандаа л амьдарч байгаа. 2 боллоо гэхэд эцэг эхээсээ өвлөж авсан нэг л

байртай, энэ хүмүүс ингэж учиргүй татварын хөнгөлөлтөөс ашиг орлого орох нь бага. Тэгэхээр энэ нь өөрөө яг үнэнээ хэлэхэд зүгээр ард иргэдийг цалингийн орлоготой хүмүүсийн татварыг нь 1 хувь болгож байгаа нэрээр цаана нь нөгөө хөрөнгөтэй, хөлжсөн, мөнгөтэй хүмүүсийнхээ татварыг бууруулж өгч байгаа, ерөөсөө татварын хулгай мэт харагдаж байна. Би тэгээд хариултаа авчхаад тодруулъя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Саруулсайханы Цэнгүүн гишүүн хариулъя.

С.Цэнгүүн: Энэ нэг зүйлийг тодруулж би бас гайхаад байгаа юм л даа. Бид Монголд залуучууд нь Монгол Улсдаа амьдрах итгэлгүй байгаад байна, маш олон залуучууд бүх 10 жил дээр яваад асуугаад үзэхэд, энд бүх ер нь дийлэнх нь Монголдоо амьдрахгүйгээр гадагшаа явъя гэдэг сонголт гаргаж байгаа юм. Яагаад вэ гэхээр, ер нь бидний сүүлийн 12 жил гаргасан бодлого нь ердөөсөө өндөр орлого олох, чинээлэг байх, амьдрал ахуйгаа цааш нь өөд нь татах тэр хүсэл мөрөөдөлтэй байдаг, тэр хүсэл мөрөөдөл болон тэр зүйлүүдээ ярьж байгаа хүмүүсийг бид бүхэн буюу дундаж давхаргын тухай л яриад байгаа юм. Тэр хүмүүсийг дэмжих бодлого ерөөсөө хэзээ ч хийдэггүй байгаад байдаг. Тэгээд ямар нэгэн байдлаар төрөөс хамааралгүйгээр ажил хөдөлмөр эрхлээд өөрсдийнхөө бизнесийг сайн ашиг орлоготой болгоод явчихъя гэдэг санаачилга гаргахаар нь энд баяжих гээд байна, тэд нар илүү болох гээд тийм болохоор энэ хүмүүс чинь бараг луйвардсан гээд байгаа юм.

Миний бодлоор ямартай ч албан ёсоор татвар төлөөд хөрөнгөө нотлоод явж байгаа энэ хүмүүст ямар нэгэн асуудал байхгүй байгаа. Бидний анхаарах ёстой гээд байгаа 50, 60 байшинтай, 50, 60 үл хөдлөх хөрөнгөтэй гэж таны нэрлэж байгаа хүмүүс нь ямар нэгэн аргаар тендертэй буюу төртэй холбоотойгоор төрийн давуу эрх, эрх мэдлийг ашиглаж, тэр нь болохоор хууль бусаар тэр хөрөнгийг олж авсан хүмүүсийн тухай байгаа юм. Үнэхээр хөдөлмөрлөөд тэр хүн хөрөнгөтэй болж чадсан байвал тийм нийгмийг бүтээхийг бид хичээх ёстой шүү дээ. Монгол Улсын иргэд маань чинээлэг болох ёстой, маш олон чинээлэг иргэнтэй болж байж манай улс хөгжинө. Тэрнээс биш төр бүгдийг нь зохицуулдаг, төр бүгдийг нь өмнөөс нь хийж өгдөг, төр дандаа ядарсан иргэдээ халамжлахын нэр дор, харин яг эсрэгээрээ иргэдээ халамжилж байна гэсэн нэр дороо бид маш их мөнгийг төрдөө төвлөрүүлээд, түүнийгээ буцааж хуваарилж байна гэж нэрлээд байдаг. Гэтэл яг үнэндээ чин шударгаар цалингаасаа тэр татваруудыг төлж байгаа хүн нь буцаад нийгмийн ямар ч халамж гэдэг тэр нийгмийн хүртээлдээ, нийгмээсээ авах ёстой тэр үндсэн эрхийнхээ дагуу олгох ёстой юмнундаа хүртэж чадахгүй байгаад байгаа юм. Энэ нь шударга биш байна.

Тэгээд үндсэндээ манай улсад тийм айхтар өмчтэй, хөрөнгөтэй, капиталтай хүн байхгүй. Нийтээрээ бид капиталгүй буюу өмчгүй байгаад байгаа юм. Тэгэхээр өнөөдрийн байгаа энэ хулгайтай, өнөөдрийн байгаа энэ авлигатай, асуудалтай байгаа үед бид харин ч төсвөө багасгах ёстой. Төсөв багасаад чинээлэг иргэд олон болоод ирсэн цагт бид шатлалыг нь ярья. Тэр үед үнэхээр баян, ядуугийн ялгаа ихсээд байна уу, үгүй юү гэдгийг яримаар байна. Өнөөдөр бид ингээд баян, ядуугийн ялгааг ярих гэхээр цаанаасаа тэртээ тэргүй энэ чинь нийтдээ 80 хувь нь өмчтэй хүмүүс байхгүй байгаад байна шүү дээ манай улсад. Тэгэхээр хэсэг хугацаанд бид зүгээр 10 жил ХХОАТ-ыг 1 хувиар яваад үзэхэд тэнд эдийн засгийн ямар өсөлт гарах вэ гэдэг нь маш.../минут дуусав/

С.Бямбацогт: Баярмаа гишүүн нэмж хариулья.

Ж.Баярмаа: Энэ ЗГ ингэж худлаа ярьж болохгүй, энэ чинь ямар аймаар юм бэ. Би энэ Сангийн яамнаас асуумаар байна. Надад энэ Үндэсний статистикаас авсан энэ мэдээлэл байна. Энэ дээр юу гэж явж байна гэвэл цалингийн орлого, цалингийн орлогоо суутгаснаар өгч байгаа энэ татварын орлогыг бүрдүүлж байгаа нь 1.9 их наяд байхгүй юу, 81 хувь нь, шууд бус орлого нь 1 хувь. Үндсэндээ цалингийн орлого ерөөсөө 82 хувийг бүрдүүлж байгаа байхгүй юу. Юун тэр өндөр орлоготой иргэн 71. Энэ 81 хувийг бүрдүүлж байгаа энэ 971 мянган иргэний чинь 53 хувийнх нь цалин нь 2 саяас доош орлоготой байхгүй юу, 2 саяас доош. Энэ ЖДҮ-чдийн чинь 86 хувь нь 1-ээс 9 ажилтантай байдаг юм байна статистик. Энэ 1-ээс 9 ажилтны дундаж цалин 1.7 сая. Энэ статистикийн газар, энэ Сангийн яам энэ тоог.../минут дуусав/

С.Бямбацогт: Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Би хувьдаа энэ цалин хөлсний татварыг 1 хувь болгохыг дэмжиж байгаа. Тэгэхээр Цэнгүүн гишүүний хэлж байгаа энэ залуучуудыг дэмжиж ажилламаар байна гэдэг дээр би ч гэсэн адилхан дэмжиж ажилламаар байгаа. Тэгэхдээ бидний яриад байгаа энэ цалингийн орлогыг бууруулах дээр бид тэгвэл яагаад ингэж бүтэн хавтгайруулж 1 хувь болгох гэж байгаа гэдгийг би харин логикийг нь ойлгохгүй байгаад байгаа юм. Цалингийн орлоготой буюу залуучуудыгаа дэмжсэн энэ заалтаа аваад үлдье л дээ. Бусдыг нь тэр шатлалаар нь хуучин хэвээр нь үлдээе л дээ. Үгүй ээ, ЗГ-ын энэ хуульд өгсөн санал, тэмдэглэлээс нь би уншиж байгаа юм л даа. Тэгэхээр Статистикийн газар бодвол мэдээллээ өгч нэгтгэж байж, ЗГ энэ хуульд өгч байгаа тэмдэглэлийг гаргаж байгаа юм. Тэгэхээр энэ хэлээд байгаа байхгүй юу, та нарын тоо зөрөөд байна. ЗГ-ын саналд нийт орлогын 71 хувийг хамгийн өндөр орлоготой 13 хувь бүрдүүлдэг. Тэгэхээр энийг 1 хувь.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд асуучихъя Мандхай гишүүн.

М.Мандхай: Тэгэхээр ташраар нь хавтгайруулна гэдэг чинь үндсэндээ хөдөлмөрлөөд цалингаараа 40, 50 байртай болохгүй юм гэж хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр яаж бүрдүүлсэн нь мэдэхгүй, энэ олон байртай хүмүүсийг ерөөсөө ингээд 1 хувь болгож өгч байгаа нь өөрөө тэгээд зөв юм уу гэж хэлэх гээд байгаа юм, 1 дүгээрт.

2 дугаарт түрүүн хэллээ, ингээд олон хүмүүс хөлжөөд явах нь зүйтэй шүү дээ. Тэгвэл бид энэ орон нутгийн сум, орон нутагт байгаа сургууль, цэцэрлэг, гэрэлтүүлэг, энэ улсын төсөвт бид энэ орчинд амьдрах энэ орлогыг бид тэгвэл хаанаас бүрдүүлэх вэ? Нийт энэ орлогын чинь бараг 40 хувь нь орон нутгийн төсөв рүү явдаг гэж байгаа юм. Тэгэхээр бид хэрэв эндээс бууруулж байгаа бол нөгөө талаас нь хаанаас орлого олох боломжтой вэ гэдгийгээ хэдүүлээ шийдэлд орж ирэх хэрэгтэй. Та нарын ярьж байгаа юм зөв. Улсын төсөв өөрөө үрэлгэн байна.../минут дуусав/

С.Бямбацогт: Баярмаа гишүүн хариулья.

Ж.Баярмаа: Энэ маш харамсалтай байна. Бүр он дараалаад энэ хараа, хамгийн бага цалинтай, орлоготой иргэд нь 81 хувь, өмнөх жилийнх 78 хувь, тэрний

өмнөх 2022 оных 80 хувь байхгүй юу. Тэгээд би сая хэлсэн, 1.7 сая төгрөгийн цалинтай байна. Та нэг 3-аас 5 мянган иргэн сарын 10 саяас дээш төгрөгийн цалинтай буюу тэр шатлалын 2 дахь үед хамрагддаг юм байна. Тэр хүмүүсийг хорлохын тулд энэ 10 саяас доош төгрөгийн цалинтай, энэ ёстой нэг үнэндээ амьдралд нухчуулсан хүмүүсийг энэ татварын чөлөөлөлтөд оруулахгүй гээд байгааг ерөөсөө ойлгохгүй байна. Дээрээс нь 40 хувийн тэр мөрийтэй тоглоомчдыг хамгаалах гэж байна гэнэ үү? Та ийм хариуцлагагүй юм ярьж ерөөсөө огт болохгүй. Энд ямар ч мөрийтэй тоглоомчдын асуудал байхгүй. 100 мянган хүн 6-хан хоногийн дотор өөрсдийнхөө И-Монголиагаар (E-Mongolia) саналаа өгсөн шүү дээ. 6 хоногийн дотор 100 мянга, тэрний 85 хувь нь 40-өөс.../минут дуусав/

С.Бямбацогт: Золжаргал гишүүн хариулъя.

Ж.Золжаргал: Энэ татварын нэг хувь гэдэг бол зөв юм. Энэ шатлал гээд одоо ЗГ-аас тэр санал болгох гэж байгаа юм нь сарын 793 мянган төгрөгийн цалинтай бол тэг хувь гэдэг бол ерөөсөө дэмжлэг биш байхгүй юу. 700 мянган төгрөгийн цалин олгож байхад угаасаа ямар татвар ярих юм бэ. Тэгээд тэр шатлал яриад байгаа бол шатлал нь том байх ёстой. Тэр нь шатлал байхгүй бүр ААН-үүд нь утгагүй болбол компанийн эзэд нь хэдэн тэрбум төгрөгөө цалин гэж гаргаж авдаг тийм утгагүй юм бол яриагүй шүү дээ. Энэ чинь сая хүн байна, 2, 3 сая, 2 сая төгрөгийн цалинтай эд нарын бүр наад зах нь ийм хүмүүс чинь 1 хувийг нь татвараараа авах ёстой. Тэгэхээр зэрэг харин дэмжээд байна, тэгээд санал нийлээд байна. Тэгэхээр энэ тавьж байгаа асуулт болохоор зэрэг "тэгээд татварын системээ нураах гэж байгаа юм уу" гээд түрүүн Ганхуяг гишүүн асуугаад байсан. Тийм бол биш байхгүй юу. Байж байгаарай, намайг тасалчихлаа, би ганцхан.../үг тасрав/

С.Бямбацогт: Золжаргал гишүүн гүйцээгээд хариулчихъя. Хууль санаачлагч.

Ж.Золжаргал: Тэгэхээр ерөөсөө үндсэн агуулга бол ийм байна. Энэ дундаж давхаргыг тэлж байх хэрэгтэй гэж яриад байгаа, тэр нь зөв. Одоогийн байгаа татварын орлогын татварын байж байгаа байдал, Монголчуудын цалин, инфляц, олон улсын байж байгаа байдал, тэгээд ЗГ-аас өргөн барих гэж байгаа тэр 793 мянга байвал чөлөөлнө гэдэг байдал нь дундаж давхаргыг агшаах үр дүнд хүргээд байна. Дундаж давхаргыг ядууруулаад байна, 1 сая, 2 сая, 3 сая төгрөгтэй хүмүүсийг ядууруулаад байна шүү дээ. Тэгэхээр дундаж давхаргаа өргөн болгох гэж байгаа бол тэр нийт одоо цалин, тэр 80 хэдэн хувь хүний татварыг ядаж 1 хувь болгох ёстой байхгүй юу.

С.Бямбацогт: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя. Алга байна. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууя. Алга байна. Би бас гишүүнийхээ хувьд нэг асуучихъя. Татвар бол төсвийн орлого бүрдүүлэх гол үндсэн чиг үүрэгтэй бас биш. Ялангуяа татварыг хөнгөлж, чөлөөлж байгаа нь халамжийг хавтгайруулж байгаа асуудал биш. Хавтгайруулж бас болохгүй. Тэгээд үндсэндээ одоо ингээд бага орлоготой нь ч 1 хувь, их орлоготой нь ч 1 хувь, шударга уу? Өнөөдөр чинь их орлого олж байгаа бол илүү ихийг төлж болно. Бага орлого олж байгаа бол багыг төлөх нь зүй ёсны хэрэг.

Татвар тэгэхээр нийгэмд шударга ёсыг тогтоох, тэгш байдлыг бий болгох зорилготой. Энэ зорилгодоо нийцэхгүй байгаад байна л даа. Өнөөдөр орлого олж л байгаа бол цалин дээр болон бусад орлого нэмэгдээд хэдэн тэрбум байсан ч 1 хувь төлнө гэж байна. Сарын одоо 15 сая, 25 саяас дээш орлоготой, жилийн 300-аад

саяас дээш орлоготой нь 1 хувь төлөхөд 30 саяыг төлнө. Сарын 800 мянга ЗГ-ын өргөн барьснаар, жилийн 10 сая төгрөгийн хүртэх орлоготой нь 1 хувь төлнө, 10 сая олж байгаа нь 1 хувь төлж байгаа, 300 сая олж байгаа нь 1 хувь төлж байгаа нь шударга уу?

Тийм болохоор энэ шударга ёсны зарчимд жоохон нийцэхгүй байгаа юм биш үү? Энийг жоохон шударга болгож болохгүй юү, шатлалтай болгож? ЗГ-ын өргөн барьсан 792 мянга хүртэл буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр орлого олж байгаа бол татваргүй байя. 792 мянгаас 1.5 сая хүртэл бол 1 хувийн татвартай байя. 1.5 саяас 3 сая хүртэл орлого олдог бол, цалин авдаг бол сарын 5 хувь байя. 5 саяас дээшээ, 3 саяас дээшээ 10 сая хүртэл бол сарын олж байгаа орлого нь 10 хувь байя. 10 саяас одоо 25 сая хүртэл бол 20 хувь байя сарын, 25 саяас дээшээ орлого олж байгаа бол одоо юу гэдэг юм бүр 30 хувь, 40 хувь байя. Ингээд олж байгаа орлогод нь таарсан татварыг ногдуулдаг байвал зөв биш үү? Татварыг ийм шударга болгож болохгүй юү? Шударга ёс тогтоомоор байна, тэгш боломж, тэгш байдлыг бий болгомоор байна.

Өнөөдөр нэг настай хүүхдэд 1 килограмм ачаа өргүүлэх, 25 настай насанд хүрсэн хүнд 1 килограмм ачаа өргүүлэх 2 чинь бас шударга биш шүү дээ. Тэгээд ийм зохицуулалтууд хийх боломж бий юү? Яагаад заавал 1 тэрбумын орлого олж байсан ч 1 хувь, 10 саяын орлого олж байсан ч 1 хувь жилийн? Энэ чинь илүү одоо юу гэдэг юм, илүү орлого олдог хүмүүстээ илүү боломжийг, илүү шударга бус байдлыг тогтоож өгөх гээд байгаа юм биш үү? Сая яриад байгаа тэр хэдэн 10 байртай, тэрийгээ түрээсэлж орлого олдог болбол, хэдэн 10 машинтай, түүнийгээ түрээсэлж орлого олдог болбол 1 хувь гээд яриад байна шүү дээ. Энийг чинь л одоо шударга бус гээд л Мандхай гишүүн түрүүн яриад байх шиг байна л даа, тэгээд энэ дээр та бүхэн бас юу гэж бодож байна вэ?

Татварыг бид зөвхөн төсвийн орлого бүрдүүлэх гэж нэг хармааргүй байгаа юм. Нөгөө талдаа татварын хөнгөлөлтүүдийг хавтгайруулж халамж байдлаар оруулмааргүй байгаа юм. Өнөөдөр бага орлоготой иргэдээ л илүү дэмжмээр байна. Орлого бага байх тусмаа татвар нь бага байя. Орлого нь нэмэгдээд байх тусмаа татвар нь бас ингээд үе шаттайгаар нэмэгддэг байя. Ийм байдлаар нэг уян хатан татварын систем тогтоочихвол уул нь шударга болчих байх. Өнөөдөр хамгийн ядарч байгаа иргэд бага орлоготой иргэд байна. Бага орлоготой иргэд гэдэг маань ахмадууд, энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний цалин авч байгаа, сая ярьж байгаа тэр 1 сая 500 мянга, 2 сая төгрөгийн сарын цалин авч байгаа улсууд байгаад байна шүү дээ. Тэгээд энийгээ л ингээд нэг жоохон ялгаад өгчихвөл, энэ ялгаад өгөх боломж одоо бий юү? Энэ дээр Сангийн яам, хууль санаачлагч 2 хариулаад өгөөч. Уян хатан, үе шаттай, шаталсан татвартай болчихвол ийм боломж одоо энэ хуулийг хэрвээ дэмжвэл байгаа юү? Энийг хариулж өгөөч. Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Мэдээж татварын үндсэн 4, 5 зарчмын нэг бол шударга байх гэж байгаа л даа. Гэхдээ энэ шударга байх гэдгийг зөвхөн энэ нэг өндөр орлоготой иргэдээс л ерөөсөө асар ихээр татвар авах ёстой гэдгээр л ганцхан ойлгоод байгаа байхгүй юу. Ганцхан тэрүүгээр ерөөсөө. Энэ нэг хэдэн юмнууд баяжих гээд байна, энэ баяжиж байгаа нөхдүүд ерөөсөө татварын хөнгөлөлтөд хамрагдах гээд байна гээд л ингээд байгаа юм л даа. Тэгээд яг тэр баян хүмүүс чинь шал өөрөөр амьдардаг, тэд нар чинь компанийн юу байдаг юм СЕО байдаг юм уу, хувьцаа эзэмшигч байдаг юм уу шал өөр байгаад байна. Яагаад гэвэл энэ статистик чинь тэгж харуулаад байна л даа.

Хамгийн гол бидний санаа зовоод байгаа юм чинь дундаж анги чинь энэ 10 хувь гэдэг юманд чинь нэрвэгдэж гүйцээд байна. Энэ 792 мянга гэдэг чинь тэгж яривал 240 мянган төгрөгөөс татвар авдаггүй чинь байж байгаа, одоо байж байгаа байхгүй юу одоо хуульд тэр ХХОАТ-ын 23 дээр. Үндсэндээ 500 мянган төгрөгийг л нэмж байгаа юм, 500 мянган төгрөгийг нэмж татвар авахгүй гэж байгаа юм. Энэ бол өнөөдөр 792 мянган төгрөгөөр одоо яаж, амьдарч байна л даа, амьдарч байна. Гэхдээ энүүгээр бол хүн шиг амьдрах ямар ч боломж байхгүй шүү дээ. Өөрөөр хэлбэл, энэ та бүгдийн санаачилсан 792 мянга гэдэг чинь бага орлоготой иргэдэд зориулагдсан ийм өөрчлөлт. Бидний хүсээд байгаа бол багаас гадна энэ дундаж орлоготой иргэддээ хандаач, энэ дундаж орлоготой иргэд чинь сөхөрлөө.

Энэ дундаж орлоготой иргэд буюу дундаж анги гэдэг ямар хүмүүс вэ гэвэл тогтвортой ажилтай, тогтмол цалин авдаг, хуримтлалтай хүмүүсийг хэлнэ гээд энэ дэлхий нийтийн жишиг байна. Атал өнөөдөр Монгол Улсын цалин авч байгаа хүмүүс өрийн хуримтлалтай байна л даа, харамсалтай нь. Хадгаламжийн хуримтлалтай байх ёстой атал өр зээлийн хуримтлалтай, 600 мянган иргэн цалингийн зээлтэй. Ямар баяжаад, хэн баяжаад байгаа юм бэ? Бүхэл бүтэн сая хүний чинь 600 мянга нь цалингийн зээлтэй, энэнийхээ 100 мянга нь хугацаа хэтэрсэн зээлтэй гэж байна шүү дээ, энэ чинь судалгаан дээр ярьж байна шүү дээ. Тэгэхэд хэнийг баяжаад, мөрийтэй тоглоомчдыг хамгаалаад байна гэж яриад байгаа юм бэ? Энэ чинь дундаж ангийг хамгаалах гээд байгаа байхгүй юу. Дундаж анги, дундаж анги.

Яах вэ үнэхээрийн тэр маш маш их мэдэхгүй хэдэн байр савтай байдаг бол татварынхаа энэ төрлүүдийг нэмж болж байна. Үл хөдлөх хөрөнгийнхөө татварыг нэм, газрынхаа татварыг нэм. Газрын татвараас орж ирж байгаа орлого өнөөдөр маш бага байдаг, хэдхэн тэрбум, энэ татвараа нэм. Энэ дижитал татвар гээд сүүлийн үед гарч байна, энийгээ нэм. Ерөөсөө жоохон толгойгоо ажиллуулж энэ татварын төрөл зүйлээ нэм, дээрээс нь энэ дундаж ангиа авар гэдэг ийм л зүйлийг хэлээд байгаа юм. Та ч гэсэн орон нутгийн төсөв гэж ярьж байна. Та бас энэ саналыг дэмжээд зөв гэж үзээд орон нутагт бол нэг хувьтай байх ёстой гэж үзсэн. Тэр үед орон нутгийн төсвийг яая гэж та бодож байсан юм бэ? Би одоо танаас асуумаар байна, эсрэгээрээ. Орон... /минут тасрав/

С.Бямбацогт: Баярмаа гишүүний асуултад хариулчихъя. Тэгээд орон нутагт бол тэгсэн. 1000-аас дээш алслагдсан аймгуудад 1 хувийн татвартай, 500-аас 1000 километр бол 5 хувийн татвартай, 500 дотор Улаанбаатарт бол 10 хувийн татвартай гэдэг хуулийг би санаачилж байсан. Энэ бол алслагдсан бүсийн хөнгөлөлт, алслагдсан бүсийн нэмэгдэл гэж. Ер нь Улаанбаатараас холдох тусмаа тэр алслагдсан аймгуудад амьдарч байгаа ард иргэдийн, аймагт, суманд амьдарч байгаа иргэдийн орлого нь багасаад байдаг, зардал нь нэмэгдээд байдаг. Бензин шатахуун нь өндөр үнэтэй, гурил будаа нь өндөр үнэтэй, хувцас хунар, даавуу, даалимба нь өндөр үнэтэй, тог цахилгаан нь өндөр үнэтэй. Ингээд үндсэндээ зардал нь өндөр болчихдог.

Нөгөө талдаа орлого нь бага, нөгөө зарж борлуулдаг мал мах нь хямдхан, арьс шир нь хямдхан, ноос, ноолуур нь хямдхан, тарьж ургуулж байгаа төмс, хүнсний ногоо нь хямдхан. Ингээд орлого нь бага, зардал нь өндөр болохоор орлогоосоо давсан зардал өндөртэй, байнга өрнөөс өр, зээлээс зээлийн хооронд амьдрахаар Улаанбаатар хот руугаа очиж амьдрах, орлого өндөртэй, зардал багатай амьдрахын тулд илүү төвлөрөөд, илүү шаваад, Улаанбаатар хотын

түгжрэл, төвлөрөл, энэ сургууль, цэцэрлэгийн хүртээмжгүй байдал гээд ийм сөрөг үр дагавартай учраас тэр төрсөн, өссөн нутагт нь аятай тухтай амьдрах боломжийг бий болгоё, орлогыг нь нэмэгдүүлэх, зардлыг нь бууруулах арга хэмжээ авъя гэж татварыг нь хөнгөлье гэсэн ийм хуулийг би санаачилж байсан.

Тэгээд орлогоосоо давсан зарлага бол асуудал болчихоод байгаа юм. Энийг бид шийдэх ёстой, бага орлоготой иргэддээ илүү анхаармаар байна. Орлогоосоо давсан зардалтай иргэддээ илүү анхаармаар байна. Гэтэл чинь өнөөдөр хэдэн тэрбумаар нь олдог орлоготой иргэдийн татварыг нэг болгох гээд байгаа чинь жоохон шударга бус байна гээд байгаа юм л даа. Тэгээд энийг л бид яаж шаталсан болгож болох уу гээд асуухад та хариулахгүй байгаад байна. Хэрвээ дэмжвэл шаталсан болгох боломжтой юу? Сангийн яамнаас энэ дээр хариулж өгөөч. Тэгээд шаталсан болгож, илүү олж байгаа нь илүү төлдөг байя л даа.

Сая Баярмаа гишүүн өөрөө хэллээ шүү дээ, тэр баян хүмүүс чинь шал өөр амьдарч байгаа юм гэж. Тэгээд үнэхээр тийм, баян хүмүүс чинь энэ нийгмээ чирч явдаг, ухамсартай, илүү татвар төлөхөд бэлэн, нийгмийн хариуцлагаа хүлээдэг улсууд. Тийм болохоор миний татварыг лав л энэ баян хүмүүс 1 хувь болгоод өгөөч гэж хүсэхгүй байгаа байх. "би илүү олж байгаа юм чинь илүү төлье, надад амьдрал хангалттай хүрчхэж байгаа юм чинь улс эх орондоо, ядарсан иргэддээ дэм тус больё, жоохон ч гэсэн татвар ахиу төлчихье" гэж бодож байгаа байх. Тэгэхэд нь тэдний өмнөөс яагаад тэр баян хүмүүсийн татварыг 1 хувь болгох гээд байгаа юм бэ, шаталж болох уу энийг? 4 дүгээр номер.

Ч.Чимидсүрэн: Тэгэхээр орлогын тэгш бус байдлыг бууруулахад хэрэглэгддэг гол механизм бол энэ шаталсан татварын систем. Тийм ч учраас бид 2022 онд энэ ХХОАТ цалин хөлснөөс тооцоход шаталсан татварын системийг бол оруулж ирсэн байгаа. Жилийн 120 сая хүртэл 10 хувь, 120 саяас 180 сая хүртэлх цалин хөлснөөс бол, 120-оос 180 саяынх нь хооронд 15 хувь, 180 саяас дээшхэд нь бол нэмэлт 20 хувийн татвар авах ийм тогтолцоог бол оруулж ирсэн. Энэ бол орлогын тэгш бус байдлыг бол илүү бууруулах, тийм шаталсан татварыг боловсронгуй болгох чиглэлээр хигдсэн арга хэмжээ байгаа.

Энэ удаа бид яг өнөөдрийн энэ цаг үед эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад бага, дунд орлоготой энэ иргэдийнхээ хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжье, татварын ачааллыг нь бууруулъя, орлогыг нь бол өөрт нь үлдээх ямар механизм байна вэ гэж үзээд, тэгээд өнөөдөртөө байгаа энэ 800 орчим буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх түвшний цалингаас төлөх ХХОАТ-ыг 100 хувиар бол хөнгөлье гэсэн энэ хувилбарыг бидний хувьд оруулаад ирүүлсэн байгаа. Ингэхээр энэ ЗГ-аас оруулсан нэг хувилбар, мөн гишүүдийн санаачилсан ХХОАТ-тай холбоотой бас нэг ийм тооцоолол бол буюу аргачлалууд ингээд гарч ирж байна. Тэгэхээр магадгүй цаашид ажлын хэсгийн түвшинд энийг дахин судлах, боловсруулах шаардлага гарч ирж болох байх.

С.Бямбацогт: Хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өргөн барих үед яг хөндсөн заалтыг нь л бид хөндөх ёстой, хөндөөгүй заалтыг хөндөх боломжгүй. Тэгээд энэ чинь нэг л заалт хөндсөн байгаад байдаг. Энийг бид ингээд задлаад, олон заалт болгоод, ингээд олон шатлалтай болгох боломж ЗГ-ын хууль болон Баярмаа нарын гишүүдийн санаачилсан хууль дээр ийм боломж бий юу? Энийг Тамгын газраас хариулж өгөх үү, эсхүл Сангийн яам хариулж өгөх юм уу? Манай Тамгын газрынхан арай өөр газар л явж байх шиг байна, тийм ээ, хариулт байна уу? Энийг хэдүүлээ

судалъя, тэгэх үү. Одоо хариулт бэлэн биш байх шиг байна, энийг судлаад маргааш өглөө танилцуулаарай. Ж.Баярмаа гишүүн хариуля.

Ж.Баярмаа: Тийм, болохгүй юм байхгүй л дээ, болохгүй юм байхгүй. Одоо ягаад энийг 1 хувь гээд байна гэвэл арга байхгүй энэ ажил хөдөлмөр эрхэлж байгаа 1 сая иргэн чинь 10 саяас доош цалин авч байгаа гээд энэ судалгаан дээр чинь байгаад байна л даа, энэ чинь дундаж анги. Дахиад хэлэхэд, тэр 792 мянган төгрөгөөс нь татваргүй болгоно гэдэг бол бага орлоготой гишүүдэд зориулсан, гишүүд гэнэ, иргэдэд зориулсан болчхоод байгаа байхгүй юу. Атал цаана чинь нөгөө дундаж давхарга, Монгол Улсын хөгжлийн гэлтгүй дэлхийн бүх улсуудын хөгжлийн түлхүүр, гол хүчин бол дундаж давхарга. Дундаж анги баян чинээлэг, жижигхэн хуримтлалтай байж байж тухайн улс хөгждөг атал Монгол Улс чинь хадгаламжийн бус өрний хуримтлалтай болчхоод байна. Үнэхээрийн нэг хэдэн нөхдүүд тэнд баяжих гээд ингээд байгаа бол болно, болно. Тийм баян хүмүүс энэ рүү хамрагдаад ингээд заль гаргаад, ингээд маниус чинь нэг хуулийн хулгай хийчих гээд байгаа бол тэр хүмүүсийг тэрнээс гаргаад, тэр шаталсан хэлбэр лүү оруулж болно.

Гагцхүү энэ дундаж иргэддээ л 1 хувийн энэ татварыг авч үлдье. Бусад тэр хэдэн саяас дээшийг нь мэдэхгүй, тэр хүмүүст нь шаталсан хувилбарыг оруулж болно, болно шүү. Тэгээд ажлын хэсэг байгуулаад, яг ажлын хэсгийнхээ үед бол 2 талаасаа ярилцаад, дахиж судалгаагаа нэгтгэхгүй бол ний нуугүй хэлэхэд энэ ЗГ-ын өгч байгаа, бид бол Сангийн яамнаас авч байгаа байхгүй юу. Сангийн яамны энэ мэдээлэл чинь асар зөрөөтэй юм шиг болж хувираад байна. Гэхдээ энэ бол тэгэх үндэс байхгүй л дээ. Та зүгээр бод л доо, 80 хувь нь өндөр орлоготой хүмүүс гэхийн эцэс байхгүй байхгүй юу Монгол Улсад. Сая хүний 80 хувь нь өндөр орлоготой гэхээр хэд юм, сарын 10 сая төгрөгөөс дээш цалин авдаг гэсэн үг болох уу. Тэгэхээр эд нарын өгсөн энэ юу бол буруу болчхоод байна, тийм зөрөөд байна. Тэгэхээр энэ бүгдийгээ бүгдээрээ нийлүүлээд, ажлын хэсэг дээрээ илүү сайн ярилцаад судалгаагаа нэг болгож байгаад, дундаж ангиа энэ 1 хувьд нь аварч үлдээгээд, тэгээд одоо тэр баячууд байгаад байгаа бол тэр хүмүүст нь жоохон татварынх нь тэр хувь хэмжээг нэмэгдүүлээд үлдээхэд бол буруу биш гэж бодож.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхийдөө хариулчихлаа даа. Тэгэхээр хуулийн боломж байгаа юу, тэгээд хөндсөн заалтыг л бид хөндөж ярих ёстой. Гэтэл ЗГ-ын өргөн барьсан хууль, Баярмаа гишүүний өргөн барьсан хууль дээр хөндөгдөөгүй заалт хөндөх юм уу? Саяын татварын олон шатлалтай болгоё, бага орлоготой иргэддээ татваргүй байя, дунд орлоготой иргэддээ бага татвартай байя, өндөр орлоготой иргэддээ арай жаахан ахиухан татвартай байя гэсэн ийм уян хатан зохицуулалтууд хийж болохоор байна уу, үгүй байна уу? Манай Тамгын газар судлаад өглөө танилцуулах уу, одоо хэлчих үү? Бямбадулам дарга Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга.

Ж.Бямбадулам: ЗГ-аас өргөн мэдүүлсэн татварын хуулиудтай нэгтгэж, хууль санаачлагч хэлэлцэхийг хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг дэмжсэний дараа дэмжигдвэл нэгтгэж хэлэлцэж болно гэж зөвшөөрвөл хөндөгдөх боломжтойгоо аль хөндөх. Нэгтгэж хэлэлцэх боломжгүй гэж хэрвээ хууль санаачлагч үзвэл нөгөө хөндөгдөөгүй зүйл, заалтыг хөндөж болохгүй гэдгээрээ Дэгийн тухай хуулийн 40.3.2-т "хуулийн төсөлд хөндөгдөөгүй зүйл, хэсэг, заалт, дэд заалтад өөрчлөлт оруулахыг хориглоно" гэсэн энэнийхээ дагуу бол боломжгүй байгаа. Тэгэхлээр хэрвээ нэгтгэж байгаа тохиолдолд бол болно.

С.Бямбацогт: Дахиад сайн судлаарай, саяын тийм олон шатлалтай болгох боломж энэ 2 хуулийг нэгтгээд хэлэлцэхэд олон шатлалтай болох боломж байна уу, үгүй юү гэдгийг өглөө нэг мэдээлээрэй. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаг гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Мэндбаярын Мандхай гишүүн үгээ хэлнэ үү. 1 дүгээр индэр дээрээс.

М.Мандхай: Би сая 2024 оны статистикийг бас харлаа. Ерөнхийдөө 2 сая хүртэлх орлоготой хүмүүсийн нийлээд 53 хувьтай байна. Тэгэхлээр ЗГ-аас өгч байгаа тоо бол нийт энэ ХХОАТ-ыг төлж байгаа 71 хувь нь нөгөө хөрөнгөтэй 13 хувь буюу бидний ярьдаг нөгөө 30 айл, түүнийг дагасан хамаарал бүхий этгээдүүд гэж ярих гээд байгаа нь бараг батлагдах гээд байгаа юм шиг тоо сонсогдоод байгаа юм. Статистик дээр бол Баярмаа гишүүний ярьж байгаа тэр 80 хэдэн хувь гэдэг тоо бол байхгүй байна. Тэгэхээр энэ тоонуудаа нэгд дахиад шалгах хэрэгтэй юм байна. Тэгэхгүй бол ингээд статистик дээр бас нэг таны яриад байгаа тоо чинь энэ номтой зөрж байна. Тэгэхээр энэ тоонуудаа шалгахгүй бол энд маш том маргаан үүснэ шүү.

Тэгэхээр энэ хамгийн гол нь миний зүгээр санаа зовоод байгаа юм нь саяын гишүүдийн ярьж байгаа асуудалтай бол санаа нэг байна. Энэ таны өгсөн материал дээр зардлын тооцоон дээр, файл дээр нь хонжвор сугалаа зэрэг мөрийтэй тоглоомыг, мөрийтэй тоглоом шиг зүйлийг гэж байгаа шүү би 40 хувь гэснийг 1 хувь болгож байгаа. Дээрээс нь олон байртай, мэдэхгүй ямар нэгэн аргаар орлого олсон олон байртай хүмүүс байгаа. Энэ олон байртай хүмүүсийн татварыг бууруулахаар бичсэн байна. Дээрээс нь энэ мэт анхааруулж байгаа асуудлыг чихсэн байхыг л би гайхаад байгаа байхгүй юу. Энэ цалин хөлсний татварыг бууруулахад бол огт эсэргүүцээгүй, энийгээ дэлгэрүүлээд ярьж гэж байна. Тэгэхээр энэ хүмүүсийн цалингийн татварыг бууруулж байгааг дэмжихгүй байна гэж ойлгож байгаа бол тийм юм байхгүй. Энэ дээрээ илүү тогтож ярьж гэсэн саналтай байна.

Тэгэхээр таны бичсэн маш олон заалтуудыг тусгаад өөрчлөхөөр оруулсан байгаа зүйл дээр би дахиад хэлье эд хөрөнгийн хонжворт сугалаа буюу мөрийтэй тоглоом шиг гэж би хэлсэн шүү. Тийм учраас та битгий мушгиж яриарай. Энэ дээр мушгиж яриад байх шаардлага бол байхгүй. Тэгээд таны ярьж байгаа материал дээр чинь үндэслэж бид дүн шинжилгээ хийж ярьж байгаа шүү. Зардлын тооцоо, хуулийн үзэл баримтлал, танилцуулга, энэ тооцоо, хүснэгтээ та өөрөө дахин нэг шалгачхаад, тэгээд энэ хуулийг илүү сайжруулж ажиллуулах ёстой юм байна гэдэг ийм саналтай байна.

С.Бямбацогт: Оюунсайханы Алтангэрэл гишүүн үг хэлье. Алга байна. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн үгээ хэлье. Алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалтыг яах юм бэ, санал хураалтыг маргааш өглөө үдээс өмнө болгоё. Орон нутгийн төсөв би сая хэлсэн шүү, нөгөө алслагдсан бүсэд бол амьдрал хэцүү байдаг гэж. Орлогоосоо давсан зардалтай хөдөө орон нутаг ер нь тийм шүү дээ.

22.21 цаг

Арван хоёр.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

**хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн
2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Дараагийн асуудалдаа оръё. ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүнээс 1925 оны 07 дугаар сарын 03-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

ХЗБХ-ны 2024 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 12 дугаар тогтоолоор ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Г.Уянгахишиг ахалж, бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүн О.Алтангэрэл, Б.Баярбаатар, Х.Баасанжаргал, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

ХЗБХ-ны 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

ХЗБХ-ны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд: Хуулийн төсөл дэх цахилгаан скүүтер, цахилгаан дугуй, хувь хүний бичил цахилгаан тээврийн хэрэгсэл гэсэн нэр томъёог хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх хүрээнд мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл гэж өөрчлөх,

2.мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийг 18 нас хүрсэн хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцохоор,

3.мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн эзэмшигч нь тээврийн хэрэгслээ Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын дагуу бүртгүүлдэг байхаар,

4.ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг ердийн журмаар дагаж мөрдөхөөр, мөн хуулийн этгээдийн даатгал болон Автотээврийн тухай хуульд заасан бүртгэлтэй

холбоотой журмыг хэрэгжүүлэх зохицуулалтыг 2026 оны 06-р сарын 30-ны өдрөөс дагаж мөрдөхөөр,

5.хуулийн төслийн 11¹ дүгээр зүйлийг нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилхан үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэхээр өөрчлөн найруулахаар,

6.ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол УИХ-ын тогтоолыг боловсруулж, тогтоолд хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, мопед, түүний төрөлд хамаарах скүүтер болон тэдгээртэй адилтгах тээврийн хэрэгслийг бүртгэлжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, холбогдох журмыг шинэчлэн батлах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх олон нийтийн мэдлэг, хэрэглээний соёлыг төлөвшүүлэх сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын ЗГ, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид даалгах зэрэг асуудлыг тусгасан болно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй тул Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.25 дахь хэсэгт заасны дагуу, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх "хууль санаачлагчид буцаах нь зүйтэй" гэж үзсэн болно.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Уянгахишиг гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-ын гишүүн Пүрэвийн Батчимэг нарын 9 гишүүн санаачилсан байгаа. Ажлын хэсэг Баатаржавын Эрхэмбаяр Улсын ерөнхий прокурор /УЕП/-ын туслах прокурор, Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга, Баатарсүрэнгийн Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Түвдэндоржийн Эрхэмбаатар ЗТЯ-ны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан шинжээч, Батцагааны Очирбат Тээврийн цагдаагийн албаны ЗЦГ-ын Зам тээврийн хяналт, төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн дарга, Анжимын Энхболд ЗТЯ-ны хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн.

УИХ-д хүндэтгэлтэй хандаж, гишүүдийн асуусан асуултад үнэн зөв, бодитой хариулт өгөх үүрэгтэй. Худлаа мэдээлэл өгөх, хүндэтгэлгүй хандвал хуулийн хариуцлага хүлээдгийг хууль сануулъя та бүхэндээ. УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн алга байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн алга

байна. Пүрэвийн Батчимэг гишүүн өөрөө санаачлаад, өөрөөсөө асуух юм уу, үгүй байх. Ганбатын Хосбаяр гишүүн алга байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн алга байна. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Оройн мэнд. Би яг нөгөө скүүтертэй холбоотой асуудал дээр яг хамгийн үр дүнтэй олон улсын ямар зохицуулалт байдаг юм бэ, тэрийг нэг жишээд, тэгээд манай дээр энийг нь яг ингэж хийх гээд байгаа юм гэдэг дээр иргэдэд нэг их сайхан ойлгомжтой болгоод өгөөч гэдэг нэг асуулт байна. Гол зохицуулалт нь.

Тэгээд ярьж байгаа тэр зохицуулалтынх нь бид шилжилт хийх нь байна шүү дээ. Тэрэн дээр, жишээлбэл, бидний одоо байгаа нөөц бололцоо хэр хангагдсан юм бэ, дэд бүтцийнх нь талаасаа, удирдлага хяналт талаасаа гэдэг асуудлууд байна.

3-д нь, ер нь энэ хувь компаниуд, үйлчилгээ хүргэж байгаа компаниудтайгаа, тэдний байр суурийг ер нь сонссон уу? Тэд нарын шийдэл нь юу байсан бэ, хэлэлцүүлгийн үед ер нь ямар саналууд гарч байсан бэ гэдэг ийм 3 асуулттай байсан юм, тэрийг асуучихъя?

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Хууль санаачлагч хариулах уу, ажлын хэсэг хариулах уу? Ажлын хэсэг хариулчихъя. Уянгахишиг гишүүн хариулах юм уу? Ажлын хэсэг Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Нарийн мэдээллүүдийг ажлын хэсгээс нэмж хариулна. Тэгэхээр 1 дүгээрт, энэ скүүтертэй холбоотой, энэ цахилгаан скүүтертэй холбоотой асуудал бол мэдээж бүх улс орнуудад шинэлэг зохицуулалтууд гарч ирж байгаа, маш их хэрэглэгдэж байгаа түгээмэл. Үүнээс бол зарим улсын хувьд бүрмөсөн хаасан зохицуулалт байгаа. Жишээлбэл, Францын Парис хотноо бүрэн хаачихсан буюу яг энэ мопед, скүүтер явахад тэр замын аюулгүй байдал талаасаа боломжгүй гэдэг ийм дүгнэлтүүд гарч байгаа, гарах тохиолдлууд байгаа. Жишээлбэл яг Монголд гэхэд явган хүний замаар явж байгаа буюу явган зорчигчдод гэмтэл учруулах энэ тохиолдлууд олон байгаад байдаг.

Гэтэл яг авто зам дээр явъя гэхэд тэнчээ аюулгүй байдал хангагдсан уу, үгүй юү гэдэг асуудал гардаг гээд яг энэнтэй адилхан асуудлууд бол бүх улс оронд гарч байгаа. Тэгээд ер нь бол олон улсынхаа жишгээр дугуйн замаар болон тусгай зориулалтын яг зориулагдсан замаар явдаг ийм зохицуулалттай байгаад байгаа юм. Тэгэхээр энэ талаар улс улсынх нь туршлагаадаас ажлын хэсгээс, дэмжих багаас тайлбарыг нь нэмээд өгөх байх. Тэгээд яг энэ үйлчилгээ үзүүлж байгаа буюу энэ түрээслүүлж байгаа компаниудын төлөөлөл бол ажлын хэсэгт орж ажилласан. Тэдгээртэй бол энэ хууль санаачлагчаас өргөн барьсан төсөл болон яг энэ зарчмын зөрүүтэй саналуудыг боловсруулахад, ажлын хэсэг хуралдахад бол ААН-ийн төлөөллүүд бол бүрэн яг хамрагдаж оролцсон, хурал болгон дээр ирж оролцсон байгаа. Хоёр дахь асуулт нь юу байлаа? Нэмээд тодруулга өгье.

С.Бямбацогт: Нэмээд хариулъя, ажлын хэсэг тодорхой хариулт өгчихье. Ажлын хэсэг, 4 дүгээр микрофон.

Б.Очирбат: Гишүүний асуултад хариулъя. Олон улсад энэ төрлийн тээврийн хэрэгсэл ер нь 2017 оноос эхлээд гадаадын зарим оронд бол нэвтэрсэн байдаг.

Тэгээд Нидерланд 2018 онд энэ төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бол бүрэн хориглосон байгаа. Ирланд, Грек, Франц, Канад, Индонез зэрэг улсуудад замын хөдөлгөөнд оролцуулахыг мөн хориглосон шийдвэр гаргасан ийм байгаа. БНХАУ Шанхай, Бээжин зэрэг хотууддаа замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглосон бол ОХУ Москва, Санкт-Петербург зэрэг томоохон хотууддаа явган зорчигчийн хөдөлгөөн ихтэй зарим гудамжнууддаа хөдөлгөөнийг хориглосон ийм зохицуулалтыг бол гаргасан байгаа. Япон улсад улсын дугаар авч бүртгэлжүүлж, авто зам ашигласны төлбөрийг урьдчилсан төлсөн байх шаардлагыг тавьдаг.

Тухайн шаардлагуудыг биелүүлээгүй тохиолдолд 50 мянган иен буюу 450 долларын торгууль оногдуулдаг, эсхүл 3 сарын хугацаанд хорих ял оногдуулдаг. Англид зөвхөн түрээсийн болон 18 нас хүрсэн, тусгай сургалтад сууж төгссөн иргэд унахыг зөвшөөрдөг, хувийнх бол хурааж авдаг ийм зохицуулалт байна. БНТУ-д түрээсийн үйлчилгээг 2019 онд нэвтэрсэн, 2020 оны эцсээр одоо нэлээдгүй асуудал үүсэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд явган хүн зорчих боломжгүй ийм байсан учраас одоо тухайн улсын Тээврийн дэд бүтцийн яамнаас нь түрээсийн скүүтерт зориулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх ийм зохицуулалтыг хийгээд тусгай эрхлэх зөвшөөрөл олгох, мөн эрх авах байгууллагын хөрөнгийн доод хэмжээг нь тогтоож, үйлчилгээнд ажиллах скүүтерүүдийн хязгаарыг тухайлбал 250 гэж тогтоож өгсөн. Торгууль, төлбөр төлөх электрон системд бүртгэгдсэн байх техникийн шаардлага бүхий стандартуудыг нэвтрүүлж, түүнд нийцсэн байхыг шаардах ийм асуудлуудыг тусгасан ийм олон улсын жишгүүд байна.

С.Бямбацогт: Хариулт хангалттай юу? Тодруулъя Саранчулуун гишүүн. Энэ нэмээд хариулаарай. Саранчулуун гишүүн асууя.

О.Саранчулуун: Уучлаарай, энэ нөгөө явган зам болон энэ дэд бүтцийн асуудал бол үнэхээр хүртээмжтэй шууд холбоотой учраас би энэ дээр яг зорьж ингэж тодруулаад байгаа юм л даа. Тэгэхээр одоо жишээлбэл, энэ хуулийн төслийн 12.4.1 дээр "зорчих хэсгийн баруун гар талын зах буюу хөвөөгөөр нийтийн тээврийн эгнээгээр", 12.4.2 дээр "явган хүний замаар хурдыг цагт 10 километр хэтрүүлэхгүй явах ба зорчигчид саад, аюул учруулахгүйгээр зорчино" гэж байгаа юм. Гол нь би нөгөө асуугаад байгаа нь ингэж зорчих тэр нөгөө нөөц бололцоо байсан уу? Ер нь бид энэ анх скүүтерийг оруулж ирж зөвшөөрөхдөө Монголд ингээд л хэрэглээд эхэлчихлээ шүү дээ. Ингэхдээ ер нь нөөцөө тооцдог юм уу, үгүй юм уу? Бид чинь нөгөө автомашин ярихдаа багтаамж, замын ачааллыг ярьдаг шүү дээ. Тэгэхээр яг энэ скүүтер, унадаг дугуй дээр ер нь ийм замын ачааллын тооцоолол гаргасан юм байдаг уу?

С.Бямбацогт: Маш чухал асуулт асуугаад байгаа. Бид мэдэх, хариулах ёстой. Ажлын хэсэг, 4 дүгээр микрофон.

А.Энхболд: ЗТЯ-ны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэргэжилтэн Энхболд. Замын хөдөлгөөний аюулгүй байдал гэдэг бол хүн, тээврийн хэрэгсэл, зам, орчин гэсэн 4 элементийн аюулгүй байдлын цогц гэдгийг энэ дэлхийн эрдэмтэд 1949 оноос эхлээд тогтоочихсон юм. Тэгээд ер нь бол хүний сүүлийн үед дэд бүтэц, тээврийн хэрэгсэл гэдэг маань өөрөө хүний алдааг хүлцэх хэмжээний инженерийн шийдэл хийсэн онцлогтой байх ёстой гэдэг юмыг хэлчихсэн. Монгол Улсын хувьд унадаг дугуйн стандарт, явган хүний стандарт энэ тэр гэдэг бол бүгдээрээ байж байгаа. Энэ бол бүгдээрээ стандартаар тооцоолохдоо нэг хүний эзлэхүүн нь ямар байх юм, дугуйн, явган зорчигч ингээд явахдаа нөгөө 2 сугадаж явж байгаа 2 хүн

зөрж өнгөрөх, дугуйн стандарт нь бол яг 2 дугуй зөрж өнгөрөхдөө нэг дугуйны эзлэх хэмжээ нь бол 1 метр, тэгээд нөгөө аюулгүй.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа дуусгая.

А.Энхболд: Гэх мэтээр ийм хэмжээнүүдийг бол заасан байдаг. Тэр хэмжээ нь харамсалтай нь бол одоо хэрэгжихгүй нэг ийм асуудалтай байж байгаа. Тэгэхлээр энэ хэмжээгээ хэрэгжүүлэх шаардлагатай.

2 дугаарт нь бол одоо яадаг вэ гэхлээр энэ стандартын шаардлагад тавигдсан зам гэдэг ихээхэн чухал. Тухайлбал, одоо хэрэглэгдэж байгаа явган хүний замын 90 хувь нь шаардлага хангахгүй, унадаг дугуй явахад шаардлага хангахгүй. 2 дугаарт нь унадаг дугуйн замын 70 хувь нь бол шаардлага хангахгүй гэсэн ийм дүгнэлт гарсан байдаг. Тэгэхлээр одоо энэ унадаг дугуй, скүүтер явган хүний зам явахад бол энэ дэд бүтцийг бий болгож өгөх нь бол хамгийн чухал байна л гэж хэлэх гээд байна.

С.Бямбацогт: Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Баярлалаа. Тэгвэл одоо стандарт болон нөхцөл бүрдээгүй байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ хууль дээр жишээлбэл, шилжилтийн төлөвлөгөө гэдэг юм уу 1 дүгээрт энэ тусгагдсан уу? 2-т гэвэл Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөө байгаа. Одоо дэд бүтэцтэй холбоотой нэлээн зузаан төлөвлөгөө байсан шүү дээ, ЗГ-ын төлөвлөгөө. Тэрэнтэй тэрэнд тусгагдсан заалттай шууд уялдсан хэсэг энэ хууль дээр хаана нь байгаа вэ? Би өгчихсөн төсөл дээрээс холбож харахгүй байгаа учраас тодруулж байгаа шүү.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя, Уянгахишиг гишүүн хариулъя.

Г.Уянгахишиг: Түрүүн Саранчулуун гишүүний асуусан яг саяын заалт бол нөгөө зарчмын зөрүүтэй саналаар өөрчлөгдөж орж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол яг явган хүний замаар явахгүйгээр мопед, түүнтэй адилтгах, түүний төрөлд хамаарах гэж ангилалд ороод, үүгээрээ бол яг унадаг дугуйн замаар, хэрвээ унадаг дугуйн зам байхгүй, унадаг дугуйн эгнээ, унадаг дугуйн зам гэдэг 2-ыг Замын хөдөлгөөний дүрэмд заасан байгаа. Яг тэр зохицуулалтаар буюу Замын хөдөлгөөний дүрмийн 25.4, 25.5-аар зохицуулагдаж явахаар орсон байгаад байгаа юм.

Яг үүнтэй холбоотойгоор өнөөдөр энэ хуулийг хэрэгжүүлээд явахад маш төвөгтэй, төвөгшилтэй байдал бий болж байгаа. Энэ утгаараа бол Монгол УИХ-ын тогтоолын төслийг бол хамт оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ тогтоолын төслөөр бол ЗГ-т болон нийслэл, Нийслэлийн Засаг дарга болон Улаанбаатар хотын захирагчид үүрэг өгөөд, яг энэ замын стандартыг хангуулах, унадаг дугуйн зам, унадаг дугуйн эгнээний стандартыг хангуулах гэдэг үүргийг.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Уянгахишиг гишүүний микрофон.

Г.Уянгахишиг: Одоо болчихсон.

С.Бямбацогт: Сая дутуу л. Би зүгээр тодруулаад асуучихъя. Сая асуулт, хариултаас ойлгоход, 10 километр цагаас бага хурдтай бол мопед, скүүтертэй явган

хүний зам дээгүүр, хэрвээ унадаг дугуйн зам байхгүй бол явж болно гэж ойлголоо. Энэ зөв үү? Унадаг дугуйн замтай бол унадаг дугуйн зам дээгүүр скүүтер, суронтайгаа явж болох юм байна. 10 километр цагаас дээш явахаар бол авто зам дээгүүр зорчих юм байна. Хариулъя, Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Саяын нөгөө тайлбарласнаар, зарчмын зөрүүтэй саналаар энэ заалт хүчингүй болоод, энэ нь өөрөө "мопедтой адилтгах" гэдгээр буюу Замын хөдөлгөөний дүрэм рүү орчихсон гэсэн үг. Тэгэхээр Замын хөдөлгөөний дүрмийн зохицуулалтаар явна гэдэг маань, хэрэв унадаг дугуйн зам, эгнээ байхгүй бол замын баруун хөвөөгөөр зорчих, хэрэв баруун захаар явахад хүндрэлтэй бол явган хүний замаар бууж явгалан, явган зорчигчийн үүргээр хөдөлгөөнд оролцоно гэдэг ийм зохицуулалттай гэсэн үг. Тэгэхээр одоо 10 километр цаг байна уу, 5 километр цаг байна уу явган хүний замаар унаж болохгүй гэсэн үг. Явган хүний замаар явах нь хориглоотой, хориглосон буюу Зөрчлийн хуулиараа торгууль төлнө.

С.Бямбацогт: Мопед, суррон (Sur-Ron) бүгдээрээ адилхан уу?

Г.Уянгахишиг: Суррон чинь бол мотоциклтой адилхан зохицуулагддаг, угаасаа А ангилалтай.

С.Бямбацогт: Скүүтер?

Г.Уянгахишиг: Скүүтер тийм, 50 километр цаг хүртэл хурдалдаг.../үг тасрав/

С.Бямбацогт: Хэдэн наснаас дээш унаж болохоор зохицуулалт байгаа вэ?

Г.Уянгахишиг: 18 наснаас дээш.

С.Бямбацогт: 18 наснаас доош хүүхэд бол үндсэндээ 15, 16-тай скүүтер унаж болохгүй, суррон унаж болохгүй, мопед бүр болохгүй, тийм үү?

Г.Уянгахишиг: Тийм гэсэн үг. Зөвхөн унадаг дугуй л унаж болно гэсэн үг. Тэгээд яг үүнтэй холбоотойгоор бас нэг гол оруулсан заалт бол 18-аас доош насны хүүхэд хэрвээ энэ мопед, скүүтер унавал эцэг эх, асран хамгаалагчийг 200 мянган төгрөгөөр торгох ийм зөрчлийн зохицуулалт нэмж оруулж ирж байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос санал хураалтад бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Нам, эвслийн бүлэгт харьяалагддаг гишүүд үг хэлнэ. Зарчмын зөрүүтэй саналуудыг маргааш санал хураалт явуулъя, санал хураалтыг хойшлууллаа.

22.41 цаг

Арван гурав.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. БНМАУ-ын ЗГ-т эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны

танилцуулгыг УИХ-ын гишүүн Шинэбаярын Бямбасүрэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ш.Бямбасүрэн: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын гишүүн С.Цэнгүүнээс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн БНМАУ-ын ЗГ-т эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг УИХ 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаараа явуулж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед УИХ-ын гишүүдээс асуулт, хариулт гараагүй бөгөөд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, БНМАУ-ын ЗГ-т эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

С.Бямбацогт: Бямбасүрэн гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Энхжаргалын Сундуй “Төв тусгал” сургалт, судалгааны төвийн судлаач, Жанчивсэнгээгийн Дамбаасүрэн Өмгөөллийн Гранд лекс партнерс компанийн өмгөөлөгч. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцууллаа.

УИХ-ын гишүүд, Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Батын Батбаатар гишүүн алга байна. Даваагийн Цогтбаатар гишүүн алга байна. Отгоншарын Батнайрамдал гишүүн алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн алга байна. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

БНМАУ-ын ЗГ-т эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

22.44 цаг

Арван дөрөв. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалдаа оръё. ЗГ-т чиглэл өгөх тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, танилцуулах гишүүн нь ирж байна уу? Мөнхсоёл гишүүн. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт. Таныг индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Б.Мөнхсоёлоор ахлуулж, УИХ-ын гишүүн Н.Алтаншагай, С.Ганбаатар, С.Замира, Ж.Золжаргал, Т.Мөнхсайхан, С.Одонтуяа, А.Ундраа, Б.Уянга нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Ажлын хэсэг холбогдох яамд, орон нутгийн хог хаягдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хог хаягдлын менежментийн ААН, ТББ болон мэргэжлийн холбоод хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн төлөөлөлтэй 2 удаагийн уулзалт, 4 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн хүрээнд нийт 43 байгууллагын төлөөлөл, 400 гаруй иргэн, ААНБ, төрийн болон ТББ-ын холбогдох мэргэжилтнүүд оролцож, хог хаягдлын менежментийг сайжруулахтай холбоотой 175 санал гарсныг хүлээн авч, нэгтгэн боловсруулсан бөгөөд ЗГХЭГ, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Сангийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам.../үг тасрав/

С.Бямбацогт: Микрофон яав?

Б.Мөнхсоёл: НЗДТГ, 21 аймгийн Засаг дарга нараас Хог хаягдлын хуулийн хэрэгжилтийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг авч ажилласан байна. Ажлын хэсгийн зүгээс хог хаягдлын менежментийн өнөөгийн нөхцөл байдал, хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн хог хаягдлын салбарт тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрлэлийг хөгжүүлснээр хог булшлах асуудлаас нөөц болгон ашиглах тогтолцоонд шилжих суурь тавигдана гэж үзэн ЗГ-т чиглэл өгөх тухай УИХ-ын тогтоолын төсөл боловсруулсан.

БОХХАА-н байнгын хороо Монгол УИХ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6-д заасны дагуу, 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийг хэлэлцлээ. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Засгийн газарт чиглэл өгөх тухай” УИХ-ын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж, хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, ЗГ-т чиглэл өгөх тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Энэ аюултай хог хаягдлын тооллого хийх, бүртгэл хяналтын нэгдсэн тогтолцоо бий болгох, эрсдэлд өртөх хүн амын судалгаа шинжилгээ хийх, жагсаалтыг шинэчилж уул уурхайн болон эмнэлгийн аюултай хог хаягдлыг тусгайлан зохицуулах асуудлыг судалж шийдвэрлэх гээд энэ маш том тулгамдсан асуудлаар шийдэх шийдэлгүй л байгаа юм байна даа. Уг нь тодорхой чиглэл өгөөд шийдээд ороод ирсэн бол, хар тугалганаас авхуулаад олон асуудлууд байгаа шүү дээ. Скүүтерийн батарей, тэгээд янз янзын одоо аккумуляторууд. Энэ дээр уул нь жоохон шийдлээ оруулж ирсэн бол их зүгээр байж. Асуух юм уу? Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Миний асуултад хэрвээ яг одоо хариулах боломжгүй бол дараа нь бичгээр өгөөрэй гэж хүсэх гээд байна. Юу вэ гэвэл би Булган аймгийн төв дээр байгаа аюултай хог хаягдлыг хэлэх гээд байна. Маш олон жил болж байгаа, 2018, 2019 оны үед НҮБ-аас хэрэгжүүлсэн нэг төслийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа нийт хамгийн аюултай хог хаягдал бүхий 10 цэгийн судалгааг гаргасан байдаг юм. Тэр 10 цэгийн нэг нь яг Булган аймгийн төв дотор байдаг. Өөрөөр хэлбэл, мал эмнэлгийн одоогийн хашаа нь гэсэн үг. Тэнд дээр үед, хуучны үед мал эмнэлгийн хэрэглэж байсан аюултай хог хаягдлаа хөрсөн доор булчихсан, одоо бороо орохоор хөрснөөс нь үнэр ялгардаг, хөрс нь цайрдаг. Булган аймгийн мал эмнэлэгт ажиллаж байгаа хүмүүс дандаа хорт хавдартай, хорт хавдраар өвчилдөг, хэд хэдэн хүмүүс нь хүнд өвчинтэй ийм байдалтай байдаг.

Дээрээс нь энэ нь өөрөө яг аймгийн төв дотор байдаг. Ийм дүгнэлт гарсаар байсныг нь мэдсээр атал яг урд талд нь шинээр бас дахиад цэцэрлэг барьчихсан, энэ орчин дээр. Баруун талд нь 10 жилийн сургууль байгаа. Тэгэхээр бид яг энэ аюултай хог хаягдлыг, жишээ нь, энэ Булган аймгийн энэ аюултай хог хаягдлыг хэзээ, яаж цэвэрлэж, энэ аймгийн төвөөс холдуулах вэ, энийг хэн хариуцах вэ гэдэг асуултынхаа хариултыг чадвал одоо, одоо чадамгүй бол заавал бичгээр би авмаар байна гэсэн нэг ийм асуулт байна.

С.Бямбацогт: Байгаль орчны яам, ажлын хэсэг, 4.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батбаяр. Гишүүний асуултад хариульъя. Булган аймгийн аюултай хог хаягдлын цэгийг саармагжуулах ажлыг ОУБ-ын төслийн хүрээнд өмнө нь нэг хийж байсан, одоо бол аймгуудын төвүүд дээр байгуулагдаж байгаа аюултай хог хаягдлыг төвлөрүүлэх цэгүүдийн төслийн ажил яг хэрэгжиж байгаа. Үүний дараа цэг баригдсаны дараа тэр тухайн аюултай хог хаягдал булсан, ландфилл хийсэн газрыг дахиж аюултай хог хаягдлын төв цэг рүү нүүлгэх ажил явагдана. Одоогоор бол аюултай хог хаягдлыг төвлөрүүлэх цэг маань ашиглалтад хараахан ороогүй байгаа. Багц тендерээр явагдсан ажил байгаа. Тэгээд аймгуудаараа дүгнэгдээд, 3 аймагтай цуг байгаа, тэгээд тэрнээсээ шалтгаалж байгаа. Ойрын хугацаанд, ирэх жил бол ашиглалтад орно гэж төсөвлөж байгаа юм, төлөвлөж байгаа. 15 аймгийн төв дээр аюултай хог хаягдлыг төвлөрүүлэх цэгийн ажил явагдаж байгаа, тэр тоонд бол орчихсон явж байгаа.

С.Бямбацогт: Энэ аюултай хог хаягдлын асуудал үнэхээр манай ЗГ, Байгаль орчны онцгой анхаарах асуудал шүү. Ялангуяа бид чинь ингээд айл болгон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хэрэглэдэг болчихсон, тэр айл болгон батарейтай болчихсон, айл болгон машин унадаг болчихсон, унаж байгаа машиных нь ихэнх нь хар тугалгатай батарейтай болчихсон, эднийг тэгээд л жалгын нэг, тэгээд л энд тэндгүй хаяж байдаг, тэр нь эргээд маш байгаль орчинд сөрөг нөлөөтэй байж байгаа. Энийгээ нэг анхааралдаа авч, тодорхой бодлого оруулах ёстой байх. Энийг эцэслэн батлахдаа Байнгын хорооны тогтоол дээр найруулгын хувьд оруулах, агуулгын хувьд оруулах боломж байна уу? Ажлын хэсэг нэг анхаарчхаарай, Мөнхсоёл гишүүнээ. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Дахин боловсруулах, Мөнхсоёл гишүүн хариульъя. Ажлын хэсэг, Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Хог хаягдлын асуудал бол өөрөө ер нь маш их ийм гүнзгийрсэн, олон хүчин зүйлээс хамаарсан, босоо хэвтээ тэнхлэгтэй, маш олон ийм шийдэгдээгүй асуудлуудтай ийм цаг алдсан асуудал юм билээ. Ямар ч байсан 10

сарын 08-нд байгуулагдсанаас хойш нэлээн олон асуудлуудыг ухаж гаргаж ирсэн. Тэгээд хуумгай шууд нэмэлт, өөрчлөлт оруулахаасаа илүү хяналт, шалгалт хийсний үр дүнд ямар ч байсан санал, дүгнэлтээ боловсруулахдаа тогтоолын төслийг ийнхүү боловсруулж ирсэн. Боловсруулсан энэ тогтоол дотор маш олон асуудлуудыг оруулчихсан байгаа. Яагаад вэ гэхээр, бид нийслэлийг, орон нутгийн сум, дүүрэг, аймгийн хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, албан хаагчид, тэгээд холбогдох иргэний нийгмийн байгууллага, ААН, бусад бүх хүмүүсийг оролцуулсан хэлэлцүүлэг дээр нэгдсэн зөвшилцөлд хүрэхэд хүндрэлтэй, ужгирчихсан асуудлууд их байсан. Тэр учраас тогтоолын бүр 13 чиглэлийн ийм үүрэг өгч байна ЗГ-т. Маш их цаг алдсан асуудлыг бид харин хурдавчлуулах ийм шийдвэрт хүрсэн.

Аюултай хог хаягдлын асуудал 11-д орсон байгаа. Аюултай хог хаягдлын тооллого хийх, бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгох, эрсдэлд өртөх хүн амын судалгаа, шинжилгээ хийх, жагсаалтыг шинэчлэх, уул уурхайн болон эмнэлгийн аюултай хог хаягдлыг тусгайлан зохицуулах асуудлыг судалж шийдвэрлэх гээд. Аюултай хог хаягдлаас илүү энгийн, 3.1 дүгээр ангилал байгаа шүү дээ, энгийн хатуу хог хаягдал чинь өөрөө бүр маш асуудалтай. Хог хаягдлын нийт 97 хувь нь газар булшлагдаж байна, гуравхан хувь нь дахин боловсруулагдаж байна. Гэтэл зөвхөн Дани улстай харьцуулахад, мэдээж өндөр хөгжилтэй улс, 97 хувиа боловсруулж байна, гуравхан хувиа булшилж байна. Ийм нөхцөлд Монгол байна, дэндүү удаан энэ асуудлыг хайхраагүй явсан байна. Түрүүчийн 4 жилийн парламентын үед "шийднэ" гэхээд огт шийдээгүй. Тэгэхээр энэ удаа бол бид зайлшгүй шийдэх ёстой. Нэмэлт, өөрчлөлт гаргаж байгаад цаг хугацаа алдаж байснаас засаг ажлаа хий гээд чиглэл өгч байгаа.

Тэгэхээр ийм учраас энэ тогтоолын шийдвэрийг яаралтай боловсруулж, богино хугацаанд маш олон талыг оролцуулж ажилласан, бүгд бие бие рүүгээ асуудлаа чихдэг ийм байдалд хүрсэн байна лээ шүү. Одоо аюултай байтугай аюулгүй, энгийн хог хаягдалдаа дарагдаж, агаарын, хөрсний, усны бохирдолд автаж байна. Тэгээд сенсацаар амьдардаг улс төрчидтэй, сонгууль болохоор хог хаягдлыг хайхардаг, сонгууль дуусахаар мартдаг. Тэгэхээр энэ асуудлыг зайлшгүй яаралтай шийдэж оруулж ир. Хавар биш юм гэхэд намрын чуулганд энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулаад зохих горимд нь оруулах ёстой, тэгээд уялдаа холбоог хангах ёстой гэж байгаа юм. Энэ олон чиглэлд орчихсон байгаа. Нэг бол яам руугаа чихээд, нэг бол нийслэл рүүгээ чихээд, нэг бол орон нутаг руугаа чихдэг энэ байдлыг халъя гэж байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалтыг маргааш явуулна.

22.57 цаг

Арван тав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалдаа оръё. Засгийн газарт чиглэл өгөх тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Х.Баасанжаргал: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, бүгдэд нь оройн мэнд хүргэе. УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгагдсан хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа талаар мэдээлэл сонсох арга хэмжээний хүрээнд Өргөдлийн байнгын хороо 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаараа ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсролын яам, ХХААХҮЯ, ЭМЯ, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээлэл сонссон.

Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 05-р сарын 05-ны өдрийн хуралдаанаар ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах хүрээнд суралцагчдад чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх, хооллох зөв дадал төлөвшүүлэх, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 01 дүгээр тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал ахалж, гишүүдээр УИХ-ын гишүүн Ганмаа, Мөнхтуяа, Саранчулуун, Сарнай, Ундррам нар ажилласан болно.

Ажлын хэсэг Боловсролын яам, ХХААХҮЯ, ЭМЯ, Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудаас шаардлагатай тайлбар, мэдээллийг авч гаргасан судалгаатай нь танилцсан бөгөөд ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг хэлэлцэж, Засгийн газарт чиглэл өгөх тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулсан.

Өргөдлийн байнгын хороо 2026 оны 05-р сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгагдсан ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн биелэлтийн үр дагаварт Боловсролын яам болон Монголын Хуульчдын холбооны хийсэн үнэлгээний тайлан, дээрх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг, мөн УИХ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.10 дахь хэсгийг тус тус үндэслэн боловсруулсан Засгийн газарт чиглэл өгөх тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцлээ.

ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг хэлэлцэхэд уг хуулийн хэрэгжилт 34.6 хувьтай гарсан. Түүнчлэн уг тайланд бүх сургуульд мэргэжлийн хоол зүйчийг үе шаттайгаар ажиллуулах, тасралтгүй сургалт, мэргэжлийн үнэлгээ, давтан сургалтын тогтолцоог тогтвортой санхүүжилттэйгээр хэрэгжүүлэх, хүүхдийн зөв хооллолтын дадал, эрүүл мэнд, хүнсний боловсрол, үндэсний хоолны соёлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалтын агуулгыг боловсронгуй болгох, суралцагчид ногдох хоолны зардлын нормативыг инфляц, хүнсний бүтээгдэхүүний өөрчлөлт, шим тэжээлийг шинжлэх ухааны үндэслэлтэй уялдуулан жил бүр шинэчлэх, норматив зардлыг хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардал, хүний нөөцийн цалин урамшуулал, тоног төхөөрөмжийн шинэчлэл, тээвэр, логистик, хадгалалт, хүнсний аюулгүй байдлын хяналт зэрэг цогц бүтэцтэй болгох, ханган нийлүүлэлтийг өрсөлдөөнтэй, ил тод болгож, орон нутгийн үйлдвэрлэгчид болон жижиг, дунд нийлүүлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, эцэг эх, суралцагчдын хяналтын оролцоог тогтмол системтэй хэлбэрт

оруулах, ундны усны хүртээмжийг нэмэгдүүлэх, аяга таваг угаагч, ариутгагч автомат төхөөрөмжийг өргөжүүлэн нийлүүлэх, мөн дунд, ахлах ангийн сурагчдыг үдийн хоол хөтөлбөрт үе шаттай хамруулах шаардлагатай талаар дурджээ.

Тус хуралдаанд УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Ганмаа Монгол Улсад хүүхдийг хамгийн их өвчлөлд хүргэж байгаа хоол тэжээл дэх зохисгүй харьцааны талаар судалгаа танилцуулсан бөгөөд тус судалгаагаар Монгол хүүхдүүдийн 80 гаруй хувь нь Д витамин дутагдалтай байгаа бөгөөд 28 хоногийн турш Д витаминаар баяжуулсан сүүг хүүхдэд өдөр бүр өгөхөд эрэгтэй хүүхдийн өндөр дунджаар 1 сантиметрээр, эмэгтэй хүүхдүүдийн өндөр дунджаар 1.1 сантиметрээр нэмэгдсэн бөгөөд хүүхдийн жинд өөрчлөлт ороогүй талаар, мөн Д витамин дутагдахад үүсэх үр дагаврын талаар танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанд Засгийн газарт чиглэл өгөх тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэх үеэр УИХ-ын гишүүн Рэгдэл Ажлын хэсэг богино хугацаанд сайн ажиллаж, тодорхой шийдвэрийн төсөл танилцуулж байгаад талархалтай байгаагаар илэрхийлээд, тогтоолын төслийн заалтууд болон хавсралттай холбогдуулан ажлын хэсгээс асуулт асууж, хариулт авсан болно. Мөн Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл тогтоолын төслийг шалгуур үзүүлэлттгүй батлах талаар санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

УИХ-ын гишүүн О.Саранчулуун хүүхдүүдэд Монгол хүний бие анатомийн онцлогт тохирсон хооллолтын дадал, зуршил, соёлыг төлөвшүүлэх шаардлагатай бөгөөд сургуулиуд түүнд нь дэмжлэг үзүүлэх үүрэгтэй, буруу хооллолтоос шалтгаалан хүүхдийн эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаарх судалгааг хийх талаар байр сууриа илэрхийлж үг хэллээ.

Засгийн газарт чиглэл өгөх тухай УИХ-ын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах, хүүхдэд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан шим тэжээллэг хоол хүнсээр үйлчилж, хүүхдийн боловсрол, эрүүл мэндийг дэмжигч чиглэлээр Засгийн газарт чиглэл өгөх тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Баасанжаргал гишүүнд баярлалаа. Засгийн газарт чиглэл өгөх тухай УИХ-ын тогтоолын төслийн ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя. Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөр-Уяагийн Жамбалцэрэн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Намжилын Эрдэнэбаяр ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Ядамсүрэнгийн Эрдэнэсайхан ЖДҮ-ийн газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Баясгалангийн Батшагай ХХААХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Төмөрбатын Түмэнжаргал Боловсролын яамны Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга. Ажлын хэсэгт хүрэлцэн ирсэнд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд нэрсээ өгнө үү? Мэндбаярын Мандхай гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үгээ хэлнэ үү.

А.Ариунзаяа: Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль 2019 онд батлагдаад, тэгээд 2020 оноос хойш хэрэгжиж байгаа. Тэгээд тухайн үедээ бөөн л юм болж уг нь баталж байсан. Тэгээд миний санахын Мөнх-Оргил гишүүн ахлаад ажилласан шиг санах юм. 1-ээс 5 дугаар ангид хүүхдүүд үдийн хоол харьцангуй тэгээд байгаа нөхцөл байдалтай нийцээд авч байгаа. 2022 онд уг нь хуулиараа 6-аас 12 дугаар ангийн хүүхдүүдийг үдийн хоолонд хамруулна гэж тухайн үедээ хууль нь батлагдаж байсан, тэгээд ерөөсөө огт хэрэгжилтгүй.

Тэгээд үнэхээр хүүхдүүдээ яг 1 дүгээрт тавьж чадаж байна уу, үгүй юү гэдэг энэ асуудал 19 онд батлагдсан хуулийн хэрэгжилтээс харагдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр үнэхээр харамсалтай байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд, 1 дүгээрт төсөв, санхүүгээс нь гадна ер нь чөдөр тушаа болсон зарим заалтуудаа ч гэсэн шуурхай оруулаад явчихмаар байгаа байхгүй юу. Тэгээд заавал ингээд олон юм хүсээд байхгүй, зүгээр үнэхээрийн гал тогоонд нь ажиллах мэргэжлийн хүмүүс нь тогтохгүй байгаа бол тэр "багш" гэдгийнхээ ард талд нь "ажилтан" гэдэг үг л нэмэх хэрэгтэй юм байна лээ шүү дээ уг нь бол яг одоо энэ хоол үйлдвэрлэл дээрээ. Тэгээд тэднийгээ бас орхигдуулчихсан, хүн тогтодоггүй. Түрээсийн гал тогоо байж болохгүй гэхчхэн, үнэхээрийн гал тогоо байхгүй, стандартын бус сургуультай юм чинь одоо яах юм бэ? Дотуур байрандаа байна уу, хаана байна уу, гал тогоогоо шийдвэрлэх боломжтой бол түүнийгээ ашиглаг л даа эхний ээлждээ.

Тендерийн хуулиараа ч гэсэн бас чөдөр тушаа болчихсон. Засаг дарга нар ирээд жил болгон ярьдаг юм байна лээ шүү дээ. Тэгээд энэ мэтчилэн ийм жижигхэн, жижигхэн асуудлаараа энэ чөдөр тушааг нь тайлаад, тайлаад, Засаг дарга нарт нь өөрсдөд нь эрх мэдлийг нь бас өгчихвөл уг нь өөрсдөө сайн ажиллаад явж байгаа, сайн жишээнүүд байх боломжтой л байгаад байгаа байхгүй юу. Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга та асуудлуудаа мэдэж байгаа шүү дээ. Тэгээд шуурхай шиг цөөхөн хэдэн заалтуудыг оруулчхаж болохгүй юү? Ядаж эхний ээлждээ төсөв үнэхээрийн энэ гишүүд тойрог руугаа чирээд ердөөсөө хүүхдүүддээ анхаардаггүй юм гэхэд байгаа нөхцөл байдалтай нийцээд, энэ чөдөр тушаа болоод байгаа заалтуудаа нэг шуурхай өөрчлөх хэрэгцээ шаардлагатай байгаад байх юм.

Тэгээд уг нь ЗГ өөрөө өргөн баривал хурдан шуурхай л явчих ийм боломжтой. Энэ тал дээр хэчнээн хуульд ямар заалтуудыг өөрчлөх боломжтой вэ? Одоо яг чөдөр тушаа болж байгаа цөөхөн хэдэн заалт байгаа гэж одоо уулзахад л ярьдаг, тэгээд түүнийгээ оруулах боломжтой уу? Бидний зүгээс ядаж энэ жил биш юм гэхэд дараа жилд нь энэ 6-аас дээш, 6-аас 10 дугаар ангид нь ч юм уу нэг энэ үдийн хоолоор хангадаг байх энэ зохицуулалтыг нэг шийдэхгүй бол болохгүй. Ялангуяа 6 дугаар ангийн хүүхдүүд бол бүр хэцүү. Эхний цаг үедээ 5 дугаар анги хүртлээ хоолтой байж байгаад, тэгээд 6 дугаар ангиасаа ингээд хоолгүй болчихлоор яг тэр хэсэг дээрээ бол үнэхээрийн хэцүү байдаг юм байна лээ хүүхдүүд. Маш олон зорилтот бүлгийн хүүхдүүд байна. Үнэхээрийн сургууль дээрээ л ирж хоол идэж байгаа, халуун хоол авч байгаа ийм хүүхдүүд ч гэсэн нэлээдгүй олон байдаг гэсэн судалгаанууд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ агуулгаараа хэдүүлээ үнэхээрийн хүүхдийг дэмжье л гэж байгаа юм бол иймэрхүү байдлаар ярих биш, үйлдэл хэрэгтэй байна. 2019 онд батлагдсан хууль арай ч дээ, одоо ингээд 7 жилийн дараа бид ийм юм яриад сууж байгааг бол үнэхээр харамсалтай л байна.

С.Бямбацогт: Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир хариулъя. 4 дүгээр, ажлын хэсэг 4.

Т.Ням-Очир: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Энэ жил ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг гарчихсан, энэ хэлэлцүүлэг хийгдээд ерөнхийдөө боогдоод явж байгаа. Ер нь бол бид намрын чуулганаар энэ нэмэлт, өөрчлөлтөө өргөн барих төлөвлөгөөтэй байгаа.

Бид сум, сум дээр ямар тогтолцоо байх юм, аймаг дээр ямар тогтолцоо байх юм, нийслэл дээр ямар тогтолцоо байх юм гэдэг дээр нэлээн олон талын тооцоо, судалгаанууд хийж байгаа. Тэгэхээр захиалгын нэгдсэн систем, хүнс хангамжийн нэгдсэн тогтолцоо, түгээлтийн нэгдсэн тогтолцоог хийж, ер нь бол төр өөрөө илүү бага оролцож, илүү хувийн ААН дээр суурилсан, гэхдээ сургууль дээр зөвхөн халуун үйлдвэрлэл нь явдаг, захиалга дээрээ, хүнс хангамж дээрээ илүү тэр сургууль дээр зөвхөн халуун үйлдвэрлэл хийх боломжтой энэ захиалгуудыг хийснээрээ төрийн оролцоо багасаж, сургууль дээр аюулгүй хүнс нийлүүлэгдэх ийм боломжууд үүснэ гэдэг байдлаар бид энэ хүнс хангамж, захиалга, түгээлтийн нэгдсэн системээ бол харж байгаа.

Хэт задлаад жижиглэхээр хэт олон худалдан авах ажиллагаа, тэгээд хувь хүн дээр чиглэсэн ийм бас эрсдэлүүд Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлснээр гарч байгаа. Өөрөөр хэлбэл, сургуулийн удирдлагууд өөр өөрсдөө бие дааж тендер зарлах, худалдан авах ажиллагаа хийснээрээ янз бүрийн авлига, ашиг сонирхол ч юм уу, энэ чиглэлийн эрсдэлүүд өндөр байгаа. Тийм учраас ялангуяа нийслэл, аймгийн төв дээр бид тухайн орон нутгийн онцлогтой хангамжийн, захиалгын, түгээлтийн нэгдсэн системүүдийг хийж, гэхдээ төр бол зөвхөн менежмент хийж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон чиглэлийн хувийн ЖДҮ, ААН-үүдийн оролцох боломжийг нь бүрэн хангах боломжтой гэж харж байгаа.

Одоо ингээд бага анги бол 1-ээс 5 дугаар анги 2019 оноос хойш, ялангуяа хууль батлагдсанаас 2021 оноос хойш халуун хоол, үдийн хоолыг идээд эхэлчихсэн. Тэгэхээр одоо яг гарцаа байхгүй дунд анги дээр бол энэ хоол үйлдвэрлэл, үйлчилгээг бол хүүхдэд хоол өгөх энэ хэрэгцээ шаардлага бол маш ихээр үүсэж байгаа. Тийм учраас манай ажлын, Өргөдлийн байнгын хорооны ажлын хэсэг бол 6-аас 7 гээд, үе шаттай 8-аас 9 гээд эдийн засгийн нөхцөл байдал, байгаа боломждоо тааруулаад үе шаттай ингээд сургуулийн хэмжээнд энэ үдийн хоолыг нэвтрүүлэх санаачилгыг гаргаж байгаа нь бидний ажилд цаашдаа дөхөмтэй дэмтэй үйл ажиллагаа болно гэж ингэж харж байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Энэ хаврын чуулган дуусах болоогүй дахиад нэг сар гаруй хугацаа байгаа шүү дээ. Өргөн барь л даа, яагаад намар гээд байгаа юм бэ? Хангалттай ярилаа шүү дээ, зөндөө л боловсруулж байна гээд жилийн өмнө л яригдаж байсан. Та ч Ерөнхий боловсролын газрын дарга байхдаа энэ асуудлуудыг мэдэж байгаа шүү дээ. Одоо тэгээд ямар ч хугацаа алдах шаардлага байхгүй та хэд маань өргөн барьчихвал хэлэлцүүлгийнхээ явцад түүнийгээ сайжруулаад явчихна шүү дээ. Тэгээд шуурхай өргөн барихыг хүсэж байна. Нийслэл дээр би нэг ийм юм

сонссон. Энийг бас шалгаж анхаарал тавихгүй л бол хүүхдүүдийн аяга таваг угаах төхөөрөмж авах төсөв уг нь тавиад, худалдан авалтаа хийсэн юм шиг байгаа юм. Тэгэхдээ стандарт, анх тавигдсан стандартын бус худалдан авалт хийчихсэн. Тэгээд нөгөөдхийгөө одоо буцаасан юм уу, буцаагаад мөнгө нь ч байхгүй, төхөөрөмж нь ч байхгүй, хеликобактерыгаа ч одоо устгаж чадахгүй ийм нөхцөл байдалд байгаад байгаа юм, мэдэх үү энийг?

С.Бямбацогт: Хариулъя 4 дүгээр микрофон ажлын хэсэг.

Т.Ням-Очир: Нийслэлийн цэцэрлэгүүд дээр яг аяга таваг угаагч энэ төхөөрөмжийг худалдаж авах ажлын даалгавар боловсруулагдаад, мөн НИТХ-ын ажлын даалгавраа ямар хэлбэрээр хийх вэ гэдэг асуудал яригдаад, тухайн үеийн Боловсролын ерөнхий газар дээр намайг ажиллаж байхад энэ дээр зөвлөгөө заавар өгөөд аваад явсан. Тэгэхээр хэт том хэмжээтэй ийм аяга таваг угаагчууд ингээд ажлын даалгавар дээр орж ирээд байна. Тэгэхээр тухайн бүлэг бүлэгт нь тохирсон бага хэмжээний ийм овортой аяга таваг угаагчаар хангах нь зөв юм байна гэдэг байдлаар аяга таваг угаагчийн ажлын даалгавар бол хийгдээд яваад заавар зөвлөгөөг авсан. Зүгээр яах вэ худалдан авах ажиллагаа яг амжилттай болсон эсэх дээр бол эргэж тодруулаад танд хариу өгье.

Хууль өргөн барих дээр бол бид анхааръя. Энэ 6 сарын эхний 7 хоногт бид 3 яам хамтарсан, тэгээд олон улсын байгууллагууд оролцсон нэлээн том хэлэлцүүлгүүдийг сайд нар маань оролцож хийхээр байгаа. Тэгээд тэн дээрээс гарах зөвлөмж заавар дээрээ бид энэ хуулийнхаа.../минут дуусав/

С.Бямбацогт: Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

М.Мандхай: ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хэрэгжилтийг эрчимжүүлэх, Засгийн газарт үүрэг, чиглэл өгч байгаа тогтоолын төслийг дэмжиж байна. Яагаад гэхлээр энэ асуудал зөвхөн хүүхдэд хоол өгөх гээд байгаа асуудал биш юм. Энэ чинь хүүхдийн эрүүл мэнд, боловсролын чанар, ирээдүйн хөдөлмөрийн бүтээмж, цаашлаад бүр үндэсний аюулгүй байдлын асуудлыг хүртэл хөндөж байгаа.

Тэгэхлээр судалгаагаар бага насны шим тэжээлийн дутагдал хүүхдийн өсөлт, суралцах чадвар, анхаарал төвлөрөл, дархлаанд өөрөө шууд нөлөөлдөг. Олон улсын туршлагаар бол өөрөө яаж байгаа вэ гэхээр үдийн хоолыг халамж биш, эсрэгээр нь хүний хөгжлийн хөрөнгө оруулалт гэж баримталж ирсэн. Энийгээ бүр үндэсний хэмжээний сургуулийн хоолны тогтолцоогоо хуульчлаад, үндэсний бодлогын түвшинд авч хэрэгжүүлдэг болсон. Харамсалтай нь манай 2019 онд батлагдсан хууль тэр түвшинд өнөөдөр хүртэл тэр анхаарч явж ирсэнгүй, шаардлагатай хөрөнгө оруулалтыг нь хийсэнгүй. Бид сургуулийг нь бариад байдаг, гэтэл тэнд эрүүл орчинд ажиллаж, суралцаж, эрүүл орчинд байх нийт өдрийнхөө цагийг өнгөрөөж байгаа хүүхдүүдийн чухал асуудлыг нь хаячихсан явж ирсэн. Тийм учраас хууль 33.3 хувийн хэрэгжилттэй байна гээд гараад ирчихсэн.

Төслийн хүрээнд хоолны нормативыг инфляцтай уялдуулж нэмэгдүүлэх юм байна, 6-аас 12 дугаар ангийн сурагчдыг үе шаттай хамруулъя. Мэдээж шаардлагатай дэд бүтэц, гал тогоо, тоног төхөөрөмж гэдгийн стандартыг нь сайжруулаад, хүний нөөцийг нь бэлдье, органик, баяжуулсан хүнсний нийлүүлэлтийг дэмжье энэ тэр гээд чухал саналууд орсон байгаа.

Гэхдээ миний хувьд санаа зовоод байгаа юм бол тогтоолын, зөвхөн төсөв нэмэх тухай биш байгаад байгаа. Нийлүүлэлтийн тогтолцоог анхаарахгүй бол болохгүй байгаад байна. Зөвхөн Улаанбаатар хот, нийслэл хотын хүүхдийн хоол яриагүй, орон нутгийн хүртэл сургуулийн үдийн хоолтой болох асуудлыг ярьж байгаа. Орон нутагт одоо байгаа стандартын шаардлага хангасан нийлүүлэлт хомс, хүнс нийлүүлэх компаниуд нь хомс, үүнийгээ дагаад хүнсээ хадгалах, нөгөө тээвэрлэх, хүнсний тогтвортой сүлжээ гэсэн зүйл байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр зөвхөн мөнгө нэмээд орхих юм бол нөгөө импортын чанаргүй, улирлын хамааралтай хүнс нэмэгдэх эрсдэл байна. Өнөөдөр бид яг үнэнээ хэлэхэд хүнсний үйлдвэрүүд зөвхөн орцондоо анхаарч зээл аваад, гарцдаа буюу дотоодын нийлүүлэлтийг нэмэгдүүлж чадахгүй явж байгаа шүү дээ.

Тийм учраас дотооддоо хүнс үйлдвэрлэдэг компаниуд чинь импортоор тараг, сүүнээс эхлүүлээд худалдаж авдаг болчихсон. Тэгэхээр энэ өөрөө импортын ийм хамааралтай үдийн хоол болчих вий. Энэний цаана хүнсний баталгаат байдал, нөгөө хүнсний тогтвортой байдал, аюулгүй байдал чинь өөрөө хөндөгдөх ийм эрсдэлтэй харагдаад байна. Би үүнтэй холбоотойгоор асуулт асуумаар байгаа. Тэгэхээр энэ өөрөө ерөөсөө хүнсний эрх зүй, аюулгүй байдал, олон салбарын өөрөө огтлолцол, боловсрол, эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй, Сангийн яам, нийслэл, орон нутгийн удирдлага гээд маш олон том байгууллагуудын цогц, интеграцчилсан ийм том тогтолцоо явах гээд, механизм хөдлөх гээд байна. Тэгэхээр энэ 2030 он хүртэл хэрэгжүүлэх энэ нийт төсөв, санхүүжилтийн.../минут дуусав/

С.Бямбацогт: Асуултаа гүйцээгээд асуучихъя, М.Мандхай гишүүн.

М.Мандхай: Тэгэхээр энэ 2030 он хүртэлх хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн асуудлыг ер нь яаж шийдэх гэж байгаа юм бэ? Орон нутгийн сургууль, дотуур байрны тэр гал тогооны шинэчлэлийг ямар эх үүсвэрээр хийе гэж бодож байгаа юм бэ? Саяын хэлсэн энэ хүнсний нийлүүлэлтийн чухал асуудал хөндөгдөж байгаатай холбоотой дотоодын үйлдвэрлэгч, энэ малчин хоршоодын нийлүүлэлтийн сүлжээг ер нь яаж хамруулж ажиллуулъя гэж бодож байгаа юм бэ?

Миний хувьд Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг санаачилсан хүний хувьд энэ хүүхдийн хоол хүнсний чанар, шим тэжээлийн үр дүн хэмждэг, энийг нь бие даасан үнэлгээ хийгээд, ингээд энэнтэй нь тохирсон тэр хүний нөөц, хоол зүйчийг бэлдэх асуудлыг бас хэрхэн анхаарч ажиллаж байгаа вэ гэдгийг л холбогдох байгууллагуудаас нь тодруулан асуучихъя.

С.Бямбацогт: Боловсролын яам, ажлын хэсэг хариулъя. Ням-Очир дарга.

Т.Ням-Очир: Мандхай гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр яг үдийн хоолонд тавигдаж байгаа одоогийн энэ 2500 төгрөг ерөөсөө үдийн хоолыг үйлдвэрлэх хүнсний бүтээгдэхүүний зардал. Тийм учраас бид 2019 онд хууль батлахдаа хоол үйлдвэрлэлийг сургууль өөрөө бие дааж явуулна гэдэг байдлаар хуульчлаад, тухайн үед ялангуяа аймгийн төв, нийслэлийн 158 сургууль түрээсийн гал тогоотой байсан. Тэгэхээр хүнсний бүтээгдэхүүний зардлаа түрээсийн гал тогоо эрхэлж байгаа хүмүүст өгчихөөр түүхий эд, материалын зардал маань тэр нөгөө түрээсэлж байгаа хүмүүсийн ашиг орлогод яваад, ингээд хүүхдэд очих хэм хэмжээ, шим тэжээл буураад байгаа учраас ер нь ингээд одоо улсын хэмжээнд 140 орчим сургууль түрээсийн гал тогоотой байж байгаа.

Энэ хоорондоо мэдээж жил болгоны улсын төсөв дээр олон улсын байгууллагуудтайгаа хамтраад гал тогооны тоног төхөөрөмжөөр хангах, тэгэхээр тухайн үед нөгөө 158 сургуульдаа тэгээд шууд "түрээснээсээ боль" гэгчхээр түрээсийн байгууллагууд тоног төхөөрөмжөө аваад гараад явчих учраас улсын төсөв дээр нэг удаагийн тийм их хэмжээний мөнгө тавьж болохгүй учраас ингээд сүүлийн 5, 6 жилийн хугацаанд энэ 100 гаруй түрээсийн байгууллагыг гаргаж, тоног төхөөрөмжөө улсын төсөв дээр үе шаттай явуулж ингэж явж байгаа.

Дээрээс нь нэг бидэнд хүндэрч байгаа зүйл нөгөө сургуулийн барилга нь анхнаасаа хооллох танхим ийм зориулалтаар баригдаагүй учраас шинээр хийгдэж байгаа зураг төсөв дээр хооллох танхимтай, гал тогоо нь яг ингээд орох, гарах урсгал гээд орчин үеийн шаардлагыг хангасан ийм байхаар үе шаттай шилжээд явж байгаа. Тэгэхээр бусад улс орон ч гэсэн яг ийм замаар явсан юм байна лээ гэдэг судалгаа, тооцоонууд гарч ирж байгаа.

Дараагийн дугаарт түгээлтийн, хүнс хангамжийн, дээрээс нь захиалгын нэгдсэн систем хийхгүй бол дор бүрнээ захиалгын систем хийгээд явбал хэзээ ч ЖДҮ-үүдээ хөгжүүлж, дотоодын үйлдвэрлэлүүдээ дэмжих боломж гарахгүй юм байна лээ. Тийм учраас ЖДҮ-үүдээ оролцуулах, дотоодын үйлдвэрүүдээ оролцуулахын тулд захиалгын нэгдсэн систем, хангалтын нэгдсэн тогтолцоог хийчихвэл жишээлбэл төмс нийлүүлдэг байгууллагууд нь захиалгынхаа систем дээр ороод, тэгээд худалдан авах ажиллагаандаа ороод, нийлүүлэлтээ хийгээд ингээд явдаг ийм нэгдсэн системүүдийг гаргаад ирвэл хүссэн, хүсээгүй эрэлт хэрэгцээ нь байгаа учраас хүүхдийн хоол үйлдвэрлэлийг дагаад нийлүүлэх үйл ажиллагаа нь өөрөө ийм үр дүнтэй болоод ингээд ирэх юм байна.

Тэгэхгүй сургуулийн захирал бүр дор бүрнээ жижигхэн, жижигхэн худалдан авах ажиллагаа хийгдээд байвал энэ өөрөө систем, тогтолцоо өөрөө бүрдэхгүй ийм нөхцөл байдлууд байгаа юм. Орон нутаг дээр, бид тэгээд сум, аймгийн төв, нийслэл гээд яг орон нутаг болгоныхоо онцлогт тохирсон энэ нийлүүлэлтийн сүлжээ, системийг бид угсрах ёстой юм байна лээ. Ялангуяа алслагдсан сум яг тэр орон нутаг дээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүн нь яг тэр сургуулийнхаа хоол үйлдвэрлэлд оролцдог энэ зохицуулалтыг сум сумын онцлогтой бид хийх ёстой гэж ингэж харж, зохион байгуулалтаа хийж байгаа. Ялангуяа нийслэлийн Баянгол дүүрэг дээр бид эхний сайн туршлагаудыг.../минут дуусав/

С.Бямбацогт: Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Наадах чинь ингээд тоног төхөөрөмж, байр, бэлэн байдалтай холбоотой асуудал мэдээж чухал. Тэгэхээр миний бодлоор, энэ тогтоол дээр хэрэгжилтийн шинжтэй тийм нэг салбарын хүрээний арга хэмжээ илүү давамгайлсан харагдаж байгаа учраас хүүхдийн хоол, шим тэжээлийн асуудлыг илүү нөгөө үндэсний бодлогын түвшинд, яг олон улсын тэр стандарт, жишигтэй нийцүүлсэн ийм түвшинд нь авч үзэх ийм агуулга сул харагдаж байгаа учраас илүү энийг үндэсний бодлого болгож оруулж ирвэл яасан юм бэ гэдэг саналыг оруулах гээд байгаа юм. Тэгээд зөвхөн жил бүрийн төсвөөс ийм хамааралтай, эдийн засгийн мөчлөгөөс хамааралтай, инфляцтай ингээд хамааралтай гээд бид жил болгон л энэ төсөвтэй холбоотой асуудал дээр очихоор мөргөх гээд байгаа юм л даа. Тэгэхлээр энийг илүү үндэсний энэ түвшин.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариулах уу, Баасанжаргал гишүүн, ажлын хэсэг хариулъя.

Х.Баасанжаргал: Мандхай гишүүний 2 асуултад хариулчихъя. 1 дүгээрт, энэ орон нутгийн зүгээс ханган нийлүүлэлт хийх боломжтой юу гэдэг асуултад санасныг бодоход харин маш сайн боломж байгаа юм байна лээ нөөц бололцоонууд. ХХААХҮЯ-ны зүгээс нэлээн нарийн судалгаануудыг сая сүүлийн хэд хоногт бидэнд хийж өгсөн. Бид эхэндээ нэлээн учраа олохгүй, янз янзаар ийм зураглал гаргаж үзсэн юм. Аймгуудад ямар боломж байна, ямар нөөц бололцоо байна, ямар компаниуд ямар чиглэлээр хүнсээ нийлүүлэх боломж байна, тэрийг яаж холбох боломж байна вэ гэж ингэж гаргаж үзсэн.

Жишээ нь, баруун бүсийн аймаг гэхэд махаа орон нутгаас 100 хувь авах боломжтой гэж гарлаа, төмс, хүнсний ногоогоо орон нутгаас 100 хувь, харин төрөл бүрийн будааг Улаанбаатар хотоос 43 хувийг нь, импортоор 57 хувийг нь, сүү, сүүн бүтээгдэхүүнээ орон нутгаас 53 хувийг нь, Улаанбаатар хотоос 47 хувийг нь, гурилаа орон нутгаас 100 хувь, гурилан бүтээгдэхүүнээ мөн орон нутгаас 100 хувь, жишээ нь баруун бүс дээр бол. Хангайн бүс дээр энэ үзүүлэлт арай өндөр гарч байгаа гэх мэтээр. Тэгэхээр аймаг орон нутгуудынхаа онцлогийг харгалзаж үзэх 1 дүгээрт. 2 дугаарт энд аягүй том зах зээлийг хувийн хэвшилдээ бий болгох гээд орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдээ дэмжих, төрөөс олгож байгаа олон талаас, хөнгөлөлттэй зээл авсан ААН-үүдээ энд холбож өгөх гээд ингээд олон талаас нь хараад энэ сүлжээг ийм байж болох юм гэдэг эхний ийм тооцоо, судалгаанууд гараад явж байгаа юм гэдгийг хэлье.

2 дугаарт, үндэсний хэмжээний бодлого болох ёстой гэдэг дээр ер нь үндэсний хэмжээний хүүхдүүдийнхээ энэ хоол, шим тэжээлийг үндэсний хэмжээнд ингэж тогтмол судалж ирсэн харин баталгаа байхгүй юм байна лээ. Дандаа ОУБ-ын санхүүжилтээр судалгаа хийгээд, нөгөөдөх нь дандаа өөр, өөр зорилготой. Тэндээс хэрэгтэй дата судалгаануудаа түүвэрлэж авах маягаар ингээд нэг ийм маягтай явж ирсэн. Тэгэхээр одоо бидний тогтоол дээр нэг орж ирсэн юм юу вэ гэвэл энэ судалгааг жил болгон, түүврийн судалгаагаа жил болгон хийе. Тэгж байж нөгөө түрүүн Ганмаа гишүүний.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя, нэг минут.

Х.Баасанжаргал: Ганмаа гишүүний судалгаан дээр дурдаад байсан яг 28 хоног хүүхдүүдэд Д витаминаар баяжуулсан сүү өгөхөд хүүхдийн өсөлтөд яаж нөлөөлж байна вэ гэдэг шиг бид энэ "Үдийн хоол" хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр, ялангуяа дунд ангийн хүүхдүүдэд хэрэгжиж эхлэхээр ямар үр дүн гарах нь вэ, энэ нь өөрөө цаашид Монгол Улсын эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, хүн амын өсөлт гээд энэ олон зүйлүүдэд ямар үр дүн гарч байна вэ гэдгээ бид хэмжиж чаддаг ийм болох тогтолцоог бид угсарч үзэх гэж ингэж нэлээн нарийн заалтуудтай, нэлээн нарийн шалгуур үзүүлэлттэй ийм тогтоол гаргаж байгаа. Бас энэ тогтоолыг гаргаад зогсохгүй манай Өргөдлийн байнгын хороо бас үргэлжлүүлж ажиллаад тогтоолынхоо мөрөөр хэд хэдэн ажлууд төлөвлөөд явж байгаа. Ирэх жилийн өдийд гэхэд тогтоолынхоо хэрэгжилтийг үнэлээд, дүгнээд сууж байх гэж найдаж байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Манай Өргөдлийн байнгын хороо, ажлын хэсэг ахалсан Баасанжаргал гишүүд маш чухал тогтоолын төслийг оруулж ирсэн юм байна. Тэгээд ЕБС-ийн дунд

болон ахлах ангийн сурагчдадаа үдийн хоол хөтөлбөрт хамрагдуулах, нэг хүүхдэд ноогдох хоолны норматив зардлыг инфляцын түвшин, хоол хүнснээс авбал зохих шим тэжээлийн хэрэгцээг харгалзаж тогтоодог болох, сургуулийн хоол үйлдвэрлэлийн байр сав, тоног төхөөрөмж, материаллаг бааз, эрүүл ахуйн стандартад нийцүүлэх гээд. Сая ярьж байгаа баяжуулсан болон органик хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх, хүүхдийг өсөлтийг нэмэгдүүлэх гээд нэлээн тийм том тогтоол оруулж ирсэн байна. Хэрэгжүүлэх тал дээр манай гишүүд, Засгийн газар, холбогдох ажлын хэсэг маань анхаарч ажиллаарай.

Шаардлагатай тэр хуулийн төслүүдийг өргөн барья гэж Засгийн газрын ажлын хэсэг ярьж байх шиг байна. Тийм болохоор хуулийн төслүүдээ хурдан хугацаанд өргөн бариарай. Редакцын санал байгаа юм байна, Х.Баасанжаргал гишүүн тогтоолын төсөл дээр. Баасанжаргал гишүүний микрофон.

Х.Баасанжаргал: Энэ тогтоолын төслийн 4 дүгээр заалтад 19 оны 05-р сарын 30-ны өдрийн 53 дугаар тогтоолын нэг дэх заалтын 1, 2, 3, 4, 5, 6, 8 гэж байгаа юм. Тэгээд энэ 8 гэдэг маань энд орох ёсгүй байсан, ийм редакцын алдаа гарсан байна лээ, энийг тэмдэглэлд үлдээе.

С.Бямбацогт: Тогтоолын төслийг эцэслэж батлахдаа найруулгын хувьд анхаарах зүйлүүдийг анхаараад, илүү засах зүйл байвал засаарай. Ингээд маргааш санал хураалт явуулна.

23.26 цаг

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Үдшийн 23:26 цаг хүртэл чуулганы хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. УИХ-ын Тамгын газрын холбогдох албан тушаалтнууддаа баярлалаа. Тэгээд өнөөдөр ямар ч байсан хэлэлцэх асуудлаа 100 хувь хэлэлцээд ингээд дууслаа. Маргааш өглөө санал хураалтууд явагдана. Ойрын үед Их Хурал жоохон ачаалалтай ажиллах шаардлагатай байгаа учраас илүү цагаар ажиллаж байгаа шүү гэдгийг гишүүд маань зөв ойлгоорой.

Өнөөдрийн нэгдсэн чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Маргааш баасан гаргийн чуулган 10:00 цагаас эхэлнэ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА